



**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР**  
**СУДАЛГААНЫ ТӨВ**

# **БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ**

(СУДАЛГААНЫ ЭМХТГЭЛ)



- ◇ Эдийн засаг
- ◇ Уул уурхай
- ◇ Байгаль орчин
- ◇ Хүнсний аюулгүй байдал

**УИХМН**  
**СУДАЛГААНЫ САН**

DDC  
328015  
Б-53

«Бодлогын судалгаа, шинжилгээ» -ний эмхэтгэл (VII боть, 2011)  
-ийг УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвөөс эрхлэн гаргав.

Редактор: Ц. Норовдондог (Ph.D)

Техник редактор: Ц. Товуусүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Г. Чулуун

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

ISBN 978-99929-895-6-4

## ГАРЧИГ

### Судалгааны эмхтгэл - VII боть

#### УИХ -ЫН 2011 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГААНЫ АЖЛУУД

<b>ӨМНӨХ ҮГ</b>	6
<b>1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН АСУУДАЛ</b>	
1.1. Монгол Улсын хүн ам зүйн бодлого ба хөгжлийн асуудал, нөлөөллийн хүчин зүйлс (Бодлогын судалгаа, дүн шинжилгээ)	8
<i>Ц. Норовдондог (Ph.D), О. Нарантуяа, Б. Мөнхцэцэг Ц. Болормаа, Ө. Мөнхтунгалаг, Т. Мягмаржав А. Пагма, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа</i>	
1.2. Монгол Улсын макро эдийн засгийн 2010 оны I улирлын тойм	97
<i>Ч. Онончимэг, Ц. Батдорж, Ц.Батбаяр Г. Билгээ</i>	
1.3. Монгол Улсын макро эдийн засгийн 2010 оны III улирлын тойм	105
<i>Ч. Онончимэг, Ц. Батдорж, Ц.Батбаяр Г. Билгээ</i>	
1.4. Монгол Улсын 2011 оны төсвийн орлого, зарлагын шинжилгээ (Бодлогын судалгаа, дүн шинжилгээ)	113
<i>Ц. Норовдондог (Ph.D), Ц. Элбэгзаяа, Ц. Батдорж, Г. Билгээ, Ц. Болормаа, Г. Гэрэл, Д. Мягмарцэрэн, Ч. Онончимэг</i>	
1.5. Монгол Улсын макро эдийн засгийн 2010 оны тойм	161
<i>Ц. Норовдондог, (Ph.D), Ц. Батдорж, Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа</i>	
1.6. Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал (Мэдээлэл лавлагаа - дүн шинжилгээ)	177
<i>Ц. Норовдондог (Ph.D)</i>	
1.7. Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хуулийн төслийн шинжилгээ, гадаад орнуудын туршлага	182
<i>Д. Мягмарцэрэн, Г. Билгээ, Г. Гэрэл Ч. Онончимэг, Ц. Болормаа Ц. Элбэгзаяа</i>	
1.8. Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн тулгамдсан асуудлууд (Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж, клиринг - төлбөр тооцоо, кастодиан)	230
<i>Ц. Норовдондог (Ph.D)</i>	

**2. ЭДИЙН ЗАСАГ БОДИТ САЛБАР, УУЛ УУРХАЙ, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ**

- 2.1 **Ашигт малтмалын тухай хуулиудын харьцуулалт, бусад орны туршлага** ..... 250  
*Д. Мягмарцэрэн*
- 2.2 **Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбарын гүйцэтгэсэн үүрэг (I хэсэг)** ..... 261  
*Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаг, Б. Жигваагүнсэл, О. Нарантуяа*
- 2.3 **Монгол Улс болон Өмнөд австрали муж улсын ашигт малтмалын талаархи эрх зүйн зарим зохицуулалтыг харьцуулсан байдал** ..... 289  
*Ч. Базар (Ph.D, Ц. Батбаяр, Ц. Болормаа*
- 2.4 **Байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хангамжиг дэмжих бодлого зохицуулалтын зарим асуудал, гадаадын туршлага (Тойм судалгаа)** ..... 302  
*Ө. Мөнхтунгалаг, С. Дорждагва, Г. Чулуун*
- 2.5 **Монгол Улсад импортоор орж ирж байгаа хамгийн их хэмжээтэй 100 нэрийн бараа бүтээгдэхүүн болон тэдгээрийг дотоодод орлон үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдийн талаархи судалгаа** ..... 321  
*Г. Алтан - Оч (Ph.D), С. Дорждагва*
- 2.6 **Монгол Улс дахь орон сууцны хангамжийн асуудал, хот суурингийн усан хангамж, ариутгах татуургын өнөөгийн нөхцөл, эзэмшлийн байдал (Лавлагаа мэдээлэл)** ..... 424  
*Г. Алтан - Оч (Ph.D), С. Дорждагва, Г. Чулуун*
- 2.7 **“Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хууль” -ийн төсөлд хүргүүлсэн санал зөвлөмж (УИХ -ын БОХХААБайнгын хорооны даргын 2010.12.21 -ний өдрийн 08 тоот захирамжаар томилогдсон Ажлын хэсэгт)** ..... 437  
*Ц. Норовдондог (Ph.D)*

**• ХАВСРАЛТ**

- УИХ -ын 2011 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа ..... 442

(VIII ботид орсон бусад судалгааны жагсаалт)



## ӨМНӨХ ҮГ

УИХ -ын эрхэм гишүүд та бүхэнд УИХ -ын Тамгын газрын Судалгааны төвийн 2010 оны УИХ -ын намрын ээлжит чуулганы хугацаанд гүйцэтгэсэн судалгааны ажлуудын эмхэтгэл 7 дугаар цуврал ботийг хүргүүлж байна. УИХ -ын намрын чуулганы хугацаанд тус төв нь 30 гаруй судалгааны ажлыг гүйцэтгэснээс уг эмхэтгэлд УИХ -ын гишүүдийн захиалгаар болон Төвийн санаачлагаар гүйцэтгэсэн макро эдийн засаг, төсөв, уул уурхай, эдийн засгийн бодит салбарт хамаарах 20 орчим бодлогын судалгаа, дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа, мэдээлэл, лавлагааг төрөлжүүлэн багтаасан болно.

Эдгээр судалгааны ажлуудаас зарим судалгааг захиалагч гишүүний хүсэлтийг харгалзан зөвхөн захиалагчдад, УИХ -аар хэлэлцсэн нийтлэг асуудал болон Төвийн санаачлагаар гүйцэтгэсэн судалгааг тухай бүрт нь бүх гишүүдэд хэвлэмэл хэлбэрээр хүргүүлж УИХ -ын Номын сангийн Хөгжлийн мэдээллийн төвд цахим хэлбэрээр байршуулж байна. Ээлжит чуулган бүрийн төгсгөлд Судалгааны төвийн гүйцэтгэсэн бүх судалгааны ажлыг эмхэтгэл болгон хэвлүүлж эрхэм гишүүд та бүхний гарт хүргэдэг уламжлалын дагуу энэхүү эмхэтгэлийг толилуулж байгаадаа баяртай байна.

Тус төвийн үйл ажиллагаа нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах процесст УИХ -ын гишүүдийг хараат бус, өргөн цар хүрээтэй мэдээлэл - судалгаа, бодлогын дүн шинжилгээ, зөвлөмжөөр шуурхай хангахад чиглэгдэж байдаг тул бид байгаа нөөц боломжоо бүрэн дайчилж эрхэм гишүүд та бүхний мэдээллийн хэрэгцээг хангахын төлөө ажиллаж байна.

Нөгөө талаас, УИХ -ын гишүүд та бүхний судалгаа, мэдээллийн хэрэглээ, эрэлт хэрэгцээ өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь тус төвд ирүүлж байгаа судалгааны захиалгын статистикаас харагдаж байна. Аливаа орны хууль тогтоох байгууллагын чадавхи нь парламентын үйлчилгээний мэргэшсэн алба болох Тамгын газрын чадавхиас ихээхэн шалтгаалдаг билээ. Тамгын газраас УИХ -д мэргэжил, арга зүйн болон техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхээс гадна мэдээлэл, судалгааны үйлчилгээг үзүүлж эхэлсэнээс хойш 2 жил гаруй хугацаа өнгөрлөө.

Бусад орнуудын парламентын Судалгааны албадтай харьцуулахад манай Судалгааны төв хүн хүч, нөөц боломжоор бага ч гэлээ УИХ -ын гишүүд, Байнгын хороод, хуулийн ажлын хэсгүүд, Тамгын газрын бусад хэлтэс, албадын хэрэгцээнд шаардлагатай бүх төрлийн судалгаа, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгсөөр ирлээ. Сүүлийн үед хуулийн ажлын хэсгүүдэд судлаач, шинжээчид орж ажиллах, хуулийн төсөлд олон нийтийн саналыг авах, хэлэлцүүлэг хийх, онол-практикийн хурал зохион байгуулах, нийгмийн шинжтэй томоохон асуудлаар олон нийтээс анкетын санал асуулга авах, хөдөө орон нутагт явж судалгаа хийх зэргээр манай төвийн үйл ажиллагааны цар хүрээ улам өргөжиж байна.

Түргэн хурдацтай өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа гадаад болон дотоод орчны нөлөөн дор дэлхий дахины стандарт болон Монгол улсын онцлог нөхцөлд тохирсон хууль, эрх зүйн актуудыг УИХ-аар батлан гаргах хэрэгцээ шаардлага нь нь судалгаа, мэдээллийн эрэлт хэрэгцээ, судлаач шинжээчдэд тавигдах шаардлагыг улам бүр нэмэгдүүлж байна.

Цаашид Судалгааны төвийн чадавхийг сайжруулах, судлаачдад тавигдах шаардлагыг өндөржүүлэх, ажил үүргийн зааг ялгааг тодорхой болгох, судалгааны захиалга авах, гүйцэтгэх ажиллагаанд журам тогтоох, ачааллыг тэнцвэржүүлэх чиглэлээр дотоод зохион байгуулалтын арга хэмжээ авахаар төлөвлөж байна.

Энэхүү судалгааны эмхэтгэл нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд ажиллаж

байгаа улс төрчид болон төрийн албан хаагчид, уншигчид та бүхний гарын авлага, мэдээллийн томоохон эх сурвалж болно гэдэгт найдаж байна.

Номын арвин цагаан буян дэлгэрэх болтугай.

*Ц. Норовдондог (УИХ-ын Тамгын газрын Судалгааны төвийн дарга, Ph.D)*



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# 1

## БҮЛЭГ

---

МАКРО ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН АСУУДАЛ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН БОДЛОГО БА ХӨГЖЛИЙН АСУУДАЛ,  
НӨЛӨӨЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС**

(Бодлогын судалгаа, дүн шинжилгээ)

*Ц. Норовдондог (Ph.D), О. Нарантуяа, Б. Мөнхцэцэг, Ц. Болормаа,  
Ө. Мөнхтунгалаг, Т. Мягмаржав, А. Пагма, Ч. Онончимэг,  
Ц. Элбэгзаяа*

**АГУУЛГА****ОРШИЛ – дүгнэлтийн хэсэг****Нэг. Хүн ам зүйн судалгаа, дүн шинжилгээ**

- 1.1. Хүн ам зүйн ерөнхий ойлголт
- 1.2. Хүн ам зүйн үзүүлэлтүүдийн динамик судалгаа
- 1.3. Хүний хөгжлийн үзүүлэлтүүдийн динамик судалгаа
- 1.4. Хүн ам зүйн бодлогын тулгамдсан асуудлууд
- 1.5. Монгол Улсын хүн ам зүйн бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилт
- 1.6. Хүн ам зүйн талаар бусад орнуудын хэрэгжүүлж буй бодлого, туршлага
- 1.7. Хүн ам зүйн талаар төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи санал, зөвлөмж

**Хоёр. Монгол Улсын иргэн, харьяатын асуудлаарх судалгаа, дүн шинжилгээ**

- 2.1. Монгол Улсын иргэн, харьяатын асуудлыг зохицуулж буй эрх зүйн орчин, бодлого, хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ
- 2.2. Монгол Улсаас гадаадад гарч буй иргэдийн асуудал
- 2.3. Монгол Улсад орж ирж буй гадаадын иргэн, харьяатын асуудал
- 2.4. Иргэн, харьяатын асуудлаарх бусад орнуудын хэрэгжүүлж буй бодлого, эрх зүйн орчин
- 2.5. Иргэн, харьяатын асуудлаарх дүгнэлт, санал, зөвлөмж

**Гурав. Монгол Улсын хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хамаарлын судалгаа, дүн шинжилгээ**

- 3.1. Хүн амын өсөлтийн прогноз /2050 он хүртэл/
- 3.2. Хүн амын өсөлтөнд нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээ
- 3.3. Хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн харилцан хамаарал /бодит байдал, прогноз/

**Ашигласан материалын жагсаалт****Хавсралт 1.**

- Монгол улсын төрөөс хүн ам зүйн талаар баталсан эрх зүйн орчны лавлагаа

**Хавсралт 2.**

- Хүн ам зүйн асуудлаар хийгдсэн судалгааны жагсаалт



## Оршил

Улсын Их Хурлын Тамгын газрын Судалгааны төвийн судлаачдын баг “Монгол Улсын хүн ам зүйн бодлого ба хөгжлийн асуудал” сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Хүн ам зүйн бодлого нь хүн амын өсөлт, бүтцийг хадгалах буюу өөрчлөх, хүн амын нөхөн үржихүйн хүрээний үйл явцыг зохицуулахад чиглэгдсэн төрийн байгууллага, нийгмийн институцүүдийн зорилго, чиглэлтэй үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, энэхүү бодлого нь хүн амын тоо, өсөлт, өөрчлөлтөд нөлөөлдөг гол хүчин зүйлүүд болох төрөлт, гэрлэлт, гэр бүл салалт, нас баралт, хүн амын насжилтын бүтцийн өөрчлөлт, бүхэлдээ хүний хөгжил, амьдралын чанар, нөхцлийг сайжруулах үйл явцад нөлөөлдөг бөгөөд нийгэм, эдийн засгийн бодлоготой нягт уялдаа холбоотой хэдий ч бас өөрийн гэсэн онцлогтой юм.

Хүн ам зүйн бодлого нь эдийн засгийн, захиргаа-эрх зүйн, хүмүүжлийн болон ухуулга, сурталчилгааны цогц арга хэмжээний үндсэн дээр хэрэгждэг. Тухайлбал, хүн амын өсөлтийг дэмжсэн эдийн засгийн арга хэмжээнд жирэмсний болон амаржсаны тэтгэмж, гэр бүл, хүүхдийг дэмжсэн тэтгэмж, хүүхдийн мөнгө, татварын, орон сууцны хөнгөлт эдлүүлэх зэрэг арга хэмжээ багтдаг бол захиргаа-эрх зүйн хүрээнд гэрлэлт, гэр бүл салалт, гэр бүл дэх хүүхдийн байдал, эх, хүүхдийг хамгаалах, үр хөндөлт, хөдөлмөр эрхэлж буй эхчүүдийн хөдөлмөрийн нөхцөл зэрэг асуудлууд хамаарах ба үүнийг холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулж байна.

Хүн ам зүйн бодлогын үндсэн асуудлууд нь хүүхэдтэй гэр бүлийг дэмжих, эцэг, эхчүүд идэвхтэй хөдөлмөр эрхлэх нөхцлийг хангах, хүн амын өвчлөлт, нас баралтыг бууруулах, наслалтыг нэмэгдүүлэх, хүний хөгжлийг хангах, шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах, хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настанд үзүүлэх нийгмийн дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг асуудлууд юм.

Өнөөдөр олонх өндөр хөгжилтэй орнуудад, ялангуяа Европт хүн ам зүйн хямралын үе гэж нэрлэгддэг төрөлт харьцангуй буурч, хүн амын жам ёсны өсөлт саарч, насны бүтцэд ахмад настны эзлэх хувь нэмэгдсэн үе тохиож байгаа бол харин манай улсад хүн амын насны бүтэц идэршиж, хөдөлмөрийн насны хүн амын тоо хамгийн их байгаа **“хүн амын цонх”** хэмээн нэрлэгддэг хүн амын насны бүтцийн хамгийн тааламжтай үе ирж байгаа тухай судлаачид мэдээлж байна. Хүн амын насны бүтцийн тааламжтай үеийг зөв зохистой ашиглаж чадсан улс орнууд хурдацтай хөгжиж, ашиглаж чадаагүй нь нийгмийн олон асуудалтай тулгарч, хөгжил нь саардгийг гадаад улс орнуудын туршлага харуулж байна.

## Судалгааны зорилго:

Төрөөс баримталж буй хүн ам зүйн бодлогын хэрэгжилтийн явцад буй болсон тулгамдсан асуудлыг тодруулж, холбогдох мэдээлэл, дүгнэлт гарган тодорхой санал, зөвлөмж боловсруулахад оршино.

## Судалгааны зорилтууд:

- Монгол Улсын хүн ам зүйн болон хүний хөгжлийн үзүүлэлтүүдийн динамик судалгаа,
- Монгол улсын хүн ам зүйн бодлогын тулгамдсан асуудлыг тодорхойлох
- Монгол Улсын хүн ам зүйн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх
- Хүн ам зүйн талаар гадаадын зарим орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эрх зүйн орчин, туршлагыг харьцуулан судлах,
- Монгол Улсын иргэн, харьяатын асуудалтай холбоотой эрх зүйн орчин, тулгамдсан асуудлыг судлах,
- Монгол улсын хүн амын өсөлтийн коэффициент түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн

шинжилгээ, 2009-2050 оны хүн амын өсөлтийн прогноз болон хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хамаарал зэрэг асуудлуудыг судалсан болно.

### Судалгааны үр дүн:

Хүн амын хөгжлийг хангах чиглэлээр бодлого, хөтөлбөрүүд цөөнгүй байгаа ч зарим заалтуудын хувьд тунхаглалын шинж чанартай, хөтөлбөрийн хэрэгжилтийн шатанд илэрхий алдаа дутагдлууд гарч байгаа бөгөөд үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн чадвар дутмагаас болж хэрэгжилтэнд ахиц гарахгүй байгаа нь харагдаж байна.

- Төрөөс хүн ам зүйн талаар баримтлах тодорхой, шинжлэх ухааны үндэслэлтэй, тууштай, цаг үеийн шаардлагад нийцсэн бодлого үгүйлэгдэж байгаагийн зэрэгцээ хүн ам, гэр бүлийн хөгжлийн асуудлыг хариуцсан тогтолцоог боловсронгуй болгох, эдгээрийг үндэсний хэмжээнд төлөвлөлт, зохицуулалтаар хангах механизм бий болгох шаардлагатай байна.
- Ажлын байрны хомсдлоос шалтгаалан хүн амын хөдөөгөөс хот руу, эх орноосоо гадаад улс руу чиглэсэн албан болон албан бус шилжих хөдөлгөөн буурахгүй байна. Хөдөлмөрийн болон нөхөн үржихүйн насны олон мянган залуус гадаад, дотоодод нүүдлийн байдаар ажиллаж, амьдарч байгаагийн цаана эд материал, хөрөнгө мөнгөөр илэрхийлэх боломжгүй хүйсийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлөх, гэр бүл салж сарних зэрэг олон тулгамдсан асуудал бий болсныг анхаарах шаардлагатай байна.
- Цаашид хүн амын өсөлт, төрөлтийг дэмжсэн бодлогыг илүү үр дүнтэй, нийгмийн тэгш хөгжлийг дэмжих зорилттой уялдуулан авч хэрэгжүүлэх нь оновчтой байна. Ялангуяа тоон өсөлтөөс илүү хүн амыг боловсролтой, бие бялдрын хувьд эрүүл чийрэг, ажил мэргэжлийн чадамжтай болгон хөгжүүлэх асуудал чухал юм.
- Судалгаанаас үзэхэд ихэнхи хүмүүсийн гадаад, дотоод шилжилтэнд оролцож байгаа шалтгаан нь ажлын байр байхгүй, байсан ч цалин, хөлс бага зэрэг манай улсын хөдөлмөрийн зах зээлийн тулгамдсан асуудал байгаа нь “хүн амын урамшууллын үе”-ийг эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломж болгон ашиглаж чадахгүй байгааг харуулж байна.
- Уул уурхай, боловсруулах салбарыг хөгжүүлсэнээр хүн амын суурьшил, гэр бүлийн хөгжилд хэрхэн нөлөөлөх, шинээр хөгжиж буй салбарт шаардлагатай өндөр ур чадвартай мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, дэвшилтэт техник, технологийг эзэмших, нутагшуулах тал дээр гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдтэйгээ хэрхэн хамтарч ажиллах тал дээр ч нухацтай хандах нь зүйтэй байна.
- Судалгаанд хамрагдсан ОХУ, Швед, Франц, Итали, Бельги гэх мэт орнуудын хүн ам зүйн бодлоготой холбоотойгоор хэрэгжүүлдэг арга хэмжээг нэгтгэн үзвэл гэр бүлийн болон хүүхдийн тэтгэвэр, тэтгэмж олгох, шинэ залуу гэр бүлд орон байрны хөнгөлөлт үзүүлэх, хүн амын өсөлт нь бүх нийтийн зорилго байх ба үүнд хүрэхийн тулд дарамтыг бүгдэд тэгш хуваарилах.
- Өөрөөр хэлбэл, Хүүхэдгүй болон хүүхэдтэй болохыг хүсдэггүй /хүүхэд үрчлэхийг оруулаад/ хүмүүс хүн амын нөхөн үржихүйн үндсэн ачааллыг үүрч байгаа хэсэгт санхүүгийн тусламж үзүүлэх, /хүүхэдгүйн татвар төлөх, тэтгэврийн насыг нэмэгдүүлэх гэх мэт эдийн засгийн арга хэмжээнүүд хүн амын өсөлтөд тодорхой нөлөө үзүүлж байна.
- Иргэний харьяаллын асуудлаар Монгол улсын харьяаллаас гаралгүйгээр өөр улсын харьяат болсон иргэдийн асуудал нэлээн анхаарал татаж байгаа асуудал болж байна. Тухайлбал, өнөөгийн байдлаар манай улсаас БНХАУ-д шилжин суурьшсан иргэдээс **26644** иргэн хоёрдмол харьяалал үүсгээд

байсны **17042** иргэнийг хялбаршуулсан журмаар харьяатаас гаргах асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьж Ерөнхийлөгчийн зарлигаар шийдвэрлүүлсэн байна.

- Судалгаанаас үзэхэд гадаадын иргэд Монгол улс харьяат болох нь тооны хувьд харьцангуй буурсан, харин Монгол улсын иргэд өөрийн иргэний харьяаллаас гарах нь нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байна. Тухайлбал, 2004 онд гадаадын 23<sup>1</sup> иргэн манай улсын харьяат болсон бол 2009 онд 12 иргэн Монгол улсын харьяат болжээ. 2004 онд Монгол улсын 70 иргэн иргэний харьяаллаасаа гарсан бол 2009 онд 276<sup>2</sup> иргэн тус улсын иргэний харьяаллаас гарчээ.
- Монголчууд урт хугацаагаар гадаадад амьдрах болсноор тэдний үр хүүхдүүд тухайн орныхоо иргэн болох нь цөөнгүй байгаа болон Монгол улсын харьяатаас гарсан иргэдийн тоо нэмэгдэж байгааг анхааран давхар иргэншлийг хуульчилах боломжийг судлах, хэрэгжүүлэх.
- Давхар иргэншлийн асуудал нь хоёр чиглэлтэй юм. Эхнийх нь аль ч орны иргэн манай улсын иргэнээр давхар байж болох нөхцөл. Удаах нь зөвхөн Монгол Улсын иргэн өөр аль нэг орны иргэн давхар байж болно гэсэн чиглэл юм. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн монгол хүнд л хамаатай асуудал, ялангуяа гадаадад аж төрж, тухайн орныхоо иргэншлийг нэгэнт авчихсан болон авах гэж буй монголчуудад хамаатай болно. Олон улсын туршлагаас үзэхэд ийм практик цөөнгүй бий. Тухайлбал, манай хойд хөрш ОХУ гэхэд 2002 оноос зөвхөн ОХУ-ын иргэдийн хувьд иргэний давхар харьяалалтай байж болохыг хуульчилжээ<sup>3</sup>.
- Дотоодод ажилгүйдэл их байгаа нөхцөлд гадаадаас ажиллах хүчин олноор оруулахдаа компаний ашиг сонирхолд хөтлөгдөхгүй байх, гагцхүү шаардлагатай нөхцөлд гадаадаас тодорхой мэргэжил, мэргэшлийн ажиллах хүчин оруулахыг зөвшөөрч байх, өөрийн үндэсний мэргэжлийн ажиллах хүчин бэлтгэх ажлыг улам эрчимжүүлэхэд анхаарах зэрэг олон асуудлыг анхаарах шаардлагатай байгаа нь бидний хийсэн судалгаанаас харагдсан болно.

## I. БҮЛЭГ. ХҮН АМ ЗҮЙН СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 1.1. Хүн ам зүйн ерөнхий ойлголт

“World book” хэмээх толь бичигт хүн ам зүйн шинжлэх ухааныг хүн амын тоо, байршил, бүтэц, хөгжлийг голчлон судалдаг шинжлэх ухаан гэж тодорхойлсон байдаг байна. Олон улсад хүн ам зүйн шинжлэх ухааныг **demography** гэж нэрлэх бөгөөд энэ нь грекээр “**dem**” хүмүүс “**graphy**” бичих тэмдэглэх гэсэн утгыг илэрхийлдэг ажээ.

Хүн ам зүйн талаархи мэргэжлийн сурах бичиг, гарын авлагт<sup>4</sup> бичсэнээр **хүн ам зүй** нь хүн амын тоо, бүтэц, өсөлт, өөрчлөлтийг болон түүний үр дүнг нийгэм, эдийн засгийн үзэгдлүүдийн өөрчлөлтүүдтэй холбон авч үзэж, учир утгыг нь тайлбарладаг шинжлэх ухаан гэж үздэг байна. Зарим эрдэмтэд хүн ам зүйн шинжлэх ухааныг хүн ам судлал ба хүн ам зүй гэсэн хоёр салбараас бүрдэнэ гэж үздэг.

<sup>1</sup> Монгол Улсын хийлөгчийн Тамгын газрын мэдээлэл

<sup>2</sup> Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаархи үндэсний дээд хэмжээний уулзалт. УБ., 2005 он, 51 дэх тал

<sup>3</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын мэдээлэл

<sup>4</sup> ФЗ “О гражданстве Российской Федерации”, 2002 г. Ст.6.




**Хүн ам зүй нь:** математик тоцоолол, загвар боловсруулахтай холбоотой салбар шинжлэх ухаан юм. Тухайлбал, хүн амын өсөлт өөрчлөлтөнд нөлөөлөх гурван бүрэлдэхүүн хэсэг болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний үзүүлэлтүүд, тэдгээрийн хүн амын өсөлт, өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөллийг тооцдог байна. **Хүн ам зүйн дээрх агуулгыг схемчилэн үзүүлбэл:**



Өөрөөр хэлбэл, хүн ам зүй нь нийгмийн үзэгдлүүдийн хоорондох тоон уялдааг бусад үзэгдлүүдтэй хамаарах талаас нь тайлбарлахаасаа илүү тодорхойлон өгүүлэх, задлан шинжлэх онцлогтой байна.

**Хүн ам судлал нь:** хүн ам зүйн үзэгдлүүдийн уялдаа холбоог нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй, социологи, антропологи, анагаах, газар зүй зэрэг бусад салбар шинжлэх ухаантай нягт уялдуулан судалдаг байна. Өөрөөр хэлбэл, хүн ам, төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнд гарч буй өөрчлөлтийг бусад нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлстэй хэрхэн уялдаж байгааг судалдаг. Хүн ам судлалын энэ агуулгыг схемчилбэл:



Товчхондоо хүн ам зүй нь хүн амын тоо, өсөлт, бүтцийг тодорхойлдог бол харин, хүн ам судлал нь эдгээрийг яагаад тухайн тодорхойлогдсон түвшинд байгааг нийгэм, эдийн засаг, түүх, соёл, орчны гэх мэт бусад олон хүчин зүйлстэй холбож тайлбарладаг ажээ.

### Хүн ам зүйн шинжлэх ухааны ач холбогдол

Хүн ам судлалын судалгааны ажлууд цэвэр хүн ам зүйн шинж чанартай, зарим нь эдийн засгийн буюу түүхийн шинж чанартай ч байдаг. Тиймээс ч эдийн засгийн хүн ам зүй, түүхийн хүн ам зүй гэх мэт ойлголтуудыг эрдэмтэд өргөн хэрэглэдэг байна. **Эдийн засгийн хүн ам зүйн** асуудалд хүн амын өсөлт, өөрчлөлт ба ажил эрхлэлт, ядуурлын уялдаа хамаарал, шилжилт хөдөлгөөн ба хотжилтын асуудлууд гэх мэт өргөн хүрээг хамарсан нэн чухал ойлголтууд багтдаг байна. Харин төрөлт нас баралтын хэв маягийг тодорхойлох соёл, уламжлалын асуудлууд нь антроплогийн хүн ам зүйн асуудалд ордог.

Түүнчлэн **зах зээл** судлал хүн ам зүйн хүчин зүйлийг хамгийн түгээмэл ашигладаг байна. Үйлчилгээний эрэлт хэрэгцээ нь хүн ам зүйн хандлагыг даган өөрчлөгдөх ба бүтээгдэхүүний зах зээлд бүтээгдэхүүнийг чухам хэнд зориулж үйлдвэрлэхээ тогтооход хэрэглэгдэх гол судалгаа нь хүн ам зүйн судалгаа юм. Түүнчлэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олох ашиг нь зөвхөн зах зээлийн багтаамж буюу хүн амын тооноос гадна хүн амын үндсэн шинж байдлаас ихээхэн хамаарна. Газар зүйн байрлал, бүтээгдэхүүн хэрэглээний өөрчлөлт, хэрэглэгчдийн орлого, нас, хүйс, боловсрол, гэр бүлийн амьдралын мөчлөг, нийгмийн гарал үүсэл гэх мэт хүн ам зүйн тодорхой үзүүлэлтүүдийг үндэслэн хэрэглээний зах зээлийг илүү нарийн, зөв тодорхойлж, хэрэглэгчдийн зорилтот бүлэг рүү тусгайлан чиглүүлэх хандлага сүүлийн үед өргөжиж байгаа ажээ.

**Хөрөнгө оруулалтын** хувьд ч хүн ам зүйн үзүүлэлтүүд чухал нөлөө үзүүлдэг байна. Тэр дундаа манай улсын эдийн засаг, үйлдвэрлэлийн зарим салбарт гадны хөрөнгө оруулалт онцгой анхаарал хандуулж байгаа энэ үед хөрөнгө оруулалтын хүн ам зүйн ач холбогдлыг мэдэх нь онцгой үр дүнтэй тул товчхон дурьдая. Хөрөнгө оруулалт нь эдийн засгийн өсөлтийн анхдагч нөхцөл байдаг байна. Аж ахуйн нэгжүүд шинэ бүтээгдэхүүн гаргах, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, зах зээлээ өөрчлөхийн тулд олсон ашгаараа хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад нөлөөлдөг олон хүчин зүйлийн нэг нь хүн ам зүйн үзүүлэлт буюу тэр дундаа ирээдүйн хүн ам зүйн өөрчлөлт байдаг.

Хөрөнгө оруулалтын талаар үндэслэлтэй шийдвэр гаргахын тулд ирээдүйг маш болгоомжтой харж, олон хувилбарыг урьдчилан тооцоолсны үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулах эхлэлийг тавьдаг. Хүн амын хэтийн тоо хэмжээ, бүтцээс хамааран хэнд зориулан борлуулалт хамгийн өндөр байх бүтээгдэхүүн үйлдвэрлэх вэ гэдгээ төлөвлөдөг байна.

Иймээс хөрөнгө оруулагчид зах зээлийн ирээдүйн өсөлт, хөгжил, ашиг олох боломжийг тодорхойлж буй хүн ам зүйн өөрчлөлтийг зайлшгүй анхаардаг байна.

Хүн амын судалгааны нэг чухал хэсэг нь хүн амын нас, хүйсийн бүтцийн судалгаа юм. Хүн амын нас, хүйсийн бүтцийг судлах нь нэг талаар бизнес, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарт шаардлагатай бодлого боловсруулах, төлөвлөлт хийх, нөгөө талаар хүн амын хүчин зүйлсийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөнд тусгахад ихээхэн ач холбогдолтой байна.

Хүн амын нас, хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой учраас түүнийг шинжлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Тухайлбал, сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, төрөх, шилжих гэх мэт. Түүнчлэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нь нас хүйсийн бүтцээс хамааран өөр өөр байдаг. Нас хүйсийн бүтцийн мэдээлэл нь нийгмийн чиг хандлагыг тайлбарлах, зах зээлийг тодорхойлох, ирээдүйн төлөвлөлт хийхэд чухал ач холбогдол үзүүлдэг. Мөн нийгмийн мөн чанар, функцийг ойлгоход чухал бөгөөд хүн амын түүхэн хөгжил хувьсал болон ирээдүйн хэтийн төлөвийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэнэ.

Хүн амын бүтэц нь хүн амын өсөлт, өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөс хамаардаг гэдгийг дээр дурьдсан билээ. Төрөлт, нас баралтын өндөр түвшин нь хүн ам залуужих үндэс болдог. Энэ нь хүүхэд болон залуучуудын эзлэх хувийн жин өндөр байна гэсэн үг юм. Төрөлт, нас баралт буурахын хэрээр хүн ам насжиж, насанд хүрсэн залуу, дунд болон ахимаг насны хүмүүсийн эзлэх хувийн жин өсдөг ажээ. Шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдсэнээр насанд хүрсэн залуусын хувийн жин эрс нэмэгдэхэд хүрдэг байна. Түүнчлэн дайн, улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал гэх мэт гэнэтийн үзэгдлийн үр дүнд зарим насны бүлгийн хүмүүсийн хувь багасна. Үүнийг тухайн үеийн төрөлтийн бууралт, нас баралтын өсөлт зэргээр тайлбарладаг байна.

Цаашилбал, хүн амын бүтэц нь бидэнд хүн амын ирээдүйн шинж байдлын талаар үнэтэй мэдээллийг өгнө. Жишээ нь, залуу насны бүтэцтэй хүн амын хувьд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувийн жин өндөр байдаг учраас хүн ам хурдацтай өсөх боломж бүрддэг. Түүнчлэн энэхүү байдал нь боловсрол болон ажил эрхлэлтийн салбарт хөрөнгө оруулалтыг тодорхой хугацаанд нэмэгдүүлэхийг шаардана. Өөрөөр хэлбэл, Төрөөс нийгэм, эдийн засгийн аливаа салбарт баримталж буй бодлогоо зөв тодорхойлох, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд өөрийн улсын хүн амын бүтцийн талаар үнэн зөв мэдлэг мэдээлэлтэй байх шаардлагатай юм. Нөгөөтэйгүүр, хүн ам насжихын хэрээр тэтгэвэр, эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт болон ажиллах хүчний нийлүүлэлтийн бууралтын асуудлууд зэрэг чухал асуудлуудад бодлого боловсруулагчид болон шийдвэр гаргагчдын зүгээс анхаарал хандуулах зайлшгүй шаардлага урган гардаг.

Монголын хүн амын хүн ам зүйн шинж байдлын талаарх цогц шинжилгээг хүн ам зүйч, эдийн засагч, нийгэм судлаачдад болон бодлого боловсруулагчдад хүргэж байх нь нийгэм, эдийн засгийн аливаа салбарын хөгжлийн хэтийн бодлого, төлөвлөгөөг боловсруулахад нэн чухал байх нь зайлшгүй юм.

## **1.2. ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДИНАМИК СУДАЛГАА**

### **1.2.1 Монголын хүн амын уламжлалт бодлого**

Монгол орны газар нутагт анхны төрт улс тогтсон үе буюу одоогоос 2000 гаруй жилийн өмнөөс хүн амаа бүртгэх, хүн амын бодлого баримтлах явдал эхлэлээ тавьжээ. Түүхийн энэ үеэс барьж ирсэн бодлого XII зуун, Чингис хааны үеэс улам боловсронгуй болж, хүн амын албан татвар авах, цэргийн алба хаалгах, нутаг бэлчээр хуваарилах зэрэг зорилгын



үүднээс хүн амаа аравт, зуут, мянгат, түмтийн зохион байгуулалтанд оруулж бүртгэх тогтолцоо бий болгосон байна. Дэлхий нийтийн хүн ам зүйн түүхэн зүй тогтолын дагуу хөгжлийн ерөнхий түвшнээс хамааран энэ үед хүн амын ердийн өсөлт тун доогуур байсан ба ялангуяа XII-XIV зууны бараг дэлхийн талыг хамарсан их байлдан дагуулалтын үрээр олон тооны хүн ам бусад улс орнуудад суурьшин, аажмаар тухайн үндэстэнд ууссан нь Монголын хүн амын өсөлтийг бууруулсан нэг хүчин зүйл болсон байна.

XVIII зууны сүүлчээр шарын шашин дэлгэрүүлснээр насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 1/3 нь лам болж, гэр бүл болоогүй эмэгтэйчүүдийн хувийн жин төдий хэмжээгээр нэмэгдэн, өрхийн бүтэц гажуудалд орон төрөлт туйлын доогуур түвшинд тогтож, хүн амын өсөлт зогссон байв. Мөн өвчлөл хэт нэмэгдэж, нас баралтын түвшин ихээхэн өндөр байв. Дээрхи үйл явцаас хамааран XX зууны эхэн хүртлэх 300 гаруй жилд Монголын хүн ам 2 дахин багасч, 1918 оны тооллогоор 647,5 мянган хүн бүртгэгдсэн байна.

Үүнээс хойш хүн амын өсөлт бага зэрэг нэмэгдсэн бөгөөд 1918-1950 оны хоорондох хүн амын өсөлтийн жилийн дундаж хурд дөнгөж 0,6 хувь байв. 1930-аад оны хэлмэгдүүлэлт, өвчлөлт, 1939, 1945 оны дайн самуунууд зэрэг нийгэм, улс төрийн тогтворгүй нөхцөлүүд нь шууд болон шууд бусаар нөлөөлж хүн амын өсөлтөнд нөлөө үзүүлж байсан томоохон хүчин зүйлүүд юм.

1950-иад оны дунд үеэс улс төрийн тогтворжилтоо даган нийгэм эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэх болсон нь нийгмийн бүх салбарт эерэг нөлөө үзүүлсэн. 1960-1980 оныг хүртэл Монголын хүн амын өсөлтийн хурд 3 хувь болсон байна.

1990-ээд оны социалист системийн орнуудыг хамарсан улс төр, нийгэм-эдийн засгийн тогтолцооны бүрэн өөрчлөлт нь Монголд нэгэн адил явагдсан бөгөөд зах зээлийн эдийн засагт шилжин, бараа бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт, инфляци, ажилгүйдэл зэрэг үзэгдэл нь улс оронд эдийн засгийн гүнзгий хямрал үүсгэн, өрх, хүн амын амжиргаа доройтох үндэс болсон. Энэ үеэс хүн амын өсөлтийн хурд буурч 1,5 хувьд хүрсэн байна. Статистикийн Ерөнхий газрын мэдээллээр дараах үзүүлэлтүүдээр **Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтийг** тооцдог байна. Үүнд:

	Хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүд
1	Суурин хүн амын тоо
2	Хүн амын жилийн дундаж өсөлт
3	Хүн амын дундаж наслалт
4	1000 хүн амд ногдох төрөлтийн тоо
5	Эхийн эндэгдэл
6	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл
7	Нас барсан хүний тоо
8	Гэрлэгсэд
9	Гэрлэлт цуцлуулсан хүний тоо
10	Өрхийн тоо

11	Бүтэн өнчин хүүхдийн тоо
12	Хагас өнчин хүүхдийн тоо
13	Үрчлэл зэрэг үзүүлэлтүүдээр гаргадаг.

**Сүүлийн 5 жилийн хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгтээр харуулбал:**

Үзүүлэлтүүд	2005	2006	2007	2008	2009
Суурин хүн ам /мян.хүн/	2562.4	2594.8	2635.2	2683.5	2735.8
Жилийн дундаж өсөлтийн хувь	1,2	1,3	1,6	1,7	1,9
Дундаж наслалт	65,21	65,85	66,54	67,23	67,96
Төрсөн хүүхдийн тоо /мян.хүн/	45,32	49,9	56,64	63,77	69,17
1000 хүнд ногдох төрөлт	17,8	19,0	21,7	24,0	25,5
Хүүхэд төрүүлсэн эхийн тоо	45,14	48,88	56,41	63,45	68,74
Эхийн эндэгдэл	92,7	67,2	88,3	48,6	81,0
Нялхсын эндэгдэл /амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох/	20,7	19,1	17,6	19,4	20,0
Нас барсан хүний тоо /мян.хүн/	16,48	16,682	16,26	15,41	16,911
1000 хүнд ногдох нас баралт	6,5	6,5	6,2	5,8	6,2
Гэрлэгсэд	14993	48996	40965	32982	34071
Гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо	1622	1448	1757	1901	2399
Өрхийн тоо /мян.өрх/	611,0	632,5	645,7	677,8	716,5
Бүтэн өнчин хүүхдийн тоо	5449	5276	5074	5018	4683
Хагас өнчин хүүхдийн тоо	47088	45729	44688	43088	41174
Үрчлэл	3797	2045	2446	2406	2167

**Эх сурвалж:** Монгол улсын хүний хөгжлийн илтгэл-2000

**1.2.2 Суурин хүн амын тоо:**

Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг харуулдаг. 2007 оны байдлаар дэлхийн хүн амын хагасаас илүү хувь нь хот суурин газарт амьдардаг болсон. Дэлхий нийт даяарчлагдаж буй өнөө үед суурин хүн амын тоо жилээс жилд харилцан адилгүй гарч байна. 2000 оноос хойш монголчуудын гадагшаа чиглэсэн хөдөлгөөн ихэссэн бол сүүлийн жилүүдэд Монголыг зорьсон гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн ихэссэн байна.

1993 оны “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулиар 15,000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газрыг хот, 500-15,000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал, жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг тосгон гэж тодорхойлсон. Дээрхи хот, тосгоны тодорхойлолтуудад хамрагдахгүй хүн амыг



хөдөөгийн хүн ам гэж үздэг. Суурин хүн амын өсөлтийг хавсралтаас үзнэ үү.


Хүснэгтээс харахад Монгол Улсын суурин хүн 1990 онд 2149.3 байсан бөгөөд хотын хүн ам 905,9 буюу 42,1%-ийг, хөдөөгийн хүн ам 1197,4 буюу 55,7%-ийг эзэлж байсан байна. Харин 2000 онд 2407.5 болж өссөн бөгөөд үүнээс хотын хүн амын тоо 1377,0 буюу нийт хүн амын 57,2%-ийг эзэлж өссөн байхад хөдөөгийн хүн ам 1030,5 болж буурч нийт хүн амын 42,8% болж буурсан байна. 2009 оны байдлаар нийт хүн ам 2735.8 болж өссөн бөгөөд үүнээс хотын хүн ам 1713,3 буюу 62,6% болж өссөн, хөдөөгийн хүн ам 1022,5 буюу 37,4% болж буурсан байна. Үүнээс харахад нийгэм, эдийн засгийн байдал, хөдөөгийн малчин өрхийн амьжиргааны түвшин, дэд бүтэц зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан хүн амын хотруу шилжих хөдөлгөөн жилээс жилд өсөн нэмэгдэж байгааг харуулж байна.

1990 оноос хойш хорин жилийн хугацаанд зургаан зуу мянган орчим хүн амаар нэмэгдсэн бөгөөд үүнээс 1990 онд нийт хүн амын 42,1 хувийг хотын хүн ам эзэлж байсан бол 2009 онд нийт хүн амын 62,6 хувийг эзлэх болж 20 хувиар өссөн байна. Харин хөдөөгийн хүн ам 1990 онд 55,7 хувь байсан бол 2009 онд 37,4 хувь болж 19 орчим хувиар буурсан байна. Сүүлийн жилүүдэд хотруу шилжих хөдөлгөөн эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор маш олон асуудал урган гарч байна. Тухайлбал, эрүүл мэндийн асуудал, боловсрол, хүнсний хангамж, орон сууцны асуудлууд урган гарч нийслэлийн болон Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Төрөөс хөдөө, орон нутгийг хөгжүүлэх зорилгоор бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал баталж, хэд хэдэн худалдааны чөлөөт бүсийг байгуулсан боловч хотыг чиглэсэн их нүүдэл багасахгүй байна.


**1.2.3 Хүн амын тоо:** Хүн амын тоог хамгийн сүүлд явагдсан хүн ам, орон сууцны тооллогын дүн, суурин хүн амын тоо, ердийн болон шилжих хөдөлгөөний талаарх албан ёсны статистик мэдээллээс гадна “Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх алба”-аас Монгол Улсад оршин суугаа гадаадын мэргэжилтэн, ажилчдын тоо, Батлан хамгаалах яамнаас жагсаалын цэргийн тоо, Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газраас хорих болон баривчлах ял эдэлж байгаа хүний тоо, гадаад хэргийн яамнаас Монгол улсаас гадаадад байнга суугаа иргэдийн тоо, Эрүүл мэндийн яамнаас нялхсын нас баралтын тухай мэдээллийг авч нэгтгэн, түүний үндсэн дээр хүн амын тоог жил бүр тооцоолон гаргаж байна.

Монгол Улсын хүн ам XX зуунд бараг дөрөв дахин өсчээ. Монгол Улс 1918 онд 647.5 мянган оршин суугчтай байсан бол 2009 оны эцсийн байдлаар 2,735,780-д хүрч өссөн байна. Хүн амын өсөлтөд чухал нөлөө үзүүлсэн үе нь 1960 ба 1970-аад онуудад явагдсан бөгөөд тухайн үед хүн амын жилийн дундаж өсөлтийн коэффициент 3 хувьд дөхөн очиж хүн ам 25 хүрэхгүй жилийн дотор хоёр дахин өссөн юм. Хүн ам зүйн өндөр, тогтвортой өсөлтийн жилүүдэд хүн амд маш олон залуучууд нэмэгдсэн. Ардчилал ба зах зээлийн эдийн засгийн шилжилт явагдаж эхэлсэн 1990 оноос хойш хүн амын өсөлт буурсан нь үндсэндээ төрөлтийн огцом бууралтын үр дүн байв.

**Хүн амын тоо, жилийн өсөлтийн хувь**



Эх сурвалж. Монгол Улсын статистикийн эмхтгэл - 2009 он

**Хүн амын өсөлт /Сүүлийн 50 жил/**

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл 1994 - 2009 он

1918-2009 оныг хүртэлх 32 жилийн хугацаанд жил бүр өссөн дүнтэй байна. Өсөлтийн хурд нь харилцан адилгүй боловч хүн амын тоо буурсан жил байхгүй байна. Өнгөрсөн 32 жилийн хугацаанд хүн амаа өсгөх янз бүрийн бодлогыг хэрэгжүүлж байсан. Сүүлийн жилүүдэд хүүхдийн мөнгө өгөх арга хэмжээг төр засгаас хэрэгжүүлж эхэлснээр төрөлт нэмэгдэж хүн амын өсөлтийн хувь нэмэгдсэн байна. *Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.*

**1.2.4. Хүн амын нас, хүйсийн бүтэц:** Дэлхийн хүн амын насны бүтэц жилээс жилд хувьсан өөрчлөгдөж байна. Энэхүү өөрчлөлт нь хүн амын төрөлт, нас баралтын эрчимтэй бууралт, тухайн нийгмийн эдийн засгийн хөгжлийн хувьсал өөрчлөлтөөр тайлбарлагдах "Хүн ам зүйн шилжилт"-тэй салшгүй холбоотой. **Хүн ам зүйн шилжилт гэдэг нь** төрөлт, нас баралтын өндөр түвшинтэй уламжлалт-хөдөө аж ахуйн эдийн засгаас төрөлт, нас баралтын түвшин багатай аж үйлдвэржсэн орчин үеийн эдийн засаг руу шилжих үйл явц бөгөөд хүн ам зүйн шилжилтийн үр дүнд аливаа улс орны хүн амын насны бүтэц залуужих, идэрших, хөгшрөх хандлагатай болж, нийт хүн амд эзлэх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид, хөгшчүүдийн эзлэх хувийн жингийн өөрчлөлтүүд хурдацтай явагддаг байна<sup>5</sup>.

Хүн амын насны бүтцийн хэв маяг нь хүн амын нөхөн үржихүйн цаашдын хандлагыг тодорхойлохоос гадна улс орны эдийн засгийн нэг гол хөшүүрэг болох ажиллах хүчний түвшин, төлөвийг харуулдаг чухал үзүүлэлт юм.

**Монгол Улсын хүн амын насны бүтцийн зарим үзүүлэлтүүд<sup>6</sup>:**

Үзүүлэлтүүд	1979	1989	2000	2005	2010	2015	2020	2025
Нийт хүн ам /мян. хүн/	1595,0	2044.0	2373.5	2562.4	2741.8	2918.6	3087.0	3230.0
Нийт хүн амд эзлэх хувь								
0-14	44.3	41.9	35.8	32.6	27.5	26.2	24.7	22.8
15-59	48.5	52.3	59.0	61.9	66.7	67.3	67.1	66.4
60-64	2.3	1.8	1.8	2.0	1.5	2.4	3.5	4.5

<sup>5</sup> Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийн үр дагавар: хүн ам зүйн цонхны үе, түүнийг ашиглах боломж - Илтгэл - Ц.Болормаа /Док/, Б. Наранчимэг - МУИС

<sup>6</sup> Хүн ам, хөгжлийн тулгамдсан асуудлууд - Лавлагаа, мэдээллийн багц-УБ, 2010, 23 дах тал

65+	4.9	4.0	3.4	3.5	4.0	4.1	4.7	6.3
Насны голч	17.3	18.6	21.6	22.7	25.4	27.8	30.2	32.5
Хүн амын ачаалал	99.1	86.0	64.4	56.6	45.9	43.6	41.8	40.9
Хүүхдийн ачаалал	88.8	78.3	58.9	51.1	40.1	37.6	35.1	32.1
Хөгшчүүдийн ачаалал	10.3	7.7	5.7	5.5	5.8	5.9	6.8	8.8
Насжилтын индекс	11.5	9.9	9.7	10.8	14.5	15.8	19.3	27.4
Асран халамжлагчын харьцаа	72.5	72.3	58.1	-	-	-	-	-

**Эх сурвалж:** Хүн ам, хөгжлийн тулгамдсан асуудлууд - Лавлагаа, мэдээллийн багц

Хүснэгтээс харахад 2005 оноос эхлэн 15-аас доош насны 100 хүүхдэд ногдох 65 ба түүнээс дээш насны хүн ам аажмаар нэмэгдэж, 2015 оноос эхлэн өсөлт бага зэрэг эрчимжих шинжтэй байна.<sup>7</sup>

0 - 14 насны хүүхдийн өсөлт 1979 онд өндөр байсан бол 2000 оноос буурч 2025 он гэхэд нийт хүн амд эзлэх хувь нь 22 хувьд хүрч байна. 2025 он гэхэд хүн амын төрөлтийн түвшин буурч дундаж наслалт нэмэгдэн залуу насны хүн амын эзлэх хувийн жин буурахаар байна.

Аливаа улс орны хүн амд хөгшин насны хүн амын эзлэх хувь 10 хувиас давсан тохиолдолд тухайн улсын хүн ам хөгширч байна гэж үздэг байна. Онолын энэ ойлголтын үүднээс авч үзвэл, Монгол Улсын нийт хүн амд эзлэх 60 ба түүнээс дээш настай хүн амын хувийн жин 2025 оноос эхлэн 10 хувиар дээгүүр байхаар тооцоологдож байгаа нь энэ үеэс хүн амын насжих үйл явц эрчимтэй явагдаж эхэлнэ гэсэн үг юм.<sup>8</sup>

Хүн амын төрөлтийн бууралт, дундаж наслалтын өсөлт нь хүн амын насны бүтэц, тархалтыг ихээхэн өөрчилнө. Тодруулбал, эдгээрийн үр дүнд залуу насны хүн амын хувийн жин буурч, ахимаг насны хүн амын хувийн жин өсөх болно. 0-14 насны хүн ам 2008 онд нийт хүн амын 29,1 хувийг эзэлж байгаа бол 2030 онд 22,9 хувь болон буурчээ. Харин 65 ба түүнээс дээш насны хүн амын хувийн жин 2 дахин өсч 3,7-7,6 хувь болохоор байна. Түүнчлэн 15-39 насны хүн амын хувийн жин 2008-2030 онд 46,9-38,3 болон аажим буурч, 40-64 насны хүн амын хувийн жин 20,6-31,5 болон өсч байна. Энэ нь хэрвээ ажлын байрыг нэмэгдүүлж, хөдөлмөрийн насны хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулж чадахгүй бол тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын ачаалал ирээдүйд нэмэгдэхээр байна.<sup>9</sup>

Нийт хүн амын хүйсийн харьцаа /100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо/ хэтийн тооцооны хугацаанд үл ялиг буурч байгаа бол төрөх үеийн хүйсийн харьцаа тогтвортой байна. 65 ба түүнээс дээш насны хүн амын хувьд хүйсийн харьцаа тогтвортой буурч байгаа нь эмэгтэйчүүдийн дундаж наслалт эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад өндөр байдагтай холбоотой юм.

<sup>7</sup> Хүн ам, хөгжлийн тулгамдсан асуудлууд-Лавлагаа, мэдээллийн багц - УБ, 2010, 24 дах тал

<sup>8</sup> Хүн ам, хөгжлийн тулгамдсан асуудлууд-Лавлагаа, мэдээллийн багц - УБ, 2010, 24 дах тал

<sup>9</sup> Монгол улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо-УСХ. 2008 он. 10 дах тал

Насны бүтцийн өөрчлөлтийн хандлага аймаг, нийслэлийн хүн амын хувьд ч гэсэн ажиглагдаж байна. Хүн амын төрөлтийн эрчимтэй бууралт, дундаж наслалтын аажим өсөлтийн улмаас бүс нутгийн болон аймаг, нийслэлийн хүн амын насны бүтцэд залуу насны хүн амын эзлэх хувь багасч, хөдөлмөрийн насныхан болон хөгшин насны хүн амын эзлэх хувийн жин нэмэгджээ. Хэтийн тооцооноос харахад<sup>10</sup> манай улсын нийт хүн амын өсөлтийн хурд 2010-2020 онд 1,35 хувь, 2020-2030 онд 1,02 болж буурах хандлага ажиглагдаж байна. Нийт аймгуудын хувьд хүн амын өсөлтийн хурд улсын нийт хүн амынхтай адил ирэх онуудад аажмаар буурах тооцоо хийсэн байна.

он	Дундаж наслалын индекс	Дундаж наслалт (төрөлтөөс тооцсон)
1990	0,645	63,7
1992	0,638	62,8
1995	0,647	63,8
1998	0,669	65,1
1999	0,636	63,2
2000	0,636	63,2
2001	0,639	63,4
2002	0,642	63,5
2003	0,644	63,6
2004	0,660	64,6
2005	0,670	65,2
2006	0,681	65,9

Статистикийн ерөнхий газрын мэдээлэл болон хүн амын хөгжлийн үзүүлэлтүүдээс харахад сүүлийн 10-20 жилд хүн амын насжилт уртасч байгааг дээрхи хүснэгтээр харуулав. 1990 онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хүн амын амьдрах хэв маяг өөрчлөгдөж хүн амын наслалт богиноссон бөгөөд эдийн засгийн байдал сайжирч байгаатай холбогдон хүн амын насжилт уртасч байна. Нөгөө талаар, хүн амын эрүүл мэндийн боловсрол нэмэгдсэнтэй холбоотой юм. Хүн амын насны бүтцийн өөрчлөлт, хүн амын насжих үйл явц нь нийгэм эдийн засагт, ялангуяа нийгмийн хамгааллын салбар, нийгмийн нөөцийн хуваарилалт, хяналтад ихээхэн нөлөөлөл үүсгэдэг. Иймд манай улсын хүн амын насны бүтэц өөрчлөгдсөнөөр нийгмийн хамгаалалын салбарт зарим үйлчилгээний хэрэгцээ тулгамдсан асуудал болоод байна.

Үзүүлэлт	Насны бүлэг	Тоо хэмжээ /мян.хүн/	200 онтой харьцуулсан өөрчлөлт		
			2015	2020	2025
Нийгмийн халамж, асран хамгаалал					

<sup>10</sup> ҮСХ-оос 2008 онд хийсэн “Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо”

<b>Тэтгэврийн насны эрэгтэй хүн ам</b>	60+	55,4	86,9	116,1	158,8	+1,6 дахин	+2,1 дахин	+2,9 дахин
<b>Тэтгэврийн насны эмэгтэй хүн ам</b>	55+	98,5	163,8	218,6	275,7	+1,7 дахин	+2,2 дахин	+2,8 дахин
<b>Эрүүл мэндийн хэрэглээ</b>								
<b>Хүүхдүүд</b>	0-14	854.9	764.9	763.1	736.0	-1.1 дахин	-1.1 дахин	-1.2 дахин
<b>Насанд хүрэгчид</b>	15-59	1409.6	1962.4	2069.5	2146.6	+1.4 дахин	+1.5 дахин	+1.5 дахин
<b>Төрөх насны эмэгтэйчүүд</b>	15-49	650.9	846.4	871.7	890.6	+1.3 дахин	+1.3 дахин	+1.4 дахин
<b>Өндөр настан</b>	60+	125.1	191.3	254.4	347.3	+1.5 дахин	+2.0 дахин	2.8 дахин

**Эх сурвалж:** Хүн ам, хөгжлийн тулгамдсан асуудлууд - 2010, УБ Тайлбар: (+) өснө, (-) буурна

Харин хүн амын хүйсийн харьцааны хувьд харьцангуй тогтвортой байна. Гэвч сүүлийн жилүүдэд монгол залуучууд гадаад руу суралцах болон ажиллахаар явж байгаатай холбоотойгоор хүйсийн бүтэц алдагдаад байгаа билээ. Гадаад руу явж байгаа эрэгтэйчүүдийн ихэнх нь аль нэг улсад ажиллахаар, эмэгтэйчүүдийн ихэнх нь суралцах болон, гадаадын иргэнтэй гэр бүл болж байна. Тухайлбал, БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ГАХИТ-ийн шугамаар явсан 7105 хүнийг хүйсийн байдлаар авч үзвэл эрэгтэй-6260, эмэгтэй-845 хүн явсан байна. Энэхүү тоо баримтаас харахад л Монгол улсын хүн амын хүйсийн харьцаа хэрхэн механикаар өөрчлөгдөж байгааг харж болохоор байна. Мөн түүнчлэн эмэгтэйчүүдийг бодвол эрэгтэйчүүдийн нас баралт өндөр байдагтай холбоотойгоор ирээдүйд настай хүмүүсийн ихэнхи нь эмэгтэйчүүд байхаар хэтийн төлөв гаргасан байна.

#### 1.2.5. Хүн амын төрөлт

- Төрөлтийн ерөнхий коэффициент нь 1000 хүн ам тутамд ногдох тухайн жилд төрсөн амьд хүүхдийн тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулдаг.
- Төрөлтийн тусгай коэффициент нь төрөх насны /15-49 нас/ 1000 эмэгтэйчүүдэд ногдох амьд төрөлтийн тоог илэрхийлдэг үзүүлэлт юм.
- Төрөлтийн нийлбэр коэффициент нь нэг эмэгтэй хүний тоог нас барсан эмэгтэй хүний тоонд харьцуулсан харьцааг ойлгоно.

Монгол улсад төрөлтийн түвшин 2006 оноос эхлэн нэмэгдэх хандлагатай болж, 2007 онд 18,5 хувиар, энэ оны эхний хоёр сар тутамд 30 гаруй хувиар нэмэгдэж байгаа тоо гарчээ. Төрөлт нэмэгдэхийн хэрээр яригдах нэг асуудал нь эхийн эндэгдэл. Хэдийгээр Мянганы хөгжлийн зорилтод тусгасны дагуу эхийн эндэгдлийг 1000 хүн тутамд 85 хүртэл бууруулах ёстой ч одоогийн байдлаар энэ тоо 90-95 байна.


Төрөлт, жирэмслэлтийн улмаас нас барж буй эмэгтэйчүүдийн тоо дэлхий нийтэд 34 хувиар буурсан бол манай улсад 1990 оныхтой харьцуулахад дөрөв дахин багасч, эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд шилжсэн байна. Тухайлбал, 1990 онд 200, 2000 онд 158, өнгөрсөн онд 27 эх эндсэн бол энэ оны эхний найман сарын байдлаар 18 эх нас барсан аж.

Сүүлийн жилүүдэд манай оронд нийгэм, эдийн засгийн харилцаанд гарсан өөрчлөлттэй уялдан эмэгтэйчүүд, хосуудын төрөлтдөө хандах хандлага өөрчлөгдөж, төрөлтийн түвшний бууралт нас баралтаас түрүүлж эхэлсэн. Тухайлбал, 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 1990-2006 онд 34,4-19,0 болтлоо бараг 2 дахин, 1000 хүн амд ногдох нас баралт мөн хугацаанд 8,3-6,5 хүртэл 30 орчим хувиар буурсан.

Төрөлтийн дээд хувилбарын төсөөллөөр төрөлтийн нийлбэр коэффициент /ТНК/ аажим буурч, 2025-2030 онд нэг эмэгтэйд 2,17 хүүхэд, дунд хувилбарын хувьд дээд хувилбараас илүү хурдацтай буурч, 5 жилээр түрүүлэх бөгөөд 2025 оноос 2,0 болж тогтворжихоор байна. Харин доод хувилбарт ТНК-ийг ирээдүйд ажиглагдаж болох хамгийн баг түвшин буюу хугацааны эцэст 1,8 болохоор байна гэсэн Үндэсний статистикийн хорооноос хэтийн тооцоо гаргасан байна. Насны бүлэг дэх төрөлтийн түвшинг сүүлийн жилүүдийн динамикт үндэслэн үзвэл 20-30 насны эмэгтэйчүүдэд төрөлтийн хувь өндөр байна.

Судалгаанаас үзэхэд эхийн эндэгдлийн гол шалтгаан нь жирэмслэлттэй хавсарсан эрхтэн тогтолцооны эмгэг өвчний сэдэрлэлт, цус алдалт, жирэмсний хожуу үеийн хордлогын хүндрэл, үжил халдвар, умайн урагдал зэрэг орж байна. Түүнчлэн нийт хүн амын эрүүл мэндийн боловсрол, жирэмсний хүндрэлийн талаарх ойлголт мэдлэг хангалтгүй, жирэмсний хяналт болон төрөх үеийн тусламж, үйлчилгээ жигд сайн биш, хөдөөгийн хүн амын тархай бутархай амьдардаг, төрийн үйлчилгээний уялдаа холбоо муу зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Мөн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 45 хувь нь эрхтэн тогтолцооны эмгэгтэй, төрсөн эхчүүдийн 33,8 хувь нь жирэмсний хугацаанд ямар нэгэн хавсарсан өвчнөөр өвчилсөн байгаа нь ч голлох шалтгаан болсон хэвээр байна

Улсын хэмжээнд амьд төрсөн хүүхдийн тоо 2010 оны эхний долдугаар сарын байдлаар 39227 болж өмнөх оны мөн үеийнхээс 374 хүүхдээр буюу 2.2 хувь, амаржсан эх 39063 болж, 911 эхээр буюу 2.3 хувиар тус тус буурсан байна. Түүнчлэн нэг хүртэлх насандаа 791 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс зургаан хүүхдээр буюу 0.8 хувиар, эхийн эндэгдэл 16 болж, 10 эх буюу 38.5 хувиар тус тус буурч, 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 215 болж, 93 хүүхэд буюу 76.2 хувиар нэмэгджээ.



Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхтгэл 1994-2009 он

#### 1.2.6. Гэрлэлт, гэрлэлтээ цуцлуулсан хүний тоо

- Гэрлэлт. Тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжид гэр бүл болсноо бүртгүүлсэн хүмүүсийг гэрлэсэнд тооцно.
- Цуцлалт: Гэрлэлтээ зохих шатны шүүхээр цуцлуулж, цуцлалтаа бүртгүүлсэн бол гэр бүлээ цуцалсанд тооцно.


2009 онд нийт 34,1 мянган хос гэрлэлтээ бүртгүүлж, 2,4 мянган гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан байна. Гэрлэлт өмнөх оныхоос 3,3 хувиар, гэр бүл цуцлалт 26,2 хувиар өссөн байна. Харин 1000 хүн амд ногдох гэрлэлт 2007 оноос буурч байсан бол 2009 оноос 12,6 болж өссөн байна. 1000 хүнд ногдох гэр бүл цуцлалт 2006 оноос аажмаар өсч, 2009 онд 0,9 болж өссөн байна.

Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009
• Гэрлэлт	14993	48996	40965	32982	34071
• Цуцлалт	1622	1448	1757	1901	2399

## 1.2.7. Нас баралт

**Нас баралтын ерөнхий коэффициент.** Энэ нь 1000 хүн ам тутамд ногдох тухайн жилд нас барсан хүний тоог илэрхийлдэг бөгөөд түүнийг тооцохдоо нас барсан хүний тоог тухайн жилийн дундаж хүн амд харьцуулж 100-аар үржүүлдэг.

Он	Төрөлт	Нас барсан хүний тоо	
		Бүгд	Нялхас
1989	73593	17000	4718
1995	54293	16794	2411
1996	51806	17550	2072
1997	49488	16980	1962
1998	49256	15799	1680
1999	49461	16105	1846
2000	48721	15472	1596
2001	49658	15999	1464
2002	46922	15857	1390
2003	45723	16006	1051
2004	45501	16404	1016
2005	45326	16480	938
2006	49092	16682	937
2007	56636	16259	994
2008	63768	15413	1240
2009	69167	16911	1386



Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхтгэл 1994-2009 он



Хүснэгтээс харахад 1989 оныг хүртэл төрөлт өндөр байсан бөгөөд 1990 оны өөрчлөлт шинэчлэлттэй холбоотойгоор төрөлт багассан бөгөөд нас баралт өндөр хэвээр байсан байна. Хэдий төрөлт өндөр хувьтай байсан боловч нялхасын эндэгдэл өндөр байсан байна. 1990 оноос буурсаар 2007 оныг хүртэл тогтмол буурсан байна.

2007 оноос хүүхдийн мөнгө өгч эхэлсэн, мөн нийгэм эдийн засгийн байдал сайжирч эхэлсэнтэй холбоотойгоор төрөлт нэмэгдсэн бөгөөд нас баралтын хэмжээ ч багассан байна. Харин нялхасын эндэгдлийн хувьд төрөлтөд оногдох хувийн хувьд нэгэн жигд байсаар байна. Нас баралт буурч байгаа нь хүн амын эрүүл мэндийн боловсрол дээшилж байгаатай холбоотой юм. Монгол Улсын Статистикийн ерөнхий газраас гаргасан хэтийн төлөв байдлаас харахад Монгол улсын хүн амын насжилт уртасч байна гэсэн тооцоололоос харж болно. Энэ тухай хүн амын насжилт хэсгээс үзнэ үү.

**Өрхийн тоо:** Өрх гэж нэг орон байранд амьдардаг, нэг төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

Он	1969	1979	1989	1990	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Өрхийн тоо	252.3	311.0	427.8	449.4	514.1	517.7	531.1	535.3	541.1	554.0	559.6	568.6	585.6	596.4	611.0	632.5	645.7	677.8	716.5
Нэг өрхөд ногдох хүний тоо	4.7	5.1	4.8	4.8	4.5	4.5	4.5	4.5	4.4	4.3	4.4	4.4	4.3	4.2	4.2	4.1	4.1	4.0	3.8

**Эх сурвалж:** Монгол Улсын статистикийн эмхтгэл 1994-2009 он

Дээрхи хүснэгтээс харахад Монгол Улсын өрхийн тоо жил бүр өсөлттэй гарсан байна. 2006 оноос төрөөс шинэ гэр бүлийг дэмжих зорилготойгоор шинээр гэр бүл бологсдод нэг удаа 500,000 төгрөг олгох болсонтой холбоотойгоор гэр бүл бологсдын тоо нэмэгдсэнээр өрхийн тоо ч нэмэгдсэн байна. Харин нэг гэр бүлд ногдох хүн амын тоо нь эсрэгээрээ жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна. 1979 онд өсөлт өндөр байгаа нь энэ үед монголын хүн амын төрөлт өндөр байсантай холбоотой юм. 1990 оноос нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын тэр дундаа эмэгтэйчүүдийн боловсролын байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор төрөлт жил ирэх тусам багассантай холбоотой юм.

2009 оны байдлаар нэг өрхөд ногдох хүн амын тоо 3.8 болсон нь гэр бүл дэх хүүхдийн тоо цөөрсөнийг харуулж байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хүүхэдтэй гэр бүлийн дийлэнхи нь 1 хүүхэдтэй байгааг харуулж байна. 2 болон түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийн эзлэх хувийн жин багассаныг харуулж байна. Тиймээс залуу гэр бүлийг дэмжих, төрөлтийн түвшин нэмэгдүүлэх арга хэмжээг төрөөс нарийн дэс дараалалтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

### 1.3. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДИНАМИК СУДАЛГАА

Дэлхийн хүний хөгжлийн илтгэлийг 1990 оноос эхлэн НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд анх хэвлэж эхэлжээ. Энэхүү цуврал илтгэлүүд нь хүний хөгжлийн үзэл баримтлалыг анхлан боловсруулагч Пакистаны нэрт эдийн засагч Махбуб Алл Хакийн санаачилга, хүчин зүтгэлээр бодит биелэлээ олсон байна. Тэрээр НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрт 1989 оноос эхлэн ажиллаж, хүний хөгжлийн талаарх өөрийн үзэл баримтлалаа шингээсэн эхний цуврал таван илтгэлийн сэдэв, агуулгыг боловсруулсан. Чухам энэ үеэс



хүний хөгжлийн үзэл баримтлал дэлхий даяар тархах үндэс суурь тавигджээ.

Монголын ард түмэн өнө эртний баялаг түүхтэй ба нийгэм, эдийн засгийн асар их амжилт олсон. Гэхдээ хүний хөгжлийн талаас нь авч үзвэл феодалын харилцааны сөрөг нөлөө ул мөрөө үлдээсэн гэж хэлж болно. Социализмын үед хүний хөгжлийн үндсэн гол үзүүлэлтүүдээр Монгол улс асар хурдан үсрэлт хийсэн бөгөөд энэ нь амьдралын баталгаа, үнэ төлбөргүй эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол олгох асуудлыг бүхэлд нь төр хариуцаж ирсэнтэй холбоотой.

**Хүний хөгжил гэдэг** нь нэг талаас хүний бүх боломжийг бүрдүүлэх, эрүүл мэндээ сайжруулах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, нөгөө талаас өөрийн олж авсан боломжоо ахуй амьдралдаа ашиглах, соёл, урлаг, нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох оролцооны нэгдэл юм.

Эдүгээ олон улсын шинжээчид, ялангуяа эдийн засагчид нэг хvнд ногдох ДНБ хэмээх индексийг өргөн ашиглаж байна. /GDP index гэнэ, PPP-р хэмжинэ/ Энэ үзүүлэлтийг ОУВС, Дэлхийн банк /ДБ/ болон АНУ-ын Тагнуулын төв газар өөр өөрийн аргачлалаар тооцно.

Тухайн орны хvн амын боловсролын түвшин нь хөгжлийн чухал индикатор юм. Улс орны хөгжлийг илэрхийлэгч гойд чухал үзүүлэлт нь тухайн оронд амьдарч буй хvний хөгжлийн индекс /HDI- human development index/ билээ. 2006 оны байдлаар Монгол улс дэлхийн 179 орноос 112-д оржээ. Манай HDI нь өмнөх оныхоосоо 0,006-гаар өсөж 0,720 болсон байна.

Хүний хөгжлийн индексээс гадна сүүлийн жилүүдэд дараах үзүүлэлтүүдийг гаргадаг болсон.

- Тухайн улс орны ардчилалын индекс
- Хүүхдийн хөгжлийн индекс
- Хүний ядуурлын индекс
- Жендерийн хөгжлийн индекс гэсэн үзүүлэлтүүдийг улс орнууд гаргаж тайлагнах болсон.

*Улс орны хөгжилд ардчиллын индекс /Democracy index - DI/ тун чухал. Ардчиллын индекс нь өгсөх дарааллаар 10 хүрэх ба 8,0-10,0 бол бүтэн ардчилалтай орон,...6,0-7,9 бол сэвтсэн ардчилалтай,...4,0-5,9 бол холимог ардчилалтай, 3,9-өөс доош бол авторитари дэглэмтэй гэнэ. 2008 оны зэрэглэлээр Монгол Улс 6,60 оноогоор сэвтэй ардчилал бүхий орон хэмээгдэж, 167 орноос 58-д / хоёр дахь бүлэг улсууд/ жагсжээ. Швед 9,88 оноо-гоор тэргүүлж, Хойд Солонгос 0,86 оноогоор сүүлд нь орсон байна. Манай бүлэгт Тайвань, Израиль, Унгар, Словак, Польш, Латви, Таиланд, Молдави, Малайз гэхчлэн 50 орон орсон байна.*

*Хvvvхдийн хөгжлийн индекс /child development index-CDI / гэж тусдаа юм. Агуулга нь бага насны хvvvхдийн эрvvл мэнд, хоол тэжээлийн хангалт, боловсролын түвшинг харгалзана. CDI нь 100 хүртэлх оноогоор тодорхойлогдох ба багасах тусмаа сайн. 2006 оны байдлаар Монгол Улс дэлхийн 140 орноос 58-д оржээ. Хувьд шилжvvлж харвал 100 улстай уралдааны 41-д явна. 1990-1994 онд хийсэн судалгааг 2001-2006 онд хийсэн судалгаатай харьцуулахад манай улсын хvvvхдийн хөгжлийн индекс нь 18,1-ээс 9,12 болж эрс сайжирсан байна. Дэлхийд Япон 0,41 оноогоор нэгд, Нигер 58,47-р жагсаалтын сүүлд оржээ.*

*Хүний ядуурлын индекс:* Хүний хөгжлийн индексээр хүний хөгжлийн хүрсэн түвшинг хэмждэг бол хүний ядуурлын индекс 1 (**ХЯИ-1**)-ээр хөгжиж буй орнуудад хүний хөгжлийн түвшин нь хангагдаагүй хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жинг тооцдог. Хүний хөгжлийн индекс нь хүний амьдралд гарсан ахиц дэвшлийг хэмждэг бол хүний ядуурлын индекс нь

хүний хөгжил дэх доройтлыг дор дурьдсан гурван үндсэн үзүүлэлтээр хэмждэг байна. Үүнд: Эрүүл урт удаан амьдралыг 40 хүртэлх насандаа нас барах магадлалтай хүн амын хувийг тооцох замаар харьцангуй залуу насандаа нас барах эмзэг байдлын үзүүлэлтэд тулгуурлан хэмждэг.

Мэдлэг боловсролын түвшинг хүний унших, харилцаа холбоонд оролцох боломжид нь нөлөөлж, гадаад ертөнцөөс тусгаарлаж байдаг бичиг үсэгт тайлагдаагүй хүн амын үзүүлэлтээр хэмжинэ.

Амьжиргааны түвшинг эдийн засгийн хувьд хүрэлцээгүй байдалд амьдарч буйг харуулах үзүүлэлтүүд болох цэвэр усаар дутагдаж буй хүн амын эзлэх хувийн жин ба жин дутуу хүүхдийн эзлэх хувийн жин гэсэн хоёр үзүүлэлтийн дунджаар хэмждэг.

Ерөнхийдөө эрүүл мэндийн хүртээмжийн үзүүлэлтүүд хүний амьжиргааны түвшинг хэмжиж буй үзүүлэлтэд тусгагдсан юм. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн талаар хангалттай тоон мэдээлэл байдаггүй учраас сүүлийн хоёр үндсэн үзүүлэлтийг ашиглаж жингийн дутагдалтай 5 хүртэлх настай хүүхдийн хувийн жин, ундны цэвэр усны хэрэглээний дутагдалтай хүн амын хувийн жинг тус тус ашиглан тооцож болно.

Монгол улс зах зээлийн эдийн засаг, ардчилалд түргэн шилжсэнээр эрх чөлөө болон хүний эрх хэмжээлшгүй нэмэгдсэн. Гэвч нийгмийн үйлчилгээний түвшин санаа зовохуйц хэмжээнд хүртэл доройтож, ерөнхийдөө хүмүүсийн амьдралын баталгаа сулрав. Монгол улсын хүний хөгжлийг 1990 оноос өмнөх болон хойшхи хүний эрх гэж авч үзвэл:

**1990 оноос өмнөх үеийн хүний хөгжил:** 1990 он хүртэлх социализмын жилүүдэд эрүүл мэнд, боловсрол, жендэрийн тэгш байдал, боловсрол, нийгмийн хамгаалал, хүний аюулгүй байдал зэрэг салбарт амжилт олсон байна. Хүний хөгжлийн үүднээс авч үзвэл, социализмын үеийн гол ололтууд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын салбарт гарчээ. Мөн энэ үед жендэрийн тэгш байдлын талаар амжилт олсон байна. Квотын системийг хэрэгжүүлэх замаар шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангаж байв. Хүний хөгжлийн үүднээс, социалист тогтолцооны хамгийн учир дутагдалтай тал нь хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж байсан явдал юм. Нэг намын үзэл суртлын тогтолцоо хувь хүний үг хэлэх эрх, улс төрийн оролцоог хязгаарлаж байв. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө ч хориг хязгаартай байлаа.

**1990 оноос хойшхи хүний хөгжил:** 1990 онд ардчилалын давалгаанд автан, төрийн хатуу чанд хяналтыг устгахыг эрмэлзэн, зах зээлийн сонголтыг нэмэгдүүлж хүний хөгжлийг хурдасгана гэсэн найдлагадаа хөтлөгдөн Монгол улс бусад улс орнуудын нэгэн адилаар шилжилтийн огцом өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн юм. Үүний үр дүнд эдийн засгийн шилжилт Монгол улсад аж үйлдвэрийн уналт, нийгмийн үйлчилгээний хомсдол, ажилгүйдлийн огцом өсөлт зэргийг араасаа дагуулав. Өөрчлөн байгуулалт, шилжилтийн эхний жилүүд болох 1990-1994 онд хүний хөгжлийн үзүүлэлтүүд эрс мууджээ. Бодит орлого буурч, хүний баталгаагүй байдал нэмэгдэж, хөдөлмөр эрхлэх боломж хумигдахын хэрээр хүмүүсийн амьдрал улам бүр эрсдэлтэй болж байв. Ийнхүү нийгмийн үйлчилгээний түвшин доройтсон, улсын үйлдвэрийн газрууд хаагдснаас хөдөлмөр эрхлэлт буурсан зэрэг үйл явдлууд давхцсан нь Монгол улсад ядуурал, хүний баталгаагүй байдал зэрэг өнөөгийн хүндрэлтэй асуудлуудыг бий болгожээ.

**Хүний хөгжлийг хэмжихүй:** Хүний хөгжлийн илтгэлүүд 1990 онд хэвлэгдэж эхэлсэн цагаас хүний хөгжлийн индексийг хүний хөгжлийн ерөнхий шалгуур үзүүлэлт болгон ашиглах болсон. ХХИ-ийг хүний хөгжлийн дараахь гурван гол үзүүлэлтээр хэмждэг. Үүнд:

- Төрөлтөөс тооцсон дундаж наслалт нь урт удаан, энх тунх амьдрахыг илэрхийлнэ

- Боловсролын байдлыг насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын хувь (хувийн жингийн 2/3) болон бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин (хувийн жингийн 1/3)-ээр илэрхийлнэ.
- Зохистой амьжиргаанд шаардагдах нөөцийг нэг хүнд ногдох бодит ДНБ-ээр орлуулан илэрхийлнэ.

Хүний хөгжлийг дээр дурьдсан боловсрол, эрүүл мэнд болон орлогын индексийн энгийн арифметик дунджаар тооцно. Шилжилтийн эхний үеийн хүндрэлээс шалтгаалан Монголын хүний хөгжлийн индекс 1990-ээд оны эхний хагаст 0,652 байснаа 0,635 болж буурсан байна. Гэхдээ 1990-ээд оны дунд үеэс сайжирсаар 2006 онд 0,718 болж өссөн байна. Хэдийгээр ХХИ-д хэлбэлзэл ажиглагдаж байгаа боловч Монгол улс нь хүний хөгжлийн үзүүлэлтээр дунд зэргийн орны ангилалд багтдаг байна. 2007 оны Дэлхийн Хүний хөгжлийн илтгэлд 2005 оны мэдээллээр тооцсон ХХИ-ээр Монгол улс 177 орноос 114-т орсон байна.

### Монгол дахь хүний хөгжлийн индекс

Он	Дундаж наслалт /жилээр/	Насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдалт /хувь/	Сургалтанд хамрагдалтын нийлбэр хувь	Нэг хүнд ногдох ДНБ /PPP/	Дундаж наслалтын индекс	Боловсролын индекс	ДНБ-ий индекс	Хүний хөгжлийн индекс
1990	63,7	96,5	60,4	1,640	0,645	0,845	0,467	0,652
1992	62,8	96,5	54,3	1,266	0,630	0,824	0,424	0,626
1995	63,8	96,5	57,0	1,267	0,647	0,833	0,424	0,635
1998	65,1	96,5	62,0	1,356	0,669	0,850	0,435	0,651
1999	63,2	97,8	66,0	1707	0,636	0,872	0,472	0,661
2000	63,2	97,8	69,6	1838	0,636	0,884	0,486	0,669
2001	63,4	97,8	69,6	1968	0,639	0,884	0,497	0,674
2002	63,5	97,8	69,7	2125	0,642	0,884	0,510	0,679
2003	63,6	97,8	76,9	1.850	0,644	0,908	0,487	0,680
2004	64,6	97,8	78,0	2.056	0,660	0,912	0,505	0,692
2005	65,2	97,8	80,4	2.408	0,670	0,920	0,531	0,707
2006	65,9	97,8	79,4	2.823	0,681	0,916	0,558	0,718

Эх сурвалж: Монгол улсын хүний хөгжлийн илтгэл - 2007

### Дэлхийн улс орнуудын хүний хөгжлийн байдал

Удаан хугацааны туршид дэлхий даяар үндэстэн хэдий хэмжээний үйлдвэрлэл бүтээв гэдэг асуудал чухлаар тавигдаж байсан бол харин өнөө үед ард түмэн нь хэр дэвшилттэй байна вэ гэсэн асуулт чухлаар тавигдаж байна. Сүүлийн 30 гаруй жилд эдийн засгийн хурдацтай хөгжил бодит сайн сайхан байдлыг тэгш байдлаар бий болгож чадаагүй. Гэвч хүний хөгжлийн бодит заалтаар хэмжихэд харин ч гайхалтай амжилтанд хүрчээ.

Хүний дундаж наслалт 16 жилээр уртасч, насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдсан байдал 40 хувиар, нэг хүнд ногдох хүнсний бүтээгдэхүүний хэмжээ 20 гаруй хувиар өсч хүүхдийн эндэгдэл 2 дахин буурчээ. Чухамдаа аж үйлдвэржсэн орнуудын бараг бүхэл бүтэн зууны туршид хүрсэн хүний дэвшилд хөгжиж буй орнууд ердөө сүүлийн 30 жилийн дотор хүрсэн байна. Умард, өмнөд бүсийн орлогын /умардын орлогын 6%-тай, өмнөдийн орлогын дундаж тэнцэж/ ялгаа нь хэдийгээр их байгаа ч гэсэн хүмүүс хоорондын ялгаа нь улам бүр хурдан ойртож байгаа юм.

Манай дэлхийн тэрбум гаруй хүн үгээгүй хоосон, зовж шаналсан байдалтай амь зууж, хүн хэмээх наад захын ойлголтоос дор нөхцөлд байна. Манай дэлхий орлогын асар их ялгааг чимээгүйхэн хүлцэн өнгөрөөж байна. Баян хоосны гурвалжингийн оройд байх 1 тэрбум хүн, ёроолын 1 тэрбум хүнээс даруй 150 дахин их орлоготой байна. Дэлхийн хөгжингүй болон хөгжиж буй орнуудын тэгш бүс байдал улам нэмэгдэж байна. Жишээ нь, одоо дэлхийн хүн амын 60% ядуу орнуудад, 15% хөгжилтэй орнуудад амьдарч байна. Энэ тоо 2025 гэхэд 75% ба 12% болон тус тус өсөх төлөвтэй байна.

Хөгжиж буй орнуудад сургуульд хамрагдалтын цэвэр түвшин 82%-тай байна. Залуучуудын дунд /14-24 насны/ бичиг үсэгт тайлагдаагүй хүн амын хувь хэмжээ хөгжиж буй орнуудад 16%-тай байхад нэн буурай хөгжилтэй орнуудад 34%-тай байна. Ихэнхи хөгжиж буй орнуудад дээд боловсролд хамрагдалтын түвшин 20% хүрэхгүй байна.

#### Хүний хөгжлийн түвшин: дэлхий, бүс нутаг, улс орнуудаар

Улс орон, бүс нутгууд	ХХИ	Төрөлтөөс тооцсон дундаж наслалт	Бичиг үсэгт тайлагдалтын түвшин	Сургуульд хамрагдалтын түвшин	Нэг хүнд ногдох ДНБ PPP \$
Дэлхий	0.741	67.1	..	67	8229
ЭЗХН-ийн гишүүн орнууд	0.911	78.9	..	65	30181
Хөгжиж буй орнууд	0.694	65.0	76.6	63	4359
Буурай хөгжилтэй орнууд	0.518	52.2	54.2	45	1328
Хүний хөгжил өндөр орнууд	0.895	78.0	..	91	25665
Хүний хөгжил дундаж орнууд	0.718	67.2	79.4	66	4474
Хүний хөгжил доогуур орнууд	0.486	46.0	57.5	46	1046
Өндөр орлоготой орнууд	0.910	78.8	..	94	29898
Дундаж орлоготой орнууд	0.774	70.3	89.6	73	6104
Бага орлоготой орнууд	0.593	58.4	60.8	54	2168
Зүүн Ази Номхон далайн орнууд	0.768	70.5	90.4	69	5100
Монгол улс	0.718	65.9	97.8	79.4	2,823
Хөрш ОХУ	0.806	63.2	99.5	81.9	13.205
Хөрш БНХАУ	0.762	72.7	93.0	68.7	4.682

Эх сурвалж: UNDP. 2007. "Human Development Report - 2006"

Дэлхийн улс орнуудыг хүний хөгжлийн үзүүлэлтүүдээр нь өндөр, дунд, доод зэргийн хүний хөгжилтэй орнууд гэсэн гурван бүлэгт ангилдаг. Хүний хөгжлийн индекс /ХХИ/ нь 0,800-

гаас дээш бол өндөр, 0,500-гаас 0,800 бол дунд, 0,500-гаас бага бол доод зэргийн хүний хөгжилтэй улс гэж тооцож байна. 2007 оны Хүний хөгжлийн илтгэлд дурьдсанаар дэлхийн 179 орноос хүний хөгжил өндөр улс орон 75, дунд зэргийн хөгжилтэй улс орон 101, доод зэргийн хөгжилтэй улс орон 26 байна.

Хамгийн сүүлд хэвлэгдсэн “Хүний хөгжлийн илтгэл 2007”-д дурьдсанаар Исланд улс 0,968 индекстэйгээр хүний хөгжлөөрөө 179 орныг тэргүүлж, дунд зэргийн хөгжилтэй орнуудаас Турк улс 0,798 индекстэйгээр 76-р байранд орж харин Сьерра Леон улс 0,329 индекстэйгээр сүүлийн байрыг эзэлжээ.

Харин дундаж наслалтаар Япон улс (82,4 жил) хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бол Замби улс (41,2 жил) хамгийн доогуур үзүүлэлттэй байв. Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтаар Гүрж улс 100%-иар тэргүүн эгнээнд байхад Мексик улс 91,7%-иар 59 дүгээр байр, Мали улс 22,9%-иар 147 дугаар байрыг тус тус эзэлжээ. Бүх шатны сургуульд хамрагдалтаар Австрали улс тэргүүн байранд явж байгаа бол Джибото улсын хүн амын 25.5% нь бүх шатны сургуульд хамрагдсан байна. Люксембургийн вант улсын нэг хүнд ногдох ДНБ нь 77,089 ам доллар байхад Колумби улсын хувьд 6,381 ам доллар, Конго улсын хувьд 281 ам доллар тус тус байгаа нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн хөгжил харилцан адилгүй байгааг илтгэж байна.

### **Монгол улсын хүний хөгжлийн илтгэлүүдийн тойм:**

Монголын хүний хөгжлийн анхны илтгэл (1997) нь шилжилтийн үеийн Монголын ард түмний аж байдлын түвшинд үнэлгээ өгч дараах зөвлөмжийг гаргасан байна.

- Хүний хөгжлийн асуудлыг анхаарлын төвд тавих
- Хүний хөгжлийн хэрэгжүүлэх
- Хүний чадавхийг хэрэгжүүлэх

Монголын хүний хөгжлийн хоёр дахь илтгэл - Төрийн шинээр зүглүүлэхүй (2000) Монгол улсын төрийн гүйцэтгэх үүрэгт анхаарал хандуулж, улмаар задлан шинжилгээ хийх, иргэд төрөөс ямар зүйл хүсэн хүлээж байгаа талаар өргөн шүүмжлэл, мэтгэлцээн өрнүүлэх оролдлого хийж дараах зөвлөмжүүдийг гаргасан байна. Энэхүү илтгэлээр төрөөс хариуцах 7 чиглэлийг санал болгосон. Илтгэлийн:

- Нэгдүгээр бүлэг: Төрийг шинээр зүглүүлэхүй. Энэ бүлэгт шилжилтийн үеийн төрийн байдлыг авч үзсэн бөгөөд төрийн долоон чиг үүргийг тоочин санал болгосон байна.
- Хоёрдугаар бүлэг: Монгол дахь хүний хөгжил. Энэ бүлэгт ядуурал нүүрэлж, иргэдийн амьдарлын баталгаа алдагдаж хүний хөгжилд ухралт гарсан гэж үзсэн байна.
- Гуравдугаар бүлэг: Эдийн засгийг удирдахуй. Энэ бүлэгт Монгол Улс шилжилтийн үеийг амжилттай давж эдийн засгаа макро түвшинд тогтворжуулж чадсан бөгөөд одоо хэрхэн хурдацтай өсөлтийн зөв замыг сонгох талаар авч үзсэн байна.
- Дөрөвдүгээр бүлэг: Байгаль орчныг тэтгэхүй. Энэ бүлэгт Шилжилтийн үед байгаль орчин бохирдох аюул ихэсч, сэтгэл түгшээсэн олон асуудал шинээр гарч ирсэн нь энэ талаар иж бүрэн бодлогыг үндэсний хөгжлийн стратегитэй уялдуулах, хэрэгжилтийг цаашид сайжруулах шаардлагатай байгаа талаар тусгасан байна.
- Тавдугаар бүлэг: Нийгмийн салбарт хөрөнгө оруулахуй. Энэ бүлэгт Нийгмийн хамгаалалын тогтолцоонд тулгараад буй бэрхшээл түүнийг шийдэх арга замын талаар тусгасан.
- Зургаадугаар бүлэг: Шинэ сэтгэхүй. Энэ бүлэгт төр иргэдийн хооронд үр

бүтээлтэй холбоо харилцааг бий болгох, төр болон төрийн бус байгууллагуудын харилцааны талаар тусгасан.

Монголын хүний хөгжлийн гурав дахь илтгэл - Хот, хөдөөгийн ялгаатай байдал (2003)-д эдийн засгийн салбарт зарим нааштай өөрчлөлт гарч байгаа хэдий ч хот, хөдөөгийн хооронд ихээхэн ялгаа бий болж байгааг онцлон тэмдэглэжээ. Хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгааг задлан шинжилж, эдгээр өөрчлөлтөд төр засаг, иргэдээс үзүүлж буй хариу үйлдлийн талаар өгүүлэн, хот, хөдөөгийн ялгааг арилгахад чиглэсэн бодлогын хувилбаруудыг санал болгосон.

Илтгэлд Монгол Улсын Засгийн газар олон улсын байгууллага, иргэний нийгэмтэй түншлэлийн харилцааг бий болгох үндсэн дээр улам бүр өсөн нэмэгдэж буй хот, хөдөөгийн ялгааг бууруулахад чиглэсэн хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай байна. Хүний хөгжилд нөлөөлөх дээрх ялгааг шийдвэрлэхийн тулд тэргүүлэх ач холбогдол бүхий 4 чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

1. Ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлт
2. Тэнцвэртэй хөгжил
3. Төвлөрлийг сааруулах үйл явцыг бэхжүүлэх
4. Хөгжлийн санхүүжилт

#### **Монголын хүний хөгжлийн илтгэл - Хөдөлмөр эрхлэлт, ядуурал 2007:**

Энэхүү илтгэлээр хөдөлмөр эрхлэлтээс үүдэн гарч байгаа тулгамдсан асуудлууд, ядуурал бий болж байгаа учир шалтгааныг судлан хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан ядуурлаас гарах бодлогын зөвлөмжүүдийг санал болгосон. Илтгэлээр өргөн хүрээг хамарсан ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг улсын хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах стратегийн гол цөм болгох хэрэгтэй гэж дүгнэж дараах зөвлөмжүүдийг гаргасан.

- Хөдөлмөр эрхлэлтийн тухай стратегийг Мянганы хөгжлийн зорилтуудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын нэг гол бүрэлдэхүүн болгох
- Хүний хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн хоорондын зөрүүг арилгах
- Архидалтыг багасгах
- Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдээллийг боловсронгуй болгох
- Эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Уул уурхайн салбарыг түшиглэн хөгжих бусад салбарын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэх
- Хөдөө, орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, сумдын эдийн засгийг сэргээн бэхжүүлэх
- Албан бус салбарыг албан болгох
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох бололцоог өргөжүүлэх
- Шилжих хөдөлгөөнд оролцогчдын хөдөлмөр эрхлэх бололцоог өргөжүүлэх, тэднийг хамгаалах
- Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн устгах гэсэн 12 зөвлөмж гаргасан байна.

#### **Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл - Уур амьсгалын өөрчлөлт ба хүний хөгжил /2010/**

2010 оны Монгол Улсын хүний хөгжлийн илтгэлийн эх хувийг олж үзэж чадаагүй бөгөөд



НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн цахим хуудаст байрлуулсан мэдээллийг авсан болно.

- 1-р бүлэг: Оршил, Монголын байгаль орчны тулгамдсан асуудлууд ба хүний хөгжил;
- 2-р бүлэг: Уур амьсгалын өөрчлөлт ба хүний хөгжил. Энэ бүлэгт цаг уурын өөрчлөлт нь хүний хөгжилд хэрхэн нөлөөлж буйг авч үзээд үүнийг багасгах боломжит бодлогыг санал болгоно.
- 3-р бүлэг: Газрын доройтол болон цөлжилт нь хүний хөгжлийн тулгамдсан асуудлын нэг болох нь. Энэ бүлэгт газрын доройтлын шалтгаануудыг (биофизик ба хүний хүчин зүйл) судлахын зэрэгцээ хүний хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд газрын доройтолтой хэрхэн тэмцэх бодлогыг санал болгоно.
- 4-р бүлэг: Ус ба хүний хөгжил: Усны хүрэлцээ, тогтвортой байдал ба эрүүл мэнд. Энэ бүлэг нь хүмүүсийг усаар байнга, тогтвортой хангахад тулгамдаж буй асуудлуудыг авч хэлэлцээд усны менежментийн бодлогыг санал болгоно.
- 5-р бүлэг: Уул уурхайн салбар нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн эх үүсвэр байх боломж байна уу? Энэ бүлэгт байгалийн баялагийг байгаль орчинд ээлтэй, олох ашгийг олон нийтэд хүртээмжтэй байдлаар зарцуулахын тулд авч хэрэгжүүлэх бодлогыг санал болгоно. Ингэхдээ эдийн засгийн боломж, орлогын хуваарилалт, байгаль орчны хамгаалал, засаглал зэрэг холбогдох асуудлыг авч үзнэ.
- 6-р бүлэг: Байгаль орчны бүртгэл тооцоо ба хүний хөгжил. Энэ бүлэгт үндэсний тооцооны эдийн засгийн үзүүлэлтүүдийг байгаль орчны нөлөөллийг оруулан тооцох арга зүйг гаргаж ирэх, ингэхдээ байгаль орчны зерэг болон сөрөг нөлөөллүүд, нөөцийн хомсдол, доройтлын асуудлыг хөндөнө. Мөн түүнчлэн ингэж тооцсон үндэсний тооцооны үзүүлэлтийг бодлого боловсруулах хөтөлбөрт хэрхэн ашиглах талаар зөвлөмж өгнө.
- 7-р бүлэг: Хотжилт ба хотын өсөлтийн байгаль орчны тулгамдсан асуудлууд. Энэ бүлэгт хүн ам шигүү суурьшиж буй нийслэл хотын байгаль орчны тулгамдсан асуудал болон хүний хөгжилд түүний үзүүлж буй үр нөлөөг авч үзнэ. Түүнчлэн хүний хөгжлийг бататгахын тулд эдгээр тулгамдсан асуудлыг шийдэх бодлогыг санал болгоно.
- 8-р бүлэг: Байгуулал ба засаглалд тулгарч буй асуудлуудыг даван туулах нь. Энэ бүлэгт хүний хөгжлийг бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд тулгарч буй засаглалын гол асуудлуудыг авч үзээд зохих бодлогыг санал болгоно.

#### **1.4. ХҮН АМ ЗҮЙН БОДЛОГЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД, ТҮҮНИЙ НЭГ БОЛОХ ГЕНИЙН САН ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ, ЦУС ОЙРТОЛТЫН ТУХАЙ**

Монголын хүн ам, хөгжлийн тулгамдсан асуудлыг УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо, НҮБ-ын хүн амын сангаас гаргасан лавлагаа, мэдээллийн багцад дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөөнөөс хот руу чиглэсэн дотоод шилжих хөдөлгөөн
- Насны бүтцэд гарч байгаа өөрчлөлт, насжилтын асуудал
- Ядуурал эмзэг байдал
- Гэр бүл жендэрт суурилсан хүчирхийлэл болон хүүхдийн хүчирхийлэл
- Жендэрийн тэгш байдал гэжээ.

Энэхүү лавлагаа мэдээллийн багц нь хүн ам зүйн хөгжлийн тулгамдсан асуудлуудын хүрээнд өмнө хийгдсэн томоохон судалгаануудын дүгнэлт зөвлөмжүүдээс хэрэгжиж чадаагүй, эсвэл хэрэгжүүлээгүйгээс цаг хугацаа алдаж байгаа асуудлын өнөөгийн байдал, сөрөг нөлөөлж байгаа хүчин зүйл, арилаагүй байгаа шалтгаан, бусад орны туршлага,

цаашид анхаарах асуудлаар дүгнэлт санал зөвлөмж гаргасныг энэхүү бүлгийн 2-р хэсэгт авч үзсэн. Түүнчлэн, 2010 онд УИХ-аас баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд” Монгол улс үндэстэн оршин тогтнохын нэг гол үзүүлэлтээр хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг тусгайлан авч үзсэн байдаг. Үүнтэй холбоотойгоор судалгааны энэ хэсэгт хүн амын удмын сагийн өөрчлөлтийн талаар авч үзье.

#### Ерөнхий ойлголт:

Генийн сангийн өөрчлөлт, цус ойртолт нь Монгол улсын хувьд хүн ам зүйн салбарт тулгамдаж буй асуудлуудын нэг юм. Иймд генийн сангийн өөрчлөлт болон цус ойртолт, түүний учир шалтгаан, үр дүнгийн талаар товчхон авч үзье.

Хүний бие нь 32040 гентэй үүний 16020 -ийг нь эцгээсээ, үлдсэн 16020 -ийг нь эхээсээ авдаг гэдгийг эрдэмтэд тодорхойлжээ. Үүнийг хувь **хүний генийн сан /удмын сан/** гэдэг. Тухайн хүн эцэг эхтэйгээ генийн сангийнхаа 50, 50 хувиар хамааралтай, өвөө, эмээтэйгээ 25, 25 хувиар гэх мэтчилэнгээр хоёр дахин багасч явсаар **ес дэх үедээ** генийн сангийн холбоо нь 0.19 хувь болж буурдаг. Өөрөөр хэлбэл, 0.19 хувиар ес дэхь үеийнхээ өвөг дээдэстэй хамаатай байдаг. Үүнээс цааш 10 дахь үедээ үндсэндээ генийн сангийн хамааралгүй, харь элгийн хүмүүс болж хувирдаг байна. Тэгэхээр есөн үеийн дотор ураг холбож болохгүй гэдэг монгол ёс заншлын шинжлэх ухааны үндэслэл нь энэ юм.

**Генийн сангийнхаа/ удмын сан/ тодорхой хувиар хоорондоо ураг төрлийн холбоотой хүмүүс гэрлэхийг цус ойртсон гэрлэлт гэдэг.**

Цус ойртолтыг дотор нь **шууд** цус ойртолт, **алсуур** цус ойртолт гэж ангилдаг. Шууд цус ойртолт гэдэг нь цусан төрлийн холбоотой хүмүүс хоорондоо гэрлэхийг хэлнэ. Алсуур цус ойртолт гэдэг нь нэг нутаг усныхан, нэг сум, багийн уугуул хүмүүс олон үе, удам дамжин хоорондоо гэрлэснээс үүсдэг. Энэ нь шууд цус ойртолтод их нөлөөлнө.

#### **Судалгааны үр дүн:**

Монголчууд угийн бичгээ хөтлөхөө больсоноос гурав, дөрөв дэхь үедээ цусан төрлийн холбоотой хүмүүс хоорондоо гэр бүл болдог нь цус ойртолтыг бий болгож улмаар төрөлхийн гажиг нэмэгдэх болсон талаар мэргэжлийн судлаачдын<sup>11</sup> хийсэн судалгаанд анхаарлаа хандуулъя.

#### **Монголчуудын угийн бичиг хөтлөхөө больсоны хор уршиг:**

1925 онд Монгол Улсын Засгийн газрын тогтоол гарч монгол хүн овог хэрэглэх, угийн бичгээ хөтлөх явдлыг болиулсан. Хүний нэг үе удам гарч ирэх генетикийн хугацаа 25 жил байдаг энэ хугацаагаар тооцох юм бол гурван үе удам давсан хугацаа /85 жил/ өнгөрсөн байна. Энэ хугацаанд Монголын хүн амын дотор цус ойртох үзэгдэл явагдаж байна уу гэдэг дээр “Хүн судлалын үндэсний төв” олон жилийн судалгаа хийж, Монголын хүн амын дотор нийт цус ойртолтын коэффициентийг тооцож нэгтэй тэнцүү гэж үзвэл түүний **97.24 хувийг шууд цус ойртолт**, үлдсэн **2.76 хувийг алсуур цус ойртолт**<sup>12</sup> эзэлж байна.

#### **Төрөлхийн хөгжлийн гажиг цус ойртолттой холбоотой эсэх:**

2005-2009 онд Монголын хүн амд бүртгэгдсэн төрөлхийн хөгжлийн гажгийг цус ойртолттой холбоотой эсэхийг уруул, тагнайн сэтэрхий, зүрхний гажиг, нугасны ивэрхий, битүү бөгстэй төрөх гээд 10 гаруй төрлийн гажгаар судлахад хүн амын дотор цус ойртолт гүнзгийрч арга хэмжээ авахгүй бол жилээс жилд нэмэгдээд байна. “Цус ойртолт” гэдэг нь төрөлхийн гажиг согогтой төрдөг хүүхдийн тоо олшроод 25, 25 жилээр нэмэгдээд яваад байдаг хэнд ч

<?> <http://undp.mn/hdr/2010/mn/niltgel.html>


<sup>12</sup> Хүн ам хөгжлийн тулгамдсан асуудлууд, 2010 он



харагдахгүй, мэдрэгдэхгүй “чимээгүй тахал”<sup>13</sup> юм.

Хүн амын дотор цус ойртолтыг тодорхойлдог үндсэн хоёр арга бий. Нэгдүгээр арга, **угийн бичиглэл** хийх. Энэ нь иргэдийн хувьд цу ойртолтоос сэргийлэх хамгийн оновчтой арга. Монголын хүн амд угийн бичиглэлийн аргаар цус ойртолтыг тодорхойлоход бэрхшээлтэй зүйл нь иргэд 3 дахь үе буюу өвөө эмээгээ л мэддэг. Өвөг эцэг, эмэг эхийн дээд талд элэнц эцэг, элэнц эх байдаг. Тэрний дээд түвшинд хуланц эцэг, хуланц эх бий. Эдгээр түвшин рүү ороод ирэхээр үндсэндээ үе удмаа мэдэхээ больчихсон учраас энэ аргыг хэрэглэх хэцүү юм. Тиймээс Хоёрдугаар арга буюу **генетик тогтоцын аргыг** ашиглаж хүн ам дахь цус ойртолтыг тооцоолж ирсэн. Энэ нь шинжлэх ухааны арга юм.

Өнөөдөр Монголын хүн ам дахь цус ойртолтын байдал нь ургийн 5, 6-р үе болох элэнц, хуланцын түвшинд хамаатай үр удмууд хоорондоо гэрлэх хэмжээнд хүрчээ. Монголын хүн амд сүүлийн 30 гаруй жил судалгаа хийж цус ойртолтын газар зүйн тархалтын зураглалыг гаргажээ. **Монголын хүн ам дахь цус ойртолтын түвшний газарзүйн тархалтын зураглалаас харахад Монгол орны өргөргийн дагуу хойноосоо урагшлах тутам цус ойртолт аажмаар ихэсдэг зүй тогтол илэрч байна. Өөрөөр хэлбэл, хүн амын нягтрал сийрэгжихийн хэрээр** цөөн тооны хүмүүс хүссэн хүсээгүй хоорондоо гэрлээд алсуур цус ойртолтыг улам нэмэгдүүлж байна.<sup>14</sup>



Аливаа улс орны хүн амын удмын сангийн аюулгүй байдалд нөлөөлөх нэг гол хүчин зүйл бол тухайн нутаг орны хүн амын гэрлэлтийн төлөв байдал байдаг. “Монголын хөдөөгийн зарим сум, багуудад гэр бүл болж байгаа хосуудын 68,4-99 хувь нь зөвхөн тухайн баг дотроо төрж өссөн хүмүүс хоорондын гэрлэлт бөгөөд сумдын хүн ам нь ургийн 3-4 дэх үеийн ах дүүгийн хүүхдүүд хоорондын гэрлэлтээс үүссэн цус ойртолтын түвшинд хүрсэн нь”<sup>15</sup> судалгаагаар тогтоогдсон. Эндээс дараахь 2 дүгнэлтийг хийж болно.

1. Хөдөөгийн хүн амын төв суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ихсэж байгаа нь **багийн хүн амын эзэлхүүнийг багасгаж** баг доторх гэрлэлт ихсэх

<sup>13</sup> “Хүн судлалын үндэсний төв”-ийн захирал, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Ж.Батсуурь болон тус төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор Э.Энхмаа нарын

<sup>14</sup> Анагаах ухааны доктор Э. Энхмаа

<sup>15</sup> Анагаах ухааны доктор Э. Энхмаа

нөхцлийг бүрдүүлж байна.

2. Хүмүүс өөрөөсөө дээш 3 үеэс цааших удам угсаагаа мэдэхгүй байгаа хандлага түгээмэл байдаг нь садан төрлийн хүмүүс хоорондоо гэр бүл болж алсуур цус ойртолтыг ихэсгэж байна.

#### **Цус ойртолтын үр дагавар, хор холбогдол, хүн амын өвчлөлд нөлөөлж байгаа байдал:**

Хүн болгонд эцэг эхээс далд хэлбэрээр удамшдаг муу шинжийн генүүд хэдэн арваараа байдаг. Гэтэл цус ойртсон гэрлэлтээр нөгөө далд байсан муу шинжийн генүүд хоорондоо ижилсэх магадлал ихсэж, өвчин болж гаднаа илрэх нөхцөл нь бүрддэг.

Төрөлхийн удамшлын өвчин согогтой төрөх, оюуны хомсдолтой хүүхдүүд олноороо төрөх, амьгүй төрөлт, зулбалт их болж байгаа, хүний бие бялдрын хөгжил давжаа болох, биеийн эсэргүүцэл дархлаа сулрах, ямар нэгэн өвчнийг эсэргүүцэх хувь хүний чадавхи доройтох, юмыг их хурдан түргэн сэтгэдэг оюун ухааны ир мохоо болох зэрэг нь бүгд цус ойртолтын илрэл юм. Ийм муу үр дагавартай гэдэг нь хүний генетикийн шинжлэх ухаанаар нэгэнт нотлогдсон зүйл. Цус ойртолтын процесс Монголын хүн амын өвчлөл, өвчний улмаас цаг бусаар нас барахад бодитой нөлөөлж байна. Магадлалын статистикаар бол 95 хувь, түүнээс дээш хувийн түвшинд цус ойртолтын байдал, өвчлөл нас баралтад нөлөөлж байгаа нь тогтоогдсон<sup>16</sup>.

Хүн амын удмын санд сөрөг нөлөөлж болох хүчин зүйл нь **цус ойртолтоос** гадна архидаг согтуурах явдал газар авах, цацраг идэвхт бодисын нөлөө, хүн ба амьтны гоц халдварт өвчин гарах, хүн амын нас хүйсний бүтцийн харьцаа алдагдах, эрүүл ахуйн болон бусад тогтсон стандартыг зөрчиж эрүүл мэндэд хөнөөлтэй хоол хүнс, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж хяналтгүй худалдаалах, химийн бодистой харьцах заавар журмыг зөрчих зэрэг олон хүчин зүйлүүд байдаг.

2010 оны 7 дугаард батлагдсан Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.3.4-д “Цус ойртолтыг багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна” гэж заажээ.

#### **Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах арга зам**

- ☐ Монгол хүний удмын сан, эрүүл мэнд, хүн амын тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн төрийн иж бүрэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх,
- ☐ Удмын бичиг хөтөлдөг уламжлалыг олон түмний идэвх санаачилгад тулгуурлан сэргээх, хүн бүр овог болон өөрөөс дээш 7-9 үеэ мэддэг болох;
- ☐ Хүнсний аюулгүй байдлыг төрийн онцгой анхааралд байлгаж, хүнсний бүтээгдэхүүнд хүний эрүүл мэнд, удамшлын бүтцэд нөлөөлөх элдэв хорт бодисын хольц байгаа эсэхэд хяналт тавих, **үндэсний нэгдсэн лаборатори байгуулах;**
- ☐ Цус ойртох, архидан согтуурах, мансуурах оюун ухааны хомсдол болон сэтгэл мэдрэлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох бодлого явуулах,
- ☐ Хүний удамшил, хүн амын эрүүл мэндэд шууд болон үлдэц нөлөө бүхий онцгой хортой химийн болон биологийн гаралтай материалыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулах дамжуулан тээвэрлэх, түүнчлэн гадаад орны хортой хог хаягдал булшлах, боловсруулах замаар аж ахуй эрхлэх үйл ажиллагааг хориглох,
- ☐ Хүн амын дотор удамшлын өвчин, согог, оюун ухааны хомсдолын тархалт, илрэлтийн давтамж, болон хүний удмын санд сөрөг нөлөөлөх химийн бодис хүрээлэн буй орчинд хуримтлагдаж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж байх;

<sup>16</sup> Хүн судлалын үндэсний төвийн захирал, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Ж.Батсуурь

- Хүн амын эрүүл мэнд, эх хүүхдийн өвчлөл, нас баралтын гол үзүүлэлтүүдийг дэлхийн дундаж түвшинд хүргэн бууруулах. Эх хүүхдийн эрүүл мэндийн зарим тулгамдсан асуудлыг зөв зохистой шийдвэрлэх зорилгоор хүн амын төрөлтийг зохицуулах бодлого явуулах
- Монгол Улсын засаг захиргааны өнөөгийн бүтэц олон аймаг, сум, баг, болгоод хуваасан нь төрийн үйлчилгээг хүн амд хүргэх талаасаа сайн ч сөрөг үр дагавар нь нэг нутаг усныхан олон үе дамжин нутаг усны ойр, танил талын хүрээнд хүлэгдмэл гэрлэлтийн жижиг бүлэглэлүүд үүсэх нөхцөлийг бүрдүүлээд байна. Иймд засаг захиргааны нэгжийг томсгож төрийн бодлогоор хүн амын нягтаршил сийрэг байгаа газрууд руугаа хүн амыг зохистой шилжүүлэн суурьшуулах, үйлдвэржүүлэх, их, дээд сургуулиуд байгуулах, зам харгуй тавих, залуучууд хоорондоо уулзаж учрах нөхцөлийг бүрдүүлэх.

#### 1.5. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын талаар УИХ-ын 2004 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн зорилт болон тус бодлогын баримт бичгийн хүн амын хөгжлийг хангах бүрэлдэхүүний хүрээнд Засгийн газраас дараахь үндэсний хөтөлбөрүүд батлагдан хэрэгжиж байна:

1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөр
2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөр
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөр
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр
5. Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр
6. Өсвөр үе, залуучуудын хөгжлийн дэмжих Үндэсний хөтөлбөр
7. Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр

Эдгээр хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдлыг хөтөлбөр тус бүрээр НХХЯ-ны мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээний газрын хийсэн үнэлгээний тайлангаас тоймлон дурдав. Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн судалгааны болон мониторингийн байгууллагын хийсэн үнэлгээ олдоогүй болно.

#### **Засгийн газраас баталсан “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт <sup>17</sup> /2009 он/**

Хөтөлбөрийг 2005-2010 онд 2 үе шаттайгаар 6 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Эхний үе нь 2005-2007 он байх бөгөөд хоёр дахь үе нь 2007-2010 оныг хамаарна. Хөтөлбөрийн гол зорилго: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах, хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах бүх нөхцөлийг бүрдүүлэх, ажилтныг мэргэжлийн эрсдэлээс хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийгмийн баталгааны түвшинг нэмэгдүүлэх, нийгмийн түншлэлийн механизмыг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

<sup>17</sup> НХХЯ -ны мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээний газар

**Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/ 2009 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт нь 84.7 хувьтай байна.**

- Хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд томоохон болон зарим жижиг, дунд аж ахуйн нэгж байгууллагууд ажилтны ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж ХАБЭАҮХороо байгуулагдаж орон нутагт 14 салбар, байгууллагын дэргэд зөвлөл ажиллаж үйл ажиллагааныхаа дүрмийг боловсруулж тухайн асуудлыг хариуцсан үндэсний бүтэц бий болсон, ажлын байрны аттестачлал явуулсан, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам баталсан, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн компанит ажлыг 7 хоног, сараар олон хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн зэрэг нь сайшаалтай боловч нийт ажил олгогчдын ажлын зохион байгуулалт, ажлын сахилга, дэг журам дорвитой дээшлэхгүй байгаагийн зэрэгцээ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэг ажил олгогч болон ажилчдын дунд хангалтгүй, энэ талын зан үйл хэвшлийг байнга дээшлүүлэх нь зүйтэй байна.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль гарсантай холбогдуулан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 14 дүгээр тогтоолоор батласнаар ААНБ-уудад гарч буй үйлдвэрлэлийн ослыг тухай бүр бүртгэх, мэдээлэх тогтолцоотой болов. 2008 онд үйлдвэрлэлийн осол нийт 491, 2009 онд 366 осол гарч, үйлдвэрлэлийн осол 25,4 хувиар буурсан ба 2008 онд үйлдвэрлэлийн осолд 671 хүн өртөж байсан бол 2009 онд 410 өртөж 39 хувиар урьд оноос буурсан үзүүлэлттэй байна.
- Хөтөлбөрийн “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт боловсруулах, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлдэх хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн өнөөгийн нөхцөл байдлыг үндэсний хэмжээнд судлах, бодлогын зөвлөмж боловсруулах”, ОУХБ-ын Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн байцаан шалгах газрын тухай 81, Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай 161, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны 184 дүгээр конвенцуудад нэгдэн орох гэх мэт яамны хариуцан гүйцэтгэх ажлууд удаашралтай байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

**Цаашид анхаарах асуудлууд:**

- ХААЭА-н асуудал нь салбар дундын цогц зохицуулалт шаардаж байгаа учраас салбар хоорондын уялдааг сайн хангах
- Осол, авааргүй, эрүүл ажиллах зан үйлийг бүх шатанд төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгааг байнга тасралтгүй системтэй явуулах, мөн их, дээд сургуулийн хичээлийн программд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар оруулж өгөх болон хөдөлмөр зуучлалын үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар үндсэн ойлголт өгөх сургалт, зөвлөгөөг өргөжүүлэх,
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн системийг жижиг, дунд, үйлдвэрүүдэд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх,
- 2010 онд хөтөлбөр хэрэгжиж дуусах тул Үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжтой уялдуулан хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

### **Засгийн газраас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт- 2009<sup>18</sup>**

Хөтөлбөрийг 2006-2012 онд 2 үе шаттайгаар 6 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Эхний үе нь 2006-2008 он байх бөгөөд хоёр дахь үе нь 2008-2012 оныг хамаарна.

Хөтөлбөрийн гол зорилт: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг нь үнэлж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хамт олон, гэр бүл иргэдийн санал, санаачилгыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх эерэг хандлагыг төлөвшүүлэх.

### **2009 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт нь 83.8 хувьтай байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэл санаачлагын байгууллагын идэвхийг бэхжүүлж үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор төрийн зарим чиг үүргийг гэрээлэн гүйцэтгүүлж байгаа нь төрийн болон ТББ-ын хамтын ажиллагааг өргөжүүлсэн, ХБИ-ийн ном сонин, хэвлэл унших, зурагт үзэх, компьютер дээр ажиллах, интернэтээс мэдээ мэдээлэл авах үйл ажиллагааг нээлттэй явуулдаг төвүүд бий болж брайл үсэг бүхий номын санг байгуулж, брайл үсгийн самбар, цаас, шивүүр зэргийг олгосон, аймаг бүрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэлгэрэнгүй мэдээллийн санг бүрдүүлсэн зэрэг нь тус хөтөлбөрийн үр дүн юм. Харин хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй дэд бүтцийг сайжруулах, мэдээлэл, харилцааны технологийг хөгжүүлэх зорилтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал: хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийтээр цуглардаг гудамж, талбайд саадгүй зорчиход зориулсан зам, замын тэмдэг, дуут дохиог бий болгох, шинээр баригдаж байгаа барилга байгууламж болон эмнэлэг, үзвэр, үйлчилгээ, худалдаа, олон нийтийн байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчих нөхцөл бүрдээгүй байна.

**Цаашид анхаарах асуудлууд:** Тус хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны шалгуур, үр дүнг зорилт бүрээр тусгаж, хэрэгжүүлэх нь чухал байна. Түүнчлэн зорилт тус бүрээр тухайн жилд хийгдэх ажлын хүрээнд санхүүжилтийг төлөвлөх шаардлагатай байна.

### **Засгийн газраас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих үндэсний дэд хөтөлбөрийн хэрэгжилт - 2009<sup>19</sup>**

Хөтөлбөрийг 2006-2012 онд 2 үе шаттайгаар 6 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Эхний үе нь 2006-2008 он байх бөгөөд хоёр дахь үе нь 2009-2012 оныг хамаарна.

Хөтөлбөрийн гол зорилт нь: ХБИ-ийн улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг нь үнэлж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага хамт олон, гэр бүл иргэдийн санал санаачилгыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх эерэг хандлагыг төлөвшүүлэх. **2009 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт нь 85.0 хувьтай байна.**

<sup>18</sup> НХХЯ -ны мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээний газар

<sup>19</sup> НХХЯ-ны мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээний газар

**Хөтөлбөрийн үр дүн**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбоо, Хамтдаа хөгжицгөөе бүлгийн ажил тогтмолжиж, тэднийг дэмждэг байгууллага, иргэдийн тоо нэмэгдсэн,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгмийн халамж үйлчилгээ болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах ажил өргөжиж, хамрагдсан хүүхдийн тоо өмнөх жилээс нэмэгдэж, тэдний эцэг эхийн оролцоо дээшилсэн,
- Хөтөлбөрийн хүрээнд салбарын дэмжлэгүүд нэмэгдэж, нийгмийн халамжаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тэдний эцэг эхчүүдийн хүртэх хүртээмж, үйлчилгээнд хамрагдах хүрээ өргөжсөн,
- Хүүхдийн эрх хамгааллын асуудлаар салбарын агентлаг байгууллагын ажлын уялдаа зохицуулалт сайжирсан,
- ХБХ-ийн нарийвчилсан судалгаа мэдээллийн сантай болсон байна.

**Цаашид анхаарах асуудлууд:**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг нийгэмшүүлэх, үйлчилгээний нэр төрлийг хөдөө орон нутагт хөгжүүлэхэд тодорхой хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх,
- Үйлчилгээний газруудад ХБХ-дэд зориулсан орчин нөхцлийг бүрдүүлэх, Тухайлбал, эмнэлгийн байгууллагад ХБХ-дэд үйлчилгээ үзүүлэх эмч мэргэжилтнийг бэлтгэх,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлаар статистик судалгааг хөгжүүлэх, салбарын статистикт нарийвчилан тусгах, /Тухайлбал: уруул тагнайны цоорхойтой хүүхдүүд эрүүл мэндийн судалгаанд байдаггүй, осол гэмтлээр маш их хүүхэд нас бардаг мөн хэдэн хүүхэд гэмтэж ХБ-тэй болсон талаарх судалгаатай болох/
- Хүүхдийн байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах,
- Тус хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, шаардагдах хөрөнгө, үйл ажиллагааны шалгуур, үр дүнг зорилт бүрээр тусгаж, хэрэгжүүлэх,
- Мөн сургалтын чанартай үйл ажиллагааны хэрэгжилт хангалттай байгаа хэдий ч зөвхөн сургалт, сурталчилгаа, мэдээлэлд ач холбогдол түлхүү өгч бусад асуудлуудад анхаарлаа сул хандуулсан байгааг анхаарах,
- Хөтөлбөр хэрэгжсэнээр тодорхой үр дүнгээ өгч байгаа ч цаашид дэд хөтөлбөрийг эрчимжүүлэхийн тулд Үндэсний хэмжээнд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх Үндэсний баг байгуулах, мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн зардлыг жил бүрийн төсвийн төсөлд суулгаж өгөх,
- Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилээр нарийвчилж гаргах нь цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй болгоход ач холбогдолтой байна.

**“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжил- 2009<sup>20</sup>**

Хөтөлбөрийг 2002-2010 оны хугацаанд хэрэгжүүлнэ.

**Хөтөлбөрийн гол зорилт:** Иргэдийг өөрийн мэргэжил, үр чадварын дагуу хүссэн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдан дэмжлэг авах, өөрсдийн боломж, чадавхийг хөгжүүлэх замаар амьжиргаагаа дээшлүүлэх

<sup>20</sup> НХХЯ -ны мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээний газар



нөхцөл бололцоогоор хангахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг улс орны эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийн бодлого болон бүс нутгийн хөгжлийн онцлогтой уялдуулан хөгжүүлэхэд оршино.

**Хөтөлбөрийн хэрэгжилт 2009 оны байдлаар 96,0 хувьтай байна.**

**Хөтөлбөрийн талаарх дүгнэлт /ололт, дутагдал анхаарах асуудал /:**

- Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн ЗДТГ болон холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Аймаг, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс орон нутагтаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр гарган аймаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол болон Засаг даргын захирамж гаргуулан ажиллаж байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаар батлагдсан 10 гаруй журам хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр дүрэм, журмуудын хүрээнд зохион байгуулж байгаа үйлчилгээ, арга хэмжээнд тавих явцын хяналтын талаар тодорхой тусгагдаагүй нь ХЭДС-аас зарцуулж байгаа хөрөнгийн үр өгөөжийг зарим талаар бууруулж байна. Жишээ нь: НХА, мэргэжлийн сургалтууд гэх мэт.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг нэгдсэн стандарт байдлаар улсын хэмжээнд зохион байгуулж байгаа нь эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, ажиллах хүчний бүтэц, хот, хөдөөгийн болон бүс нутгийн ялгаа зэргээс үүссэн хөдөлмөрийн зах зээлийн болон хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид гарч буй бодит байдалтай тэр бүр нийцэхгүй байна.

**Цаашид анхаарах зүйл:**

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчлэлттэй уялдуулан хөтөлбөрт суурилсан, зохион байгуулалтыг орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн, хамрах хүрээг оновчтой тогтоож төрөөс дэмжлэг шаардлагатай зорилтот бүлгийн иргэдэд түлхүү чиглүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн хуваарилалтыг боловсронгуй болгох, үр нөлөөг сайжруулах,
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг айл өрхийн хөгжлийг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилтод нийцүүлэн хоршоо нөхөрлөл байгуулах замаар иргэдийн ур чадварыг дээшлүүлэх, аж ахуйгаа өргөжүүлэхэд нь чиглүүлэх,
- Зах зээлийн эрэлтэд тулгуурласан, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагыг хангасан мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэх,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүнг үнэлэх чанарын үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох,
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг орон нутагт зохион байгуулж, иргэдэд анхан шатны үйлчилгээг хүргэж буй ажилтнуудад чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг боловсронгуй болгох /тухайн орон нутгийнхаа онцлогоор/, тооцоолол, судалгаа хийх, боловсруулах талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар байнга хангах нь зүйтэй байна.

**“Жендерийн тэгш байдлыг хангах” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт - 2009<sup>21</sup>****Хөтөлбөр хэрэгжих хугацаа**

1 дүгээр үе шат нь: 2003 - 2004 он, 2 дугаар үе шат нь: 2005-2008 он, 3 дугаар үе шат нь: 2009-2012 он, 4 дугаар үе шат нь: 2013 - 2015он

**Хөтөлбөрийн гол зорилго:** Нийгмийн хөгжил дэвшилд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш оролцоог хангах, тэднийг нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай орчинг бүрдүүлэх замаар хүний амьдралын чанарыг сайжруулах, нийгэмд гарч байгаа сөрөг үзэгдлийг арилгахад оршино. **2009 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт нь 75,3 хувьтай байна.**

**Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/****Ололттой тал нь:**

- Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд, гэр бүлийн хөгжлийн танхимууд, төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд хүн ам, гэр бүлийн хөгжлийн асуудлаар дагнасан нэгж зэргийг байгуулсан нь гэр бүлийн ёс суртахууныг эрхэмлэх, бат тогтвортой байдлыг хангах, ялангуяа залуучуудыг гэр бүлийн амьдралд бэлтгэх нийгмийн орчныг бүрдүүлж чадсан байна.
- Гэр бүлийн гишүүдийн эрхийг зөрчих явдалтай тэмцэх чиглэлээр хууль эрх зүйн орчинд ахицтай өөрчлөлтүүд гарсан. (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт зохион байгуулах журам, сургалтын хөтөлбөр, Цагдаагийн ажилтнаас хохирогчийг төлөөлж эрх хязгаарлах хүсэлт гаргах загвар, хохирогчийн бүртгэлийн маягт)
- Гэр бүл, бэлгийн хүчирхийллийн хохирогчид эмнэлэгт түшиглэсэн нэг цэгийн анхан шатны үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий үйлчилгээний төвийн үйл ажиллагааны журмыг батлан холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь Монгол улсад төрийн байгууллагын хувьд анхных гэдгээрээ ач холбогдолтой байна.
- Үр хүүхдээ эсэн мэнд бойжуулж, нийгэмд нэр төртэй иргэн бэлтгэж өгсөн олон гэр бүлийн туршлагыг сурталчлан таниулсан нь ялангуяа залуучуудад үлгэр дууриал болсон үр дүнтэй ажил болжээ.
- Гэр бүлийн хүчирхийлэл, жендэрийн тухай ойлголт, энэ чиглэлийн хууль эрхзүйн актын талаар нийгмийн амьдралын бүхий л хүрээнд сурталчлан таниулсан нь иргэдийн ойлголт мэдлэгийг дээшлүүлсэн ажил болжээ.
- Жирэмсний хүндрэлтэй, архаг хууч өвчтэй эхчүүдэд зориулан аймгийн төв, болон ихэнх сумдад эхчүүдийн амрах байрыг гэрийн нөхцөлд ойртуулан ажиллуулж, шаардлагатай тоног төхөөрөмж хангалтуудыг олгож, зарим аймагт шинээр төрөх газруудыг ашиглалтад оруулсан нь хүн амд ялангуяа хөдөөгийн хүн амын НҮЭМ-ийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар сайжруулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болжээ.
- Засгийн газраас “Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх тухай дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эмзэг бүлгийн 25333 иргэдэд хүнсний хэрэглээний

<sup>21</sup> НХХЯ-ны мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээний газар



гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөр тооцсон хүнсний талоныг олгосон нь иргэдийн амьжиргаанд нэмэр болсон үр дүнтэй ажил болжээ.

*Дутагдалтай тал нь:*

- ☐ Дээрх үйл ажиллагаанууд ихэнхдээ төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн нь цаашид төрийн дэмжлэг шаардлагатай байгааг илтгэж байна.
- ☐ Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тал дээр учир дутагдалтай байна.
- ☐ Эдийн засгийн бодлогод жендэрийн тэгш байдлыг хангах механизм бүрдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн зарчмыг нэвтрүүлэх тал дээр хангалтгүй ажиллагаа хийгдсэн байна.

**Цаашид анхаарах асуудлууд:**

- ☐ Орон нутгийн жендэрийн асуудал хариуцсан ажилтныг мэргэшүүлэх, чадавхижуулах,
- ☐ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тодорхой санхүүжилтыг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгах,
- ☐ Орон нутаг дахь жендэрийн асуудлаарх бүтцийг засаг захиргааны нэгжүүдэд оновчтой зохион байгуулах саналуудыг орон нутгаас ирүүлж байгааг харгалзан үзэх
- ☐ Энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага нэгжүүдийн үйл ажиллагааг уялдуулан төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- ☐ Хөдөөгийн хүн амын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх,
- ☐ Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг хангах орчин бүрдүүлэх
- ☐ Эх хүүхдийн эндэгдлийг бууруулах орчныг бүрдүүлэх
- ☐ Хөтөлбөрийн үйл ажиллагааг бусад хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай уялдуулах,
- ☐ Хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлуудад тулгуурлан судалгаа, мэдээлэлийн сан бүрдүүлж ажиллах түүнийг бодлогод тусгах, зохион байгуулж буй сургалтуудын хамрах хүрээ, үр дүн, чанарыг улам боловсронгуй болгох,
- ☐ Аймаг, дүүргийн нэгжүүд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг цаг хугацаанд нь маш тодорхой, тайлагнаж байх хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх,
- ☐ орон нутгийн шинээр томилогдсон шийдвэр гаргах түвшний удирдлагуудад хөтөлбөрийн талаарх ойлголтыг сайжруулах талаар нэгдсэн арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах,
- ☐ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг ихэвчлэн олон улсын байгууллагууд, гадаад орнуудын төсөл хөтөлбөрөөс гаргаж байна. Цаашид өөрийн эх үүсвэрийг дайчлах, хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг төрийн бодлого хөтөлбөрт тусгах замаар санхүүжилтийг сайжруулах шаардлагатай.

**“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт - 2009<sup>22</sup>****Хөтөлбөр хэрэгжих хугацаа:**

- Нэгдүгээр үе шат 2007-2008, Хоёрдугаар үе шат 2009-2012

**Хөтөлбөрийн гол зорилт:**

- Залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хөгжих, эрх ашгаа хамгаалах, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог өргөжүүлэх ээлтэй орчинг бүрдүүлэх замаар чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, тэдний улс орныхоо хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оршино.

**2009 оны байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт нь 67,9 хувьтай байна.**

**Дүгнэлт /ололт, дутагдал анхаарах асуудлууд /**

- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлага дээшлэх, хөгжих, эрх ашгаа хамгаалах, нийгмийн амьдралд оролцох оролцоо, улс орныхоо хөгжилд оруулах хувь нэмэр нэмэгдэж байгаад ололттой тал нь оршиж байна.
- Хөтөлбөрийн 24 зорилтын хүрээнд орон нутгийн түвшинд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн нь сайшаалтай байна. Эдгээрээс залуучуудад мэргэжил эзэмшүүлэх, нөхөн үржихүйн эрүүл мэнд, архи тамхи, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа, хүүхэд залуучуудын авьяас чадварыг дэмжсэн соёл урлаг, спортыг арга хэмжээнүүдийг орон нутгийн түвшинд сайн зохион байгуулж олон мянган хүүхэд залууст хүрч ажилласан байна.
- Гэвч эдгээр нь үр дүнг шууд хэмжих үзүүлэлт болж чадахгүй учраас залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилд зуучлан байнгын ажлын байраар хангах, гэмт хэрэгт өртсөн залуучуудыг нийгэмшүүлэх, хорих байгууллагаас суллагдах үед ажлын байраар хангах, залуучуудын санаачилсан бичил аж ахуйн чадавхийг бэхжүүлэх тал дээр төрөөс дэмжлэг үзүүлж, барьцаа уян, хүү бага зээлийн нөхцөл боломжийг бүрдүүлсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага гарч байна.
- Залуучуудыг мэдлэг боловсролоо дээшлүүлэх, мэргэших, гадны өндөр хөгжилтэй оронд суралцуулах, гадаад харилцааг өргөжүүлэх тал дээр төрийн болон олон нийтийн байгууллагын зүгээс цаашид санаачилгатай ажиллах шаардлагатай байна.
- Орон нутаг дахь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд нь ажлын уялдаа холбоог сайжруулах, хүүхэд залуучуудын өмнө тулгамдаж буй асуудлыг хүч хавсарч, цогц байдлаар шийдвэрлэхийн тулд далайцтай ажиллах, орон нутгийн засаг дарга нарын зүгээс салбар хоорондын уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллах нь үйл ажиллагааны үр дүнд сайнаар нөлөөлж байгаа тул анхаарч ажиллах хэрэгтэй байна.
- Хэд хэдэн аймгууд залуу гэр бүлийг дэмжсэн “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв”-ийг байгуулж үйл ажиллагааг тогтмолжуулснаар, залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж, гэр бүл бат бөх байх, эцэг эх нь хүүхдээ эрүүл өсгөн бойжуулж, боловсрол, хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлсэн байна. Иймд: Бусад аймгууд мөн нээн ажиллуулах шаардлагатай

<sup>22</sup> НХХЯ-ны мэдээлэл хяналт, шинжилгээ үнэлгээний газар

гэж үзэж байна.

- Гэр бүл болсон залуучуудад бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үүднээс зээл олгож хүүгийн нөхөн төлбөрийг шинээр ажлын байр бий болгосон уг иргэдэд олгож байхаар заасан үйл ажиллагааг цаашид хэрэгжүүлэх нь залуучуудыг дэмжсэн дэвшилттэй үйл ажиллагаа болох юм.

#### **Цаашид анхаарах асуудлууд:**

- Орон нутгийн болон нийслэлийн түвшинд салбар хоорондын хамтын ажиллагаа хангалттай бус байна. Аливаа мэдээлэл, ухагдахууны талаар нэгдсэн нэг ойлголттой байх, мэдээллээ хоорондоо хуваалцдаг байх шаардлага нэн түрүүнд тулгамдаж байна.
- Бусад хүн амын бүлгүүдийн чиглэлээр хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүд, төрийн бус болон ОУБ -аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдтэй үйл ажиллагааг уялдуулж хэрэгжүүлэх.
- Аймгийн Засаг Дарга нарын НХХСайдтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд тусган оруулах,
- Өмч болон эдийн засгийн харилцааны талаар өсвөр үе залуучуудын ойлголт мэдлэгийг сайжруулах, “Бизнес мэдээллийн төв”, “Гэр бүлийн хөгжлийн төв”, “Хүүхэд залуучуудын төв” -ийг цаашид бүх аймаг, дүүрэгт байгуулан ажиллуулах

#### **ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ**

Хөтөлбөрийн нэр	Зорилтын тоо бүгд	Хэрэгжих хугацаа /жил/	Хэрэгжилтийн хувь		
			Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	2009 оны хувь
1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” Үндэсний хөтөлбөр	2	2002-2010	88.8	70.1	96.0
2. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл орчныг сайжруулах” Үндэсний хөтөлбөр	5	2005-2010	83.5	63.6	84.7
3. “Жендерийн тэгш байдлыг хангах” Үндэсний хөтөлбөр	15	2003-2015	41.5	31.5	75.3
4. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” Үндэсний хөтөлбөр	6	2006-2012	50.1	41.9	83.8
5. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих” дэд хөтөлбөр	4	2006-2012	50.1	42.6	85.0
6. “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” Үндэсний хөтөлбөр	6	2006-2014	44.4	38.7	90.0

7. “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” Үндэсний хөтөлбөр	24	2007-2015	37.5	21.0	67.9
<b>Дүн</b>	<b>62</b>				<b>83.2</b>

\* \* \*

### 1.6. ХҮН АМ ЗҮЙН ТАЛААР БУСАД ОРНУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ТУРШЛАГА

Хүн ам зүйн талаар бусад орнуудын баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй туршлагыг судлахын тулд юуны өмнө хүн ам зүйн тухай ойлголт, түүнийг судалдаг шинжлэх ухааны онолын мэдлэгийг ерөнхий байдлаар товчхон авч үзэх шаардлагатай юм.

Доорх орнуудыг сонгохдоо эдийн засгийн өндөр хөгжилтэй болон хүн ам цөөн, түүнчлэн цөөн хүн амтай ч богино хугацааны дотор хүн амаа өсгөсөн, хүн ам зүйн үндсэн үзүүлэлтийн хувьд таатай нөхцлийг бүрдүүлсэн зэрэг үзүүлэлтүүдээр сонгосон бөгөөд мэдээллийг интэрнэтийн эх сурвалжаас<sup>23</sup> авсан болно.

#### ОХУ

ОХУ бол хүн ам зүйн талаарх хамгийн нарийн чанд, цэгцтэй бодлого баримталдаг улс орон гэж үзэж болохоор байна. Учир нь хүн ам зүйн талаар төрөөс баримталж буй бодлого, хүн ам зүйн хөгжлийн стратеги нь тодорхой хугацаатай, нарийн төлөвлөгөөтэй байна. Тухайлбал, тухайн улсын 2001 онд “Хүн ам зүйн хөгжлийн коцепци” баталсан бөгөөд түүний хүрээнд “2025 он хүртэл баримтлах хүн ам зүйн хөгжлийн стратеги” төлөвлөгөөг ч бас баталсан байна.

Оросын ойрын 20 жилийн хүн амзүйн хөгжлийн стратегийн зорилго, түүнд өгсөн судлаачдын үнэлгээ:

2001 оны 9 сард Засгийн газар “Оросын хүн ам зүйн хөгжлийн конценци”-ийг баталсантай холбоотой энэ салбарт хэд хэдэн арга хэмжээ хэрэгжүүлсэн байна. Үүнд: төрөлттэй холбоотой нэг удаагийн тэтгэмж 2 удаа нэмэгдсэн, 2002-2010 онуудад хэрэгжих “Орон сууц” хөтөлбөрийн “Залуу гэр бүлийг орон сууцаар хангах” дэд хөтөлбөр батлагдсан, шилжилт хөдөлгөөнийг зохицуулсан хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулсан, бүсчилсэн үзэл баримтлал болон төрөлт нас баралтын салбарын нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээний хөтөлбөр боловсруулалтын шатанд явагдаж байна.

Хэдийгээр дээрх арга хэмжээг авсан ч өнгөрсөн жилүүдэд хүн ам зүйн нөхцөл байдалд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсангүй гэж олон нийт, судлаачдын зүгээс үзэж байгаа юм. Энэ нь:

- Засгийн газрын дээрх арга хэмжээнүүдэд гаргасан зардал нь хангалтгүй байсан бөгөөд хүн амын нөхөн үржихүй ба шилжилтэд гарч буй сөрөг хандлагуудыг зогсоох чадваргүй байсан,
- Эдгээр арга хэмжээнүүд нь тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдээгүй байсан. Жишээ нь төрөлтийн хүрээнд хоёр дахь болон гурав дахь хүүхэд төрүүлэх үед олгох урамшуулалд гол анхаарал чиглэгдээгүй бөгөөд нийгмийн халамж шаардлагагүй анхны хүүхдэд чиглэсэн нь гол алдаа гэж үзжээ. Шилжилтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь шилжин ирэгсдийг татах бус тэдгээрийн урсгалыг

<sup>23</sup> <http://www.budgetrf.ru/Publications/Magazines/VestnikSF/2005/vestniksf277-25/vestniksf277-25130.htm>

зогсоох, иргэний харъяалал авахад хүндрэл үүсгэхэд нөлөөлсөн гэж үзжээ.

Ингээд үр дүнд нь 2000-2004 оны төрөлтийн өсөлт нь хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүн биш харин бүтцийн хүчин зүйл байсан. Өөрөөр хэлбэл, энэ нь 1980-аад онуудад төрөлт өндөр байсантай холбоотой гэж үзсэн байна. Төрөлт өссөнтэй зэрэгцэн нас баралт мөн өсчээ. Шилжин ирэгсдийн өсөлт мөн 5 дахин буурчээ.

2001 онд батлагдсан концепцид “ОХУ-ын хүн ам зүйн хөгжлийн зорилго бол хүн амын тоог тогтворжуулах ба хүн ам зүйн өсөлтийг дагуулах хүчин зүйлийг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна. Уг концепцийн анхны боловсруулалтанд тухайн үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилгод хүрэхэд нөхөн үржихүйн төдийгүй шилжилтийн эх үүсвэрийг дайчлана гэж заасан байсан ч холбогдох байгууллагын санал авах явцад уг заалт өөрчлөгдсөн байна.

Хүн ам зүйн хөгжлийн зорилгын хүрээнд хүн амын чанарыг сайжруулах асуудал байж болохгүй учир нь энэ нь нийгмийн бодлогын гол зорилго гэж үзжээ. Гэвч хүн ам зүйн өсөлт, чанарын өсөлт хоёрыг аль алиныг нь нэгэн зэрэг хэрэгжүүлсэнээр л хүн амыг өсгөж болно гэж ОХУ-ын хүн ам зүйч эрдэмтэд үзсэн байна. Уг концепцийн дутагдалтай талуудыг судлаач, эрдэмтдийн шүүмжлэлтэй байр сууринаас<sup>24</sup> үзвэл:

Нэг: XXI зууны эхний 25 жилийн Оросын хүн амын хөгжлийн онцлогийг тооцоогүй явдал гэж судлаачид үзжээ. Энэ нь өмнөх үеийн буюу 1980-аас 1990-ээд онуудын үеийн төрөлтийн түвшинтэй холбоотой.

Хоёр: Ойрын 15-20 жилд төрөлт яаж ч өслөө гэсэн хөдөлмөрийн эх үүсвэрт өсөлт өгч чадахгүй. Иймээс 2-3 дахь 5 жилд гадаад ажиллах хүчийг дээд хэмжээгээр ашиглаж, тэднийг иргэншилдээ татах, мөн хүн амын нас баралтын түвшинг бууруулах, тэр тусмаа хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн нас баралтыг бууруулах дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзжээ.

Гурав: Концепцийн тунхаглалын тал дээр гарсан гэж судлаачид дүгнэсэн байна. Энэ нь:

- Хүн ам зүйн үзүүлэлтүүдийн тодорхой хугацаанд хүрэх босгыг тогтоогоогүй,
- Захиргааны бүтцэд тавьсан зорилгод чиглэсэн улсын хүн ам зүйн хөгжлийг зохицуулах байгууллага байхгүй байгаа явдал гэж дүгнэжээ.

Дөрөв: Оросын хүн ам зүйн хөгжлийн Концепци нийт улсыг хамарч чадаагүй гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, бусад салбарт, тэр дундаа хүн амын хэлбэлзэлд шууд нөлөөлөх салбарт хэрэгжиж байгаа бодлого нь хүн ам зүйн хөгжлийн стратегид харшлахгүй байх тийм шинжийг тус концепцоор олгоогүй гэж дүгнэсэн байна.

“Оросын хүн ам зүйн хөгжлийн ойрын 20 жилийн стратеги”-ийн **зорилго нь** нөхөн үржихүйн болон шилжилт өөрчлөлтийн харилцан адилгүй хамаарлын үндсэн дээр хүн амын тоог тогтворжуулж түүний өсөлтийг бий болгох явдал юм. Энэ зорилго нь XXI зууны эхний хагаст ялгавартайгаар хэрэгжинэ гэж судлаачид үзэж байна. Энэ нь төрөлтийн хэлбэлзэл, шилжилтийн эх үүсвэрийг ашиглах урьдчилсан боломжуудаас хамаарна. Ингэхдээ шилжилтийн хүчин зүйл нь оросын угсаатны зүйн бүтцэд нөлөөлж болохыг анхаарах хэрэгтэй ажээ.

Хүн ам зүйн бодлогыг төрөлт, нас баралт, шилжилтэд нөлөөлөх бүтцийн элемент болгохын тулд дараахь зүйлсийг анхаарах шаардлагатай гэж ОХУ үзжээ:

<sup>24</sup> [www.expert.ru/.../demography/](http://www.expert.ru/.../demography/)

- Тус бүрийн босго үзүүлэлттэй таван жилийн хүн ам зүйн хөгжлийн үе шатыг боловсруулах, эдгээр нь ямар бодлого баримтлахаас хамааран өөр өөр байж болно
- Концепци нь бүх нийтийн статустай байх ёстой ба өөрөөр хэлбэл бусад салбарт, тэр тусмаа хүн ам зүйн үзүүлэлтүүдэд шууд нөлөөлөх салбарт хэрэгжиж байгаа бодлогууд концепцийн үзэл санаа, зорилгод харшлахгүй байх,
- Концепци батлагдахтай зэрэгцээд холбооны улсын хэмжээнд төрөлтийг нэмэгдүүлэх, гэр бүлийн институтийг бэхжүүлэх, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, наслалтыг уртасгах, цагаачдыг татах, байнгын оршин суух эрхийг хангах талаар адил арга хэмжээ авах,

ОХУ-ын хүн ам зүйчид болон төрийн байгууллагуудын үзэж байгаагаар хүн ам зүйн бодлого үр дүнтэй байх ёстой, энэ утгаараа их хэмжээний хөрөнгө шаардагдана гэдэг дээр санал нэгдээд байна. Түүнчлэн, Монгол улсын ТЕГ-ын “Сургалт, судалгаа дүн шинжилгээний төв”-өөс зохион байгуулсан судалгааны уулзалт<sup>25</sup> дээр тавигдсан илтгэлүүдийн хүрээнд ОХУ-ын хүн ам зүйн талаар дараахь баримт дурьдагдсан байна. Тус улсад 2009 оны байдлаар байнга оршин суугч иргэд өмнөх оныхоос 0,08 хувиар буурсан үзүүлэлт гарсан бөгөөд гол шалтгаан нь хүн амын шилжин суурьших хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой гэж үзжээ. Түүнчлэн, хүн амын нас баралт 2009 оны 10 сард өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 75,6 мянгаар буурсаны дотор нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 0,5 мянгаар буурсан үзүүлэлттэй байна. Тус улсын “Эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн Яам”-ны мэдээлснээр 2009 оны 10 сарын байдлаар 1 сая 475 мянган хүүхэд мэндэлсэн нь сүүлийн 15 жилд анх удаагаа төрөлт нь нас баралтаасаа давсан үзүүлэлт гарчээ.

Төрсөн эхэд олгодог 250 рублийн тэтгэмжийг 2009 оны 1 сарын нэгнээс 312 мянган рубль болгон нэмэгдүүлсэн бөгөөд өнөөгийн байдлаар 0,3 сая эх энэ тэтгэмжийг аваад байгаа гэжээ. Энэ нь ОХУ-ын хүн амын өсөлтийн талаар баримталж буй бодлогын тод илэрхийлэл юм. Түүнчлэн 2009 онд жирэмсэн үеийн 25 мянга 390 рубль байсан тэтгэмжийн хэмжээг 2010 онд 34 мянга 583 рубль болгон нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс гадна хүүхэд асаргааны тэтгэмж сар бүрийн 7 мянга 492 рублийг ирэх онд 13 мянга 833 рубль болгон нэмэгдүүлэх ажээ.

2009 оны 11 сарын байдлаар нийт хүн амын 53 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа үзүүлэлт гарсан бөгөөд нөгөө талаас ажилгүйдэл хөдөлмөрийн чадвартай иргэдийн 8,3 хувийг хамарч байгаа нь 2009 оны 3 сартай харьцуулбал ажилгүйдлийн түвшин аажмаар буурсан дүн гарчээ.

### ОХУ-ын “Хүн ам зүйн бодлого”-ын үзэл баримтлал, чиглэл:

Оросын хүн ам зүйн хөгжлийн стратеги нь үндэсний ашиг сонирхолд тулгуурлан боловсруулагдсан бөгөөд хүн амын хэлбэлзлийг тогтоох, түүний босго үзүүлэлтийг тодорхойлох, тухайн баримт бичгээр дэвшүүлсэн зорилгод хүрэх арга замыг боловсруулах, хүн ам зүйн бодлогын үндсэн зарчмуудыг тодорхойлох зорилготой<sup>26</sup> юм хэмээн баримт бичигт дурьджээ. *Тухайн баримт бичгээр тодорхойлсон үндсэн зарчмууд нь:*

1. Хүн ам зүйн аль үзүүлэлтэд нөлөөлөхөөс үл хамааран төрөөс хэрэгжүүлэх бүх арга хэмжээнүүд хоорондоо зохицсон байх бөгөөд энэ нь улсын хүн ам зүйн хөгжилд олон чиглэлийн нөлөө үзүүлэх боломжийг бий болгох,
2. Шинэ хүн ам зүйн давалгаа гаргахгүй байх, эсвэл түүнийг намжаахын тулд мөн төсвийн дарамтийг бууруулахын тулд хүн ам зүйн бодлогын арга хэмжээнүүд нь

<sup>25</sup> [www.expert.ru/.../demography/](http://www.expert.ru/.../demography/)

<sup>26</sup> <http://www.budgetrf.ru/Publications/Magazines/VestnikSF/2005/vestniksf277-25/vestniksf277-25130.htm>

дараахь байдалтай байх шаардлагатай:

- Үе шаттайгаар өөр өөр нутаг дэвсгэрүүдэд хүн ам зүйн бодлогыг хэрэгжүүлэх. Тухайлбал, эхний ээлжинд геополитикийн хувьд хамгийн чухал хязгаар бүсүүдэд болон хамгийн таатай бус нөхцөлтэй газруудад хэрэгжүүлэх бөгөөд харин сүүлд нь хамгийн таатай нөхцөлтэй бүсүүдэд хэрэгжүүлнэ.
  - Хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой бүлгүүдэд хувааж 4-5 жилийн хугацаанд тогтмол хэрэгжүүлнэ.
3. Хос болон ганц бие хүн хэдийд, ямар зайтай, хэдэн хүүхэд төрүүлэхээ өөрсдөө шийдэх гэр бүл төлөвлөлтийн эрхтэй байдгийг харгалзах, түүнчлэн Засгийн газар дотоод хэрэгцээндээ таарсан бодлогыг явуулах эрхтэй байх,
  4. Хүн ам зүйн өсөлт нь бүх нийтийн зорилго байх ба үүнд хүрэхийн тулд дарамтыг бүгдэд тэгш хуваарилах, Тухайлбал, Хүүхэдгүй болон хүүхэдтэй болохыг хүсдэггүй /хүүхэд үрчлэхийг оруулаад/ хүмүүс хүн амын нөхөн үржихүйн үндсэн ачааллыг үүрч байгаа хэсэгт санхүүгийн тусламж үзүүлэх, /хүүхэдгүйн татвар төлөх, тэтгэврийн насыг нэмэгдүүлэх гэх мэтээр/
  5. Хүн амын наслалтыг уртасгахад чиглэсэн арга хэмжээнүүд нь нийгмийн бүхий л давхаргыг хамрах бөгөөд өвчтнүүдийн эмчилгээг сайжруулах, эрүүл хүмүүсийн эрүүл мэндийг хадгалах, хамгаалах, хар тамхинд донтох, архинд донтох гэх мэт нийгмийн гажуудалд өртсөн хэсгийг нөхөн сэргээх, донтолтоос гаргах,
  6. Шилжилтийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь хүн амын өсөлтөд нөлөөлөх хэрэгтэй ба донор орнууд болон суурьшлийн бүсүүдийг сонгохдоо улсын геополитикийн ашиг сонирхлыг тооцох, боломжит угсаатны зүйн хөдөлгөөнийг хянах,
  7. Хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн санхүүжилт нь төрийн болон, орон нутгийн төсвөөс, мөн төсвийн бус эх үүсвэрээс санхүүжигдэх бөгөөд ингэхдээ улсын секторын аливаа субъектын санхүүгийн байдлыг харгалзан үзнэ. Улсын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилтын хамгийн бага хэмжээг тогтоож өгөх хэрэгтэй ба улсын аль ч субъект энэ хэмжээнээс зайлсхийж болохгүй гэсэн үндсэн зарчмуудыг баримталжээ.

### Бүгд Найрамдах Франц Улс

Франц улсын хувьд хүн ам зүйн өсөлтийг нэмэгдүүлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлж чадсанаараа хүн ам зүйн бодлогын тодорхой загвар орноор тооцогддог байна. Өөрөөр хэлбэл, Франц нь Европын орнуудаас анхлан хүн амын бууралттай тулгарч, түүнийг даван туулах болон хүн амын тоог өсгөх арга хэмжээний цогц системийг боловсруулж чадсан улс юм.

Францийн хүн амын тооны хэлбэлзлийг сонирхвол дараахь байдалтай байжээ: 1801 он – 28.3 сая хүн, 1901 он – 40.7 сая хүн, 2002 он – 59.8 сая хүн. XIX зууны төгсгөл XX зууны эхэн үед Францийн хүн амын төрөлт болон ердийн өсөлт эрс буурч эхэлсэн бөгөөд энэ нь олон тооны жижиг хөрөнгөтнүүдийн давхаргад гэр бүл дэх хүүхдийн тоог хязгаарлах эрмэлзлээр тайлбарлагддаг байжээ. Тухайн үед нас баралтын түвшний байнгын бууралтыг үл харгалзан төрөлтийн түвшний бууралтын хэмнэл илүү өндөр байжээ. XX зуунд дэлхийн 2 дайнд оролцсон болон 30-аад оны дэлхийн хямралд өртсөн зэрэг нь хүн амын бууралтад нөлөөлжээ. 1914-1919 онуудад Франц улсын хүн ам 3 сая хүнээр багассан бөгөөд 1939-1945 онуудад дахиад 1.2 сая хүнээр багассан байна.

Энэ үед буюу 1920-оод оноос эхлэн Францийн төр засгаас төрөлтийг нэмэгдүүлэх хүн ам зүйн идэвхитэй бодлого явуулж эхэлсэн байна. 1967он хүртэл жирэмслэтээс сэргийлэх хэрэгслийн худалдааг хориглон, 1975 он хүртэл үр хөндөлтийг хориглосон хууль гаргасан байна.

1946 онд Францид гэр бүлд үзүүлэх мөнгөн төлбөрийн болон татварын хөнгөлөлтийн



систем өргөн нэвтэрсэн байна. Энэ нь нэг дэх, хоёр дахь тэр тусмаа гурав дахь хүүхдийн төрөлтийг урамшуулахад чиглэгдсэн байна. Үр дүнд нь Баруун Европын орнууд дундаас 1980-аад онд Франц нь хамгийн өндөр төрөлтийн нийлбэр коэффициенттэй буюу 1.8-1.9 коэффициенттэй орнуудын нэг болсон байна. Хүн ам нь жил бүр 0.3-0.4%-аар өсөж байжээ.

Хүн амын өсөлтийн горим удааширсан нь Засгийн газрыг гадаад ажилчдын шилжих хөдөлгөөнийг урамшуулах, төрөлтийг нэмэгдүүлэх эрчимтэй арга хэмжээ авахад хүргэжээ. XIX зууны 60-аад онуудаас XX зууны 30-аад онуудад Францийн хүн амын шилжилтийн өсөлт 3.2 сая хүнд хүрч байсан бөгөөд энэ нь нийт оршин суугчдын өсөлтийн дөрөвний гурвыг бүрдүүлж байсан байна. 1931 онд Францид 2.7 сая гадаадууд, мөн 0.4 сая хүн Францийн харъяат болжээ. 1931 онд уурхайчдын 40-өөс дээш хувийг, төмөрлөгийн ажилчдын 1/3-ийг, барилгачдын 1/4-ийг, хөдөө аж ахуйн ажилчдын 1/3-ийг гадаад ажилчид бүрдүүлж байсан статистик мэдээ байна.

XX зууны хоёрдугаар хагаст, 1946-1974 онуудад Францийн хүн ам 12.1 сая хүнээр өссөн бөгөөд 8.5 сая нь ердийн өсөлтөөр, 2.4 сая нь шилжилтээр, 1.2 сая нь хуучин колони улсуудаас француудыг эргүүлэн татсанаар бүрдсэн байна.

Өнөө үеийн Францийн төрөлтийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хүүхэдтэй өрхийн материаллаг байдалд бодитой нөлөө үзүүлж байна.

Хүүхдэд өгөх үндсэн тэтгэмж нь Францид амьдарч байгаа, түүнчлэн 2-оос доошгүй хүүхэдтэй хүмүүст тэдний хүүхдийн иргэний харъяалал зэргийг харгалзан олгох ба 20 хүртэлх насанд нь харъяалал үл харгалзан олгодог. Тэтгэмжийн хэмжээг хүүхдийн тооноос хамааран ялгавартай тогтоодог байна. Үүнийг доорх хүснэгтээр үзүүлье.

#### **Франц улс дахь өрхийн хүүхдийн тооноос хамааран өссөн тэтгэмжийн хэмжээ**

<b>2 хүүхэдтэй өрхөд</b>	<b>107 евро</b>
<b>3 хүүхэдтэй өрхөд</b>	244 евро
<b>4 хүүхэдтэй өрхөд</b>	382 евро
<b>5 хүүхэдтэй өрхөд</b>	519 евро
<b>6 хүүхэдтэй өрхөд</b>	656 евро

Түүнчлэн, хүүхдийн наснаас шалтгаалан дараахь байдлаар тэтгэмж нэмэгддэг байна. Тухайлбал, 11 наснаас дээш насны хүүхдэд 30 евроны нэмэгдэл, 16-аас дээш насны хүүхдэд 54 евроны нэмэгдэл өгдөг. Ийм нэмэлт нь 2 хүүхэдтэй айлын эхний хүүхдэд олгогддоггүй бөгөөд тухайн өрхийн орлого энэ тэтгэмжийн хэмжээнд нөлөөлдөггүй байна. Харин өрхийн орлого нь дараахь нэмэлт тэтгэмжид хамаардаг байна:

- 3 хүртэлх насны хүүхэдтэй жирэмсэн эх бүрт орлогын хэмжээнээс хамааран жирэмсний 4-р сараас эхлэн 154 евро
- Ганц бие эцэг эхчүүдэд сард 502 евро, хүүхэд бүрийн сар бүрийн 167 евро нэмэгдэл
- Хичээлийн шинэ жилд 6-18 насны сурч буй хүүхэд бүрт 67 евро
- Бага орлоготой болон 3-аас 21 насны 3 болон түүнээс олон хүүхэдтэй өрхөд, эсвэл ганц бие эцэг эхчүүдэд өрхийн нөхөн төлбөр болгож сар бүр 139 евро олгодог байна.

Үүний хажуугаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалтанд зориулж сард 107 евро,



хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд орон байрны тэтгэмж тогтоогдсон байдаг байна. Түүнчлэн 6 хүртэлх насны хүүхэдтэй өрхөд **хүүхдийн асрамжийн мөнгө** олгогддог. Тус тэтгэмжийн хэмжээ нь өрхийн орлогоос хамаардаг бөгөөд дээд хэмжээ нь 3 сард 1500 евро байна. Энэ нь жилийн 33685 еврогийн орлоготой, 3 хүртэлх настай хүүхэдтэй өрхөд олгогдоно. Харин 3-6 насны хүүхдийн тэтгэмж нь 3 сард 500 еврогоос хэтэрдэггүй. Мөн 6-аас доош насны хүүхдэд асрагч хөлсөлж байгаа өрхүүдэд тэтгэмж олгодог байна.

Мөн, хүүхэд нь хүнд өвчтэйн улмаас хагас цагаар ажилладаг болон ажлаасаа урт хугацааны чөлөө авсан эцэг эхчүүдэд тэтгэмж олгодог. Тэтгэмжийн хэмжээ нь үлдэж буй орлогоос хамаарна. Ганц бие эцэг эхчүүдэд нэмэгдэл олгоно. Өнчин хүүхдүүдэд сар бүрийн 100 еврогийн тэтгэмж олгоно.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд ганц удаагийн тэтгэмжүүд олгогдох болсон. Энэ нь анхны хүүхдэд үндсэн цалингийн 260%, дараа дараагийн хүүхдэд 717%, жирэмсний амралтанд цалингийн 90%-ийн хэмжээгээр тэтгэмж олгодог болжээ.

Дээр дурьдсан олон төрлийн тэтгэмжийн бодлого нь Францын хүн амын хурдацтай өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн гэж дүгнэж болох юм. Тодруулбал, тухайн өрхийн орлогыг үл харгалзан олгох хүүхийн мөнгөн тэтгэмж, хүүхдийн тооноос хамаарсан тэтгэмж, жирэмсний болон хүүхэд асаргааны тэтгэмж, орон байрны дэмжлэг гэх мэт эдийн засгийн хөшүүрэг нь төрөлтөд багагүй хэмжээгээр нөлөөлж байгаа юм.

### Шведийн Вант Улс

Швед улс нь 2008 оны байдлаар 9,2 сая хүн амтай, эдийн засаг өндөр хөгжсөн, иргэдийн амьдралын түвшин өндөр орон юм. Энэ улс нь урт хугацааны турш зэс, модны экспортлогч орон байсан бөгөөд 20-р зуунд эдийн засаг, нийгмийн хамгааллын хувьд дэлхийн тавцанд хүчирхэг орон дээгүүр байр суурь эзлэх болсон төдийгүй НҮБ-ын хүний хөгжлийн индексээр тэргүүн орнуудын тоонд байнга дээгүүр бичигддэг байна.<sup>27</sup> Тус улсын хүн амын өсөлт нь өгөөмөр хүн ам зүйн бодлоготой холбоотой гэж судлаачид үздэг байна. Учир нь Швед улс гэр бүлийн тэтгэмжийг өөрийн орны иргэд болон хууль ёсны цагаачдад ч мөн адил олгогддог байна.

Олон улсын стандартаар Швед нь тэгш эрхийг хангагч жишиг орноор тодорсон байна. Скандиновын хойгийн орнуудын жендэрийн бодлогын загвар нь тэгш байдал, тэгш эрх, адил эрх ба боломж, эрх мэдэлд хүрэх тэгш боломжийг олгодог байна. Энэ зарчим нь Шведийн хүн ам зүйн бодлогод тод илэрдэг гэж судлаачид үзжээ.<sup>28</sup> Өөрөөр хэлбэл, Францаас ялгагдах онцлог нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой тэтгэмжийн бодлого байдаг байна. Шведийн Засгийн газрын бодлого нь гэрлэсэн эмэгтэйчүүдийн бие даасан байдлыг бий болгоход чиглэгддэг бөгөөд эмэгтэй хүн бүр орлого олох бодит боломжтой байна гэж үздэг ажээ.

Шведийн мэргэжилтнүүдийн үзэж буйгаар ажил эрхлэлтийн хүрээнд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн эрхийг хамгаалах нь тэгш эрх болон боломжийг хангах бодлогын хүрээнд дэх хамгийн асуудалтай салбар болоод байна. Хөдөлмөрийн зах зээл дээрх тэгш эрхийн асуудлаар хуулийн үйлчилгээнд хамгийн ихээр хандсан нь **жирэмсэн эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхтэй** холбоотой асуудал байдаг байна. Тухайлбал, жирэмсэн эмэгтэйчүүдийн ажилд орох болон гэрээний дагуу ажлаас халахтай холбоотойгоор хөдөлмөрлөх эрхийг хамгаалах асуудал хурцаар тавигддаг байна. Энэ төрлийн бүх

<sup>27</sup> “Дулхийн улс орнуудын парламент”, УИХ-ын ТГ-ын Судалгааны төв, УБ., 2010 он, 705 дахь тал

<sup>28</sup> <http://www.budgetrf.ru/Publications/Magazines/VestnikSF/2005/vestniksf277-25/vestniksf277-25130.htm>

маргааны дийлэнх нь эмэгтэйчүүдийн сонирхлын дагуу шийдэгддэг байна.

Түүнчлэн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад ажиллаж буй эцэг эхчүүдийн ажлын байрыг хадгалах эрх зүйн зохицуулалт үйлчилж байна. Ажиллаж буй эцэг, эхчүүд хүүхдээ нэг нас хүртэл нь асрах чөлөө авах хуульд заасан эрхтэй байдаг (2002 оны 1 сарын 1-ээс 13 сар болсон бөгөөд үүнээс 2 сарыг нь зөвхөн эцэг эдлэх ба энэ нь хүүхдийн хүмүүжилд эцгийг нь эртнээс татан оруулах зорилготой ажээ). Хүүхэд бүрт 18 нас хүртэл нь сар бүр 800 швед кроны /80доллар/ тэтгэмж олгодог бөгөөд дээд сургуульд суралцагсад 2000 швед кроны стипенд, 5000 швед кроны хөнгөлөлтийн зээл сар бүр олгох ба эргэж төлөгдөх хугацаа нь 20 жил байдаг байна.

Гэр бүлийн хөгжил, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах бодлогын хүрээнд төрөөс **гэр бүл төлөвлөлт** болон **залуучуудын сексийн боловсролын** асуудал, **гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд** ихээхэн анхаарал хандуулдаг. Шведэд залуучуудын сексийн боловсролын 250 гаруй төв байдаг байна. Тэдгээр нь орон нутгийн төсвөөс санхүүждэг. Тус төвүүд нь өсвөр насныханд харилцааны сэтгэл зүйн асуудал, жирэмслэлтээс сэргийлэх, гэр бүл үүсгэх зэрэг асуудлаар үнэгүй зөвлөгөө өгдөг. Шаардлагатай хүмүүсийг жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэлээр хангадаг /үнэгүй болон хөнгөлөлтийн үндсэн дээр/. Түүнчлэн өсвөр насныханд бусдын санаа бодлыг тулгалгүйгээр өөрсдөө сексийн хандлагаа олоход туслах зэрэг ажлуудыг идэвхтэйгээр хэрэгжүүлдэг байна. Түүнээс гадна сексийн асуудлаар, хүмүүс хоорондын харилцааны асуудал, өсвөр насныхан өөрсдийн үе тэнгийнхэн болон эцэг эхийн хоорондох зөрчилдөөний талаар зөвлөгөө өгдөг утасны үйлчилгээнүүд олон байдаг. Утасны үйлчилгээ үзүүлдэг төвийн ажилтны бүрэлдэхүүнд эмч, сэтгэл зүйчид, нийгмийн ажилчид, багш сурган хүмүүжүүлэгчид ордог байна.

Шведдэх сексийн боловсролын хөгжил нь урт хугацааны түүхтэй. Анх ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт энэхүү асуудлыг оруулах нь зайлшгүй талаарх асуудал 1905 онд Шведийн сурган хүмүүжүүлэгчдийн Холбооны их хурал дээр хэлэлцэгдсэн бөгөөд 1942 оноос сургуулиудад бэлгийн хүмүүжлийн хичээл орох болжээ. 1960-аад оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулиудад жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл, гэр бүл төлөвлөлт болон нилээн сүүлд үр хөндөлтийн талаарх хөвгүүдийн хариуцлага, ижил хүйсийн харьцааны асуудлаар сургалтын хөтөлбөр явуулдаг болжээ.

Шведэд сексийн цөөнх, уламжлалт бус сексийн хандлага зэрэг нэр томъёонууд нь ялгаварлан гадуурхсан гэж шүүмжлэгддэг, ижил хүйстний гэрлэлт хуулиар зөвшөөрөгдсөн байна. 2002 онд ижил хүйстний гэр бүл хүүхэд үрчлэхийг зөвшөөрсөн хууль батлагдсан ба энэ нь дэлхийн аль ч улс оронд байхгүй жишиг ажээ. Шведэд гэр бүлийн харилцааны хүрээн дэх хамгийн хурц асуудлуудын нэг нь сексийн хүчирхийллийн асуудал гэж хүлээн зөвшөөрөөд байгаа. Хууль эрх зүйн хүрээнд эмэгтэйчүүд гэр бүлийн сексийн хүчирхийллийн талаар шүүхэд хандах эрхтэй. Сексийн хүчирхийлэл нь ихэвчлэн бие махбодийн хүчирхийлэлтэй давхцдаг гэж үздэг учраас тус улсын төрөөс энэ асуудалд онцгой ач холбогдол өгөн хохирогчдийн эрхийг хамгаалах, хохирогчийг нийгэмшүүлэх тал дээр дорвитой арга хэмжээ авдаг байна.

Швед улсын хувьд хүн ам, хөгжлийн бодлогын хүрээнд гэр бүлийн тогтвортой байдалд өндөр ач холбогдол өгч байгаа нь нийгмийн анхдагч суурь болсон гэр бүл нь ирээдүйн иргэний төлөвшилд голлох байр суурь эзэлдгийг бүрэн мэдэрсэн төрийн бодлого гэж үзэхээр байна. Түүнчлэн гэр бүл дэх эцэг эхийн үүрэг хариуцлага ижил байх, тэдгээрт ижил боломж олгох нь хүн амын өсөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлөх шалгуур үзүүлэлт болж байна. Нөгөөтэйгүүр, тухайн улсын эдийн засгийн өгөөмөр бодлого нь хүн амын хөгжлийн индексээр дэлхийд дээгүүр ороход нөлөөлж байна. Тухайлбал, иргэний бүх шатны боловсролд төрөөс үзүүлж буй дэмжлэг тусламж, эрүүл мэндийн салбарт үзүүлж буй дэмжлэг, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт үзүүлж буй дэмжлэг, хуулиар

олгож буй хүйсийн тэгш боломж нь иргэний хөгжилд чухал нөлөө үзүүлж байна.

### Бельгийн Вант Улс

Бельгийн Засгийн газар хүн ам зүйн бодлогын хүрээнд дараахь төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна. Үүнд: тэтгэмж олгох, татвар багасгах, орон байраар хангах болон хүүхдийн сургалтанд мөнгөн тусламж үзүүлэх гэх мэт. Хүүхдийн тэтгэмж нь хүүхдийн наснаас хамааран өсөх бөгөөд 14 ба түүнээс дээш насны хүүхдийн тэтгэмж нь 14 хүртэлх насны хүүхдийн тэтгэмжээс 3 дахин их байдаг байна. Хэрвээ хүүхэд сурдаг бол тэтгэмж нь 25 нас хүртэл олгогддог байна. Энэ нь хүүхдийн наснаас хамааран хэрэглээ өсөж байгааг мэдэрсэн төрийн бодлогын илрэл юм.

### Бүгд Найрамдах Австри Улс

Австри улсын хувьд хүн ам зүйн бодлогын хүрээнд өрхөд үзүүлэх хүүхдийн тэтгэмж болон бусад хөнгөлөлтийн хэмжээг тогтооход өрхийн орлого биш харин өрхийн хүүхдийн тоог чухалчилан үздэг байна. Энэ нь хүн амын өсөлтийг нэмэгдүүлэх хүн ам зүйн бодлоготой холбоотой юм. Өрх бүрт олгох тусламж, тэтгэмж нь Австрийн **“Тэтгэмжийн нийтийн сан”**-гаас олгогддог байна.

“Тэтгэмжийн нийтийн сан”-д өрхийн аливаа тэтгэмжийг олгох бүхий л бүрэн эрх шилжсэн байдаг ба гол эх үүсвэр нь үйлдвэрлэлийн татварын орлогоос бүрддэг байна. Бусад эх үүсвэр нь Засгийн газар болон мужын захиргааны байгууллагаас олгох төсөв байх ба эдгээр нь татварын орлогоос хуваарилсан хөрөнгө байдаг ажээ. Мужууд нь өрхийн “Тэтгэмжийн нийтийн сан”-д хөрөнгө хуваарилахдаа өөрийн нутаг дэвсгэрийн оршин суугчдийн хувь тэнцүүлсэн байдлаар хөрөнгө оруулдаг. “Тэтгэмжийн нийтийн сан” нь Гэр бүл, залуучууд, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах сайдын удирдлага доор байдаг байна. Хүүхдийн тэтгэмжийн хувьд хэрэв хүүхдүүд сурдаг бол тэднийг 27 нас хүртэл нь олгодог байна.

### Бүгд Найрамдах Итали Улс

Италийн хүн амзүйн бодлогын гол зорилгын нэг нь эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах болон гэр бүлийн халамжийг сайжруулах бодлого юм. Өрх бүрт олгох тэтгэмж нь тухайн өрхийн сар бүрийн дундаж орлогоос хамааран олгогддог байна. Тэтгэмжийн хэмжээ нь өрхийн орлогоос урвуу, өрхийн гишүүдийн тоотой шууд хамааралтай байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн өрхийн орлого бага байх тохиолдолд тэтгэмжийн хэмжээ өсөх бөгөөд өрхийн хүн ам олон бол тэтгэмжийн хэмжээ нь ч мөн адил түүнийг дагаад өснө. Энэ нь Итали улсын төрөлтийг дэмжиж буй бодлогын нэг хэлбэр юм. Харин 41 721 еврогоос их орлоготой өрхөд тэтгэмж олгохгүй бөгөөд хэрэв хүүхэд суралцаж байгаа бол 25 нас хүртэл нь тэтгэмж олгодог байна.

### Америкийн Нэгдсэн Улс

АНУ нь хүн ам зүйн талаарх төрөөс баримталж буй бодлого нь хамгийн тодорхой бус орон ажээ<sup>29</sup>. Учир нь, Хүн амын механик өсөлт явагдах нөхцөл бүрдсэн, хүүхэдтэй гэр бүлийг татвараар дэмжих арга хэмжээ авдаг, мөн бусад янз бүрийн орон нутгийн болон эвлэлийн хөтөлбөрүүд хэрэгждэг байна. Энэ нь өнөөгийн байдлаар бусад хөгжингүй орнуудтай харьцуулахад АНУ-ийн хүн ам зүйн байдал илүү таатай байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, тухайн улс дэлхийд тэргүүлэх байр суурьтай, цагаачдыг их татдаг ба улс орны сонирхолд нийцүүлэн харъяатыг сонгох боломжтой гэдгээр тайлбарлагддаг байна.

<sup>29</sup> <http://www.budgetrf.ru/Publications/Magazines/VestnikSF/2005/vestniksf277-25/vestniksf277-25130.htm>

## Европын Холбоо

Европын холбооны гишүүн орнуудын хувьд хүүхэдтэй гэр бүлийг төрөөс дэмжихтэй холбоотой зарчмын хандлагууд дээр тодорхой зөвшилцөлд хүрсэн байдаг ажээ. Тодруулбал, 1989 онд батлагдсан “Гэр бүлийн бодлогыг хариуцсан сайд нарын зөвлөлийн тогтоолд”-д Евро Комисс тухайн үед үүсээд байсан нөхцөл байдлыг дараахь байдлаар тодорхойлсон байна. *“Гишүүн орнуудад гэр бүлийн институтэд хандах олон янзын хандлага ажиглагдаж байна. Холбооны улсуудын гэр бүлд чиглэсэн Засгийн газрын ойлголт өөр өөр байна.*

*Түүнчлэн нийгмийн халамж, татварын бодлого, гэр бүлийн эрх, өөр бусад чиглэлүүдийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төрөл бүрийн арга хэмжээний тусламжтайгаар бүх л гишүүн орнууд дахь холбогдох Төрийн байгууллагууд нь өрхийн амьдралын харилцааг зохицуулж байна. Гэр бүлийн бодлого нь эдгээр арга хэмжээнүүдийн нийлбэр цогц юм.”* гэжээ. Энэ тогтоолд гэр бүлийн бодлого нь хамгийн өргөн хүрээгээр тайлбарлагдаж байгаа бөгөөд хүн ам зүйн бодлогыг багтаасан байна.

Өрхийн тэтгэмж нь Европын холбооны орнуудад хэрэгжиж байгаа гэр бүлийн талаар баримталж буй бодлогын нэг хэлбэр юм. Холбооны хувьд тэтгэмж бага хэрэглэгддэг улс орнуудад татварын хөнгөлөлт маш өргөн хэмжээгээр ашиглагддаг байна. Жишээлбэл, Исландад хүүхдийн үндсэн тэтгэмж нь татварын суутгал хэлбэрээр тооцогддог ба татварын алба хэрэгжилтийг нь хангадаг байна.

**Хүүхдийн үндсэн тэтгэмж болох татварын суутгал** нь 7 хүртэлх насны хүүхэд бүрт өрхийн орлогоос үл хамааран адил байх ба татварын хөнгөлөлт нь хатуу шинж чанартай. Европын холбооны ихэнх орнуудад хүүхэдтэй өрхөд олгох тэтгэмж тухайн улсын төсвөөс төлөгддөг ба ингэхдээ тухайн иргэн нийгмийн даатгал төлсөн эсэхээс хамаардаггүй байна. Тэтгэмж авах гол үндэслэл нь хүүхэд болон эцэг эх нь тухайн орны оршин суугч байх явдал юм. Гэхдээ, Германд хүүхдийн тэтгэмж авахын тулд эцэг эхийн аль нэг нь тухайн оронд татвар төлсөн байхад л хангалттай байдаг.

Европын холбооны ихэнх орнуудад тэтгэмжийн хэмжээ хүүхдийн наснаас хамаарч байдаг. Зөвхөн Данид л хүүхдийн нас нэмэгдэх тусам тэтгэмжийн хэмжээ багасч байдаг бол бусад орнуудад нэмэгдэж байдаг. Үүний хажуугаар ихэнх орнуудад бага насны хүүхдэд олгох нэмэлт тэтгэмжийн бодлого баримталдаг байна.

Европын холбооны зарим оронд тэтгэмжийн хэмжээ хүүхдийн төрөлтийн дарааллаас хамааран ялгавартай тогтоогддог байна. Үүний хажуугаар зөвхөн Их Британид л эхний хүүхдийн тэтгэмж 103 фунт стерлинг байдаг бөгөөд энэ нь дараа нь төрсөн хүүхдүүдийнхээс 69 фунтээр өндөр байдаг ажээ. Бусад тохиолдолд тэтгэмжийн хэмжээ төрөх дараалийн дагуу өсч байдаг байна. Францид эхний хүүхдэд үндсэн тэтгэмж олгодоггүй. Ихэнх орнуудад хүүхдийн тэтгэмжийн эрх нь өрхийн орлоготой хамааралгүй байдаг ажээ.

Өнөө үед Европын холбоонд хүн амын өсөлт зогсонги байдал орж, хүн амын хөгшрөлт, хөдөлмөрийн нөөц багасах зэрэгтэй холбоотойгоор хүн ам зүйн бодлогод хандах шинэ хандлага боловсруулах сонирхол хүчтэй болсон байна.

Судалгааны энэ бүлгийн хоёр болон гурав дахь дэд сэдвүүдэд Монгол улсын хүн ам зүй, түүний үндсэн үзүүлэлтүүдийн динамик судалгаа болон Төрөөс хүн ам зүйн талаар баримталж буй бодлого, түүний хүрээнд хэрэгжүүлж буй Засгийн газрын хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал, ололт амжилт болон бэрхшээл дутагдалтай талууд, цаашид авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар авч үзсэн бөгөөд эцэст нь судалгааны энэ хэсэгт орсон гадаадын зарим орны хэрэгжүүлсэн туршлагатай холбогдуулан цаашид авах арга хэмжээний талаарх санал зөвлөмжийг судлаачдын баг боловсруулсан билээ.

### 1.7. ХҮН АМ ЗҮЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ САНАЛ ЗӨВЛӨМЖ

1994 онд Кайр хотноо болсон “Хүн ам ба хөгжил” олон улсын бага хуралд 179 орон оролцсон бөгөөд түүний дотор Монгол улс ч багтсан билээ. Тус хурлаар улс орнууд хүн ам ба хөгжлийн үндсэн зарчим, холбогдох асуудлаар зөвшилцөлд хүрч, 20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийг баталсан байна. Тус “Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 1999 онд анхны үнэлгээ хийсэн бөгөөд дүнг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулганаар хэлэлцэж “Дараагийн шатны үндсэн арга хэмжээ”-ний баримт бичиг болгон баталжээ.

Тус олон улсын бага хуралд оролцсоноос хойших 15 жилд Монгол улсын хүн ам хөгжлийн асуудлаар ихээхэн ахиц гарсан гэж Монгол улс дах НҮБ-ын ХАС дүгнэжээ. Бага хурлаас дэвшүүлсэн хүн амын ядуурлыг бууруулах, хүн ам ба хөгжил, жендэрийн тэгш байдлыг хангах, эрүүл мэндийг сайжруулах гол зорилтуудын хүрээнд Монгол улсын Парламент болон Засгийн газраас холбогдох бодлогын баримт бичиг, тухайн салбарын мастер төлөвлөгөө, түүнд холбогдох үндэсний хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Өөрөөр хэлбэл, хүн ам зүй болон хүн амын хөгжлийн талаарх бодлого, хөтөлбөрүүд нь Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци, Монгол улсын Мянганы хөгжлийн зорилттой тодорхой хэмжээгээр уялдуулан боловсруулсан боловч зарим заалтуудын хувьд тунхаглалын шинж чанартай байна. Түүнчлэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн шатанд илэрхий алдаа дутагдлууд гарч байгаа бөгөөд үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн чадвар дутмагаас болж хэрэгжилтэнд ахиц гарахгүй байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн, 2010 оны УИХ-ын 48-р тогтоолоор баталсан **“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”**-д “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн.” гээд тус үзэл баримтлалын 3.1.3 дахь хэсэгт хүн ам, удмын сангийн аюулгүй байдлын талаар дараахь заалтуудыг оруулсан байна. Үүнд:

- 3.1.3.1. Монгол Улсын хүн амын өсөлтийг дэмжиж, монгол хүний хөгжил, амьдралын чанарт дэвшил гаргана.
- 3.1.3.2. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа иргэддээ эх орондоо эргэн ирж ажиллаж, амьдрах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.
- 3.1.3.3. Гадаадад төрж тухайн улсын иргэний харьяалалтай болсон иргэд, тэдний үр хүүхдэд Монгол Улсад зорчих, оршин суух, суралцах, ажиллаж амьдрах, даатгалд хамрагдах таатай нөхцөлийг бүрдүүлнэ. Хоёрдмол харьяалал үүсч, төрөөс иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах баталгаа алдагдахаас сэргийлнэ.
- 3.1.3.4. Цус ойртолтыг багасгах, архидан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулна.
- 3.1.3.5. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалж, бүртгэл, мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.
- Энэхүү заалтууд нь төрөөс хүн ам зүйн талаар баримталж буй гол үзэл баримтлал бөгөөд үүнд нийцүүлэн судалгааны багаас дараахь санал зөвлөмжийг боловсруулж байна.

### Хүн амын өсөлтийг дэмжих, монгол хүний хөгжил, амьдралын чанарт дэвшил гаргах бодлогын хүрээнд:

Судалгаанд хамрагдсан ОХУ, Швед, Франц, Итали, Бельги гэх мэт орнуудын хүн ам зүйн бодлоготой холбоотойгоор хэрэгжүүлдэг арга хэмжээг нэгтгэн үзвэл дараахь төрлийн эдийн засгийн арга хэмжээнүүд хүн амын өсөлтөд тодорхой нөлөө үзүүлж байна. Үүнд:

- Гэр бүлийн тэтгэмж олгох. Тэтгэмжийн хэмжээ нь өрхийн орлогоос урвуу, өрхийн гишүүдийн тоотой шууд хамааралтай байх,
- Хүүхдийн тэтгэмж болон бусад хөнгөлөлтийн хэмжээг тогтооход өрхийн орлого биш харин өрхийн хүүхдийн тоог чухалчилан үздэг, хүүхдийн тоо ихсэх тусам хүүхдийн тэтгэмжийн хэмжээ ч нэмэгдэнэ,
- Хүүхдийн тэтгэмж нь хүүхдийн наснаас хамааран өсөх бөгөөд 14 ба түүнээс дээш насны хүүхдийн тэтгэмж нь 14 хүртэлх насны хүүхдийн тэтгэмжээс 3 дахин их байдаг. Хэрвээ хүүхэд сурдаг бол тэтгэмж нь 25 нас хүртэл олгогддог байна. Энэ нь хүүхдийн наснаас хамааран хэрэглээ өсөж байгааг мэдэрсэн төрийн бодлогын илрэл ажээ.
- Зөвхөн тэтгэмж олгохоос гадна татвар багасгах, орон байраар хангах болон хүүхдийн сургалтанд мөнгөн тусламж үзүүлэх,
- Гэр бүлийн халамжийг сайжруулах, гэр бүлийн тэтгэмж олгох, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах,
- Шинэ залуу гэр бүлд орон байрны хөнгөлөлт үзүүлэх,
- Тэтгэмж бага хэрэглэгддэг улс орнуудад татварын хөнгөлөлт маш өргөн хэмжээгээр ашиглагддаг,
- Ажиллаж буй эцэг, эхчүүд хүүхдээ нэг нас хүртэл нь асрах чөлөө авах хуульд заасан эрхтэй байдаг ба шинэ төрсөн хүүхдийн эцэгт 2 сарын чөлөө олгох ба энэ нь хүүхдийн хүмүүжилд эцгийг нь эртнээс татан оруулах зорилготой ажээ,
- Суралцагсдад стипенд олгох, хөнгөлөлтийн зээл сар бүр олгох ба эргэж төлөгдөх хугацаа нь 20 жил байдаг
- Жирэмсэн эмэгтэйчүүдийн ажилд орох болон гэрээний дагуу ажлаас халахтай холбоотойгоор хөдөлмөрлөх эрхийг хамгаалах. Энэ төрлийн бүх маргааны дийлэнх нь эмэгтэйчүүдийн сонирхлын дагуу шийдэгддэг,
- Гэрлэсэн эмэгтэйчүүдийн бие даасан байдлыг хангах, эмэгтэй хүн бүр орлого олох бодит боломжтой байх,
- Ажил эрхлэлтийн хүрээнд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн эрхийг хамгаалах,
- 6 хүртэлх насны хүүхэдтэй өрхөд **хүүхдийн асрамжийн мөнгө** олгох,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалтанд зориулж сард 107 евро, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхүүдэд орон байрны тэтгэмж тогтоох,
- Хүүхэд нь хүнд өвчтэйн улмаас хагас цагаар ажилладаг болон ажлаасаа урт хугацааны чөлөө авсан эцэг эхчүүдэд тэтгэмж олгох,
- Тэтгэмжийн хэмжээг хүүхдийн тооноос хамааран ялгавартай тогтоох,
- Францид гэр бүлд үзүүлэх мөнгөн төлбөрийн болон татварын хөнгөлөлтийн систем өргөн нэвтэрсэн.
- Хүн амын өсөлт нь бүх нийтийн зорилго байх ба үүнд хүрэхийн тулд дарамтыг бүгдэд тэгш хуваарилах. Өөрөөр хэлбэл, Хүүхэдгүй болон хүүхэдтэй болохыг хүсдэггүй /хүүхэд үрчлэхийг оруулаад/ хүмүүс хүн амын нөхөн үржихүйн үндсэн ачааллыг үүрч байгаа хэсэгт санхүүгийн тусламж үзүүлэх, /хүүхэдгүйн татвар төлөх, этгээрийн насыг нэмэгдүүлэх гэх мэтээр
- Хүн амын наслалтыг уртасгахад чиглэсэн арга хэмжээнүүд нь нийгмийн бүхий л давхаргыг хамрах бөгөөд өвчтнүүдийн эмчилгээг сайжруулах, эрүүл хүмүүсийн



эрүүл мэндийг хадгалах, хамгаалах, хар тамхинд донтох, архинд донтох гэх мэт нийгмийн гажуудалд өртсөн хэсгийг нөхөн сэргээх, донтолтоос гаргах,

### **Бодлого, хөтөлбөрийг боловсруулах, батлах шатанд анхаарах зүйлс:**

1. Бодлого болон хөтөлбөрүүдийн агуулга, зорилт, хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн төлөвлөгөөг тунхаглалын шинж чанартай боловсруулж байгаад анхаарах,
2. Хөтөлбөрийг боловсруулах шатанд тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхэд шаардагдах мониторинг үнэлгээ хийх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгох,
3. Хөтөлбөрийн санхүүжилтийг батлах, хувиарлах үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн арга зүйд шилжих,
4. Засгийн газраас хэрэгжүүлж буй Үндэсний болон дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны биелэлт болон санхүүгийн хувиарлалтанд хөндлөнгийн мониторинг-үнэлгээ хийх,
5. Хөтөлбөр хэрэгжүүлэгч, санхүүжүүлэгч, хяналтын үйл ажиллагааг тодорхой болгох, хөтөлбөрүүдийн хоорондын харилцан уялдааг сайжруулах, хөтөлбөр хоорондын давхцлыг арилгах,
6. Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа бүх хөтөлбөрүүдийг хэрэгжих боломжтой үндэсний хэмжээний нэгдсэн 1 хөтөлбөрт шилжүүлж, давхцлыг арилгах, тодорхой санхүүгийн эх үүсвэртэй үе шаттайгаар хэрэгжүүлэх, хөндлөнгийн байгууллагаар нэгдсэн байдлаар үнэлгээ хийлгэж, хүрсэн үр дүнг нийтэд ил тод болгох.

## **II. БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН АСУУДЛААРХ СУДАЛГАА, ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **2.1. монгол улсын иргэн, харъяатын асуудлыг зохицуулж буй эрх зүйн орчин, бодлого хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ**

#### **2.1.1. Монгол улсын иргэн, харъяатын харилцааг зохицуулж буй эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ**

Хүн тодорхой нэг улсад эрх, эрх чөлөө эдэлж болох бөгөөд үүнийхээ зэрэгцээ тухайн улсын харъяат байхаас шууд хамааралтайгаар төрийн өмнө үүрэг хүлээдэг. Монгол Улсын харъяат иргэд Монгол Улсын шинэ Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон эрх, эрх чөлөөг эдэлж, үүргээ биелүүлэн, хууль ёсныхоо ашиг сонирхлыг төрөөр хамгаалуулдаг. Монгол Улсын харъяат иргэний эрх, эрх чөлөө зөрчигдөх тохиолдолд Монгол Улс харъяат иргэнээ тус улсын дотоодод төдийгүй гадаадад, өөр улсад сууж байгаагаас үл харгалзан хамгаалж байдаг. Тухайлбал, судалгааны сэдвийн хүрээнд Монгол Улсын иргэн, харъяатын харилцааг зохицуулж буй дараах хуулиудын зохицуулалтыг авч үзлээ. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он
- Харъяатын тухай хууль, 1995 он

Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулинд Монгол Улсын иргэний харъяалал хийгээд харъяат болох, харъяатаас гарах үндэслэл, журмыг гагцхүү хуулиар тогтоох, харъяатаас хасах, эх орноосоо хөөх, өөр улсад шилжүүлэн өгөхийг хориглоно... гэж хуульчилсан явдал бол Монгол улсын харъяат иргэн байх нь тухайн хүний туйлын эрх учраас түүнийг Монголын улсын харъяат иргэн гэдгийг хэн ч, ямар ч хуулиар хасах, эх орноосоо хөөн гаргахыг хориглосоноор баталгаажсан байна.

Түүнчлэн Монгол Улсын Харъяатын тухай хуулиар харъяат болох харъяатаас гарах үндэслэл, харъяатаас татгалзах, сэргээхтэй холбогдсон төрийн байгууллага, Ерөнхийлөгч, төрийн захиргааны байгууллагын эрх хэмжээг зохицуулсанаас гадна хоёрдмол харъяаллыг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэлийг ... Монгол Улсын Иргэн харъяат нэгэн зэрэг гадаад улсын харъяат байхыг хүлээн зөвшөөрөхгүй, гадаадын улсын харъяат Монгол Улсын харъяат болохыг хүсвэл тухайн улсынхаа харъяатаас гарсан байх шаардлагатай ... гэж хуульчилсан.

1995 онд Харъяатын тухай Монгол Улсын хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш Монгол Улсын иргэний харъяатыг тооцох явдлыг нэгдүгээрт ураг төрлийн уламжлалыг, хоёрдугаарт нутаг дэвсгэрийн, гуравдугаарт зөвшөөрлийн гэсэн 3 зарчмаар шийдвэрлэнэ.<sup>30</sup>

Нэгдүгээрт, Ураг төрлийн уламжлалаар Монгол Улсын харъяат байна гэдэг нь

1. Монгол Улсын харъяат эцэг эх хоёрын дундаас төрсөн хүүхэд хаана, аль улсын нутаг дэвсгэрт төрснөөс шалтгаалахгүй Монгол улсын иргэн байна.
2. Эцэг, эх хоёрын аль нэг нь Монгол улсын харъяат, нөгөө нь аль ч улсын харъяат биш иргэдийн дундаас төрсөн хүүхэд хаана, ямарч улсын нутаг дэвсгэрт төрснөөс хамаарахгүй Монгол улсын иргэн байна.
3. Аль ч улсын харъяат биш эцэг эх хоёрт үрчлэгдсэн боловч төрүүлсэн эцэг, эх хоёр нь буюу аль нэг нь Монгол улсын харъяат байсан 16 нас хүрээгүй хүүхэд Монгол улсын харъяат байна.

Хоёрдугаарт, Нутаг дэвсгэрийн зарчмаар Монгол улсын харъяат байна гэдэг нь

- Эцэг эх хоёрын аль нэг нь Монгол улсын харъяат, нөгөө нь аль нэг улсын гадаадын иргэн, харъяат иргэдийн дундаас төрсөн Монгол улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхэд Монгол улсын харъяат иргэн байна.
- Эцэг, эх хоёр нь аль улсын харъяат хэн болох нь тогтоогдоогүй боловч Монгол улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхэд Монгол улсын харъяат байна.

Гуравдугаарт, Зөвшөөрлийн зарчмаар Монгол улсын харъяат иргэн болно гэдэг нь Монгол улсын харъяат иргэн болно гэдэг нь

- Гадаад улсын харъяатаас гарсан буюу аль нэг улсын харъяат биш иргэний Монгол улсын харъяат болох гэсэн хүсэлтийг нь үндэслэн Монгол улсын харъяат болгодог. Гадаадын харъяат байсан буюу аль ч улсын харъяат биш хүнийг Монголын харъяатаар зөвшөөрөх шийдвэр гаргах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан боловсруулж уламжилснаар Монгол Улсын Төрийн Тэргүүн бүрэн эрхийнхээ ёсоор шийдвэрлэдэг.
- Иргэний харъяаллыг сэргээн тогтоох нь зөвшөөрлийн зарчмаар монголын харъяат болох хоёр дахь хэлбэр юм. Урьд нь ураг төрлийн уламжлалаар буюу нутаг дэвсгэрийн болон зөвшөөрлийн зарчмын аль л хэлбэрээр Монгол улсын харъяат байсан боловч хуульд заасан журмын дагуу Монгол улсын харъяатаа алдсан хүмүүсийг дахин Монгол улсын харъяат болгон хүлээн зөвшөөрөх явдал юм. Үүнд
  1. Гадаадын харъяат эхнэр, нөхөр хоёрт үрчлэгдэж тэдгээрийн хүсэлтээр Монголын иргэний харъяаллаа алдсан хүмүүс Монголын харъяат

<sup>30</sup> Г. Совд, Ж. Амарсанаа, Н. Жанцан С. Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ, 200, 77 - 78 дахь тал



болохоор хүсэх

2. Эцэг, эх хоёр нь Монголын харъяатаа өөрчилсөнтэй холбогдож хүүхэд байхдаа Монголын иргэний харьяаллаа алдсан хүмүүс 18 нас хүрсэнээс хойш 5 жил өнгөрсний дараа Монголын харъяат болохоор хүсэх
3. 1921 оны 7 дугаар сарын 11-ний өдөр болон түүнээс хойш Монголын харъяатаас гарч аль нэг гадаад улсын харъяат болсон хүмүүс Монголын харъяат болохоор хүсэх тохиолдолд тэдгээрийн иргэний харьяаллыг сэргээхийг Харъяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уламжилснаар Монгол Улсын Төрийн Тэргүүн шийдвэрлэдэг байна.

Монгол Улсын иргэний харьяалал нь нэгдүгээрт харъяатаас гарах, хоёрдугаарт иргэний харьяаллыг алдах гэсэн хоёр үндсэн шалтгаанаар өөрчлөгдөнө. Монгол Улсын харъяат иргэн өөрийн хүсэлтээр Монгол Улсын иргэнээс гарах эрхтэй. Иргэн Монгол улсын харъяатаас гарах тухай хүсэлтээ Харъяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан Монгол улсын төрийн тэргүүнд гаргах бөгөөд уг этгээдийг Монгол улсын харъяатаас гаргах эсэх асуудлыг төрийн тэргүүн эцэслэн шийдвэрлэнэ.

Харъяатаас гарах хүсэлт гаргасан иргэдийн хувьд дараах шалтгаанаар түтгэлзүүлэнэ,

- Хүсэлт гаргасан иргэн Монгол Улсын буюу иргэний болон байгууллагын өмнө хүлээсэн тэдгээрийн ашиг сонирхолтой холбогдсон эд хөрөнгийн үүргээ биелүүлээгүй,
- Уг этгээд гэмт хэрэгт холбогдож яллагдагчаар татагдан мөрдөгдөж байгаа буюу шүүхээр шийтгүүлж ял эдлэж байгаа
- Уг этгээдийг харъяатаас гаргах нь Монгол улсын үндэсний болон нийгмийн аюулгүй байдалд хохирол учруулахаар шалтгаанууд байвал түүнийг харъяатаас гаргахыг татгалзах ёстой.

*Харъяатаа алдах нөхцөлүүд нь дараах шалтгаанаар бий болно,*

- Гадаадын харъяат эхнэр, нөхөр хоёрт үрчлэгдсэн хүүхдийн харъяатын асуудлыг үрчилж авсан эцэг эх хоёрын хүсэлтийг харгалзан монголын харъяатаас гаргах,
- Эцэг, эх хоёр нь монголын харъяатаас өөрчлөгдсөнөөр хүүхдийн иргэний харьяалал өөрчлөгдөх
- Хуурамч бичиг баримт, худал мэдээлэл бүрдүүлж монголын харъяат болсон байх,
- Монголын харъяатаас гарах,
- Монгол Улсын олон улсын гэрээнд болон харъяатын тухай хуульд заасан бусад үндэслэлээр харъяатаа алдах,

Одоогийн байдлаар гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх алба нь эрхлэх асуудлын хүрээнд иргэн, харъяатын асуудлыг хариуцан хэрэгжүүлж байна. Тус алба нь Хууль зүй дотоод хэргийн сайдын удирдлаган дор үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаад улсад оршин суугаа хүний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэхээр холбогдох бусад бичиг баримт, саналын хамт Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчид өргөн барьж, гарсан шийдвэрийн дагуу Монгол Улсын харъяат болсон, харъяатаас гарсан, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, иргэний харьяаллаа алдсан хүний нэгдсэн бүртгэлийг хөтөлдөг байгууллага юм.

Гадаадын иргэн харъяатын асуудал эрхлэх алба нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон гадаад улсад оршин суугаа хүний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлэхдээ тус улсын тагнуулын болон цагдаагийн төв байгууллага, иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, орон нутгийн цагдаагийн байгууллага, иргэний бүртгэлийн асуудал эрхэлсэн алба, Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар энэ хуульд заасан журам, тус тусын чиг үүргийн дагуу оролцдог.

**Монгол Улсын иргэн, харъяатын асуудлуудыг зохицуулж буй дараахь эрх зүйн актууд үйлчилж байна. Үүнд:**

- Засгийн газрын 2003 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан *“Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам”*
- ГИХАЭА-ны даргын 2002 оны 94 дүгээр тушаалаар баталсан *“Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалт”*
- Хууль зүйн сайдын 1996 оны 225 дугаар тушаалаар *“Монгол Улсын харьяатаас гарахыг хүсч өргөдөл гаргасан Казак үндэстэн Монгол Улсын иргэдийн асуудлыг шийдвэрлэх “түр журам” шаардагдах бичиг баримтын жагсаалт, тэдгээрийг бүрдүүлэх “журам” бичиг баримтын “заавар”*
- Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 237/А/287 дугаар тушаалаар *“Гадаадын иргэнд монгол улсын харьяат хүүхэд үрчлүүлэх журам”*
- *“Гадаадын иргэнд холбогдсон иргэний гэр бүлийн бүртгэлийн байдлын түр журам”-ыг* Хууль зүйн сайдын 1998 оны 123 дугаар тушаалаар зохицуулагдаж байна.

Засгийн газрын 2003 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан *“Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам”* нь Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүн харъяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан 5 төрлийн нөхцөлийг хангасан эсэхийг ГИХАЭ алба тогтоосон байх, тус хуулийн 22 дугаар зүйлийн 6-д зааснаар харъяатын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтыг бүрдүүлсэн байх,

Монгол Улсад 5-аас доошгүй жил байнга оршин суусныг батлах паспорт үнэмлэхтэй байх, зохих байгуулагуудын албан ёсны тодорхойлолт байна гэж заажээ. Дашрамд дурьдахад 2008 онд **22**, 2009 онд **12**, 2010 оны 9 дүгээр сарын 20-ны байдлаар **3**, нийтдээ **37** гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын харьяат болсон.

Мөн ГИХАЭА -ны даргын 2002 оны 94 дүгээр тушаалаар баталсан *“Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалт”*-д хүсэлт гаргагч нь бүрдүүлсэн байх ёстой хувийн болон гэр бүл, ахуй амьдралын талаар бичиг баримт бүрдүүлэх, харьяат болох, харьяатаас гарах, харьяаллаа сэргээхийг хүсэгчдийн анкет бичих аргачлалыг тогтоож өгсөнөөс гадна хүсэлт гаргагч Монгол Улс болон гадаадад ямар нэгэн өр төлбөргүй, нэхэмжлэлгүй байх, гэмт хэрэгт холбогдоогүй байдлыг тогтоох зорилгоор шүүх, цагдаагийн байгууллага, банкны өр барагдуулах алба, татварын байгууллага, сургалтын төрийн сан, өргөдлийн хураамж төлсөн баримт зэргийг бүрдүүлэхээс гадна иргэний харьяаллын асуудлаар хүсэлт гаргагч гэр бүлийн гишүүдийнхээ хамтаар өргөдлөө хамтран гаргаж болох журам тогтоосон байна.

**Монгол Улсын харьяатаас гарсан байдал.** 2008 онд **301**, 2009 онд **276**, 2010 оны 9 дүгээр сарын байдлаар **17503**, нийтдээ **17503**, нийтдээ **18080** иргэн харьяатаас гарсан.

**Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон байдал**

2008 онд **14**, 2009 онд **365**, 2010 оны 9 дүгээр сарын 20-ны байдлаар **106**, нийтдээ **485** хүн Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон. Иргэн харьяатын асуудлаар Монгол Улсын харьяат Казах иргэд хөдөлмөрийн гэрээгээр БНКаЗУ-д ажиллаж байсан болон сайн дураараа шилжин суурьшиж буй казак иргэдээс Казахстан улсын иргэн болох зорилгоор Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтээ гаргах болсон нь тэдгээрийн иргэний харьяалалтай холбоо бүхий нэлээд төвөгтэй асуудлыг буй болгосон байна.

Үүнтэй холбогдуулан Хууль зүйн сайдын 1996 оны 225 дугаар тушаалаар *“Монгол Улсын харьяатаас гарахыг хүсч өргөдөл гаргасан Казак үндэстэн Монгол Улсын иргэдийн асуудлыг шийдвэрлэх “түр журам” шаардагдах бичиг баримтын жагсаалт, тэдгээрийг бүрдүүлэх “журам” бичиг баримтын “заавар”* –ыг батлажээ. Тус журмаар Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын Гадаад хэргийн яамдын Консулын зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотод 2009 оны 11 дүгээр сард болох үеэр Казахстаны тал тус улсад нийт **100 мянга** гаруй Монгол Улсын харьяат казак иргэн оршин сууж байгаагаас **90497** нь тус улсын харьяаллыг авсан талаар албан ёсоор мэдэгдсэн. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын харьяатаас гараад байгаа **48216**, Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сан болон нийт иргэний бүртгэлд байхгүй **15637**-г тус тус хасахад **26644** иргэн хоёрдмол харьяалал үүсгээд байна.

ГИХАЭА нь Монгол Улсын харьяатаас гаралгүйгээр БНКаЗ.У-ын харьяат болж хоёрдмол харьяалал үүсгэсэн **17042** иргэнийг хялбаршуулсан журмаар харьяатаас гаргах асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьж Ерөнхийлөгчийн зарлигаар шийдвэрлүүлсэн байна.<sup>31</sup>

Монгол Улсын гэр бүлийн тухай хуульд зааснаар зохих журмын дагуу гадаадын иргэнд хүүхдийг үрчлүүлж болдог. Энэ журмын дагуу гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлтээ өөрийн улсын эрх бүхий байгуулагаар дамжуулан ГИХАЭА-д гаргадаг бөгөөд дараах журмаар зохицуулагдаж байна. Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 237/А/287 дугаар тушаалаар *“Гадаадын иргэнд монгол улсын харьяат хүүхэд үрчлүүлэх журам”*-ыг баталсан. Гадаадын иргэнд Монгол улсын харьяат хүүхэд үрчлүүлэх журмаар 2007 оноос 2010 оны эхний 08 сарын байдлаар нийт 47 хүүхдийг үрчлүүлсэн мэдээлэл байна.<sup>32</sup>

Гадаадын иргэн, Монгол Улсын иргэд гадаад улсад олноор зорчиж удаан хугацаагаар ажиллаж амьдрах болсонтой уялдан гадаадын иргэдтэй гэр бүл болох нь түгээмэл болж *“Гадаадын иргэнд холбогдсон иргэний гэр бүлийн бүртгэлийн байдлын түр журам”*-ыг Хууль зүйн сайдын 1998 оны 123 дугаар тушаалаар зохицуулагдаж байна.

Энэхүү журмын нийтлэг үндэслэл нь гэрлэснийг бүртгэх, хүүхэд төрсөнийг бүртгэх, хүүхэд үрчилснийг бүртгэх, гэрлэлт цуцалсныг бүртгэх, гэрлэлт сэргээн тогтоосныг бүртгэх, эцэг тогтоосныг бүртгэх, овог, эцгийн нэр, нэр өөрчилсөнийг бүртгэх, нас барсаныг бүртгэх, гэрчилгээ дахин олгох, иргэний гэр бүлийн бүртгэлийн гэрчилгээг хадгалах, тайлагнах журмыг тус тус тусгажээ. Тус журам нь гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, орон нутагт аймгийн Засаг даргын Тамгын газар, гадаад улсад суугаа тус улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар энэ журмын дагуу хөтөлдөг. 2006-2009 онд Монгол

<sup>31</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас авсан мэдээлэл

<sup>32</sup> Гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн газрын статистик тоон мэдээлэл 2010 он

Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэд 2441 бүртгэгдсэн байна.<sup>33</sup>

Иргэн харъяатын асуудлыг зохицуулж буй эрх зүйн баримт бичгүүдээс гадна иргэн харъяатын асуудлыг зохицуулсан Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолд **“Монгол улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”**-ийн хүрээнд 2008-2012 онд Монгол улсын иргэн, харъяатын асуудлуудаар мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийгдэхээр төлөвлөсөн байна. Өнөөгийн байдлаар тус хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл албан ёсоор гаргаагүй байна.

“Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” УИХ-ын 2010 оны 12 сарын 30-ний 99 дүгээр тогтоолд хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд 2010 онд Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийн хэмжээг 120 мянган төгрөгөөр тогтоосон бол шинээр Монгол Улсын харьяат болсон иргэний тухайн жилд ногдох хишиг, хувийг харьяат болсны дараа жилээс эхлэн олгох, Монгол Улсын иргэн тус улсын харьяатаас гарч гадаад улсын харьяат болох хүсэлт гаргавал харьяатаас гарах жилийн олгох мөнгөний хэмжээгээр бодож 3 жилийн хишиг, хувийг 1 удаа олгох зэрэг зохицуулалт тус тус тусгагджээ.

### Харьяалалгүй хүмүүсийн эрх зүйн байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг хуулиар тогтооно. <sup>34</sup> гэж заасан юм. Харьяалаггүй хүн гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд аль нэг улсын харьяат иргэн гэдгийг нотлох ямар ч баримтгүй хүнийг хэлдэг.

Хүн аль ч улсын харьяат биш болох явдал аль нэг улсын иргэний харьяатаас гарах, хасагдах зэрэг шалтгаанаар үүсч болдог. Түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аль ч улсын харьяат гэдгийг нотлох боломжгүй эцэг эх нь хэн болох нь мэдэгдэхгүй хүүхэд олдох явдал байдаг нь аль ч улсын харьяат биш иргэнд тооцогдох үндэслэл болдог. Үүнээс гадна дайн байлдааны хор уршгаар хүн олзлогдсон, дүрвэсэн зэргээс болж аль улсын харьяат болохоо нотлох баримтгүй болсоноос аль ч улсын харьяат биш хүн үүсдэг байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар тус улсын нутаг дэвсгэрт байгаа аль ч улсын харьяат биш хүний эрх зүйн байдлыг Монгол Улсын хуулиар зохицуулна. Аль ч улсын харьяат биш учраас тэднийг төлөөлөн эрх ашгийг нь хамгаалах улс байдаггүй тул гадаадын харьяат нарын эрх зүйн байдлыг зохицуулахад баримталдаг харилцан адил байх буюу хоёр улсын гэрээгээр шийдвэрлэх зарчмуудыг хэрэглэх боломж байдаггүй.

Иймд аль ч улсын харьяат биш хүнд Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөөг зохицуулдаг хуулиудын заалтууд ба гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулах тохиолдол ч гардаг байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа аль ч улсын харьяат биш иргэнд Монгол улсын олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлалт тогтоож болохыг Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан байна.

Гадаадын иргэн харъяатын албанаас гаргасан мэдээлэлд Монгол Улсад оршин суугаа

<sup>33</sup> Гадаадын иргэн харъяатын асуудал эрхэлсэн газрын статистик тоон мэдээлэл

<sup>34</sup> Хүний эрхийн тө. Монгол Улсын иргэд гадаадад зорчих, цагаачлах, гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс Монгол улсад оршин суух, дамжин өнгөрөхтэй холбогдсон хуулиудын эмхтгэл, УБ, 2000, 111 дэх тал

зөвхөн гадаадын иргэдийн статусын байдлыг авч үзвэл 2007 онд **75**, 2008 онд **68**, 2009 онд **54**, 2010 оны эхний 08 сарын байдлаар **30** харъяалалгүй хүн бүртгэгдсэнээс Монгол улсад оршин суух үнэмлэхийг 2007-2010 онд нийт **4** хүнд олгосон байна.<sup>35</sup>

*2.1.2. Монгол улсын иргэн, харъяатын асуудлыг хүн ам зүйн бодлоготой уялдуулан дэмжлэг үзүүлэх арга замууд*

Улсын Их Хурал 2004 онд Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн найруулж, хүн ам, хөгжлийн бодлогын зорилгыг “хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчинг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон<sup>36</sup>. Түүнчлэн энэхүү бодлогын баримт бичгийн “Хүн ам зүйн талаар” гэсэн хэсэгт *Хүн амын бодлогын цөм хүн ам зүйн талаар баримтлах чиглэлийн хүрээнд хүн амын тооны өөрчлөлтөд шууд нөлөөлөгч хүчин зүйл болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний асуудлыг цогцоор авч үзнэ*” гэж заажээ.

Энэ тунхаглалын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлд ч иргэний харъяаллын асуудлаар тусгагдсан зохицуулалтгүй байгаа нь хүн амын талаар баримтлах бодлогын баримт бичгүүдэд иргэн харъяатын асуудал нь хүн амын тооны өөрчлөлтөд нөлөөлж шилжих хөдөлгөөн гэдэг агуулгаар тусгагджээ.

Гэтэл иргэн харъяатын асуудал нь хүн амын тооны өөрчлөлтөд нөлөөлөх шилжих хөдөлгөөн төдийгүй дотоодын болон гадаадын иргэний статус өөрчлөгдөхтэй холбогдсон хоёрдмол харъяалал, харъяалалгүй хүмүүс өөр улсад сууж байгаагаас үл харгалзан хамгаалж байх үндсэн хуулиар олгогдсон эрх эрх чөлөө, олон улсын гэрээ, конвенцийн хүний эрх, эрх чөлөөний хэм хэмжээний хүрээнд зохицуулалт шаарддаг асуудал юм. Иймд иргэн харъяатын асуудлуудыг шийдвэрлэхэд тулгадаж буй асуудлуудын шалтгаан нөхцөлийг судлан үзье.

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн даяаршлын эрин үед гадаадад амьдрахыг хүсэгчид өндөр хөгжилтэй орнуудад ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн хамгааллын болон бусад олон төрлийн хангамж эдлэн удаан хугацаагаар амьдран суух гэсэн иргэд тэр улсынхаа харъяат болохыг чухалчилдаг. Манай улсын хууль тогтоомжоор хоёрдмол харъяаллыг хүлээн зөвшөөрдөггүйгээс, монгол улсын харъяатаас гарч гадаадын харъяат болох, эсвэл Монгол Улсын харъяатаас гаралгүйгээр гадаадад харъяалалгүй амьдрах нөхцөл бүрддэг байна.

Харъяаллын асуудлаа нэг мөр болгоогүй иргэд үр хүүхдээ тус улсынхаа харъяат болгохыг хүсдэг байна. Сүүлийн 10 гаруй жилд АНУ-д 300 гаруй монгол хүүхэд мэндэлж, тус улсын уугуул иргэн болжээ. Зөвхөн нэг улсын жишээ дурьдахад ийм үзүүлэлт байгаа нь иргэний хоёрдмол харъяаллыг хүлээн зөвшөөрөхгүй манай улсын хувьд дотоод болон гадаад иргэдийнхээ талаар ялгавартай бодлого барих боломж байж болох талтай. Манай улс хоёр том гүрний дунд оршдог байршлаа харгалзан хоёрдмол харъяаллыг хүлээн зөвшөөрвөл хүн амын тоо механикаар өсч, монгол үндэстний удмын сан саармагжих зэрэг сөрөг үр дагавар гарна гэж болгоомжилдог биз.

Гэхдээ Монгол улсын харъяатаас гарах асуудлыг боловсронгуй болгохгүй бол өнөөдөр

<sup>35</sup> Гадаадын иргэн харъяатын асуудал эрхэлсэн газрын статистик тоон мэдээлэл 2010 он

<sup>36</sup> УИХ -ын 2004 оны 4-р сарын 23-ны өдрийн 21 тогтоол. Монгол Улсын төрөөс хйн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай

үндэсний хэмжээнд гавъяа байгуулсан, шинжлэх ухааны нээлт, бүтээл туурвисан, урлаг спортын амжилт гаргасан улсынхаа нэрийг дуурсгаж яваа хүмүүсийг алдах, гадаадын иргэнтэй гэр бүл болсон иргэдийн хувьд хоёрдмол харъяаллыг хүлээн зөвшөөрвөл эх орондоо чөлөөтэй зорчих, оршин суух, гадаадын иргэнд үрчлэгдсэн монгол улсын харъяат хүүхдүүдийн харъяаллын асуудал, хөдөлмөрийн гэрээгээр Казахстанд 100 мянга гаруй Монгол Улсын харъяат казах иргэн оршин сууж байгаагаас 26644 иргэн хоёрдмол харьяалал үүсгэсэн гэх иргэдийн асуудлуудыг шийдвэрлэх амьдралын наад захын хэрэгцээг шийдвэрлэхэд эерэг үр дагавар гарах ач холбогдолтой.

Гадаадын 30 гаруй улс оронд Монгол улсын 120 гаруй мянган иргэд ажиллаж, амьдарч байгаа ба үүнээс хамгийн их буюу 31185 мянган иргэн БНСУ-д ажиллаж амьдарч байгаагийн 70 хувь нь хууль ёсоор оршин сууж 30 хувь нь хараар ажилладаг байна. БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг дагаж очсон хүүхдийн тоог үзвэл Гадаад хэргийн Яамны мэдээлснээр одоогийн байдлаар 450 хүүхэд эцэг эхээ даган амьдарч, 1800 гаруй Монгол эмэгтэйчүүд БНСУ-ын иргэдтэй гэр бүл болсон байна. Гэвч бусад улс орнуудад байгаа хүүхэд, тэдний амьдралын нөхцөл байдлын талаар мэдээлэл туйлын хомс байна.

Сүүлийн жилүүдэд Монголын иргэд гадаадад хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших шилжилт хөдөлгөөн улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан хүүхдийн нөхцөл байдалд тулгамдаж байгаа бэрхшээлтэй асуудлууд энэ мэтчилэн олноор урган гарсаар байгаа нь хүн ам зүйн бодлогын шинэчлэлийг хийх цаг үеийн нөхцөл бүрдсэн байна.

Монгол Улсын иргэн харъяатын талаарх хууль, эрх зүйн актын зохицуулалт нь хүн ам зүйн бодлогын баримт бичгүүдэд иргэн, харъяатын асуудлуудыг шилжих хөдөлгөөнд нөлөөлөх тооны өөрчлөлт талаас нь авч үзсэнээс бусад хүчин зүйлсийг судлан хүн ам зүйн бодлоготой уялдуулаагүй, дотоодын иргэний статус өөрчлөгдөж гадаад улсын иргэн харъяат болсон эсэх харъяалалгүй иргэдийн талаарх бүртгэл мэдээлэл, тэдгээрийн амьдралын нөхцөл байдлын талаарх зохицуулалт хангалтгүй, Монгол Улсын харъяат иргэн гадаад улсын харъяат хүүхэд үрчлэн авах зохицуулалт бүрхэг, энэ талын статистик мэдээлэл одоогийн байдлаар бүртгэгдээгүй, цагаач, улс төрийн орогногч, дүрвэгсэд гэх гадаадын иргэн олноор манайд ирж болзошгүй нөхцөл байдлын үед эрх зүйн зохицуулалт, авах арга хэмжээ дутмаг байна.

Иймд хүн ам зүйн бодлогын баримт бичгүүдэд дараах зохицуулалт тусгах саналтай байна. Үүнд:

- Монгол Улс хоёрдмол харъяалалыг хүлээн зөвшөөрвөл гарч болох эерэг, сөрөг үр дагавруудыг судлах, хоёрдмол харъяаллыг дотоод, гадаадын иргэдийн хувьд ялгавартайгаар зохицуулалт хийх боломжит хувилбар дэвшүүлэх,
- Гадаад улсад ажиллаж амьдарч буй монгол улсын харъяат иргэн төрөөс иргэдээ олгож байгаа нийгмийн халамжийн тэр дундаа эх орны хишиг хувь хүртэх, хуулиар олгогдсон газар хувьчлах, сонгууль өгөх эрхийг хүн ам зүйн бодлогын шинэчлэлийн хүрээнд зохицуулалт хийх,
- Гадаадад хөдөлмөр эрхэлж буй монгол улсын харъяат иргэний дагаж очсон болон төрүүлсэн хүүхдүүд нь эцэг эхийнхээ тухайн улсын иргэний харъяаллын статусаас хамаарч сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, хүчирхийлэлд өртөх, гэмт хэрэгт өртөх, бэлгийн мөлжлөг, хүний наймааны хохирогч болох эрсдэл өндөр байгааг анхаарч хүүхдийн талаарх олон улсын гэрээ конвенцийн үзэл санаанд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдний эрх ашгийг



хамгаалах

- Цагаач, улс төрийн орогногч, дүрвэгсэд гэх гадаадын иргэн олноор манайд ирж болзошгүй нөхцөл байдлын үед эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
- Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар Монгол Улсын иргэн, харъяатынхаа хууль ёсны ашиг сонирхлыг чиг үүргийнхээ хүрээнд хамгаалах, бүртгэл мэдээллийнхээ агуулгыг баяжуулж, тогмолжуулах

## 2.2. МОНГОЛ УЛСААС ГАДААДАД ГАРЧ БҮЙ ИРГЭДИЙН АСУУДАЛ /АЛБАН ЁСООР СУРАЛЦАХААР, АЖИЛЛАХААР, АЛБАН БУСААР Г. М./

Даяаршлын үйл явц дэлхийн хэмжээнд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт нэвтэрч байгаа өнөө үед гадаадад шилжих хөдөлгөөн ч мөн түргэцтэй явагдаж байна. Манай улсын иргэдийн хувьд гадагш чиглэсэн хөдөлгөөн зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-ээд оны эхэн үеэс идэвхижиж эхэлсэн. Энэ нь шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээл нь тэднийг гадаадын өндөр хөгжилтэй орнуудын амьдралын нөхцөл байдал, нийгмийн халамжийн үйлчилгээ тэднийг татах хүчин зүйлс болсон.

2001 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулиар Монгол Улсын иргэнийг гадаадад, гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх, тэдний эрх, ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хууль<sup>371</sup>, Хөдөлмөрийн тухай хууль<sup>382</sup>, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль<sup>393</sup>, Нийгмийн даатгалын тухай хууль<sup>404</sup> болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар ажиллах хүч гаргах асуудлыг зохицуулдаг.

Ажиллах хүч гадаадад гаргах үйл ажиллагааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэн эрхлэх бөгөөд зуучлах зөвшөөрлийг холбогдох гэрээ болон бусад бичиг баримтат тулгуурлан гурван жил хүртэлх хугацаагаар хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгох бөгөөд байгууллагын хүсэлт, үйл ажиллагааны тайлан, үр дүнг үндэслэн зуучлах зөвшөөрлийг сунгадаг ажээ.

Зуучлагч байгууллага нь ажиллах хүч гадаадад гаргахдаа хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тухайн улсын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар гэрээндээ тусгасан байхын зэрэгцээ иргэн өөрөө хүсвэл Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу даатгалд хамруулж, нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан байна. Мөн Монгол Улсын иргэн гадаадад гэрээгээр ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас амь насаа алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд зуучлах зөвшөөрөл авсан байгууллага холбогдох хохирлыг барагдуулах бөгөөд ар гэрийнхэн нь хүсэлт гаргасан тохиолдолд амь алдсан иргэний цогцсыг Монгол Улсад авчрах зардлыг хариуцдаг.

<sup>37</sup> [www.news.mn](http://www.news.mn) “Цагаач болон харъяалалгүй хүүхдүүдийн асуудлуудыг шийдвэрлэхэд бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг өргөжүүл” нийтлэл, Хүүхдийн төлөө үндэсний газрын дарга М.Тогтохням

<sup>38</sup> <sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл”-ийн 1992 оны №1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>39</sup> <sup>2</sup>Хөдөлмөрийн тухай хууль. – “Төрийн мэдээлэл”-ийн 1999 оны №25 дугаарт нийтлэгдсэн.

<sup>40</sup> <sup>3</sup>Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. “Төрийн мэдээлэл”-ийн 1995 оны №2 дугаарт нийтлэгдсэн

Түүнчлэн гадаадад ажиллах хүч гаргах гэрээний биелэлт, гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа болон цуцлагдсан, сунгагдсан гэрээ бүхий иргэдийн талаархи тайлан, мэдээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу түүний эрх олгосон байгууллагад албан ёсоор ирүүлэх бөгөөд гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа Монгол иргэдийн хөдөлмөрийн гэрээ дуусмагц эх оронд нь буцаах арга хэмжээ авах үүрэгтэй.

Гадаадад ажиллах хүч дадлагажигч гаргах талаар Засгийн газрын болон яамны түвшинд байгуулсан хоёр талын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, санамж бичгүүдийг БНСУ, БНЧУ, Тайвань, Япон улстай байгуулсан байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар БНЧУ-ын засгийн газар хоорондын 1999 онд ажиллах хүч харилцан солилцох хэлэлцээр
- Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яам, Япон улсын олон улсын сургалтын хамтын ажиллагааны байгууллага “Житко”-ын төлөөлөгчид үйлдвэрлэлийн дадлагын асуудлаар 1998 оны 9 дүгээр сард хамтран ажиллах санамж бичигт Монгол Улс Тайваний хооронд 2001 онд байгуулсан ажиллах хүчний салбарт хамтран ажиллах санамж бичиг
- Монгол Улсын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон БНСУ-ын хөдөлмөрийн яамны хоорондын харилцан Ойлголцлын санамж бичгийг 2004 оны 5 дугаар сарын 3-нд байгуулсан бөгөөд гөөд 2006 оны 7 дугаар сарын 28 ны өдөр Улаанбаатар хотноо дахин шинэчлэн байгуулсан.

Одоогийн байдлаар Засгийн газрын 2007 оны 36 дугаар тогтоолоор **“Гадаадад ажиллах хүч илгээх төв”** ХХК нь байгуулагдсан төрийн өмч давамгайлсан буюу нийт хувьцааны 51 хувийг төр эзэмшдэг компани байгуулж гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас авч 2007 оны 4 дүгээр сараас эхлэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

*Гадаад албан ёсоор гэрээгээр ажиллаж амьдарч буй иргэдийн талаар*

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яамны шугамаар нийт 23686 иргэнийг ажиллах хүч гадаадад зуучлах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудаар дамжуулан хөдөлмөрийн гэрээгээр болон үйлдвэрийн дадлагжигчаар БНСУ, Япон, БНЧУ, БНУУ зэрэг улсад илгээсэн байна. Өнөөгийн байдлаар 19 аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна. /Хүснэгт 1/

**Хөдөлмөрийн гэрээгээр гадаад орнуудад ажиллахаар явсан иргэдийн тоо<sup>41</sup>**

Хүснэгт 1

№	Улс	2004	2005	2006	2007	2008	2009	2010	Нийт
1	БНСУ	1708	4796	5970	2512	3306	1487	1130	20909
2	Япон	757	328	389	333	204	107	-	2118
3	Чех	12	26	100	135	-	-	-	273
4	Унгар	42	30	12	-	-	-	-	84
5	Тайвань	100	202	-	-	-	-	-	302

<sup>41</sup> Нийгмийн даатгалын тухай хууль. “Төрийн мэдээлэл” -ийн 1994 оны №8 дугаарт нийтлэгдсэн.



	Дүн	2619	5382	6471	2980	3510	1594	1130	23686
--	-----	------	------	------	------	------	------	------	-------

НХХЯ-ны гэрээгээр гадаад оронд ажиллахаар нийт 23686 иргэн зуучилсан нь монголын хүн амын 0,01 -ийг эзэлж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 88 хувь нь БНСУ -д, 9 хувь нь Японд, 3 хувь нь Чех, Унгар, Тайвань зэрэг орнуудыг ажиллаж байна.

**БНСУ -д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ГАХИТ -ийн шугамаар явсан иргэдийн ажиллах салбараар болон онуудаар гаргасан тоо баримт**

Хүснэгт 2

Салбар	Илгээсэн иргэдийн тоо														
	2007 он			2008 он			2009 он			2010 он			Нийт		
	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт
Хөдөө аж ахуй	38	40	78	327	60	387	73	40	113	0	0	0	438	140	578
Барилга	0	0	0	328	0	328	35	0	35	0	0	0	363	0	363
Загасны аж ахуй	16	0	16	348	0	348	22	0	22	1	0	1	387	0	387
Үйлдвэр	970	92	1062	1882	340	2222	1124	166	1290	1022	107	1129	4998	705	5703
Хөргөх байгууламж	28	0	28	21	0	21	25	0	25	0	0	0	74	0	74
Нийт	1052	132	1184	2906	400	3306	1279	206	1485	1023	107	1130	6260	845	7105

2005-2006 онуудад гадаадад ажил хөдөлмөр зорьсон иргэдийн тооны үзүүлэлт хамгийн өндөр байгаа нь бодлого эрх зүйн орчин нөлөөлсөнөөс гадна гадаад ажиллах хүч зуучлах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд олноор байгуулагдсантай холбоотой юм. 2007-2008 оноос эхлэн Чех, Унгар, Тайвань зэрэг орнуудын зуучлагч компануудтай хийгдсэн гэрээний тусгай зөвшөөрөл сунгагдаагүйн улмаас эдгээр жилүүдэд дээрх улсуудад хөдөлмөр эрхлэхээр манай улсын иргэд яваагүй бөгөөд цаашид ажиллах хүч гаргах талаар гэрээ хийх бэлтгэл ажлыг зохион байгуулж байгаа юм байна.

2000-2010 онд БНСУ-д ажиллахаар манай улсаас нийт 7105 иргэн хөдөлмөрийн гэрээгээр зуучлуулсанаас хүйсийн хувьд 845 нь эмэгтэйчүүд байгаа нь нийт ажиллагсдын 11,8 хувийг эзэлж байна. Энэ нь хоёр улсын харилцан ойлголцох санамж бичгийн гэрээнд заасан тухайн ажлын байрны онцлогоос хамаарч хүйсийн хувьд эрэгтэй хүмүүсийг түлхүү ажиллуулах сонирхол байдаг байна.




График 2

БНСУ-д гэрээгээр ажиллаж буй нийт ажиллагсдыг ажиллаж буй салбараа нь авч үзвэл 5703 хүн буюу 80 хувь нь үйлдвэрт, 74 хүн буюу 1,05 хувь нь хөргөх байгууламжид үлдсэн хувь нь бусад салбарт ажиллаж байгаа бөгөөд эмэгтэйчүүдийг үйлдвэрийн салбар, хөдөө аж ахуйн салбарт голлон ажиллуулж байгаа мэдээлэл байна.

Гадаадад гэрээгээр ажиллаж буй ажилчдын хөдөлмөрийн хөлсийг авч үзвэл Япон улсад 680-750 ам доллар, БНСУ-д 1000-1500 ам доллар, Тайвани улсад 350-400 ам доллар, БНЧУ-д 6000-15000 крон /240-400 ам доллар/-ын цалин хөлсийг сард авч байгаа нь манай улсын нэг өрхийн дундаж орлогоос гадаадад ажиллаж байгаа нэг ажилтан дунджаар 2-3 өрхийн орлогыг нэг сард ажиллаж олдог гэсэн үг юм.<sup>42</sup> Насны бүтцийн хувьд Япон улсад 20-29, БНСУ-д 18-35, БНЧУ-д 20-45 насны залуучуудыг ажиллуулж байна.

*Гадаадад албан бусаар хөдөлмөр эрхэлж буй ажиллагсдын талаар:*

Гадаадад албан бусаар хөдөлмөр эрхэлж буй иргэдийн ахуй амьдралын нөхцөл болон нийт ажиллагсдын тоог албан ёсоор гаргасан мэдээлэл олдоогүй бөгөөд гаргах ч бололцоогүй юм. Учир нь гадаадад хууль бусаар хөдөлмөр эрхлэх явдал нь хууль зөрчсөн үйлдэл учраас тус асуудлаар нарийвчилсан тоо баримт гаргах бололцоогүй байдаг байна.

Өнөөдрийн байдлаар манай улсын 120 гаруй мянган иргэн хилийн чанадад ажиллаж, амьдарч байна гэсэн албан бус тоо бий. Харин бодит байдал дээр энэ тоог хоёр дахин их гэдэг. Америкт 20 мянга гаруй, Англид 4 мянга орчим, Чехид 10 мянга орчим, Солонгост 40 мянга орчим, Японд 1000, Израйльд 500 орчим монголчууд байгаа гэсэн тоо байгаа ба дэлхийн 80 гаруй оронд монголчууд хөдөлмөрлөж, сурч байна.<sup>43</sup>

“Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангуулах, ажилгүйдлээс сэргийлэн хамгаалуулах эрхтэй.”<sup>44</sup> БНСУ-д гэрээгээр ажиллаж буй гадаадын ажилчин Хөдөлмөрийн Яамны салбарт хандан ажлын байраа 3 удаа сольж болно.<sup>45</sup> Хэдийгээр БНСУ-ын хөдөлмөрийн хуулинд эрх зүйн ийм зохицуулалт байдаг ч бодит байдал дээр хэрэгжилт нь хангалтгүй байдаг ажээ. Монгол ажилчид БНСУ-д

<sup>42</sup> ГАХИТ-өөс авсан тоо баримт 2010 он

<sup>43</sup> Гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн газрын Олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн А.Байгальмаагийн ярилцлага

<sup>44</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал 23-р зүйл

<sup>45</sup> БНСУ-ын Хөдөлмөрийн хууль, Нийтлэг зарчим 2 [\* Энэ төв нь сүмийн дэргэдэх байгууллага ч шаашин шүтлэгээр ялгаварлалгүй гадаадын иргэдэд туслан дэмжих зорилготой ажилладаг. БНСУ-ын хэмжээнд 60 -аад салбартай. Гадаадын иргэд их байдаг дүүргүүдэд энэ мэт төвийг байгуулан ажиллуулдаг аж]

очихынхоо өмнө ажлын байрныхаа нөхцлийн талаар хангалттай мэдээлэл авч чаддаггүй байна. БНСУ-д ажиллаж буй гадаад ажилчид ихэвчлэн бохир, хүнд хэцүү, аюултай орчин ажилладаг тул ажил нь хүнддэх, эрүүл мэндэд таагүй нөлөө үзүүлэх, хөдөлмөрийн нөхцөл тааруу, цалин хөлс нь бага, үйлдвэрийн эзэд болон хамтран ажиллагсадтай таарамжгүй байх зэрэг шалтгаанаар ажлаа солих шаардлага гардаг байна.

Судалгаанд оролцогчдын 35,5 хувь нь буюу 117 хүн ажлын байраа хэдийнэ сольчихсон байгаа бөгөөд цалин бага /12,7%, байр хоолны хангамж тааруу /3,0%, хүнд хэцүү ажилтай /6,1%, ажлаас шалтгаалан өвчин /2,4%, үйлдвэрлэлийн ослын улмаас /0,9%, ажлын байрны дарамт ихтэй /2,4%, үйлдвэр дампуурсан /4,2%, эзэнтэйгээ зөрчилдсөн /0,3%/ гэсэн шалтгааны улмаас ажлын байраа сольжээ. Ажлын байраа солих болсонд хөдөлмөрийн гэрээний нөхцлөө хангалттай сайн мэддэггүй байсан нь зохих хэмжээгээр нөлөөлдөг нь гарцаагүй юм. Нэгэнтээ ажлын байраа гурвантаа сольчихсон гадаад ажилчидад дахин сонголт байхгүй тул ямар ч нөхцлийг хүлээн зөвшөөрөх эсвэл “харлах”-аас өөр аргагүйд хүрдэг байна.

### 2.2.3. Гадаадад албан ёсоор суралцагсдын талаар

Манай улсаас гадаадад албан ёсоор суралцахаар сургалтын төрийн сангийн зээлээр, засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу элссэн магистрант, докторант, засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу оюутнуудыг суралцуулдаг байна. Сургалтын төрийн сангийн зээлээр гадаад улсад суралцагчдад “Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам”, “Гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргүүлэн төлүүлэх журам”-ыг тус тус баримталж байна.

Дээрх журмаар Засгийн газрын тогтоол гарган төрийн сангийн зээлээр гадаад, дотоодын их сургуульд суралцан мэргэжлээрээ эх орондоо ажиллаж байгаа хүмүүсийг зээл болон зээлийн хүүгээс чөлөөлөх шийдвэр гаргасан байна. Мөн Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журмыг 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Манай Улсаас гадаадад дээр дурьдсан шугамаар явсан суралцагчдын БСШУЯ-ны Мэргэжлийн боловсролын газраас ирүүлсэн явсан тоон мэдээллийг авч үзье.

/Хүснэгт 3/

№	Гадаадад суралцагсдын хэлбэр	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	Дүн
1	СТС-ийн зээл	61	87	109	131	145	112	92	94	124	48	-	1003
2	Засгийн газар /магистр, доктор/	74	74	74	82	84	96	134	137	238	126	169	1288
3	Засгийн газар /бакалавр/	204	239	226	259	288	474	482	521	427	479	484	4083
Нийт		339	400	409	472	517	662	708	752	789	653	653	6374

Манай улсаас 2000-2010 онд нийт 6374 суралцагч сургалтын төрийн сангийн зээлээр, засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу элссэн магистрант, докторант, засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу суралцсан болон суралцаж байгаа юм байна. Энд

нэг зүйлийг тодруулахад дээрх мэдээлэлд албан ёсоор болзол шалгуур хангаж гадаад орнуудад суралцах эрх авч явсан оюутны тоо юм. Харин эдгээр оюутнуудаас хэд нь төгсөөд эх орондоо ирсэн, одоо суралцаж байгаа мэдээлэл байхгүй байна.

Төрийн сангийн эзэлээр гадаадын 28 оронд 1003 оюутан их, дээд сургуулиудад суралцаж буй тоог авч үзвэл, АНУ - 36,7 хувь, Япон - 20,1 хувь, ОХУ - 13,1 хувь, Англи - 8,2 хувь, Австрали - 7,8 хувийг эзэлж байгаа бөгөөд 2003 - 2006 онуудад суралцагчдын тоо харьцангуй өндөр байна.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 14 оронд 1288 иргэн магистр, докторантын чиглэлээр суралцсанаас ОХУ-41 хувь, Энэтхэг-10,9 хувь, Турк-10,1 хувь, БНХАУ-25,8 хувийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд засгийн газрын хэлэлцээрийн дагуу суралцаж буй магистр, докторантын тоо өсөж байгаа нь төрөөс боловсролын салбарт анхаарч байгааг илтгэж байна.

Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 18 оронд 4083 иргэн бакалаврын зэргээр суралцаж байгаагаас ОХУ-36,9 хувь, БНХАУ-22,2 хувь, Япон-9,5 хувь, Турк-11,9 хувь, Польш-3,6 хувийг тус тус эзэлж байна. Гадаадад суралцаж буй иргэдийн тоон үзүүлэлтээс харахад засгийн газар хоорондын хэлэлцээрийн шугамаар хамгийн олон суралцагчид буюу нийт суралцагчдын 80 гаруй хувийг эзэлж байна.

### 2.3. МОНГОЛ УЛСАД ОРЖ ИРЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Иргэний хууль болон бусад хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол тэдгээртэй нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэр, “дүрэм”, “заавар” гадаад улсуудтай байгуулсан гэрээ хэлцэл нь гадаадын иргэний эрх зүйн үндэслэл болно.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн оршин суух, ажил хөдөлмөр эрхлэх, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ хэлцэл хийх зэргээр хуулиар тогтоогдсон эрх үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хориглосон, хязгаарласан, тусгайлсан шинжтэй хэм хэмжээг тогтоосон байдаг гадаадын иргэний эрх зүйн онцлог оршино.

Монгол Улсын Үндсэн хуульд

- Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа гадаадын иргэний эрх үүргийг Монгол Улсын хууль, тус иргэнийг харъяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно.
- Монгол Улс олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо тус иргэний харъяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална.
- Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно.
- Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал монгол улсад орогнох эрх олгож болно гэж заасан.

Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно заалтууд байдаг.

### Гадаадын иргэний эрх, үүргийн үндсэн зарчим

Монгол улсад оршин суугаа гадаадын иргэн нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэн монгол улсад түр болон удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух «журам» болон бусад хуульд зааснаар тодорхой эрх эдэлж үүрэг хүлээнэ.

*Монгол Улсын нутаг* дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн тус улсын хууль тогтоомжоор өөрт нь олгогдсон эрх, эрх чөлөөг Монгол Улсын иргэний нэгэн адил эдэлж, үүрэг хүлээнэ. Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжийн бусад акт болон Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаадын иргэний эрх, үүргийг тодорхойлохдоо уг иргэнийг харьяалсан улстай энэ талаар харилцан адил байх зарчим баримтална. Гадаадын иргэн Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээгээр тодорхойлогдсон эрх, эрх чөлөөг Монгол Улсын эрх ашиг, тус улсын иргэний болон бусад хүний эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшаар эдэлж болохгүй.

### Гадаадын иргэний эрх, үүргийн хязгаарлагдмал шинж

- Монгол Улсын төрийн болон засаг захиргааны нэгж, хот тосгоны өөрөө удирдах байгууллагад сонгох, сонгогдох эрх эдлэхгүй, ард нийтийн санал асуулгад оролцохгүй.
- Монгол Улсын Зэвсэгт хүчин, бусад цэрэгт алба хаах үүрэг хүлээхгүй.
- Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагчаар ажиллахгүй.
- Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах, байгууллага байгуулах, түүнд элсэн орох, бусад хэлбэрийн улс төрийн аливаа үйл ажиллагаа явуулж болохгүй.
- Монгол Улсын үндэсний эв нэгдлийн эсрэг сурталчилгаа явуулах, үндэсний ёс заншил, хуульд харш шашны урсгал, хүчирхийллийн аливаа хэлбэр, садар самуун, мансууруулах бодисыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглэхийг хориглоно.
- Визийн хугацаа хэтрүүлэх, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхлэх, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулах, гадаадын иргэнийг бүртгэх журам зөрчин өөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид зорчихыг хориглоно.

Гадаадын иргэний эрх, үүргийн хязгаарлагдмал шинжүүдийг Монгол Улсын хууль, тогтоомжуудад тогтоосон байдаг. Жишээ нь:

Монгол Улсын үндсэн хуульд Монгол Улсын иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэхийг хориглосон байдаг бөгөөд төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд харьяалалгүй хүнд газрыг төлбөр хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол журмаар ашиглуулж болно.

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны даргын тушаалаар гадаадын иргэн тус улсын нутагт байнга оршин суух, цагаачлах, эрхийг түдгэлзүүлэх, тус улсад орох, гарахыг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх, гадаадын иргэний эрхийг хуульд заасан журмаар хязгаарлах гэх мэтээр хууль, тогтоол, “дүрэм”, “заавар”-уудад хуульчлагдсан байдаг.

Гадаадын иргэн, харьяатын асуудлаар Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоолоор ХЗДХ-ийн сайдын эрхлэх ажлын хүрээнд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба нь чиг үүргийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тодорхой нэгжид оршин

суугч мөн болохыг тодорхойлсон оршин суух үнэмлэх олгох, Монгол Улсад албан болон хувийн хэргээр зорчигч, түр болон удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэний оршин суух хугацааг сунгах, оршин суух үнэмлэхийг нь хадгалах, бүрмөсөн явах тохиолдолд хурааж авах, гадаадын иргэний урьж ирүүлсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд урилга олгох асуудлыг шийдвэрлэх, Монгол Улсын харъяат хүүхэд үрчлүүлэх асуудлыг хүн амзүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Тус алба нь Монгол Улсад оршин суух, зорчих хугацаа хэтрүүлсэн, хууль бусаар хөдөлмөр эрхэлсэн ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулах, гадаадын иргэнийг бүртгэх журам зөрчин өөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид зорчигчдод цагдаагийн болон хилийн цэргийн байгууллагатай хамтран эрэн сурвалжлан олж шийдвэрт заасан хугацаанд улсын хилээр албан гаргах арга хэмжээ авах зэрэг чиг үүргийг барьж ажиллана.

### Монгол улсад оршин суугаа гадаадын иргэдийн статус

Манай улсад оршин суугаа гадаадын иргэдийн статусыг дараах байдлаар ангилна. Монгол Улсад хувийн хэргээр 90 хоногоос 5 жил хүртэл хугацаагаар оршин суугаа гадаадын иргэнийг **хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч** гэнэ. Монгол Улсын харъяат иргэнтэй гэр бүл болсон бөгөөд 90 хоногоос дээш хугацаагаар Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэнийг **байнга оршин суугч** гэнэ. Хувийн хэргээр Монгол Улсад амьдрахаар 5 жилээс дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэнийг **цагаач** гэнэ. Харин ямар нэг улсын гэх хууль ёсны бичиг баримтгүй Монгол Улсад оршин сууж байгаа иргэнийг **харъяалалгүй хүн** гэнэ.<sup>46</sup>

Хүснэгт 1

Оршин суугаа статус	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Түр оршин суугч	226	360	1250	2830	639	1174	1502	1431	997	2935
ХХУХОС	43	91	113	222	533	637	904	1004	1262	1547
АХУХОС	8921	9575	10400	14315	13754	20364	20892	18418	19184	21682
Байнга оршин суугч	243	742	834	981	1074	962	1178	1139	932	815
Цагаач	243	2431	2310	2280	2314	2330	2375	2420	2225	2138
Харъяалалгүй хүн	65	69	85	78	81	79	75	68	54	30


<sup>46</sup> Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны тогтолцоо, УБ.2008 он, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын дүн шинжилгээний албанаас авсан тоо баримт 2010 он

<b>НИЙТ</b>	<b>9741</b>	<b>13268</b>	<b>14992</b>	<b>20706</b>	<b>18395</b>	<b>25546</b>	<b>26926</b>	<b>24480</b>	<b>24654</b>	<b>29147</b>
-------------	-------------	--------------	--------------	--------------	--------------	--------------	--------------	--------------	--------------	--------------

**Тайлбар:**

- **ХХУХОС**- Хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суух,
- **АХУХОС**-Албан хэргээр удаан хугацаагаар оршин суух.

График 1



Монгол улсад түр хугацаагаар оршин суугчдыг оноор нь авч үзвэл:

Хүснэгт 2

Онууд	Хүний тоо
2001 он	226
2002он	360
2003он	1250
2004он	2830
2005он	582
2006 он	1170
2007он	1502
2008 он	1431
2009 он	997
2010 оны эхний 8 сар	2935



График 2



Монгол улсад түр хугацаагаар оршин суугчийг улсаар авч үзвэл:<sup>47</sup>

Хүснэгт 3

Улсын нэр	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010
БНХАУ	109	460	727	912	626	1272
АНУ	131	183	171	98	82	351
ОХУ	14	37	105	88	53	155
БНСУ	147	92	97	71	29	38
ЯПОН	6	103	43	17	13	62
Бусад	175	295	359	245	194	1057
Нийт	582	1170	1502	1431	997	2935

График 3



<sup>47</sup> Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх албаны тогтолцоо, УБ.2008 он, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газрын дүн шинжилгээний албанаас авсан тоо баримт 2010 он.

**Монгол улсад оршин суугаа гадаадын иргэдийг улс, орноор харьцуулж үзвэл:**

Хүснэгт 4

Улсын нэр	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010
АНУ	1131	1441	1351	1380	1573	1893
БНСУ	1620	2210	2268	2310	2431	2157
БНХАУ	7325	11547	13578	12716	13248	16675
ОХУ	4062	4587	4133	3617	3352	3068
УКРАЙН	633	743	748	402	250	218
ЯПОН	427	652	681	503	521	621
БУСАД	3197	4194	4167	3552	3279	4518
НИЙТ	18395	25374	26926	24480	24654	29150

График 4

**Монгол улсад оршин суугаа байнга оршин суугч гадаадын иргэдийг оноор харьцуулж үзвэл:**

Хүснэгт 5

Онууд	Хүний тоо
2001 он	243
2002 он	742
2003 он	834
2004 он	981
2005 он	1074
2006 он	962
2007 он	1178
2008 он	1139

2009 он	932
2010 оны эхний 8 сар	815

График 5



Монгол улсад оршин суугаа харъяалалгүй хүмүүсийг авч үзвэл:

Хүснэгт 6

Онууд	Хүний тоо
2001 он	65
2002 он	69
2003 он	85
2004 он	78
2005 он	81
2006 он	79
2007 он	75
2008 он	68
2009 он	54
2010 эхний 8 сар	30

График 6



**Монгол улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугчийг он, улсаар харьцуулж үзвэл:**

Хүснэгт 7

Онууд	Хүний тоо
2001 он	43
2002 он	91
2003 он	113
2004 он	222
2005 он	533
2006 он	637
2007 он	904
2008 он	1004
2009 он	1262
2010 оны эхний 8 сар	1547


График 7



Хүснэгт 8

Улсын нэр	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010
АНУ	188	264	362	449	613	744
БНСУ	113	121	156	170	221	255
БНХАУ	31	42	42	41	46	53
ОХУ	40	42	54	44	68	88
БУСАД	161	168	290	300	314	407
НИЙТ	533	637	904	1004	1262	1547

График 8



Монгол улсад албан хэргээр удаан хугацаагаар оршин суугчдыг он, улсаар авч үзвэл:

График 9



Хүснэгт 9


Онууд	Хүний тоо
2001 он	8921
2002 он	9575

2003 он	10400
2004 он	14315
2005 он	13754
2006 он	20052
2007 он	20892
2008 он	18418
2009 он	19184
2010 оны эхний 8 сар	21685

Хүснэгт 10

Улсын нэр	2004	2005	2006	2007	2008	2009 он	2010
<b>БНХАУ</b>	6046	5569	9459	11184	10125	11072	13911
<b>ОХУ</b>	2758	2551	3055	2475	2023	1914	1613
<b>БНСУ</b>	1051	1335	1899	1902	1921	2093	1777
<b>АНУ</b>	763	782	964	784	808	857	782
<b>УКРАЙН</b>	733	583	678	682	350	201	167
<b>Бусад</b>	2964	2934	3997	3865	3191	3047	3435
<b>БҮГД</b>	14315	13754	20052	20892	18418	19184	21685

График 10



**Монгол улсад цагаачлан амьдарч байгаа гадаадын иргэдийг оноор, улсаар авч үзвэл:**

Хүснэгт 11

Онууд	Хүний тоо
2001 он	243
2002 он	2431
2003 он	2310
2004 он	2280
2005 он	2314
2006 он	2330
2007 он	2375
2008 он	2420
2009 он	2225
2010 оны эхний 8 сар	2139

График11




Хүснэгт 12

Улсын нэр	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010
БНСУ	38	43	41	51	1241	36
БНХАУ	1322	1317	1333	1338	922	1204
ОХУ	922	937	966	993	31	871
Бусад	32	33	35	38	31	28
Нийт	2314	2330	2375	2420	2225	2139



График 12



Өнөөгийн байдлаар манай улсад гадаадын 118 орны 29 мянга гаруй иргэн манай улсад ажиллаж амьдарч байна. Статусын байдлаар нь авч үзвэл *түр оршин суугч 2935, хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч 1547, албан хэргээр удаан хугацаагаар оршин суугч 21682, байнга оршин суугч 815, цагаач 2138, харъяалалгүй 30* иргэн оршин сууж байна. Оршин сууж буй гадаадын иргэдийг улс орноор нь авч үзвэл дийлэнх буюу Хятад 16675, Орос 3068, Солонгос 2157, Америк 1573, бусад орны 839 иргэн байна.

Дэлхий нийтийн жишгээс харахад ер нь аль ч оронд хил залгаа орнуудынх нь иргэд дийлэнх хувийг эзэлдэг. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр амьдарч байгаа гадаадын иргэдийн тоо нийт хүн амын гурван хувь, нэг улсын иргэдийн тоо нэг хувиас хэтэрвэл үндэсний аюулгүй байдалд заналхийлж эхэллээ гэж үздэг. Дээрх аргачлалаар бодож үзэхэд гадаадын иргэдэд тогтоосон квот 87 мянга гаруй хүн болж байгаа бөгөөд одоогийн байдлаар үндэсний аюулгүй байдлын асуудал нөлөөлөхүйц хүчин зүйл биш юм.

Гэхдээ 2001 оны байдлыг 2010 оны 08 дугаар сарынхтай харьцуулахад хувийн болон албан зорилгоор хүрэлцэн ирж буй гадаадын иргэдийн тоо 3 дахин өссөн бөгөөд гадаад харилцаа өргөжихийн хэрээр тус улсад хүрэлцэн ирэх гадаадын иргэдийн тоо тогтмол нэмэгдэх хандлагатай үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц асуудал ирээдүйд бодитой тулгарах эрсдэл байж болохыг үгүйсгэхгүй байна.

Судалгааны явцад гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцүүлгийн шатандаа явж байгаа бөгөөд гол зохицуулж буй харилцаа нь гадаадын иргэд манай улсад зорчих, оршин суух, тэдгээрт виз олгох журам боловсронгуй болж, нэгдсэн хяналт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах эрх зүйн орчин бүрдэж, гадаадын иргэдийн талаар төрийн захиргааны болон орон нутгийн байгууллага, албан тушаалтны хэрэгжүүлэх бүрэн эрх, хамтран ажиллах зарчмыг хуульчилснаар төрийн институци дахь давхардал, хүнд суртал, шат дамжлага багасах чухал ач холбогдолтой гэжээ.

Мөн гадаадын иргэний эдлэх эрх, хүлээх үүрэг, хориглох үйл ажиллагааг тус тусад нь томъёолж хуульчилснаар гадаадын иргэний эрх зүйн байдал тодорхой болно. Нөгөө талаас гадаадын иргэнийг урьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг чангатгаснаар гадаадын иргэдтэй холбоотой зөрчлөөс сэргийлэх, гаралтыг бууруулах ач холбогдолтой юм.<sup>48</sup>

Шинэчилсэн төслийн гол зохицуулалт нь гадаадын иргэний эрх зүйн байдлыг одоогийн зохицуулж буй харилцааны алдаа оноотой, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх эерэг ач холбогдолтой ч нөгөө талаараа улс гүрэн өөрийн нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын

<sup>48</sup> [www.parliament.mn](http://www.parliament.mn). Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга

иргэд, тэдний эд хөрөнгөнд ОУЭЗ-ээр тогтоосон зохих хамгаалалт үзүүлэх талаасаа зохицуулалтгүй байна. Тухайлбал, Оршин сууж буй улсын хууль хяналтын байгууллагын төрийн албан хаагчид гадаадын иргэний биед халдах, эд хөрөнгөнд нь хохирол учруулах, гадаадын иргэний учир шалтгаангүйгээр барьж хорих гэх мэт хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө зөрчигдөх явдал гаргадаг байна.

Иймд гадаадын иргэний эрх зүйн байдлын шинэчилсэн төслөөр бодлого хэрэгжүүлэгч төр захиргааны байгууллагуудын ажлын уялдааг сайжруулж, гадаадын иргэний хуулиар олгогдсон эрх эрх чөлөөг хүндэтгэж, ОУЭЗ хэм хэмжээний хүрээнд дотоодын хууль тогтоомжыг шинэчлэх хэрэгтэй байна.

#### **2.4. ИРГЭН ХАРЬАТЫН АСУУДЛААРХИ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА, БОДЛОГО ЭРХ ЗҮЙН ОРЧИН / АНУ, АВСТРАЛИ, ХБНГУ, БНХАУ, БНКАЗ.У/**

Иргэний харьяалалтай болох, харьяаллаас гарахтай холбогдсон бүх асуудал нь аливаа улс гүрний тусгаар тогтнолтой холбоотойгоор тэдгээрийн хууль, тогтоомжоор зохицуулагдаж байдаг хүний эрхийн чухал асуудлын нэг юм. Иргэн, харьяатын асуудлыг зарим улс оронд эрх зүйн хувьд хэрхэн зохицуулдагыг авч үзье.

##### **2.4.1. АНУ -ын иргэн, харьяатын асуудлын эрх зүйн зохицуулалт, бодлого**

###### АНУ -ын иргэний харьяаллын асуудал

АНУ-ын иргэн, харьяатын асуудалтай холбоотой харилцааг АНУ-ын Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлт, өөрчлөлт болон 1952 оны “Цагаачлал, харьяатын тухай” хуулиар зохицуулдаг байна. Иргэний харьяалалтай болох үндсэн бөгөөд хамгийн түгээмэл аргуудын нэг нь төрснөөр харьяат болох юм. АНУ-ын иргэн байх олон арга зам байдгийн нэг нь энэхүү төрсөнөөр АНУ-ын иргэн болох, өөрөөр хэлбэл АНУ-ын нутаг дэвсгэр дээр буюу 50 муж улс, Колумбын тойрог төдийгүй АНУ-ын эзэмшлийн нутаг дэвсгэр болох Пуэрто-Рико, Гуам, Хойд Марианы арлууд, Америкийн Виржинийн арлууд дээр төрсөн хүүхдүүд төрсний эрхийн дагуу АНУ-ын иргэн болдог. Үүнийг хөрсний эрх, зарчим гэж нэрлэдэг. Харин АНУ-д суугаа гадаадын дипломат төлөөлөгчдийн хүүхдүүд энд хамаардаггүй.

Түүнчлэн эх, эцэг нь АНУ-ын иргэн бол хүүхэд нь өөр улсад төрсөн ч АНУ-ын иргэн болно, үүнийг цусны эрх буюу зарчим гэж нэрлэдэг. Уг эрхийн дагуу хүүхэд төрөх үед эх, эцэг хоёулаа АНУ-ын иргэн бол, мөн эцэг, эхийн аль нэг нь хүүхэд төрөхөөс өмнө АНУ-д амьдарч байсан бол төрсөн хүүхэд АНУ-ын иргэн болдог байна. Гадаадад төрсөн тухай АНУ-ын элчин сайдын яам болон консулын газарт бүртгүүлж, гэрчилгээ авах ба энэ нь АНУ-ын иргэн болохыг гэрчилдэг.

Мөн АНУ-ын хилийн чанадад төрсөн хүүхдийн эх,эцэг хоёрынх нь аль нэг нь АНУ-ын иргэн бол цусны зарчим үйлчилдэг ба 1986 оны 11 дүгээр сарын 14-ны өдрөөс хойш төрсөн хүмүүсийн хувьд дараах нөхцлүүд бүрдсэн тохиолдолд АНУ-ын иргэн болдог байна. Үүнд:

1. Хүүхэд төрөх үед эцэг, эхийн аль нэг нь АНУ-ын иргэн байх,
2. Хүүхдийн АНУ-ын иргэн эх буюу эцэг нь хүүхдээ төрөхөөс өмнө АНУ-д
3. 5 -аас доошгүй жил амьдарсан байх,
4. Эдгээр 5 жилийн доод тал нь 2 жилийг нь тухайн эх буюу эцэг 14 нас хүрсэнээс хойш АНУ-д амьдарсан байх.

Хүүхэд гадаадад төрсөн тухай АНУ-ын элчин сайдын яам болон консулын газарт бүртгүүлж, гэрчилгээ авах ба энэ нь АНУ-ын иргэн болохыг гэрчилдэг. Хэрэв хүүхэд 1986 оны 11 дүгээр сарын 14-ны өдрөөс өмнө хилийн чанадад АНУ-ын иргэнээс төрсөн

тохиолдолд АНУ-ын үүнийг зохицуулсан хууль XX зууны туршид олон удаа өөрчлөгдсөн бөгөөд тодорхой тохиолдол бүрт хүүхэд төрөх үед зохицуулж байсан хуулийн заалтыг баримталдаг ажээ.

АНУ-ын иргэн болж төрөөгүй хүн тодорхой нөхцлийн дагуу АНУ-ын харьяат болох боломжтой. Naturalization- энэ нь АНУ-д хууль ёсоор байнга оршин суугч нь АНУ-ын иргэн болох эрх зүйн журам юм. 1952 оны “Цагаачлал, харьяатын тухай” хуулиар гадаадын харьяат хүн дараах нөхцлийн дагуу АНУ-ын харьяат болно. Үүнд:

- **Нас:** АНУ-ын харьяат болохыг хүссэн өргөдлийг 18, түүнээс дээш настай хүмүүс гаргана
- **Эрх зүйн байдал:** Гадаадын иргэн 5 жилийн турш АНУ-д хууль ёсоор байнга оршин суугч байх, АНУ-ын иргэнтэй хууль ёсны гэр бүл болсон гадаадын иргэн байнгын оршин суугчийн эрх авсанаас хойш 3 жилийн дараа АНУ-ын харьяат болох хүсэлт гаргах эрхтэй
- **АНУ-д амьдарсан хугацаа:** Өргөдөл гаргагч нь АНУ-ын харьяат болохоор хүсэлт гаргахыг зөвшөөрсөн хугацааны талаас доошгүй хугацаанд АНУ-д тогтмол амьдран суусан байх ёстой.
- **АНУ-д тасралтгүй оршин суух хугацаа:** АНУ-ын хилийн чанадад 365, түүнээс дээш хоног тасралтгүй оршин суувал АНУ-д тасралтгүй оршин суух хугацааг зөрчсөнд тооцогдоно. Үүнээс гадна хүндэтгэх шалтгаангүйгээр 6 сараас дээш хугацаагаар АНУ-д амьдраагүй бол АНУ-д байнга оршин суугчийн статус алдагдах боломжтой.
- **Ёс суртахууны өндөр чанар:** АНУ-ын харьяат болохын тулд хүсэлт гаргагч нь ёс суртахууны өндөр чанартай байх ёстой. Урд нь гэмт хэрэг үйлдэж ял эдлэж байгаагүй байх ёстой.
- **АНУ-ын хэл, түүхийн мэдлэг:** Хүсэлт гаргагч нь англи хэлээр уншдаг, бичдэг, ярьдаг байх, мөн АНУ-ын түүх, төрийн байгууллалтын талаар хангалттай мэдлэгтэй байх ёстой.
- **АНУ-д үнэнч байх тангараг өргөх:** АНУ-д үнэнч байхаа илэрхийлсэн тангараг өргөх нь АНУ-ын харьяат иргэн болох үйл явдлын заавал байх ёстой бүрэлдэхүүн хэсэг юм.

АНУ-ын иргэн болсоноор дараах эрхтэй болдог байна. Үүнд:

- Сонгуульд оролцох
- Ажил хөдөлмөр эрхлэх, үүний дотор төрийн албанд ажиллах
- Өөрийн ойрын төрөл саданд цагаачлалын эрх олгуулахаар хүсэлт гаргах
- АНУ-ын паспортаар гадаадад зорчин, хилийн чанадад АНУ-ын хамгаалалтанд байх зэрэг болно.

АНУ-ын цагаачлалын хуулийн дагуу хүнд гэмт хэрэг үйлдсэн, АНУ-д ирэхийн тулд холбогдох албадад худал мэдээлэл, хуурамч бичиг өгсөн, АНУ-д нууцаар нэвтэрсэн, хууль бус цагаачдыг нэвтэрэхэд дэмжлэг үзүүлсэн, АНУ-ын эсрэг үйл ажиллагаа явуулсан, АНУ-ын армид алба хаахаас татгалзсан, татвар төлөхөөс татгалзсан зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулсан, эрх зүйн зөрчил гаргасан хүмүүст АНУ-ын харьяат болохыг зөвшөөрдөггүй.

АНУ -д хоёрдмол болон түүнээс дээш харьяалалтай байхыг зөвшөөрдөг учир АНУ-ын харьяат болсон хүн урдныхаа иргэний харьяаллаас татгалзахгүй байж болдог байна.

**АНУ -ын гадаадын иргэн, харьяатын асуудал, шилжилт, хөдөлмөний талаархи бодлого, эрх зүй**

АНУ -д гадаадаас цагаачлагчдын дийлэнхи хувийг хөдөлмөрийн цагаачид эзэлдэг ба тэд АНУ-ын эдийн засаг дахь ажиллах хүчний зонхилох хэсгийг бүрдүүлдэг байна. Хөдөлмөрийн цагаачдыг америкийн ажил олгогч компанийн урилгаар байнгын ажил, хөдөлмөр эрхлэхээр ирсэн хөдөлмөрийн цагаачлагч статустай, цагаачлагч бус түр ажилчин гэсэн хоёр ангилалд хуваадаг.

Гадаадаас АНУ-д ажил, хөдөлмөр эрхлэхээр цагаачлан ирэгсдийн талаархи АНУ-ын төрийн бодлого аажмаар, тогтмол боловсрогдож ирсэн бөгөөд энэхүү бодлогын чухал зарчмууд нь 1952 онд Конгрессын баталсан Уолтер-Маккаренy хуулиар хуульчлагдсан байна. Үүнд:

- Гадаадаас ажиллах хүч авах үйл ажиллагаа нь дотоодын хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийг хангаж, АНУ-ын иргэд болон байнга оршин суугчдын ажил хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний байдалд нөлөөлөхгүй байх боломжийг хангах
- Визний квот тогтоох замаар гадаадын дээд зэрэглэлийн мэргэжилтэн, гоц авьяас, чадвартай хүмүүс, шаардлагатай ховор мэргэжлийн ажилтнуудыг АНУ-д татан оруулж ажиллуулахыг дэмжих
- Гадаадаас ажиллах хүч хяналтгүй орж ирэх явдлыг таслан зогсоох зэрэг болно.

АНУ-ын цагаачлалын талаархи хууль, тогтоомжид АНУ-ын зүгээс өөрийн улсад ямар салбарын гадаадын мэргэжилтнүүдийг ажиллуулах сонирхолтой байгааг тодорхой заасан байна. 1952 оны “Цагаачлал, харьяатын тухай” хуулинд 1997 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөнд дараах салбарын мэргэжилтэнийг ажиллуулахаар хуульчилжээ. Үүнд:

1. Тэргүүлэх мэргэжилтэнүүд (шинжлэх ухаан, соёл, урлаг, спорын салбарт гарамгай амжилт гаргасан гадаадынхан, нэрт эрдэмтэн, профессорууд, олон улсын компаниудад ажилладаг менежер, мэргэжилтэн, удирдах ажилтан, эдгээр нь нийт хөдөлмөрийн цагаачлагчдын 28,6 хувь байна)
2. Эрдмийн зэрэг, цолтой болон гоц авьяас, чадвартай гадаадынхан (нийт хөдөлмөрийн цагаачлагчдын 28,6 хувь байна)
3. Нарийн мэргэжилтэй ажилчин, мэргэжилтэн, АНУ-д тухайн ажил, хөдөлмөрийг гүйцэтгэх ажилтан байхгүй мэргэжлээр хөдөлмөрийн цагаачдыг авах (нийт хөдөлмөрийн цагаачлагчдын 28,6 хувь байна)

АНУ -д түр ажил хийхээр ирэх цагаач бус хүмүүсийг дараахи бүлгээр ангилан авч үздэг байна. Үүнд:

- Гарамгай амжилт гаргасан, гоц авьяас чадвартай ажилтанууд (юуны өмнө шинжлэх ухаан, соёл, урлаг, шашны салбарт)
- Америкийн ажил олгогчидтой байгуулсан гэрээний дагуу түр хөдөлмөр эрхлэгчид нь хөдөө аж ахуйн салбарын, бусад салбарын гэж хоёр хуваагддаг
- Америкийн компаниудын урилгаар мэргэжил дээшлүүлэхээр ирэгсэд
- Америкийн компаниудын салбар, төлөөлөгчдийн газар ажиллагсад болон АНУ-д салбар, төлөөлөгчдийн газраа байгуулсан гадаадын пүүс, компанийн ажиллагсад

АНУ-д түр ажиллах зөвшөөрөлтэй байдаг гадаадын иргэд бол АНУ-д сурч байгаа болон оюутан солилцооны журмаар ирсэн оюутнууд байдаг. Ер нь түр ажиллахаар ирсэн хүмүүсийг ажлын чиглэлэр нь бүлэглэн арван хэдэн төрлийн виз олгодог ажээ.

АНУ-ын хөдөлмөрийн зах зээлд мэргэжлийн бус ажиллах хүчныг авах бүтэц нь өвөрмөц

байдаг байна. Практикаас үзэхэд улирлын чанартай ажил хийхээр ирсэн Н-2 төрлийн визтэй 5 ажилчны дөрөв нь ерөнхийдөө түргэн ялзарч мууддаг жимс, ногоо хураах ажил хийхээр ирсэн хөдөө аж ахуйн ажилчид байдаг. Түүнчлэн түр ажиллахаар ирсэн Н-2В төрлийн буюу хөдөө аж ахуйн бус салбарын ажилчдын дийлэнхи нь амралт сувилал, цэнгээний газруудын үйлчилгээний ажилчид байдаг байна. Үүнээс үзэхэд энэ бүлэг дотор аж үйлдвэрийн болон барилгын салбарт түр ажилчин бараг авдаггүй байна.

#### **2.4.2. Австрали улсын иргэн, харьяатын асуудлын эрх зүйн зохицуулалт, бодлого**

##### **Австрали улсын иргэний харьяаллын асуудал**

Австралийн иргэний харьяалалтай холбоотой үүссэн харилцааг 1948 онд батлагдсан Австралийн харьяатын тухай хуулиар зохицуулж байсан ба 2007 онд Австралийн харьяатын тухай шинэ хуулийг баталсан байна.

Австралийн харьяатын тухай хуулинд тодорхойлсоноор үндсэн 2 арга зам байдаг байна. Нэгдүгээрт, Австралид төрсөн бол, эцэг, эх хоёулаа болон аль нэг нь Австралийн иргэн бол, нутаг дэвсгэрээр нэгдсэн бол, мөн Австралийн нутагт орхигдсон хүүхэд автоматаар Австралийн иргэн болдог байна. Хоёрдугаарт, Австралийн иргэн болохоор хүсэлт гаргах замаар харьяат болдог.

2002 онд Харьяатын тухай 1948 оны хуульд өөрчлөлт оруулан Австрали хоёрдмол иргэний харьяаллыг хуульчилжээ. Австралид байнга оршин суугчийн визтэй гадаадын иргэд Австралийн харьяат болохоор хүсэлт гаргасан тохиолдолд 2007 оны 7 дугаар сарын 1-нээс хойш дараах шаардлагуудыг хангасан байх ёстой ажээ. Үүнд:

- 18 наснаас дээш настай байх
- Австралид хууль ёсоор 4-өөс доошгүй жил амьдарсан ба үүнээс 1-ээс доошгүй жилийн хугацаанд байнгын оршин суугчийн статустай байх, үүний зэрэгцээ хүсэлт гаргахаас өмнө 3 сарын турш Австралид тогтмол оршин суусан байх
- Австралийн түүх, төрийн байгууллын бүтэц, зарчим, австралийн нийгмийн үнэт зүйлстэй холбоотой сэдвээс бүрдсэн тестийн шалгалт өгөх
- Австралийн харьяат болохоор хүсэлт гаргах
- Австралийн харьяат болсны ёслол үйлдэх

Австралийн иргэн болсноор байнгын оршин суух статустай хүмүүсээс дараах давуу эрхийг эдэлдэг байна. Үүнд:

- Бүх түвшний сонгуульд оролцож сонгох, сонгогдох
- Австралийн иргэний паспорт авч гадаадад саадгүй зорчих ба дэлхийн олон оронд визгүй зорчих боломжтой
- Гадаадад Австралийн дипломат албаны тусламжийг авах боломжоор хангагдах
- Австралийн харьяат байхыг шаарддаг нөхцөл бүхий төрийн албанд ажиллах
- Австралийн армид алба хаах (гэрээ байгуулах)
- Гадаадад төрсөн хүүхдээ (25 хүртэлх насны) Австралийн харьяатаар бүртгүүлэх эрхтэй зэрэг болно.

2007 оны Австралийн харьяатын тухай хуулийн дагуу австралийн иргэн нь өргөдөл гарган Австралийн харьяатаас гарах эрхтэй.

#### **Австрали улсын гадаадын иргэн, харьяатын асуудал, шилжилт, хөдөлгөөний талаархи бодлого, эрх зүй**

Австралийн өнөө үеийн цагаачлалын онцлог нь маш олон бөгөөд янз бүрийн орноос цагаачлагчид ирдэг болсон явдал юм. Австралид шилжин ирэгсдийн бүрэлдэхүүнд бүтцийн өөрчлөлт орсон нь Европын бус орноос цагаачлагчдыг хүлээн авахыг хязгаарладаг байсан бодлого өөрчлөгдсөнтэй холбоотой ажээ. Үүнд эхний алхамыг 1958 онд “Шилжилт хөдөлгөөний тухай хууль”-ийг батласнаар тавьжээ. 1966 онд Азиас гаралтай шилжин ирэгсдийн Австралийн харьяат болохоор хүсэлт гаргах хугацааг шилжин суурьшинаас хойш 15 жил байсныг 5 жил болгосноор Ази тивийн улс орнуудаас цагаачлагчдын тоо нэмэгдсэн байна.

Австралийн орчин үеийн шилжилт хөдөлгөөний бодлого нь гадаадаас улс орныхоо эдийн засгийн хөгжлийн шаардлагад нийцсэн өндөр чадвар, мэргэшилтэй хүмүүсийг шилжүүлэн суурьшуулах, хууль бус цагаачлалыг зогсоох, олон талт соёлтой нийгмийн зарчмыг хөгжүүлэх гэсэн зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэж байна.

Дараахи хууль, эрх зүйн актууд Австралийн шилжилт, хөдөлгөөнийг зохицуулах төрийн бодлогын үндсийг бүрдүүлж байна. Үүнд:

- Гадаадын иргэдийн тухай хууль, 1984 он
- Шилжилт, хөдөлгөөний тухай хууль, 1958 он
- Визийн зохицуулалтын тухай, 1997 он
- Харьяатын тухай хууль, 2007 он,

Дээрхи хууль, эрх зүйн актууд нь дараа дараагийн нэмэлт өөрчлөлтүүд орсноор шилжилт хөдөлгөөний харилцааг зохицуулж байгаа ба энэ салбарын хууль, эрх зүйн баазыг боловсронгуй болгох ажлын үндсэн зарчим нь нэг талаар, эх оронлуугаа гадаадын мэргэжилтнүүд, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийг татах, нөгөө талаар, хүсэмжлээгүй цагаачдын категори орж ирэхээс сэргийлэх явдал юм.

Австралийн шилжилт хөдөлгөөний бодлогыг удирдах тогтолцоо нь төвлөрсөн бүтэцтэй бөгөөд Австралийн Цагаачлал, харьяатын яам энэ салбарын асуудлыг бүхэлд нь хариуцаж дараах чиг үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:

- Австралид ирэх, амьдрах, ажиллахаар хүссэн өргөдлийг шийдвэрлэх
- Цагаачлалын үйл явцад хяналт тавих
- Хууль бус цагаачлалтай тэмцэх, таслан зогсоох
- Харьяат болгох
- Үндэстэн ястны болон соёл хоорондын харилцааг хөгжүүлэх зэрэг болно.

Австралийн цагаачлалын талаар баримтлах бодлогын чухал хэсэг нь байнгын цагаачлал, шилжин суурьшилт ба эдгээрийн дотор дараах 3 гол чиглэл зонхилох байрыг эзэлдэг. Энэ нь:

1. Өндөр мэргэшлийн мэргэжилтэнүүд ба бизнес цагаачлал
2. Гэр бүл нэгдэн нийлэх үйл явц
3. Хүмүүнлэгийн цагаачлал ба дүрвэгсдийг хүлээн авах

Өндөр мэргэшлийн мэргэжилтэнүүд ба бизнес цагаачлал, гэр бүл нэгдэх хүрээнд хүлээн авах цагаачдын тоог Цагаачлалын хөтөлбөрийн хүрээнд жил бүр Засгийн газраас тогтоодог байна.

Хөдөлмөрийн цагаачлалын хувьд Австралийн засгийн газрын зорилго нь ажил олгогчдын эрх ашиг, дотоодын хөдөлмөрийн зах зээлийг хамгаалах хоёрын тэнцвэртэй байдлыг хангах замаар гадаадын өндөр мэдлэг чадвартай мэргэжилтэнүүдийг өөрийн оронд татан ажиллуулах явдал юм. Мэргэжилтнүүдийн цагаачлалын хөтөлбөрийн хүрээнд Австралийн



хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй мэргэжлүүдийн онцгой жагсаалт гаргадаг ба хүсэлт гаргагчийн нас, боловсрол, мэргэшил, мэргэжлийн дагуу ажилласан жил, хэлний мэдлэг зэргийг тодорхой баллаар үнэлдэг байна. Энэ үнэлгээний дагуу зөвшөөрөл олгодог ажээ. Австралийн ажил олгогчийн зүгээс ивээн тэтгэж буй нэр дэвшигчийн хувьд нэлээн доогуур балл авч зөвшөөрөл авах боломжтой байна.

Гэр бүл нэгдэн нийлэх үйл явцын хүрээн дэх шилжилт хөдөлгөөний тухайд энэ нь Австралийн цагаачлалын хөтөлбөрийн дагуу нийт шилжин суурьшигчдын 35,3 орчим хувийг эзэлдэг байна. Энэ ангилалд Австралийн иргэд болон байнга оршин суугчдын эхнэр нөхөр, сүйт бүсгүй, хархүү, хүүхдүүд, эдийн засгийн хараат байдалд байдаг эцэг эх, 18 хүртэлх насны өнчин хамаатан садан зэрэг маш олон хүмүүс хамаардаг.

Түүнчлэн Австралид түр оршин суух хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлал, суралцах, төрөл садантайгаа уулзах, түр ажиллах, нийгэм-соёлын харилцаа тогтоох зэрэг олон чиглэлээр хүмүүс зорчидог байна. Түр зорчих визийн хугацаа нь богино хугацаа нь 3 сар, урт хугацааны виз нь 4 жил хүртэл хугацаа байдаг байна. Түр оршин суух виз авах хүсэлтийг авч үзэхдээ ийнхүү зорчихийн зорилгыг анхааран авч үздэг ба энэ нь улс орных нь эдийн засгийн байдал сайжрахад, олон улсын харилцаа хөгжихөд, нийгэм-соёлын амьдрал баяжихад ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг үндэс болгон зөвшөөрөл олгодог байна.

#### **2.4.3. ХБНГУ-ын иргэн, харьяатын асуудлын эрх зүйн зохицуулалт, бодлого**

##### ***ХБНГУ-ын иргэний харьяаллын асуудал***

ХБНГУ-д 2000 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс “Харьяатын тухай” шинэ хууль хүчин төгөлдөр болсон байна. Юуны өмнө урдын адил төрснөөр ХБНГУ-ын харьяат болох зарчим үйлчилж байна, өөрөөр хэлбэл, эцэг, эхийнх нь аль нэг нь Германы иргэн бол хүүхэд шууд Германы иргэн болно.

Дээрхи шинэ хуулиар хэрэв гадаадын иргэн Германд хууль ёсоор, байнга, 8-аас доошгүй жил амьдарсан бол, эсвэл 3-аас доошгүй жил хугацаагүй амьдрах зөвшөөрөлтэй бол Германд төрсөн хүүхэд нь автоматаар Германы иргэн болохоор хуульчилсан байна. Эдгээр хүүхдүүд Германы иргэн болж бүх эрх, үүргийг эдлэхийн хамт ихэнхи тохиолдолд эцэг, эхийнхээ харьяат улсын харьяаллыг давхар авах боломжтой.

Гэсэн хэдий ч тэд 23 нас хүрэхээсээ өмнө чухам аль иргэний харьяалалтайгаа үлдэх вэ гэдгээ албан ёсоор хүсэлт гарган хүслээрээ сонгох ёстой ажээ. Үүнийг “Оптаци загвар” буюу хүслээрээ сонгох загвар гэнэ. Хэрэв тэд гадаадын харьяалаа үлдээх хүсэлтэй байгаа бол Германы харьяаллаас гарна. Албан ёсоор хүсэлт гаргаагүй тохиолдолд ч аль нэг иргэний харьяаллаасаа татгалзах ёстой. Түүнчлэн 10 нас хүртэлх насны хүүхдүүдийн хувьд шинэ хуулийн үзэл баримтлалд тохирсон шилжилтийн нөхцөлүүдийг тодорхойлжээ.

Гадаадын иргэдийн хувьд Германы харьяат болох нь төрсөнөөр автоматаар иргэн болохоос ялгаатай. Германд удаан хугацаанд байнга оршин суусан гадаадын иргэн хүсэлт гаргаснаар тодорхой нөхцөлүүдийн үндсэн дээр харьяат болох боломжтой.

Германы хууль, эрх зүйн актуудыг Европын Холбооны нэгдсэн стандартад нийцүүлсэнээр гадаадын иргэд Германы иргэний харьяалалтай болох нөхцөлүүдэд нэлээн өөрчлөлт орсон байна. Тухайлбал, 2001 оноос өмнө иргэний харьяалалтай болохын тулд Германд 15 жил хууль ёсоор байнга оршин суусан байх ёстой байсан бол 2001 оноос хойш 8 жил оршин суусан байж болно. Түүнчлэн дараах нөхцөлүүдийг хангасан байх ёстой ажээ. Үүнд:

- Албан ёсоор оршин суух зөвшөөрөлтэй байх
- Үндсэн хуулийг хүлээн зөвшөөрөх



- Үндсэн хуулийн эсрэг үйл ажиллагаа явуулаагүй байх
- Нийгмийн халамж болон ажилгүйдлын тэтгэмж авахгүйгээр амьдрах боломжтой байх
- Ял эдэлж байгаагүй байх
- Герман хэлний мэдлэг зэрэг болно.

Герман улс хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй учир Германы харьяат болсоноос хойш 1жилийн дотор өөр улсын харьяаллаас татгалзах ёстой, ийнхүү татгалзаагүй тохиолдолд Германы иргэний харьяалалыг хүчингүй болгоно. Зарим онцгой тохиолдолд, тухайлбал, өндөр настай хүмүүс, 1950-иад оны эхэн үеэс Германд амьдарч байгаа хүмүүсийн хувьд хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөн ажээ. Мөн герман хүн хэд хэдэн улсын иргэний харьяалалтай бол өөрөө зохих байгууллагуудад хүсэлт гарган, тэдгээрийн зөвшөөрсөнөөр Германы иргэний харьяаллаас татгалзах эрхтэй.

### **ХБНГУ-ын гадаадын иргэн, харьяатын асуудал, шилжилт, хөдөлгөөний талаархи бодлого, эрх зүй**

ХБНГУ-д зорьчиж, амьдарч, сурч, ажиллаж байгаа гадаадын харьяат иргэдтэй холбоотой харилцааг зохицуулдаг эрх зүйн баримт бичиг нь 1990 онд батлагдсан “Гадаадын иргэдийн тухай хууль” юм.

1994 ноос Герман улс Европын Холбооны гишүүн бус орнуудын иргэд Германд ирж ажиллахыг хориглосон хязгаарлалтаа цуцалсан ба нэлээд олон оронтой дараах 3 бүлэг хөдөлмөрийн цагаачдыг хүлээн авах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулжээ. Үүнд:

1. Улирлын ажилчдын талаархи хоёр талын хэлэлцээр. 90-ээд оны эхээр ийм хэлэлцээрийг Хорват, Польш, Румын, Словак, Чех, Унгар, Болгар зэрэг улсуудтай байгуулсан байна. 1993 оны 5 дугаар сараас Германы ажил олгогчид гадаадын улирлын ажилчдыг ажиллуулсны төлбөр нэг ажилчны төлөө 100 немц марк төлдөг болжээ.
2. Тодорхой төрлийн үйлчилгээний ажил хийлгэхээр гадаадын төслийн ажилчдыг ажиллуулах хоёр талын хэлэлцээр. 1989-1993 онуудад Герман улс Болгар, Чех, Югослав, Босни ба Герцеговина, Хорват, Македони, Турк, Литв, Латви зэрэг орнуудтай ийм хэлэлцээр байгуулжээ. Төслийн дагуу ажилд гадаадын компани нь орон нутгийн компанитай гэрээ байгуулан онцгой төрлийн ажилд тодорхой хугацаагаар (2-3 жил) өөрийн ажиллах хүчнийг оруулах эрхтэй болдог байна. Төслийн ажилтан бүрийн төлөө ажил олгогч нь ойролцоогоор жилд 1100 евро төлдөг.
3. Зочин ажилтан солилцооны хоёр талын хэлэлцээр, 90-ээд онд Герман ийм хэлэлцээрийг Албани, Болгар, Латви, Польш, ОХУ, Словак, Чех, Унгар улсуудтай байгуулжээ.

ХБНГУ-ын цагаачлалын бодлогын шинэчлэл нь шинэ мянганы эхэнд 2000 оны 8 сараас тус улс гадаадын компьютерын мэргэжилтэнүүдийг хүлээн авах шинэ хөтөлбөрөө зарласнаас эхэлсэн гэж үздэг. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд гадаадын компьютерын техник, мэдээллийн технологийн салбарын тэргүүлэх мэргэжилтнүүдийг хүлээн авч ногоон карт олгосон ба 5 жил хүртэл хугацаанд ажиллах гэрээ байгуулна.

Германы хууль, тогтоомжийн дагуу ажиллах зөвшөөрөл авах гэсэн ерөнхий ойлголт нь дараахи хоёр ойлголтоор тодорхойлогддог байна. Үүнд:

- Ажиллах зөвшөөрөл
- Ажиллах эрх

Германы “Нийгмийн хууль”-ийн дагуу гадаадын иргэдэд ажиллах зөвшөөрөл олгохдоо тодорхой нөхцөлд хөдөлмөрийн зах зээлийн байдлыг харгалзан олгодог. Ингэхдээ гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт нь Германы иргэдийн ажил эрхлэлтийн байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх ёстой. Гадаадын иргэний хөдөлмөрийн нөхцөл нь Германы иргэдийн ажиллах нөхцөлтэй ижил байх ёстой.

Ажиллах зөвшөөрөл авах эхний нөхцөл нь Германд тодорхой хугацаагаар амьдарсан байх явдал юм байна. Хуулийн дагуу ажиллах зөвшөөрлийг 1 жил хүртэл хугацаанд олгодог. Ажиллах анхдагч зөвшөөрөл авахын тулд хүлээх хугацаа янз бүр байдаг байна. Үүнд:

- Тодорхой хугацаанд амьдрах зөвшөөрөлтэй гадаадын иргэний гэр бүлийн хүн, хүүхдүүд нь 4 жил хүлээнэ
- Ажиллах болон байнга амьдрах зөвшөөрөлтэй гадаадын гадаадын иргэний гэр бүлийн хүн, хүүхдүүд нь 1 жил хүлээнэ

Германы Нийгмийн хуулийн дагуу байнга оршин суудаг, өмнөх 5 жилд ХБНГУ-ын нутаг дэвсгэр дээр хөлсний хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан бол гадаадын иргэдэд ажиллах зөвшөөрөл олгодог. Үүний зэрэгцээ хуулиар тогтоосон зарим тодорхой ажил, мэргэжлийн хүмүүст ажиллах зөвшөөрөл авалгүйгээр ажиллах боломж олгодог байна.

Мөн дараах тохиолдолд гадаадын иргэнд хугацаа, хаана ажиллах хязгаарлалт тогтоолгүйгээр ажиллах эрх олгодог. Үүнд:

- ХБНГУ-ын иргэний гэр бүл бөгөөд амьдрах зөвшөөрөлтэй бол
- Германд зайлшгүй оргонох эрхтэй бол
- ХБНГУ-ын засаг, захиргаанаас олгосон дүрвэгчийн үнэмлэхтэй бол
- Хуулийн дагуу хүмүүнлэгийн үйл ажиллагааны хүрээнд албан ёсны дүрвэгчийн статустай бол
- ХБНГУ-д байнга амьдрах зөвшөөрөлтэй, 6 жилийн турш тасралтгүй Германд оршин суугаа бол

#### **2.4.4. БНХАУ-ын иргэн, харьяатын асуудлын эрх зүйн зохицуулалт, бодлого**

##### **БНХАУ -ын иргэний харьяаллын асуудал**

БНХАУ-ын “Харьяатын тухай хууль” нь 1980 оны 9 дүгээр сарын 10-наас хүчин төгөлдөр болсон бөгөөд БНХАУ-ын иргэний харьяат болох, харьяаллаа алдах, сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулдаг байна.

Хятадад төрсөн, эцэг, эх болон эдгээрийн аль нэг нь БНХАУ-ын иргэн бол тухайн хүн БНХАУ-ын харьяат болдог. БНХАУ иргэний хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй. Хилийн чандад төрсөн, эцэг, эх нь хоёулаа болон аль нэг нь Хятадын харьяат бол ийм хүн БНХАУ-ын иргэний харьяалалтай болж болно, харин ийм хүн төрсөн цагаасаа гадаадад амьдарч, амьдарч буй улсынхаа харьяат бол тухайн хүн Хятадын харьяалалтай болох боломжгүй.

Хятадад төрсөн, эцэг эх нь Хятадад байнга оршин суудаг боловч аль нэг улсын харьяалалгүй эсвэл харьяалал нь тодорхой бус бол тухайн хүн БНХАУ-ын иргэний харьяалалтай болж болно. Гадаадын харьяат болон харьяалалгүй хүн БНХАУ-ын Үндсэн хууль бусад хууль, тогтоомжийг хүлээн зөвшөөрч сахихад бэлэн болоод дараах нөхцөлүүдийн аль нэг нь байгаа бол БНХАУ-ын иргэний харьяалалтай болохоор өргөдөл гаргаж болно. Үүнд:

- Хятадад ойрын төрөл садан нь байх
- Хятадад байнга оршин суух

- Бусад хууль ёсны үндэслэлтэй байх

Гадаадад амьдардаг Хятадын иргэд гадаадын харьяалалтай болсон тохиолдолд автоматаар Хятадын иргэний харьяаллаа алдана. БНХАУ-ын харьяат иргэд дараахь тохиолдолд Хятадын иргэний харьяаллаас гарахаар өргөдөл гаргах эрхтэй. Үүнд:

1. Гадаадын харьяат ойрын төрөл садантай байх
2. Гадаадад байнга амьдран суудаг байх
3. Бусад хууль ёсны үндэслэлтэй байх зэрэг болно.

БНХАУ-ын төрийн албан хаагчид болон цэргийн албан хаагчдыг иргэний харьяаллаас гарахыг хориглодог ажээ. БНХАУ-ын иргэний харьяалалтай болох, гарах, сэргээх тухай өргөдлийг БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам хүлээн авч шийдвэрлэдэг байна.

### **БНХАУ -ын гадаадын иргэн, харьяатын асуудал, шилжилт, хөдөлгөөний талаархи бодлого, эрх зүй**

1978 оноос хойш барилгын төсөл хэрэгжүүлэх, их, дээд сургуульд суралцах, эрдэм шинжилгээний ажил хийх, худалдаа наймаа эрхлэх зэрэг олон төрлийн ажлаар БНХАУ-зорьчих гадаадын иргэдийн тоо нэмэгджээ.

Гадаадын жуулчдын зэрэгцээ Хятадын засгийн газар зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийг хурдсахын тулд гадаадын шинжээч, мэргэжилтнүүдийг өөрийн улсад ажиллуулахыг дэмжих болжээ. Гадаадын експертуудыг тэд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, батлах хамгаалах хүчээ шинэчлэх шинэчлэлийн бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг байна. Энэ зорилгоор өндөр мэдлэг чадвартай инженер, техникийн ажилтан, эрдэмтэд, удирдах ажилтнуудыг өөрийн хөдөлмөрийн зах зээлд татах засгийн газрын урт хугацааны стратегийг боловсруулжээ. Энэхүү стратегийн хүрээнд гадаадад оюутан, эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургах чиглэл ч мөн багтаж байна.

Гадаадын шинжээч, мэргэжилтнүүдийг Хятадад татан ажиллуулах үйл ажиллагааны зарчмуудыг 1995 онд батлагдсан “Гадаадын експертүүдийг ажиллуулах агентлагуудын үйл ажиллагааны түр дүрэм”-ээр тодорхойлжээ. Гадаадын мэргэжилтнүүдийг ажиллуулах агентлагууд нь дараах үүрэг хүлээдэг байна. Үүнд:

- Хятадад ажиллах хүсэл сонирхолтой гадаадын мэргэжилтнүүдийг олж бүртгэх. Эдгээр гадаадын мэргэжилтнүүд нь техникийн зааварчилгаа өгөх, зөвөлгөө өгөх, мэргэжлийн сургалт явуулах, судалгаа хийх, лекц унших зэрэг чадвартай байх ёстой.
- Гадаадын шинжээчдэд төсөл боловсруулж, судлах, маркетингийн судалгаа явуулах, менежментийн үйл явцыг шинжлэх, Хятадын удирдах албаны хүмүүст зөвөлгөө өгөх ажилд нь дэмжлэг үзүүлэх
- Экспертүүдийг ажлаа хийх бэлтгэл ажлыг нь хангах, бүх талын туслалцаа үзүүлэх эдгээр болно.

Хятадад гадаадынхны хөдөлмөр эрхлэлтийн захиргааны удирдлагыг хангах зорилгоор 1996 онд “Гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн захиргааны удирдлагыг хангах дүрэм”-ийг баталжээ. Хятадад хөдөлмөр эрхлэхийн тулд гадаадын иргэд дараахь шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

- 18 түүнээс дээш настай байх
- Эрүүл байх
- Хүссэн мэргэжлээрээ ажиллах өндөр мэргэшилтэй, ажлын туршлагатай байх
- Урьд нь ял эдлээгүй байх

- Ажил олгогч нь тодорхой байх
- Хүчин төгөлдөр гадаад паспорт, түүнийг орлох олон улсын бичиг баримттай байх зэрэг юм.

Дараах тохиолдолд гадаадын иргэд дүрэм, журмын дагуу ажиллах зөвшөөрөл, гэрчилгээ авахаас чөлөөлөгдөнө. Үүнд:

- Хятадын засгийн газар, засгийн газрын агентлагаас ажиллуулахаар уригдсан ажилтан, онцгой мэдлэг чадвартай, техникийн өндөр албан тушаал хашдаг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн, мөн Хятадын гадаадын экспертүүдын Товчооны гэрчилгээтэй мэргэжилтэн
- Татваргүй бүсэд нефьт олзворлох ажил хийх тусгай бэлтгэгдсэн гадаадын ажилчид
- Хятадын соёлын яамны зөвшөөрлөөр түр хугацаанд арилжааны цэнгээнт тоглолт хийж буй гадаадын иргэд

Түүнчлэн хоёр талын гэрээ, хэлэлцээр болон олон улсын гэрээний дагуу Хятад улс гадаад улсын хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаанд оролцох гадаадын иргэд, Хятад улс дахь гадаадын пүүс, компаниудын төлөөлөгчдийн газрын ажилтнууд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахгүй буюу Хятадад ирсэнийхээ дараа зохих бичиг баримтаа үзүүлэн зөвшөөрөл хүсэх эрхтэй байна.

Зарим гадаадын иргэд өөрсдийн шугамаар Хятадад ажил хайж болох боловч Хятадад хууль бус гадаад шилжилт хөдөлгөөнийг хатуу шийтгэх, таслан зогсоох бодлого баримталдаг байна. Өнөө үед гадаад шилжилт хөдөлгөөний талаар Хятадын баримталж байгаа бодлого нь ажиллах хүчээ гадаадад гаргах, гадаадын экспертүүдийг өөрийн орондоо татан ажиллуулах гэсэн хоёр чиглэлээр хэрэгжиж байна. Эдгээрийн аль аль нь Хятадын баримталж байгаа шинэчлэл, нээлттэй байдлын чиг шугамын бүрэлдэхүүн хэсгүүд юм.

1978 он хүртэл Хятадад ажиллах хүч гадаад гаргахыг хязгаарлаж байжээ. Харин 1990-ээд оноос Хятадын эдийн засаг дэлхий эдийн засгийн үйл явцад нэгдэн нягтрахын хэрээр ажиллах хүч гадаадад гаргах үйл явц хурдассан ба Хятад улс дэлхийн янз бүрийн бүсэд ажиллах хүч гаргаж эхэлжээ. Хятадын засгийн газраас эрх бүхий пүүсүүд зохион байгуулалттайгаар ажиллах хүч гаргахыг дэмждэг байна. Эдгээр эрх бүхий пүүсүүдийнх нь гадаадад гаргах ажиллах хүчний тоо жилээс жилд нэмэгдэж байгаа ба хятад ажилчид хөдөө аж ахуй, оёдолын үйлдвэр, барилга, хүнсний салбарт 10 гаруй улсад ажиллаж байгаа ажээ.

#### **2.4.5. БНКаЗУ-ын иргэн, харьяатын асуудлын эрх зүйн зохицуулалт, бодлого**

##### **БНКаЗУ-ын иргэний харьяаллын асуудал**

БНКаЗУ-ын иргэний харьяаллын асуудал нь БНКаЗУ-ын Үндсэн хуулинд үндэслэн 1991 онд батлагдсан “БНКаЗУ-ын харьяатын тухай” хуулиар зохицуулагддаг байна. Тус хуулийн дагуу дараах тохиолдолд Казахстан улсын харьяат болно. Үүнд:

- Төрсөнөөр
- 1992 оны 3 дугаар сарын 1 хүртэл Казахстанд байнага оршин суусан бол
- БНКаЗУ-ын харьяат болохоор хүсэлт гарган харьяат болсоноор тус тус иргэний харьяалалтай болно.

Эх, эцэг хоёр нь хоёулаа Казахстаны иргэн бол мөн эцэг, эхийн аль нэг нь Казахстаны иргэн, нөгөөх нь харьяалалгүй иргэн бол хүүхэд нь хаана төрсөнөөс үл хамааран Казахстаны

иргэн болно. Түүнчлэн Казахстаны нутаг дэвсгэрт байгаа эх, эцэг нь тодорхойгүй хүүхэд, Казахстанд байнга оршин суудаг харьяалалгүй иргэдийн Казахстанд төрсөн хүүхэд Казахстаны харьяат болохоор хуульчилжээ.

Бүгд Найрамдах Казахстан Улс иргэний хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй байна. “БНКаЗУ-ын харьяатын тухай” хуулийн 16 дугаар зүйлийн дагуу дараахь нөхцөлийг хангасан гадаадын иргэдийн Казахстаны иргэн болохоор гаргасан хүсэлтийг ёсоор болгох боломжтой ажээ. Үүнд:

- БНКаЗУ-ын харьяат болохыг хүсэн өргөдөл гаргах хүртлээ Казахстанд тасралтгүй 5-аас доошгүй жил байнга оршин суусан байх
- Казахстаны иргэнтэй гэр бүл болсон бол
- Казахстанд ойрын төрөл садантай бол, ойрын төрөл саданд: эх, эцэг, төрсөн ах, дүү, эхнэр, нөхөр, эмэг эх, өвөг эцгийг тооцно.
- Сүүлийн хоёр үндэслэлээр Казахстанд байнга амьдарсан хугацааг харгалздаггүй байна.

Ер нь Казахстаны харьяат болгох хялбаршуулсан, нийтийн тогтсон гэсэн хоёр янзын журам байдаг. Хялбаршуулсан буюу бүртгэх журам нь БНКаЗУ-ын байгуулсан олон улсын хэлэлцээрийн дагуу хэрэгждэг ба Казахстан улс ийм хэлэлцээрийг ОХУ, БНБелУ, Кыргыз улс, Украин улстай байгуулжээ.

БНКаЗУ-тай хэлэлцээр байгуулсан дээрхи улсууд хоёр талын аль нэг улсын хүсэлт гаргасан иргэнд хялбаршуулсан журмаар улсынхаа иргэний харьяаллыг олгохоор харилцан үүрэг хүлээжээ. Ингэхдээ хүсэлт гаргагч нь урд нь эдгээрийн аль нэг улсын ба хуучин ЗСБНХУ-ын иргэн байсан, эдгээр улсад байнга оршин суудаг, ойрын төрөл садан нь иргэний харьяалал хүссэн улсынх нь иргэн буюу байнга оршин суугч байх ёстой ажээ. Хялбаршуулсан журам нь дээрхи улсуудын аль нэгний иргэн ба нөгөө улсад байнга оршин суудаг иргэнд хамаатай ба иргэний харьяаллыг нь авах гэж буй улсдаа оршин суусан хугацааг харгалзахгүй юм.

Дээрхи хоёр талын хэлэлцээр байгуулсанаас бусад улс орны иргэд БНКаЗУ-ын харьяат болох журам нь нийтийн тогтсон журам юм. Энэ журмаар Казахстан улсын иргэний харьяалал хүссэн өргөдлийг БНКаЗУ-ын Ерөнхийлөгчийн нэр дээр гаргаж өөрийн оршин суугаа газрын шилжилт, хөдөлгөөний полицийн Удирдах газар өгдөг байна. Ингэхдээ дагалдах бичиг баримт, тухайлбал, ажлын газрын тодорхойлолт, ял эдэлж байгаагүй талаар цагдаагийн газрын тодорхойлолт, БНКаЗУ-ын иргэний ойрын төрөл садан болохыг нотолсон баримт зэргийг бүрдүүлдэг байна.

Гадаадын иргэдийн БНКаЗУ-ын иргэний харьяалалтай болох хүсэлтийг БНКаЗУ-ын Ерөнхийлөгч авч үзээд тодорхой нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Казахстан улсын харьяат болсон тухай БНКаЗУ-ын Ерөнхийлөгчийн Зарлиг гаргадаг байна.

***БНКаЗУ-ын гадаадын иргэн, харьяатын асуудал, шилжилт, хөдөлгөөний талаархи бодлого, эрх зүй***

БНКаЗУ-ын гадаадын иргэн, харьяатын асуудал, шилжилт хөдөлгөөнийг дараахь хууль, эрх зүйн баримт бичгүүд зохицуулж байна. Үүнд:

- БНКаЗУ-ын Үндсэн хууль. 1995 он
- Хүн амын шилжилт хөдөлгөөний тухай хууль. 1997 он
- БНКаЗУ-ын хүн амын шилжилт хөдөлгөөний талаар баримтлах бодлогын үзэл баримтлал 2001-2007 он
- БНКаЗУ-ын хүн амын шилжилт хөдөлгөөний талаар баримтлах бодлогын үзэл

баримтлал 2007-2015 он зэрэг болно.

Хүн амын шилжилт хөдөлгөөний тухай хуулинд БНКаЗУ-ын хүн амын шилжилт хөдөлгөөний талаар баримтлах бодлогын дараахь зарчмуудыг тодорхойлжээ. Үүнд:

- БНКаЗУ-ын Үндсэн хуульд тунхагласан хүн амьдрах газраа чөлөөтэй сонгох, чөлөөтэй хөдөлмөрлөх, ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, эх орноо орхин явах, эх орондоо эргэн ирэх эрхийг хангах
- Хүнийг гарал үүсэл, нийгэм, албан тушаал, эд хөрөнгийн байдал, яс, үндэс, арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, үзэл бодол, амьдран суугаа газар болон бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх
- БНКаЗУ-ын шилжилт хөдөлгөөний бодлогыг олон улсын хэм хэмжээ, Шилжилт хөдөлгөөний Олон улсын байгууллагын зөвлөмж, улс орныхоо нийгэм-эдийн засгийн байдал, өнгөрсөн түүхэн уламжлал, хөгжлийн ирээдүйтэй нийцүүлэх
- Казах угсаатныг БНКаЗУ-д шилжин ирж нутагших үйл явцад бүх талын дэмжлэг үзүүлэх, үүнийг зохион байгуулах, ажлын байр бий болгох, нийгмийн хангамж, халамж, туслалцаа үзүүлэх зэрэг болно.

БНКаЗУ тусгаар тогтнолоо зарласны дараа гадаадад амьдарч буй казах угсаатнуудыг түүхэн эх орондоо эргэн ирэхийг дэмжих бодлогоо зарлаж энэхүү бодлогоо анх 1992 онд батлагдсан “Харьяатын тухай”, Цагаачлалын тухай” зэрэг хуулинд хуульчилжээ. Улмаар 1998 онд уг харилцааг зохицуулах Үзэл баримтлал батлагдан хилийн чанадад буй казах угсаатнуудыг түүхэн эх оронд нь эгүүлэн авчрах нь Казахстан улсын шилжилт хөдөлгөөний бодлогын тэргүүлэх чиглэл болохыг онцолсон байна. Энэхүү Үзэл баримтлалын зорилго нь хилийн чанадад буй казах угсаатнуудыг түүхэн эх оронд нь эгүүлэн авчрах үйл явцын бодит механизмыг бий болгох, түүний дотор тэдгээрийг зохион байгуулалттай нүүлгэн шилжүүлж авчрах, суурьшуулах асуудал орж байжээ.

Казах угсаатнуудыг түүхэн эх оронд нь эгүүлэн суурьшуулах бодлого нь Казахстаны хүн амын тоон болон жам ёсны өсөлтийг нэмэгдүүлэх, улс орны хүн ам зүйн байдлыг эрүүлжүүлэх нэг чухал хүчин зүйл гэж үздэг байна. Дээрхи бодлогын хүрээнд 1991 оноос Узбекистанаас- 120000, Монголоос- 67000, Туркменстанаас- 28000, ОХУ-аас- 10000, Таджикистанаас- 10000 казах угсаатан БНКаЗУ-д шилжин суурьшсан байна.

Ерөнхийдөө шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2007 онд “БНКаЗУ-ын шилжилт хөдөлгөөний бодлогын 2007-2015 он хүртэлх Үзэл баримтлал”-ыг баталжээ. Энэ үеийн шилжилт хөдөлгөөний бодлогын чухал зорилт нь угсаатны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах асуудал байжээ. Шилжин ирсэн казахууд юуны түрүүнд байнга оршин суух зөвшөөрөл, улмаар иргэний харьяалалтай болох асуудлыг шийдвэрлэж байв. Түүнчлэн тэдэнд улсын төсвөөс нэг удаа мөнгөн тэтгэлэг олгох, хилийн чанадаас нүүн ирсэн зардлыг нөхөн олгох, ажлын байртай болгох асуудлыг дэс дараатай шийдвэрлэсэн байна.

Казахстаны эдийн засаг эрчимтэй хөгжиж, нийгмийн тогтвортой байдал нэмэгдэн, шилжилт хөдөлгөөний либерал бодлого хэрэгжүүлэхийн хэрээр тэнд ажиллахаар очих гадаадын иргэдийн тоо нэмэгдсэн байна. Хөдөлмөрийн цагаачлал өсөн нэмэгдсэн нь хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой байдал, санал болгож буй ажлын байрны олон янз байдал, хөрш орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр хөдөлмөрийн хөлс зэрэгтэй холбоотой ажээ.

БНКаЗУ нь хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулахдаа юуны өмнө дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалахад анхаардаг байна. Ингэхдээ өөрийн нутаг дэвсгэрт хууль ёсоор хөдөлмөр эрхлэхээр орж ирсэн гадаадын шилжин ирэгсдийг нутгаасаа гаргах арга хэмжээ авдаггүй тэднийг өөрийн хөдөлмөрийн зах зээл дээр зохистой байршуулах бодлого хэрэгжүүлдэг.



Казахстаны шилжилт хөдөлгөөний бодлогын нэг гол чиглэл нь улс орныхоо эдийн засагт гадаадын ажилтан, мэргэжилтнүүдийг татан ажиллуулж, өрсөлдөх чадвар бүхий эдийн засгийг өндөр мэргэжилтэй ажиллах хүчнээр хангах явдал юм. Ингэхдээ тэдгээр мэргэжилтнүүдийг төрөөс стратегийн хувьд чухал гэж үзсэн тэргүүлэх салбаруудад ажиллуулдаг байна.

Гадаадын ажиллах хүчнийг ажиллуулдаг зонхилох салбарууд нь барилга(57,3%), уул уурхай (10,7%), боловсруулах үйлдвэрүүд (8,9%), болно. Өнөөгийн байдлаар Казахстаны хөдөлмөрийн зах зээл нь ажилгүйдлийн түвшни бууралт, ажил эрхлэгч хүн амын тоо өссөн байдлаар тодорхойлогдож байна.

Казахстаны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь гадаадаас ажиллах хүч авах талаархи эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг байнга хийдэг бөгөөд энэ үйл ажиллагаанд квот тогтоосон нь хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн ажиллах хүчээр хангах боломжийг бий болгож байна.

2008-2009 онд Казахстан улсын гадаадаас ажиллах хүч оруулахад квот тогтоох, гадаадаас ажиллах хүч оруулах ажил олгогчдод зөвшөөрөл олгох нөхцөл, дэг журамд хоёр удаа өөрчлөлт оруулсан ба дараах зүйлсийг харгалзан үзэх ёстой байна. Үүнд:

- Гадаадаас ажиллах хүчин авах квотыг ажиллах хүчний ангилалыг харгалзан ялгавартай тогтоох
- Гадаадаас ажиллах хүчин авах зөвшөөрлийг олгох ажлын ил тод, тунгалаг байдлыг хангах, хялбарчилах
- Гадаадын ажилтанд хувьд нь зөвшөөрөл олгох
- Гадаадын мэргэжилтэний боловсрол, мэргэжлээрээ ажилласан жил, тухайн мэргэжлийн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ зэргийг харгалзан онооны системээр шалгаруулах зэрэг болно.

Түүнчлэн зарим мэргэжил, албан тушаалтнуудад зориулан ажиллах зөвшөөрлийг хялбаршуулсан байдлаар олгох журмыг тогтоосон нь гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх, эрдэм шинжилгээний ажил, багшлах боловсон хүчний хүчин чадвар дээшлэхэд үнэтэй хувь нэмэр болж байгаа ажээ.

## **2.5. ИРГЭН, ХАРЬАТЫН АСУУДЛААРХИ ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

### **Дүгнэлт:**

1. Иргэний харьяалалтай болох цусны, хөрсний гэсэн хоёр үндсэн зарчим бий. Өнөө үед ихэнхи улсын, түүний дотор бидний судалгаандаа авч үзсэн орнуудын хууль тогтоомж илүү ач холбогдол бүхий цусны зарчмыг хөрсний зарчимтай хослуулан хэрэглэж байна. Монгол улсад мөн адил энэ хоёр зарчмын аль алинийг нь хүлээн зөвшөөрч байна.
2. Аливаа улсын эрх бүхий байгууллагын акт болон олон улсын гэрээний үндсэн дээр харьяат болох нь иргэний харьяалалтай болох хоёр дахь түгээмэл арга юм. Ихэнхи улсын хууль тогтоомж нь тогтвортой оршин суух хугацааны доод хязгаарыг тогтоодог. Тухайлбал, тухайн улсын харьяат болохын тулд АНУ-д 5 жил, Австралид - 4 жил, ХБНГУ-д 8 жил, БНКаЗУ-д 5 жил, Монгол Улсад 5-аас доошгүй жил байнга оршин суусан байх ёстой юм.
3. Хоёрдмол болон иргэний олон харьяалал бол дэлхийн олон улс оронд бодитой байгаа эрх зүйн түгээмэл зүйл юм. Бидний авч үзсэн улс орнуудаас АНУ, Австрали



хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөг бол Монгол улс, ХБНГУ, БНХАУ, БНКаЗУ хоёрдмол харьяаллыг хүлээн зөвшөөрдөггүй байна.

4. Иргэний харьяаллын асуудлаар Монгол улсын харьяаллаас гаралгүйгээр өөр улсын харьяат болсон иргэдийн асуудал нэлээн анхаарал татаж байгаа асуудал болж байна. Тухайлбал, өнөөгийн байдлаар манай улсаас БНКаЗ.У-д шилжин суурьшсан иргэдээс **26644** иргэн хоёрдмол харьяалал үүсгээд байсны **17042** иргэнийг хялбаршуулсан журмаар харьяатаас гаргах асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барьж Ерөнхийлөгчийн зарлигаар шийдвэрлүүлсэн байна.
5. Судалгаанаас үзэхэд гадаадын иргэд Монгол улс харьяат болох нь тооны хувьд харьцангуй буурсан, харин Монгол улсын иргэд өөрийн иргэний харьяаллаас гарах нь нэмэгдсэн үзүүлэлт харагдаж байна. Тухайлбал, 2004 онд гадаадын 23<sup>49</sup> иргэн манай улсын харьяат болсон бол 2009 онд 12 иргэн Монгол улсын харьяат болжээ. 2004 онд Монгол улсын 70 иргэн иргэний харьяаллаасаа гарсан бол 2009 онд 276<sup>50</sup> иргэн тус улсын иргэний харьяаллаас гарчээ.
6. 1990-ээд оноос Монгол улсын иргэд “хүний өөрийн амьдрах орчноо чөлөөтэй сонгож амьдрах” Үндсэн хуулиар олгосон эрхийнхээ дагуу гадаадын олон улс оронд сурч, хөдөлмөрлөж амьдарч эхэлснээс хойш Монгол улсын улс төр-эдийн засаг, боловсрол, нийгмийн сэтгэл зүй, оюуны сэтгэлгээд маш их өөрчлөлтүүдийг оруулж байна.
7. Манай иргэдийн гадаад шилжилт хөдөлгөөн, ялангуяа хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн нь макро, микро түвшинд эерэг болон сөрөг үр дагавартай байна гэж үзэж болно. Макро түвшинд, өөрөөр хэлбэл, улс, нийгмийн хүрээнд: улс орондоо ажилгүйчүүдийн эгнээг тодорхой хэмжээгээр нимгэлэхийн зэрэгцээ төрөл садан, ар гэрийнхэндээ мөнгө гуйвуулж байгаа нь зохих хүн амын хэсгийн амьжиргааг өөд нь татаж, шууд бусаар Монгол улсын валютын нөөц, төлбөрийн балансад эерэг нөлөө үзүүлж байна.

Микро түвшинд: гадаадын соёл иргэншилтэй танилцах, хэл сурах, боловсрол, мэргэжил эзэмших, бие даан амьдрах чадвартай болох, мөнгө хуримтлуулах зэрэг хувь хүн, түүний гэр бүл, ойрын хүмүүсийн амьдралд эерэг тал ажиглагдаж байна. Харин сөрөг үр дагаврын хувьд макро түвшинд, залуу боловсон хүчнээ гадагш алдаж буй нь дотоодод хөдөлмөрийн зах зээл дээр тодорхой хомсдол бий болох, түүнчлэн хүн амын бүтцэд, тухайлбал, гэр бүл салах, гадаадад гарч байгаа хүмүүсийн дийлэнхи нь нөхөн үржихүйн насны хүмүүс байгаа нь хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлж байна.

Түүнчлэн гадаадад хууль бусаар оршин сууж буй иргэд элдэв хэрэг, зөрчилд амархан холбогддог ба энэ нь ОНХМХ-ээр мэдээлэгдэж эцсийн дүндээ Монгол орны талаар сөрөг сурталчилгаа болох хувирдаг. Микро түвшинд дараахи сөрөг үр дагавар гарч байна. Үүнд, гадаадад ажилласнаар боловсрол мэргэжил эзэмших хугацаа алдах, гэрлэлт, төрөлт оройтох, эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах боломжгүй байх, эх орныхоо амьдралаас холдох, гэр орноо санаж сэтгэлийн хүнд хямрал, дарамтанд орох зэрэг олон сөрөг үр дагавартай байна.

8. Гадаадад оршин суугаа иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж,

<sup>49</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын мэдээлэл

<sup>50</sup> Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаархи үндэсний дээд хэмжээний уулзалт. УБ., 2005 он, 51 дэх тал

эх оронтойгоо хэлхээ холбоотой байх боломжоор хангах, тэдний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг цаг алдалгүй авах нь улам бүр чухал болж байна. Тухайлбал, эрүүл мэнд, нийгмийн даатгал, хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх, давхар харьяаллыг тодорхой хүрээнд хүлээн зөвшөөрөх, сонгуулийн эрхийг нь хэрэгжүүлэх, мэдээллийн технологийг өргөн ашиглах г.м. арга хэмжээ авах шаардлага гарч байна.

9. Бидний судалсан улс орнууд гадаадын иргэн, харьяатын асуудлыг өөр өөрийн хууль, тогтоомжоор зохицуулж байгаа бөгөөд эдгээр оронд шилжин ирэгсдийн дийлэнхи хувийг тухайн оронд хөдөлмөр эрхлэхээр ирж буй гадаадын хүмүүс эзэлж байна. АНУ, Австрали, Германд гадаадын иргэдийг шилжүүлэн суулгах, хөдөлмөр эрхлүүлэх тусгайлсан хөтөлбөр хэрэгжиж байна. Тухайлбал, Австралийн мэргэжилтнүүдийн цагаачлалын хөтөлбөр, Германы гадаадын компьютерын мэргэжилтэнүүдийг хүлээн авах шинэ хөтөлбөр зэрэг юм.
10. Эдгээр орнууд гадаадаас ажиллах хүч авахдаа ажил олгогчдын эрх ашиг, дотоодын хөдөлмөрийн зах зээлийг хамгаалах хоёрын тэнцвэртэй байдлыг хангах замаар гадаадын өндөр мэдлэг, чадвартай мэргэжилтэнүүдийг өөрийн оронд татан ажиллуулахыг зорьж байна.
11. Манай Улсын хувьд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба байгуулагдсанаар гадаадын иргэдэд тавих хяналт, зөвшөөрөл бүртгэлийн үйлчилгээ нэг цэгт төвлөрсөн бөгөөд мэргэжлийн байгууллага энэ асуудлыг эрхлэх болсон нь энэ салбарт гарсан нэг дэвшил юм. Гэвч сайжруулах боловсронгуй болгох зүйлүүд нэлээдгүй байна. Гадаадын иргэдэд тавих хяналтын нэгдсэн тогтолцоо байхгүй, хяналтын тогтолцоо нь боловсронгуй бус байгаа нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болоод байна.
12. Цагаач ажилтны эрхийн асуудал нь одоо цагт хүний эрхийн гол анхаарал татсан асуудал болоод байгаагийн дээр өнөөг хүртэл Монгол улсын Засгийн газар Дүрвэгсдийн асуудлаар нэгдсэн мэдээлэл, тоо баримт байхгүй, дүрвэн ирсэн болон гарсан иргэдийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй учир энэ талаар мэдээ баримтыг цэгцлэх, олон нийт, хүний эрхийн байгууллагуудад нээлттэй болгох шаардлагатай<sup>51</sup>.

### **Санал, зөвлөмж:**

1. Гадаадад ажиллаж амьдарч байгаа Монгол улсын иргэдийн асуудлаар судалгаа, мэдээллийн сан бүрдүүлж, энэ үндсэн дээр гадаадад буй Монгол иргэдтэй холбоотой асуудлаар төр засгийн оновчтой бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.
2. Монголчууд урт хугацаагаар гадаадад амьдрах болсноор тэдний үр хүүхдүүд тухайн орныхоо иргэн болох нь цөөнгүй байгаа болон Монгол улсын харьяатаас гарсан иргэдийн тоо нэмэгдэж байгааг анхааран давхар иргэншлийг хуульчилах боломжийг судлах, хэрэгжүүлэх. Давхар иргэншлийн асуудал нь хоёр чиглэлтэй юм. Эхнийх нь аль ч орны иргэн манай улсын иргэнээр давхар байж болох нөхцөл. Удаах нь зөвхөн Монгол Улсын иргэн өөр аль нэг орны иргэн давхар байж болно гэсэн чиглэл юм. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн монгол хүнд л хамаатай асуудал, ялангуяа гадаадад аж төрж, тухайн орныхоо иргэншлийг нэгэнт авчигдсан болон авах гэж буй монголчуудад хамаатай болно. Олон улсын туршлагаас үзэхэд ийм практик цөөнгүй бий. Тухайлбал, манай хойд хөрш ОХУ гэхэд 2002 оноос

<sup>51</sup> Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын мэдээлэл

зөвхөн ОХУ-ын иргэдийн хувьд иргэний давхар харьяалалтай байж болохыг хуульчилжээ<sup>52</sup>.

3. Гадаадад ажиллаж буй манай иргэдийн зарим эрх зөрчигдөж байгаа, хүчирхийлэл, элдэв дарамт шахалтад өртөх явдал нэлээдгүй байгааг харгалзан мөн гадаадаас монгол улсад ирж ажиллаж буй цагаач ажилчдын эрх ашгийг хамгаалах үүднээс “Цагаач ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай” НҮБ-ын конвенцид нэгдэж орох асуудлыг судлах
4. Ажиллах хүч гадаад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зуучлагч байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, зуучлах тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг шийдвэрлэхдээ үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, тэдний эрхийг хамгаалах, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлснийг нь харгалзан үзэх, гадаадад ажиллахыг хүсэгчдэд зориулсан сургалтын агуулга, чанарыг сайжруулах, хяналт тавих, гадаадад ажиллахтай холбогдсон мэдээллийг нийтэд хүртээмжтэй болгох, гадаадад ажиллагсдын эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг төрөөс дэмжих, хамтран ажиллах зэрэг асуудлыг тусгах
5. Гадаадад ажиллах хүч гаргахдаа аль болох гэр бүлээрээ явж ажиллах боломжийг олгох, эх орондоо эргэж ирээд мэргэшсэн чиглэлээрээ ажлын байр бий болгож ажиллах тухай гэрээ хийсэн хүмүүст давуу боломж олгох гэх мэт оновчтой хувилбаруудыг сонгох
6. Гадаад улсад ажиллаж амьдарч буй монгол улсын харъяат иргэн төрөөс иргэддээ олгож байгаа нийгмийн халамжийн тэр дундаа эх орны хишиг хувь хүртэх, хуулиар олгогдсон газар хувьчлах, сонгууль өгөх эрхийг баталгаажуулан хэрэгжүүлэх, энэ зорилгоор зохих хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах
7. Гадаадад хөдөлмөр эрхэлж буй монгол улсын харъяат иргэний дагаж очсон болон төрүүлсэн хүүхдүүд нь эцэг эхийнхээ тухайн улсын иргэний харьяаллын статусаас хамаарч сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, хүчирхийлэлд өртөх, гэмт хэрэгт өртөх, бэлгийн мөлжлөг, хүний наймааны хохирогч болох эрсдэл өндөр байгааг анхаарч хүүхдийн талаарх олон улсын гэрээ конвенцийн үзэл санаанд нийцүүлэн үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдний эрх ашгийг хамгаалах
8. Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн буюу консулын газар Монгол Улсын иргэн, харъяатынхаа хууль ёсны ашиг сонирхлыг чиг үүргийнхээ хүрээнд хамгаалах, бүртгэл мэдээллийнхээ агуулгыг баяжуулж, тогмолжуулах
9. Монгол ажилчид гадаадад ажиллах хугацаандаа эзэмшсэн мэргэжил, олсон дадлага, туршлагаа ашиглан эх орондоо аж ахуй эрхлэх, аж ахуйн нэгж байгуулахыг төрөөс дэмжиж, зээл, татвар, санхүүгийн таатай орчин бий болгох замаар тэднийг эх орондоо эргэж ирэх, үйлдвэрлэл эрхлэх сонирхолыг төрүүлэх, нэмэгдүүлэх бодлого боловсруулах
10. Гадаадад амьдарч байгаад ирж байгаа гэр бүлийг суурьшуулах, тогтвортой ажиллах эрх зүй, эдийн засаг, сэтгэл санааны орчинг бий болгох талаар төрөөс анхаарч, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах бололцоог бүрдүүлж өгөх

<sup>52</sup> Монголын шилжин суурьшигчдын эрхийн төлөв байдал. Судалгааны тайлан. УБ., 2009 он

талаар бодлого, төлөвлөгөө, үйлчилгээ шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

11. Дотоодод ажилгүйдэл их байгаа нөхцөлд гадаадаас ажиллах хүчин олноор оруулахдаа пүүс, компаний ашиг сонирхолд хөтлөгдөхгүй байх, гагцхүү шаардлагатай нөхцөлд гадаадаас тодорхой мэргэжил, мэргэшлийн ажиллах хүчин оруулахыг зөвшөөрч байх, өөрийн үндэсний мэргэжлийн ажиллах хүчин бэлтгэх ажлыг улам эрчимжүүлэхэд анхаарах
12. Гадаадын иргэдэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, гадаадын иргэдийн зөвшөөрөл, бүртгэл, хяналтын цахим сүлжээг төрийн зохих байгууллагууд, гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, хилийн боомтууд хооронд бий болгох шаардлагатай байна. Ингэснээр хууль журам сахиулах, зөрчигчидтэй хариуцлага тооцох ажил сайжирч, нөгөө талаар гадаадын иргэдэд учруулдаг хүнд суртал, чирэгдэл багасах юм.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН


## МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2010 ОНЫ I УЛИРЛЫН ТОЙМ

Ч. Онончимэг, Ц. Батдорж, Ц.Батбаяр, Г. Билгээ

## 1. Мөнгөний үзүүлэлтүүд:

“Монгол Улсын Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэл”-д хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг 8%-аас хэтрүүлэхгүй түвшинд байлгаж, цаашид тогтворжуулах бодлого баримтална гэж тусгасан бол 2010 он гарсаар эхний улирлын байдлаар инфляци өмнөх сарынхтай харьцуулахад 2.0 хувь, өмнөх оны жилийн эцсийнхээс 7.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1: Инфляцийн түвшин, жилийн эцэст, хувиар



2009 оны эцэст 4,2 хувьтай байсан хэрэглээний үнийн улсын индекс 2010 оны 3 сард 7,4 хувь, суурь инфляци 6,0 хувьтай болж өссөн нь хүнсний барааны бүлгийн үнэ 4,2 хувиар нэмэгдсэн ялангуяа махны үнэ өссөн, мөн иргэдэд эх орны хишиг сангаас 70 000 төгрөгийг тараасантай холбоотой гэж үзсэн байна.

Зураг 2: Зарим орны инфляцийн түвшин




2010 он гарсаар Төвбанкны бодлогын хүүнд өөрчлөлт ороогүй бөгөөд Монголбанк 2010 оны 4 сарын 21 нээс эхлэн 7 хоногтой ТБҮЦ -ны хэмжээг хязгаарлах, арилжааг хүүгээр өрсөлдүүлэх хэлбэрээр зохион байгуулахаар болсон байна. Мөн 7 хоногтой ТБҮЦ-ны арилжааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд банкуудын ирүүлэх саналын тоог нэмэгдүүлэх, заавал байлгах нөөцийн 50 хүртэл хувиараа ТБҮЦ худалдан авах боломжийг үнэт цаасны

арилжааны журамд тусгасан байна.

Дэлхийн зарим орнуудын Төвбанкны бодлогын хүүг сонирхоход Япон улсын бодлогын хүү хамгийн бага буюу 0,1%, Венесуэль улсад хамгийн их буюу 18,25%, манай 2 хөрш орон болох БНХАУ-д 5,31%, ОХУ-д 8,25%, АНУ, Канад, Швейцарь улсуудад тус бүр 0,25%-тай байна. 2010 оны 1 дүгээр улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлт 2974,5 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийхээс 26,4 хувиар буюу 621,9 тэрбум төгрөгөөр өссөн нь төгрөгийн харилцах өнгөрсөн оны мөн үеэс 67,0 хувиар, төгрөгийн хадгаламж 42,2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлтийг бүтэц талаас нь авч үзвэл мөнгөний нийлүүлэлтийн 46,2 хувийг төгрөгийн хадгаламж, 18,5 хувийг валютын хадгаламж, 13,4 хувийг төгрөгийн харилцах, 12,3 хувийг валютын харилцах, 9,9%-ийг банкнаас гадуурхи мөнгө эзэлж байна. Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийг 2009 оны эхний улирлын байдалтай харьцуулж үзвэл:


Зураг 3: Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц




2009 онд Банк санхүүгийн салбарт үүсээд байсан гол хүндрэл бол чанаргүй зээлийн асуудал байсан бөгөөд бодит эдийн засаг буурч, банкуудын зээлийн эрсдэл өссөнтэй холбоотойгоор банкууд зээл гаргахгүй, гадаад актив болон Төвбанкны үнэт цаас худалдан авах болсон.

Аж ахуйн нэгж иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2007 онд 68,0 хувиар, 2008 онд 28,7 хувиар тус тус өсч байсан бол 2009 онд 0,7 хувийн өсөлттэй буюу бараг зээл олгоогүй гэсэн үзүүлэлт гарч байсан, 2010 оны эхний улиралд зээл олголт өнгөрсөн оны мөн үеэс 1,9 хувиар өссөн байна. 2009 оны гүйцэтгэлээр чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 22,0 хувийг эзэлж байсан.

Тэгвэл он гарсаар эхний 3 сарын байдлаар чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 20,7 хувь болж бага зэрэг буурсан хэдий ч банк санхүүгийн систем хүндрэлтэй хэвээр байгааг харуулж байна. Чанаргүй зээл дангаараа нийт зээлийн өрийн үлдэгдлийн 15,3 хувийг эзэлж байна.



Манай улсын гадаад валютын цэвэр албан нөөц 2009 оны 10 сараас хойш харьцангуй тогтвортой байж, 2010 оны эхний улиралд 1107,4 сая ам.доллар болж, манай улсын импортын 24,7 долоо хоног буюу 6,2 сарын хэрэгцээг хангахаар байна. ОУВСангийн 2010 оны 2-р сарын мэдээллээс харахад Япон, Орос, Солонгос, Энэтхэг зэрэг дараахь орнууд гадаад валютын хамгийн их нөөцтэй байна.



Эх сурвалж:

<http://www.imf.org/external/np/sta/ir/8802.pdf>

## 2. Төсвийн үзүүлэлтүүд:

2010 оны эхний улирлын байдлаар улсын нэгдсэн төсөв 109.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч төсвийн нийт орлогын үзүүлэлтүүд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад өсөлттэй гарч урсгал тэнцэл 27.1 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Төсвийн алдагдал сайжирч байгаа нь засгийн газрын орлого, зарлагын тогтвортой байдлыг тууштай хадгалж тодорхой арга хэмжээ авсны үр дүн. Нийт орлого ба зарлагийн дүн өмнөх оны мөн үеийнхээс багагүй өссөн байгаа нь дэлхийн зах зээл дээрх зэс, алтны үнэ өсөж гадаад худалдааны эргэлт сайжирч байгаа боловч инфляци өсөх хандлагатай байна.

Хүснэгт №1:

- Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /2009 - 2010 оны эхний улиралын байдлаар, сая төгрөг өссөн дүнгээр/



Орлого, зарлагын төрөл	2009 оны 01-03 сар			2010 оны 01-03 сар		
	Улсын нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Улсын нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв
Төсвийн орлого:						
Нийт орлого, тусламжийн дүн	333 926.8	242 165.0	56 920.7	554 837.4	442 179.8	65 548.2
Нийт орлого	333 926.8	216 885.2	51 292.2	540 290.8	397 650.8	59 161.3
Урсгал орлого	333 465.1	216 885.2	50 830.5	539 663.3	397650.8	58 533.8
Татварын орлого	277 220.	166 239.7	45 230.8	480 284.2	341664.8	55 140.7
Татварын бус орлого	56 245.2	50 645.5	5 599.7	59 379.1	55986.0	3 393.1
Хөрөнгийн орлого	461.7	-	461.7	627.5	-	627.5
Тусламжийн орлого	-	25 279.8	5 628.5	14 546.6	44 529.0	6 387.0
Төсвийн зарлага:						
Нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл	440 852.5	375 872.9	44 044.4	664 038.9	500 218.8	54 310.5
Нийт зарлага	433 950.9	368 971.3	44 044.4	553 912.2	390 092.1	54 310.5
Урсгал зардал	406 231.2	344 994.9	43 370.2	512 556.8	351 299.9	51 795.7
Хөрөнгийн зардал	27 719.6	23 976.4	674.2	41 355.3	38 792.2	2 514.8
Эргэж төлөгдөх цэвэр зээл	6 901.6	6 901.6	-	110 126.7	110 126.7	-
Тэнцэл	-106.9	-133.7	12.8	-109.2	-58.0	11.2

### Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн

2010 оны эхний улирлын байдлаар 554.8 тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 664.0 тэрбум төгрөг болж, нийт тэнцэл 109.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Төсвийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 2.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн алдагдал харьцангуй тогтворжиж байгаагийн шинж бөгөөд нийт орлого 206.3 тэрбум төгрөгөөр, нийт зарлага 120 тэрбум төгрөгөөр өсчээ.

### Төсвийн урсгал тэнцэл

539 663.3 тэрбум төг, урсгал зардал 512 556.8 тэрбум төгрөг болж, урсгал тэнцэл 27.1 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. **Татварын нийт орлого** Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 203.1 тэрбум төгрөг буюу 73.3 хувиар өсөхөд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 69.6 тэрбум төгрөг буюу 13.5 дахин, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 41.0 тэрбум төг буюу 68.6 хувь, аж ахуйн нэгжийн орлогын албан татварынх 39.8 тэрбум төгрөг буюу 97.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

### Татварын бус орлого

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 3.1 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар өсөхөд төсөвт газрын өөрийн орлого 13.2 тэрбум төгрөг буюу 73.0 хувь, навигацийн орлого 4.5 тэрбум төгрөг буюу 2.0 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ**

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2010 оны эхний улиралд 664.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 223.2 тэрбум төгрөг буюу 50.6 хувиар өсөхөд татаас, шилжүүлэг 82.6 тэрбум төгрөг буюу 46.1 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

**Хөрөнгийн зардалд**


Хөрөнгийн зардалд 2010 оны эхний улиралд 41.4 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 13.6 тэрбум төгрөг буюу 49.2 хувиар өссөн байна. Хөрөнгийн зардлын өсөлтөд дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 17.1 тэрбум төгрөг буюу 72.5 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ<sup>53</sup>.

**2. Макро эдийн засгийн салбарын зарим үзүүлэлтүүд:****• Дотоодын үйлдвэрлэл:**

Манай улсын аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2010 оны эхний улиралд (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 394.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 46.4 тэрбум буюу 13.4 хувиар өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхай, олборлох аж үйлдвэр нийт үйлдвэрлэлийн 67.0 хувийг боловсруулах аж үйлдвэр 20.2 хувийг, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж 12.8 хувийг тус тус эзлэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад уул уурхай, олборлох аж үйлдвэр 10.8 хувиар өссөн бол боловсруулах аж үйлдвэрийн салбар 5.0 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж 5.8 хувиар тус тус буурсан байна.

Зураг 6:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал /сараар, сая төгрөгөөр/




Зураг 6 -аас үзэхэд уул уурхай, олборлох салбарын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2010 оны 3-р сард 220071.1 сая төгрөг болж өмнөх сараас 151226.7 сая. төгрөгөөр өссөн бөгөөд энэхүү өсөлтөнд газрын тос шатдаг хий олборлолтын үйлдвэрлэл 42229.3 сая төгрөгөөр эрс өссөн байна. Харин боловсруулах аж үйлдвэрийн хувьд 2010 оны 3-р сард нийт үйлдвэрлэл 53128.6 сая төгрөг болж 2010 оны 2-р сараас 19193.3 сая төгрөгөөр өссөн байна. Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн энэхүү өсөлтөд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл /ундаа, согтууруулах ундаа үйлдвэрлэл/ 20620.3 сая төгрөгөөр эрс өссөн нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

<sup>53</sup> www.nso.mn

- Гадаад худалдаа:

Манай улс 2010 оны I улирлын байдлаар нийт 103 оронтой худалдаа хийж, нийт гадаад худалдааны бараа эргэлт 1076.2 сая ам доллар болж өмнөх оны мөн үеэс 360.0 сая ам доллар буюу 50.3 хувиар, харин 2008 оны мөн үеэс 266.7 сая ам доллар буюу 32.9 хувиар тус тус өссөн байна. /Зураг 2/ Харин нийт бараа эргэлтийг улсаар нь авч үзвэл БНХАУ 52.9 хувь, ОХУ 22.2 хувь, бусад улс орон 24.9 хувь болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад БНХАУ-тай хийсэн бараа эргэлтийн хувийн жин 20.9 пунктээр, ОХУ-тай хийсэн бараа эргэлтийн жин 5.9 пунктээр нэмэгдэж, харин бусад улстай хийсэн бараа эргэлтийн хувийн жин 26.8 пунктээр буурсан байна.<sup>54</sup>

Зураг 7: Гадаад худалдааны нийт бараа эргэлт /сая.ам доллараар/




Эх сурвалж: ҮСХороо, 2010 оны 3 сарын бюллетень

Экспорт: Манай улсын 2010 оны нэгдүгээр улиралын экспортын хэмжээ 499.0 сая ам долларт хүрч өмнөх оны мөн үеэс 176.7 сая ам.доллар буюу 54.8 хувиар, 2008 оны мөн үеэс 65.6 сая ам.доллар буюу 13.1 хувиар тус тус өссөн байна. 2010 оны эхний улиралд экспортын үнийн дүнгийн 92.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас чулуу, үнэт металл, гоелын зүйлс, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн эзлэж байна.


<sup>54</sup> “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал” танилцуулга 2010/3 ЫСХороо

Зураг 8: Экспорт /сая.ам доллараар/



Импорт: Нийт бараа эргэлт дэх импортын хэмжээ 2010 оны эхний улиралд 577.2 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 183.3 сая ам.доллар буюу 46.6 %-аар, 2008 оны мөн үетэй харьцуулахад 201.1 сая ам.доллар буюу 53.4 %-аар тус тус өссөн байна. Нийт импортын 24.5%-ийг эрдэс бүтээгдэхүүн, 21.0 %-ийг машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн анги, сэлбэг, 19.7 %-ийг авто, агаар, усан замын тээврийн хэрэгсэл голлон эзлэж байна.

Зураг 9: Импорт /сая.ам доллараар/




- Хөдөө аж ахуй:**

Манай улсын эдийн засгийн томоохон салбарын нэг болох хөдөө аж ахуй нь цаг уурын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн хүчтэй нөлөөнд оршдог. 2009 оны жилийн эцэст нийт 44 сая толгой мал тоологдсон нь малын тоо өмнөх оноос 1.7 хувиар өссөн таатай үзүүлэлттэй байсан.

Зураг 10:

- Зүй бусаар хорогдсон малын тоо болон төллөсөн хээлтэгч малын тоо /мян.толгой/



Эх сурвалж: ҮСХороо, 2010 оны 3 сарын бюллетень

Гэвч зүй бусаар хорогдсон малын тоо оны эхэнд тоологдсон нийт малын 14.3 хувь буюу 6310.8 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5712.9 мянган толгой буюу 10.6 дахин өссөн нь өвөлжилт ихээхэн хүндэрч хөдөө аж ахуйн салбарт таагүй байдлын бий болгоод байна.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2010 ОНЫ III УЛИРЛЫН ТОЙМ СУДАЛГАА

Ч. Онончимэг, Ц. Батдорж, Ц.Батбаяр, Г. Билгээ


### 1. УЛСЫН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### Улсын нэгдсэн төсөв

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2010 оны III улирлын гүйцэтгэл төсвийн нийт орлогын бүрдүүлэлт 113.9 хувийн, нийт зарлага 81.2 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт алдагдал төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 730.9 тэрбум төгрөгөөр бага байна.


Зураг 1.

- Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл 2008 - 2010 оны эхний 9 сараар, тэрбум төг.



2010 оны эхний 9 сарын байдлаар улсын нэгдсэн төсвийн алдагдал 19.7 тэрбум төгрөг гарсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад алдагдалын хэмжээ 312.8 тэрбум төгрөг буюу 16.9 дахин буурсан байна.

Урсгал тэнцлийн хувьд 495.2 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.0 хувиар өсчээ. 2009 болон 2010 оны эхний 9 сард улсын нэгдсэн төсвийн тэнцэл тус тус алдагдалтай гарч байгаа. Харин энэ оны 5-р сараас хойших алдагдалын хэмжээ тогтмол өсөж байна. Ийнхүү төсвийн тэнцэл эрс сайжирч байгаа нь уул уурхайн орлоготой холбоотой хэмээн Дэлхийн банкны судалгаанд өгүүлсэн байна.

**Зураг 2.** Улсын нэгдсэн төсвийн тэнцэл, 2009, 2010 оны эхний 9 сар, тэрбум төг.

### Нэгдсэн төсвийн орлого

2010 оны III улирлын байдлаар улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн гүйцэтгэл 2 058.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 727.2 тэрбум төгрөгөөр буюу 54.6 хувиар өссөн байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого татварын орлогоор 87.7 хувь, татварын татварын бус орлогоор 10.4 хувь, тусламжийн орлогоор 1.7 хувь, хөрөнгийн орлогоор 0.2 хувь тус тус бүрдсэн үзүүлэлттэй байна.

АНУ-ын санхүү, эдийн засгийн хямралтай байгаа орнуудад үзүүлж буй тусламжийн хүрээнд манай улсад 14.5 тэрбум төгрөгийн мөнгөн тусламжийг нийгмийн халамжийн санхүүжилтэд зориулан олгосон зэрэг нь нэгдсэн төсвийн орлого төлөвлөгөөнөөс давж биелэхэд нөлөөлсөн байна.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 734.3 тэрбум төгрөг буюу 68.6 хувиар нэмэгдэхэд зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 179.8 тэрбум төгрөг буюу 3.0 дахин, аж ахуйн нэгжийн орлогын албан татварынх 131.7 тэрбум төгрөг буюу 2.1 дахин, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 153.8 тэрбум төгрөг буюу 65.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 31.1 тэрбум төгрөг буюу 12.7 хувиар буурахад газрын тосны орлого 22.4 тэрбум төгрөг буюу 3.6 дахин, бусад нэр заагдаагүй орлого 18.8 тэрбум төгрөг буюу 2.7 дахин өссөн хэдий ч хувьцааны ногдол ашгийн орлого 80.3 тэрбум төгрөг буюу 88.2 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

### Нэгдсэн төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2010 оны эхний 9 сард 2,557.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 2078.2 тэрбум төг болж 81.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 414.3 тэрбум төг буюу 24.9 хувиар нэмэгдсэн байна.

Нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ өссөн нь татаас, шилжүүлэг 169.7 тэрбум төг буюу 30.6 хувь, бараа, үйлчилгээний бусад зардал 61.8 тэрбум төг буюу 23.6 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Хөрөнгийн зардалд 2010 оны эхний 9 сард 331.8 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 67.5 тэрбум төг буюу 25.5 хувиар нэмэгджээ. Энэ нь гадаад



эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 5.1 тэрбум төг буюу 37.2 хувиар буурсанч дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 72.6 тэрбум төг буюу 29.0 хувиар өссөнөөс шалтгаалжээ. Төсвийн орлого нэмэгдсэн хэдий боловч зардал дагаад өслөө хүн бүрт энэ оны 2-р улиралд 70000 төгрөг олгосон бөгөөд 8 сараас хүн бүрт сар бүр 10000 төгрөг тарааж эхлээд байгаа бөгөөд 10-р сарын 1-нээс төрийн албан хаагчийн цалин ба тэтгэвэр, тэтгэмжийг 30 хувиар нэмэгдүүлж байгаа нь зардлыг өсгөсөөр байна. Үүний зэрэгцээ, засгийн газраас УИХ-д өргөн барьсан төсвийн зардлыг нэлээдгүй нэмэгдүүлэх 2010 оны нэгдсэн төсөвт оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг 7 сард УИХ баталсан. Мөн зардлын өсөлтийг эдийн засгийн өсөлтөөс хэтрэхгүй байлгахын тулд зээлийн хэмжээнд хязгаар тавьсан байна<sup>55</sup> (ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй).

## 2. МӨНГӨНИЙ БОДЛОГО

### Инфляци


Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах Үндсэн чиглэлд “Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийг найман хувиас хэтрүүлэхгүй байлгаж, цаашид тогтворжуулах, эдийн засгийн мөчлөгийн сөрөг нөлөөг бууруулах, эдийн засгийн өсөлтийг сэргээх бодлого баримтлана” гэжээ.

Огноо	Сарын	Оны эхнээс	Жилийн
2010/9 сар	-0.7	8.3	10.6
2010/8 сар	0.7	9.0	11.2
2010/7 сар	-2.8	8.3	9.8
2010/6 сар	-1.5	11.4	11.4
2010/5 сар	3.2	13.1	11.6
2010/4 сар	2.1	9.7	8.3
2010/3 сар	1.9	7.4	8.5
2010/2 сар	3.0	5.4	8.3
2010/1 сар	2.3	2.3	5.

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮҮИ) 2010 оны 9 дүгээр сард өмнөх сарынхтай харьцуулахад 0.7 хувиар буурч, өмнөх оны жилийн эцсийнхээс 8.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 10.6 хувиар тус тус өссөн байна. Ерөнхий индекс өмнөх сарынхаас буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дүн 2.1 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Харин 8 дугаар сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сарынхаас /7 сар/ 0.7 хувь өмнөх оны мөн үеийнхээс 11.2 хувиар өсчээ. Дэлхийн хөгжингүй орнуудын инфляцийн түвшинг авч үзвэл АНУ 1.10%, Европ 1.60%, Хятад 3.60%, ОХУ 7.00% зэрэг байна.

Дэлхийн улс орнуудын инфляцийн түвшинг динамикаар харуулбал:


<sup>55</sup> Mongolia Quarterly Economic Update, World Bank, Oct 2010.

**Зураг 3.** Дэлхийн зарим улс орнуудын инфляцийн түвшин

### Бодлогын хүү

2010 оны өвлийн зуд, мөн оны 4 дүгээр сараас иргэн бүрт Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө олгож эхэлсэнтэй холбоотойгоор нийлүүлэлтийн болон эрэлтийн гаралтай инфляци өдөөгдөж суурь инфляцид нөлөөлж эхэлснээр Монголбанк 5 дугаар сард бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн 11 хувьд хүргээд байна. Дэлхийн зарим улс орнуудын бодлогын хүүг авч үзвэл, Австрали улс 2010 оны 5 дугаар сарын 04-ны өдөр 4.25% байсан бодлогын хүүгээр 4.50% болгосон байна. Харин АНУ-ын хувьд 2008 оны 12 сараас хойш бодлогын хүүдээ өөрчлөлт оруулаагүй 0.25% /өмнө нь 1% байсан/ хэвээр байна.

Дэлхийн зарим улс орны төв банкны бодлогын хүүг динамикаар харвал:



### Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт 2010 оны 08 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 42.6% буюу 1093.4 тэрбум төгрөг, өмнөх сарынхаас 3.2% буюу 114.3 тэрбум төгрөгөөр өсч 3657.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн хурд өнгөрсөн оны мөн үеийнхээс 43.1 нэгж хувь, өмнөх сарынхаас 1.5 нэгж хувиар өсчээ. Хадгаламж зээлийн хоршоо дахь хадгаламж нь банкуудын хадгаламжийн 1.4 хувийг эзэлж байв. Харин гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө өмнө оны мөн үеэс 21.7 хувь буюу 83.4 тэрбум төгрөг, өмнөх сарынхаас 3.4 хувь буюу 15.2 тэрбум төгрөгөөр өсч 467.5 тэрбум төгрөгт хүрчээ.

Бараг мөнгө нь 2010 оны 08 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 36.8% буюу 758.5 тэрбум төгрөг, өмнөх сараас 0.3 хувь буюу 8.9 тэрбум төгрөгөөр өсч 2725.4 тэрбум төгрөгт хүрэв. Нийт хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 34.6 хувь буюу 556.3 тэрбум төгрөг,

өмнөх сараас 0.5 хувь буюу 10.5 тэрбум төгрөгөөр өсч 2164.6 тэрбум төгрөгт хүрсэн.


Найман сарын байдлаар иргэдийн хадгаламж 1.2 хувь буюу 17.0 тэрбум, аж ахуй нэгж, байгууллагын хадгаламж 8.8 хувь буюу 8.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Гадаад валютын хадгаламж 2.4 хувь буюу 15.3 тэрбум төгрөгөөр буурчээ. Нийт хадгаламжийн 71.8 хувь нь төгрөгийнх, 28.2 хувь нь валютын хадгаламж байна.

Бага мөнгө өмнөх оны мөн үеэс 56.1 хувь буюу 334.9 тэрбум төгрөг, өмнөх сараас 12.7 хувь буюу 105.4 тэрбум төгрөгөөр өсч 932 тэрбум төгрөгт хүрсэн байна. Төгрөгийн харилцах өмнөх оны мөн үеэс 94.6 хувь буюу 280.8 тэрбум төгрөг, өмнөх сараас 19.8 хувь буюу 95.3 тэрбум төгрөгөөр буурч 577.5 тэрбум төгрөг болжээ.

### Гадаад валютын цэвэр албан нөөц

Гадаад валютын цэвэр албан нөөц өмнөх оны мөн үеэс 70.7 хувь буюу 585.3 сая ам.доллар, өмнөх сараас 10.4 хувь буюу 133.6 сая ам.доллараар өсч 1412.9 сая ам.долларт хүрчээ. Энэ нь импортын 25 долоо хоног буюу 6.2 сарын төлбөртэй тэнцэхүйц байна


Зураг 6. Монгол улсын гадаад валютын цэвэр албан нөөц



### 3. ГАДААД ХУДАЛДАА


#### Нийт бараа эргэлт

Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийг улсаар нь авч үзвэл 2010 оны эхний 9 сарын байдлаар дэлхийн 122 оронтой худалдаа хийснээс 55.9 хувь нь БНХАУ-д, 19.3 хувь нь ОХУ-д үлдсэн 24.8 хувь нь бусад улсуудад ногдож байна. Харин нийт бараа эргэлт 2010 оны эхний 9 сарын байдлаар 4273.9 сая ам.доллар болж энэ нь өмнөх оны мөн үеэс 1495.8 сая ам.долл буюу 53.8 хувиар өссөн бол 2010 оны IX сард 515.1 сая ам.доллар болж, VIII сарынхаас 36.0 сая ам.долл буюу 6.5 хувиар буурч өмнөх оны мөн үеийнхээс 88.9 сая ам.долл буюу 20.8 хувиар өссөн байна.


**Зураг 1.** Гадаад худалдааны нийт бараа эргэлт, 2009 - 2010 оны I - IX сар, сая ам.долл

### Экспорт

Манай улс 2010 оны эхний 9 сарын байдлаар 61 оронд экспорт хийснээс 84.7 хувийг БНХАУ-тай, 5.3 хувийг Канад улстай, 5.4 хувийг Их Британи болон ОХУ-тай үлдсэн 4.6 хувийг БНСУ, Итали зэрэг бусад улс оронтой хийжээ. 2010 оны эхний 9 сарын байдлаар нийт экспортын хэмжээ 2025.6 сая ам.долл болж өмнөх оны мөн үеийнхээс 731.8 сая ам.долл буюу 56.6 хувиар өсч харин 2010 оны IX сард экспортын хэмжээ 232.0 сая ам.долл болж VIII сарынхаас 23.1 сая ам.доллараар буурсан байна. Энэхүү бууралтанд үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийнх 109.1 сая ам.долл, ургамлын гаралтай бүтээгдэхүүнийх 3.5 сая ам.долл, хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийх 0.2 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ.

**Зураг 7.** Гадаад худалдааны экспортын хэмжээ, 2009 - 2010 оны I - IX сар, сая ам.долл

Нийт экспортын 78.4 хувийг эрдэс бүтээгдэхүүн, 7.2 хувийг үнэт ба хагас үнэт чулуу, металл, гоёлын зүйлс, 8.4 хувийг нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, 6.0 хувийг бусад бараа бүтээгдэхүүн эзлэж байна. Манай улс 2010 оны эхний 9 сард нийт 117 оронтой худалдаа хийж импортын худалдааны 34.3 хувийг ОХУ, 30.0 хувийг БНХАУ, 5.8 хувийг БНСУ, 11.0 хувийг АНУ болон Япон улс, 2.6 хувийг ХБНГУ, 6.3 хувийг Франц, Сингапур болон бусад улс оронтой хийсэн байна.

**Импорт****Зураг 8.** Гадаад худалдааны импортын хэмжээ, 2008 - 2010 оны I - IX сар, сая ам. долл

2010 оны эхний 9 сарын байдлаар импортын хэмжээ 2248.3 сая ам.доллар болж энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 764.0 сая ам.доллар буюу 51.5 хувиар өсчээ. Харин 2010 оны IX сарын хувьд импортын хэмжээ 283.1 сая ам. доллар болж энэ нь VIII сарынхаас 12.9 сая ам.доллараар буурсан байна. Энэ бууралтанд ургамлын гаралтай бүтээгдэхүүний хэмжээ 5.5 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Импортын хэмжээг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад суудлын автомашин 49.7 сая ам.долл, автобензиний импортын хэмжээ 5.5 сая ам.доллараар өсч харин гурилын импортын хэмжээ 9.2 сая ам.долл, цагаан будааны импортын хэмжээ 0.1 сая ам.доллараар буурсан байна.

**Гадаад худалдааны тэнцэл**

Гадаад худалдааны тэнцэл 2010 оны эхний 9 сарын байдлаар 222.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 32.1 сая ам.долл буюу 16.9 хувиар өссөн дүн гарсан байна. Харин 2009 оны IX сард гадаад худалдааны тэнцэл 4.1 сая ам.доллар байсан бол 2010 оны IX сарын байдлаар 51.0 сая ам.долларын алдагдалтай гарч өмнөх оны мөн үеийнхээс 46.9 сая ам.долл буюу 12.4 дахин өссөн байна.

**4. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ****Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2010 оны эхний 9 сард /2005 оны зэрэгцүүлэх үнээр/ 1341.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 175.2 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеийнхээс 175.2 тэрбум төгрөг буюу 15.0 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөнд дараахь дэд салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

- Нүүрс олборлолт 88.3 хувь;
- Газрын тос, шатдаг хий олборлолт 41.1 хувь;
- Бусад ашигт малтмал олборлолт 23.0 хувь;
- Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 43.5 хувь;

- Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл 43.5 хувь;
- Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт 34.7 хувь;
- Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 33.4 хувь;
- Төмрийн үйлдвэрлэл 28.3 хувь;

Харин аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2010 оны IX сард 357.4 тэрбум төгрөг болж өмнөх VIII сарынхаас 4.6 тэрбум төг буюу 1.3 хувиар буурч, өмнөх оны IX сарынхаас 72.3 тэрбум төг буюу 25.3 хувиар өссөн байна.

### **Хөдөө аж ахуй**

Манай улсын эдийн засгийн томоохон салбарын нэг болох хөдөө аж ахуй нь цаг уурын өөрчлөлт болон хүний хүчин зүйлийн хүчтэй нөлөөнд оршдог. 2009 - 2010 оны эхэн үеийн өвлийн зудны улмаас маш олон тооны мал хорогдсон нь хөдөө аж ахуйн салбарт хамгийн муу үзүүлэлттэй байсан.

2010 оны эхэнд нийт 44 сая толгой мал тоологдсон нь малын тоо өмнөх оноос 1.7 хувиар өссөн таатай үзүүлэлттэй байсан хэдий ч 2010 оны эхний 9 сард 116.0 мян.мал өвчнөөр хорогдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 29.3 мян буюу 33.7 хувиар нэмэгдсэн байна. Хөдөө аж ахуй салбарын газар тариалангийн хувьд 2010 оны 10 дугаар сарын байдлаар

- 183.3 мян.га-аас 248.7 мян.т үр тариа,
- 11.7 мян.га-аас 127.5 мян.т төмс,

5.9 мян.га-гаас 66.9 мян.т хүнсний ногоо хурааж 987.7 мян.т өвс хадлан, 20.9 мян. т гар тэжээл, 0.3 мян.т дарш бэлтгээд байна.

### **Дотоодын нийт бүтээгдэхүүн**

Монгол Улсын ДНБ /2005 оны зэрэгцүүлэх үнээр/ 2010 оны эхний 3 улиралд нийт 2646.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 156.6 тэрбум төгрөг буюу 6.3 хувиар өссөн байна. Энэ өсөлтөнд аж үйлдвэр, барилгын салбарын үйлдвэрлэл болон үйлчилгээний салбар, бүтээгдэхүүний татварын хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг нь өмнөх оны мөн үеийнхээс 12.3 хувиар, үйлчилгээний салбарынх 9.0 хувь, бүтээгдэхүүний татварын хэмжээ 56.2 хувиар тус тус өссөн бол хөдөө аж ахуйн нэмэгдэл өртөг өмнөх оны мөн үеийнхээс 26.5 хувиар буурсан байна.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН 2011 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ,  
ТҮҮНИЙ МАКРО ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**  
(БОДЛОГЫН СУДАЛГАА - ДҮН ШИНЖИЛГЭЭ)

*Ц. Норовдондог (Ph.D), Ц. Элбэгзаяа, Ц. Батдорж, Г. Билгээ,  
Ц. Болормаа, Г. Гэрэл, Д. Мягмарцэрэн, Ч. Онончимээ*

**Сэдвийн агуулга**

Оршил

Судалгааны дүгнэлт

**Нэг.** Монгол Улсын нэгдсэн төсөв

- Төсвийн тогтворжуулалтын сан

**Хоёр.** Төсвийн орлогын шинжилгээ

- Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн орлого
  - а) Урсгал орлого
  - б) Орлогын албан татварын орлого
  - в) НӨАТ
  - г) Гаалийн албан татвар
  - д) Бусад татвар

**Гурав.** Төсвийн зарлагын шинжилгээ

- 3.1 Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн зарлагад хийсэн шинжилгээ
- 3.2 Урсгал зардал
- 3.3 Хөрөнгийн зардал ба цэвэр зээл
- 3.4 Урсгал зардлын шинжилгээ
- 3.5 Бараа, үйлчилгээний зардал
- 3.6 Бараа, үйлчилгээний бусад зардал
- 3.7 Татаас ба урсгал шилжүүлэг
- 3.8. Хөрөнгийн зардлын шинжилгээ
- 3.9. Орон нутгийн төсвийн зарлагын шинжилгээ

**Дөрөв.** Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

**Тав.** Монгол Улсын 2011 оны төсөв макро эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл

- 5.1. Эдийн засгийн бодит өсөлт
- 5.2. Эдийн засгийн өсөлтийн тооцоолол
- 5.3. Эдийн засгийн өсөлт ба Инфляци
- 5.4 Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдэл

**УИХ.МН**  
**СУДАЛГААНЫ САН**

\*\*\*

**Оршил**

Энэхүү судалгаагаар 2000-2010 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн ерөнхий танилцуулга, макро эдийн засгийн өсөлт, бууралт, инфляци болон ажилгүйдэл ямар түвшинд ирсэнийг тооцохын зэрэгцээ 2011 оны Нэгдсэн төсөв үүнд хэрхэн нөлөөлж болзошгүй талаархи таамаглалыг дэвшүүлсэн болно.



Монгол Улсын эдийн засагт 2009-2010 онд томоохон өөрчлөлтүүд гарсан жил байсан бөгөөд эдийн засгийн хүрээний томоохон хууль, эрх зүйн актуудыг УИХ-аас батласан. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хүний хөгжлийн сангийн тухай хуулиудыг шинээр баталсаны зэрэгцээ Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулан, цаашид Таван толгойн ордыг ашиглах гэрээний үндсийг тавьсан болно.

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэн эдийн засгийн өсөлтийн хувийг тооцохдоо 2000-2010 оны статистик тоон мэдээлэл, 2011 онд батлагдсан Монгол Улсын төсөв болон бусад судалгааны тайлан мэдээллийг ашиглан, 2011 оны батлагдсан төсөв нь Монгол улсын макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлөхийг эконометрикийн коинтегрэвшн болон регрессийн шинжилгээний аргаар судалсан болно.

### Судалгааны дүгнэлт

1930-аад оны их хямралтай холбоотойгоор макро эдийн засаг нь эдийн засгийн сэтгэлгээний бие даасан чиглэл болон бүрэлдэн тогтжээ. Учир нь энэ үед үнийн хөшүүргийн тусламжтайгаар чөлөөт зах зээл өөрөө аяндаа зохицуулагдана гэдэг эдийн засгийн сонгодог загвар нь тухайн үеийн эдийн засагт бий болсон нөхцөл байдлыг тайлбарлах боломжгүй ба хямралаас гарах үр ашигтай арга хэмжээ болж чадахгүй болсон юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэл өөрөө хэрэглээг бий болгодог учир төрийн зүгээс ямар нэг оролцоо шаардлагагүйгээр эдийн засгийн өсөлт хангагдана гэсэн онол бодит байдал дээр нуран унасан.

Харин Английн эдийн засагч Кейнс **“Мөнгө ба зээлийн хүү ажил эрхлэлтийн ерөнхий онол”** бүтээлээрээ хямралаас гарахад буюу эдийн засгийн хэвийн хөгжлийг хангахад төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай болохыг тодорхойлжээ. Түүний онолын гол үндэслэл нь:

- Улсын зардлыг өргөжүүлэн нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийн уналтыг бууруулж үйлдвэрлэлийн бодит хэмжээг нэмэгдүүлэх
- Нийт зардлын өсөлт нь нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийг өсгөж эдийн засгийн эрүүлжүүлнэ гэж үзжээ.

Судалгааны явцад манай улсын макро эдийн засгийн бодлогод Кейнсизм хүчтэй илэрч байгаа боловч сонгодог эх загвараасаа зарим талаар гажсан болох нь харагдаж байна. Тухайлбал, төсвийн зарлагын өсөлтөөс харахад, улсын зардлыг нэмэгдүүлснээр нийт эрэлтийг нэмэгдүүлэх ба энэ нь нийлүүлэлт буюу үйлдвэрлэлийг өсгөж эдийн засгийн эрүүлжүүлнэ гэсэн бодлогыг барьж байна гэж үзэж болох юм.

Тэгвэл төсвийн орлогын бүрдүүлэлтийг харахад, Кейнсизмийн өөр нэг гол шинж болох татварыг бууруулах замаар үйлдвэрлэлийн уналтыг бууруулж үйлдвэрлэлийн бодит хэмжээг нэмэгдүүлэх гэсэнтэй шууд зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, татвараар боомилуулсан үйлдвэрлэлийн салбар нь эрэлтийг хангах бүтээгдэхүүн бий болгох чадваргүй гэдэг нь мэдээжийн хэрэг юм.

Ийнхүү хоорондоо зөрчилдсөн бодлого нь эдийн засгийн хөгжлийн гол саад тогтвор тул ямар нэг эдийн засгийн онолыг баримталж байгаа эсэх нь үл мэдэгдэх тодорхойгүй байдлаас илүү аюултай юм. Товчхондоо, ямар онол баримтлах нь хамаагүй, ядаж бодлого нь зөрчилдөхгүй байх ёстой юм. Гэхдээ макро эдийн засгийн ямар онолыг баримталснаас үл хамааран дараах гол гурван асуудлыг шийдвэрлэх ёстой юм. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлтийг эдийн засгийн ямар хүчин зүйлс хангаж байна вэ? Эдгээр нь удаан хугацаанд тогтвортой байж чадах уу?

2. Ажилгүйдлыг хэрхэн тайлбарлах вэ? Эдийн засгийн мөчлөгийн өсөлт ба бууралтын үе шат болгонд ажилгүйдлын өндөр түвшин буурахгүй тохиолдолд хэрхэх вэ?
3. Инфляцийг хэрхэн тайлбарлах вэ? Инфляцийн түвшинг хэрхэн бууруулах вэ? Бага түвшинд хэрхэн тогтоон барих вэ?

Эдгээр асуудлуудыг хэрхэн зүй зохистой шийдвэрлэснээс хамаарч тухайн улсын эдийн засгийн хөгжлийг тодорхойлдог. Энэхүү судалгаагаар манай улсын макро эдийн засгийн бодлого, хөгжлийг тодорхойлогч гол хүчин зүйл болох улсын Нэгдсэн төсвийн орлого зарлага нь макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлөхийг судласан.

Судалгааны үр дүнгээс үзэхэд төсвийн орлого зарлага макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдэд шууд нөлөөлдөггүй мэт харагдаж байна. Гэвч энэ нь хуурмаг харагдах байдал бөгөөд учир нь макро эдийн засгийн судалгааны гол аргуудаар бодитой үр дүн гарахгүй байгаатай холбоотой юм. Макро эдийн засгийн судалгааны ирээдүйн үр дүнг таамаглах аргуудын гол зарчим нь “өнгөрсөн цагт энэ үзүүлэлт ингэж өөрчлөгдөхөд ийм үзүүлэлт гарч байсан тул цаашид мөн ийм үр дүн үзүүлэх боломжтой” гэсэн таамаглал гаргадаг.

Тэгвэл манай улсын хувьд эдийн засгийн тогтолцооны онцлогоос хамаарч дээрх байдлаар таамаглал гаргахад тэр бүр бодитой байж чадахааргүй байна. Тиймээс төсвийн орлого зарлага макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөөлж болохыг ерөнхий байдлаар тайлбарлая. Үүнийг дэлгэрүүлэн тооцооллын хэсгээс үзэх боломжтой.

Одоогийн байдлаар, манай улсын төсөвт уул уурхайгаас их хэмжээний мөнгө төвлөрөөд байна. Энэ нь нийт төсвийн үндсэн хэсгийг бүрдүүлж байгаа ба цаашид мөн ийм төрлийн орлогоос үндсэндээ бүрдэх төлөвтэй байгаа тул эдийн засгийн өсөлтийг тогтворгүй болгож байна. Дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын түүхий эдийн үнэ савлах бүрд улсын төсвийн орлого нэмэгдэх буюу багасах болно. Ингэснээр ДНБ-ний өсөлтөд шууд нөлөөлөх тул аль болох олон тулгуурт эдийн засгийн бодлогыг баримталж өсөлтийг тогтворжуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, энэхүү өсөлт нь тун эмзэг өсөлт юм.

Гэвч одоогоор энэхүү мөнгөн хөрөнгийг үндсэндээ “Хүний хөгжил” сангаар дамжуулан бэлнээр тарааж байгаа нь эдийн засгийн эерэг өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Учир нь, байгалийн баялгийн нөөц, түүний ашиглалт нь хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлтөд нэмэр биш нэрмээс болох тохиолдол их хэмээн олон орны эрдэмтэд үздэг. Өөрөөр хэлбэл, “Эрдэс баялгийн дэлхийн зах зээлийн үнээс хамаарч тухайн орны ханш, эдийн засгийн чадавхи, өсөлтийг чангааж буй үзэгдлийг баялгийн хараал гэнэ” хэмээн тодорхойлдог.

Тэгэхээр үүнийг дайрч биш тойрч гарахад төр засгийн оновчтой бодлого нэн шаардлагатай цаг үе тулгараад байгаа юм. Уг салбарын бодлогыг зөв тодорхойлж, мөнгийг үр ашигтай хуваарилж, зарцуулснаар татвар, ажлын байр, орон нутгийн хөгжил болоод бусад салбарыг хөгжүүлэх хөгжлийн гарц нь болох ёстой. Хэзээ нэгэн цагт ашиглаад дуусах газрын баялгийг зөв захиран зарцуулах нь хамгийн чухал асуудал аж. Дээр нь ашигт малтмалын үнэ ханш, ашиглалтын байдал төдийлөн тогтвортой байдаггүй тул дэлхий нийтийн чиг хандлага, төлөв байдалд анхаарлаа хандуулан тооцоолж байх нь чухал юм.

Манай улсын хувьд уул уурхайн салбарын олон төсөл хүлээгдэж, удахгүй ашиглалтын үйл ажиллагаа эхлэх гэж байгаа. Мөн дэлхийн зах зээлээс ихээхэн хамааралтай байдаг учир “Голланд өвчин”-өөр өвчлөх магадлал хамгийн өндөр. Монгол Улсын төсөв одоогийн байдлаар уг салбараас хамгийн их хамааралтай байгаа энэ үед төсвийг гамгүй зарцуулж амлалтаа биелүүлж байна гээд их хэмжээний мөнгийг иргэн бүрт хуваарилаад байх нь буруу хэмээн эдийн засагчид үзэж буй.

Сүүлийн үед эдийн засгийн үйл явцад нэгэн хандлага ажиглагдаж буй нь инфляци, импортын барааны өсөлт юм. Импортын бараа одоогийн байдлаар 43.7 хувиар өссөн тоо гарсан. Дотоодын үйлдвэрлэлийг дэмжихийн оронд их хэмжээний мөнгө тарааж импортын бараанд хөрөнгө оруулах нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг. Уул уурхайн салбараас орж ирсэн мөнгийг үе хооронд хэрхэн, яаж тэгш хуваарилах, тогтворжуулахад төр, засгийн удирдлагууд төдийлөн анхаарахгүй байгаа. Эдийн засагчид олон орны туршлага, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан баялгаас хуримтлал үүсгэх нь хамгийн оновчтой шийдэл хэмээн үздэг.

Хуримтлалын, тогтворжилтын болон нэгдмэл сангуудыг манай улс нэн даруй байгуулж ирээдүйн баталгаат орлогыг хангах нь хамгийн сайн арга юм. Ингэснээр богино хугацаанд орсон орлогоор төсвийн тогтвортой байдлыг хангах, дэлхийн зах зээл, ханшаас үүсэх сөрөг нөлөөллөөс хамгаалах, орлогыг тэгш хуваарилах гээд эерэг нөлөөлөл бий болох юм.

Төсвийн орлогын хэсэг макро эдийн засагт ийнхүү нөлөөлөх хандлагатай байгаа бол одоо зарлагын талыг нь авч үзье.

Төсвийн зарлага ихсэх нь инфляцийг хөөрөгдөж байна гэж үзэх хандлага байгаа ба үүний жишээнд цалин нэмэх тухай зарлахад маргааш нь өргөн хэрэглээний барааны үнэ өсдөг явдлыг дурьддаг. Өнгөц харахад тийм ч юм шиг. Өнгөрсөн онд Засгийн газраас цалин нэмэгдүүлэх тухай мэдэгдэл хиймэгц гурилын үнэ бараг хоёр дахин өсч байсан. Хэрэв үнэхээр чөлөөт зах зээл байсан бол, тэр олон худалдагч хэнээс ч хамаарахгүй наймаагаа хийдэг бол, нэг хэсэг нь үнэ нэмж байхад нөгөө хэсэг нь бушуухан бараагаа борлуулчихаад мөнгөө тоолоод дараагийнхаа гурилаа бодож суух ёстой.

Тэгэхгүй байна гэдэг нь эдгээрийн цаана зах зээлээ атгасан цөөн хэдэн том нийлүүлэгч байна гэсэн ойлголт төрүүлж байгаа юм. Бизнес эрхлэгчид өөр хоорондоо зарчмаа тохиролцон бараа, үйлчилгээний үнийг хөөрөгдөх боломж ихтэй байдаг. Тухайн салбар дахь компанийн тоо цөөн, тэр цөөн хэд нь том байх тусмаа хоорондоо үгсэн хуйвалдаж үнэ хөөрөгдөн олон нийтийг хохироох, хэрэглэгчдэд үнэ тулгах боломж төдий чинээ их байх болно. Дэлхийн бараг бүх оронд монополь үзэгдлийн эсрэг хууль үйлчилдэг бөгөөд антитрестийн (antitrust) хууль гэж ерөнхийд нь нэрлэдэг.

Тэгэхээр Засгийн газраас цалин нэмэх нь Төв банкнаас зээл аваагүй тохиолдолд инфляци хөөрөгдөх хүчин зүйл биш бөгөөд харин цөөн хэдэн том компани, олигархиудын үгсэн хуйвалдаж буй нь үнийн өсөлтийн гол шалтгаан юм. Цалингаа сэм сэм нэмж тэмцэх биш харин монополийн эсрэг хуулийг бүрэн агуулгаар хэрэгжүүлж байж л зохиомол үнийн хөөрөгдөл, инфляцийн эсрэг тэмцэлд амжилт олно. Ер нь аль ч агуулгаар нь авч үзсэн төсвийн зардал инфляци өдөөх шууд шалтгаан, хүчин зүйл биш гэдгийг ойлгох хэрэгтэй. Харин үргүй зардалтай албан болон албан бус сектор, ер нь хаа хаанаа тэмцэл өрнүүлэх нь зүй ёсны хэрэг.

Дээрхээс үзэхэд нэгэнт үндсэн шууд өдөөгч нь биш тул төсвийг хумих замаар инфляцитай тэмцэх нь тийм ч оновчтой шийдэл биш. Харин ч эрүүл мэнд, боловсролын салбарыг дэлхийн стандарт түвшинд хүргэж, үр ашигтай хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжсэн, нэгэнт тогтоосон зорилго арга хэмжээндээ хөрөнгө мөнгийг хангалттай зарцуулах байдлаар хийх шаардлагатай юм. Товчхондоо, төсөвт орж ирсэн төгрөг бүрийг эргэлтэнд оруулах учиртай.

Нөгөө талаар хэдий эдийн засгийн өсөлт жил бүр нэмэгдэж байгаа ч ажилгүйдлийн хэмжээ тэр бүр буурч чадахгүй тогтмол хэмжээнд хадгалагдсаар байна. Энэнд төсвийн тэлэлт нөлөөлж байгаа гэж үзэж болно. Төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд татварыг нэмэхэд компаниуд зардлаа багасгах үүднээс ажиллагсдаа цомхтгох хандлагатай байдаг. Үүний

эсрэг төрөөс тодорхой арга хэмжээ авдаггүй, тунхаглалын шинжтэй зорилт тавихаас хэтэрдэггүй нь ажилгүйдлийг багасгахад бодитой нөлөө үзүүлдэггүй. Үүн дээр нэмэгдээд төсвийн зарлага талаас шинээр ажлын байр бий болгоход чиглэсэн бодлого байхгүй, халамжийн бодлого түлхүү баримталдаг нь ажил хайх, хийх эрмэлзлийг бууруулж байж болох талтай.


Тухайлбал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилалын төрлүүд тодорхой бус, шилжих зардлууд их байгаагаас ойлгомжгүй зардлын төрлүүд их байна. Төсвийн зарлагад хийсэн анализаас үзэхэд 2011 оны төсвийн алдагдлыг 9,9%-д хүргээд буй төсвийн зардлын нэмэгдэлд голлох байр суурь эзэлж буй хүчин зүйл нь сонгуулын амлалттай холбоотой халамжийн шинжтэй зардлууд өссөнтэй холбоотой байна. Дээрх нийгмийн халамжийн шинжтэй зардал өссөнтэй холбоотойгоор урсгал зардлын нийт зардалд эзлэх хувь нь өндөр, хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь харьцангуй бага байгаа нь эдийн засгийн хий өсөлт бий болоход нөлөөлж байна гэж үзэж болохоор байна.

Иймд, цаашид эдийн засгийн өсөлтийг бодитой болгохын тулд нийгмийн халамжид зарцуулж буй /Хүний хөгжил сангийн болон Улсын төсвийн урсгал зардал дахь нийгмийн халамжийн зардал/ зардлыг хөрөнгө оруулалтын зардал руу шилжүүлж бүтээн байгуулалтын ажилд зориулах нь хамгийн зөв гарц юм.

Эдийн засаг, санхүү, банкны төв байгууллагуудын макро эдийн засгийн бодлого нийтэд ойлгомжтой, харилцан уялдаатай, ил тод, тогтвортой байх ёстой бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийг хангах, бизнесийн эрүүл орчныг бүрдүүлэх, далд эдийн засагтай тэмцэх гол урьдчилсан нөхцөл юм. Харин нэгдсэн төсвийн төлөвлөгөө ба хэрэгжүүлэлтийг харьцуулан харахад аман дээрээ нэг бодлого зарлах мөртлөө ачир дээрээ нөгөөхөө эргэж хорлосон шийдвэр гаргаад байгаа гэж үзэж болохоор байна.

\* \* \*

### Нэг. Монгол Улсын нэгдсэн төсөв



Зураг 1.1. Монгол улсын нэгдсэн төсөв (Тэрбум төгрөгөөр)

Эх сурвалж: Сангийн яам


### 1.1 Төсвийн тогтворжуулалтын сан

Шинээр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсөв тогтворжуулах гол хэрэгсэл бол Төсвийн тогтворжуулалтын сан бөгөөд төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагад нийцсэн нэгдсэн төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилготой. Тус санд тэнцвэржүүлсэн орлогоос давсан бүх орлогыг оруулна. Өөрөөр хэлбэл эрдэс баялгын үнэ төлөвлөж байснаас давж өссөн үед

тогтворжуулалтын санд хөрөнгө хуримтлагдах бөгөөд үнэ буурсан үед уг сангаас төсвийн алдагдалыг санхүүжүүлж байхаар зохицуулж өгсөн байна. (Зураг 1.2.)

Санг мөнгө хэлбэрээр хадгалж удирдана. Санг байгуулах доод хэмжээ нь ДНБ-ний 5 хувьтай тэнцүү байх бөгөөд эх үүсвэр нь төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан орлого, төсвийн ашиг зэрэг орлогуудаас бүрдэнэ. Сан нь зөвхөн төсөв тогтворжуулахад хязгаарлагдмал зориулалтай. Сангийн удирдлага, хяналт, тайлагналыг Төв банк-Засгийн газрын эрх, үүрэг, хариуцлага, сангийн өгөөжийн норм, эрсдлийн менежементийн зэрэг харилцааг зохицуулах гэрээ байгуулж мөрдөх аж.

Зураг 1.3. Төсөв тогтворжуулах сан



Төсвийн тогтворжуулалтын санд 2011 онд 183.1 тэрбум төгрөг төвлөрхөөр төсөвлөсөн байна. Улмаар 2013 оноос Төсвийн тогтворжуулалтын сангаас хөгжлийн хөрөнгө оруулалт хийх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг дагаж мөрдөх **шилжилтийн хугацаанд** баримтлах шаардлагуудын дараах хүснэгтэд харууллаа. (Хүснэгт 1.1.)

Хүснэгт 1.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг дагаж мөрдөх шилжилтийн хугацаа


Тусгай шаардлагууд / Төсвийн жил	2011 он	2012 он	2013 он
Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох	Баримтлана	Баримтлана	Баримтлана
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх	Баримтлахгүй	Баримтлахгүй	Баримтлана

Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх	Баримтлахгүй	Баримтлахгүй	Баримтлана
Улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх	<b>Баримтлана</b> /хуулиар <b>50</b> хувь байж болох бөгөөд 40 хувиас илүү гарсан 10 хувиар зөвхөн Хөгжлийн банкинд зээлийн баталгаа гаргах зориулалттай/	<b>Баримтлана</b> /хуулиар <b>60</b> хувь байж болох бөгөөд 40 хувиас илүү гарсан 20 хувиар зөвхөн Хөгжлийн банкинд зээлийн баталгаа гаргах зориулалттай/	<b>Баримтлана</b> /хуулиар <b>50</b> хувь байж болох бөгөөд 40 хувиас илүү гарсан 20 хувиар зөвхөн Хөгжлийн банкинд зээлийн баталгаа гаргах зориулалттай/

### Хоёр. Төсвийн орлогын шинжилгээ

Төсвийн орлого дахь уул уурхайн салбарын нөлөөлөл

Зураг 2.1. Монгол улсын эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувь



Эх сурвалж: Эрдэс баялаг, эрчим хүчний яам

Уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй томоохон салбар болоод байна. Монгол улсын Засгийн газар экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн салбарыг тус орны эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон бөгөөд уул уурхайн салбараас улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр 2004 оноос хойш өсч 2009 онд ДНБ-ний 28.2 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 65.4 хувь, экспортын бүтээгдэхүүний 84.6 хувьд хүрч<sup>66</sup> (Зураг 2.1.) байгаа нь Монгол Улсын эдийн засаг бүхэлдээ тус салбараас хамааралтай болж байгаа нь ажиглагдаж байна.

Энэ талаар олон яригдаж, бичигдэж байгаа бөгөөд тэдгээрийн нэг болох ННФ-аас эрхлэн гаргасан “Уул уурхайн орлогын менежментийн макро бодлого ба институциональ

<?> Эрдэс баялаг, эрчим хүчний яам. Эх сурвалж: <http://www.mmre.energy.mn/branch/now/102/detail/1004090002/> - 2011.02.25



тогтолцоо” судалгааны тайланд<sup>57</sup> уул уурхайн салбарын төсөвт хэрхэн нөлөөлж байгааг дурьдсан байна. (Хүснэгт 2.1.)

Хүснэгт 2.1.

**Төсвийн орлого дахь уул уурхайн салбарын нөлөөлөл (Тэрбум төгрөгөөр)**

Үзүүлэлтүүд	2005 он	2007 он	2008 он
Нийт орлого ба тусламжийн дүн	713.1	1880.4	2170.4
Ашигт малтмалын нийт орлого	25.0	417.0	141.4
Нийт орлогод ашигт малтмалын эзлэх хувь	3.5	38.0	6.5
Ашигт малтмалын орлогыг хассан төсвийн нийт орлого	688.1	1166.4	2029.0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	711.2	1747.3	2466.8
Төсвийн нийт тэнцэл	-39.3	133.1	-296.4
Ашигт малтмалын орлогыг хассан төсвийн нийт тэнцэл	-64.3	580.8	-437.8

**Эх сурвалж:** ННФ, “Уул уурхайн орлогын менежментийн макро бодлого ба институциональ тогтолцоо”

2007 онд уул уурхайн бүтэгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөгөөр ашигт малтмалын нийт орлого төсвийн нийт орлогын 38.0 хувийг эзэлж, төсвийн нийт тэнцэл 133.1 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Гэвч тус оны сүүлийн 3 сард нь зэсийн үнэ буурснаас 2008 онд энэ орлого эрч буурч, төсвийн нийт орлогын дөнгөж 6.5 хувийг эзэлж, төсвийн нийт тэнцэл 296.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Энэ бүгд манай улсын төсөв уул уурхайн салбараас ихээхэн хамааралтайг нотолж байна. Ингэснээр манай улсын төсвийн тогтвортой байдал дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал болон гадаад зах зээл дээрх зарим бүтэгдэхүүний үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай байгааг өмнөх туршлага харуулсан.

## 2.1 Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн орлого

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу төсвийн тогтвортой байдлыг хангах, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс бий болсон орлогоор хуримтлал үүсгэх зорилгоор төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцож 2011 оны нэгдсэн төсөвт тусгасан байна. Монгол Улсын 2011 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг ДНБ -нд эзлэх хувиар ТДХМ-ээс 19.2, харин 2010 оны төсвийн тодотголоос 14.4-ээр нэмэгдүүлэн тооцсон байна. Төсвийн орлогыг тооцохдоо НӨАТ, Импортын гаалийн албан татвар, Нөөц ашигласны төлбөр зэрэг татварыг орлогыг нэмэгдүүлэн 2010 оны үзүүлэлттэй харьцуулахад 25 гаруй хувиар өссөн байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3-т заасны дагуу 2011 онд зэс, нүүрсний үнийг ОУВС-ын сүүлийн 12 жилийн дундаж, “Bloomberg” агентлагийн 2010-2013 оны зэс, нүүрсний үнийн төсөөллийн дунджаар тооцоолон зэсийн үнэ 5983.1 ам.доллар, боловсруулсан нүүрсний үнэ 98.8 ам.доллар байхаар байна. Мөн 2011 онд дэлхийн зах зээл дэх алтны үнийг 1250.0 ам доллар, цэвэр зэсийн үнийг дунджаар 8425.0 ам.долларт хүрэхээр тооцсон байна.

<sup>57</sup> “Уул уурхайн орлогын менежментийн макро бодлого ба институциональ тогтолцоо” судалгааны тайлан. Нээлттэй нийгэм форум. 2010 он.




Төсвийн тогтвортой байдлын хуулийн 4.1.3-т заасны дагуу тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа эрдэс баялгийг “**гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого**”-д “**зэс**” болон “**нүүрс**”-нээс төвлөрөх орлого хамаарч байна. Харин алтны хувьд дээрх шаардлагыг хангаж чадахгүй байгаа тул 2011 оны хувьд хамаарахгүй болно.


Зэс, нүүрсний үнийн төсөөллийг ирэх 2011 онд одоогийн байгаа түвшинд хэлбэлзэнэ гэж үзээд Тогтворжуулалтын санд ирэх онд 183.1 тэрбум төгрөгийн орлого төсөвлөсөн байна.

Зураг 2.2. Урсгал орлого ДНБ-нд эзлэх хувиар

а) Урсгал орлого



Зураг 2.3. Урсгал орлогын бүтэц, ДНБ-нд эзлэх хувиар



Эх сурвалж: Сангийн яам

Урсгал орлогын ДНБ-нд эзлэх хувь 2006 он хүртэл 0.8 хувиар тогтмол буурч байсан бол түүнээс хойшхи 6 жилд арваас дээш хувийн хэлбэлзэлтэй байна. 2007 оны төсвийн гүйцэтгэлээр урсгал орлогын ДНБ-д эзлэх хувь 41.0 гарч байсан бол 2 жилийн дараа 29 хувиар буурч байсан, харин 2009 оны гүйцэтгэлээс 2011 оны төсвийн төлөвлөгөө хүртэлхи 2 жилд 27 хувиар өссөж 3 292.7 тэрбум төгрөгт хүрсэн байна. (Зураг 2.2.)

2011 оны төлөвлөгөөгөөр Хөрөнгийн орлого өмнөх оныхоос 1 дахин нэмэгдэхээр, харин тусламжийн орлого өмнөх оныхоос 2,5 дахин багасахаар тусгагдсан байна. Тусламжийн орлого өмнөх оныхоос 40 гаруй хувиар багассан нь Монгол Улсын эдийн засаг өсч тэлэхийн хирээр уг орлогын дүн багасах хандлагтай болж байна. (Хүснэгт 2.2)

## Хүснэгт 2.2 Хөрөнгийн болон тусламжийн орлого (Тэрбум төгрөгөөр)

	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010 тод	2011 төл
• Хөрөнгийн орлого	0,0	0,8	1,0	1,6	2,5	3,2	2,3	1,6	3,3
• Тусламжийн орлого	8,7	6,0	4,3	4,7	22,0	16,1	19,1	22,0	8,6


Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын нэгдсэн төсвийн дийлэнхийг хувийг бүрдүүлж байдаг татварын орлогыг 2011 оны төсөвт 2003-2009 оны ДНБ-нд эзлэх хувийн дундажаас 19 хувиар өндөр төлөвлөсөн байна. Ийнхүү ДНБ-нд эзлэх хувиар 37.0 хүрэхээр төсөвлөсөн нь дэлхийн эдийн засгийн хямралаас өмнөх үе буюу 2007 оны гүйцэтгэлээс 10.2 хувь, өмнөх оныхоос 14.6 хувиар тус тус өндөр байна. (Зураг 2.3.)

Орлогын албан татвар нь татварын орлогын дийлэнхи хувийг бүрдүүлж ирсэн. Үүнд: Хувь хүний орлогын албан татвар, Аж, ахуй нэгж байгууллагын орлогын албан татвар болон Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар зэрэг томоохон татварын төрлийг хамруулдаг. Уг орлогыг 2011 оны төсөвт харьцангуй багаар төсөвлөсөн нь УИХ-аас батлагдсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль 2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонтой холбоотой.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын зарим нэг гол төрлүүдийг дэлгэрүүлэн авч үзье.

## б) Орлогын албан татварын орлого, ДНБ -нд эзлэх хувиар



Зураг 2.4. Орлогын албан татварын бүтэц

Эх сурвалж: Сангийн яам

Татвар төлөгчдийн тоо сүүлийн 6 жилд дунджаар 13.3 хувиар тогтмол өсөж байсан тул Хувь хүний орлогын албан татварын орлогын гүйцэтгэл 2005 оноос хойш 4,2-19,2 хувиар давж байсан бөгөөд 2009 оны гүйцэтгэлээр бүр нэг дахин давж биелэгджээ. Харин 2010 оны 12 дугаар сарын гүйцэтгэлээр 160.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь тодотголоор төлөвлөсөн дүнгээс 44.0 тэрбум төгрөгөөр давж биеэлсэн байна.

Ийнхүү төлөвлөснөөсөө 27.3 хувиар давуулан биелүүлсэн нь 2010 оны 10 дугаар сарын 1 -ний өдрөөс эхлэн төсвийн байгууллагын ажиллагсадын цалин 30 хувиар нэмэгдсэнтэй холбоотой. Мөн уул уурхайн салбарын ажил эрчимжиж байгаатай холбоотойгоор ажлын байр шинээр нэмэгдэж байгаа нь ийнхүү Хувь хүний орлогын албан татварын орлого нэмэгдэхэд нөлөөж байна.


2011 оны төсөвт Хувь хүний орлогын албан татварын орлогыг 172.7 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн нь 2003 оныхтой харьцуулахад 6 дахин, өмнөх оныхтой харьцуулахад 31 хувиар өссөн байна. 2010 оны намрын чуулганаар Ашигт малтмалын тухай, Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогын албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулснаар хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллгааг зохицуулах, эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

Одоогийн байдлаар 17 аймгийн 57 орчим сумын 100 гаруй цэгт 30 орчим мянган хувиараа ашигт малтмал олборлогч иргэд байгаа бөгөөд дээрхи хуулиар тэд сард 53 мянган төгрөгийн албан татвар төлнө. Дэлхийн зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг тогтвортой байхаар тооцоолж ААН байгууллагын орлогын албан татварт 433.2 тэрбум төгрөгийн орлогыг төлөвлөсөн нь өмнөх оныхоос 123.9 тэрбум төгрөг буюу 40 хувиар нэмэгдсэн байна.


### в) НӨАТ

НӨАТ-ийн орлогоос 816.8 тэрбум төгрөгийн орлого төлөвлөсөн нь өмнөх оныхоос 317.8 тэрбум төгрөг буюу 63.7 хувиар нэмэгдсэн байна. Ийнхүү нэмэгдэхэд Импортын барааны НӨАТ-ын орлогыг өмнөх оныхоос 197.6 тэрбум төгрөг буюу 62.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Зураг 2.5. НӨАТ-ын нийт орлого \Тэрбум төгрөгөөр



Зураг 2.6. НӨАТ-ын орлогын бүтэц (ДНБ-нд эзлэх хувиар)



Эх сурвалж: Сангийн яам

**г) Гаалийн албан татвар**

Гаалийн албан татвараас 239.4 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн нь өмнөх оныхоос 74.1 тэрбум төгрөг буюу 44.8 хувиар нэмэгдүүлсэн байна. Үүнээс импортын барааны гаалийн албан татвар 84.2 тэрбум төгрөг буюу 54.3 хувиар нэмэгдсэн байна. Учир нь уул уурхайн салбарын бүтээн байгуулалтын ажил, түлш, машин механизм, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон холбогдох дэд бүтцийн төслүүд нэмэгдсэнээр эдийн засаг тэлж, тэр хэрээр импорт огцом өсч байна.

Хүснэгт 2.3. Гаалийн албан татварын дүн (Тэрбум төгрөгөөр)


	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010 тод	2011 төл
<b>Гаалийн албан татвар</b>	<b>32,6</b>	<b>44,7</b>	<b>57,0</b>	<b>72,1</b>	<b>102,5</b>	<b>140,8</b>	<b>116,0</b>	<b>165,3</b>	<b>239,4</b>
Импортын барааны	31,1	40,8	53,2	65,2	96,3	132,1	111,2	155,1	239,3
Экспортын	1,6	3,9	3,8	6,8	6,2	8,8	4,8	10,1	0,1

Эх сурвалж: Сангийн яам


**д) Бусад татвар**

Бусад татвар, төлбөр, хураамжийн 2011 ойн орлого 2003-2010 онуудын дунджаас нэг дахин, өмнөх оныхоос 262.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн орлогыг төвлөрүүлэхээр төлөвлөгдсөн. Үүнд:

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 197.8 тэрбум төгрөг (өмнөх оныхоос 42.8 тэрбум төгрөгөөр өссөн), мөн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 169.7 тэрбум төгрөг, шинээр батлагдсан Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу агаарын бохирдлын төлбөрөөр 30.0 тэрбум төгрөгийн орлогыг төлөвлөгдсөн байна.



Зураг 2.7. Бусад татварын нийт орлого (ДНБ -нд эзлэх хувиар)



Зураг 2.8. Бусад татварын орлогын гол бүрэлдэхүүн орлогууд (ДНБ-нд эзлэх хувиар)

Харин Агнуурын нөөц ашигласны төлбөр 2010 оны үзүүлэлтээс даруй 4 дахин багассан. Өмнөх жилүүдэд уг орлогын дийлэнх хувийг идлэг шонхор шувуу экспортоор гаргасны орлого байсан бөгөөд Амьтны хороо (CITIES) 2010 онд Монгол орноос 300 хүртэл толгой идлэг шонхор шувуу экспортлох квотыг тогтоож өгсөн байна.

### Гурав. Төсвийн зарлагын шинжилгээ

Жил бүрийн Нэгдсэн болон Улсын төсөвт орлого болон зарлагын харьцаа, төсвийн алдагдал, түүний макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаархи тооцоо судалгаа цөөнгүй хийгдсэн байдаг. Харин төсвийн зарлага ямар үндэслэл, шаардлагаар нэмэгдсэн, тэр нь үнэхээр өсөх зардал мөн эсэх, өнгөрсөн жилд улсын төсвөөс гарсан зардлын хичнээн хувь нь хэрхэн хэмнэж болох үргүй зардал байв гэсэн учир шалтгааныг үндэслэлтэйгээр гаргасан судалгаа ховор байна. (тийм судалгаа олдсонгүй) Ийм судалгаа гаргахын тулд үнэн зөв, өргөн хүрээг хамарсан бодит тоо баримт, тайлбар бүхий мэдээлэл хэрэгтэй нь ойлгомжтой.

Иргэний нийгмийн ихэнхи судлаачид, Олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээллийн аливаа хэрэгслээр 2011 оны Нэгдсэн төсвийн зарлага өнгөрсөн жилийнхээс үлэмж хэмжээгээр нэмэгдсэн тухай ярьж, бичиж байгааг бид мэднэ. Төсвийн төлөвлөгөөний үр дүнг харахад ч төсвийн зарлага орлогоосоо 779,4 тэрбум төгрөгөөр хэтэрч төсвийн алдагдал 9,9 хувьд хүрсэн үр дүн бидэнд харагдаж байна.


Тэгвэл энэ алдагдал юунаас болж үүссэн, төсвийн зарлагын өсөлт урсгал зарлагадаа байна уу, хөрөнгө оруулалт болон нийгмийн халамжид зарцуулж буй зарлагад агуулагдаад байна уу гэдэгт бодит хариулт өгөх нь судалгааны 3-р бүлгийн шинжилгээний зорилго болж байна. Түүнчлэн төсвийн зарлагад шинжилгээ хийсний үр дүнд цаашид бид төсвөө үр дүнтэй зарцуулж эдийн засгийн бодит өсөлтийг бий болгохын тулд ямар зардлаа танах, ямар зардлаа нэмэх шаардлагатайг тодорхойлж болох юм.

Үүний тулд 2010 оны нэгдсэн төсвийн зарлага болон 2011 оны зарлагын задаргааг нэг бүрчлэн харьцуулан үзэж илт мэдэгдэм ихээр нэмэгдсэн зардлуудыг тодорхойлох нь шалтгааныг тодруулахад чухал ач холбогдолтой гэж үзсэн юм. Улсын төсөв, орон нутгийн төсөв, нийгмийн даатгалын сан болон хүний хөгжил сангийн төсөв Нэгдсэн төсвийг бүрдүүлэх бөгөөд судалгааны энэхүү хэсэгт улсын төсвийн зардлыг түлхүү авч үзсэн болохыг анхаарна уу.

Нэгдсэн төсвийн зарлагыг бүрдүүлж буй Улсын болон Орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Хүний хөгжлийн сангийн зарлага нь тоон үзүүлэлтээрээ дараах утгатай байна. Харин 2011 оны Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн **4 их наяд 84,1 тэрбум** байхаар төлөвлөгдсөн байна. Гэтэл Нэгдсэн төсвийг бүрдүүлж буй дээрх төсөв тус бүрийн зарлагын нийлбэр нь **4 их наяд 631,7 тэрбум** гарч байна. Энэ нь дотоод гүйлгээний давхардлаас шалтгаалж байгаа бөгөөд уг тоо нь залруулга хийгдээгүй дүн гэдгийг анхаарна уу.

2011 оны Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд Улсын болон Орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Хүний хөгжил сангийн нийт зарлага ба цэвэр зээл хичнээн хувийг эзлэхийг доорхи зургаар харуулъя.

Зураг 3.1 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд зарлагуудын эзлэх хувь




### 3.1 Монгол Улсын 2011 оны нэгдсэн төсвийн зарлагад хийсэн шинжилгээ

Монгол улсын нэгдсэн төсөвт дүн шинжилгээ хийж 2003 оноос 2011 он хүртлэх зарлагын үзүүлэлтүүдийн өсөлт, бууралт хувь хэмжээг нэгдсэн төсөв, улсын төсөв, орон нутгийн төсөв зэргээр харьцуулан шинжиллээ. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн сүүлийн жилүүдэд үлэмж хэмжээгээр өссөн байгаа нь төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр зарлага дагаж нэмэгдсэн мөн үр ашиггүй зарлагын өсөлт зэргээс үүдэн 2006 - 2011 онд 3.3 дахин өсчээ. Монгол улсын нийт зарлагын өсөлтийн гол шалтгаан нь ашигт малтмалын өсөлтийн жилүүдэд төсөв уул уурхайгаас хэт хамааралтай болсон ба тэрхүү хуримтлалын ихэнх хэсгийг цалин хөлс, нийгмийн халамжийн зардал, хөрөнгө оруулалтын зардлуудад зарцуулсан байна.

Зураг 3.2 –оос харахад урьд жилүүдэд тогтмол өсч байсан зардлууд болох хөрөнгийн зардал болон цэвэр зээл, урсгал зарлагын бүлгийн зардлууд 2009 онд тодорхой хэмжээгээр буурсан нь эдийн засаг, санхүүгийн хямралтай холбоотой Засгийн газраас зарлагыг хумих бодлого баримтлаж тодорхой арга хэмжээ авснаар харьцангуй тогтворжих хандлагатай байсан. Харин 2010 оноос дахин өсч 2011 онд өмнөх оныхоосоо нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 31.4 хувиар нэмэгдсэн ба үүнд эзлэх урсгал зарлага 34.5 хувиар, хөрөнгийн зардал 39 хувиар өсч харин цэвэр зээл 42.1 хувиар буурахаар төсөвт тусгагдсан байна.

Зураг 3.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн өсөлт /тэрбум төг/



ДНБ, Төсвийн нийт зарлага, урсгал зардалын өсөлтийг 2003 оноос 2011 он хүртэл харьцуулан шинжиллээ. 2003 ДНБ тасралтгүй өссөн дүнтэй байгаа бөгөөд нийт зарлага 2009 онд -5.3 хувиар буурч харин урсгал зардал тогтмол өссөн дүн ажиглагдаж байна. 2003 оноос 2011 он хүртэл ДНБ 5.3 дахин, нийт зарлага 6.4 дахин, урсгал зардал 7.1 дахин өссөн байна. Доорх хүснэгтээс харахад сүүлийн жилүүдэд нийт зарлага болон урсгал зардал ДНБ-ний өсөлтөөс илүү хурдтай өсч байна. Энэ нь эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр байгааг харуулж байна. ДНБ, нийт зарлага, урсгал зардалын өсөлтийг хүснэгт болон зургаар үзүүлээ.

## Хүснэгт 3.1


- **ДНБ, төсвийн нийт зарлага (ТНЗ) ба урсгал зардал (ТУЗ) өсөлт оны үнээр, хувиар** (тэрбум төгрөгөөр)

		2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010 *	2011
ДНБ	оны үнээр	1461.2	1910.9	2266.5	3714.9	4599.5	6019.8	6055.7	7171.4	7836.9
	хувиар	17.8	30.8	18.6	63.9	21.8	35.4	0.6	18.4	9.2
ТНЗ	оны үнээр	616.5	752.5	764.6	1237.0	1747.3	2466.7	2336.5	3107.9	4084.1
	хувиар	12.4	22.1	1.6	61.8	41.3	41.2	-5.3	33.0	31.4
ТУЗ	оны үнээр	434.8	538.7	600.3	982.3	1367.6	1761.1	1788.1	2339.6	3146.4
	хувиар	4.7	23.9	11.4	63.6	39.2	28.8	1.5	30.8	34.5

2010\*- тодотголоор




Зураг 3.3 ДНБ, төсвийн нийт зарлага ба урсгал зардлын өсөлтийн хурд /хувиар/



Төсвийн нийт зарлага ба урсгал зардал 2003-2006 онд ДНБ-ээс бага хувь хэмжээгээр нэмэгдэж байсан бол 2007 оноос огцом нэмэгдэж цаашид ч улам өсөх хандлагатай байна. ДНБ-нд эзлэх зарлагын хувь хэмжээгээр эдийн засагт үзүүлэх төрийг үүрэг, оролцооны түвшинг тодорхойлдог. 2003-2006 онд буурч байгаад 2007, 2008, 2010, 2011 онуудад дахин нэмэгдэж, 2008 онд 40,2 хувь, 2010 онд 43.3 хувьд хүрч 2011 онд бүр 52.1 хувьд хүрч эдийн засагт үзүүлэх төрийн оролцоо өндөр байна.

2009 онд хямралын эсрэг авсан арга хэмжээний үр дүнд тодорхой түвшингээр буурсан байна. Төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэлд макро эдийн засгийн засгийн байдлыг тогтворжуулж, нийт эдийн засаг дахь Засгийн газрын оролцоог багасгах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн эрүүл хөрс, суурийг бий болгох гэж зорилт тавьсан нь биелэлээ олоогүй байна. Мөн нэгдсэн төсвийн нийт зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг бууруулж 2009 онд 37.7 хувь, 2010 онд 33.2 хувь, 2011 онд 32.0 хувьд хүргэх гэсэн шалгуур үзүүлэлт тавьсан боловч 2010 онд 10 хувиар, 2011 онд 20.6 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 3.4 ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувиар



### 3.2 Урсгал зардал

2006 оноос 2011 он хүртэл нийт зарлагын дүнд эзлэх урсгал зардал 3.2 дахин, хөрөнгийн зардал 4.8 дахин нэмэгдсэн байна. Урсгал зардал өсөхөд барааны үйлчилгээний зардалын зүйл ангийн зардлууд болох цалин хөлс 143.5 тэрбум төгрөг буюу 22.2 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимэтгэл 13.4 тэрбум төгрөг буюу 21.6 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 118.1 тэрбум төгрөг буюу 22.8 хувь тус тус нэмэгдсэн байна.


Урсгал зардалын дүнд хамгийн их өсөлттэй гарсан зардал болох татаас ба урсгал шилжүүлэг

561.9 тэрбум төгрөг буюу 50.1 хувь, тус тус өсч харин зээлийн үйлчилгээний төлбөр 16.8 тэрбум төгрөгөөр, буюу 29.9 хувиар буурсан байна. /Зураг 3.5 дээрх зардлуудын өсөлт, бууралтыг харна уу/

Дээрх зардлууд өсөхөд 2010 оны 10 сард төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмсэн мөн хүний хөгжил сангийн мөнгийг 2011 онд 805 тэрбум төгрөгөөр төсөвлөн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний төлбөр, оюутны сургалтын төлбөр, иргэдэд сар бүр олгох 21 мянган төгрөг зэргээс шалтгаалан өсч байгаа бөгөөд бараа үйлчилгээний бусад зардал доторх зарим зардлууд зах зээл дэх бүтээгдэхүүний үнийн өсөлт болон бусад хүчин зүйлээс хамаарч нэмэгдсэн байна.

Татаас ба урсгал шилжүүлэг нэмэгдэхэд Засгийн газар хоорондын шилжүүлэг 43.4 тэрбум төгрөгөөр, өрх гэрт олгох шилжүүлэг 496.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Өрх гэрт олгох шилжүүлгийн бүлгийн зардлууд болох тэтгэвэр тэтгэмжийн зардал өмнөх оныхоос 89.9 тэрбум төгрөгөөр хүний хөгжил сангийн зардал 378,5 тэрбум төгрөгөөр нэмэгдэн төсөвт тусгагдсан нь дээрх зардлууд өсөхөд нөлөөлсөн байна.

Зураг 3.5 Урсгал зардлын бүлгийн зардлуудын өсөлт, бууралт



### 3.3 Хөрөнгийн зардал ба цэвэр зээл

2011 онд ДНБ-ий 10.7 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг 2011 онд хөрөнгө оруулалтанд зарцуулах бөгөөд 2010 онд 8.4 хувиар баталсан бөгөөд хөрөнгө оруулалтын зардал 31.8 хувиар, их засвар 61.2 хувиар, гадаад төслийн зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт 144.3 хувиар тус тус нэмэгдсэн бол хөрөнгийн бусад зардал 9.6 хувиар буурсан байна. Хөрөнгө оруулалтын зардал төсвийн дунд хугацааны мэдэгдэлтэй нийцэж байгаа бөгөөд цаашид тооцоо судалгаа, үндэслэл муутай хөрөнгө оруулалтыг арга хэмжээг төсөвт суулгахгүй байх нь чухал юм.

Эргэж төлөгдөх цэвэр зээл 2011 онд ДНБ-ний 1.2 хувьтай тэнцэхээр байгаа ба 2010 оныхоос дотоод цэвэр зээл 20 хувиар нэмэгдэж гадаад цэвэр 96.6 хувиар буурч төсөвт суусан байна. /Хөрөнгийн зардал, цэвэр зээлийн хувь хэмжээг хүснэгт 3.2-оос үзнэ үү./


## Хүснэгт 3.2 Хөрөнгийн зардал ба цэвэр зээл /тэрбум төгрөгөөр/

		2008		2009		2010		2011	
		тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь	тэрбум төг	хувь
Хөрөнгийн зардал		624.4	108	460.6	-26.2	607.8	31.9	844.9	39
1	• Хөрөнгө оруулалт	482.6	101.7	396.6	-17.8	522.1	31.6	688.2	31.8
2	• Их засвар	27.5	-3.1	11.7	-57.4	28.9	147	46.6	61.2
3	• Хөрөнгийн бусад зардал	94.0	1005	25.5	-72.8	18.6	-27	16.8	-9.6
4	• Гадаад төслийн зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт	20.1	-13.3	26.6	32.3	38.1	43.2	93.1	144.3
• Эргэж төлөгдөх цэвэр зээл		81.1	1.3	87.9	8.3	160.5	82.5	92.9	-42.1
1	Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	16.7	125.6	1.0	-94	74.9	7390	89.9	20
2	Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	64.5	-11.2	86.9	34.7	85.5	-1.6	2.9	-96.6

## Урсгал зардлын шинжилгээ

Улсын төсвийн зарлагад хийх шинжилгээг илүү ойлгомжтой харагдуулах үүднээс дээрхи бүдүүвч зургаар зарлагын ерөнхий бүтцийг харуулсан юм. Тус бүдүүвчид үзүүлснээр урсгал зардал хамгийн олон задаргаатай нь харагдаж байна. Иймээс ч 2011 оны улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгээс харахад урсгал зардлын эзлэх хувь хамгийн өндөр буюу 70 хувьтай байна. Харин хөрөнгө оруулалтын зардал нийт зардлын ердөө л 27 хувийг эзлэж байгаа бөгөөд эргэж төлөгдөх цэвэр зээл нь 3 хувийг эзлэж байгааг доорх / зураг 3.6/ харуулж байна.

Зураг 3.6 2011 оны улсын төсвийн нийт зарлагад зарлагуудын эзлэх хувь



Үүнийг илүү ойлгомжтой тодорхой харагдуулах үүднээс улсын төсвийн нийт зарлагад

эзлэх зардлуудыг тоо болон хувиар нь харьцуулан үзүүлбэл дараах зураглал харагдаж байна. Үүнд : /Зураг 3.7/




Иймд тэргүүн ээлжинд улсын төсвийн урсгал зардлын ерөнхий бүтцэд анализ хийх шаардлага гарч байна. Үүний тулд улсын төсвийн нийт зарлагын 70 хувийг эзлэж буй **урсгал зардлын** задаргааны өсөлт, бууралтыг бүлэглэн авч үзэх нь илүү дөхөмтэй юм. Энгийн хүний хувьд улсын төсвийн зарлага дундаас хамгийн өргөн хүрээтэй бөгөөд ойлгомжгүй, замбараагүй задаргаатай зардал нь урсгал зардал байна. Иймд, 2011 оны урсгал зардлыг эдийн засгийн ангиллаар нь бүлэглэн үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3.3 Урсгал зардлын бүлэглэсэн задаргаа /2011 он/				
Бараа, үйлчилгээний зардал	Зээлийн үйлчилгээний төлбөр	Татаас ба урсгал шилжүүлэг		
		Татаас	Урсгал шилжүүлэг	
1. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимэтгэл 3. Бараа үйлчилгээний бусад зардал: <input type="checkbox"/> Эд хогшил худалдан авах <input type="checkbox"/> Төлбөр хураамж болон бусад зардал <input type="checkbox"/> Төлөвлөсөн арга хэмжээ <input type="checkbox"/> Засгийн газрын нөөц хөрөнгө <input type="checkbox"/> Орон нутгийн хуваарилагдаагүй зардал <input type="checkbox"/> Төрийн албан хаагчдын сургалт, хурал, зөвөлгөөний зардал <input type="checkbox"/> Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс	-Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр -Дотоодын зээлийн хүү	-Эрчим хүч дулаан алдагдлын татаас - Хотын нийтийн тээврийн татаас - Хувийн хэвшлийн байгууллагад үйлдвэрлэл нэмэгдүүлэх зорилготой -Улаан буудайн татаас -Орон нутагт төсвөөс өгөх татаас - Бусад татаас	-Засгийн газар хоорондын шилжүүлэг -Төрийн бус байгууллагад олгох хандив тусламж -Өрх гэрт олгох шилжүүлэг -Хүн амын тодорхой бүлэгт үзүүлэх дэмжлэг	-Хандив тусламж -Төлбөр хураамж -Арилжааны даатгалын хураамж -Гадаад шилжүүлэг

Дээрхи хүснэгтэнд үзүүлсэн урсгал зардлын үндсэн гурван задаргаа тус бүрт төлөвлөгдсөн мөнгөн хөрөнгө нь 2011 оны улсын төсвийн урсгал зардал болох **1 их наяд 951,9 тэрбум** төгрөгөнд дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:


- Бараа, үйлчилгээний зардал – **1 их наяд 353,0 тэрбум**

- Зээлийн үйлчилгээний төлбөр – **38,1 тэрбум**
- Татаас ба урсгал шилжүүлэг – **560,7 тэрбум** /Орон нутаг, ННД, ХХС-ын татаас, шилжүүлэг ороогүй гэдгийг анхаарна уу/ төгрөгөөр тус тус улсын төсвийн урсгал зардалд тусгагдсан байна. Үүнийг хувиан үзүүлбэл дараах / зураг 3.8/ харагдана:



Өөрөөр хэлбэл, улсын төсвийн урсгал зардал дотор **бараа, үйлчилгээний зардал** 69%, татаас ба урсгал шилжүүлэг 29%, зээлийн үйлчилгээний төлбөр 2%-ийг тус тус эзлэж байгаа нь харагдаж байна. Тэгвэл өмнөх онтой харьцуулахад бараа үйлчилгээний зардал, болон зээлийн үйлчилгээний төлбөр, татаас шилжүүлэг хэрхэн өөрчлөгдсөнийг зураг 3.9-өөс үзье.

Зураг 3. 2010-2011 оны Урсгал зардлын өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)




Зураг 3.9 -өөс үзэхэд бараа үйлчилгээний зардал өмнөх оноос **21,5%**, татаас шилжүүлэг өмнөх оноос **10,4%** тус тус өссөн байгаа бол харин зээлийн төлбөр нь өмнөх оныхоос **30,5** хувиар буурсан байна. Тиймээс бараа, үйлчилгээ болон татаас шилжүүлгийн зардлын талаар дэлгэрэнгүй авч үзье.

### 3.5 Бараа, үйлчилгээний зардал

Хүснэгт 3.4-д үзүүлсний дагуу **“Бараа, үйлчилгээний зардал”** нь:

1. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил
2. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимэтгэл
3. Бараа, үйлчилгээний бусад зардал гэсэн 3 үндсэн хэсэгт хуваагдана. Бараа, үйлчилгээний зардал болох **1 их наяд 353,0 тэрбум** төгрөгийн хичнээн хувийг ямар зардал эзэлж байгааг зурагаар харуулъя. / Зураг 3.10/



Зураг 3.10-аас Урсгал зарлага дахь бараа, үйлчилгээний зардлын 53% буюу **714 тэрбум 396,4 сая** төгрөгийг нийт төрийн албанд ажиллагсадын цалин, хөлс болон нэмэгдэлд зориулах бөгөөд 5% буюу **66 тэрбум 42,2 сая** төгрөгийг ажил олгогчоос нийгмийн даатгалын санд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Харин үлдсэн 42% буюу **572 тэрбум 597,7 сая** төгрөгийг бараа, үйлчилгээний бусад зардалд зориулдаг нь харагдаж байна. Бараа, үйлчилгээний зардлыг өмнөх оны үзүүлэлтүүдтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнийг үзвэл:

/Хүснэгт 3.4 Тэрбум төгрөгөөр/

Бараа, үйлчилгээний зардал	2010	2011	Өөрчлөгдсөн хувь
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	588,3	714,4	21.4%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимэтгэл	54,7	66,4	21.3%
Бараа, үйлчилгээний бусад зардал	470,2	572,6	21.7%
Бараа, үйлчилгээний нийт зардал	1113,3	1353,4	21,5%

Дээрх хүснэгтээс үзэхэд 3 үзүүлэлтийн хувьд өсөлтийн хувь дунджаар 21хувьтай гарсан бөгөөд энэ нь төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар өсгөсөн төрийн бодлоготой холбоотой гэж үзэх үндэслэлтэй юм. Энэ өсөлт нь нийгмийн зүгээс маш их хүлээгдэж байсан зайлшгүй өсөлт бөгөөд ОУБ болон судалгааны ТББ-ын дүгнэсэн зарлагын хэт тэлэлт биш юм.

Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал нийт дүнгээрээ өмнөх оноос 21,4 хувиар өссөн дүн харагдаж байгаа ч тус зардлын нарийвчилсан задаргаанд 2010 онтой харьцуулахад буурсан зардал ч мөн байна. Тухайлбал, **үр дүнгийн урамшуулалд** зарцуулах зардал 2010 онд **14 тэрбум 26,2 сая** төгрөг байсан бол 2011 оны төсвийн төлөвлөгөөнд **11,9 сая** төгрөг болтлоо буурсан байна.

Энэ нь 2011 оны төсөвт төлөвлөгдсөн үр дүнгийн урамшуулал нь өмнөх оныхоос **14 тэрбум 14,3 сая** төгрөгөөр буурсан байгаа бөгөөд ойролцоо дүнгээр 1200 дахин буурсан гэдэг үзүүлэлт харагдаж байна. Эндээс 2011 оны төсвийн төлөвлөлтөд төрөөс баримталж буй бодлогын ерөнхий чиглэл харагдаж байх ба төр боломжтой зардлыг аль болох хэмнэх бодлого баримталсан гэж дүгнэж болохоор байна.

Бараа, үйлчилгээний зардалын 53 хувийг эзэлж байгаа цалин хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимэтгэлийн зардал 5 хувь байгаатай холбогдуулан төрийн

албан хаагчдын тоо, тэдний хөдөлмөрийн насныханд эзлэх хувь болон холбогдох бусад мэдээллийг судалж үзье.

- Төрийн албаны тухай хууль-ийн 37 дугаар зүйлийн 37.3, 37.4-р зүйл болон Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөх журам”-ын 13-т заасны дагуу төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагууд нь “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г жил ТАЗөвлөлд ирүүлэх журамтай ажээ.

ТАЗ -ийн вэбсайтанд тавигдсан мэдээллээс үзвэл, 2010 оны 1 дүгээр сарын 1 -ны байдлаар:

- ☐ Хөдөлмөрийн насны хүн амын тоо - **1704.4 мянга**
- ☐ Үүнээс, ажиллах хүч - **1137.9 мянга**
- ☐ Үүнээс - **1006.2 мянга** нь аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэгч байна.

Дээрх хөдөлмөр эрхлэгчдийн тоонд гадаадад гэрээгээр буюу Гадаад хэргийн яамны шугамаар ажиллаж байгаа хүмүүсийн тоо ороогүй байна. Нийт хөдөлмөр эрхлэгчдийн хичнээн хувь нь төрийн төсөвт /төрийн албанд/ байгууллагад ажиллаж байгааг дараах зураг харуулж байна. Үүнд:

/Зураг3.11/



Өөрөөр хэлбэл, улсын хэмжээнд нийт хөдөлмөр эрхлэгчдийн 81,6% нь хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэгчид байгаа бөгөөд үлдсэн 18,4 хувь төрийн төсөвт байгууллага болон улсын үйлдвэрийн газар ажил эрхлэгчид байна. Төрийн төсөвт байгууллага болон үйлдвэрийн газар ажил эрхлэгч болох 18,4% буюу 210,3 мянган ажил эрхлэгчдээс 175,5 мянга буюу 83,4% нь төсөвт байгууллагад, үлдсэн 16,6% буюу 34,8 мянга нь улсын үйлдвэрийн газар ажил эрхэлдэг нь зураг 3.11-ээс харагдаж байна.

Харин доорхи зургаас та төрийн нийт алба хаагчдаас хэд нь төрийн тусгай албан тушаалд хамрагдах шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдал, батлан хамгаалах, хил хамгаалах, тагнуул гэх мэт төрийн тусгай албан тушаалд ажиллаж байгаа болон эмч, багш, эрдэм шинжилгээ, үйлчилгээний ажилчид гэх мэт үйлчилгээний албанд хэд, төрийн захиргааны албанд хэд нь ажилдаг болохыг харах болно. /Зураг 3.12/<sup>58</sup>

<sup>58</sup> [http://csc.gov.mn/main/index.php?option=com\\_content&view=article&id=222:-2010-1-1-&catid=10:2010-05-17-07-39-06&Itemid=46](http://csc.gov.mn/main/index.php?option=com_content&view=article&id=222:-2010-1-1-&catid=10:2010-05-17-07-39-06&Itemid=46)





Харин нийслэлийн хэмжээнд нийт төрийн албан хаагчдын хичнээн хувийг улс төр, төрийн захиргаа, тусгай, үйлчилгээний албан хаагчид эзэлж байгааг доорхи /Зураг 3.13/<sup>59</sup> харуулж байна.



Эдгээр тоо баримтууд нь төрийн өндөр албан тушаалтны тансаг төсөв улсын төсвийн зарлагын ихэнхи хувийг эзэлж байдаг гэсэн хардлагыг няцааж байна. Тухайлбал, нийслэлийн хэмжээнд төрийн албан хаагчдын 85,5 хувь нь дундаж буюу түүнээс доош орлоготой төрийн үйлчилгээний болон тусгай албан хаагчид эзэлж байгаа бол дундаж орлоготой гэж тооцогддог төрийн захиргааны албан хаагчид 13,7 хувийг эзэлж байгаа нь дээрх зургаас тодорхой харагдаж байна.

“Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г гаргахдаа:

<sup>59</sup> [http://csc.gov.mn/main/index.php?option=com\\_content&view=article&id=222:-2010-1-1-&catid=10:2010-05-17-07-39-06&Itemid=46](http://csc.gov.mn/main/index.php?option=com_content&view=article&id=222:-2010-1-1-&catid=10:2010-05-17-07-39-06&Itemid=46)

- ☐ Насны ангилал,
- ☐ Боловсрол,
- ☐ Цалингийн тайлан байгууллагаар,
- ☐ Ангилал, зэрэглэлд хамаарах ТАХ-ийн тоо,
- ☐ Албан тушаалын дэд ангиллын албан хаагчдын тоо гэсэн 5 үзүүлэлтээр гаргадаг байна.


### 3.6 Бараа, үйлчилгээний бусад зардал

Тэгэхээр 2011 оны улсын төсвийн урсгал зардлын бараа, үйлчилгээний зардал дахь цалин, хөлс болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимэтгэлд харагдаж буй зардлын өсөлт нь зайлшгүй өсөлт байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна. Харин “Бараа, үйлчилгээний зардал”-ын 42 хувийг эзэлж буй **бараа, үйлчилгээний бусад зардлын** задаргааны өсөлт бууралтыг өмнөх онтой харьцуулж үзье.

Бараа, үйлчилгээний бусад зардалд зарцуулагдаж буй нийт зардал нь мөнгөн дүнгээрээ **2010 онд 470.2 тэрбум** төгрөг байснаас **2011 оны** төсвийн төлөвлөгөөнд **572.6 тэрбум төгрөг** буюу **102.4 тэрбум** төгрөгөөр буюу **21,7 хувиар** өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс бичиг хэрэг, гэрэл цахилгаан, түлш халаалт, тээвэр шатахуун, шуудан холбоо, цэвэр бохир ус, дотоод албан томилолт, ном хэвлэл авах, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, Эрдэм шинжилгээний ажил гэх мэт бараа, үйлчилгээний бусад зардалд өндөр хувь эзэлдэг зардлуудыг өмнөх оны үзүүлэлтүүдтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнийг үзье.

Содбаа 3.14 2010-2011 оны зардлын харьцуулалт /Тэрбум төгрөгөөр/



Зураг 3.14-өөс харахад 2011 онд гэрэл цахилгаан, түлш халаалт, тээвэр шатахуун, цэвэр бохир усны зардал нилээд хэмжээгээр өссөн харагдаж байна. Энэ нь тухайн үйлчилгээний үнийн өсөлттэй холбогдон тайлбарлагдах нь ойлгомжтой. Бусад зардлууд жигд өссөн дүнтэй байна.

“Бараа, үйлчилгээний бусад зардал”-ыг дараах байдлаар ангилж болох бөгөөд энэхүү бүлэг тус бүр нь өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнийг харъя:

/Хүснэгт 3.5 Тэрбум төгрөгөөр/

Бараа, үйлчилгээний бусад зардал	2010 он	2011 он	Өөрчлөгдсөн байдал
Эд хогшил худалдан авах	7,4	13,9	87,8 %
Төлбөр хураамж болон бусад зардал	30,7	15,06	-50.9%
Төлөвлөсөн арга хэмжээ	20,6	38,6	87,3%
Засгийн газрын нөөц хөрөнгө	20,0	20,0	өөрчлөгдөөгүй
Орон нутгийн хуваарилагдаагүй зардал	1,7	3,2	88,2%
Төрийн албан хаагчдын сургалт, хурал, зөвлөгөөний зардал	22,8	21,6	-5,2%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	35,3	52,4	48.4%

Дээрх хүснэгтээс үзэхэд бараа, үйлчилгээний бусад зардал өмнөх оныхтой харьцуулахад 21,7 хувиар өссөн харагдаж байна. Харин төлбөр хураамж болон бусад зардал 51 хувиар, Төрийн албан хаагчдын сургалт, хурал, зөвлөгөөний зардал 5,2 хувиар тус тус буурсан бол бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 48 хувиар, эд хогшил худалдан авах, төлөвлөсөн арга хэмжээний зардал, орон нутгийн хуваарилагдаагүй зардал тус тус 87-88 хувиар өссөн дүн гарчээ.

Эд хогшил худалдан авах болон, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс 50-80 хувь хүртэл өссөн нь бараа үйлчилгээний үнэ нэмэгдсэнтэй холбоотой юм.

Бараа, үйлчилгээний зардалд хийсэн анализаас харахад бараа үйлчилгээний зардлын 21,5 хувийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн хүчин зүйл нь төрийн албан хаагчдын цалингийн 30 хувийн нэмэгдэл, эрчим хүч, шатахууны үнийн нэмэгдэл зэрэг үйлчилгээний үнийн өсөлт байна гэж үзэж болохоор байна.

### Татаас ба урсгал шилжүүлэг

Татаас ба урсгал шилжүүлэг нь **урсгал зардлын 29%-ийг** эзэлж байгаа бөгөөд нийт мөнгөн дүнгээрээ **560,7 тэрбум** төгрөг 2011 оны төсөвт төлөвлөгдсөн байна. Энэ нь өмнөх оны татаас болон урсгал шилжүүлгийн зардалтай харьцуулахад **52,9 тэрбум** төгрөг буюу **10,4 хувиар** өссөн байна.

### Татаас

Татаас ба урсгал шилжүүлэгт төсөвлөгдсөн нийт мөнгөн хөрөнгийн **273,9 тэрбум буюу 48,9 хувийг** татаас, **286,7 тэрбум буюу 51,1%-ийг** урсгал шилжүүлэг эзэлж байна. 2011 оны төсөвт татаас дараах байдлаар төлөвлөгдсөн бөгөөд нийт татааст эзлэх хувь:

УНМН  
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 3.6 /Тэрбум төгрөгөөр/

Татаасын төрөл	Төлөвлөгдсөн	Нийт татааст эзлэх хувь
Эрчим хүч дулаан алдагдлын татаас	39,8	30,4%
Хотын нийтийн тээврийн татаас	30,4	
Хувийн хэвшлийн байгууллагад үйлдвэрлэл нэмэгдүүлэх зорилготой	0,4	
Улаан буудайн татаас	12,6	
Бусад татаас	190,7	69.6 %

Тэгвэл, татаасын 30,4%-ийг эзэлж байгаа татаасын төрлүүд нь өмнөх онтой харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнийг харъя.



График 3.15-д урсгал зардал дахь татаасын 30,4 хувийг эзэлж буй эрчим хүч, дулаан алдагдал, хотын нийтийн тээвэр, хувийн хэвшлийн татаас, улаан буудайн татаас, орон нутгийн төсөвт өгөх татаасын 2010, 2011 оны дүнг харьцуулан үзэхэд хотын нийтийн тээврийн татаас 30 дахин буюу **913 саяас 30 тэрбум 409 сая** төгрөг хүртэл 29,5 тэрбумаар өссөн байна. Харин үйлдвэрлэл нэмэгдүүлэх зорилготой хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас **4,7 тэрбумаас 0,4 сая** болтлоо буурсан бол, Эрчим хүч дулаан алдагдлын татаас **9,1 хувиар**, Улаан буудайн татаас **10,9 хувиар**, Орон нутгийн төсөвт өгөх татаас **11,7 хувиар** тус тус өссөн байна. Харин бусад татаас нь нийт дүнгээрээ 11,7 хувиар өссөн байна.

#### Урсгал шилжүүлэг

2011 оны төсөвт урсгал шилжүүлэг **286,8 тэрбум** төгрөг төсөвлөгдсөн байна. Энэ нь өмнөх оны урсгал шилжүүлэгтэй харьцуулахад **0,8 хувиар** өссөн дүнтэй байна. Үүнээс урсгал шилжүүлгийн төрлүүд өмнөх онтой харьцуулахад хичнээн хувиар өссөнийг дараах хүснэгтээр харуулъя.

Хүснэгт 3.7 Тэрбум төгрөгөөр/

Шилжүүлгийн төрөл	2010 он	2011 он	Өсөлтийн хувь
Засгийн газрын хоорондын шилжүүлэг	20,2	22,5	11,4%

Төрийн бус байгууллагад олгох хандив тусламж	4,06	4,6	13.3%
Өрх гэрт олгох шилжүүлэг	146,2	174,3	19.2%
Нийгмийн халамжийн зардал	122,5	137,8	12.4%
Ажил олгогчоос олгох нэг удаагийн урамшуулал	31,8	33,4	5%
Хүн амын тодорхой бүлэгт үзүүлэх дэмжлэг	106,9	63,7	-40.4%
Хандив тусламж	1,2	4,3	3.5 дахин
Төлбөр хураамж	3,2	13,9	4,3 дахин
Нийт урсгал шилжүүлэг	284,4	286,8	0,8%

Дээрх хүснэгтэнд үзүүлснээр Хүн амын тодорхой бүлэгт үзүүлэх хандив тусламж 2011 онд өмнөх оноос 40,4 % дахин буурч, хандив тусламж болон төлбөр хураамж тус бүртээ 3,5-4,3 дахин өссөн бол бусад шилжүүлгийн дүн 5-19 хувийн хооронд өссөн байна. Дээр үзүүлсэн шилжүүлэг дотор дараах шилжүүлгүүд хамгийн өндөр хувьтай байна. Тухайлбал, өмнөх онтой харьцуулахад халамжийн тэтгэвэр **20,9%**, жирэмсэн, хөхүүл эхийн тэтгэмж **20.9%**, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмж **89,8 %** тус тус нэмэгдсэн байна. Түүнчлэн, Сургалтын төлбөрийн хандив тусламж нь өнгөрсөн жилд **1,2 тэрбум** байсан бол 2011 онд **4,2 тэрбум** буюу **3 тэрбум** төгрөгөөр өссөн үзүүлэлттэй, түүнчлэн төлбөр хураамж түүн дотроо шүүхийн шийдвэрийн дагуу олгох төлбөр хураамж 18,4 сая байснаа 2011 онд **11 тэрбум** буюу **10,6 тэрбум** төгрөгөөр өссөн дүн гарсан байна.

Дээрх нэмэгдсэн шилжүүлгээс харахад сонгуулийн амлалттай холбоотой халамжийн шинж чанартай шилжүүлгийн зардлын дүн ихэвчлэн өссөн байна. Харин ахмад настуудад үзүүлэх хөнгөлөлт 13,5 %, хоол тэжээлийн тусламж дэмжлэг 4,8%, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцах дэмжлэг 38,1%, Төрийн албан хаагчийн гэр бүлд олгох мөнгөн тусламж 41,8%, бүтцийн өөрчлөлтийн улмаас чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөх олговор 78,2%, нүүлгэн шилжүүлэх зардал 100%, Хөдөлмөр, ажил эрхлэлт, ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр өгөх тусламж 67,7% гэх мэт зарим шилжүүлгүүд буурсан байна.

Өөрөөр хэлбэл буурсан зардлыг ажиглахад 2011 оны байдлаар төрийн албан хаагчдын сургалт, хурал, зөвлөгөөний зардал, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцах дэмжлэг, төрийн албан хаагчийн гэр бүлд олгох мөнгөн тусламж, бүтцийн улмаас чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох нөхөх олговор гэх мэт төрийн алба хаагчдад зориулсан зардлыг түлхүү бууруулах бодлого баримталсан нь ажиглагдаж байна.

Энэ нь төрийн нийт албан хаагчдын ихэнхи хувийг эзэлж буй төрийн үйлчилгээ, төрийн тусгай болон төрийн захиргаа гэх мэт дундаж болон түүнээс доош орлоготой иргэдэд зарцуулагдах шилжүүлэг буурсан гэсэн үг. Урсгал шилжүүлгийн зардлын тухайн бууралт нь төрийн албан хаагчдын цалингийн 30 хувийн нэмэгдэлтэй холбоотой байх үндэслэлтэй юм.

Нөгөө талаар, ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр өгөх шилжүүлгийн зардлыг 67,7 хувиар бууруулсан нь хэр оновчтой бодлого вэ гэдгийг Засгийн газар эргэж харах нь зүйтэй юм. Ажлын байр нэмэгдүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн бодит өсөлтийг хангах зорилт дэвшүүлсэн үед зайлшгүй тухайн зорилго, зорилтыг хангах үйл ажиллагаа хийгдэх болно. Гэтэл үйл ажиллагаа явуулж, ажил хийж байгаа үед ажлын цар хүрээ болон

цаг хугацаанаас хамаарч зардал нэмэгдэх нь гарцаагүй үнэн. Иймд үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг бууруулна гэдэг үйл ажиллагаа тэр хэмжээгээр явцуурч, хийгдэх ажил мөн л тэр хэмжээгээр багасна гэсэн үг. Тэгэхээр зарлага бууруулахдаа чухам ямар зарлага бууруулах вэ, ямарыг нь нэмэх вэ гэдэгт үндэслэлтэй хандах нь бодит үр дүнд хүргэнэ.

### 3.8. Хөрөнгийн зардлын шинжилгээ

2011 оны Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд **27 хувийг** эзэлж байгаа **737,9 тэрбум** төгрөгийг хэрхэн зарцуулахаар төлөвлөснийг авч үзье. Хөрөнгө оруулалтын зардал маш ойлгомжтой бөгөөд түүний ангиллыг дараах зургаар үзүүлэв.


Зураг 3.16/



Зураг 3.16 -д үзүүлсэн хөрөнгийн зардлын ангилал нь нийт хөрөнгийн зардалд ямар хувь хэмжээтэй төлөвлөгдсөнийг график 5-аар харуулсан. Тус графикт үзүүлнээр 2011 оны улсын төсвийн хөрөнгийн зардалд:

- ☐ Дотоод хөрөнгө оруулалт - 78,7%
- ☐ Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх зардал - 1%
- ☐ Газар ба материаллаг бус зүйлсийн зардал - 1,2%
- ☐ Хөрөнгийн шилжүүлгийн зардал - 6,3%
- ☐ Гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалтын зардал - 12,6 хувийг тус тус эзэлж байгааг мөнгөн дүнгээр үзүүлсэн байна.


Сбддд 3.17 2011 оны улсын төсвийн хөрөнгийн зардлын хуваарилалт /Тэрбум төгрөгөөр/



#### Дотоод хөрөнгө оруулалтын зардал

Дотоод хөрөнгө оруулалтын нийт зардал нь 2011 онд **581,4 тэрбум** төгрөг төлөвлөгдсөн байна. Энэ нь хөрөнгийн зардалд төлөвлөгдсөн нийт зардлын **78,7** хувийг эзэлж байгааг зураг 3.17-д үзүүлсэн бөгөөд өмнөх онд зарцуулсан дотоод хөрөнгө оруулалтын зардлаас **13,5** хувиар буюу **78,2 тэрбум** төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ бол сайн мэдээ юм. Учир нь Хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэнэ гэдэг нь бодит бүтээн байгуулалт нэмэгдэж,

эдийн засгийн өсөлтөд бодит нөлөө үзүүлэх сайн талтай. Дотоод хөрөнгө оруулалтад төлөвлөгдсөн 581,4 тэрбум төгрөг ямар ямар хөрөнгө оруулалтанд хичнээн хувь нь зарцуулагдахаар төлөвлөгдсөнийг дараах зурагаас харъя.



Зураг 3.18-аас харахад Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт нь дотоод хөрөнгө оруулалтын **87% буюу 508,1 тэрбум**, Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж нь **12,5 % буюу 73,0 тэрбум**, Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт нь **0,04% буюу 0,25 тэрбум** төгрөг төлөвлөгдсөн нь харагдаж байна. Эдгээр үзүүлэлт нь өнгөрсөн онтой харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнийг доорх хүснэгтээс үзье.

Хүснэгт 3.8 /тэрбум төгрөгөөр/

Дотоод хөрөнгө оруулалтын зардал	2010 он	2011 он	Өөрчлөгдсөн байдал
Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	452,0	508,1	12,4 %
Төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж	40,1	73,0	82%
Өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	2,2	0,25	-88,6%
Замын сангийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	9,0	0	0
Дотоод хөрөнгө оруулалтын нийт зардал	503,2	581,4	13,5%

Хүснэгтээс харахад өөрийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт ойролцоогоор 90% буурсан бөгөөд тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 82 хувиар нэмэгдсэн байна. Харин замын сангийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын зардал тэглэсэн байна.

#### Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх зардал

Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэхэд зориулж 2011 оны улсын төсөвт **8 тэрбум** төгрөг төлөвлөсөн бөгөөд энэ нь өнгөрсөн жилд төсөвлөгдсөн **5,7 тэрбум** төгрөгнөөс **2,3 тэрбум** төгрөг буюу **45** хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх зардал нь Хүнс, барааны нөөц, Үрийн нөөц, Өвс тэжээлийн нөөц, Шатахууны нөөцөд хичнээн хувиар төлөвлөгдсөн, өмнөх онтой харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн мэдээллийг дараах хүснэгтээс үзье. Үүнд:



Хүснэгт 3.9 /тэрбум төгрөгөөр/

Улсын нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх	2010	2011	2011 онд эзлэх хувь	Өөрчлөгдсөн хувь
Хүнс, барааний нөөц	1,04	1,7	21,2 %	63.5%
Үрийн нөөц	0,9	1	11.8%	11.1%
Өвс, тэжээлийн нөөц	0,8	2	25%	150%
Шатахууны нөөц	3	3,3	41.8%	10%
Нийт	<b>5,7</b>	<b>8</b>	<b>100%</b>	<b>40.3%</b>

Хүснэгтээс харахад нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх зардал нь нийтдээ нэмэгдсэн үзүүлэлттэй бөгөөд буурсан зардал байхгүй байгаа нь харагдаж байна. Түүнчлэн хүнс, барааны нөөц болон өвс, тэжээлийн нөөцийн эх үүсвэр нэмэгдүүлэх сангийн зардал 63,5-аас 1,5 дахин нэмэгдсэн байна. Өвс, тэжээлийн нөөцийн сан, шатахууны нөөцийн сангийн зардлын нэмэгдэлд голлох хүчин зүйл нь өвөлжилт, цас зудын хүндрэл гэж үзэх үндэслэлтэй юм.

#### Газар ба материаллаг бус зүйлсийн зардал

Хөрөнгийн зардлын **1,2%-ийг** эзэлж буй тус зардалд 2011 оны улсын төсөвт **8,9 тэрбум** төгрөг төлөвлөсөн байна. Тус зардлын хуваариалалтыг өмнөх онтой харьцуулж үзвэл:


Хүснэгт 3.10 /тэрбум төгрөгөөр/

	2010	2011	Өөрчлөгдсөн хувь
Геологи хайгуулын зардал	5,1	4	-1,9%
Ойжуулалтын зардал	4,9	4,9	өөрчлөгдөөгүй
Байгаль орчны төслийн зарлага	0,47	0	-100%

Геологи хайгуулын зардал буурсан бөгөөд байгаль орчны төслийн зардалд мөнгө төлөвлөгдөөгүй байна.

#### Хөрөнгийн шилжүүлэг болон Гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалт

Хөрөнгийн шилжүүлгийн зардал нь төсөвт газрын их засварт зарцуулагдах бөгөөд 2011 онд **46,6 тэрбум** төгрөг төлөвсөн ба энэ нь өнгөрсөн оныхоос **17,7 тэрбум** төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин, гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалтын зардлыг өнгөрсөн оныхоос **2,8** дахин нэмж **38,2 тэрбумаас 93,1 тэрбум** болтол нь өсгөсөн байна. Гадаад зээлээс санхүүжих хөрөнгө оруулалтын зардал нь дараах байдлаар хуваарилагдсан байна.



Зураг 3.19 -өөс харахад барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 2010 онд нэг ч төгрөг төлөвлөгдөөгүй бөгөөд мал аж ахуйн даатгалын зардал 2011 онд төлөвлөгдөөгүй нь харагдаж байна.

### 3.9.Орон нутгийн төсвийн зарлагын шинжилгээ

Монгол улсын засгийн газрын дунд хугацааны зорилтод засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг боловсронгуй болгон, орон нутгийн бие даасан байдлыг хангаснаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна гэж заасан байна. Монгол Улсын хувьд орон нутгийн төсвийн зарлагын хэмжээ улсын төсвийн зарлагаас харьцангуй бага байгаа нь иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг Засгийн газар голчлон санхүүжүүлдгийн илэрхийлэл юм. Сүүлийн арван жилийн дунджаар ДНБ-д улсын төсвийн зарлагын эзлэх хувь хэмжээ 33.4 хувь байгаа бол орон нутгийн төсвийн зарлагын хувь хэмжээ 6,6 хувь байна. Өөрөөр хэлбэл ДНБ-д эзлэх улсын төсвийн зарлага орон нутгийн төсвийн зарлагаас 5 дахин их байна.


Орон нутгийн хариуцан нийлүүлж байсан бүтээгдэхүүн, үйлчилгээний тодорхой хэсгийг ТБУСТ хуулиар Засгийн газар хариуцах болсноор ДНБ-д эзлэх улсын төсвийн зарлагын хэмжээ өсч харин орон нутгийн төсвийн зарлагын хувь хэмжээ 75 хувиар буурсан байна. Улс орны төвлөрсөн болон төвлөрсөн бус удирдлагатайг ДНБ-д орон нутгийн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь хэмжээгээр илэрхийлдэг. /Улсын төсөв болон орон нутгийн төсвийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг Зураг 3.20-оос харна уу/

Орон нутаг үндэсний нийт баялгийн маш бага хувийг захиран зарцуулж байгаа бөгөөд орон нутаг нь санхүүгийн талаар бие даасан бус байгаа нь үүнээс харагдаж байна. Орон нутгийн төсвийн зарлага нь 2011 онд ДНБ-ий 5.5 хувийг эзэлж байгаа нь маш бага үзүүлэлт боловч 2003-2010 он хүртлэх хугацаатай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм. Мөн улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх орон нутгийн зарлагын хэмжээ 2002 онд 30.8 хувь байсан бол 2011 оны байдлаар 10.4 хувь болж буурсан байна.

Орон нутгийн төсвийн нийт зардлын 78.2 хувийг 2008 онд, 87.5 хувийг 2009 онд, 93.7, хувийг 2010 онд, 75.0 хувийг 2011 онд тус тус төсвийн урсгал зардал эзэлж байгаа бол орон нутгийн нийт төсвийн зарлагад эзлэх хөрөнгийн зардлын хэмжээ 2008 онд 21,6 хувь, 2009 онд 12.5 хувь, 2010 онд 6.1 хувь болж буурч байсан боловч 2011 онд 24.9 болж нэмэгдсэн дүнтэй байна. ТБУСТ хууль батлагдан гарсанаас хойш орон нутгийн төсвийн зарлагын дийлэнх хувь орон нутгийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байна.


Энэ дүн сүүлийн жилүүдэд өсч орон нутгийн төсвийн зарлагын багахан хувийг эзэлдэг хөрөнгийн зардлын хувь хэмжээ буурсаар байсан боловч 2011 онд 24.9 хувь /Зураг 3.21-ээс харна уу/ болж нэмэгдсэн байна.


Зураг 3.20 Улсын ба орон нутгийн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ



Зураг 3.21

- Орон нутгийн төсвийн урсгал зардалын бүлгийн зардлуудын динамик /тэрбум төгрөгөөр/





2011 оны байдлаар нийт урсгал зардлын 41.1 хувийг бараа, үйлчилгээний зардал, 58.9 хувийг татаас ба урсгал шилжүүлэг эзэлж байна. Татаас шилжүүлэг нэмэгдэхэд орон нутгийн төсөвт өгөх татаас өнгөрсөн оноос үлэмж хэмжээгээр нэмэгдсэнтэй холбоотой өссөн байна.

Төсвийн орлого бүрдүүлэлт 2007, 2008 онуудад харьцангуй өндөр буюу орон нутагт хөрөнгө оруулалтад тодорхой санхүүжилт хийх боломжтой байсан үе бөгөөд 2009 онд болсон эдийн засгийн хямрал, төсвийн алдагдал зэргээс шалтгаалан энэ байдал муудсан ч 2011 оны төсөвт 106.6 тэрбум төгрөг буюу орон нутгийн нийт төсвийн 25 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр тусгасан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалт, их засварт зориулж нийт 95.8 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа нь хөрөнгө оруулалт орон нутаг руу чиглэж байгааг харуулж байна.

Хүснэгт 3.11

- ДНБ, нэгдсэн төсвийн зарлагад орон нутгийн зарлагын эзлэх хувь хэмжээ/тэрбум төгрөгөөр/

Он	ДНБ	Нэгдсэн төсвийн зарлага	Улсын төсвийн зарлага		Орон нутгийн төсвийн зарлага		
			тэрбум төг	ДНБ-нд эзлэх %	тэрбум төг	ДНБ-нд эзлэх %	НТЗ-д эзлэх %
2000	1044.6	429.6	292.9	28.0	136.6	13.1	31.8
2001	1115.6	489.7	415.4	37.2	154.8	13.9	31.6
2002	1240.8	548.6	450.7	36.3	168.9	13.6	30.8

2003	1461.2	615.8	585.4	40.1	50.1	3.4	8.1
2004	1910.9	752.5	711.2	37.2	68.8	3.6	9.1
2005	2779.6	764.6	717.8	25.8	79.3	2.9	10.4
2006	3714.9	1237.0	1176.7	31.7	95.5	2.6	7.7
2007	4599.5	1747.3	1652.9	35.9	121.6	2.6	7.0
2008	6130.3	2466.8	1745.5	28.5	203.3	2.6	8.2
2009	6282.7	2336.6	1746.6	27.8	268.1	4.4	11.4
2010	7168.9	3107.9	2423.1	33.8	300.5	4.1	9.6
2011	7838.6	4084.1	2782.7	35.5	427.5	5.5	10.4

### Дөрөв. Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

2011 оны нэгдсэн төсвийн тэнцэлийг өмнөх оныхоос 317,3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 779,5 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн байна. Энэ нь 2011 оны ДНБ-ний 9.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.1.

- **Монгол улсын 2011 оны нэгдсэн төсвийн тэнцэл** (тэрбум төгрөгөөр)

	2009 (Гүйц)	2010 (Тод)	2011 Төл	ДНБ-д эзлэх хувь		
				2009	2010	2011
Урсгал тэнцэл	-13.8	282.5	146.3	-0.2	3.9	1.9
Нийт тэнцэл	342.6	-462.2	-779.4	-5.4	-6.4	-9.9

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн алдагдал болох 779,5 тэрбум төгрөгийн 290.4 тэрбум төгрөг нь улсын төсөвт, -16.1 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгалын санд, харин Хүний хөгжил санд 504.0 тэрбум төгрөг, 1.2 тэрбум төгрөгийг орон нутагт тус тус хуваарилан төсвийн алдагдлыг нөхөхөд зориулж төлөвлөсөн байна.

### Хүснэгт 4.2. 2011 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт (тэрбум төгрөгөөр)

	2010 тод	Өөрчлөлт	2011	
			Төл	ДНБ-д эзлэх хувь
• Нэгдсэн төсөв	462.2	317.3	779.5	9,9
• Улсын төсөв	282.6	7.8	290.4	3,7
• НДС	-7.3	-8.7	-16.1	-0,2
• ХХС	183.9	320.1	504.0	6,4
• Орон нутаг	3.0	-1.8	1.2	0,0

Эх сурвалж: Сангийн яам

Монгол улсын 2011 оны төсвийн нийт алдагдлын ДНБ -д эзлэх хувийг 9,9 болгон төсөвлөсөн нь 2010 оны тодотголд төсвийн тэнцэлийн ДНБ -д эзлэх хувь 6.4 байснаас өссөн (Хүснэгт 4.1) ба энэ үзүүлэлт нь УИХ-аас баталсан Төсвийн Дунд Хугацааны Мэдэгдэлтэй (ТДХМ) нийцэхгүй байгаа юм. (Хүснэгт 4.3) Тухайлбал, ТДХМ -д төсвийн алдагдлын дээд хязгаарыг 5 хувь байна гэж заасан байхад бараг хоёр дахин их хувиар баталсан нь маш хол зөрүүтэй байна.

Хүснэгт 4.3.

- **Монгол Улсын 2011 оны ТДХМ, 2012 - 2013 оны Төсвийн төсөөллийн үзүүлэлт (ДНБ -д эзлэх хувиар)**

	ТДХМ 2011	ТДХМ 2012	ТДХМ 2013
Төсвийн нийт орлогын доод хязгаар	35.4	35.4	30.3
Төсвийн нийт зарлагын дээд хязгаар	40.4	39.4	32.3
Төсвийн нийт алдагдлын дээд хязгаар	-5.0	-4.0	-2.0
Хөрөнгө оруулалтын зардлын доод хязгаар	6.3	6.0	4.7

Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын 2010 оны 40 дүгээр тогтоол


Түүнчлэн төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу 2013 оноос эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ний 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх гэсэн заалтыг баримтлана. Үүнийг баримтлахын тулд одоогийн төсвийн алдагдлыг 2013 он гэхэд 7,9 % бууруулах шаардлагатай болно.

Тиймээс цаашид 2012-2013 оны төсвийн алдагдлыг ТДХМ-д заасан шиг хэмжээгээр бууруулах боломж тун багатай гэж үзэж байна. Учир нь 2003 оноос хойш төсвийн алдагдлын үзүүлэлтээс харахад төсвийн алдагдал сонгуулийн жилүүдэд их хэмжээгээр өсдөг нь харагдаж байна. Тухайлбал, өмнөх сонгуулийн жил болох 2008 онд төсвийн алдагдал 2007 оны алдагдлаас 7,7 хувиар нэмэгдэн ДНБ -ний 4,8% болж өссөн үзүүлэлттэй гарж байсан байна. Хэрэв алдагдал ҮНБ-ний 2-3 хувийг эзэлж байвал эдийн засгийг хямраагүй гэж, харин алдагдал 10 хувиас хэтэрвэл эдийн засаг хүчтэй хямарч байна гэж үздэг байна.

Зураг 4.1 дээрээс харахад зөвхөн 2005-2007 онуудаас бусад онуудад төсвийн алдагдалтай гарсан ба 2008 оноос эхлэн төсвийн алдагдал нэмэгдсээр 2011 онд 779.5 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна. Үүний гол шалтгааныг төсвийн урсгал зарлагын өсөлттэй шууд холбоотой гэж үзэхээр байгаа бөгөөд үүнд төрийн албан хаагчдын цалингийн 30 хувийн нэмэгдэл, эрчим хүч, шатахууны үнийн нэмэгдэл зэрэг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт, татаас ба зарим урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос өссөн зэрэг гол нөлөөлж байна.

УИХ-ЫН  
СУДАЛГААНЫ САН

Зураг 4.1. 2003 - 2011 онуудын төсвийн алдагдлын хэмжээ (тэрбум төгрөгөөр)



Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт 4.4. 2011 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилбал

Эх үүсвэр	2011 оны тодотгол /Тэрбум төгрөг/	ДНБ-д эзлэх хувь	Нийт санхүүжилтийн эзлэх хувь
• Нэгдсэн төсвийн алдагдал	779.5	9.9	100
• Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	17.8	0.2	2
• Засгийн газрын урт хугацаатай бонд	92.4	1.2	12
Засгийн газрын зээл	83.5	1.1	11
Урьдчилгаа төлбөр	470.9	6.0	60
Өмч хувьчлал	114.8	1.5	15

Эх сурвалж: Сангийн яам

Эдгээр санхүүжилтын эх үүсвэрүүдээс харахад Монгол улсын 2011 оны төсвийн төлөвлөсөн 9,9 хувийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд бэрхшээлтэй байгаа ба санхүүжилтын ихэнхийг бүрдүүлж байгаа уул уурхайн томоохон гэрээнээс авах урьдчилгаа төлбөр, өмч хувьчлалын орлого Засгийн газрын зээл, Засгийн газрын шинээр гаргах бондоос хамаарна. Гэвч эдгээр эх үүсвэрээс санхүүжүүлэх нь дараах сөрөг хандлага үзүүлэх магадлалтай. (Хүснэгт 4.4) Үүнд:

- **Урьдчилгаа төлбөр**

Энэ жилээс эхлэн Засгийн газар уул уурхайн гэрээнээс ДНБ-ий 6 хувьтай тэнцэх хэмжээний (470.9 тэрбум төгрөг) урьдчилгаа авахаар тооцсон. Үүнээс 132 тэрбум төгрөгийг Оюу толгой төслийн урьдчилгаа төлбөрөөс гаргана. Их хэмжээний урьдчилгаа авахаар гэрээ байгуулах тохиолдолд засгийн газрын эрх мэдлийг бууруулах магадлалтай.

- **Өмч хувьчлал**

ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэх хэмжээний (114.8 тэрбум төгрөг) орлогыг өмч хувьчлалаас, түүний дотор Төрийн банкны хувьчлалаас цуглуулахаар төлөвлөсөн.




Төрийн банкны хувьчлалын асуудлыг төсвийн төсөлд тусгаснаар өмч хувьчлалыг дуусгавар болгосон байх ёстой хугацааг зааж өгч, засгийн газрын гэрээ хэлэлцээр явуулах эрх хэмжээг сулруулж байна.

- **Засгийн газрын зээл**

Өнгөрсөн онд төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон Япон Энэтхэг улсаас 200.1 тэрбум төгрөгийн зээл авсан байна. Мөн Лондонгийн Стандарт банкаар дамжуулан Засгийн газрын бондыг олон улсын зах зээлд арилжаалж 66.2 сая ам.доллар буюу 94.7 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг алт олборлох үйл ажиллагааг дэмжих зорилгоор арилжааны банкуудад дамжуулан зээлдүүлсэн.

Гадаад зээлийн үлдэгдлийн 35 хувийг Азийн хөгжлийн банк, 22 хувийг Дэлхийн банк, 21 хувийг Япон улсаас авсан зээл эзэлж байгаа бол үлдэх 22 хувийг бусад 19 зээлдэгчээс авсан зээл эзэлж байна (Зураг 4.2).



Зураг 4.2. Гадаад зээлийн үлдэгдэл

Монгол Улс 2011-2012 онуудад гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн зээлээр 1,103.8 тэрбум төгрөгийн зээл авч ашиглахаар байгаа бөгөөд эдгээрийн дийлэнхи хувь нь зам, эрчим хүч, уул уурхайн хөгжлийг дэмжихэд зориулагдахаар байна. Харин 2011 оны төсвийн алдагдлыг нөхөхөд зориулж 83.5 тэрбум төгрөгийн засгийн газрын зээл шаардлагатай, энэ нь нийт ДНБ-ний 1.1 хувийг эзэлнэ. 2011 оны төсвийн алдагдлыг нөхөхөөр төлөвлөсөн Засгийн газрын зээлийг өмнөх он болох 2010 оны Засгийн газрын зээл болох 121.5 тэрбум төгрөгтэй харьцуулбал 38.0 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй төсвийг баталсан байна.

- **Засгийн газрын бонд**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 77 дугаар тогтоолын хүрээнд 2009 оны 12 дугаар сарын 31-ны өдөр Монгол Улсын төсвийн улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдал болон төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 170.0 тэрбум төгрөгийн 3 төрлийн Засгийн газрын үнэт цаас гаргаж, гэрээний үндсэн дээр Монгол банкинд арилжаалсан. Монгол улс өнөөгийн байдал болон цаашдын хандлагыг харгалзаж үзээд 137 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хүүгийн хамт хугацаанаас нь өмнө төлж барагдуулсан.

Засгийн газраас бонд гарган арилжааны банкуудад арилжаалж, Хөгжлийн банкинд зээл олгох нь бондын эргэн төлөлтийн тал дээр төсөвт хүндрэл үүсгэх магадлал өндөр. Тухайлбал, Хөгжлийн банкинд олгох зээл нь хугацааны хувьд Засгийн газрын бондоос урт байх тохиолдолд эргэн төлөлтийн нөхцөлд төсөвт эх үүсвэр тал дээр хүндрэл учруулах эрсдэл бий. Түүнчлэн Засгийн газраас 2011 онд 800 тэрбум төгрөгийн бонд гаргахад төсөвт 2012-2015 онуудад тус бүр 64 тэрбум төгрөг, 2016 онд 864 тэрбум төгрөг, тус бондыг гаргаснаас нийт дүнгээр төсөвт 1,120 тэрбум төгрөгийн дарамт тус тус үүсэхээр байна.

Монгол улс 2011 онд 92.4 тэрбум төгрөгийн Засгийн газрын урт хугацаатай бонд

гарган төсвийн алдгадлыг нөхөхөд зориулахаар төлөвлөсөн байна. Энэ нь ДНБ-ний 1,2 хувийг эзэлнэ.

**Үүнээс гадна төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд дараах боломжууд байдаг. Үүнд:**

Валютын нөөцөө ашиглах, алт болон үнэт металл, түүхий эдээр төсвийн алдагдлыг нөхөх арга, татварыг нэмэгдүүлэх, шинээр мөнгө хэвлэн гаргах, дотоод зээллэг гаргах зэрэг аргууд байдаг.

Монгол улсын 2011 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрүүдэд хийсэн дээрх анализаас үзэхэд урьдчилгаа төлбөрөөр болон өмч хувьчлалаар санхүүжүүлснээр засгийн газрын эрх мэдлийг бууруулж болох эрсдэлтэй ба мөн Засгийн газрын зээл, Засгийн газрын бонд их хэмжээгээр гаргаснаар цаашид төсөвт дарамт учруулах эрсдэлтэй, тиймээс цаашид төсвийн алдагдлыг санхүүжүүлэх бусад боломжуудыг ашиглаж болно.

**Тав. Монгол Улсын 2011 оны төсөв макро эдийн засагт нөлөөлөх нөлөөлөл**

**5.1. Эдийн засгийн бодит өсөлт:**

2008 - 2009 онд дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэн ашигт малтмалын үнэ болон экспортын эрэлт огцом унасан явдал Монгол улсын эдийн засагт гаднаас хүндхэн цочрол болж туссан. Энэхүү цочрол нь тус улсын эдийн засгийн бүтэц ба бодлогын орчинд оршиж байсан сул талуудыг улам даамжруулсан. Тухайлбал, хямралд өртсөнөөр тус улсын төсвийн нөхцөл байдал ашигт малтмалын орлогоос улам бүр хараат болж ирсэн бөгөөд өсөлтийн жилүүдэд зохистой хөрөнгө нөөцөлж хуримтлуулах бодлого авч хэрэгжүүлээгүй буюу тогтворгүй, үр ашиггүй зарцуулалт үлэмж нэмэгдсэн.

2009 оны II хагаст Засгийн газраас хямралын эсрэг төсөв, мөнгө, валютын ханш, санхүүгийн бодлогын чиглэлээр чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсэн ба 2009 онд Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулснаар уул уурхайн салбарын шинэчлэл болон хөгжилд бодитой ахиц дэвшлийг авчирсан юм.

Түүхий эдийн үнэ болон Хятадын импортын өсөлт сэргэх зэргээр гадаад нөхцөл байдал сайжирсан нь төр засгийн бодлогын арга хэмжээнд сайнаар нөлөөлж, 2009 оны дунд үеэс эдийн засгийн байдал даруй тогтворжих хандлагатай болж ирсэн. Гэвч 2008 онд ДНБ-ий бодит өсөлт 8.9% байсан бол 2009 онд 1.3 хувиар буурч харин 2010 онд 6.1 хувь болж өссөн байна.

Оюу Толгой, Тавантолгойн уул уурхайн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр Монгол улсын өсөлт цаашид тааламжтай байх төлөвтэй байна.<sup>60</sup> Уул уухайн салбараас шалтгаалан ирэх гурван жилд манай улсын эдийн засгийн өсөлт 8-10 орчим хувь байхаар тооцоолж байна. Тухайлбал, "Fitch Ratings"-ийн шинжээчид манай эдийн засгийн өсөлт 2011-2012 онд өсөх зам руугаа орно хэмээн онцолжээ. Тус байгууллагын шинжээчид "2011 онд дотоодын нийт бүтээгдэхвн 7.5 хувь, 2012 онд 8.0 хувиар өснө" хэмээн үзэж буй юм.

Мөн Хятадын түүхий эдийн эрэлт жил ирэх бүр нэмэгдэж буй нь манай уул уурхайн салбарт хамгийн их хөрөнгө оруулалт татаж, борлуулалт нэмэгдэх хандлагатай байна. Учир нь, 2010 онд манай экспортын бүтээгдэхвний 73 хувь нь БНХАУ-руу гарсан бөгөөд манай улсын хувьд БНХАУ-ын нийрсний импортын 30 хувийг бүрдүүлж, цаашид манай улс жилд 20 сая тонн нийрс олборлох төлөвлөгөөний дагуу нийрсний хэрэгцээний 40 хувийг хангах боломжтой.

<sup>60</sup> <http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/COUNTRIES/EASTASIAPACIFICEXT/MONGOLIAINMONGOLIANEXTN/0,,contentMDK:22806493~menuPK:475489~pagePK:2865066~piPK:2865079~theSitePK:475350,00.html>

Манай эдийн засгийн өсөлтийн нэг шалтгаан бол Оюутолгой орд. Тус орд 2013 оноос ашиглалтад ороод эхэлбэл жилд 3.5 тэрбум ам.долларын бүтээгдэхүүн гаргах тооцоо бий. Энэ нь өнөөдрийн байдлаар манай дотоодын нийт бүтээгдэхүүний 90 хувьтай тэнцэх юм.

Монгол улсын 2011 оны төсвийн бодлогын гол чиглэл нь ирэх жилүүдийн эдийн засгийн өсөлтийн суурийг оновчтой бүрдүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийг татварын болон бодлогын бусад арга хэрэгслээр дэмжих, улмаар уул уурхайгаас хэт хамааралтай болж буй эдийн засгийн бүтцийг аажмаар өөрчлөх, жижиг дунд үйлдвэрлэл, түүн дотроо дотоодоос түүхий эдээ хангадаг үйлдвэрлэлийн салбарыг хөхиүлэн дэмжих замаар ажилгүйдлийг бууруулах асуудал юм. 2011 оны төсөвт зэсийн үнийг 5983.1 ам.доллар, боловсруулсан нүүрсний үнэ 98.8 ам.доллараар тусгасан байна. Дэлхийн зах зээл дээрх цэвэр зэсийн үнэ 2011 онд дунджаар 8425.0 ам.долларт байхаар тооцсон. Үүнтэй уялдаад уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимтэй оруулж улс орныг үйлдвэржүүлж, хүн ардынхаа аж амьдралыг богино хугацаанд дээшлүүлэх зорилт тавигдаж байна.<sup>61</sup>

Оюу толгой төслийн ойрын ирээдүйн төлөв, түүнийг дагасан бүтээн байгуулалтын ажил хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн бусад салбарын өсөлтийг ч түргэсэж байна. Мөн түүнчлэн Таван толгойн нүүрсний ордыг ашиглахаар төлөвлөж байгаа нь уул уурхайн салбарт хийгдэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг ойрын жилүүдэд нилээд өсгөнө.

Ийнхүү уул уурхайн салбарт төслүүд хэрэгжихтэй холбоотойгоор манай улс руу чиглэх валютын дотогшлох урсгал төлбөрийн тэнцлийн хөрөнгийн дансыг өсгөж, төгрөгийн ханшид чангарах дарамт учруулж эхлээд байна. Аж ахуй эрхлэгчид, хэрэглэгчдийн идэвхи дээшилж, хөрөнгийн дотогшлох урсгал хурдан өсч банкны салбар сэргэхийн зэрэгцээ ханшийн хэт чангаралтыг саармагжуулах арга хэмжээ авснаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, зээлийн өсөлтийг хурдасгах нөхцлийг бүрдүүлж байна. Манай улсын импортын өсөлт экспортоос илүү хурдацтай байхаар байна.

Уул уурхай, дэд бүтцийн үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэн импортын хэмжээг ихээр өсгөж байна. Мөн түүнчлэн төгрөгийн ханш чангарч буй нь импортын өсөлтийг тэтгэхийн зэрэгцээ өрхийн орлогын өсөлтийг даган импорт мөн өсч байна. Үүний улмаас урсгал тэнцлийн алдагдал 2010, 2011 онуудад ихээхэн өсч энэүү алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр байна.

2011 онд эдийн засгийн өсөлтийн хурд бага зэрэг саарах төлөвтэй байгаа нь улсын нэгдсэн төсвийн орлого зарлагатай холбоотой байна. 2011 оноос уул уурхайн салбарын гэнэтийн ашгийн татварыг зогсоох нь төсвийн орлогыг ДНБ-ний 2 хувьтай тэнцэх хэмжээгээр багасана гэж тооцоолж буй, мөн донор орнуудын төсвийн санхүүжилт буурахаар хүлээж байгаа нь төсвийн орлогыг бууруулж байна.

Эдийн засгийн өндөр өсөлт, хувийн секторын идэвхжилттэй зэрэгцэн хөрөнгө оруулалтаас илүүтэйгээр хэрэглээг дэмжсэн байдлаар төсвийн зардал ихээхэн нэмэгдвэл инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлж, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлөх хандлагатай байна. ДНБ-ний бодит өсөлт 2005 - 2008 онуудад дунджаар 8.7 хувь, 2009 онд -1.6 хувь байсан бол 2010 онд 6.1 хувь болж өссөн байна.

<sup>61</sup> [www.mof.gov.mn-Монгол](http://www.mof.gov.mn-Монгол) Улсын 2011 оны төсвийн танилцуулга

## Хүснэгт 5.1. ДНБ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр Тэрбум төгрөгөөр

	2005	2006	2007	2008	2009
• ДНБ	2779.6	3017.4	3325.9	3622.7	3913.7
• Өсөлт, %	7.3	8.6	10.2	8.9	-1.3
• Хөдөө аж ахуй	608.3	654.1	757.5	801.2	813.5
• Өсөлт, %	10.7	7.5	15.8	5.8	1.5
• Уул уурхайн	608.2	646.3	665.0	645.9	669.8
• Өсөлт, %	10.6	6.3	2.9	-2.9	3.7
• Боловсруулах	102.0	115.6	149.1	154.7	137.5
• Өсөлт, %	-19.5	13.4	29	3.8	-11.1
• Цахилгаан эрчим хүч	80.0	83.6	89.9	98.2	101.9
• Өсөлт, %	0.5	4.5	7.5	9.2	3.8
• Барилга	58.8	61.8	67.1	58.4	29.9
• Өсөлт, %	15.6	5.1	8.5	-13.0	-48.8
• Худалдаа	227.0	261.8	279.4	324.7	238.4
• Өсөлт, %	2.5	15.3	6.7	16.2	-26.6
• Тээвэр холбоо	309.1	346.4	438.6	528.6	592.3
• Өсөлт, %	22.5	12.1	26.6	20.5	12.1
Бусад үйлчилгээ	474.4	464.4	469.9	518.7	580.6
Өсөлт, %	4.7	-2.1	1.2	10.4	11.9
Бүтээгдэхүүний цэвэр татвар	311.7	383.4	409.5	480.2	400.4
Өсөлт, %	1.2	23	6.8	17.5	-16.6

## 1. Эдийн засгийн өсөлтийн тооцоолол:

Монгол Улсын 2011 оны улсын нэгдсэн төсвийн эдийн засгийн өсөлтөнд нөлөөлөх нөлөөллийг дараахь байдлаар тооцлоо. Кейнсын онолоор эдийн засгийн өсөлтийг эрэлтийн хүчин зүйлийн үүднээс авч үздэг. Тэд ҮНБ-ий өсөлтийг хангаж чадахгүй байгаа нийлмэл зардлын түвшнээр өсөлтийн хурдац бага байгааг тайлбарладаг. Иймээс тэд хүүгийн хэмжээ бага байх явдлыг /хямд мөнгөний бодлого/ хөрөнгө оруулалтыг урамшуулах хэрэгсэл гэж үздэг. Хөрөнгө оруулалтын өндөр түвшинг инфляци үүсгэхээргүй байлгахын тулд шаардлагатай бол Засгийн газрын зардал ба хэрэглээг хязгаарлах санхүү-төсвийн бодлого ашиглаж болдог. Өөрөөр хэлбэл Кейнсын онолоор Засгийн газрын зардал буюу улсын төсвийн зарлагын өсөлтөөс хамааран эдийн засаг өсдөг буюу төсвийн зарлага, эдийн засгийн өсөлтийн хооронд шууд хамаарал байдаг гэж үздэг.

Хэдий эдийн засаг өсч байгаа ч гэсэн төсвийн зарлага өсөх нь инфляцид нөлөөлөх гээд байдаг. Яагаад зардлын өсөлт нь инфляцийг өсгөх шалтгаан болдог вэ гэхээр төсвийн зардал өсөх нь улсын төсвөөс хийж буй хөрөнгө оруулалтын зардал, улсын төсвийн урсгал зардал гэсэн 2 талтай гэж үзэж болно. Улсын төсвөөс хийж буй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхгүйгээр урсгал зардлыг нэмэгдүүлснээр инфляцийг нэмэгдүүлэх хүчин зүйл

болдог.

Хэрвээ улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал өсвөл энэ нь инфляцид нөлөө үзүүлэхгүй, харин урсгал зардал нэмэгдсэн нь инфляцийг өсгөх нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Тухайлбал: Хиний хөгжил сангаас иргэн бүрт олгож буй 21000 төгрөг буюу нийт 805 тэрбум төгрөгөөр үйлдвэр байгуулж, 3000 хүнийг ажлын байраар хангалаа гэж бодвол энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг өсгөж, эргээд энэ нь эдийн засгийн бодит өсөлт буюу экстенсив өсөлтийг бий болгосноор инфляцид үзүүлэх нөлөөлөл бага байх болно.

Харин үүний оронд 21000 төгрөгийг иргэн бүрт бэлэн мөнгөөр тарааснаар төсвийн хөрөнгө оруулалтын зардал бус урсгал зардал нэмэгдэж, мөн иргэдээс мөнгөө хуримтлал болгон хадгалах явдал нь бага бөгөөд хоол хүнсэндээ ихэвчлэн зарцуулдаг тул сөргөөр нөлөөлж инфляцийг өсгөх хүчин зүйл болно.

Дээрх байдлаас үзэхэд манай нөхцөлд экстенсив<sup>62</sup> бодит өсөлтийн оронд голчлон интенсив өсөлт буюу хий өсөлт бий болоод байна. Бэлэн мөнгө тарааснаар өсөлтөд бодитой харагдах зүйл байна уу. Бид 21000 төгрөгөө өдөр тутмын хоол, хүнс гэх мэтийн зардалд зориулж байгаа учраас үүнийг даган бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж хий өсөлтийг бий болгож байна.

Харин үүний оронд зам барих, үйлдвэр байгуулах зэрэг хөрөнгө оруулалтын ажлыг түлхүү хийвэл экстенсив өсөлтийг бий болгож инфляцийг хөөрөгдөхгүй.

ДНБ-ний цэвэр өсөлтийг дараахь томъёогоор тооцдог болно:

$$GDP = C + I (I^f + I^d) + G (I^g + G^g) + NX$$

C - Өрхүүдийн зарлага /Хувийн зардал/

I - Хөрөнгө оруулалт

I<sup>f</sup> - Гадаадын хөрөнгө оруулалт

I<sup>d</sup> - Дотоодын хөрөнгө оруулалт

G - Төсвийн байгууллагын зардал буюу төсвийн зардал

NX - Цэвэр экспорт

### 5.3. Эдийн засгийн өсөлт ба инфляци:

Хөгжсөн болон хөгжиж буй орнуудын алинд ч макро эдийн засгийн бодлогын гол зорилго нь эдийн засгийн өндөр өсөлтийг доогуур инфляцийн түвшинтэй хослуулан барих явдал юм. Өнгөрсөн онд эдийн засгийн ихэнх салбарт өсөлт мэдрэгдэж, 2009 онд 1.3 хувиар буурсан дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээ 6.1 хувиар нэмэгджээ. Харин хөдөө аж ахуйн салбарт өнгөрсөн жилийн зудын гамшиг нөлөөлснөөр 11 сая мал хорогдож, 2010 оны сүүлийн гурван улиралд хамгийн олон хувиар буурсан байна.

2009 - 2010 оны статистик мэдээллээс үзвэл Хятад, ОХУ зэрэг манай улсад элсэн чихэр, будаа болон хүнсний зарим шаардлагатай бүтээгдэхүүн нийлүүлэгч гол бүс нутагт хүнсний бүтээгдэхүүний үнэ өсч байгаа аж. Энэ нь Монголд дарамт болж, улмаар инфляцийг хөөрөгдөж болзошгүй байгаа юм.

Харин дотоодын хүнсний бүтээгдэхүүний зах зээл сул байгаагаас 2010 онд махны үнэ багагүй өссөн бөгөөд энэ нь гадаадаас импортолдог хүнсний бүтээгдэхүүний үнийн дарамт, дотоод зах зээлийн сөрөг үр дүнг авчирах боломжтой юм. Өөрөөр хэлбэл онолын

<sup>62</sup> Экономикс Кэмпбелл Р.Макконнелл, Стэнли Л.Брю

үүднээс авч үзэхэд эдийн засаг өсөхийн хирээр инфляци мөн адил өснө, инфляци өндөр байхад ажилгүйдэл бага, инфляци бага байхад ажилгүйдэл өндөр байдаг ба инфляци ажилгүйдлийн хооронд урвуу хамаарал байдгийг А. В. Филиппс нотолсон байдаг.


Мөн ажилгүйдэл 1 хувиар өсөхөд, ДНБ-ний алдагдал 2,5 хувь байдаг бөгөөд үүнээс эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл урвуу хамааралтай болохыг Оукен нотолсон зэрэг онолууд байдаг. Зарим судлаачдын хийсэн судалгаа, тооцооллоор Эдийн засгийн өсөлт, инфляцийн хоорондын хамаарлын талаар янз бүрийн байр суурийг илэрхийлсэн байдаг.

Тухайлбал, инфляцийн түвшин өндөр орнуудад эдийн засгийн өсөлт доогуур байдаг, инфляцийн түвшин 10 нэгж хувиар нэмэгдэхэд, нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээ жилд 0,2-0,3 нэгж хувиар буурч байдаг гэжээ. Мөн зарим эмпирик судалгаагаар инфляци тодорхой түвшнээс доогуур байхад эдийн засгийн өсөлтөд ямарч нөлөөгүй, урт хугацаанд өсөлтөд нөлөө үзүүлэхгүй, богино хугацаанд сөрөг нөлөө үзүүлдэг, инфляци 8 хувиас бага үед өсөлтөд нөлөө үзүүлдэггүй, 8 хувиас их үед хүчтэй сөрөг хамааралтай гэж үзсэн байна.

Тэгвэл манай орны сүүлийн 10 жилийн эдийн засгийн өсөлт ба инфляцийн түвшний хооронд ямархуу хамаарал байна вэ гэдгийг зургаас харъя. Зураг болон хүснэгтээс харахад манай орны сүүлийн 10 жилийн инфляцийн түвшин, эдийн засгийн өсөлтийн хооронд ямар нэгэн хамаарал тэр дундаа урвуу гэх хамаарал ажиглагдахгүй байна.

Зураг 5.1.

- Дотоодын нийт бүтээгдэхүүн ба Инфляцийн хоорондын хамаарал (2001 - 2010, хувиар)



	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Инфляци	8.0	1.6	4.7	11.0	9.5	6.2	17.8	22.1	4.2	13.0
ДНБ	1.0	3.9	7.0	10.6	7.3	8.6	10.2	8.9	-1.3	6.1

Монгол Улсын хувьд инфляци, эдийн засгийн өсөлтийн динамик Зураг 5.1-ээс харахад ямар нэг хамааралгүй ажиглагдахгүй байна. 2001 - 2010 он хүртлэх хугацаанд эдийн засаг дунджаар 6.9 хувиар өссөн байхад инфляци 9.2 хувиар өссөн байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт өндөр гарах бүрт инфляцийн түвшин нэг оронтой тоонд, доогуур түвшинд байсан нь ажиглагдаж байна. Тиймээс инфляцийн түвшнийг таамаглахын тулд Төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хувь, нийт мөнгөний өсөлтийн хувь, болон махны үнийн өсөлтийн хувь нь нөлөөлөх хүчин зүйлс гэж үзэн олон хүчин зүйлсийн регрессээр тооцоолъё.

Хүснэгт 5.2.

Он	Y = инфляцийн түвшин	X <sub>1</sub> = Төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хувь	X <sub>2</sub> = M2 нийт мөнгөний өсөлтийн хувь	X <sub>3</sub> = махны үнийн өсөлтийн хувь
2000	8,1	29,7	17,5	12,4
2001	8,0	31,6	27,9	14,8
2002	1,6	31,2	42	14,8
2003	4,7	37,9	49,5	18,3
2004	11,0	37,3	20,4	22,6
2005	9,5	37,0	34,6	16,51
2006	6,2	36,6	34,8	16,39
2007	17,8	34,4	56,3	19,75
2008	22,1	35,4	-5,5	21,84
2009	4,2	31,7	26,9	20,14
2010	13	36,9	62,5	28,9
2011	9,0	42,2	50,0	30,0

SUMMARY OUTPUT								
Regression Statistics								
Multiple R	0,570172							
R Square	0,325096							
Adjusted R Square	0,072006							
Standard Error	5,59392							
Observations	12							
ANOVA								
	df	SS	MS	F	Significance F			
Regression	3	120,5845	40,19482	1,28451	0,344031			
Residual	8	250,3355	31,29194					
Total	11	370,92						
	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
Intercept	5,956915	17,49782	0,340438	0,742294	-34,3931	46,30696	-34,3931	46,30696
X Variable 1	-0,16294	0,677009	-0,24068	0,815858	-1,72413	1,398243	-1,72413	1,398243
X Variable 2	-0,11623	0,109398	-1,06242	0,319061	-0,3685	0,136045	-0,3685	0,136045



X Variable 3	0,682279	0,576523	1,183437	0,270607	-0,64719	2,011743	-0,64719	2,011743
--------------	----------	----------	----------	----------	----------	----------	----------	----------

Дээрх тооцооллоос харахад инфляцийн түвшинд махны үнэ огцом өсөлт хамгийн ихээр нөлөөлөхөөр байна. Тухайлбал: 2011 онд зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт 70,0 хувьтай, махны үнэ өнгөрсөн оны түвшинд буюу 28,9 хувь байна гэж тооцъё.

**2011 оны Инфляцийн түвшин =**

$$= 5.956915 - 0.16294 * 42.2 - 0.11623 * 70.0 + 0.682279 * 28.9 = 10.4$$

Махны үнийг энэ оны түвшинтэй адил байна гэж үзвэл ирэх жил инфляцийн түвшин 10,4%, махны үнэ өмнөх оныхоос өсч 35 хувьтай байвал 14,8%, махны үнэ 40,0 хувиар өснө гэж таамаглавал инфляцийн түвшин ирэх онд 18,2 хувьтай байхаар байгаа бөгөөд махны үнийн өсөлт нь инфляцийг хамгийн ихээр хөөрөгдөж байна гэж үзэж болохоор байна.

Инфляцид төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хувь, зах зээл дахь нийт мөнгөний нийлүүлэлт, махны үнийн өсөлт, ДНБ-нд эзлэх төсвийн урсгал зардал нөлөөлнө гэж үзье. Эндээс

Хүснэгт 5.3

Он	Y = инфляци	X <sub>1</sub> = Төсвийн зарлагын ДНБ -нд эзлэх хувь	X <sub>2</sub> = Нийт мөнгөний өсөлтийн %	X <sub>3</sub> = Махны үнийн өсөлт	X <sub>4</sub> = Төсвийн урсгал зарлагын ДНБ -д эзлэх хувь
2000	8,1	42,2	17,5	12,4	30,8
2001	8,0	43,9	27,9	14,8	32,9
2002	1,6	42,1	42	14,8	33,3
2003	4,7	44,2	49,5	18,3	30,5
2004	11,0	39,3	20,4	22,6	27,5
2005	9,5	33,7	34,6	16,51	21,2
2006	6,2	33,3	34,8	16,39	26,4
2007	17,8	32,0	56,3	19,75	29,7
2008	22,1	40,2	-5,5	21,84	29,3
2009	4,2	37,1	26,9	20,14	29,6
2010	13	43,3	62,5	28,9	32,6
2011	9,0	52.1	70,0	30,0	40,2

SUMMARY OUTPUT							
Regression Statistics							
Multiple R	0,698918						
R Square	0,488486						
Adjusted R Square	0,147477						
Standard Error	5,620346						

Observations	11							
ANOVA								
	df	SS	MS	F	Significance F			
Regression	4	180,9976	45,24939	1,432474	0,329966			
Residual	6	189,5297	31,58828					
Total	10	370,5273						
	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95,0%	Upper 95,0%
Intercept	10,98492	17,73598	0,619358	0,55845	-32,4135	54,38331	-32,4135	54,38331
X Variable 1	-0,59999	0,578379	-1,03736	0,339556	-2,01523	0,815257	-2,01523	0,815257
X Variable 2	-0,15023	0,1005	-1,49481	0,185589	-0,39614	0,095687	-0,39614	0,095687
X Variable 3	0,800356	0,398079	2,010545	0,091086	-0,17371	1,77442	-0,17371	1,77442
X Variable 4	0,413964	0,761061	0,54393	0,606096	-1,44829	2,276213	-1,44829	2,276213

Регрессийн үр дүнгээс харахад инфляцитай махны үнэ болон төсвийн урсгал зардал өсөх нь сөрөг нөлөөтэй байна. Тухайлбал: махны үнэ, төсвийн урсгал зардал нэмэгдэхэд инфляцийн түвшин хэрхэн өсч байгааг доорхи хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 5.4

Төсвийн урсгал зардлын өсөлтийн хувь	Инфляцийн түвшин		Махны үнийн өсөлтийн хувь	Инфляцийн түвшин
35,0%	8,7%		30,0%	10,8%
40,2%	10,8%		35,0%	14,8%
45,0%	12,8%		40,0%	22,9%
50,0%	14,9			


Дэлхийн банкнаас 2011 оны төсөвт хийсэн шинжилгээгээр 2011 оны төсөв эрсдэл дагуулж байгаа бөгөөд төсвийг энэ хэлбэрээр хэрэгжүүлбэл инфляци эрс өсөх болно гэж үзсэн. Мөн зарим эдийн засагчид, судлаачдын зүгээс төсвийн байгууллагын ажилчдын цалин хөлсийг 2010 оны 10 сарын нэгнээс 30 хувиар нэмэгдүүлсэн явдал, 2011 оноос иргэн бүрт тараах 21000 төгрөг зэрэг нь инфляцийг огцом өсгөх шалтгаан гэж үзэж байна.<sup>63</sup>

Хүснэгт 5.5

Он	Төсвийн зарлагын өсөлтийн хувь	Инфляцийн түвшин
2000	17,8	8,1
2001	14,0	8,0

<sup>63</sup> <http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/COUNTRIES/EASTASIAPACIFICEXT/MONGOLIAINMONGOLIANEXTN/0,contentMDK:22806493~menuPK:475489~pagePK:2865066~piPK:2865079~theSitePK:475350,00.html>

2002	9,6	1,6
2003	14,8	4,7
2004	22,2	11,0
2005	1,6	9,5
2006	61,8	6,2
2007	41,3	17,8
2008	41,2	22,1
2009	-5,3	4,2
2010	33,0	13,0
2011	31,4	14,6



Зураг 5.2. 2011 онд инфляцийн түвшингийн таамаглал энгийн болон олон хувьсагчийн регресс

Нэг хувьсагчтай регрессээр тооцоолол хийхэд  $R^2 = 0.39$  гарч 2011 онд инфляцийн түвшин 14,6 хувьтай байхаар байна. Гэхдээ  $R^2 = 0.39$  гарч байгаа нь төсвийн зарлагын өсөлтийн хувь болон инфляцийн хоорондын хамаарал бага байгаа бөгөөд тооцоолол хийхэд тийм ч тохиромжтой бус юм.

#### 5.4 Эдийн засгийн өсөлт ба ажилгүйдэл:

Эдийн засгийн өсөлтөд олон хүчин зүйлс нөлөөлөх нь гарцаагүй юм. Гэхдээ судалгааны захиалгын гол зорилго бол 2011 оны төсөв макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд хэрхэн яаж нөлөөлөх талаархи таамаглал, прогноз гаргах явдал юм. Регрессээр тухайн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал, нөлөөллийг тооцоолоход  $R^2$  0,5 ба түүнээс их гарсан тохиолдолд хоорондоо ямар нэгэн хамааралтай байна гэж үздэг байна.

Судалгааны ажлын эхэнд нэгдсэн төсвийн орлого зарлагыг макро эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдтэй 1 хувьсагчийн регрессээр нөлөөллийг тооцоолоход тухайн үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал, нөлөөллийг харуулдаг  $R^2$  нь бидний авсан үзүүлэлтүүдийн хувьд

0,5-аас бага гарч байсан тул тухайн үзүүлэлтийн хооронд хамаарал бага байна гэж үзэн улмаар илүү бодитой тооцоолол хийхийн тулд олон хүчин зүйлсийн регресс хийж үзэхэд дараах үр дүн харагдаж байна. Тухайлбал: Эдийн засгийн өсөлтөд ажилгүйдлийн түвшин, зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хувь, ДНБ-нд эзлэх төсвийн орлогын хувь тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэж үзэж эдгээрийн хооронд регресс хийж үзье. Үүний тулд: 2000-2010 оны хооронд тоон үзүүлэлтүүдийг авч үзье.

Хүснэгт 5.5

Он	Эдийн Засгийн Өсөлт	$X_1$ - Төсвийн орлогын ДНБ-нд эзлэх хувь	$X_2$ - Нийт мөнгөний өсөлтийн хувь хэмжээ	$X_3$ -Ажилгүйдлийн түвшин
2000	1,1	29,7	17,5	4,6
2001	1,0	31,6	27,9	4,6
2002	3,9	31,2	42,0	3,4
2003	7,0	37,9	49,5	3,5
2004	10,6	37,3	20,4	3,6
2005	7,3	37,0	34,6	3,3
2006	8,6	36,6	34,8	3,2
2007	10,2	34,4	56,3	2,8
2008	8,9	35,4	-5,5	2,8
2009	-1,3	31,7	26,9	3,3
2010	6,1	36,9	62,5	8,6
2011	12,1	42,2	70,0	5,0

Эндээс 2011 онд ЭЗӨ хэдэн хувьтай байх талаар урьдчилсан тооцооллыг хийхдээ банк санхүүгийн салбар сэргэж байгаа гэж үзэж 2011 онд зах зээл дэх нийт мөнгөний хэмжээ өмнөх оныхоос өснө гэж тооцоолж байгаа тул нийт мөнгө 70 хувиар өснө, эдийн засаг сайжрахын хирээр ажилгүйдэл буурна гэж үзэн ажилгүйдлийн түвшинг 5,0 хувь байхаар таамаглаж үзлээ.

Multiple R	0,798559						
R Square	0,637696						
Adjusted R Square	0,501832						
Standard Error	2,568122						
Observations	12						
ANOVA							
	df	SS	MS	F	Significance F		
Regression	3	92,86717	30,95572	4,693639	0,035703		

Residual	8	52,762	6,59525					
Total	11	145,6292						
	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
Intercept	-21,4942	7,718372	-2,78481	0,023748	-39,2928	-3,6956	-39,2928	-3,6956
X Variable 1	0,860425	0,231814	3,711698	0,005942	0,32586	1,39499	0,32586	1,39499
X Variable 2	0,007315	0,048653	0,150344	0,884215	-0,10488	0,119508	-0,10488	0,119508
X Variable 3	-0,64892	0,4591	-1,41346	0,195229	-1,70761	0,409767	-1,70761	0,409767
G_GDP=-21.4942+0.8604*BR/GDP+0.0073*G_M2-0.6489*UER						BR/GDP	G_M2	UER
						42,2	70,0	5,0

Дээрх шинжилгээнээс регресс хийж үзэхэд дээрх нөхцөлд ирэх онд эдийн засгийн өсөлт 12,1 хувьтай байхаар байна.

$$G\_GDP = - 21,4942 + 0,8604 * 42,2 + 0,0073 * 70,0 - 0,6489 * 5,0 = 12.1$$

$$G\_GDP = - 21,4942 + 0,8604 * 42,2 + 0,0073 * 70,0 - 0,6489 * 8,0 = 10.2$$

Ирэх онд ажилгүйдлийн түвшин 5 хувиас их буюу өнгөрсөн оны түвшинд байна гэж үзэж 8 хувьтай байхаар тооцоолоход эдийн засгийн өсөлт буурч **10,1** хувь байхаар байна. Эндээс эдийн засгийн өсөлт ба ажилгүйдэл хоорондоо урвуу хамааралтай нь тодорхой харагдаж байна 2009 онд ажилгүйдлийн түвшин 3,3 хувьтай байсан бол 2010 онд 8,6 хувьтай гарч өмнөх оноос 5,3 хувиар ажилгүйдэл өссөн байна. Ажилгүйдэл өснө гэдэг нь ДНБ-ний алдагдлыг авчирдаг гэсэн Оукены хуулиар ажилгүйдлийн түвшин өмнөх оноос 5 хувиар өссөн нь ДНБ -ний өсөлтийг 3,4 хувиар бууруулсан байна.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2010 ОНЫ ТОЙМ**

*Ц. Норовдондог, (Ph.D), Ц. Батдорж, Ч. Онончимэг,  
Ц. Элбэгзаяа*

**I. Макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүд****2010 онд Макро эдийн засгийн үзүүлэлтэнд гарсан өөрчлөлтүүд:**

- ✓ Хөдөө аж ахуйн салбар нь манай улсын эдийн засгийн голлох салбаруудын нэг юм. 2010 онд өвлийн зудны хүндрэлээс шалтгаалан оны эцэст 32729.5 мян. толгой мал тоологдсон нь өмнөх оны мөн үеийнхээс 11294.4 мян.толгой буюу 25.7 хувиар буурсан байна. Үүнээс гадна өвөлжилтийн хүндрэлээс шалтгаалан 2010 онд 10.3 сая том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оныхоос 8.6 сая толгойгоор илүү байна.
- ✓ Атар III аяны хүрээнд газар тариалангийн салбарын хувьд таатай үзүүлэлтийг бий болгосон. 2010 онд 355.1 мян.т үр тариа, 168.0 мян.т төмс, 82.3 мян.т хүнсний ногоо хурааж, 1132.3 мян.т хадлан, 31.3 мян.т гар тэжээл бэлтгэсэн байна. Энэ нь өмнөх оныхоос хураасан үр тариа 36.6 мян.т буюу 9.3 хувиар бага, харин төмс 16.7 мян.т буюу 11.1 хувь, хүнсний ногоо 4.3 мян.т буюу 5.5 хувиар нэмэгдэж, хадлан 220.0 мян.т буюу 24.1 хувь, гар тэжээл 5.5 мян.т буюу 21.1 хувиар их бэлтгэжээ.
- ✓ Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж /2005 оны зэрэгцүүлэх үнээр/ 1874.6 тэр бум төгрөг болж, өмнөх оныхоос 167.7 тэрбум төгрөг буюу 10.0 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн салбарын энэ өсөлтөнд уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн газрын тос, хайлуур жоншны баяжмал, нүүрс зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 16.7-91.8 хувиар нэмэгдсэн нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.
- ✓ Үүнээс гадна 2008 - 2009 онуудад уналтанд ороод байсан барилгын салбарын хувьд 2010 онд 350.8 тэрбум төг болсны 326.5 тэрбум төг буюу 93.1 хувь нь дотоодын, 24.3 тэрбум төг буюу 6.9 хувь нь гадаадын барилгын байгууллагуудад ногдож байна.
- ✓ Барилга угсралт, их засварын ажил өмнөх оныхоос 71.4 тэрбум төг буюу 25.6 хувь, үүнээс дотоодын байгууллагын гүйцэтгэсэн ажил 75.9 тэрбум төг буюу 30.3 хувиар өссөн байна.
- ✓ Гадаад худалдааны хувьд импортын хэмжээ 2010 онд 3277.9 сая.долл буюу өмнөх оны мөн үеэс 1140.2 сая.ам.долл буюу 53.3 хувиар өссөн байна.

**Гадаад худалдаа**

2010 онд Макро эдийн засгийн байдал харьцангуй тогтвортой, өсөлттэй байсан нь гадаад худалдааны үзүүлэлт мөн үеийнхээс өсч, ДНБ-тэй харьцуулахад 96.7 хувь буюу тэнцэхүйц түвшинд хүрсэн үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна. Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 6177.1 сая.ам.долл, үүнээс экспорт 2899.2 сая.ам.долл, импорт 3277.9 сая.ам.долл хүрсэн байна.


Гадаад худалдааны тэнцэлийн хувьд 2010 онд 378.7 сая.ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 126.4 сая.ам.долл буюу 50.1 хувиар нэмэгдсэн байна.

**Нийт бараа эргэлт**

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийг улсаар нь авч үзвэл 2010 онд дэлхийн 132

оронтой худалдаа хийснээс 56.0 хувь нь БНХАУ-д, 18.9 хувь нь ОХУ-д, үлдсэн 25.1 хувь нь бусад улсуудад ногдож байна. Харин нийт бараа эргэлтийн хэмжээ 2010 онд **6177.1 сая.ам.долл** болсон нь өмнөх оны мөн үеэс **53.5 хувиар** нэмэгдсэн бөгөөд экспорт 53.8 хувь, импорт 53.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Гадаад худалдааны нийт бараа эргэлт, 2009 - 2010 оны I - XII сар, сая долл



### Экспорт

Манай улс 2010 онд нийт 67 оронтой экспортын худалдаа хийснээс 84.9 хувийг БНХАУ-тай, 4.9 хувийг Канад улстай, 2.7 хувийг ОХУ-лстай үлдсэн 7.5 хувийг БНСУ, Итали, ХБНГУ зэрэг бусад улс оронтой хийсэн байна. 2010 онд нийт экспортын хэмжээ 2899.2 сая ам.долл болж өмнөх оны мөн үеийнхээс 1013.8 сая ам.долл буюу 53.8 хувиар өссөн байна.

Экспортын үнийн дүнгийн 98.0 хувийг зөвхөн эрдэс бүтээгдэхүүн (80.8%), үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, ноос, нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн, мал амьтаны гаралтай түүхий эд эзлэж байна.

Сүүлийн 3-н жилийн байдлаар экспортод гарсан зарим эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээний өөрчлөлтийг авч үзвэл төмрийн хүдэр, нүүрсний экспорт жил тутам өсөж байна. Төмрийн хүдэрийн хувьд 2008 онд 1013.1 мян.т, 2009 онд 1598.1 мян.т харин 2010 онд огцом өсөж 3539.3 мян.т буюу өмнөх оны мөн үеэс 1941.2 мян.т буюу 54.8 хувиар өссөн байна.


### Импорт

2010 онд манай улс 125 оронтой импортын худалдаа хийж, нийт импортын хэмжээ 3277.9 сая.ам долл хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1140.2 хувь буюу 53.3 хувиар өссөн байна. Манай улсын хувьд импортын 3968 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирсэн нь өмнөх оныхтой харьцуулахад машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, техник хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг анги, хими химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн 273 нэр төрлөөр ихэссэн байна.


Гадаад худалдааны импортын өсөлтөнд машин тоног төхөөрөмж 363.8 сая.ам.долл, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, тэдгээрийн сэлбэг, эд анги 261.6 сая.ам.долл, эрдэс бүтээгдэхүүний импорт 189.6 сая.ам.долл, хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн 77.6 сая.ам.доллар байсан нь нөлөөлсөн байна.




Зураг 2. Гадаад худалдааны экспортийн хэмжээ, 2009 - 2010 оны I - XII сар, сая ам.долл



Зураг 3. Гадаад худалдааны импортын хэмжээ, 2009 - 2010 оны I - XII сар, сая ам.долл




Зураг 4. 2010 онд гадаад худалдааны импортын хувь, хэмжээ



### Гадаад худалдааны тэнцэл

Гадаад худалдааны тэнцэл 2010 онд 378.7 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 126.4 сая ам.долл буюу 50.1 хувиар өссөн дүн гарсан байна. Гадаад худалдааны тэнцэл 2009 оны I, 12 дугаар сард ашигтай, 2-11 дүгээр сард алдагдалтай гарсан бол 2010 онд 1, 5, 6 дугаар сард ашигтай, 2-4 болон 7-12 дугаар сард алдагдалтай гарсан байна.

Зураг 5. Гадаад худалдааны тэнцэл, 2009 - 2010 он, сая ам.долл




### ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

#### Аж үйлдвэр


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2010 оны байдлаар (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 1874.6 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 169.7 тэрбум төгрөг буюу 10.0 хувиар өссөн байна. Энэ өсөлтөнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын зарим дэд салбараас гадна дараахь дэд салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

- Нүүрс олборлолт 91.8 хувь;
- Газрын тос, шатдаг хий олборлолт 16.7 хувь;
- Бусад ашигт малтмал олборлолт 19.5 хувь;
- Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл 5.5 дахин;
- Резин болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл 84.4 хувь;
- Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 24.0 хувь;
- Төмрийн үйлдвэрлэл 29.6 хувь;

Харин аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 2010 онд металын хүдэр олборлолт (-6.4%), мебель тавилга үйлдвэрлэл, боловсруулх бусад үйлдвэрлэл (-22.2%), арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл (-55.3%), тээврийн болон бусад хэрэгсэл үйлдвэрлэл (-90.0%) зэрэг салбарын үйлдвэрлэлийн хэмжээ буурсан байна.


**Зураг 6.** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, тэрбум төг.

2010 онд Аж үйлдвэрийн салбарын хувьд үйлдвэрлэсэн нийт бараа бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд газрын тос олборлолт 100 хувь, металлын хүдэр олборлолт 92.9 хувь, нүүрс олборлолт 89.4 хувь, бусад ашигт малтмал олборлолтын салбар 79.2 хувийг борлуулсан байна.

**Зураг 7.** 2010 онд Аж үйлдвэрийн нийт борлуулалтанд салбаруудын эзлэх хувиар

### Дотоодын нийт бүтээгдэхүүн

Монгол Улсын ДНБ /2005 оны зэрэгцүүлэх үнээр/ 2010 оны эхний 3 улиралд нийт 2646.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 156.6 тэрбум төгрөг буюу 6.3 хувиар өссөн байна. Энэ өсөлтөнд аж үйлдвэр, барилгын салбарын үйлдвэрлэл болон үйлчилгээний салбар, бүтээгдэхүүний татварын хэмжээ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

**Зураг 8.** ДНБ-ний цэвэр өсөлт, бууралт, 2000 - 2010 он

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий хэмжээ 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 8255.1 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 4154.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос оны үнээр 25.3 хувь, зэрэгцүүлэх үнээр 6.1 хувиар тус тус өслөө. ДНБ-ий 2010 оны дээрх өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар 23.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбар 11.3 хувь, уул уурхай, олборлох салбар 6.3 хувь тус тус өссөн нь голлон нөлөөлж байна.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр 8420.7 тэрбум төг болж, өмнөх оныхоос 1852.3 тэрбум төг буюу 28.2 хувиар өслөө. Уг өсөлтөд эцсийн хэрэглээ болон нийт хуримтлал нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

## II. УЛСЫН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2010 оны Урьдчилсан гүйцэтгэлээр улсын нэгдсэн төсөв 2.2 тэрбум төгрөгийн ашигтай гарч төсвийн нийт орлогын үзүүлэлтүүд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 340.4 тэрбум төгрөгийн өсөлттэй гарсан байна. 2010 оны эхний улиралаас эхлэн урсгал тэнцэл ашигтай гарсаар ирсэн ба урьдчилсан гүйцэтгэлээр 764.7 тэрбум төгрөгийн ашигтай гарч төсвийн үзүүлэлт сайжирсан.

Нийт орлогын дүн өмнөх онтой харьцуулахад 1 084.5 тэрбум төгрөгөөр өссөн байгаа нь дэлхийн зах зээл дээрх зэс, алтны үнэ өсөж гадаад худалдааны эргэлт сайжирч, гэнэтийн ашгийн татвар, дотоодын нэгжүүдийн шууд болон шууд бус татварын нөлөө их байсан байна. Төсвийн орлого нэмэгдэж тэнцэл сайжирсанч зарлага даган өссөөр байна. 2010 онд төсвөөс нийт 276.0 тэрбум төгрөг хүний хөгжил сангаас тараасан ба төрийн албан хаагчдын цалинг 30 хувиар нэмдүүлсэн зэрэг нь зарлага өсөхөд багагүй нөлөө үзүүлснээр барахгүй имфляци өсөхөд нөлөөлсөн.

Доорхи хүснэгт №1-ээс Нэгдсэн төсөв, улсын төсөв, орон нутгийн төсвийн тоон үзүүлэлтийн дүнг 2009-2010 оны үзүүлэлтүүдийг хурьцуулан харуулсан болно. Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр/

Хүснэгт №1 /сая төгрөг оны үнээр/

Орлого, зарлагын төрөл	2009 оны 12 сар			2010 оны 12 сар		
	Улсын нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Улсын нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв
Төсвийн орлого:						
Нийт орлого, тусламжийн дүн	1 993 995.6	1 431 875.4	283 717.0	3 078 418.6	2 451 137.8	361 531.3
Нийт орлого	1 974 927.9	1 251 071.2	270 068.8	3 043 857.1	2 221 006.0	341 394.7
Урсгал орлого	1 972 619.3	1 251 071.2	267 168.9	3 035 868.6	2 221 006.0	333 406.2
Татварын орлого	1 620 549.6	933 245.4	237 214.0	2 637 573.3	1932 183.0	300 888.1
Татварын бус орлого	352 069.7	317 825.8	29 955.0	362 295.4	288 832.1	32 518.1
Хөрөнгийн орлого	2 308.6	-	2 899.9	7 988.5	-	7 988.5


Тусламжийн орлого	19 067.7	180 804.2	13 648.2	34 561.4	230 131.8	20 136.6
Төсвийн зарлага:						
Нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл	2 336 629.7	1 746 616.9	268 150.7	3 076 197.4'	2 376 197.4'	353 251.5'
Нийт зарлага	2 248 722.1	1 658 709.3	268 150.7	2 835 860.8	2 135 795.4	353 251.5
Урсгал зардал	1 788 157.6	1 406 273.3	234 876.3	2 271 150.0	1 632 065.6	294 699.8
Хөрөнгийн зардал	460 564.5	252 436.0	33 274.4	564 710.8	503 729.8	58 551.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	87 907.6	87 907.6	-	240 402.0	240 402.0	-
Нийт тэнцэл	-342.6	-314.7	15.5	2.2'	75'	8.2'
Урсгал тэнцэл	184.5	-155.2	32.3	764.7'	589'	38.8'

### Төсвийн нийт ба урсгал тэнцэл:

Нэгдсэн төсвийн нийт орлого 2010 онд 3 078.4 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл 3 076.1 тэрбум төгрөг болж нийт тэнцэл 2.2 тэрбум төгрөг, урсгал тэнцэл 764.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. 2007 онд дэлхийн зах зээл дээрх ашигт малтмалын үнэ өсч манай улсын төсөв ашигтай гарч байсан боловч зарлага нэлээдгүй хэмжээгээр өссөөр байсан. 2008 оны сүүлийн хагасаас дэхийн санхүү эдийн засгийн хямрал манай улсын эдийн засагт нөлөөлж эхэлсэн ба тухайн үед Засгийн газраас хямралын эсрэг арга хэмээ авч зарлагыг хумих мөн орлого зарлагын тэнцвэртэй харьцааг хадгалах бодлого баримтлаж хямралын нөлөөг багасгасан. 2010 онд дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын үнэ дахин өсөж эхэлсэн нь манай улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлж нийт тэнцэл ашигтай гарахад нөлөөлжээ.

### Зураг №9

- 2007 оноос хойшхи Нэгдсэн төсвийн орлого, зарлагын өсөлт бууралт болон нийт тэнцэл, урсгал тэнцэл




### Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн дүн

2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3 078.4 тэрбум төг, нийт орлого 3 043.8 тэрбум төгрөг, урсгал орлого 3 035.8 тэрбум төгрөг болж өссөн дүнтэй гарчээ. Төсвийн нийт орлогын 87.8 хувь буюу 2 673.5 тэрбум төгрөгийг татварын орлого, 11.8 хувь буюу 362.2 тэрбум төгрөгийг татварын бус орлого бүрдүүлж байна.

Графикаас №10-оос харахад урсгал орлого нэмэгдэхэд татварын орлогын нөлөө их байгаа ба татварын орлогын өсөлтөнд орлогын албан татвар өмнөх оныхоос 46.5 хувиар, нийгмийн даатгалын шимтгэл 18 хувиар, өмчийн татвар 18.3 хувиар, дотоодын бараа, үйлчилгээний албан татвар 41 хувиар, гадаад худалдааны татварын орлого 40 хувиар, бусад татвар 34.6 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Нийт орлогын өсөлтөнд хөрөнгийн орлого, тусламжийн орлогын үзүүлэх нөлөө бага байгаа боловч хөрөнгийн орлого өмнөх оныхоос 70.8 хувиар, тусламжийн орлого 44.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг №10 Нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлтүүд




### Татварын орлого

Татварын нийт орлого өмнөх жилүүдэд тогтмол өсөлттэй гарсаар ирсэнч 2009 онд өмнөх оныхоосоо буурч гарсан нь санхүү эдийн засгийн хямралтай хобтоотойгоор гадаад худалдааны эргэлт багасаж импортын бараа таваараар дотоодын хэрэгцээнийхээ ихэнх хувийг хангадаг манай улсын хувьд хямралын нөлөө өндөр байсан.

2009 онд орлогын албан татвар, дотоодын бараа үйлчилгээний татвар, гадаад худалааны татварын орлого, бусад татвар зэрэг буурснаас 2009 онд өмнөх 2008 оныхоос буурч гарсан. Харин 2010 оноос дэлхийн санхүү эдийн засгийн хямрал илааршиж дэлхийн зах зээл дээрхи зэс алтны үнэ өсөж, эдийн засаг сэргэж эхэлсэнээр татварын орлого нэмэгдсэн дүнтэй гарсан. 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр татварын орлого 2 673.5 тэрбум төгрөг болж өмнөх оныхоос 1 053.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Татварын орлого нэмэгдэхэд орлогын албан татвар, гадаад худалдааны татварын орлого, дотоодын бараа үйлчилгээний албан татвар, бусад татвар зэрэг голлон нэмэгдсэн байна.

**Татварын бус** Татварын бус орлого өмнөх жилүүдэд тасралтгүй өссөн дүнтэй байгаа ба 2008 онд буурсан дүнтэй гарсан байна. Татварын бус орлого нь 2010 он урьдчилсан гүйцэтгэлээр 362.2 тэрбум төгрөг болж өмнөх оноосоо 10 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй гарсан байна.


Зураг №11 Татварын орлогын үзүүлэлтүүд



### Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр 3 076.2 тэрбум төг. болж өмнөх оныхоос 739,6 тэрбум төгрөг буюу 24 хувиар өссөн дүнтэй гарсан. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ өсөхөд урсгал зардалын бараа үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас шилжүүлэг зэрэг бүгд нэмэгдсэн дүнтэй гарсанаас гадна хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх зээл мөн нэмэгдэн гарсан нь голлон нөлөөлжээ.

Зураг №12 Нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлтүүд




### Урсгал зардал

Урсгал зардал 2005 оноос тогтмол өсч 1.792.1 тэрбум төгрөг болтлоо өссөн нь байна. 2005-2009 онуудад урсгал зарлагын бүлгийн зардалууд огцом өссөн. Графикаас харахад бараа үйлчилгээний зардал хоёр дахин, татаас ба шилжүүлэг дөрөв дахин нэмэгдсэн бол зээлийн үйлчилгээний төлбөр 8 хувиар нэмдэгжээ. Бараа үйлчилгээний зардлыг

нэмэгдэхэд цалин хөлс, бараа үйлчилгээний бусад зардалын бүлгийн зардалууд огцом өссөнтэй холбоотой юм.

Зураг №13 Урсгал зардлын үзүүлэлтүүд



**Хөрөнгийн зардал** Хөрөнгийн зардалд 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр 564.7 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх оныхтой харьцуулахад 104.2 тэрбум төг. буюу 18.4 хувиар өссөн байна. Хөрөнгийн зардлын өсөлтөд дотоодын эх үүсвэрээс хийгдсэн хөрөнгийн зардал 117.6 тэрбум төгрөг буюу 21.3 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Гадаад эх үүсвэрээр манхүүжүүлэх зардал нь 2009 оныхоос 50.3 хувиар буурсан дүнтэй гарсан байна.

Монгол улсын төсвийн нийт зарлаг ба цэвэр зээлийн дүн сүүлийн жилүүдэд 3 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2005 оноос 2009 онд нийт зарлага цэвэр зээлийн дүнд эзлэх урсгал зарлага 3 дахин, хөрөнгийн зарлага 5 дахин нэмэгдэж цэвэр зээл 3.9 хувиар буурсан байна. Урсгал зардал зардал өсөхөд брааны үйлчилгээний зардалын зүйл ангийн зардлууд болох цалин хөлс 436.1 тэрбум төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 146.7 тэрбум төгрөгөөр, зээлийн үйлчилгээний төлбөр 8.3 тэрбум төгрөгөөр, 29.9 тэр бум төгрөгөөр өссөн ба эдгээрийн нийт дүн нь 621 тэрбум төгрөг болж Монгол улсын нэгдсэн төсвийн 2003 оны орлогын гүйцэтгэлээс давж гарсан байна.

Монгол улсын нийт зарлагын өсөлтийн гол шалтгаан нь ашигт малтмалын өсөлтийн жилүүдэд төсөв уул уурхайгаас хэт хамааралтай болсон ба тэрхүү хуримтлалын ихэнх хэсгийг цалин хөлс, нийгмийн халамжийн зардал, хөрөнгө оруулалтын зардалуудад зарцуулсан байна. Графикаас харахад 2008-2010 онд урсгал зардалаас бусад зардал буурсан үзүүлэлттэй гарсан нь хөрөнгийн зардал болон цэвэр зээл тодорхой хэмжээгээр буурсан ба урсгал зардлын бүлгийн зардлууд өмнөх жилүүдэд тогтомол нэлээд өндөр өсөлттэй байдаг байсан бол 2009 оноос тогтворжих хандлагтай байснаа 2010 оноос огцом өссөн дүнтэй гарсан байна.

### III. Монгол Улсын мөнгөний үзүүлэлтүүд


#### Бодлогын хүү

Монгол банкнаас бодлогын хүүг эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагад нийцүүлэн тогтоодог. Монголбанкнаас 2008 онд 22.1 хувьд хүрээд байсан инфляцийн түвшинг бууруулах, төгрөгийн ханшийг тогтворжуулах зорилгоор мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж, бодлогын хүүг 2009 онд 14.0 хувь хүртэл өсгөж байсан. 2010 оны 5 сард 11,0 хувь болгосноос хойш бодлогын хүүнд өөрчлөлт ороогүй байна.



Дэлхийн зарим орны бодлогын хүүг сонирхоход Австралид 4.75%, Англид 0.5%, Америкийн Нэгдсэн Улсад 0.25%, Канадад 1,0%, Шинэ Зеландад 3,0%, манай хөрш 2 орон болох БНХАУ-ын бодлогын хүү 5.81, ОХУ 7,75 хувьтай байна.

Зураг 15: Төвбанкны бодлогын хүүний өөрчлөлт




Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

## Инфляци

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2010 онд баримтлах үндсэн чиглэлд” Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барьж, эдийн засгийн бодит өсөлтийг сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ хэмээн тусгасан байна. Харин Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшин 2009 онд 4,2 хувьтай байсан бол 2010 оны эцэст өмнөх оны мөн үеэс 13,0 хувиар өссөн байна.

Инфляцийн түвшин 13,0 хувьтай гарахад 2010 оны 2 сард эх орны хишиг сангаас иргэн бүрт 70000 төгрөг, 8-12 сарын хооронд 50000 төгрөгийн хувь хишиг хүртээсэн явдал, 2010 оны 10 сарын 1-нээс төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг 30 хувиар нэмэгдүүлсэн, хүнсний бүтээгдэхүүн тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт, цахилгаан түлш, боловсролын үйлчилгээний үнэ өссөн зэрэг нь инфляцийн өсөлтийг өдөөсөн хүчин зүйл болсон гэж үзэж байна.

Зураг 16: Инфляцийн түвшин, жилийн эцэст,



Тайлбар:

\* Урьдчилсан гүйцэтгэл


Эх сурвалж: Монголбанк 2009 оны жилийн тайлан, ҮСХ 2010/12 танилцуулга

Инфляцийн жилийн дундаж түвшин 10,1 хувьтай гарчээ. Өрхийн хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг мах, махан бүтээгдэхүүний бүлгийн үнийн дүн 2010 оны эцэст өмнөх оныхоос бүх аймагт 8,6-88,9 хувь хүртэл өссөн дүн байна. Тухайлбал: Баянхонгор аймагт 88,9%,

Өвөрхангай аймагт 82,6%, Говь-алтай аймагт 76,7%, Баян-өлгий аймагт 74,5% зэрэг ихэнх аймагт 50-иас дээш хувиар өссөн байна.

Зураг 17:


- Инфляцийн түвшин, Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлтийн хувиар



Тайлбар: \* Урьдчилсан гүйцэтгэл, Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 14,3 хувиар өсчээ. 2010 оны жилийн эцсийн байдлаар хэрэглээний сагсанд багтдаг 287 төрлийн нэрийн бараа, үйлчилгээний 69,0 хувийнх нь үнэ өссөн гэж ҮСХорооноос мэдээлж байна

Зураг 18: 2010 оны 12 сарын байдлаар зарим улс орны инфляцийн түвшин




Эх сурвалж: <http://www.tradingeconomics.com/>

### Мөнгөний нийлүүлэлт, түүний бүтэц

Зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт эдийн засаг өсөлттэй байх үе буюу 2004-2007 онд дунджаар 36.5 хувиар, хямралын жилүүдэд 10,7 хувиар тус тус өсч байсан бол 2010 онд 62,5 хувиар өсч, мөнгөний нийлүүлэлт 4680,0 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 19: Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) 2010/12 сарын бюллетень

Мөнгөний нийлүүлэлт өмнөх оноос 62,5 хувиар өссөн нь төгрөгийн хадгаламж 62,2%, гадаад валютын хадгаламж 21.3%, гадаад валютын харилцах 105,8%, төгрөгийн харилцах 110,1 хувиар нэмэгдсэнтэй холбоотой. Нийт мөнгөний нийлүүлэлтийн 42.8 хувийг төгрөгийн хадгаламж, 16,1 хувийг валютын хадгаламж, 16,4 хувийг валютын харилцах, 16,4 хувийг төгрөгийн харилцах, 8,3 хувийг банкнаас гадуурхи мөнгө тус тус эзэлж байна.

### Аж ахуйн нэгж, иргэд байгууллагад олгосон зээл

Зураг 20: Чанаргүй зээлийн эзлэх хувь



Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn) 2010/12 сарын бюллетень

Банк санхүүгийн хямралын улмаас банкны секторт тулгамдсан асуудлуудын нэг бол чанаргүй зээлийн хэмжээ огцом нэмэгдэж, нийт зээлийн багцад чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувийн жин өсч, банкууд бэлэн мөнгөний хомсдолд орж, зээл төлөлтөд хүндрэл үүссэн явдал юм. Тухайлбал: банкны салбарт 2007 оны эцэст 68,1 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн багц байсан бол энэ тоо 2008 оны эцэст 2,8 дахин их буюу 120,6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байсан. 2009 оны гүйцэтгэлээр хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл нийт зээлийн багцийн 22,0 хувийг эзэлж байсан бол 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр энэ тоо буурч чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн багцийн 14,8 хувийг, чанаргүй зээл дангаараа 11,9 хувийг эзэлж байна.

## Хүснэгт 3. Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл


	2004	2005	2006	2007	2008	2009	2010
Нийт зээл	606.8	859.8	1223.3	2056.1	2635.5	2655.0	3112,5
өсөлтийн хувь	37.2%	41.7%	42.3%	68.1%	28.2%	0.7%	17,2%
Хэвийн зээл	546.1	789.4	1129.9	1947.7	2353.6	2071.3	2651,3
өсөлтийн хувь	34.7%	44.5%	43.1%	72.4%	20.8%	-12.0%	28,0%
Хугацаа хэтэрсэн зээл	21.6	20.9	33.3	40.3	93.3	121.7	90,2
өсөлтийн хувь	39.3%	-3.2%	59.3%	21.0%	131.5%	30.4%	-25,9
Чанаргүй зээл	39.1	49.5	60.0	68.1	188.7	462.0	370,9
өсөлтийн хувь	85.3%	26.6%	21.2%	13.5%	177.1%	144.8%	-19,7
Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзэлж буй хувь	10.0%	8.2%	7.6%	5.3%	10.7%	22.0%	14,8%

Эх сурвалж: Монголбанк. 2010/12 сарын бюллетень

## Нийт хадгаламжийн хэмжээ


Банкуудын иргэд, аж ахуйн нэгж, бусад байгууллагуудаас татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ жилээс жилд нэмэгдсээр байна. Хадгаламжийн хэмжээ 2008 онд 7,7 хувиар өмнөх оноос буурч байсныг эс тооцвол 2000 оноос хойш тууштай өсч ирсэн нь дээрх зургаас харагдаж байна. 2009 онд нийт хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 35.1 хувиар, 2010 онд 48,5 хувиар нэмэгдэж, 2010 оны эцэст нийт хадгаламжийн хэмжээ 2756,2 тэрбум төгрөг болж, ДНБ-ний 33,4 хувийг эзэлж байна.

Зураг 21: Нийт хадгаламжийн хэмжээ, ДНБ-нд эзлэх хувиар

Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

2009 онд 41,3 хувиар өсч байсан гадаад валютын хадгаламж 2010 онд 21,3 хувь болж, жилийн өсөлтийн хурд буурсан бол харин төгрөгийн хадгаламж 2009 онд 37,3 хувийн өсөлттэй байсан бол энэ онд 62,2 хувь болж өссөн байна.

Зураг 22: Төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн өсөлтийн хувь



Эндээс харахад валютын ханшийн тогтворгүй байдал, валютын ханшийн чангаралтаас шалтгаалж, иргэд байгууллага хадгаламжаа гадаад валютаар хадгалуулах сонирхол нь буурч, үндэсний мөнгөн тэмдэгт рүү шилжүүлэн хадгалах сонирхолтой байгаа нь харагдаж байна.

Зураг 23: Гадаад валютын цэвэр албан нөөц



Эх сурвалж: Монголбанк. Жилийн тайлан 2009, YCX. 2010/12 танилцуулга


### Гадаад валютын нөөцийн талаар

2010 оны 12 сарын байдлаар манай орны гадаад валютын цэвэр албан нөөц өнгөрсөн оны мөн үеэс 945,9 сая ам доллараар нэмэгдэж 2091,2 сая ам доллар болж энэ нь импортын

### Арилжааны банкуудын актив

Банкны салбарын эх үүсвэр, актив өсөх тусам аж ахуйн нэгж, иргэд байгууллагад олгох зээл, санхүүжилтийн хэмжээ тогтвортой нэмэгдэж байдаг.

Зураг 24. Арилжааны банкуудын активын хэмжээ



Эх сурвалж: Монголбанк. 2010/12 барын бюллетень

2010 онд арилжааны банкуудын активын хэмжээ 5873,5 тэрбум төгрөгт хүрч, энэ нь өмнөх оноос 43,6 хувиар нэмэгдэж, ДНБ-ний 71,1 хувьтай тэнцэж байгаа нь санхүүгийн зуучлалын цар хүрээ улам нэмэгдэж байгааг харуулж байна.



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

(Мэдээлэл лавлагаа - дүн шинжилгээ)

*Ц. Норовдондог (Ph.D)*

Үнэт цаасны зах зээл нь хөрөнгийн чөлөөт урсгалыг эдийн засгийн санхүүжилтэнд чиглүүлэх үүрэг бүхий санхүүгийн зах зээлийн томоохон бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үнэт цаасны төрөл бүрийн хэрэгсэлүүдээр дамжуулан ил тод, нээлттэй, шударга зарчмаар олон улсын хэмжээнд тогтоосон эрх зүйн зохицуулалтын нийтлэг стандартад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах ёстой.

Монгол улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж зах зээлийн үеийн аж ахуйн болон санхүүгийн шинэ хэв маягт шилжиж байна. Зах зээлийн эдийн засаг нь чөлөөт эдийн засгийн харилцаа болохын хувьд хувийн хэвшил хөгжих, чөлөөт өрсөлдөөн бий болох, санхүүгийн эх үүсвэрийг хөрөнгө оруулалтад татан төвлөрүүлэх, хөрөнгийн үр ашигтай хуваарилалт хийх олон төрлийн үр ашигтай арга механизмуудыг бий болгосон нь санхүүгийн зах зээлийн хөгжлийн явцад бий болгосон гайхамшигт ололт амжилт мөн бөгөөд үүний нэг хэсэг нь Үнэт цаасны зах зээл /Хөрөнгийн зах зээл/ юм.

Өнгөрсөн 20 жилд Монгол улсад ямарч гэсэн үнэт цаасны зах зээлийн үндэс суурийг тавьсан нь томоохон амжилт мөн боловч зах зээлийг бий болгох, хөгжүүлэх явцдаа бид маш их алдаа дутагдал гаргаж байна. Өнөөг хүртэл зах зээлийн төлөвшил, эрх зүйн орчин, зах зээлд оролцогчдын дагаж мөрдөх мэргэжлийн болон ёс зүйн дүрэм журам, зах зээлийн дэд бүтэц, орчин үеийн шинэлэг техник технологийг нэвтрүүлэх тал дээр төр засгийн зүгээс ч, зах зээлд оролцогчдын зүгээс ч санал санаачлага гарч идэвхитэй хөгжиж чадахгүй байна.

**1. Монгол улсын үнэт цаасны зах зээлийн хөгжил, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн:**

• **1991 - 1995**

1991 онд Хөрөнгийн бирж болон түүний харьяа 29 брокерийн пүүсийг аймаг орон нутагт байгуулсанаар Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн суурийг тавьсан. Өмч хувьчлалын комиссийн шийдвэрээр 476 улсын үйлдвэрийн газруудыг /1990 онд байсан Монгол улсын нийт хөрөнгийн 44,3% буюу 22 тэрбум төгрөг / хувьцаанд хөрвөх хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр нийт 1,2 сая иргэдэд эзэмшүүлсэн. Ваучераар явуулсан хувьчлал 1995 онд үндсэндээ дуусч иргэд хувьцаагаа Хөрөнгийн бирж дээр чөлөөлтэй арилжиж болохоор шийдвэрлэсэн. Үүний үр дүнд үнэт цаас гаргагч 476 ХК, 1,1 сая хувьцаа эзэмшигч, Хөрөнгийн бирж, брокерийн пүүсүүд зэрэг дэд бүтцийн байгууллагууд бий болсон

• **1995 - 2000**

1995 он гэхэд зарим брокерийн пүүсүүд дээр захиалаггүй болон “Эрдэнэт”, “Монголросцветмет” “Монголын харилцаа холбоо” зэрэг хувьчлах шийдвэр гаргаагүй компаниудын хувьцааг эзэмшихээр захиалга өгсөн Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн үлдэгдэл, мөн хувьчлах шийдвэр гарсан боловч ХОЭБ-ээр баталгаажаагүй 104 ҮААГ-ын хувьцаа, мөн брокерийн пүүсүүдэд бүртгүүлсэн баталгаажаагүй ХОЭБ зэрэг үлдэгдэлүүд байсан байна.

1995 онд Монголын Хөрөнгийн биржийн захирал шийдвэр гаргаж эдгээр ХОЭБ-ийн үлдэгдэлийг нэгтгэсэн Хамтын санг 29 брокерийн пүүсийн дэргэд байгуулах шийдвэр гаргасан. Гэвч брокерийн пүүсийн дэргэд байгуулагдсан хамтын сангууд нь үндсэндээ брокерийн пүүсүүдтэй нэгдмэл сонирхолтой удирдлага, харилцагчаас давуу

мэдээлэлтэй байж хувийн сонирголоор хөрөнгийг захиран зарцуулах болсон. 1995 онд Хамтын сангуудыг Хөрөнгө оруулалтын бие даасан сан болгох оролдлого хийгдэж Үнэт цаасны хорооноос тусгай зөвшөөрөл олгож эхлэв. Гэвч практик дээр ХОС-ууд жинхэнэ утгаараа ажиллаж чадаагүй бөгөөд санд төвлөрсөн ХОЭБ болон хувьцааг дур мэдэн захиран зарцуулж, хөрөнгийн үнэлгээг нь санаатай санамсаргүйгээр буулгах замаар үрэн таран хийж 2000 он гэхэд үндсэндээ эзэнгүйдэж дампуурсан юм.

1994 онд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль батлагдан гарч Хөрөнгийн бирж, БДК, Хөрөнгө оруулалтын сан зэрэг зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгож эхлэв. Мөн зах зээлд ажиллах мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, аттестатчилах ажлыг ТББ-тай хамтран зохион байгуулж эхлэв. 1998 онд Хөрөнгийн биржид хийсэн шалгалтаар харилцагчдын дансанд байсан 1,035 тэрбум төгрөгийг эрсдэлд оруулж үгүй хийсэн зөрчил илрэв

#### • 2000 - 2005

1998 оны сүүлчээс эхлэн Хөрөнгийн бирж харилцагчдын дансанд байгаа хөрөнгийг найдвартай хадгалж хамгаалж чадаагүй, Брокер-дилерийн компаниуд харилцагчдын дансанд байсан хувьцаа, мөнгөн хөрөнгийг эзнийх нь зөвшөөрөлгүйгээр захиран зарцуулсан, хууль бусаар шилжүүлсэн, ашигласан зөрчил маш ихээр илрэх болов. Үнэт цаасны арилжааны явцад ХК-иудын хяналтын багцыг төвлөрүүлэх, үйл ажиллагааг нь зогсоох, өмч хөрөнгө эзэнгүйдэх, үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа зогсож улсын үйлдвэрийн газрууд дампуурах, хувьцааны үнэ ханш эрс буурах, үнэ ханшийг зохиомлоор өсгөх бууруулах үзэгдэл газар авав.

1995 - 2000 онд үндсэндээ ХК -иудын хяналтын багцийг эзэмшихийн төлөөх тэмцэл хөрөнгийн зах дээр өрнөж үүнд мэргэжлийн байгууллагууд татагдан орсон нь илэрхий болов. Хөдөө орон нутагт брокерийн пүүсүүд ажиллахаа больсон ба Үнэт цаасны хорооноос орон нутагт БДК -иудыг ажиллуулах талаар шахалт шаардлага тавиад ч нэмэргүй байв. Сүүлдээ орон нутагт брокерийн пүүсгүй аймгуудын харилцагчдыг шинээр байгуулагдсан БД компаниудад хүчээр шахам хариуцуулах, орон нутагт салбар төлөөлөгч ажиллуулах шаардлага тавих, БДК-иудыг нэгдэж нийлэхийг дэмжих байдлаар янз бүрийн байдлаар зохицуулалт хийх оролдлогыг ҮЦХ -ноос хийсэн боловч зах зээл идэвхгүй болсон, санхүүгийн хувьд боломжгүй хэмээн үндсэндээ орон нутагт үнэт цаасны зуучлалын үйл ажиллагааг зогсоох хэмжээнд хүргэсэн юм.

Мөн ХОС -ийн эзэд нь санд төвлөрүүлсэн хөрөнгийг дураараа захиран зарцуулах, сангийн гишүүдийн хурал хийх, хөрөнгийг өсгөх талаар санаачлагатай ажиллагүйгээс сангийн хөрөнгө үнэгүйдэж хариуцах эзэнгүй болсон байлаа. Иймд тухайн үед бүртгэлтэй байсан 16 ХОС -ийг бүртгэлээс хасах арга хэмжээ авсан байна.

#### • 2005 - 2007

Хувьцааны төвлөрөл хүчтэй явагдсанаас зах зээл идэвхгүй байдалд орсон тул шинэ төрлийн үнэт цаасыг зах зээлд гаргах, үнэт цаасны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талаар анхаарахаас өөр аргагүй байдал бий болов. Засгийн газрын богино хугацаат үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах болсон нь бага ч болов дэмжлэг болсон. Мөн барилгын компаниуд бонд гаргах замаар санхүүжилт хийж эхэлсэн. Үнэт цаасны мэргэжлийн байгууллагуудтай холбоотой зөрчил маш ихээр илрэх болсон тул Хорооноос тавих хяналт, зохицуулалтыг сайжруулах шаардлага бий болсон.

Хөрөнгийн бирж үнэт цаасны бүртгэл, арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн чиг үүргийг төвлөрүүлэн эрхэлж байсан нь зах зээлийн нийтлэг горим, хяналт зохицуулалтыг тодорхой хэмжээнд алдагдуулж байна гэж үзсэн тул Азийн хөгжлийн банкны хөтөлбөрийн хүрээнд үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн чиг үүргийг



салгаж Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” 100% төрийн өмчит компанийг бие даасан хэлбэрээр байгуулсан байна. Ингэснээр харилцагчдын мөнгөн хөрөнгө болон үнэт цаасны бүртгэл, хадгалалт хамгаалалтыг биржээс тусгаарласан дэвшилтэт арга хэмжээ болсон. Мөн зарим компани шинээр үнэт цаас гаргаж зах зээлд арилжаалж эхлэв.

Хувьцааны хяналтын багц нь төвлөрсөн, үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон, хувьцааны үнэ ханш нь унасан компаниудыг биржийн бүртгэлээс хасах талаар Хороо болон хөрөнгийн биржээс санаачлага гаргах болов. Ингэснээр хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-ийн тоо 336 болов. Мөн Анод банк, Зоос банк зэрэг банк санхүүгийн байгууллагууд шинээр хувьцаа гаргаж зах зээд арилжаалж эхэлсэн боловч эдгээр банкуудад хувьцаа гаргах үеийн санхүүгийн байдлын талаархи мэдээлэл дутагдалтай, зөвшөөрөл олгох болон арилжаалах процесст Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн хамтарч шийдвэр гаргаж хяналт тавьсан нь тодорхойгүй байгаагаас эдгээр банкуудын хувьцаа эзэмшигчид өнөөдрийн байдлаар хохирсон хэвээр байна.

Статистикаас үзэхэд, 2006 оноос зах зээлийн үнэлгээ өссөн, ТОП - 20 индекс 2007 онд огцом өссөн боловч хямрал эхэлсэнээс хойш буурсан, 2010 онд огцом өсөж 14759 төгрөгт хүрсэн, үнэт цаасны мэргэжлийн байгууллагуудын тоо 2001 онд 42 байсан бол буурсаар 2006 онд 25 болсон. 2006 оноос БДК, андеррайтерийн компаниуд шинээр байгуулагдаж одоо 52 мэргэжлийн зуучлагч компани ажиллаж байна. ҮЦЗЗ-д хувьцаа, Засгийн газрын бонд, компанийн бондыг арилжаалж байна. 1997 онд 54 ХК ногдол ашиг тараасан бол 1998 оноос ногдол ашиг тараалт үндсэндээ үгүй болжээ.

Өнгөрсөн онд 16 ХК ногдол ашиг тараасан байгаа нь нийт бүртгэлтэй компанийн 5% -д хүрэхгүй байна. ҮЦЗЗ -д нийт 6000 гаруй харилцагч данс нээлгэн үйлчлүүлж байгаагийн 90 гаруй % нь дотоод харилцагч, 225 гадаад харилцагч байна. Нийт арилжааны 60 орчим хувь нь дотоодын ААН, 30 гаруй хувьд гадаадын ААН оролцож байна. Өнөөдрийн байдлаар ДНБ -ны 10 орчим хувийг хөрөнгийн зах зээл бүрдүүлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

## **2. Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчин, төрөөс авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ**

Монгол улсад үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, эрх зүйн орчин нь зах зээл идэвхтэй, нээлттэй, шударга, хяналттай хөгжих нөхцөлийг бүрдүүлж чадахгүй байна. Эрх зүйн орчны хувьд :

- “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” 1994 онд батлагдсан, 2005 онд шинэчлэгдсэн
- “Компанийн тухай хууль” –
- “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль” гэх мэт цөөхөн тооны хуулиар хязгаарлагдаж байна.

Үнэт цаасны зах зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санаачлагатай алхамууд төдийлөн хийгдэхгүй байна. Засгийн газрын 2010 оны 115 тоот тогтоолоор “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний жагсаалтыг баталсан. Энэхүү төлөвлөгөөнд зааснаар “Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Хөрөнгийн бирж болон төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааны дүрэм журмыг боловсронгж болгох, хяналт шалгалтын болон хууль эрх зүйн орчны уялдаа холбоог сайжруулах зэрэг цаг үеийн шинжтэй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр заажээ.

Мөнхөрөнгийн биржийн удирдлагыг гадаадын компанид шилжүүлэх, улмаар менежментийн хувьчлалд оруулахаар яригдаж байна. Хөрөнгийн зах зээлийн онол, практикийн асуудлаар мэргэшсэн шинжээчийн хувьд хэлэхэд, өнгөрсөн хугацаанд төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөв байдлыг харахад, 1991 онд 1 удаа төрөөс дэмжлэг үзүүлж зах зээлийн анхдагч суурийг бий болгосноос хойш энэ зах зээл үндсэндээ тодорхой эрх зүйн зохицуулалт, бодлого төлөвлөлт, хяналтгүй явж ирсэн гэдгийг онцолж хэлмээр байна.

Өнгөрсөн үеийн практикаас харахад, зах зээлд бий болсон гажуудал, хөгжихгүй байгаагийн шалтгаан нь объектив гэхээс илүүтэй субъектив хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байна. Энэ зах зээл нь өөрөө маш их хэмжээний хөрөнгийг төвлөрүүлэх, завших, хууль бус үйл ажиллагаа явуулах боломжийг олгодгоороо зах зээлд оролцогч этгээдийн хөрөнгө эзэмших сонирхол, хууль зөрчих нөхцөлийг бүрдүүлж байдаг. Тийм ч учраас ҮЦЗЗ-ийн Олон улсын зохицуулах байгууллагаас зах зээлийн зохицуулалтын хэм хэмжээг тодорхой тогтоож, хатуу чанд мөрдүүлэхийг зөвлөсөөр ирсэн, зөвлөж ч байгаа. Эс бөгөөс зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийн шударга бус үйл ажиллагааны дүнд хөрөнгө оруулагчид хохирдогийн жишээг бид олон удаагийн дэлхийн санхүүгийн хямралаас харсан.

### **Өнгөрсөн хугацаанд эрх зүйн зохицуулалтын хүрээнд, зах зээлд ямар алдаа дутагдал гарав аа? Юуг анхаарах вэ?**

- Өмч хувьчлалын бодлогыг Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн бодлоготой уялдуулаагүйгээс зах зээлийн нэр хүнд унаж, зах зээлд оролцогчдын итгэл алдарсан
- Хөрөнгийн зах зээлийг тодорхой бодлого, төлөвлөлтгүй явуулж ирсэн. Хөрөнгийн биржээр өмч хувьчлалыг явуулахын өмнө ч дараа нь ч иргэд олон нийт, мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх, аттестатчилах, олон нийтэд тайлбарлан таниулах ажиллагаа хийгдээгүй.
- Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчин, батлан гаргасан хууль бодлого шийдвэр нь зах зээлийн зохицуулалтын нийтлэг стандарт шаардлагыг хангахгүй байна. Үнэт цаасны хууль, Компанийн тухай хууль зэрэг одоогийн мөрдөж байгаа хууль нь зах зээлийн зарчимд нийцэхгүй байгаа. Асуудлыг бүрэн, уялдаа холбоотой тусгаагүй, хэрэгжүүлэх арга механизм нь тодорхой бус
- Зах зээлд зайлшгүй шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдээгүй. Үнэт цаасны хөрөнгө оруулалтыг дэмжих схем ажиллахгүй байна. Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгийн итгэмжлэгдсэн удирдлага, тусгай зориулалтын сангуудыг хөрөнгийн зах зээлд ашиглах, харилцагчдад үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх, үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг бүрдүүлэх, үнэт цаас гаргалтыг нэмэгдүүлэх, эрсэдлээс хамгаалах хяналт зохицуулалтын орчин бүрдээгүй байна.
- Зах зээлд оролцогчдын идэвхи санаачлага сул, зах зээлийн өөрийгөө зохицуулах зарчим, харилцан хяналт тавих нөхцөлийг бүрдүүлээгүй байна. Зах зээлд оролцогчдын үүсгэл санаачлагаар бирж болон бусад томоохон зуучлагч байгууллагыг үүсгэн байгуулахыг дэмжихгүй байна. Хөрөнгийн биржийн хувьцааг зах зээлд оролцогчид эзэмших, хамтын удирдлага хяналтын системийг бий болгоогүй.
- **Төрөөс анхаарах хамгийн чухал асуудал нь Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг бүрдүүлэх явдал юм.** Зах зээл нэгэнт оролцогчдын үүсгэл санаачлагаар хөгжиж чадахгүй байгаа тохиолдолд үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийг бий болгоход төрөөс тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийх нь зайлшгүй. Тухайлбал, Үнэт цаасны зах зээл хөгжих суурь бүтэц нь харилцагчид, хөрөнгө оруулагчдад үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц буюу төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, кастодиан үйлчилгээний нэгдсэн систем байдаг.
- Өөрөөр хэлбэл, орчин үеийн техник, технологийн дэвшлийн түвшинд мэдээлэл,

холбоо, программ хангамжийн томоохон дэд бүтцийг бий болгож аймаг, орон нутгийг холбох асуудал чухлаар тавигдаж байна. Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийг 100% төрийн өмчит толгой компанийн хэлбэрээр ажиллуулж зах зээлд зуучлагчдын сүлжээнд холбох нь үнэт цаасны зах зээл болон эдийн засгийн аюулгүй байдалд нийцнэ.

- Хөрөнгийн бирж нь арилжаа эрхлэх үүрэг бүхий томоохон субъект мөн ч гэсэн харилцагчдын мөнгөн хөрөнгө, үнэт цаас арилжаанд шууд оролцогчдоос тусгаарлагдсан байх шаардлагатай. Мөн бусад орнуудын жишгээр цахим хэлбэрийн төвлөрсөн бус биржийн сүлжээг байгуулахад төрөөс анхаарах, хөрөнгө оруулалт хийх.
- Хөрөнгийн биржийн удирдлага, хувьчлалын асуудал нь санхүүгийн зах зээлийн аюулгүй байдал, харилцагчдын хөрөнгийн нууцлалтай холбоотой асуудал гэдгийг анхаарах.
- Зохицуулах байгууллага / Санхүүгийн зохицуулах хороо/-н эрх үүрэг, үйл ажиллагааг сайжруулах. Үнэт цаасны зах зээл нь санхүүгийн зах зээлийн өндөр түвшний мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан байх, мэргэжлийн шалгуур шаардлагыг өндөрсгөх
- Зах зээлд оролцогчдын захиалгаар, тэдний ашиг сонирхолд нийцсэн цоорхойтой хуулийг батлан гаргах, хуулийн хүрээнд луйвар хийх боломж байсаар байна. Иймд хууль, бодлого шийдвэрийн төслийг боловсруулахдаа мэргэшсэн, хараат бус шинжээчдийг оролцуулах, шийдвэр гаргах шатанд ажиллуулах шаардлага байна.
- Зах зээлд гарч буй хууль бус үйлдлийг таслан зогсоох, хариуцлагын механизмсыг өндөрсгөх, шүүх, хуулийн практикт үнэт цаасны хэргийг хянан шийдвэрлэх мэргэшсэн хуульчдыг бэлтгэх гэх мэт.

Үнэт цаасны зах зээл нь хүн төрөлхтөний түүхэнд бий болгосон санхүүгийн зах зээлийн “төгс” хэлбэр учраас маш нарийн зохицуулалт, хяналттай байх ёстой. Зохицуулалт, хяналтын систем, үйл ажиллагаа, дэд бүтэц нь стандарт түвшинд зохион байгуулагдах шаардлагатай тул Олон улсын Үнэт цаасны Зохицуулах байгууллага (IOSCO)-аас эрх зүйн зохицуулалтын 30 стандарт, хэрэгжүүлэх арга хэмжээний аргачлал, зааварчилгааг гаргасан байдаг.

Учир нь үнэт цаасны зах зээл хэдийн чинээн стандартад нийцсэн байдлаар хөгжнөв, төдийчинээн дэлхийн санхүүгийн зах зээлд интеграцчилалд орох, гадаадын хөрөнгө оруулалтыг ҮЦЗЗ рүү татах, эсвэл Монголын компаниуд гадаадын ҮЦЗЗ-д гарах нөхцөл бүрдэх юм. Мөн зах зээлд зуучлагсдад итгэж хөрөнгөө оруулж байгаа бүх хөрөнгө оруулагчид тэдний үйл ажиллагаа шударга, нээлттэй, ил тод байхыг шаарддаг учраас зах зээлийн эрх зүйн орчинг энэхүү нийтлэг шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх шаардлагатай.



ОШ.МН  
СУДАЛГААНЫ САН

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ  
САЛБАРТ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ШИНЖИЛГЭЭ, ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА**  
(Харьцуулсан судалгаа, Захиалагч - УИХ -ын гишүүн С. Бямбацогт)

*Д. Мягмарцэрэн, Г. Билгээ, Ц. Болормаа, Г. Гэрэл,  
Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа*

**Агуулга**

**Оршил**

**Судалгааны үр дүн, санал зөвлөмж**

1. Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал
2. Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах талаарх эрх зүйн зохицуулалт
3. Зарим улс орнуудын гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах болон хориглосон талаархи туршлага
  - БНХАУ
  - ХБНГУ
  - ОХУ
  - Дэлгэрэнгүй хүснэгт
4. “Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай” хуулийн төсөлд хийсэн шинжилгээ

**Ашигласан материалын жагсаалт**

**Хавсралтууд**

**Хавсралт – 1.**

- Монгол улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт (Салбараар)

**Хавсралт – 2.**

- Монгол улсад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн тоо (Салбараар)

**Хавсралт – 3.**

- Монгол улсад бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт(Улсаар)

**Хавсралт – 4.**

- БНХАУ-ын гадаадын хөрөнгө оруулалтын каталог

\* \* \*

**Оршил**

Судалгааг УИХ-ын гишүүн С.Бямбацогтын 6/43 тоот албан бичгээр ирүүлсэн “Үндэсний аюулгүй байдлыг хангахад Стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадыг хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хуулийн төсөл”-д шинжилгээ хийлгэх, гадаад орнуудын холбогдох хуулийн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаа хийлгэх захиалгын дагуу УИХ-ын Тамгын газрын судалгааны төвийн Эдийн засгийн судалгааны багийн судлаачид хийж гүйцэтгэв.

Энэхүү судалгаа нь:

- Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтын талаархи эрх зүйн зохицуулалт
- Энэ талаарх бусад орнуудын туршлага
- Хуулийн төсөлд хийсэн шинжилгээ гэсэн үндсэн хэсгүүдтэй.
- Судалгаанд жишээ болгон 20 орчим орныг сонгон авч харьцуулан судласан. Эдгээрийг сонгохдоо манай улсад оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлж байгаа улс орнууд, мөн гадны хөрөнгө оруулалтаар эдийн засгаа хөгжүүлсэн туршлага бүхий улс орнууд, эдийн засгийн өсөлт, хөгжлөөр манай улстай ойролцоо улс орнууд гэсэн шалгуурыг үндэслэсэн.

Судалгааны үр дүнд манай улсад оруулж буй гадны хөрөнгө оруулалтаас хүртэх үр ашгийг дээшлүүлэхийн зэрэгцээ үндэсний аюулгүй байдал болон дотоодын эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөхүйц эрсдэл ба үүнээс сэргийлэх арга замуудыг тодорхойлохыг зорьсон болно. Судалгааны үр дүн, бусад орнуудын туршлагад тулгуурлан Монгол улсын стратегийн ач холбогдолтой салбарууд, тэдгээрийг тодорхойлсон байдал, хууль эрх зүйн хүрээнд тавьсан хязгаарлалт, хориглолт бий эсэх, хэрэгжүүлэх боломж, механизм нь ямар байгаа талаар харьцуулан судлав.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнгээс харахад аль ч улсад гадаадын хөрөнгө оруулалтын бодлогоо үндэсний аюулгүй байдал болон дотоодын эдийн засгаа хамгаалах бодлоготойгоо уялдуулан шууд болон шууд бус аргаар зохистой хэмжээнд хязгаарлах, шаардлагатай бол хориглох арга хэмжээ авдаг байна.

Судалгаанд хамрагдсан 20 орноос ОХУ, БНХАУ нь бие даасан хуулиар стратегийн ач холбогдолтой салбараа тодорхойлж эдгээр болон бусад холбогдох салбаруудад нь гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээг хязгаарлах, эсвэл хориглох тухай хуульчилсан байна.

Бусад орнуудын хувьд тухайн тухайн салбарын хуулиараа гадаадын хөрөнгө оруулагчдын эзэмших хувь хэмжээг тогтоох, үнэ, тарифийн дээд хязгаар тогтоох, тусгай зөвшөөрөл авах процессийг олон шат дамжлагатай, хяналттай болгох, ажиллах хүчний квот болон ижил хэмжээний цалин тогтоох, хөрөнгө оруулалтын болон хувь нийлүүлэгчдийн гэрээгээр хязгаарлах зэрэг шууд бус олон арга механизмуудыг ашиглан зохицуулалт хийж байна.

Судалгаанаас үзэхэд 2010 онд шинэчлэн баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3-р бүлэгт эдийн засгийн аюулгүй байдал, бие даасан байдлаа хангаж хөгжих, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах гэх мэтийн үзэл баримтлалуудыг тодорхойлсон боловч стратегийн ач холбогдолтой салбаруудыг нарийвчлан тогтоосон, үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалд нийцүүлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын тэнцвэрт байдал, стратегийн ач холбогдол бүхий салбарт баримтлах хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлсон тодорхой хуулийн зохицуулалт, хэрэгжүүлэх механизм дутагдалтай байна. Одоогоор манай улсад Засгийн газрын тогтоолоор стратегийн ач холбогдол бүхий орд газруудын жагсаалтыг баталсан, Үндсэн хуулиар гадаадын этгээдэд газар өмчлөхийг хориглосноос өөр тодорхой хязгаарлалт байхгүй байна.

Бусад орнуудын туршлагаас үзэхэд, зарим орнуудын хувьд стратегийн ач холбогдолтой салбаруудаа хуульчлан нэрлэсэн, эсвэл салбарын хуулиндаа гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалтыг шууд болон шууд бус замаар хориглосон болон хязгаарласан зохицуулалт байдаг байна.

Монгол улсын эдийн засгийн эмзэг бүтэц, гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын өсөлт, тодорхой салбарт чиглэгдэж байгаа байдал, хөрөнгө оруулалт хийж буй арга механизм, ирээдүйд гарч болзошгүй үр дагаврыг харгалзан үндэсний аюулгүй байдалд хамааралтай зарим салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтыг татахдаа дэлхий нийтээр дагаж мөрдөж байгаа хөрөнгө оруулалтын болон хувь нийлүүлэлтийн гэрээний стандарт, шууд бус хязгаарлалтын арга хэрэгсэлүүдийг ашиглах, илүү нээлттэй, хяналттай хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай болох нь судалгаанаас харагдаж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлахдаа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах эерэг, тааламжтай нөхцөлийг алдагдуулахгүй байх, Монгол улсын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эерэг үнэлэмжийг бууруулахгүй байхаар тооцож зохицуулалт хийх шаардлагатай байна.

Хуулийн төслийг боловсруулсан байдлаас үзэхэд, 2008 онд батлагдсан ОХУ-ын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хуулийн концепцтэй нэлээд дөхүү байгаа боловч дараахь хэд хэдэн асуудлыг анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна. Тухайлбал:

1. Хуулийн агуулгаас үзэхэд энэ хуульд стратегийн ач холбогдол бүхий үйл ажиллагааг тодорхойлохдоо ихэвчлэн ОХУ-ын ижил төстэй хуулийн батлан хамгаалахын чиглэлийн үйл ажиллагааны төрлүүдийг авсан байх ба үүн дээр нэмж ашигт малтмал, хүнсний аюулгүй байдал, өдөр тутмын хэвлэл, телевиз радио, холбоо мэдээлэл зэрэг цөөхөн салбаруудыг нэмж тусгасан нь хангалтгүй байна.
2. Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан концепцийн агуулгыг хуулийн төсөлд бүрэн тусгаагүй байна. Тухайлбал, ашигт малтмал, эрчим хүч, банк санхүү, зам тээвэр зэрэг салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар зохицуулалт хийнэ “ хэмээн тусгасан боловч энэ хуулийн төсөлд үзэл баримтлалын агуулгад тэр бүр нийцэх зүйл, заалт ороогүй байна.
3. Хуулийн төслийн 5-р зүйлд заасан “стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид хяналт тогтоох” тухай зохицуулалт нь ойлгомжгүй, төрийн зүгээс тухайн хяналтын багц эзэмшигчид тавих хяналт, хязгаарлалт зэргийг тодорхой заагаагүй, агуулга, утга санаа нь бүрхэг байна.

Хуулийн төслийн хувьд үндсэндээ үзэл баримтлал, зорилгоо тэр бүр хангаж чадахгүй нь харагдаж байгаа тул дараах асуудлуудыг нэмж тусган дахин боловсруулах нь зүйтэй юм. Хуулийн нэр, концепцээс үзэхэд, үндэсний аюулгүй байдалд хамаарах стратегийн ач холбогдолтой салбаруудад хийгдэх гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах, хяналт тавих тухай хууль гэж ойлгогдож байгаа. Иймд энэ хуулийн зохицуулалтанд дараах салбаруудын үйл ажиллагаануудыг тодорхой нарийвчилсан байдлаар тусгаж, холбогдох зохицуулалтуудыг хийх нь зүйтэй байна. Үүнд:

**1) Стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг энэ хуулиар тодорхойлох.**

- а) Ашигт малтмал
- б) Төсөв, банк санхүү, хөрөнгийн зах зээл
- в) Зам тээвэр, эрчим хүч зэрэг дэд бүтцийн салбар
- д) Харилцаа холбоо, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
- е) Үл хөдлөх хөрөнгө зэрэг салбаруудын үйл ажиллагаанаас аль хэсгийг нь стратегийн ач холбогдолтойд тооцохыг холбогдох мэргэжлийн байгууллагуудын тусламжтайгаар нарийвчлан тодорхойлох шаардлагатай.



**2) Хязгаарлалтын арга хэлбэрүүдээ тодорхойлох**

- a) Хувьцаа эзэмших хувь хэмжээг тогтоох буюу шууд хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхой заах.
- b) Ажиллах хүчний квот тогтоох замаар дотоодын ажиллах хүчээ дэмжиж хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах. Мөн гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийн нэмэгдүүлэх нь ГХО-ыг шууд хориглосон зохицуулалт болдоггүй боловч шаардлагатай салбартаа уян хатан байдлаар хязгаарлалт хийж буй тул энэ нь аль аль талдаа хүлээн зөвшөөрөхүйц хязгаарлалт болж болно.
- c) Лицензийн систем буюу аливаа үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг олгохдоо тодорхой үе шат бүхий процесс бий болгох нь хязгаарлалт шаардлагатай салбартаа шууд бус байдлаар хязгаарлалт тавьж байгаа хэлбэр болно. Нөгөө талаар, энэ процессын явцад тухайн ГХО-ын талаарх нарийвчилсан мэдээллийн сан бүрддэг тул энэ нь ийм төрлийн хязгаарлалтыг хэрэглэх үндэслэлийг нэмэгдүүлж байгаа юм.
- d) ГХО-т бүхий үйл ажиллагаанд тодорхой цаг хугацаанд үечилсэн байдлаар буюу эсвэл тодорхой үйл ажиллагаанд чиглэсэн байдлаар хяналт шалгалт байнга хийх нь аливаа зөчил, эрсдлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Гэвч энэ нь хөрөнгө оруулагчийн хэвийн үйл ажиллагаанд их бага ямар нэг хэмжээгээр ямагт саад болж байдаг тул шууд бус хязгаарлалтын нэг төрөл болох юм.

Судалгааны үр дүнгээс харахад дотоод эдийн засгийн чадавхи сайтай ОХУ, БНХАУ зэрэг томоохон орнууд шууд хориглох механизмыг хэрэглэж байгаа нь харагдаж байна. Монгол улс шиг хөгжиж байгаа, буурай орнуудын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг шууд хориглохоос илүүтэй зохистой хязгаарлалт, хяналтын бодлогыг хэрэгжүүлэх нь илүү оновчтой байх болов уу хэмээн үзэж байна. Үүнтэй холбогдуулан “Үндэсний аюулгүй байдлыг хангахад Стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадыг хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хуулийн төсөл”-д хийсэн шинжилгээ болон бусад улс орнуудын туршлагын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны үндсэн хэсгээс үзнэ үү.

**1. МОНГОЛ УЛС ДАХЬ ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн татах, гадаадын хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудал, татварын тогтолцоо, эрх зүйн бусад холбогдолтой зохицуулалтыг улс орон бүхэн өөрийн орны онцлог талыг харгалзан өөр өөрөөр шийдвэрлэдэг.

Манай орны хувьд гадаадын хөрөнгө оруулалт нь бүхэлдээ хийгээд бүсчилсэн нутаг дэвсгэр, тодорхой аймаг нийслэл, сум баг, компанийн хөгжил дэвшил, үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлдэг улс төр, эдийн засаг, эрх зүйн чухал хүчин зүйл юм. Монгол улсын эдийн засгийн хөгжилд гадаадын хөрөнгө оруулалт голлох байр суурийг эзэлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дараахь давуу талууд байна.

**Давуу талууд:**

- Гадаадын Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрдсэн.
- Гадаадын Хөрөнгө оруулалттай холбоотой Олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан.
- Дэлхийн Худалдааны байгууллага, НҮБ болон холбогдох бусад олон улсын байгууллагад гишүүнээр элссэн.
- Нээлттэй эдийн засгийн бодлоготой.
- Татварын тогтолцоо, хөнгөлт, чөлөөлөлтийн систем
- Хоёр их гүрний дунд оршдог
- Байгалийн томоохон нөөц ордуудтай.

**Дутагдалтай талууд нь :**

- Хууль эрх зүй, эдийн засгийн тогтворгүй байдал/эмзэг эдийн засагтай жижиг улс/
- Улс төрийн тогтворгүй байдал
- Инфляци
- Дэд бүтцийн хөгжил сул
- Авлига, хүнд суртал
- далайгаас алслагдсан, газар зүй, байгаль, цаг уурын тааламжгүй нөхцөл


Монгол Улс дэлхийн бусад орны нэгэн адил гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж үр шимийг нь хүртэх зорилгоор Үндсэн хууль болон Монгол Улсын элсэн орсон олон улсын гэрээгээр зохицуулахын зэрэгцээ “Монгол Улсын Гадаадын Хөрөнгө Оруулалтын хууль”-ийг 1993 онд баталсан бөгөөд 1998, 2001, 2002 болон 2008 онд 2 удаа нийт 5 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү хуулийн хүрээнд “Гадаадын Хөрөнгө Оруулалт, Гадаад Худалдааны Агентлаг”-ийг байгуулан ажиллаж байна.

Монгол улс нь Дэлхийн Банкны Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлагийн гишүүн бөгөөд 1965 оны Вашингтоны конвенцид Олон улсын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх асуудлаар 1996 онд, 1985 оны Сөүлийн конвенцид хөрөнгө оруулалтын даатгалын асуудлаар 1999 онд тус тус элсэн орсон.

Манай улс бусад орнуудтай харьцуулахад дэлхийн гадаадын хөрөнгө оруулалтын урсгалаас өчүүхэн хэсгийг хүртэж байгаа нь олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа хэдий ч хөрөнгө оруулалтыг дэмжих оновчтой бодлого, зөв зохион байгуулалт, эрх зүйн таатай орчин зэргийг оновчтой бүрдүүлэн хөгжүүлж чадвал зохих үр шимийг хүртэх бүрэн боломжтой юм. 1990 оноос өнөөг хүртэл Монгол Улсад 104 улс орон, тусгай статустай бүс нутгуудаас **10686** гадаадын хамтарсан болон 100 хувийн хөрөнгө оруулалттай компани бүртгэгдэж, нийт **4 826 тэрбум ам.долларын** хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Нийт гадаадын хөрөнгө оруулалтын 65,4 хувь буюу 3156,2 тэрбум ам.долларыг геологи, уул уурхайн салбарт, 18,7 хувь буюу 901,7 сая ам.долларыг худалдаа нийтийн хоолны салбарт, 2,7 хувь буюу 131,4 сая ам.доллар нь банк санхүүгийн салбарт, 2,2 хувь буюу 107,9 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хөнгөн үйлдвэрийн салбарт, үлдсэн 11,0 хувийг нь бусад салбаруудад оруулсан байна.

Зураг 1. Гадаадын хөрөнгө оруулалт хамгийн ихээр хийгдсэн салбарууд




Эх сурвалж: Гадаадын Хөрөнгө Оруулалт, Гадаад Худалдааны Агентлаг



Манай улсад 1990 оноос одоог хүртэл хамгийн их хөрөнгө оруулалт хийсэн улс орон буюу оруулсан хөрөнгийнх нь нийт гадаадын хөрөнгө оруулалтад эзлэх хувиар нь авч үзвэл:

- БНХАУ-аас 51,9 хувь буюу 2465,0 тэрбум ам.доллар,
- Канад 8,3 хувь буюу 400 сая ам.доллар,
- Их Британийн Виржин арал 7,6 хувь буюу 367,1 сая ам доллар,
- БНСУ 5,3 хувь буюу 255,7 сая ам.доллар,
- Нидерланд 3,1 хувь буюу 149,1 сая ам доллар,
- Япон 2,9 хувь буюу 138,4 сая ам.доллар,
- ОХУ 2,24 хувь буюу 18,1 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.



Эх сурвалж: Гадаадын Хөрөнгө Оруулалт, Гадаад Худалдааны Агентлаг

Зураг 3-аас харахад манай оронд оруулах гадаадын хөрөнгө оруулалтын урсгал жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2007 онд 36,4 хувь, 2008 онд 41,8 хувь, 2009 онд 13,0 хувь, 2010 оны урьдчилсан гүйцэтгэлээр 26,3 хувиар тус тус өмнөх оныхоос өссөн байна.



2010 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар буюу жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр **1 тэрбум 11,5 сая орчим ам.долларын** хөрөнгө оруулалттай **746 гадаадын хөрөнгө оруулалттай компани** бүртгэгдээд байгаагаас салбараар нь авч үзвэл, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбарт 817,7 сая, худалдаа нийтийн хоолны салбарт 150,5 сая, банк санхүүгийн салбарт 13 сая, эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээний салбарт 7,5 сая, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт 3,8 сая, тээврийн салбарт 2,9 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн нь бусад салбаруудыг тэргүүлж байна.

2010 онд бүртгэгдсэн хөрөнгө оруулалтыг улс орноор авч үзвэл Нидерланд улсаас 233,0 сая, БНХАУ-аас 173,3 сая, Канадаас 147,8 сая, Бермудаас 114,5 сая, Их Британийн Виржин арлуудаас 101,7 сая, Хонгконгоос 79,6 сая, БНСУ-аас 38,7 сая, Сингапураас 31,0 сая, Люксембургаас 25,6 сая ам.долларын хөрөнгө оруулалт гэх зэрэг нийт 59 орноос 1011,6 ам долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна.

2010 онд бүртгэгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт нь өмнөх оны жилийн эцсийнхээс 26,3 хувиар өссөн ба сүүлийн 5 жилийн дунджаас 1,9 дахин, 1990-2009 онуудад бүртгэгдсэн нийт хөрөнгө оруулалтын дунджаас 5 дахин буюу 530 хувиар өссөн байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дотоодын 67 мянган боловсон хүчнийг ажлын байраар хангасан бөгөөд 2500 гаруй гадаадын мэргэжилтнүүд Монгол улсад ажиллаж удирдлагын шинэ шинэ арга технологийг нэвтрүүлсэн нь маш том оюуны хөрөнгө оруулалт юм. Caterpillar, Samsung, Sumitomo, Coca Cola, Itochu, Komatsu, Hyundai, Procter & Gamble, Ford, Mercedes-Benz болон бусад дэлхий дахинд алдаршсан томоохон корпорациуд Монголд үйл ажиллагаа явуулж байна. Уул уурхай, аялал жуулчлал, дэд бүтэц болон газар тариалан зэрэг нь гадаадын хөрөнгө оруулалтын томоохон салбарууд болоод байна. Төр засгаас 2002 оныг “Хөрөнгө оруулалтыг сурталчлах жил” болгон зарласан бөгөөд үүний зорилго нь уул уурхай, газар тариалангийн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах, аялал жуулчлал болон мэдээллийн технологийн зэрэг голлох салбаруудад хийгдэх хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэхэд оршиж байв.<sup>64</sup>

## 2. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, эд хөрөнгийг хамгаалах болон гадаадын хөрөнгө оруулалтын холбогдолтой харилцааг зохицуулах зорилт бүхий “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийг УИХ-аас 1993 онд баталсан болно.

Манай улсын хувьд энэ хуулиар Гадаадын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжиж, хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл бүрдүүлсэн боловч өнөөдрийн байдлаар эдийн засагт хангалттай хэмжээний өсөлтийг бий болгож чадахгүй байна. Түүнчлэн, гадаадын хөрөнгө оруулалтыг хэт дэмжих бодлого нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалд хамаарах стратегийн зарим салбарын хувьд сөргөөр нөлөөлөх хандлагатай байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар **гадаадын хөрөнгө оруулагч** - Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харъяалалгүй хүн, түүнчлэн гадаадад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/-ийг хэлнэ. Гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээс бусад

<sup>64</sup> ГХГОА-ийн мэдээллээс;

хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт хийж болохыг хуулиар тодорхойлсон байна.

Аж ахуйн үйл ажиллагааны зөвшөөрлийн тухай хуульд /2001/ зааснаар хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, импортлох, худалдах /эмнэлгийн зориулалтаар зэрэг тусгайлан зөвшөөрсөн бол үүнд хамаарахгүй/, садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих, казиногийн үйл ажиллагаа эрхлэх /чөлөөт бүсэд хамаарахгүй/, олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар хууран мэхэлж ашиг хонжоо олох үйл ажиллагаа нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд хориотой юм.

Монгол Улсад оруулах гадаадын хөрөнгө оруулалт нь эрх зүйн хувьд:

- а/ чөлөөтэй хөрвөх валют, хөрөнгө оруулалтын үр дүнг төгрөгөөр олсон орлого;
- б/ хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээртэй холбогдсон эд хөрөнгийн эрх;
- в/ оюуны өмчийн эрх гэсэн гурван үндсэн төрөлтэй байна.

Тэгвэл гадаадын хөрөнгө оруулалтыг эрх зүйн хэлбэрийн хувьд:

- а/ аж ахуйн нэгж байгуулах;
- б/ монголын хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;
- в/ монгол улсын аж ахуйн нэгжийн ногдол хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах замаар шууд бус хөрөнгө оруулалт хийх;
- г/ байгалийн баялгийг ашиглах, боловсруулах талаар хууль, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу эрх олж авах;
- д/ маркетинг, менежментийн гэрээ байгуулах;
- е/ санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх хэлбэрээр хэрэгжих боломжтой юм.

Үүнээс үзэхэд цаашид холбогдох гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хууль батлах замаар улс орны эдийн засагт стратегийн ач холбогдол бүхий зарим салбаруудад гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг улс орны эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, үндэсний бизнесийн салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах шаардлагатай гарч байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн хүрээнд дэх эрх зүйн зохицуулалтаас гадна Үндэсний аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий салбарын асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдөр “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” 48 тоот тогтоолыг баталсан. Мөн тогтоолын,

- 3.2.2 -т Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогыг дараахь байдлаар тодорхойлжээ.
- 3.2.2.1. Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.2.2. Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтална. Гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцвэртэй байлгах бодлого баримтална.

- 3.2.2.3. Монгол Улсын үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд борлуулахдаа гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлээр баримтлах бодлогын зарчим алдагдахгүй байх эрх зүйн орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.2.4. Гадаадын хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чадвар, санхүү, менежментийн үр өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үндсийг тавих чухал хөшүүрэг, арга хэрэгсэл болгоно.
- 3.2.2.5. Гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт хараат байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулна. Эсспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Энэ тогтоолын 1.1.1-т **“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал”** гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ гэж заасанаас бол стратегийн ач холбогдол бүхий салбар гэдэгт уг тогтоолоор Эрдэс баялаг, хүнс, хөдөө аж ахуйн, эрчим хүч, зам тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, санхүүгийн салбар зэрэг салбарыг багтаасан байна.

#### **Монгол улсын хууль тогтоомжоор гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалтын талаар хэрхэн зохицуулсан вэ?**

Гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын стратегийн ач холбогдолтой салбарын компанийн хувьцааг эзэмших, хөрөнгө оруулалт хийхэд ямар нэгэн хязгаарлалт тавигдаагүй байгаа бөгөөд “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуульд зааснаар гадаадын хөрөнгө оруулагч Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу худалдан авч шууд хөрөнгө оруулалт хийх, ААН, салбар төлөөлөгчийн газраа дангаар буюу хамтарсан компанийн хэлбэрээр байгуулах, хөрөнгө оруулалтын тааламжтай нөхцөл, татварын хөнгөлөлт, тогтвортой байдлын гэрээ хийх асуудлууд хуульчлагджээ.

Уг хуулинд гадаадын хөрөнгө оруулагч Монгол улсын хуулиар хориглоогүй үйлдвэрлэл үйлчилгээг хориглосноос бусад нутаг дэвсгэрт явуулж болохоор зааснаас үзэхэд цаашид холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар ашигт малтмал, эрчим хүч, зам, тээвэр, банк санхүү зэрэг улс орны эдийн засагт стратегийн ач холбогдолтой салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт оруулах асуудлыг улс орны эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, үндэсний бизнесийн салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

Гадаадын хөрөнгө оруулагчидын хувьд Монгол Улсын хууль болон дүрэм, гэрээний заалтыг сахин биелүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах, монголын ард түмний үндэсний ёс заншлыг хүндэтгэх үүргийг хуульчлан өгсөнөөс гадна дараахь асуудлуудыг зохицуулсан байна.

- 1) Монгол Улсад аж ахуйн нэгж байгуулахын тулд өөрийн хөрөнгө нь 100 мянган ам.доллараас дээш байх, түүний 25-аас доошгүй хувь нь хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн байх шаардлагатай юм.
- 2) Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь бүртгүүлсэн өдрөөсөө хуулийн этгээдийн эрх эдэлнэ. Харин аж ахуй нэгж байгуулах, зөвшөөрлийг Гадаадын хөрөнгө оруулалтын газар мэргэжлийн хяналтын байгууллагын гаргасан дүгнэлтийг /хуульд нийцэж байгаа эсэх, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл,

стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцэж байгаа эсэх, техник, технологийн түвшний үнэлгээ/ үндэслэн олгоно.

- 3) Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид татварын хууль тогтоомжийг үндэслэн татвар ноогдуулахын зэрэгцээ Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Гаалийн тариф, Гаалийн татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Онцгой албан татварын тухай хууль, Газрын тухай хуулийн дагуу зохих хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг шийдвэрлэж байна.
- 4) Монгол Улсын зах зээлд хөрөнгө оруулагчийг татах эрх зүйн нэг чухал хэлбэр нь “Тогтвортой байдлын гэрээ” юм. Монгол Улсад 20 сая ам.доллараас доошгүй хэмжээний хөрөнгө оруулах хөрөнгө оруулагч хүсэлт гаргавал түүний үйл ажиллагаа явуулах орчныг тогтвортой байлгах эрх зүйн баталгаа болгож Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд уг хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээг 20 жил, 50 сая ам.доллараас дээш бол 15 жилээр гэрээ байгуулна.
- 5) Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалтын нэг чухал асуудал бол газрын харилцаа юм. Гадаадын хөрөнгө оруулагчид газрыг төлбөртэйгээр, гэрээний үндсэн дээр ашиглуулах бөгөөд газар ашиглах гэрээний үндсэн хугацаа эхний ээлжинд 60 жил, дараагийн удаа 40 жилээр сунгаж болно.

Үүнээс гадна Гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиас гадна Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай (1993), Иргэний хууль (2002), Хөдөлмөрийн тухай (1999), Компанийн тухай (1999), Аудитын тухай (1997), Дампуурлын тухай (1997), Аялал, жуулчлалын тухай (2000), Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай (2000), Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (2001), Ажиллах хүч гадаадад гаргах, Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001), Үнэт цаасны зах зээлийн тухай (2002), Төв банкны тухай (1996), Валютын зохицуулалтын тухай (1994), Банкны тухай (1996), Гаалийн тухай (1996), Гаалийн тарифын тухай (1996), Газрын тухай (2002), Газрын төлбөрийн тухай (1997), Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай (2006), Хувь хүний орлогын албан татварын тухай (2006), Онцгой албан татварын тухай (2006), Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай (2006) зэрэг хуулиар зохицуулж байна.

Эдгээр хуулиар гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн гэж үзэж болох бөгөөд цаашид тэдгээрийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах, стратегийн ач холбогдол бүхий зарим салбарын хувьд тодорхой хязгаарлалтыг тогтоон мэдээлэл, технологи, татвар, үйлдвэрлэлийн чиглэлээр хууль, тогтоомжийг шинээр батлан гаргах нь зүйтэй юм.

### **Гадаадын зарим улс оронд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн хязгаарласан бэ?**

Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиуд нь гадаадын хөрөнгө оруулалтыг хянах, дэмжин зохицуулах үүрэгтэй байдаг ба улс орнуудын хууль гурван янз байдаг байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтыг ихээхэн дэмжсэн, элдэв хязгаарлалтыг аль болох бага байлгахад чиглэсэн байх (ихэвчлэн булангийн орнууд)
2. Хөрөнгө оруулалтыг янз бүрийн аргаар дэмждэг ч, дотоодын оролцоог илүү чухалчилах, квот тогтоох зохицуулалт хийх (ихэвчлэн хөгжиж буй орнууд)
3. Гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрч байгаа боловч дотоодын хяналтанд байлгах бодлого (ихэвчлэн хөгжингүй орнууд)

Улс орон бүр гадаадын хөрөнгө оруулалтыг янз бүрийн аргаар хязгаарладаг бөгөөд хамгийн түгээмэл арга бол хөрөнгө оруулалтын хувь хэмжээнд хязгаарлалт тогтоох явдал

юм. Тухайлбал: БНХАУ-д хөрөнгө оруулалтыг 51%, Энэтхэгт 40%, Солонгос 50%, Мексикт 49% хүртэлх нь тухайн улс үндэсний өөрийн хөрөнгө оруулалт байхыг зөвшөөрсөн байдаг.

Хөрөнгө оруулалтын хувь хэмжээнээс гадна эдийн засгийн тодорхой нэг салбарын хувьд хязгаарлалт хийж болох бөгөөд ингэхдээ нэгд, зөвхөн тухайн улс эсвэл дотоодын компани л хөрөнгө оруулах эрхтэй эдийн засгийн салбар, хоёрт, тоотой хэдэн гадаадын хөрөнгө оруулагчид л хөрөнгө оруулах эрхтэй аль нэг тодорхой салбар, гуравт, гадаадын хөрөнгө оруулалтыг бүрэн дэмжих салбар гэсэн гурван арга зам байна.

**Нэг дэх** төрлийн буюу гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд хаалттай салбар бол нийтийн хэрэглээний салбар, **стратегийн ач холбогдол бүхий салбар**, тухайн улсад харьцангуй өндөр түвшинд хөгжчихсөн салбар, дотоодын үйлдвэрлэгчийн хөрөнгө оруулж чадах жижиг дунд үйлдвэрийн салбарууд зэргийг юм. Тухайлбал: Франц улсад мэдээллийн хэрэгсэл, шуудан холбоо харилцаа, төмөр зам, цахилгаан, газ зэрэг салбар зөвхөн төрийн эсвэл төрийн өмчийн компаниудад нээлттэй байдаг бол ОХУ-д даатгалын салбар, үнэт цаасны арилжааны салбарт гадны хөрөнгө оруулахыг хорьсон.<sup>65</sup>

**Хоёр дахь** буюу гадаадын хөрөнгө оруулалтад тодорхой хэмжээний хязгаарлалт бүхий салбаруудыг тухайн улс янз бүрийн шалтгаанаар хязгаарладаг. Тухайлбал: Өмнөд Солонгост ажлын хүчийг ихээр шаарддаг салбар, түүхий эд боловсруулалт, дотоодын зах зээл рүү чиглэсэн салбаруудыг тодорхой хэмжээгээр хязгаарлаж байдаг. Австрали улсад радио, телевиз, мэдээллийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг 20% хүртэл хязгаарласан байна.

**Гурав дахь** буюу гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд бүрэн нээлттэй салбар нь ихэвчлэн дотоодын хүчин чадал, нөөц багатай, дотоодын ажилгүйдлийг багасгах, гадаад худалдааны экспортын хэмжээг ихэсгэхэд чиглэгдсэн салбарууд байдаг.

Ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд тухайн үйлдвэрлэлийн суурь тавих, технологийн шинэчлэл хийх, ажилгүйдлийг багасгах, экспорт ихэсгэх салбарууд болох хөдөө аж ахуй, мал аж ахуй, байгалийн баялаг ашиглалт, аялал жуулчлал, үйлдвэрлэл, уул уурхай, барилга, тээвэр, олон улсын худалдаа, компьютер технологи зэргийг ихээхэн дэмжиж байна.

Манай улсын хувьд хөгжлийн чухал ач холбогдол бүхий салбарууд болох уул уурхай, хөдөө аж ахуй, дэд бүтэц, аялал жуулчлал, банк санхүү, мэдээллийн технологи, барилга угсралт зэрэг салбаруудад хөрөнгө оруулалт түлхүү хийгдэж байна. Гадаадын хөрөнгө оруулалтад салбарын хязгаарлалтаас гадна зарим орнуудын хувьд газар зүйн хязгаарлалтууд байдаг. Тухайлбал: Аргентин улсад далайн эрэг орчмын газарт гадаадын хөрөнгө оруулалтыг хориглодог бол Индонези, Тайланд, Өмнөд Солонгост гадаадын иргэн газрыг өмчлөхөд хориглодог.

#### **Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах шаардлагууд:**

Гадаадын хөрөнгө оруулалтад тавих хяналтын нэг хэлбэр нь Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьцаа эзэмших эрхийг хязгаарлах явдал юм. Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулагч тодорхой нэг компанийн хувьцааг эзэмшихийг бүрэн хориглох, тодорхой хувийг эзэмшихийг зөвшөөрөх /49%-аас доош хувь эзэмших/, эсвэл холбогдох төрийн захиргааны

<sup>65</sup> <http://www.tsast.mn/project/?pageID=31&mid=34&subid=34&smid=31> – 2011.01.07



байгууллагаас урьдчилж зөвшөөрөл авсны үндсэн дээр хувьцаа эзэмших зэрэг аргуудыг бусад орнууд хэрэглэдэг байна.

Үүнээс гадна энэ хязгаарлалтын хүрээнд гадаадын хөрөнгө оруулалттай компанийн хувьд хөрөнгө оруулж буй салбараас хамааран тухайн компанийн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи нь тухайн орны иргэн байх шаардлагыг тавьдаг. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага OECD<sup>66</sup> - /Organisation for Economic Co-operation and Development/-гийн гишүүн орнууд гадаадын хөрөнгө оруулалтанд олон төрлийн хязгаарлалт, шаардлагуудыг тавьж байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг III бүлгээс үзнэ үү./

Гадаадын хөрөнгө оруулагчдад хувьцаа эзэмшүүлэхийг хязгаарлах бодлого нь дараахь шалтгаанаас үүдэлтэй. Үүнд:

- Эдийн засгийн шалтгаан - ихэвчлэн хөгжиж буй орнуудад түгээмэл байдаг бол үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шалтгаан нь өндөр хөгжилтэй орнуудад чухал шалтгаан болдог байна.
- Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах болон улс төрийн шалтгаан - Гадаадын хөрөнгө оруулалт, тэр тусмаа гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшихийг хязгаарлаж буй салбарууд нь ихэвчлэн байгалийн нөөц баялгийг ашиглах болон батлан хамгаалах салбар байна. Мөн эрчим хүч, тээвэр, харилцаа холбооны салбарт энэ хязгаарлалтыг түгээмэл хэрэглэдэг байна.

Дээрхи шалтгаануудаас үүдэлтэй хязгаарлалтуудыг дэлгэрэнгүйгээр авч үзвэл.

### **Дотоодын хөрөнгө оруулалтыг хамгаалахтай холбоотой хязгаарлалтууд**

Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах эдийн засгийн шалтгаан нь ихэвчлэн тухайн салбарын бодлоготой холбоотой. Өөрөөр хэлбэл төрийн зүгээс тухайн салбарыг дэмжих үүднээс дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжих бодлогыг барьж байгаа тохиолдолд тухайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласнаар үндэснийхээ бизнесийн салбарыг хөгжүүлэх бодлого барих шаардлагатай юм. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагч компаниудыг дотоодын зах зээл дээр монополь тогтоохоос хязгаарлаж улмаар дотоодын компанийг өсөж хөгжих нөхцөл бололцоогоор хангаж байгаа явдал юм.

Тодорхой салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах бодлого нь түр зуурын шинжтэй байх ба үүнийг дэлхийн олон улс орнууд өргөнөөр хэрэглэж байна. Хэдийгээр иймэрхүү хязгаарлалт тогтоох практик нь Олон улсын худалдааны байгууллагын тогтоосон де-факто буюу олон улсын худалдаа хийхэд ямар нэгэн саад тогтор үзүүлж буй ялгаварласан асуудал болох боловч ОУХБ нь эдийн засгийн тодорхой салбарт хязгаарлалт, хориг тавихыг зөвшөөрдөг байна. Гэхдээ тухайн улс орон тодорхой хугацааны дараа энэхүү хориг, саадыг өөрчлөх үүрэг хүлээх ёстой гэсэн нөхцөл тавьдаг.

Эдийн засгийн шалтгаанаар тодорхой салбарт хөрөнгө оруулахыг хязгаарласан орнуудын тоонд Латин Америкийн хэд хэдэн орнууд орж байна. Жишээ нь, Чили улс далайн тээвэр, атомын цахилгаан станцад гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан. Аргентин улс санхүүгийн салбарт, даатгал, радио телевизин салбарт, Бразил улс мөн санхүүгийн сектор, төмөр зам, уул уурхай, холбооны салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байна.

### **Үндэсний аюулгүй байдал болон улс төрийн шалтгаантай холбоотой хязгаарлалтууд**

Энэ төрлийн хязгаарлалтууд нь ихэвчлэн өндөр хөгжилтэй орнуудад хэрэглэгддэг бөгөөд

<sup>66</sup> [http://en.wikipedia.org/wiki/Organisation\\_for\\_Economic\\_Co-operation\\_and\\_Development](http://en.wikipedia.org/wiki/Organisation_for_Economic_Co-operation_and_Development)

гадаадын хөрөнгө оруулагч нь ямар нэг компанийн хувьцааг эзэмших хэлцэл хийхийг тодорхой салбарын хувьд бүхэлд нь хориглох, эсвэл нэг удаагийн хязгаарлалт байж болдог. Эдийн засгийн шалтгаантай хязгаарлалтаас ялгаатай нь гэвэл ОУХБ-ын зүгээс үндэсний аюулгүй байдлын шалтгааныг харгалзан ямар нэгэн хориг тавихгүй бөгөөд үүнийг түр зуурын арга хэмжээ гэж үздэг.

Өөрөөр хэлбэл гадаадын тодорхой нэг хөрөнгө оруулагчийг тухайн улсад хөрөнгө оруулах, аль нэг үндэсний компанийн хувьцааг эзэмшихийг хориглосон хязгаарлалт гэж ойлгож болох юм. Тухайлбал: БНХАУ нь АНУ-ыг генетикийн хувьд өөрчлөгдсөн ургамлын үр үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт хийхийг хориглодог байна. Мөн ХБНГУ нь терроризмыг илт дэмждэг болон улс төрийн хувьд дарангуйллын системтэй улс орнуудыг тухайлан нэр зааж, эдгээртэй харилцах эдийн засгийн аливаа харилцаанд тодорхой хязгаарлалт, хориглолт тавьсан хуулийг батласан байна.

Үүнээс гадна гадаадын хөрөнгө оруулалт оруулах, дотоодын компанийн хувьцааг эзэмшихэд эдийн засгийн аль ч салбарт ямар ч хориг саад, хязгаарлалт тавьдаггүй зарим улс орнууд байна. Эдгээр орнуудын хувьд гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмшихдээ төрийн байгууллагаас ямар нэгэн зөвшөөрөл авахгүй бөгөөд хөрөнгө оруулсныг төрийн байгууллагын зүгээс гэрчилдэг байна.

Дээрхи хязгаарлалтуудыг хэлбэр нь Гадаадын хөрөнгө оруулалтыг хориглох, хязгаарлах талаар дэлхийн бусад улс орнуудын баримталж буй бодлого, хандлагаас үзэхэд хязгаарлалтууд үндсэндээ стратегийн ач холбогдолтой салбаруудад голдуу тавигдаж байна. Үүнд: байгалийн нөөц ашиглах, батлан хамгаалах, тээвэр, дэд бүтэц, эрчим хүч, харилцаа холбоо, санхүүгийн салбар болон хэвлэл мэдээллийн салбарууд голлож байна.

### **3. ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЯЗГААРЛАХ БОЛОН ХОРИГЛОСОН ТАЛААРХИ ТУРШЛАГА**

#### **3.1. БНХАУ**

Хятад улсын эдийн засгийн өндөр өсөлтөөс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг ихээхэн татдаг улс гэдгийг тодорхойлж болно. Гэсэн ч Хятад улсад хөрөнгө оруулахыг хүссэн гадаадын хөрөнгө оруулагчид зарим нэг хөрөнгө оруулалтын орчин нөхцлийн дутагдалтай асуудлуудтай тулгардаг. Үүнд: ил тод байдал дутагдах, дотоодын фирмүүдийг дэмжин хамгаалсан аж үйлдвэрийн бодлогууд, найдваргүй хуулийн систем зэрэг багтана.

Одоогоор хятад улсын гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихгүй байгаа салбарт:

- Ашгийн төлөөх валют, үл хөдлөх хөрөнгө эсвэл хөрөнгийн дамын наймаа
- Хятадын үндэсний аваргыг хөгжүүлэх гэж хичээж байгаа салбарууд
- Улсын монополийн эрхтэй болон улсын хөрөнгө оруулалтын уламжилсан түүхэн ач холбогдолтой салбарууд
- Нийгмийн тогтвортой байдалтай холбогдолтой чухал салбарууд
- “Roundtrip” хөрөнгө оруулалт

Хятадын хууль болон эрх зүйн зохицуулалтууд нь гадаадын ашиггүй өрсөлдөөнөөс болон гадаадын монополын аж үйлдвэрүүдээс хамгаалах чухал хамгаалалт болдог. Үүнд зориулан байнга авдаг арга хэмжээнүүд нь ил тод биш байдаг нь гадаадын хөрөнгө оруулагчдад урьдчилан тооцоход ихээхэн нөлөөлдөг, учир нь хөрөнгө оруулагчид тэдний хөрөнгө оруулалтын төслийг Хятад улс зөвшөөрөх эсэх нь тодорхой бус байдаг.

Одоогоор Хятад улсын гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа салбарт, гадаадын



хөрөнгө оруулалтыг нээлттэй байлгахыг шаардаж байгаа ба Хятад улсын дарга бас хятад улс нь зарим салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхитэй дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Үүнд: өндөр технологийн судалгаа болон хөгжил дэвшилтэт үйлдвэрлэл, болон орчин үеийн газар тариалан ба үйлчилгээний салбар харин энгийн үйлдвэрлэл биш байна.

### **“Чухал аж үйлдвэрүүд ба чухал ач холбогдолтой салбар”-т хөрөнгө оруулалтын хязгаарлалт**

Хятад улс “Чухал аж үйлдвэрүүд ба чухал ач холбогдолтой салбар”-т хувийн хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байгаа, Хятадын засгийн газрын тодорхойлсноор, үүнд “Үндэсний аюулгүй байдалтай хамаарах аж үйлдвэрүүд, гол дэд бүтэц ба чухал ашигт малтмалын нөөц, нийтийн чухал бүтээгдэхүүн болон үйлчилгээ үзүүлдэг аж үйлдвэрүүд мөн тулгуур үйлдвэрүүд ба өндөр технологийн чухал ач холбогдол бүхий аж ахуйн нэгжүүд орно”. 2006 оны 12 сард “Guiding Opinion Concerning the Advancement of Adjustments of State Capital and the Restructuring of State-Owned Enterprises”-д Хятад өөрийн улсынхаа эдийн засгийг хөгжүүлэх ба бэхжүүлэхийг гол болгон уриалсан. Үүнд удирдлагаа чангатгах ба “Үндэсний аюулгүй байдал болон үндэсний эдийн засгийн амьдарлын шугамтай холбогдох Чухал аж үйлдвэрүүд ба чухал ач холбогдолтой салбар”-ын нөлөөллийг чангатгах зэргийг оруулна.

Улсын хөрөнгө хяналт захиргааны комисс /State-owned Assets Supervision and Administration Commission (SASAC)/-ын удирдагчын “Чухал аж үйлдвэрүүд ба чухал ач холбогдолтой салбар”-ыг тодотгосноос хойш, энэ нь зөвхөн нисэх хүчин, нүүрс, батлан хамгаалалт, эрчим хүч болон улсын газрын тос, нефть химийн, усан онгоцны тээвэрлэлт ба алсын холбоо зэргээр хязгаарлагдахгүй гэж тодотгосон. “Тулгуур аж үйлдвэр”-т автомашины, химийн, барилга, электрон мэдээлэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, төмөр болон ган, өнгөт төмөрлөг, шинжлэх ухаан ба технологи, мөн олборлолт болон дизайн хийх зэрэг орно.

Хятад улсын хөрөнгийн тухай хууль нь хятад улсын эдийн засгийн системийг хамгаалах “Социалист зах зээлийн эдийн засаг”-ыг дэмжих, улсын эдийн засгийг бэхжүүлэх ба хөгжүүлэх, түүнчлэн Хятадын эдийн засагт ялангуяа “Чухал аж үйлдвэрүүд ба чухал ач холбогдолтой салбар”-т SOE-ыг голлох рольд тоглуулах зорилготой. Энэ хууль нь Хятад улсыг үндэсний аюулгүй байдал болон “Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал”-д чухал ач холбогдолтой аж үйлдвэрүүдийн төвлөрүүлэлт болон давамгайл байдалтай байлгах SOE-г дэмжих бодлогын арга хэмжээ авахыг шаарддаг байгаа.

### **Хятад улсын гадаадын хөрөнгө оруулалтын шалгалт болон зөвшөөрөл олгох процесс**

2004 оны 10-р сард гаргасан ба одоо ч хүчинтэй байгаа “Гадаадын хөрөнгө оруулалтын зөвшөөрөл ба хяналт шалгалтыг удирдах түр арга хэмжээ” /the Interim Measures for the Administration of Examining and Approving Foreign Investment Projects/-ний дагуу, хятад улсад хийх бүх гадаадын хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын салбар болон ач холбогдлоос нь хамааран NDRC эсвэл мужын эсвэл орон нутгийн Хөгжил шинэчлэлийн комисс /Development and Reform Commissions/ “төслийн баталгаа /project verification” –г заавал хураалган өгнө. Төслийн хяналт нь хятад улсын хууль эрх зүйн зохицуулалт, улсын үндэсний аюулгүй байдал болон эдийн засгийн хөгжилд тохирч байгаа эсэхийн талаар төсөлд үнэлгээ хийх зэргийг багтаана. Зарим тохиолдолд NDRC нь мөн Хятад улсын холбогдох аж үйлдвэр зохицуулалтын “Зөвлөх агент” –аас (үүнд дотоодын фирмүүдийг төлөөлдөг салбарын холбоонууд орж болно) саналыг авдаг.

Хэрэв төслийн хяналт дуусвал худалдааны яамнаас (MOFCOM) гадаадын хөрөнгө оруулалтын гэрээний үүсгэн байгуулалт нь хятад улсын хууль эрх зүйн зохицуулалтад

тохирсон болохыг гэрчилсэн “Аж үйлдвэр байгуулах баталгаа /enterprise establishment verification/” хийж өгнө. Гадаадын хөрөнгө оруулагч үүний дараагаар улсын аж үйлвэр болон худалдааны яаманд компани үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох бизнесийн лицензийн өргөдөл гаргана. Хэрэв лицензээ авчихвал, хөрөнгө оруулагч Хятад улсын татвар болон гадаад валют арилжааны агентад бүртгүүлнэ. Хэрэв Greenfield салбарт хөрөнгө оруулалт хийх гэж байгаа бол заавал Хятад улсын байгаль орчин хамгааллын яам болон газрын нөөцийн яамнаас зөвшөөрөл авах шаардлагатай байдаг.

### **Гадаадын хөрөнгө оруулалттай холбогдох хууль тогтоолуудын хязгаарласан гол заалтууд**

#### **“БНХАУ-ын банк санхүүгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тогтоол”**

5-р зүйл Бүрэн хөрөнгө оруулалттай болон хамтарсан хөрөнгө оруулалттай банк байгуулахад бүртгэлийн хураамж хамгийн багадаа 300000000 юантай тэнцэх хэмжээтэй төлбөр төлнө. Бүрэн хөрөнгө оруулалттай болон хамтарсан хөрөнгө оруулалттай санхүүгийн компани байгуулахад бүртгэлийн хураамж хамгийн багадаа 200000000 юан байна.

13-р зүйл Хятадын ардын банк гадаадын хөрөнгө оруулалттай банк санхүүгийн байгууллагын өргөдөл анхан шатны хяналт шалгалт хийж, бүрэн бүтэн материалаа хураалгасан өдрөөс эхлэн 6 сарын дотор хүлээж авах эсэх шийдвэр гаргана. Хүлээн авах шийдвэр гарвал, өргөдөл гаргагчид албан ёсны өргөдлийн маягтыг өгнө. Хүлээж авахгүй бол өргөдөл гаргагчид бичгээр шалтгааныг нь мэдэгдэнэ.

#### **“Ард түмний агаарын тээврийн салбарын гадаадын хөрөнгө оруулалтын тогтоол”**

3-р зүйл Гадаадын хөрөнгө оруулалтыг иргэдийн агаарын тээврийн салбарын хүрээнд иргэдийн онгоцны буудал (үүнд цэргийн зориулалттай онгоцны буудал орохгүй), нийтийн агаарын тээврийн компани, нийтийн хэрэглээний агаарын болон агаарын тээвэртэй холбогдолтой төрөл зэрэгт ангилна.

Агаарын зам тээврийн удирдах системд гадаадын хөрөнгө оруулалт болон удирдлагад оролцохыг хориглоно. Мөн улсын нууцтай холбогдох ажиллагааны төрлийг хориглоно.

6-р зүйл Иргэдийн онгоцны буудлын гадаадын хөрөнгө оруулалтанд хятадын тал хамгийн их хувьцааг эзэмшигч байна. Нийтийн агаарын тээврийн салбарт хятадын тал хувьцааг эзэмших ба нэг гадаад хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын хэмжээ 25 хувиас дээшгүй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын онгоцны засвар болон агаарын тээврийн шатахууны төрөлд хятадын тал хувьцаа эзэмшинэ. Барааны агуулах, газар дээрх үйлчилгээ, агаарын хүнс, зогсоол зэрэг төрөлд гадаадын хөрөнгө оруулалтын харьцааг Хятад ба гадаадын хөрөнгө оруулагч талууд тохиролцож болно.

7-р зүйл Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан үйл ажиллагаатай компани үйл ажиллагаа явуулах хугацаа 30 жилээс хэтрэхгүй байна.

14-р зүйл Гадаадын хөрөнгө оруулагч иргэдийн агаарын салбарт /төсөлд хувьцааны эрхээ ихэсгэх эсвэл өөрчлөх үед, хянан зөвшөөрөл олгодог байгууллагаар хянан зөвшөөрүүлэх ёстой.

**“Газрын ховор элементүүдийн салбарт гадаадын  
хөрөнгө оруулалтыг удирдах түр тогтоол”**

3-р зүйл Газрын ховор элементүүдийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтын төслийг уурхайн уул, хайлуулалт хуваалт, боловсруулалт болон хэрэглэх гэсэн 3 том ангилалд хуваадаг.

1. Гадаадын хөрөнгө оруулалтыг Хятад улс доторх газрын ховор элементүүдийн уурхайн уулын салбарт хориглоно.
2. Газрын ховор элементүүдийн хайлуулалт хуваалт зэрэг салбарт гадаадын хөрөнгө оруулалттай компанитай хамтран үйл ажиллагаа буюу хамтран хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж болно.

8-р зүйл Газрын ховор элементүүдийн хайлуулалт хуваалтын үйл ажиллагаа явуулдаг Хятадын хувьцаа гаргадаг компанид хятадын хуулийн этгээд гадаадын хөрөнгө оруулагчид хувьцаагаа шилжүүлэхийг хориглоно.

**“Гадаадын хөрөнгө оруулалттай хэвлэл нийтлэлийн үйлдвэр байгуулах түр тогтоол”**

6 - 5 зүйл Хэвлэл нийтлэл гаргах үйл ажиллагаа явуулах хамтарсан компанид хамтран үйл ажиллагаа явуулах Хятадын тал хувьцааг эзэмших ба голлох байр суурьтай байна. Түүнээс ийм төрлийн компанид захирлыг хятадын талаас томилох ба захирлын зөвлөлийн хурлын гишүүдийн хятад талын тоо гадаадын талаас олон байна.

6 - 6 зүйл Үйл ажиллагаа явуулах хугацаа 30 жилээс хэтрэхгүй.

**“Гадаадын хөрөнгө оруулалтын чиглэл удирдах тогтоол”**

6-р зүйл дараах тохиолдлууд нь гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах төрлийн төслүүд:

1. Техникийн түвшин хоцрогдсон бол.
2. Байгалийн баялаг хэмнэлт болон байгаль орчныг сайжруулахад ашиггүй бол.
3. Улсаас тогтоосон хамгаалалтын шинжтэй онцгой ашигт малтмалд хайгуул хийх буюу олборлоход.
4. Улсын чөлөөтэй болгосон салбаруудад хамаарагдах бол.
5. Хууль, захиргааны хуулиудад тогтоосон бусад төрлийн төсөл.
6. 7-р зүйл дараах тохиолдлууд нь гадаадын хөрөнгө оруулалтыг хориглох төрлийн төслүүд:
  - Улсын аюулгүй байдал болон нийгэмд нийтийн эрх ашгийг хохироохоор бол.
  - Байгаль бохирдуулах аюултай болон байгалийн баялаг эсвэл хүний эрүүл мэндэд хор учруулахаар бол.
  - Тариалангийн талбайг их хэмжээгээр эзэлсэн, газрын баялагыг хамгаалах ба нээхэд ашиггүй бол
  - Цэргийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд болон ашиглах үр дүнд хохирол учруулж байгаа бол
  - Хятад улсын онцгой гар урлаг эсвэл технологийн үйлдвэрлэх бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа бол
  - Хууль, захиргааны хуулиудад тогтоосон бусад байдал

8-р зүйл **“Гадаадын хөрөнгө оруулалтын чиглэл удирдах тогтоол”-д** гадаадын

хөрөнгө оруулалтын төрөлд хамтран ажиллах, хамтран хөрөнгө оруулахыг хязгаарласан бол, Хятадын тал хувьцааг эзэмших эсвэл хятадын тал хамгийн их хувьцааг эзэмшинэ.

Хамтран ажиллах, хамтран хөрөнгө оруулахаар хязгаарласан гэдэг нь зөвхөн хятад гадаадын хамтран хөрөнгө оруулалтыг зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулах болон хятад гадаадын хамтран ажиллахыг хэлнэ. Хятадын тал хувьцааг эзэмшинэ гэдэг нь хятадын хөрөнгө оруулагч гадаадын хөрөнгө оруулалтын төсөлд эзэмших хувьцаа нь нийт 51 хувиас дээш байна. Хятадын тал хамгийн их хувьцааг эзэмшинэ гэдэг нь хятадын хөрөнгө оруулагчид гадаадын хөрөнгө оруулалттай төсөлд эзлэх нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь ямар ч талын гадаадын хөрөнгө оруулагчдын нийт хөрөнгө оруулалтын хэмжээнээс их байна. Хятадын эзэмших хувьцааны хэмжээ 50% хүрэхгүй байж болно.

## I. Гадаадын хөрөнгө оруулалтын каталог

Хятад улс гадаадын хөрөнгө оруулалтын зорилгоо “Гадаадын хөрөнгө оруулалт хийх аж үйлдвэрийн салбарын удирдлагын каталог” /Catalogue for the Guidance of Foreign Investment Industries/-д тодорхойлсон. Гадаадын хөрөнгө оруулалтын каталогыг хамгийн сүүлд 2007 онд өөрчлөн шинэчилсэн. Каталогт хэдэн жил болгон янз бүрийн засгийн газрын агентын заавраар нэмэлт засвар хийгддэг. Энэ бол байнгын баримт бичиг, үүний бодлогыг тодорхой хугацаанд засгийн газрын саналаар өөрчилж тогтоодог, тиймээс хэвлэгдсний дараа хятадын гадаадын хөрөнгө оруулалтыг бүрэн тусгаж чаддаггүй. 2008 оны 12 сард хятад улс төв өрнөд бүс нутагтаа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор энэ каталогт дахин нэмж өөрчлөлт оруулсан.

Гадаадын хөрөнгө оруулалт каталог нь хоёр гол үйл ажиллагааг үзүүлдэг. Нэгдүгээрт, хятад улс гадаадын хөрөнгө оруулагчдад туслах зорилгоор аль эдийн засгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмждэг, хязгаарладаг болон хориглодог талаар хятад улсын олон төрлийн аж үйлдвэрийн бодлогыг тодорхойлохоор зориулагдсан. Түүнчлэн үүнд янз бүрийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтын зарим хязгаарлалтыг тодорхой тайлбарласан байдаг. Хязгаарласан олон салбарт гадаадууд хөрөнгө оруулалтыг хийхдээ хятадын компанитай хамтран хамтарсан компани байгуулах ёстой болдог. Ингэхдээ тэдний хувьцааг Хятад улсын талаас бага байхаар хязгаарладаг. Түүнчлэн засгийн газраас зөвшөөрөн өөрчлөн шинэчилсэн каталогийг, шинэ дүрэм журмыг дагаж мөрдөх болон арга хэмжээнүүдийг явуулах бусад холбогдох агентууд руу явуулна.

Каталогт ороогүй хөрөнгө оруулалтын салбарыг зөвшөөрдөг салбарт тооцно. Хятад улсад “Дэмждэг” төрлийн хөрөнгө оруулалтын салбар нь гадаадын туслалцааг болон технологийг Хятад улсад ашигтай гэж үздэг. Харин “Хязгаарладаг” салбарт үндэсний эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ байхгүй гэж тооцдог. Хятад улсаас гадаадын хөрөнгө оруулалтыг “Хориглосон” олон салбар байдаг. Тухайлбал: зарим хөдөө аж ахуй, уул уурхай, үйлдвэрлэл, эрчим хүч, тээвэрлэлт, шинжлэх ухааны судалгаа, боловсрол болон хэвлэл мэдээллийн аж үйлдвэрүүд зэрэг орно.

## Гадаадын хөрөнгө оруулалтын каталогт гарч байгаа асуудлууд

Гадаадын хөрөнгө оруулалтын каталогт гарч байгаа гол асуудал бол Хятад улс каталогиа шинэчлэхээс өмнө нээлттэй байдгүйд сэтгэл дундуур байгаагаа мөн ямар ч өөрчлөх шалтгаангүй өөрчлөлт хийдэг гэж гадаадын хөрөнгө оруулагчид саналаа илэрхийлсэн. Үүнээс гадна Хятад улсын эрх бүхий зохицуулагчид нь каталогыг дагахгүйгээр, харин гадаадын хөрөнгө оруулалтыг бусад шалтгаанаар хязгаарлалт хийдэг ба эсвэл зөвшөөрлийг уян хатнаар үл тоодог байдал гаргадаг байна. Асуудлын хэсэг шалтгаан бол каталог бол ерөнхий удирдамж болохоос албан ёсны хязгаарлалтын бүхэлд нь хамарсан жагсаалт биш юм.

Каталог ба бусад арга хэмжээнүүдийн хоорондох зөрчилдөөн нь хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлдэг ба хөрөнгө оруулалтын бизнесийн төлөвлөгөөнд бат бэх суурийг олгож чаддаггүй ойлгоц байдлыг нэмэгдүүлдэг.

### 3.2. ХБНГУ

Уламжлал ёсоор, Герман улс нь гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй бодлого баримталдаг улс юм. Харин маш бага тооны хязгаарлалт байдаг нь зэр зэвсгийн үйлдвэрлэл болон байлдааны хэрэгсэл, нууц бичээс тайллын системийн үйлдвэрлэл, түүнчлэн улсын нууцын зэрэглэлтэй материалын тээвэрлэлтэд зориулсан өндөр чанартай, сансрын алсын зайн удирдлагатай системийн үйлдвэрлэл гэх мэт улс орны батлан хамгаалах салбарт хамааралтай үйлдвэрлэлд гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан байдаг ажээ.

Герман улсын хувьд гадаадын хөрөнгө оруулалтын харилцааг “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хууль”, “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-аар тусгайлан зохицуулах бөгөөд, ашигт малтмал, банк, санхүү болон бусад салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг Герман улсын иргэний хууль, ашигт малтмалын тухай хууль, Германы төв банкны тухай хууль гэх мэтчилэн холбогдох хууль тогтоомжуудаар зохицуулсан байдаг.

2009 оны 4 сарын 24-ны өдөр “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хууль” /Foreign trade and payments act/ болон “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх журам” /Regulation Implementing the Foreign trade and payments act/-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь Герман дахь гадаадын хөрөнгө оруулалтыг хянах, цаашлаад тодорхой заримыг нь хориглох боломж бололцоог өргөтгөж өгсөн байна.

#### “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хууль” дахь хязгаарлалт:

**Хязгаарлах болсон үндэслэл:** Тус нэмэлт өөрчлөлтөөр Германд түр оршин суугч болон Герман улсын харъяат бус хөрөнгө оруулагч нь Германы аж ахуйн нэгж, компанийг шууд болон шууд бус замаар худалдан авах, тухайн компаний саналын эрхтэй хувьцааны 25 болон түүнээс дээш хувийг худалдан авах нь төрийн бодлогод харшилсан шинжтэй бөгөөд ХБНГУ-лын аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй гэж үзвэл дээрх худалдан авалтыг хориглох боломжийг хуулиар олгосон юм. Энэхүү зохицуулалтыг “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хууль”-ийн 7-р зүйлд нэмэлтээр оруулсан байна.

Дээрх төрийн бодлого болон улсын /үндэсний/ аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй нөхцөл байдал нь үнэн бодитой, нийгмийн үндсэн ашиг сонирхлын аль нэгэнд ноцтой аюул занал учруулах тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалтыг хориглоно. “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хууль” болон “Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-д аль нэг салбарыг онцлон хязгаарлахаар нэрлээгүй бөгөөд эрчим хүчний хангамж болон стратегийн ач холбогдол бүхий харилцаа холбооны чиглэлийн хөрөнгө оруулалтуудад голчлон анхаарсан бөгөөд энэхүү зохицуулалтыг тус хуулийн 28-р зүйлд нэмэлт өөрчлөлт оруулснаар зохицуулсан байна.

Хуульд шинээр хийгдсэн зохицуулалтууд нь Европын холбоо болон Европын Чөлөөт Худалдааны Холбооны гишүүн орнуудын иргэн, оршин суугч хөрөнгө оруулагчдыг хамрахгүй бөгөөд, харин Америк, Австрали, Азийн орны хөрөнгө оруулагчдад хамааралтай зохицуулалт юм.

Түүнчлэн, тус нэмэлт өөрчлөлтөөр “Хэрэв, гадаадын хөрөнгө оруулагч нь Германы аж ахуйн нэгжийг бүхлээр нь буюу хэсэгчлэн худалдаж авбал “Холбооны Эдийн Засаг Технологийн Яам” худалдан авалтын гэрээ хийгдсэнээс хойш 3 сарын дотор тухайн

худалдан авалт нь Герман улсын үндэсний аюулгүй байдал, төрийн бодлогод харшилж байгаа эсэхийг шалгах аргаар хяналт шалгалт явуулах боломжтой” болсон байна. Хэрэв уг хяналтын шалгалтаар тухайн худалдан авалт нь Германы төрийн бодлого болон үндэсний аюулгүй байдалд харшилж байвал худалдан авалтыг хориглох эрхтэй байна. Ийнхүү хориглох шийдвэрийг яам дангаараа гаргахгүй бөгөөд Холбооны Засгийн газрын зөвшөөрлөөр уг шийдвэрийг гаргах аргаар заасан байна.

Тус нэмэлт өөрчлөлтөөр зохицуулсан дараагийн нэг асуудал нь Германы компанийг бүхлээр нь эсвэл 25 хувиас дээш саналын эрх авсан этгээд нь Европын холбоо болон Европын Чөлөөт Худалдааны Холбооны гишүүн орны иргэн, оршин суугч байсан ч, тухайн компаний 25 хувиас дээш саналын эрхийг эзэмшигч нь Европын холбоо болон Европын Чөлөөт Худалдааны Холбооны гишүүн орны иргэн, оршин суугч биш бол дээр дурдсан хяналт шалгалтыг мөн явуулж болохоор заасан явдал юм. Эдгээр зохицуулалтын талаар тус хуулийг хэрэгжүүлэх журмын 53-р зүйлээс нарийвчилсан зохицуулалтыг харж болох юм.

Эдгээр хязгаарлалтууд нь ямар нэгэн салбар, секторыг тодорхойлон заагаагүй, шаардлагатай тохиолдолд аль ч салбарт үйлчлэх хүчинтэй байна. Мөн аж ахуйн нэгжийн хэмжээ, цар хүрээг тодорхойлон заагаагүй тул шаардлагатай тохиолдолд ямар ч хэмжээний аж ахуйн нэгжийг хамарч болно.

Түүнчлэн, хөрөнгө оруулагч нь Германы аж ахуйн нэгжийг худалдан авах буюу хөрөнгө оруулахаас өмнө Холбооны эдийн засаг, технологийн яамнаас тухайн хөрөнгө оруулалт нь Германы үндэсний аюулгүй байдал, төрийн бодлогод харшлахгүй гэсэн тусгай Сертификат авах боломжтой бөгөөд ингэхийн тулд тус яаманд хандан өргөдөл гаргаж болох ажээ. Хөрөнгө оруулагч нь Холбооны эдийн засаг, технологийн яамны гаргасан шийдвэртэй холбогдуулан Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах дээрх хууль болон журам нь Герман улс дахь хөрөнгө оруулалтын нээлттэй, таатай нөхцлийг муутгахгүй бөгөөд ховор, онцгой тохиолдлуудад хэрэглэгдэх ажээ.

#### **“Гадаад худалдаа болон төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-д заасан хязгаарлалтууд**

Дээрх хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор тухайн хуулийг хэрэгжүүлэх журамд 2009 онд мөн нэмэлт өөрчлөлт орсон юм. Энэхүү журам нь Гадаад худалдаа болон төлбөр тооцооны тухай хуулийн заалтыг нарийвчлан зохицуулсан журам юм. Тус журмын 2, 3-р бүлгээр экспорт болон импортын бараа бүтээгдэхүүн дахь хязгаарлалтыг зохицуулсан байна. Харин 3,4,5-р бүлгүүдээр үйлчилгээ, үндсэн хөрөнгийн болон төлбөр тооцооны гэрээ, хэлэлцээр дахь хязгаарлалтуудын талаар зохицуулсан байна. Үүнээс 7-р бүлэг болох Төлбөр тооцооны гэрээний асуудлаар дараахь улс орнуудад тусгайлан хязгаарлалт хийхээр зохицуулсан байна. Үүнд:

- Сомали
- Руанда
- Сьерра-Леоне
- Ал-Кайда бүлэглэлийн хүчирхийлэгч Осам Бин Ладэн болон Террорезмийн эсрэг тусгайлсан хязгаарлалт
- Ирак
- БНАКонго улс
- Либери
- Зимбаб



- Бирм, Мянмар
- Зааны ясан эрэг
- Судан
- Узбекистан
- Ливан
- Хойд Солонгос зэрэг нийт 13 оронд тусгайлсан хязгаарлалт баримтлахаар тус журамд зохицуулсан байна.

### 3.3. ОХУ

ОХУ-д стратегийн ач холбогдол бүхий салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хэд хэдэн эрх зүйн актаар зохицуулж байна. Үүнд:

1. ОХУ-д гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль. №160. 1999 он.
2. Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хууль. №57. 2008 он.
3. “Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай” холбооны хууль батлагдсантай холбогдуулан ОХУ-ын зарим хууль эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах болон хүчингүй болсонд тооцох тухай хууль. №58. 2008 он.
4. Өрсөлдөөнийг хамгаалах тухай хууль. №135. 2006 он.
5. ОХУ-д гадаадын хөрөнгө оруулалтын хэрэгжилтэнд хяналт тавих Засгийн газрын хорооны тухай. Засгийн газрын тогтоол №510. 2008 он.
6. Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулах тухай хэлцэл хийх урьдчилсан зөвшөөрөл олгох болон тэдгээр аж ахуй нэгжүүдэд хяналт тогтоохыг зөвшөөрөх тухай журам. Засгийн газрын тогтоол №838. 2009 он.
7. Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулагчдын үүргийн биелэлтийг хангуулах төрийн үйл ажилгааны тухай. Холбооны монополютой тэмцэх албаны журам. 2010 он.
8. Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдийн дүрмийн сангийн 5 болон түүнээс дээш хувийн хувьцааг гадаадын хөрөнгө оруулагч эзэмших тухай мэдэгдэх хуудасыг хянаж үзэх төрийн үйл ажиллагааны тухай. Холбооны монополютой тэмцэх албаны журам. 2010 он.
9. Гадаадын хөрөнгө оруулагчид улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдтэй хэлцэл хийх урьдчилсан зөвшөөрөл олгох болон тэдгээр тэдгээр аж ахуй нэгжүүдэд хяналт тогтоох тухай өргөдлийг хянаж үзэх төрийн үйл ажиллагааны тухай. Холбооны монополютой тэмцэх албаны журам. 2010 он.

Эдгээрээс тус улсад гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчны ерөнхий зохицуулалтыг “ОХУ-д гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-иар (1999 он) зохицуулдаг бөгөөд уг хуульд зааснаар үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууламж, зан суртахуун, эрүүл мэнд, улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, бусдын хууль, эрх зүйн ашиг сонирхол зэргийг хамгаалах зорилгоор үндсэний зарим салбарт гадаадын хөрөнгө

оруулалтыг Холбооны хуулиар хязгаарлана<sup>67</sup> гэсэн байна.

“ОХУ-д гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийн 6-р зүйлд 2008 онд өөрчлөлт оруулсан. Шинэчилсэн найруулгад гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллага, эсхүл тэдгээрийн хяналтад байдаг байгууллага нь оросын ААН-ийн дүрмийн санг бүрдүүлж буй саналын эрх бүхий хувьцааны 25-аас дээш хувийг шууд буюу шууд бусаар эзэмших тухай хэлцэл, эсхүл тэдгээр аж ахуйн нэгжийн удирдлагын шийдвэрт хориг тавих боломж олгох тухай хэлцэл байгуулахад “Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай” хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэхээр заажээ.<sup>68</sup>

“Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай” (№57) хуулиар дараахь асуудлыг зохицуулж байна:

- гадаадын хөрөнгө оруулагчид стратегийн ач холбогдол бүхий ААН-үүдийн хувьцааг эзэмших тухай, эсхүл энэ төрлийн ААН-үүдэд хяналт тогтоох тухай хэлцлийг хязгаарлах,
- стратегийн ач холбогдол бүхий үйл ажиллагааг тодорхой болгох,
- гадаадын хөрөнгө оруулагчид стратегийн ач холбогдол бүхий ААН-үүдэд хөрөнгө оруулах тухай өргөдлийг хянаж үзэх процедур,
- хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлага.

**Стратегийн ач холбогдол бүхий ААН** гэдгийг №57 хуулийн 6-р зүйлд заасан улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий үйл ажиллагааны 42 төрлүүдийн аль нэгийг эрхэлж байгаа ААН-г ойлгоно гэсэн байна.<sup>69</sup> Үүнд цөмийн хэрэглэгдэхүүн, радио идэвхит бодис олборлох, боловсруулах, тээвэрлэх, ашиглах, хадгалах; мэдээлэл төрөлжүүлэх, ашиглах; байлдааны зэвсэг техник зохион бүтээх, үйлдвэрлэх, засвар, ашиглах, худалдах хийх; сансарын үйл ажиллагаа зэргийг хамруулсан байна.

Мөн түүнчлэн байгалийн баялаг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлүүд, хэвлэлийн үйлдвэр, харилцаа холбооны зэрэг салбаруудын үйл ажиллагаануудыг стратегийн ач холбогдол бүхий үйл ажиллагаанд багтаасан бөгөөд эдгээр 18 төрлийн үйл ажиллагааг “Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай” Монгол Улсын хуулийн төсөлд тусгасан байна.

2004 оны ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1009 тоот зарлигаар Холбооны стратегийн ач холбогдол бүхий 514 үйлдвэрийн газар, ААН, болон 549 төр удирдах саналын эрхтэй хувь нийлүүлсэн компаниудын жагсаалтыг гаргасан байна.<sup>70</sup> Жагсаалтад хэд хэдэн удаа өөрчлөлт орсон бөгөөд 2010 оны байдлаар улсын үйлдвэр, ААН – 230, хувь нийлүүлсэн компани – 208 болж цөөрсөн. Мөн 2010 оны 6-р сард ОХУ-ын Ерөнхийлөгч Дмитрий

<sup>67</sup> “ОХУ-дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”. 4-р зүйлийн 2 дахь заалт. 1999.07.09. №160-ФЗ.

<sup>68</sup> “ОХУ-дахь гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”. 6-р зүйл. 1999.07.09. №160-ФЗ.

<sup>69</sup> “Улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий аж ахуй нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх тухай хууль” 2-р зүйлийн 1 дэх заалт. 2008.04.29-ны №57-ФЗ.

<sup>70</sup> “Стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрийн газар болон хувь нийлүүлсэн компаниудын жагсаалт”. ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1009 тоот зарлиг. 2004.08.04. Эх сурвалж: <http://archive.kremlin.ru/text/docs/2004/08/75174.shtml>



Медведев уг жагсаалтыг бүр 5 дахин багасгах тухай зарлигийг гаргасан улсын үйлдвэр, ААН – 159, хувь нийлүүлсэн компани – 41 хүрсэн байна.<sup>71</sup>

2008 оны “ОХУ-д гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд хяналт тавих Засгийн газрын хорооны тухай” Засгийн газрын 510 тоот тогтоол нь №57 хуультай холбогдон гарч, ОХУ-д улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий ААН-үүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд хяналт тавих Засгийн газрын хороог байгуулсан.

Хорооны үндсэн үүрэг нь дээрхи салбарт гадаадын хөрөнгө оруулах тухай хэлцэл хийх урьдчилсан зөвшөөрлийг Холбооны хуульд нийцүүлэн олгох, эсвэл түтгэлзүүлэх аж. Хорооны гишүүдийг Засгийн газар томилох ба одоогийн байдлаар Хорооны даргаар Засгийн газрын тэргүүн Путин В.В. ажиллаж байна. Мөн тогтоолоор ОХУ-д улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий ААН-үүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд хяналт тавих эрх бүхий байгууллагаар Холбооны монопольтой тэмцэх алба (ХМТА).

- №57 хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн хугацаанд ХМТА-нд нийт 165 гадаадын хөрөнгө оруулагчдаас<sup>72</sup> 174 өргөдөл ирсэн бөгөөд өргөдлийн агуулгыг дараах байдлаар ангилна:
- 56% – холбооны шинжтэй газрын баялаг ашиглахтай холбогдсон хэлцэл,
- 19% – мэдээлэл төрөлжүүлэх салбар, тэр дундаа 15% - банкны салбартай холбогдсон хэлцэл,
- 11% – монополь үйл ажиллагаа явуулж буй хүрээнд;
- 9% – радио телевиз болон хэвлэлийн салбартай холбогдсон хэлцэл,
- 5% – бусад стратегийн ач холбогдол бүхий салбартай холбогдсон хэлцэл.

Харин Засгийн газрын хороо нь 8 удаагийн хуралдаанаараа гадаадын хөрөнгө оруулагчдын 47 өргөдлийг хянаж үзээд 38-д нь зөвшөөрсөн, 2-т нь татгалзсан хариу өгсөн бөгөөд 7 өргөдлийг гадаадын хөрөнгө оруулагчдад нь хуульд заасан тодорхой үүргүүдийг биелүүлэхийг даалгаж, биелүүлсэн тохиолдолд зөвшөөрөл олгохоор шийдсэн байна.

ХМТА нь улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий ААН-үүдэд гадаадын хөрөнгө оруулалттай холбоогдсон хууль тогтоомжийг илүү нарийвчилан зохицуулах журмуудыг гаргажээ. Журмуудаар дараах асуудлыг нарийвчлан журамлажээ:

- гадаадын хөрөнгө оруулагчдын гаргаж байгаа өргөдөлд тавих шаардлагыг илүү тодорхой болгох,
- өргөдөл гаргагч нь нэг салбарт хүсэлт гаргасан, эсхүл гаргасан өргөдөлдөө өөрчлөлт оруулах гэх мэт ижил төстэй хэд хэдэн өргөдөл гаргаж байгаа тохиолдолд өргөдөлүүдийг хүлээн авсан хугацааг тогтоох,
- эрх бүхий байгууллагын бүрэн эрхийг тодорхой болгох,
- ХМТА-ээс зөвшөөрөл олгох дараалал, Засгийн газрын хорооноос заасан гадаадын хөрөнгө оруулагчдын биелүүлэх үүргийн дарааллыг тогтоох.

<sup>71</sup> <http://www.finmarket.ru/z/nws/news.asp?id=1532135&rid=1>

<sup>72</sup> Олон улсын байгууллага – 10, гадаад улсын Засгийн газар, олон улсын байгууллага, эсхүл тэдгээрийн хяналтад байдаг байгууллага – 24, гадаадын хөрөнгө оруулагч хувийн компани – 131.

## Дэлгэрэнгүй хүснэгт

Улс орон	Хязгаарлаж буй арга хэлбэрүүд	ГХО-ыг хорьсон салбарууд	Тайлбар
<b>1. БНХАУ</b>  нийтдээ 80 гаруй салбарт хязгаарлалт тогтоосон байна. Тухайлбал: -Хүнсний үйлдвэрлэлд төмс, хөвөн, ургамлын тос -Мод бэлтгэл, экспортлох /Хамтарсан компаниудад/ -газрын ховор элементийг олборлох ашиглах /Хамтарсан Компаниуд/ -эм бэлтгэл зэргийг хязгаарладаг. Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт хэсгээс үзнэ үү.	1. ГХО-тай Компани байгуулахад шаардагдах мөнгөн хөрөнгийн доод хязгаар тогтоосон. Үүнд: -ГХО-тай хуулийн этгээдийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 100,000 Юань, -Хамтарсан Хөрөнгө Оруулалттай Хуулийн этгээдийн этгээдийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 30,000 Юань, -Хөрөнгийн Биржд бүртгэгдсэн болон Засгийн Газраас тусгайлан ГХО-ыг хязгаарласан салбаруудад хөрөнгө оруулах ГХО-тай хуулийн этгээдийн дүрмийн сангийн доод хэмжээ нь 5,000,000 Юань байна. 2. Хориглосон болон хязгаарласан салбарын талаархи тусгай жагсаалтыг Засгийн газраас баталдаг. 3. Хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хятадын талын эзэмших хувь нь 51 –ээс дээш байхыг шаарддаг.	Нийтдээ 32 салбарт хориглосон. Тухайлбал: -Мэдээллийн агентлагууд, -Радио телевизийн дамжуулах сүлжээ, -Кино үйлдвэрлэл -Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл -Ерөнхий боловсрол -Зарим ашигт малтмалын олборлолт, боловсруулалт -Ногоон болон тусгай цай хийх Хятадын уламжлалт соёл -Хятадын уламжлалт эмийн үйлдвэрлэл -Генетикийн хувьд өөрчлөгдсөн ургамлын үрийн үйлдвэрлэлд АНУ-ын Хөрөнгө оруулалтыг хориглосон.	ГХО-ыг үндсэндээ тэр бүр дэмждэггүй. Дотоодын эдийн засгаа хамгаалах болон үндэсний аюулгүй байдал гэсэн шалтгаанаар ГХО-ыг ихээхэн хязгаарлаж хориглосон. Хязгаарлаж буй арга хэлбэрийг 2 хувааж болно. Нэг дэх хэсэгт шууд бусаар хязгаарлаж байгаа бол 2, 3 дахь хэсэгт шууд хязгаарлаж байна.
<b>2. ОХУ</b>  Гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээг тухайн төсөл хөтөлбөр, компанид: -Эрчим хүчний салбарт 20-25 хувь, -Ашигт малтмалын салбарт 10 хувь, -Иргэний агаарын тээвэрт Эдгээрээс гадна батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах салбарт тусгайлан хууль батлан гаргасан. Энэ хуулиар ГХО-ыг 49 хүртэл хувь байхыг зөвшөөрсөн. Гэхдээ зарим тодорхой үйл ажиллагаа эрхлэхэд 10 хүртэл хувийг зөвшөөрөхөөр тусгасан.	Гадаадын хөрөнгө оруулах тухай хуулиар шууд болон шууд бус хэлбэрээр хязгаарласнаас гадна хязгаарлалтыг нэг удаагийн буюу байнгын, хориглосон салбарыг хугацаатай болон хугацаагүй, тухайлсан нэг улстай буюу нийтэд нь гэж салбаруудыг ангилж үзсэн байна. Тухайлбал: шууд бус хязгаарлалтын хэлбэр нь хөрөнгө оруулагчид виз олгох болон сунгахад, компанийн ажиллагсадын тодорхой хувийг ОХУ-ын иргэд байхыг шаардах зэргээр илэрдэг.	Цахилгаан эрчим хүч болон байгалийн хийн монополь компаниудаас 2006, 2008 онд ГХО-г хассан. <sup>1</sup>	ГХО-ыг тэр бүр дэмждэггүй. Аль болох бага байлгах, шаардлагатай салбаруудаас ГХО-ыг шахах бодлого баримтладаг.

<b>3.Казахстан</b>  2009 оны 8-р сард ЗГ-ын тогтоолоор газрын тос болон байгалийн хийн 100 гаруй ордыг стратегийн ач холбогдолтой гэж үзсэн. Үүнд Тэнгиз, Кашаган, Карачаганакскийн ордууд багтдаг.	Газрын хэвлийн тухай шинэ хуулиар <sup>2</sup> ГХО-тай компани дахь тус улсын иргэн болон гадаад ажилчид адил хэмжээний цалин авч байх, орон нутгийн хөгжилд зориулан хандив тусламж өгч байх зэрэг далд хэлбэрийн хязгаарлалтууд бий болгосон. Мөн гадаад ажилчдад виз олгоход хүндрэл бий болгох, ажлын байрны төлбөрийг нэмэгдүүлэх зэргээр дотоодын ажиллах хүчнээ илүү дэмждэг.	Байхгүй	ГХО-ыг дэмждэг ч үүнийг ашиглан дотоодын ажиллах хүчнээ боловсруулах, иргэдийнхээ амьдралын чанарыг дээшлүүлэх бодлого баримталж байна.
<b>4.Кувейт</b>  -Газрын тос -Байгалийн хий -Банкны салбар -Агаарын тээвэр	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын тухай хуулиар <sup>3</sup> газрын тос, байгалийн хийн компанийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Банкны салбарт тодорхой нэр бүхий 10 компанид зөвшөөрөл олгосон. Агаарын тээврийн компанийн ажилчдын тодорхой хувь нь тус улсын иргэд байхыг шаарддаг. Мөн бие даасан аудиторууд 2 жил тутам үйл ажиллагаанд нь шалгалт хийдэг. 2001 онд өмч хувьчлалын хөтөлбөр хэрэгжүүлсэн. Гэхдээ тодорхой салбаруудыг хувьчлалд хамруулаагүй. Шатахуун худалдаалдаг хувийн компанийг зөвшөөрдөг ч ЗГ-аас тогтоосон үнээр шатахуунаа борлуулахыг шаарддаг.	– Шатахууны худалдаа, – Харилцаа холбоо, – Шуудан, – Усан боомт, – Нийтийн тээвэр, – Эрчим хүч, – Усны салбар  Гэхдээ эдгээрийг шууд хориглосон гэж тооцоход учир дутагдалтай. Учир нь эдгээр салбарт ГХО хийхийн тухайлан зааж хориглоогүй, бүтээгдэхүүний үнэ ханшийг нь төрөөс хатуу заасан. Энэ хэмжээ нь ГХО-чдад ашиг олох ямар ч боломжгүй байдаг.	ГХО-ыг маш их хэмжээгээр дэмждэг. Өмч хувьчлалын хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхэлсэн. Гэвч төрөөс тодорхой төрлийн бүтээгдэхүүний үнийг барьж байдаг нь ГХО-чдын сонирхлыг бууруулдаг.
<b>5.Катар</b>  • Нийтийн тээвэр • Гангийн үйлдвэрлэл • Цементийн үйлдвэрлэл • Шатахууны худалдаа • Харилцаа холбоо • Банкны салбарт 18 банкинд эрх олгосон	Ерөнхийдөө ГХО-г хязгаарлах салбартаа 49% байхаар хуулиар <sup>4</sup> тогтоосон. (Хамтарсан компанийн хэлбэрээр) Хөрөнгийн зах зээл дээр ГХО-чдыг тухайн компанийн 25%-г л эзэмшихийг зөвшөөрдөг. Тус улсын иргэд ямар нэг татвар төлдөггүй бол ГХО-чид 10-35%-ийн орлогын албан татвар төлдөг.	Хувьцаа гаргахыг зөвшөөрдөггүй.	ГХО-ыг дэмждэг.
<b>6.Вьетнам</b>  – Харилцаа холбоо – Шуудан – Усан боомт – Агаарын тээвэр	ГХО-ын тухай хуулиар <sup>5</sup> ГХО-чид нь хамтарсан компанийн 49 хүртэл %-ийг эзэмшиж болно. Хувь хүн байх тохиолдолд 15 хүртэл %-ийг зөвшөөрдөг.  Стратегийн ач холбогдол бүхий ГХО-д Үндэсний Ассамблейн зөвшөөрөл шаардагддаг бол дэд бүтцийн талаарх ГХО-ыг ЗГ-аас зөвшөөрч батладаг.	– Батлан хамгаалах – Нийтийн аюулгүй байдал – Эрүүл мэнд – Түүх болон соёлын салбар – Хэвлэл мэдээлэл – Боловсрол – Банк санхүү – Үл хөдлөх хөрөнгө – Ашигт малтмалын хайгуул, олборлолт	ГХО-ыг дэмжихийг хичээдэг. Гэвч социалист загварын төлөвлөгөөт зах зээлийн систем, татварын хангалтгүй орчин, эдийн засгийн хаалттай салбар олон байдаг зэрэг нь ГХО хийх сонирхлыг бууруулдаг.

<b>7.БНСУ</b> –Хэвлэл мэдээлэл (25-30%) –Цахилгаан болон дулааны эрчим хүч (30%) –Үүрэн болон сансрын харилцаа холбоо (49%) –Хиймэл дагуулын бродкастинг (33%) –Усан болон агаарын тээвэр (50%) –Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл (50%)	ГХО-ыг дэмжих тухай хуулиар <sup>6</sup> хориглосон болон хязгаарласан салбаруудаа тодорхойлсон. Хязгаарласан салбар тус бүрд ГХО-ын эзэмшлийн хувь хэмжээг тогтоож өгсөн.	– Цөмийн эрчим хүч – Радио болон телевизийн нэвтрүүлэг	ГХО-ыг дэмжих бодлого баримтладаг. Гэхдээ үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлнө гэж тооцсон салбарт ГХО-ыг хориглосон. Дотоодын эдийн засгаа дэмжих үүднээс тодорхой салбаруудад ГХО-ыг хязгаарласан.
<b>8.Япон</b> – Үүрэн болон сансрын харилцаа холбоо (33%) Nippon Telegraph and Telephone – Радио телевизийн нэвтрүүлэг (20-33%). Гэвч үүнд сансрын хиймэл дагуулаар дамжуулах бродкастинг хамаарахгүй. – Агаарын тээвэр (20%) Narita International Airport. Гэтэл энэ хязгаарлалтад Haneda Airport хамаардаггүй. – Үл хөдлөх эд хөрөнгийн салбар. Токио, Осака, Нагоя болон газар тариалангийн бүс нутгууд дахь газар	Эрх зүйн харилцааны онцлогоос шалтгаалж тус улсад ГХО-ыг нийтлэг байдлаар хязгаарладаггүй. ЗГ-аас тодорхой компаниуд дахь ГХО-ын хязгаарыг зааж өгдөг.	Байхгүй	ГХО-ыг дэмждэг. Гэвч зарим салбар дахь хөрөнгө оруулагчид хуулийн зохицуулалтыг төвөгтэй, ойлгомжгүй, ялгаварлан гадуурхсан хандлагатай гэж шүүмжилдэг.
<b>9.АНУ</b> – Агаарын тээвэр (25%) – Далайн тээвэр (25%) – Усан болон бусад Эрчим хүчний үйлдвэрлэл – Банк – Даатгал – Үл хөдлөх хөрөнгө – Газрын баялаг	ГХО-ын тухай хууль зүйн зарчмаар <sup>7</sup> Агаарын болон далайн хөлөг, бусад холбогдох бүх зүйл нь тус улсын иргэн дээр бүртгэгдэнэ. ГХО-ч нь зөвхөн хувь эзэмшинэ. Эзэмших хувь нь тухайн компанийг хянахааргүй хэмжээний байхыг шаарддаг.  Мөн тогтоосон журмын <sup>8</sup> дагуу тодорхой хугацаанд хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааныхаа талаарх нарийвчилсан тайланг гаргаж байх ёстой.	– Харилцаа холбоо. Үүнд цахилгаан мэдээ, радио болон телевизийн нэвтрүүлэг багтана. – Цөмийн эрчим хүч	ГХО-ыг тэр бүр дэмждэггүй. Дотоодын эдийн засгаа дэмжих үүднээс ГХО-чид аль болох хөрөнгө эзэмших боломжийг багасгасан эрх зүйн зохицуулалттай.

<b>10.Герман</b> – Нийтийн тээвэр (Deutsche Bahn 25%) – Харилцаа холбоо (Deutsche Telekom 48%) – Шуудан (Deutsche Post 30.5%)	Тус улсын эдийн засаг, улс төрийн онцлогоос шалтгаалж төрийн өмчийн монополь эрх бүхий тодорхой төрлийн компаниуд байдаг. Эдгээрийн ГХО-ын хувь эзэмшлийн хэмжээг тусгайлан хуульчилж зааж өгөөгүй ч хяналтын багцыг өгдөггүй.	Байхгүй	ГХО-ыг дэмждэг.
<b>11.Чили</b> – Зэсийн уурхай – Загасны аж ахуй – Банк – Даатгал – Хүрээлэн байгаа орчин – Харилцаа холбоо	ГХО нь 10,000 USD-с дээш хэмжээтэй байж Төв банкны зөвшөөрлийг авдаг. Тухайн хөрөнгө оруулах үйл ажиллагаанд нь хамаарах салбар бүрд холбогдох төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг авдаг. Хүнд суртлын аргаар шууд бус хэлбэрээр ГХО-тад хязгаарлалт тавьдаг.	– Цөмийн эрчим хүч – Далайн тээвэр – Уул уурхай – Батлан хамгаалах салбар – Үл хөдлөх хөрөнгө	ГХО-ыг дэмжих сонирхол бага. Үндэсний аюулгүй байдлын үүднээс тодорхой салбаруудыг ГХО-чидад хаалттай болгосон. Нээлттэй салбарууддаа ч хөрөнгө оруулж үйл ажиллагаа эрхлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлууд бий болгосон.
<b>12.Дани</b> Үл хөдлөх хөрөнгийн хувьд зөвхөн Европын холбооны улсын иргэдэд эзэмшүүлэхээр заасан ч тус улсад сүүлийн 5 жил байнга оршин суусан тохиолдолд аль улсын иргэнээс үл хамаараад Хууль зүйн яамнаас эзэмших эрх олгодог.	Тус улсын Худалдааны зөвлөл болон Гадаад хэргийн яам хамтран байгуулсан Өрсөлдөөний Агентлагаас (Competition Authorities) ГХО-чийн чадавхи болон хөрөнгө оруулалтын зорилго зэргийг харгалзан үзээд зөвшөөрөл олгох эсэхийг шийддэг. Үүнд үндсэндээ хөрөнгийн эх үүсвэр, хэмжээг нь авч үздэг. Хамтарсан компанийн хэлбэр бүхий ГХО нь 10 сая USD-оос дээш бол Өрсөлдөөний тухай <sup>9</sup> хуулийн дагуу тус Агентлагт хянуулах ёстой. Үүнээс их хэмжээтэй бол Евро Комиссийн зөвшөөрөл шаардагддаг. Гэвч бодит байдал дээр 2 сая USD-оос дээш хэмжээтэй ГХО-ыг Агентлаг заавал хянаж үздэг байна.	Байхгүй	ГХО-ыг маш их дэмждэг.

<p><b>13.Энэтхэг</b></p> <p>Агаарын тээвэр, телевиз, радио нэвтрүүлэг (20-49%), согтууруулах ундааны үйлдвэрлэл, барилгын үйлдвэрлэл (49%), автомашин үйлдвэрлэл зэрэг нийт 60 шахам салбарт хуваагдсан олон тооны үйл ажиллагаанд шууд болон шууд бус хэлбэрийн хязгаарлалтууд тавьсан. Эдгээрээс дурьдахад:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Банк (10-49%). Төрийн мэдлийн банкинд (20%)</li> <li>• Тамхины үйлдвэрлэлд хувь эзэмшлийн хэмжээ заагаагүй ч заавал эрх бүхий газраас зөвшөөрөл авахаар тусгасан.</li> <li>• Нүүрс (74%). Төрийн мэдлийн компанийн 49 хүртэл хувийг эзэмшиж болно.</li> <li>• Хөрөнгийн зах зээлд шууд хөрөнгө оруулалт, хувьцаа эзэмшил зэргийг нийтэд нь 49 хүртэл хувь байхаар заасан ч шууд хөрөнгө оруулалтыг 26% гэж хязгаарласан. Хөрөнгө оруулагч нь хувь хүн байх бол 5%-ыг зөвшөөрнө.</li> <li>• Зам гүүр, орон сууцны хороолол барих зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтад ГХО-ыг 100% байж болохыг зөвшөөрдөг ч бүтээн байгуулалтын ажлын цар хүрээний доод хязгаарыг зааж өгсөн.</li> </ul>	<p>Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиар<sup>10</sup> улсын эрх ашигт харшлах бол ГХО- тай компанийг дангаар байгуулах болон дотоодын компаниудтай нэгдэх хамтрах зэргийг шууд хориглосон. Төрийн эзэмшлийн компаниас гадна 100 % хувийн эзэмшлийн байсан ч хязгаарлах салбарын аливаа компаниудад ГХО-ын хувь эзэмшил 49% байхыг шаарддаг. Зарим нэг тодорхой нөхцөлүүдэд 5 хүртэл хувь болгон бууруулсан. Тус улсын эрх ашигт нийцэхээр бол хориглосон салбарын зарим нэг үйл ажиллагаанд шууд бус хязгаарлалтын хэлбэрээр ГХО-ыг зөвшөөрдөг.</p>	<p>– Газар тариалан – Үл хөдлөх хөрөнгө – Хууль зүйн үйлчилгээ – Харуул хамгаалалтын үйлчилгээ – Цөмийн эрчим хүч – Төмөр зам – Мөрийтэй болон бооцоот тоглоом – Сугалаа</p> <p>Үл хөдлөх хөрөнгийн салбарт шинээр бүтээн байгуулалт хийх бол зөвшөөрөл олгодог. Барилга орон сууц гэх мэт</p>	<p>ГХО-ыг дэмжих сонирхол бага. Дотоодын эдийн засгаа дэмжих үүднээс маш олон салбарт ГХО-ыг их хэмжээгээр хязгаарладаг.</p>
---	--	--	--

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

<b>14.Сингапур</b> – Хэвлэл мэдээлэл (25-30%) – Харилцаа холбоо (15-30%) – Банк, санхүүгийн үйлчилгээ (5-44%) – Хууль зүйн үйлчилгээ (49%) – Үл хөдлөх хөрөнгө – Телевиз, радио нэвтрүүлэг	Тусгай хязгаарлалтын журмаар <sup>11</sup> хязгаарлалт хийх салбаруудаа тодорхойлсон. ГХО-чийн эзэмшлийн хувь хэмжээг шууд тодорхой заагаагүй ч лиценз, зөвшөөрөл олгох байдлаар эзэмшлийн хэмжээг хязгаарладаг.	Байхгүй	ГХО-ыг дэмждэг. Гэхдээ дотоодын эдийн засгаа дэмжих зорилгоор тодорхой салбаруудад бага хэмжээний хязгаарлалт хэрэглэдэг.
<b>15.Канад</b> – Харилцаа холбоо (20-46%) – Түүх болон соёлын салбар – Хэвлэл мэдээлэл – Радио болон телевизийн нэвтрүүлэг – Банк – Даатгал – Агаарын тээвэр – Уул уурхай (уран) – Үл хөдлөх хөрөнгө – Цахилгаан эрчим хүч	ГХО-ыг үндсэндээ хөрөнгийн зах зээл дээрх мэдээллээр хянадаг. Зарим салбарууддаа ГХО хийх хувь хэмжээг эрх зүйн актад шууд заах замаар хязгаарлалт хийдэг бол зарим үйл ажиллагааг эрхлэхэд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл олгох замаар хязгаарлалт тавьдаг. Эдийн засгийн талаарх ОУ-ын гэрээний гишүүнчлэл <sup>12</sup> зэрэг шууд бус далд хэлбэрийн саад бий болгодог. Эрх зүйн харилцааны онцлогоос шалтгаалж зарим мужуудад тусгайлан эрх зүйн акт гаргаж болдог.	Байхгүй	ГХО-ыг дэмжих сонирхол бага.
<b>16.Австрали</b> – Хууль зүйн үйлчилгээ (49%) – Харилцаа холбоо. Үүнд цахилгаан мэдээ, радио болон телевизийн нэвтрүүлэг багтана. – Үл хөдлөх хөрөнгө – Агаарын тээвэр	ГХО-ыг хэн хөрөнгө оруулагч гэдгээс нь шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл, Хятадын хөрөнгө оруулагчдад таагүй хандаж ямар нэг байдлаар саад хийхийг оролддог бол Америкаас хийх ГХО-тыг ихээхэн дэмждэг.	Байхгүй	ГХО-тад хоёр талтай ханддаг. Дотоодын эдийн засагт сөргөөр нөлөөлөх боломжтой гэж тооцдог улс орнуудын хөрөнгө оруулалтад улс төрийн болон бусад арга замуудаар саад хийдэг.
<b>17.Чех</b> • Байхгүй	Байхгүй	– Банк – Даатгал – Үл хөдлөх хөрөнгө – Батлан хамгаалах	ГХО-ыг маш их дэмждэг. Зөвхөн үндсэний аюулгүй байдлаа хангах үүднээс тодорхой салбаруудад ГХО-ыг хориглосон.



<b>18.Украин</b>  <ul style="list-style-type: none"> <li>Стратегийн ач холбогдол бүхий салбаруудад ГХО-ыг 30% хүртэл зөвшөөрнө.</li> </ul>	ЗГ-ын санал болгосноор Парламентаас Стратегийн ач холбогдол бүхий салбаруудаа тодорхойлдог. ГХО-ч нь 50.000 USD-аас дээш хэмжээний мөнгөн хөрөнгийг гадагш нь гаргах тохиолдолд Төв банкнаас зөвшөөрөл авах шаардлагатай байдаг.	– Телевиз, радио нэвтрүүлэг	ГХО-ыг дэмждэг ч хөрөнгө оруулагчдыг үндэсний баялагаас хүлцэх хэмжээнээс илүүг авч магадгүй гэсэн хандлага байдаг. Тиймээс маш олон тооны хяналт шалгалт байнга хийдэг нь хөрөнгө оруулагчдад таатай санагддаггүй.
<b>19.Франц</b>  <ul style="list-style-type: none"> <li>Мөрийтэй, бооцоот тоглоом, харуул хамгаалалтын үйлчилгээ, хими биологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, батлан хамгаалах салбарт хамаарах үйлдвэрлэл үйлчилгээ зэрэг нийт 20 орчим үйл ажиллагаа.</li> </ul>	Тусгай журмаар <sup>13</sup> ГХО-ыг хязгаарлах үйл ажиллагаануудыг тодорхойлсон. Эдгээр үйл ажиллагааг эрхлэхэд заавал ЗГ-ын буюу тухайлбал, Батлан хамгаалах яамны зөвшөөрөл шаардагддаг. Мөн ажлын цаг, цалин хөлсний хэмжээ, татвар зэрэг албан бус далд хэлбэрийн хязгаарлалтууд байдаг.	Байхгүй	ГХО-ыг дэмждэг. Гэхдээ тус улсын нийгмийн харилцааны онцлогоос шалтгаалж хөрөнгө оруулагчдад нийгмийн хамгаалал, халамжийн шинжтэй дарамт учирдаг.
<b>20.Турк</b>  <ul style="list-style-type: none"> <li>– Үл хөдлөх хөрөнгө (2,5 га газар. Тодорхой хэмжээс заагдаагүй газар эзэмших эрх бүхий компанид ГХО-ч хувь эзэмших бол 10% байна.)</li> <li>– Далайн болон агаарын тээвэр (49%)</li> <li>– Бродкастинг (25%)</li> <li>– Банк, санхүү</li> <li>– Даатгал</li> <li>– Газрын тос</li> </ul>	ГХО-чид газрын эрх олгодог ч энэ нь хэмжээ болон хөрөнгө оруулалтаар хязгаарлагддаг. Мөн ГХО-тай компани байгуулахад бүртгэлийн үйл ажиллагааг хүндрүүлэх зэрэг далд хэлбэрийн хязгаарлалт байдаг.	Байхгүй	ГХО-ыг маш их дэмждэг.

\* \* \*

# 1. “ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖИД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

УИХ-д өргөн барьсан энэхүү хуулийн төслийн танилцуулгад дурьдсанаар хуулийн төсөл боловсруулах үндэслэл шаардлага нь:

- Өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоор гадаадын

хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хуулиар хориглоогүй үйлдвэрлэл үйлчилгээг хориглосноос бусад нутаг дэвсгэрт явуулж болохоор заасан. Хуулийн энэхүү хэт нээлттэй зохицуулалт нь ГХО-ын үр өгөөжийг бодитойгоор бий болгохгүй байгаагийн зэрэгцээ зарим тохиолдолд Монгол улсын Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хандлага ажиглагдаж байна. Иймд цаашид холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар ашигт малтмал, эрчим хүч, зам тээвэр, банк, санхүү, хөрөнгийн зах зээл зэрэг улс орны эдийн засагт стратегийн ач холбогдолтой салбаруудад гадаадын хөрөнгө оруулалт оруулах асуудлыг улс орны эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, үндэсний бизнесийн салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах;

- Үүний тулд Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбарыг тодорхой болгох, тэдгээр салбарт тавих хязгаарлалтыг хуульчлан тогтоох;
- Гадаадын хөрөнгө оруулалтад хяналт тавихын тулд саналын эрхтэй хувьцаа эзэмших эрхийг хязгаарлах арга замыг тодорхой болгох зэрэг үндсэн шаардлага тавигдсан байна.
- Гэвч хуулийн төслийг боловсруулахдаа ОХУ-ын “Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдолтой аж ахуйн нэгжүүдэд гадаадын хөрөнгө оруулах тухай” хуулийг орчуулсан байдлаар ашигласан нь хуулийн төслийн зохицуулалтууд үзэл баримтлал, үндсэн зорилготойгоо нийцээгүй зөрчилдөж байна.

Хуулийн төсөлд шинжилгээ хийж үзэхэд төслийн 6-р зүйлд Үндэсний Аюулгүй Байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг тодорхойлохдоо хуулийн төслийн үзэл баримтлалдаа дурьдсан эрчим хүч, зам тээвэр, банк, санхүү, хөрөнгийн зах зээл гэсэн гол салбаруудаа орхигдуулсан. Харин гидрометеорологи, геофизик, цахилгаан холбооны системийн мэдээлэл төрөлжүүлэхтэй холбогдуулан боловсруулалт хийх, техник хэрэгсэл, байр, хэсэгт алдаатай мэдээллийг хүлээн авахтай холбогдуулан цахилгаан төхөөрөмжийг гаргах үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх, дэлбэрэх материалын үйлдвэрлэл, тэдгээрийг түгээх үйл ажиллагаа, зэвсэг, техникийн үйлдвэрлэлд ашигладаг тусгай зориулалтын хайлш болон метал боловсруулах салбар гэх зэрэг батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлийн үйл ажиллагаануудыг түлхүү оруулсан байна.

Стратегийн ач холбогдол бүхий салбарууддаа ГХО-ыг хязгаарлах, хяналт тавьдаг талаархи бусад улс орнуудын жишгээс үзэхэд ГХО-ыг дараах салбарууддаа хориглодог байна.

Үүнд:

- Улсын аюулгүй байдлыг хангах
- Эрүүл мэнд
- Түүх болон соёлын салбар
- Цөмийн эрчим хүч
- Харилцаа холбоо
- Үл хөдлөх хөрөнгө
- Суурь боловсрол
- Хэвлэл мэдээлэл

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

#### **Хязгаарладаг салбаруудын хувьд:**

- Дулааны болон цахилгаан эрчим хүч
- Ашигт малтмалын салбар
- Банк санхүү
- Харилцаа холбоо
- Дэд бүтэц
- Даатгал

- Үл хөдлөх хөрөнгө
- Хүрээлэн байгаа орчин

Манай улсын хувьд хөгжингүй орнуудын жишгээр ГХО-ыг шууд хориглосон салбарыг тодорхойлох нь эдийн засгийн чадавхи харьцангуй муутай өнөөгийн нөхцөлд учир дутагдалтай юм. Учир нь одоогоор стратегийн ач холбогдол бүхий салбарууд нь эдийн засгийн өсөлтийг хангаж буй үндсэн суурь юм. Гэхдээ үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс зарим нэг салбаруудад тодорхой хэмжээний хяналт, хязгаарлалт байх нь зүйтэй.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлд хязгаарлалтын хэлбэрийг тодорхойлохдоо хувьцааны эзэмшлийн хэмжээг заах арга замыг сонгосон байна. Дийлэнхи улс орнуудын хувьд мөн энэ аргыг сонгодог байна. Харин манай улсын хувьд Стратегийн ач холбогдолтой салбарыг зөвхөн ашигт малтмал ба бусад гэж ангилсан нь хэт явцуу зохицуулалт болсон байна. Ашигт малтмалын салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг 10 хувь байхаар хязгаарласан нь хэтэрхий бага байна. Жишээ нь томоохон хөрөнгө оруулалт шаардсан төсөл дээр Монгол Улсын Засгийн Газар 90 хувийн хөрөнгө оруулалт хийх хүчин чадал байгаа эсэх нь эргэлзээтэй. Мөн энэ нь ашигт малтмалын салбарт хийгдэх гадаадын хөрөнгө оруулалтыг үргээж болох талтай.

Төслийн 6 дугаар зүйлд Үндэсний аюулгүй байдал стратегийн ач холбогдол бүхий үйл ажиллагааг тодорхойлохдоо үзэл баримтлалдаа дурьдсан дараахь үндсэн салбаруудыг орхигдуулсан байна. Үүнд:

- Эрчим хүч,
- Зам тээвэр,
- Банк
- Санхүү,
- Хөрөнгийн зах зээл
- Эрүүл мэнд,
- Үл хөдлөх эд хөрөнгө /Real Estate/

Жишээ нь: Арилжааны банкнуудын дийлэнхи нь 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай байгаа манай орны хувьд барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгө байна. Хэрэв зээлдэгчид нь зээлээ төлж чадахгүй нөхцөлд барьцааны зүйл болох газар өмчлөх эрх ГХО-д шилжинэ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, газрын тухай холбогдох хуулиудтай зөрчилдөж Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд нөлөөлөх боломжтой юм.

Хуулийн төсөлд дээрх байдлаар хязгаарлалт хийх салбарууд болон хязгаарлалтын арга замыг тодорхойлохыг оролдсон боловч энэ нь тун хангалтгүй байна. Стратегийн ач холбогдол бүхий салбаруудыг биш зөвхөн зарим нэг салбарт хамаарах үйл ажиллагаануудыг л тодорхойлсон.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах агуулга бүхий тодорхой нарийвчилсан зохицуулалт хийлгүйгээр, зөвхөн хувьцааны эзэмшлийн хувь хэмжээний тухай тайлбарласан ба төслийн бусад зүйл заалтуудад хөрөнгө оруулагчид тавих хяналтын талаарх процессын шинжтэй үйл ажиллагаануудыг тусгасан нь хуулийнхаа агуулгыг тодорхой гаргаж ирж чадахгүй байна. Энэ нь үзэл баримтлал болон уг хуулийг батлан гаргах болсон үндсэн шаардлагатай шууд зөрчилдөж байна. Иймээс энэхүү төслийг үзэл баримтлал, зорилгодоо нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар дахин нарийвчлан боловсруулах шаардлагатай юм.

- 1) Хуулийн төсөл нь “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” (2001.11.08) хуулийн 13 дугаар зүйлд заасан Хуулийн төсөлд тавих нэр томъёо, хэл зүйн шаардлагыг хангаагүй, зүйл заалтууд нь найруулгын болон утгын хувьд ойлгомжгүй, нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэх боломжтой, үг хэллэг нь хоёрдмол утга бүхий тодорхойгүй, ойлгоход хүндрэлтэй зүйл заалтууд нэлээдгүй байна,

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжид хэрхэн нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тусгаагүй, бусад салбарын хууль тогтоомжтой хэрхэн уялдаж байгаа талаар тодорхойгүй байна. Үүнд: Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль гэх мэт.

\* \* \*

Хавсралт – 1

**МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**  
(Салбараар, 1000 ам. долл.)

№	Салбарын нэр	%	Нийт	1990- 2004	2005	2006	2007	2008	2009	2010.12.23
1	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбар	65,4	3 156 666,56	493 972,74	183 961,91	195 390,34	336 985,65	485 189,08	643 454,56	817 712,29
2	Худалдаа, нийтийн хоол	18,7	901 691,95	162 764,31	53 376,62	103 388,43	111 528,37	187 447,85	132 636,45	150 549,91
3	Бусад	4,8	231 785,68	92 880,36	52 884,35	47 739,57	13 882,50	6 875,86	3 510,34	14 012,70
4	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	2,7	131 390,33	67 105,46	9 671,09	11 982,63	21 936,52	4 495,96	3 219,31	12 979,37
5	Хөнгөн үйлдвэр	2,2	107 908,16	85 001,91	1 792,13	1 454,22	1 205,34	18 208,00	92,82	153,75
6	Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	1,5	74 117,26	55 237,94	772,73	1 791,75	4 273,45	1 894,74	9 366,55	780,10
7	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	1,1	55 411,01	53 516,29	825,33	292,50	540,00			236,89
8	Мэдээлэл, холбооны технологи	0,7	36 108,56	19 623,03	6 267,60	480,86	6 916,70	1 442,57	1 252,80	125,00

9	Тээвэр	0,6	28 039,30	20 951,90	933,33	24,60	657,15	174,13	2 406,20	2 892,00
10	Аялал жуулчлал	0,4	18 770,70	13 028,04	1 490,23	1 637,36	486,70	1 365,63	491,34	271,40
11	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	0,5	21 984,49	15 297,57	303,96	1 424,37	710,00	100,50	298,08	3 850,00
12	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	0,3	14 683,80	10 656,24	12,99	391,47	67,00		3 495,61	60,48
13	ХАА, газар тариалан, МАА	0,3	14 813,78	9 305,76	2 787,10	362,60	208,43	1 242,38	504,15	403,36
14	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	0,3	12 491,40	4 011,72	56,30	5,25	395,00	101,00	430,12	7 492,00
15	Мебель, модон эдлэл	0,1	5 886,75	5 400,63	22,00	14,15	81,30	335,06		33,60
16	Эрчим хүч	0,1	5 515,80	5 415,32	100,48	-	-			
17	Нийтийн ахуйн үйлчилгээ	0,1	2 720,22	2 474,73	33,19	162,50	-	49,80		
18	Үнэт зүйлс, бэлэг дурсгал	0,1	2 648,18	1 224,43	1 353,75	-	70,00			
19	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	0,0	1 809,20	1 615,02	194,18	-	-			
20	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	0,0	1 432,50	1 411,50	-	3,00	18,00			
<b>НИЙТ ГШХО</b>		<b>100</b>	<b>4 825 875,62</b>	<b>1 120 894,91</b>	<b>316 839,28</b>	<b>366 545,59</b>	<b>499 962,11</b>	<b>708 922,55</b>	<b>801 158,33</b>	<b>1 011 552,85</b>

\*\*\*

## Хавсралт – 2

**МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ  
КОМПАНИЙН ТОО (Салбараар)**

№	Салбарын нэр	%	Нийт	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010.12.23
1	Худалдаа, нийтийн хоол	64,6	<b>6905</b>	969	522	1112	1505	1515	572	710
2	Бусад	13,8	<b>1472</b>	860	297	262	21	3	15	14
3	Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл	3,6	<b>386</b>	327	15	14	20	4	6	
4	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт	3,5	<b>373</b>	272	27	22	23	4	12	13
5	Аялал жуулчлал	2,9	<b>305</b>	176	57	35	23	12	1	1
6	Хөнгөн үйлдвэр	1,8	<b>190</b>	167	7	14	1	1		
7	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1,7	<b>179</b>	172	5	2				
8	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалт	1,5	<b>158</b>	149	4	4				1
9	Тээвэр	1,1	<b>118</b>	101	7	3	1	1	2	3
10	Мэдээлэл, холбооны технологи	1,0	<b>106</b>	72	7	11	7	6	2	1
11	ХАА, газар тариалан, МАА	1,0	<b>102</b>	86	8	5	1		1	1
12	Мебель, модон эдлэл	0,7	<b>77</b>	71	2	4				
13	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	0,6	<b>64</b>	60	1	3				
14	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	0,5	<b>57</b>	36	2	5	7	4	2	1
15	Эрүүл мэнд, гоо сайхны үйлчилгээ	0,5	<b>52</b>	47	1	2		1		1
16	Эрчим хүч	0,4	<b>44</b>	39	4	1				
17	Нийтийн ахуйн үйлчилгээ	0,4	<b>40</b>	36	2	2				
18	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	0,3	<b>29</b>	23	3	3				

19	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	0,2	21	21						
20	Үнэт зүйлс, бэлэг дурсгал	0,1	8	7		1				
	<b>Нийт ГХОКомпанийн тоо</b>	<b>100</b>	<b>10686</b>	<b>3691</b>	<b>971</b>	<b>1505</b>	<b>1609</b>	<b>1551</b>	<b>613</b>	<b>746</b>

\* \* \*

Хавсралт – 3

**МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**  
(Улсаар, 1000 ам. долл.)

№	Улсын нэр	%	Нийт	1990-2004	2005	2006	2007	2008	2009	2010.12.23
1	БНХАУ	51,09	2 465 491,57	441 786,38	227 922,28	172 014,03	339 614,67	497 800,88	613 058,80	173 294,53
2	Канад	8,29	400 005,03	174 206,58	1 542,25	72 180,37	497,15	2 739,57	1 028,00	147 811,12
3	Нидерланд	6,09	294 081,63	5 265,58	221,70	475,86	58,50	4 069,20	51 028,60	232 962,18
4	БНСУ	5,30	255 734,19	85 180,14	19 004,49	16 434,78	22 991,38	41 765,41	31 673,98	38 684,01
5	Виржини арлууд (УК)	4,60	222 113,15	48 394,23	5 033,92	6 111,67	35 449,00	6 157,89	19 305,18	101 661,27
6	Япон	2,87	138 370,37	66 208,26	5 840,80	4 727,59	2 450,10	46 623,46	5 594,78	6 925,37



7	БНХАУ / Гонконг/	2,63	126 813,01	25 033,35	773,02	350,50	8 255,51	1 757,81	11 032,44	79 610,37
8	Бермуда	2,51	121 059,66	1 604,48	4 962,86		30,30	6,46		114 455,56
9	ОХУ	2,24	108 081,51	37 163,16	7 450,14	11 654,52	39 774,38	3 795,42	6 139,20	2 104,68
10	АНУ	2,19	105 800,36	45 725,48	5 564,06	37 165,78	4 285,67	6 466,89	2 571,52	4 020,97
11	Сингапур	1,81	87 261,96	8 513,28	4 645,78	728,60	700,00	32 339,86	9 359,44	30 975,00
12	Их Британи	1,06	51 226,56	25 813,22	6 347,90	9 013,47	2 429,000	6 057,76	972,15	593,07
13	Кейман арал	1,00	48 417,86	264,02		2 400,00		35 069,33	321,45	10 363,06
14	Швейцарь	0,86	41 469,98	5 732,89	2 563,50	6 676,45	366,52	90,00	22 190,40	3 850,22
15	Болгар	0,64	30 867,98	30 778,48		17,00	15,00	7,50		50,00
16	Герман	0,57	27 737,41	10 369,80	370,20	1 386,27	817,49	580,01	13 281,00	932,64
17	Вьетнам	0,50	24 352,85	505,80	231,67	20 448,54	674,73	1 270,11	442,00	780,00

18	Австрали	0,47	22 522,74	3 730,19	12 066,75	384,40	289,20	3 361,90	516,50	2 173,80
19	Франц	0,41	20 024,49	326,99	35,00	66,30	12 550,00	170,08	2 376,34	4 499,79
20	БНХАУ/ Тайвань/	0,41	19 811,31	11 123,37	474,75	20,10	590,80	6 443,49	997,50	161,30
21	Сэйнт Киттс энд Невис	0,41	19 718,25	5,00			10,00		173,70	19 529,56
21	Багамын арлууд	0,37	17 627,79	17 435,79		102,00				90,00
22	Итали	0,32	15 212,65	8 265,85	5 219,43	44,90	37,50	856,97	340,00	448,00
23	Малайз	0,30	14 411,85	4 529,19	2 993,00	711,60	60,75	5 340,69	445,12	331,50
24	Казахстан	0,30	14 288,15	551,76	35,30	31,30	11 522,22	214,57	1 515,00	418,00
25	Португал	0,28	13 506,00	13 506,00						
26	Люксембург	0,72	34 647,84	2 911,70	1 809,30	10,00	3 118,917	195,80	1 012,65	25 589,47
27	Кипр	0,24	11 607,65	244,08		10,00	7 091,52	71,00	190,00	4 001,05
28	Израйль	0,17	8 273,61	8 094,91	10,00	20,00	23,70	15,00		110,00

29	Энэтхэг	0,16	7 527,69	334,00	10,00	128,00	4 925,00	690,00	1 155,00	285,69
30	Украин	0,15	7 290,54	6 148,12	24,95	89,90	66,90	45,00	725,63	190,04
31	Чех	0,14	6 833,74	4 145,87	24,00	52,22	80,61	2 015,04	80,00	436,00
33	Шинэ Зеланд	0,13	6 301,02	2 489,20	1 139,60	60,00	225,95	1 706,28	580,00	100,00
34	Бельги	0,11	5 272,71	2 744,72		2 190,90	134,46	75,00	27,62	100,00
35	БНХАУ / Макао/	0,09	4 461,00	4 461,00						
36	Турк	0,07	3 353,67	1 910,27	80,00	32,00	114,30	338,60	514,50	364,00
37	Лехтенштейн	0,07	3 336,45	3 336,45						
38	Австри	0,05	2 335,14	1 984,85	10,00	101,87	6,40	191,52		40,50
39	Польш	0,04	2 036,26	1 780,26	10,00	16,00	20,00	10,00	150,00	50,00
40	Унгар	0,04	1 895,68	1 162,48	12,71	54,20	18,00	240,00	408,29	
41	Узбекстан	0,04	1 704,30		3,20			100,00	756,10	845,00
42	БНАСАУ	0,03	1 401,86	1 162,61	66,50	22,75	50,00			100,00

43	Панам	0,03	1 293,65	1 055,45	7,70				100,00	130,50
44	Словак	0,02	<sup>1</sup> 192,06	869,06		273,00	50,00			
45	Пакистан	0,02	931,05	698,95	15,00	6,00	21,10	80,00		110,00
46	Антигуа ба Барбуда	0,02	729,86	729,86						
47	Кыргызстан	0,01	650,50	469,50	1,00				120,00	60,00
48	Щвед	0,01	660,10	13,10	10,90		466,00	30,00	40,10	100,00
49	Мауритан	0,01	510,00					30,00	480,00	
50	Сири	0,01	410,99	285,89	5,10	15,00		105,00		
51	Белиз	0,01	375,88		13,00	175,88			85,00	102,00
52	Ирланд	0,01	320,14	46,25	9,00		9,00		76,54	179,35
53	Гибралтар	0,01	291,00	176,00	15,00					100,00
54	Тайланд	0,01	287,10	76,00				3,00	108,10	100,00
55	Югослав	0,01	285,07	280,17	4,90					
56	Армен	0,01	270,05	239,60	15,30	6,60		8,55		
57	Беларус	0,01	269,06	27,00				56,00		186,06

58	Иран	0,01	253,00		18,00		2,00			233,00
59	Бангладеш	0,00	215,00				10,00		105,00	100,00
60	Азербайжан	0,00	210,00				20,00			190,00
61	Британийн Мэн арал	0,00	200,00							200,00
62	Саудын Араб	0,00	198,30	198,30						
63	Норвеги	0,00	193,15	67,15	10,00	5,00	6,00	90,00		15,00
64	Кампуж	0,00	168,30		153,30	15,00				
65	Хорват	0,00	146,00	146,00						
66	Ливан	0,00	142,86	134,94		7,92				
67	Ирак	0,00	115,00	15,00						100,00
68	Индонез	0,00	104,00			20,00			84,00	
69	Британийн Вест Индизс Ангуила	0,00	100,00							100,00
70	Румын	0,00	100,00							100,00
71	Дани	0,00	90,30	90,30						
72	Испани	0,00	89,60	59,60		20,00	10,00			

73	Гүрж	0,00	73,05	18,05			5,00		50,00	
74	Сейшалын арал	0,00	70,00				10,00	17,00		43,00
75	Аргентин	0,00	55,00						55,00	
76	Грек	0,00	49,00	49,00						
77	Финлянд	0,00	41,67	20,00	8,17	7,00		6,50		
78	Молдав	0,00	41,50	39,00			2,50			
79	Катар	0,00	40,00					10,00	30,00	
80	ХБНАБалба улс	0,00	35,00	5,00					30,00	
81	Туркс энд Кейкос арлууд	0,00	31,00		3,10					27,90
82	Туркменистан	0,00	30,00							30,00
83	Барбадос	0,00	30,00	20,00	10,00					
84	Тажикстан	0,00	30,00	10,00	10,00	10,00				
85	Шри Ланка	0,00	28,00					28,00		
86	Британийн энэтхэгийн далайн газар	0,00	25,00			25,00				
87	Йордан	0,00	24,93	21,60		3,33				
88	БНЛибер Улс	0,00	20,50	20,50						
89	Морокко	0,00	20,00					20,00		

90	Гондурас	0,00	19,50	13,50	6,00					
91	Эстони	0,00	17,00	17,00						
92	Серби Монтенегро	0,00	15,00	8,25	6,75					
93	Камерун	0,00	12,00	12,00						
94	Мауритус	0,00	12,00			12,00				
95	Латви	0,00	10,00	10,00						
96	Маршалын арал	0,00	10,00	10,00						
97	Мианмар	0,00	10,00		10,00					
98	Минор Оутлайн арлууд	0,00	10,00			10,00				
99	Сайнт Нелена	0,00	6,00		6,00					
100	Мелчизедекийн арлууд	0,00	5,61	5,61						
101	Нигер	0,00	5,00	5,00						
102	Филлипин	0,00	4,90				4,90			
103	Этопи	0,00	2,50	2,50						
104	Виржини арал /US/	0,00	2,00		2,00					
<b>НИЙТ ГШХО</b>		<b>100</b>	<b>4 825 875,62</b>	<b>1 120 894,91</b>	<b>316 839,28</b>	<b>366 545,59</b>	<b>499 962,11</b>	<b>708 922,55</b>	<b>801 158,33</b>	<b>1 011 552,85</b>

\* \* \*

## Хавсралт – 4.

## БНХАУ-ЫН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН КАТАЛОГ

	Салбар	Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарласан			Гадаадын хөрөнгө оруулалтыг хориглосон
		Хятадын тал хувьцааг эзэмшинэ. (51%-аас дээш)	Хамтран ажиллах, хамтран хөрөнгө оруулахаар хязгаарласан	Хязгаарласан	
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, мал аж ахуй, загас агнуур	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний шинэ сортыг үйлдвэрлэх	Ховор үнэт модны боловсруулалт	Хөвөн боловсруулалт	Улсын ховор сайн чанарын сорт (ургамал, амьтан, үсан үйлдвэрийн сайн чанарын бүтээгдэхүүн) Ургамлын үр болон үржүүлгийн үйлдвэрлэл болон хөгжүүлэх Улсын харьяат газар болон голд загас агнуур
2	Ашигт малтмалын олборлох	Ховор төрлийн нүүрсний төрөлд хайгуул болон олборлох Марганц олборлох	Хүнд жоншны хайгуул болон олборлох	Үнэт төмөрлөг (алт, мөнгө, цагаан алт) –ийн хайгуул, олборлох Алмаз зэрэг үнэт чулуунд хайгуул болон олборлох Фосфат олборлох Магни олборлох Celestine олборлох	Вольфрам молебдин, цагаан тугалга, хайлуур жоншид хайгуул хийх, олборлох Газрын ховор металд хайгуул хийх, олборлох Цацраг идэвхт ашигт малтмалд хайгуул хийх, олборлох
3	Үйлдвэрлэл	Хүнсний боловсруулалт		Эрдэнэ шишийн боловсруулалт	
		Шар буурцаг, ургамлын тос гаргаж авдаг үр зэрэгт боловсруулалт хийх Шингэн түлшийн үйлдвэрлэл			
	Архи ундааны үйлдвэрлэл	Шар айраг, алдартай цагаан архины үйлдвэрлэл		Нүүрс хүчлээр баяжуулсан ундаа үйлдвэрлэх	Улсын уламжлалт аргын ногоон болон онцгой төрлийн цайнд боловсруулалт хийх(алдартай цай зэрэг)
	Тамхи үйлдвэрлэл			Тамхи ба filter tips-д боловсруулалт ба үйлдвэрлэл	
	Хэвлэл нийтлэл	Хэвлэл			
	Газрын тосны боловсруулалт болон коксжуулах			Жилд 8000000 тонн болон доош боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж ба үйл ажиллагаа явуулах	



		Химийн түүхий эд ба химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл			Ионы салст эхүүн сод —ны бүтээгдэхүүн, Эмзэг мэдрэмтгий материал, Бензидрин бүтээгдэхүүн, Хүүхрийн хүчил энгийн титаны үйлдвэрлэл, Төмрийн хүдэр, Бари давсны үйлдвэрлэл	
		Эмийн үйлдвэрлэл	Мансууруулах үйлчилгээтэй буюу өвчин намдаах тайвшруулах үйлчилгээтэй эмийн үйлдвэрлэл		Хлорамин, пенициллин G, lincomycin, гентамицин, dihydrostreptomycin, oxytetracycline, hydrochloride amikacin, tetracycline, , medecamycin, kitasamycin, ciprofloxacin, norfloxacin, and ofloxacin зэрэг бүтээгдэхүүн 2. Парацетамол, Витамин В1, В2, С E, Analgin, гэх мэт	“Зэрлэг эмийн ургамлын нөөц баялагыг хамгаалах тогтоол”-д орсон болон “хятадын үнэт ховор, аюулд орсон ургамлыг хамгаалах жагсаалт”-д орсон хятад эмийн ургамалд боловсруулалт хийх
		Chemical fibre			Chemical fibre drawnwork of conventional chipper	
		Резин бүтээгдэхүүн үйлдвэрлэл			Дугуйн хаймарыг шинэчлэх	
		Өнгөт металын хайлуулалт болон боловсруулалт		Газрын ховор метал хайлуулалт	Вольфрам, молебдин, цагаан тугалга зэрэг газрын ховор металын хайлуулалт	Цацраг идэвхт ашигт малтмалын хайлуулах болох боловсруулалт хийх
		Төмөрлөгийн үйлдвэрлэл			Хөнгөн цагаан, зэс, хар тугалга, цинк зэргийн өнгөт металын хайлуулалт	
					Контейнер үйлдвэрлэл	
		Энгийн Тоног төхөөрөмж үйлдвэрлэл			Хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	
		Тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл			Дунд доод зэрэглэлийн В загварын хэт дуу авиа дүрслэлийн төхөөрөмж үйлдвэрлэх	Зэвсгийн дарь үйлдвэрлэх
		Тээврийн хэрэгсэл үйлдвэрлэл	Энгийн усан онгоц засварлах, дизайн хийх болон үйлдвэрлэх			

		Электрон болон алсын холбоо ба бусад электрон бүтээгдэхүүний үйлдвэрлэл			Телевизийн хиймэл дагуулын чухал сэлбэгийн үйлдвэрлэл	
					Санхүүгийн мөнгө тоологч хэрэгслийн үйлдвэрлэл	
		Аж үйлдвэр болон бусад үйлдвэрлэл				Зааны ясан сийлбэр
						Барын ясан боловсруулалт
						Лакадсан эдлэл үйлдвэрлэл
						Паалантай эдлэлийн үйлдвэрлэл
						Өмөн үүсгэх идэвх, төрөлхийн гажиг согог үүсгэдэг, мутацийн үүсэл болон байгаль орчин бохирдуулдаг тэсвэртэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл
4	Эрчим хүч, газ ба усны үйлдвэрлэл болон түгээх салбар	Цахилгаан сүлжээний барилга байгууламж, үйл ажиллагаа явуулах			Төвд, Уйгар, Хайнан-зэрэг газарт жижиг цахилгаан сүлжээний барилга угсралт ба үйл ажиллагаа явуулах	
5		Төмөр замаар зуучид тээвэрлэх компани			Төмөр замын бараа тээврийн компани	Агаарын тээврийг удирдах компани
	Зам тээвэр, агуулах, шуудангийн салбар	Усан тээврийн компани			Замаар зуучид тээвэрлэх компани	Шуудангийн компани
		Зураг авах, хайгуул хийх зэрэг агаарын тээврийн компани			Хил гардаг машины тээврийн компани	
					Телеком компани: гадаадын хөрөнгө оруулалт 50 хувиас хэтэрч болохгүй	
Гэтэл үүнд зарцуулагдах мөнгөн хөрөнгийг тооцохдоо (*жишээлбэл, 2006 оны хуулийн 39-р зүйлийн 1.9-д*) тусгай дансанд байгаль орчныг хамгаалахад шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэхээр заасан нь тун хангалтгүй юм. Нөгөө талаар, **уул уурхайн компаниуд байгаль орчны нөхөн сэргээлтийн зорилгоор байгуулагддаггүй учраас энэ чиглэлээр ажиллах чадвар дутдаг, сонирхол байдаггүй.** Тиймээс энэ тогтолцоог өөрчилж байгаль орчны нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг 100 хувь тухайн ордыг эзэмшигчээс гаргуулдаг тогтолцоог бий болгох ёстой. Ингэвэл байгаль орчныг хамгаалахад шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын хэмжээ үнэн зөв гарахын зэрэгцээ нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх бололцоотой болно. Нөгөө талаас компаниуд байгаль орчныг хамгаалах талаар одоо зарцуулж байгаагаасаа хамаагүй өндөр зардал гаргаж эхлэх учраас зардлаа багасгах үүднээс аль болох байгаль орчинд таатайгаар үйл ажиллагаагаа явуулах болно.

Үүнээс гадна бас нэг анхаарал татаж буй асуудал бол Монгол улсад байгаль орчны хохирлын хэмжээг тогтоох, экологи эдийн засгийн үнэлгээг гаргах аргачлал, стандарт өнөөг хүртэл байхгүй явж ирсэнээс хохирлын нөхөн төлбөр гаргуулах, гэм буруутай этгээдэд хариуцлага оногдуулахад ихээхэн хүндрэл учирч байна. Байгаль орчны экологи эдийн засгийн үнэлгээг хийх эрх бүхий субъектэд хандвал одоохондоо аргачлал байхгүй учраас тухайн компаний байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгийн хэмжээгээр л хохирлыг тогтоож өгье гэсэн бүрхэг хариулт өгдөг. Нэгэнт сүйтгэгдээд өнгөрсөн хойно нь экологийн эдийн засгийн үнэлгээг тогтоох гэж оролдох нь бодитой байж чадахгүй учраас ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааг эхлэхээс өмнө тухайн газар нутгийн экологи эдийн засгийн үнэлгээг гаргадаг байх, нөхөн сэргээлтийг тийм хэмжээнд хүртэл хийдэг байх зохицуулалтыг хуульд оруулж өгөх шаардлагатай байна.



## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ

*Р. Батсүх (Ph.D), Ө. Мөнхтунгалаг, Д. Жигваагүнсэл,  
О. Нарантуяа*

### 1. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн төлөв байдал, Монгол улсын эдийн засагт гүйцэтгэсэн үүрэг

#### 1.1. Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

1970 онд Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 217279,7 сая.төг, үүнээс мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 188367,0 сая төгрөг буюу нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 86,9 хувийг, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 28416,8 сая.төг буюу нийт бүтээгдэхүүний 13,1 хувийг эзлэж байсан байна. 1980 онд нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 233817,3 сая төг, үүнээс мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 196919,4 сая.төг буюу нийт бүтээгдэхүүний 84,2 хувийг, газар тариалангийн үйлдвэрлэл нь 35195,3 сая.төг буюу 15,8 хувийг эзлэж байсан бол 1990 онд нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт нь 350228,7 сая.төг, үүнээс мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 262105,2 сая.төг буюу нийт бүтээгдэхүүний 74,9 хувийг, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь 78934,4 сая.төг буюу нийт бүтээгдэхүүний 23,1 хувийг тус тус эзэлж байв.

Харин 2000 онд нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 852823,5 сая төг, үүнээс мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 755085,7 сая.төг буюу нийт бүтээгдэхүүний 88,6 хувийг, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт 12,4 хувийг эзлэж байсан бол, 2008 оны байдлаар хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 1167711,7 сая.төг, үүнээс мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 965551,9 сая.төг буюу нийт бүтээгдэхүүний 82,7 хувийг, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 202159,9 сая.төг буюу нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 17,3 хувийг тус тус эзлэж байгаа нь нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт жил ирэх тутам нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүнд мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дийлэнх буюу 80 гаруй хувийг эзлэдэг бол газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 20 орчим хувийг эзлэсээр иржээ.

Хүснэгт 1

Он	Нийт бүтээгдэхүүн	Мал аж ахуйн бүтээгдэхүүн	Газар тариалангийн бүтээгдэхүүн
1970	217279,7	188367,0	28416,8
1975	267147,2	212046,7	50540,0
1980	233817,3	196919,4	35195,3
1985	330017,2	215342,7	99623,1
1990	350228,7	262105,2	78934,4
1995	341523,6	299940,5	41583,1
2000	852823,5	755085,7	97737,8
2005	851704,1	738477,4	113226,7
2008	1167711,7	965551,9	202159,9

## 1.2. Нэг хүнд ногдох хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

Нэг хүнд ногдох хөдөө аж ахуйн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг төрөл тус бүрээр 5 жилийн дунджаар авч үзвэл 1970 оны байдлаар мах 144,1 кг, сүү 176,9 кг, цөцгийн тос 2,4 кг, өндөг 4,6 ш, үр тариа 261,6 кг, төмс 16,7 кг, хүнсний ногоо 10,6 кг байсан бол, 1990 онд мах 119,9 кг, сүү 152,1 кг, цөцгийн тос 2,1 кг, өндөг 17,9 ш, үр тариа 346,1 кг, төмс 63,2 кг, хүнсний ногоо 20,1 кг болсон байна. Харин 2008 оны байдлаар авч үзвэл нэг хүнд ногдох мах 74,4 кг, сүү 178,6 кг, өндөг 14,3 ширхэг, үр тариа 59,2 кг, төмс 45,6 кг, хүнсний ногоо 28,7 кг байгаа нь өмнөх 1990 онтой харьцуулахад мах 1,6 хувиар, өндөг 1,2 хувиар, үр тариа 5,8 хувиар, төмс 1,4 хувиар буурсан бол сүү 1,1 хувиар, хүнсний ногоо 1,3 хувиар өссөн байна. Цөцгийн тосны үйлдвэрлэлийг 1995 оноос хойш статистикийн үзүүлэлтээр гаргаагүй байна.

Хүснэгт 2


Үзүүлэлт	1970	1975	1980	1985	1990	1995	2000	2005	2008
<b>Маж</b> /няд. жин/	144,1	162,3	140,9	123,9	119,9	105,5	115,5	77,1	74,4
<b>Сүү</b> /кг/	176,9	159,2	140,2	147,8	152,1	143,8	174,1	120,1	178,6
<b>Цөцгийн тос</b> /кг/	2,4	2,2	2,4	2,4	2,1	0,5	-	-	-
<b>Өндөг</b> / ширхэг/	4,6	5,8	13,1	14,2	17,9	5,6	3,1	4,5	14,3
<b>Үр тариа</b>	261,6	371,7	178,2	486,1	346,1	196,5	81,7	49,1	59,2
<b>Төмс</b>	16,7	26,0	23,5	62,5	63,2	31,0	24,3	28,1	45,6
<b>Хүнсний ногоо</b>	10,2	16,5	16,3	22,6	20,1	10,1	15,7	20,6	28,7

График 2





График 3



### 1.3. Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувь


Хөдөө аж ахуйн салбар нь 1999 он хүртэл ДНБ-ний 30-40 орчим хувийг үйлдвэрлэж байсан бол 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурчээ. /Хүснэгт 3, график 4/

Дотоодын нийт бүтээгдэхүүн /оны үнээр/

Хүснэгт 3

Онууд	Нийт бүтээгдэхүүн сая,төг	Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн	
		Нэмэгдэл өртөг /сая.төг/	Дүнд эзлэх хувь
1970	608604,3		35,7
1975	842571,3		32,0
1980	1102814,8		22,0
1985	1533152,4		22,0
1990	1855585,0		19,0
1995	1699160,6		20,0
2000	2004471,4		42,0
2005	2779578,3		31,0
2009	3564278,1		33,0

График 4



**Хоёр. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн судалгаа****2.1. Мал аж ахуй хөдөө аж ахуйн гол салбар болох нь****2.1.1 Малын тоо толгой, сүргийн бүтэц**

Малын тоо толгойн өсөлтийг 1970-2009 оны байдлаар 5 жилийн дунджаар нь авч үзлээ. / Хүснэгт 3, График 5,6/ Нийт малын тоо нь 1970-1990 он хүртэл харьцангуй тогтвортой 200-300 мянган толгойгоор өсөж байсан бол 1995 оноос 2 сая гаруй толгойгоор нэмэгдэж, 1970 оны дундажтай харьцуулахад 2000 онд 31457,3 мянга буюу 0,3 хувиар өссөн бол 2005 онд 26765,4 мянга буюу 0,1 хувиар, 2009 онд 40594,7 мянга буюу 1 дахин өссөн байна. 1990 оноос хойш нийт мал сүргийн тоо ихээхэн эрчимтэй өсөх болсон нь малыг хувьд шилжүүлэн хувьчилсантай ихээхэн холбоотой.

Энэ үеэс хувийн малын тоо ихээхэн нэмэгдэж 6361,7 мянга болсон нь нийт мал сүргийн 26,7 хувийг эзэлж байв. 2009 он гэхэд хувийн малын тоо 40083,8 мянга болж нийт мал сүргийн 98,7 хувийг эзлэх болжээ. Нийт мал сүргийн дотор тэмээн сүргийн тоо жил ирэх тусам буурсан байхад ямаан сүргийн тоо ихээхэн өсөн нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад үхэр, хонь, адуун сүргийн тоо харьцангуй тогтвортойгоор өсөн нэмэгдсээр иржээ.

Сүргийн бүтцийн хувьд 1970-1990 онд нийт сүргийн 21,6 хувийг бод мал, 78,3 хувийг бог мал эзэлж байсан бол, 1990-2009 онд нийт сүргийн 17,6 хувийг бод мал, 82,4 хувийг бог мал эзлэх болсон нь сүргийн бүтэц алдагдсаныг харуулж байна. 1990 оноос өмнө бог малын тоог нийт сүргийн 75 хувиас хэтрүүлэхгүй байх бодлого баримталж байсан нь сүргийн бүтцийг хадгалах зохистой арга хэлбэр байжээ. Сүүлийн жилүүдэд малын тоо толгойг олшруулах бодлого хэрэгжиж “Мянгат малчин” тодруулж эхэлсэн, ноолуурын үнэ буурснаас экспортын гаалийн татварыг тэглэсэн, ямаа бүрт 5000 төгрөгийн тусламж олгох болсон зэрэг хөнгөлөлт үйлчилгээг төрөөс үзүүлэх болсон нь ямааны тоо толгой өсөхөд ихээхэн нөлөөлсөн байна.

**Малын тоо, толгойн өсөлт /мян.тол/**

Хүснэгт 4


Он	Нийт малын тоо	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Хувийн малын тоо
1970	23430,4	633,5	2317,9	2107,8	13311,7	4204,0	5005,6
1975	23430,4	619,7	2255,1	2249,9	13914,5	4391,4	5002,8
1980	23741,6	606,1	2090,1	2432,2	14024,1	4589,1	4606,3
1985	23535,1	575,2	1928,1	23855,4	1408,3	4508,4	4644,8
1990	23807,8	549,2	2126,0	2617,6	13845,3	4669,6	6361,7
1995	26355,4	398,4	2341,4	2938,8	14131,2	6544,2	21124,6
2000	31457,3	349,6	2909,4	3547,4	14297,6	10353,1	29953,1
2005	26765,4	261,1	2036,8	1910,3	11580,2	10976,8	26184,7
2009	40594,7	264,4	2190,6	2424,1	17360,5	18355,1	40083,8



График 5



График 6



## 2.1.2. Малчдын тоо

1970-1990 оны дунджаар малтай өрхийн тоо мянга, 339,4 мянга, малчдын тоо 2980,2 мянга байсан бол 1990-2009 оны дунджаар малтай өрхийн тоо 4921,2 мянга, малчин өрх 3224,6 мянга, малчдын тоо 7098,5 мянга болж өссөн байна. Үүнийг 1970-1990 оны дундажтай харьцуулбал малтай өрхийн тоо 1,1 хувиар, малчин өрх 9,5 хувиар, малчин өрхийн тоо 2,3 хувиар тус тус өсчээ. /хүснэгт 4, график 6 / Малчдын тоог насны бүлгээр нь ангилан авч үзвэл 1970-1990 онд 16-35 хүртэл насны малчид 831,6 буюу нийт малчдын 27,9 хувийг, 36-55/60 хүртэл насны малчид 841,7 буюу 28,2 хувийг, тэтгэврийн насны малчид 132,4 мянга буюу 4,4 хувийг эзэлж байсан бол 1990-2009 оны дунджаар 16-35 хүртэл насны малчид 2758,7 буюу нийт малчдын 38,9 хувийг, 36-55/60 хүртэл насны малчид 1307,1 буюу 9,3 хувийг, тэтгэврийн насны малчид 843,7 мянга буюу 11,8 хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд сүүлийн 20 жилд малтай өрхийн тоо 16-35 хүртэл насны малчид 3,3 хувиар, 35-55/60 хүртэл насны малчид 1,5 хувиар, тэтгэврийн насны малчид 6,3 хувиар тус тус өсчээ.

### Малчдын тоо, насны бүрэлдэхүүн

Хүснэгт 5

Он	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Малчдын тоо	Үүнээс		
				16-35 хүртэл насны	36-55/60 насны	Тэтгэврийн насны
1975	203,2	-	170,8	-	-	-

1980	206,8	-	154,8	61,1	71,2	18,7
1985	210,1	-	138,4	62,5	66,2	9,7
1990	242,6	67,9	132,1	67,1	59,4	5,6
1995	290,6	149,7	338,1	186,1	94,3	57,9
2000	274,3	184,4	411,8	230,4	126,4	58,6
2005	238,2	174,2	381,7	202,9	129,1	49,1
2009	226,4	170,7	360,1	171,2	141,8	47,1

График 7





График 8



### 2.1.3 Мах, сүү, ноос, ноолуурын үйлдвэрлэл

- **Махны үйлдвэрлэл** /нядалгааны жингээр/ мян.тонн

Махны үйлдвэрлэл 1970-1990 онд нядалгааны жингээр 4680,1 мянган тонн мах үйлдвэрлэснээс тэмээний мах 188, адууны мах 619,8, үхрийн мах 1391, хонины мах 2017,5, ямааны мах 422,8, гахайн мах 37,3, шувууны мах 3,8 мянган тонн тус тус үйлдвэрлэсэн байна. 1990-2008 онд нядалгааны жингээр 4089,6 мянган тонн мах үйлдвэрлэснээс үхрийн мах 1270,7, хонь, ямааны мах 1967,3, гахайн мах 11,5, шувууны мах 0,5 мянган тонн үйлдвэрлэсэн байна. 1991-1994 онд адууны мах 68,7, тэмээний мах 140,9 мянган тонн үйлдвэрлэсэн бөгөөд 1995 оноос хойш адуу, тэмээний махны үйлдвэрлэлийг статистик үзүүлэлт гаргаагүй байна. 1970-1990 оны махны үйлдвэрлэлийг 1990-2008 оныхтой


харьцуулахад нийт махны үйлдвэрлэл 590,5 мянган тонн, бодын мах 718,5, богийн мах 473, гахай, шувууны мах 29,1 мянган тонноор өссөн байна.

### Махны үйлдвэрлэл /мян.тонн/

Хүснэгт 5

Он	1970	1975	1980	1985	1990	1995	2000	2005	2008
Махны үйлдвэрлэл	179,8	202,6	227,7	231,9	237,9	232,8	273,6	194,4	117

График 7




### • Сүүний үйлдвэрлэл /мян.тонн/

Сүүний үйлдвэрлэл 1970-1990 онд 7936,1 мянган тонн үйлдвэрлэснээс ингэний сүү 47,9, гүүний сүү 416,6, үнээний сүү 6552,5, хонины сүү 712,4, ямааны сүү 207 мянган тонныг тус тус үйлдвэрлэсэн байна. 1990-2008 онд нийт 6642,2 мянган тонн сүү үйлдвэрлэсэн бөгөөд 1995 оноос хойш төрөл тус бүрээр статистикийн үзүүлэлт гаргаагүй байна.

Хүснэгт 6

Он	Сүү үйлдвэрлэлийн дүн /мян.тн/	Үүнээс				
		Ингэний сүү	Гүүний сүү	Үнээний сүү	Хонины сүү	Ямааны сүү
1975	224,3	1,5	9,3	195,1	12,8	1,4
1980	236,3	1,1	7,3	194,9	11,7	10,7
1985	247,7	1,0	11,4	231,9	13,2	11,9
1990	306,1	1,0	26,1	260,2	15,3	13,1
1995	318,9	0,8	32,	295,5	17,1	23,9
2000	418,2	-	-	-	-	-
2005	322,8	-	-	-	-	-
2008	457,7	-	-	-	-	-

График 8



- Ноосны үйлдвэрлэл /тонн/

Ноосны үйлдвэрлэл 1970-1990 онд тэмээний ноос 103936, бодын хөөвөр 44300,8, бодын хялгас 41663,6, ямааны ноолуур 39748,4, ямааны ноос 39748,4, хонины ноос 618,9 тонныг үйлдвэрлэсэн байна. 1990-2008 онд ямааны ноолуур 88849 тонн, хонины ноос 528,3 тонныг үйлдвэрлэсэн бөгөөд ямааны ноос, бодын хялгас, бодын хөөвөр, тэмээний ноосны статистик үзүүлэлтийг тооцож гаргаагүй учир 1970-1990 оны ноосны үйлдвэрлэлтэй жиших бололцоогүй байна. 1990-2008 онд ямааны ноолуурын үйлдвэрлэл огцом өссөн нь ноолуурын үнэ өссөн, малчид ноолуурын үнэ өссөнөөс ямааг голлон өсгөх болсон нь нөлөөлжээ.

#### Ноосны үйлдвэрлэл /тонн/

Хүснэгт 7

Үзүүлэлт	1970	1975	1980	1985	1990	1995	2000	2005	2008
Хонины ноос	19000	20180	19700	20180	19220	20500	20100	13240	18266,6
Тэмээний ноос	3313,9	3120,1	3062,9	3003,4	2737,4	2078,1	-	-	-
Ямааны ноос	902,7	990,1	979,7	836,9	808,5	1001,9	-	-	-
Ямааны ноолуур	1027,9	1154,2	1237,8	1331,1	1326,6	1768	2920	3160	4900
Бодын хөөвөр	1447,3	1445,6	1296,2	1294,9	1327,9	1199,9	-	-	-
Бодын хялгас	1563,3	1387,9	1134,9	1091,5	969,7	903,1	-	-	-

#### 2.1.4. Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1970-1990 онд цэцгийн тос 80510 тонн, өндөг 384,7 сая ширхэг, зөгийн бал 302,6 тонн, каракуль арьс 690.1 тонн, булганы арьс 510,6 тонн, хар үнэгний арьс 37,7 тонныг үйлдвэрлэсэн байна. Харин 1990-2008 онд өндөг 266,4 сая ширхэг, 1999-2008 онд адууны шир 39605,20, үхрийн шир 6479,7, хонины арьс 39865,9, ямааны арьс 27175,6 мянган тонныг тус тус үйлдвэрлэсэн байна.

**Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл /тонн/**

Хүснэгт8

Он	Цэцгийн тос /тонн/	Өндөг / сая, ширхэг/	Зөгийн бал	Каракуль арьс	Булганы арьс	Хар үнэгний арьс	Арьс шир			
							Адууны	Үхрийн	Хонины	Ямааны
1970-1990	80510	384,7	302,6	690,1	510,6	37,7	-	-	-	-
1990-2008	-	266,4	-	-	-	-	39605,20	6479,7	39865,9	27175,6

**2.1.5. Хөдөө аж ахуйн материал техникийн бааз хөгжсөн нь**


- Байгалийн хадлан, тэжээл бэлтгэл /төрөл, мян.тн/

Байгалийн хадлан, тэжээл бэлтгэлийн байдлыг 1970-2009 оны хооронд тав, таван жилээр нь дунджлан хүснэгтээр харууллаа. /Хүснэгт 9, График 10/ Хадлан, тэжээл бэлтгэлийн хувьд 1980-аад онд хамгийн их хадлан, тэжээл бэлтгэсэн байна. 2009 онд хадлан 964,9 мян.тонн, тэжээл 527,2 мян.тонныг бэлтгэсэн нь 1970 оны дундажтай харьцуулахад хадлан 1,7 хувиар, тэжээл 11,1 хувиар өссөн ч, хамгийн их хадлан тэжээл бэлтгэсэн 1985 оны дундажтай харьцуулахад хадлан 1,2 хувиар, тэжээл 1,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9

Он	Хадлан	Нийт тэжээл
1970	576,6	47,5
1975	811,0	110,8
1980	1062,4	152,1
1985	1203,1	395,5
1990	1154,3	689,5
1995	733,8	437,5
2000	678,9	349,1
2005	827,1	449,5
2009	964,9	527,2

График 10



- Уст цэгийн тоо

Бэлчээрийг усжуулах зорилгоор 1990-ээд оныг хүртэл олон мянган инженерийн хийцтэй худаг барьж байгуулсан байна. 1989 оны эцэст 42925 худаг байсны 25740 нь инженерийн хийцтэй худаг байжээ. /Инженерийн хийцтэй худаг нь өрөмдмөл, уурхайн худгийг хэлж байна./ Нийгэм эдийн засгийн шилжилтийн жилүүдэд худаг, уст цэгт тавих анхаарал суларч, эзэнгүйдснээс дээрх инженерийн хийцтэй худгийн гуравны хоёр нь эвдэрч, тоногдож, ашиглалтгүй болсон байна. 2000 он гэхэд инженерийн хийцтэй худаг 8,2 мянга үлджээ.

Ашиглалтгүй болсон худгийн 70 гаруй хувь нь бэлчээрт байршиж байснаас бэлчээрийн усан хангамжийн түвшин бараг 2 дахин багасчээ. Иймд сүүлийн 10 гаруй жилд бэлчээрийн худгийг сэргээн засварлах, шинээр худаг гаргахад улсаас ихээхэн хэмжээний хөрөнгө нэмж гаргах шаардлагатай болсон тул “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд инженерийн хийцтэй худгийг сэргээн засварлах, шинээр гаргах ажлыг ихээхэн анхаарч улсын төсвөөс 0,7-3,2 тэрбум төгрөг зарцуулсан ч төдийлөн үр дүнтэй бус байна. Хүснэгтээс харахад нийт худгийн тоо 1990 оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Уст цэгийн тоо /мян,ширхэг/

Хүснэгт 10

Онууд	Худгийн тоо				Усан сангийн тоо
	Бүгд	өрөмдмөл	уурхайн	энгийн	
1970	21,4	1,4	6	14	-
1975	25,5	2,2	8,7	14,6	0,6
1980	32,6	4,1	13,3	15,4	2,1
1985	38,6	5,9	16,3	16,5	3,5
1990	42,9	7,4	17,6	16,9	4,2
1995	36,1	5,4	13,4	17,2	2,6
2000	30,9	-	8,2	22,7	1,0
2006	38,7	-	10,0	28,6	0,8

2009	42,3	-	10,2	32,1	0,5
------	------	---	------	------	-----

Хүснэгт




- **Нийт хашааны тоо**

Улсын хэмжээнд малын хашаа, байрны тоо сүүлийн жилүүдэд өсч байгаа ч чанарын хувьд төдийлөн сайн биш байгаа нь статистикийн мэдээллээс харагдаж байна. Нийт хашааны тоо 1970, 1975 оны үед багтаамж ихтэй, чанар сайтай, тооны хувьд 47,1-52,5 мянган ширхэг байсан бол 1980 оноос малын хашааны тоо 25,3-29,5 хүртлээ буурчээ.

Нийт хашааны тоо 1990 оноос 1,7 дахин өссөн боловч хашааны багтаамж, хашаажилтын түвшин үндсэндээ нэг хэмжээнд байгаа бөгөөд энэ хугацаанд дулаан байрны багтаамж 3,6 дахин, саравчтай хашааных 17,4 хувиар буурч, харин саравчгүй хашаа буюу хорооны тоо 8,0 дахин, тэдгээрийн багтаамж 7,7 дахин өсчээ. Үүнээс үзэхэд мал сүргийг цас, зуд, хүйтнээс хамгаалах дулаан байр, саравчтай хашаа цөөрч, саравчгүй хашаа, хорооны тоо нэмэгдсэн байна. Энэ нь 1970-1975 оны үед байсан дулаан байр, саравчтай байрыг буулган тарааж, дахин барихдаа зөвхөн саравчгүй хашаа болгон барьсантай холбоотой юм.

График 12



- **ХАА-н мэргэжилтэн, техникийн тоо**

Энд хөдөө аж ахуйн мэргэжилтэн, техникийн тоон үзүүлэлтийг 1989-2006 оны байдлаар авлаа. Учир нь статистикийн хорооноос өмнөх онуудад дээрх үзүүлэлтээр мэдээлэл гаргаагүй байна. Доорх хүснэгтээс харахад 1989 онд мал зүйч 1,2 мянга, малын эмч 1,8 мянга, байсан бол 2006 онд малын зүйч 0,8 мянга, малын эмч 1,8 байна. Техникийн тоон



үзүүлэлт ч мөн буурсан дүнтэй байна.

Хүснэгт 11

Онууд	Мэргэжилтэн /мян.хүн/				Техникийн тоо /мян.ш/			
	Мал зүйч	Малын эмч	Агрономич	Механик-жуулагч	Трактор	Үр тарианы комбайн	Тариа үрлэгч	анжис
1989	1,2	1,8	-	-	11,5	2,5	6,2	2,2
1990	-	-	-	-	-	-	-	-
1991	0,8	1,6	-	-	9,0	-	-	-
1992	0,5	1,7	-	-	-	9,0	5,3	1,6
1993	0,5	1,7	-	-	-	-	-	-
1994	0,3	1,7	-	-	-	-	-	-
1995	0,3	1,6	-	-	-	-	-	-
1996	0,4	1,5	-	-	7,0	7,0	2,9	1,4
2000	1,1	2,0	-	-	4,7	4,7	2,0	1,1
2003	0,9	2,0	-	-	-	-	-	-
2006	0,8	1,8	-	-	-	-	-	-

### 2.1.6 Мал аж ахуйн талаар төрөөс авсан арга хэмжээ, түүний үр дүн

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг. Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм. Монгол улсын эдийн засгийн гол үндэс болсон хөдөө аж ахуйн салбар нь 2008 оны байдлаар улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 18,8 орчим, экспортын орлогын 10,0 гаруй хувийг бүрдүүлж нийт ажиллах хүчний 36,0 гаруй хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний 89.3 хувийг мал аж ахуйн салбар дангаараа үйлдвэрлэж байна. Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

- Төрөөс мал аж ахуйн салбарт үзүүлж буй дэмжлэг тусалцаа

#### 1. Хууль эрх зүй хувьд:

1992 оны Монгол улсын Үндсэн хуульд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” хэмээн зааж өгсөнөөр мал аж ахуйн салбарын эрх зүйн зохицуулалтын үндэс суурийг тавьж өгсөн. Энэхүү хуультай уялдуулан “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-ийг 2001 онд, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль”-ийг 2004 онд бусад холбогдох хууль тогтоомжуудын батлан гаргаж мөрдөж байна.

Мөн түүнчлэн сүүлийн жилүүдэд төр засгаас мал аж ахуйн салбарт төрөөс анхаарал нилээд хандуулах болсон ба үүний үр дүнд УИХ -аас “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого /2003/, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” /2009/, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг төрийн бодлогын баримт бичгүүдийг батлан гаргаж мал аж ахуйн салбарт төрөөс баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлсон. Эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлсон зорилт, үзэл баримтлал, үе шатыг харгалзан тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан МУ-ын Засгийн газраас тодорхой бүс нутагт газар тариалантай хосолсон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж, импортыг бууруулах, хүн амыг хүрэлцэхүйц, чанартай хүнсээр хангах томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

- **Мал аж ахуйн салбарт мөрдөгдөж буй голлох хуулиуд:**
  - Монгол Улсын Үндсэн хууль
  - Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль
  - Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль
  - Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
  - Иргэний эрүүл мэндийн тухай хууль
  - Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
  - Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай
  - Газрын тухай хууль
  - Усны тухай хууль
  - Хүнсний тухай хууль
  - Хоршооны тухай хууль
  - Газрын төлбөрийн тухай хууль
- **УИХ-ын тогтоолоор батлагдсан бодлогын болон бусад эрх зүйн актууд**
  - Төрөөс малчдын талаар баримтлах бодлого
  - Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
  - Зөвшөөрөл олгох тухай
  - МУ-ын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
  - МУ-ын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндсэний хөгжлийн цогц бодлого
  - МУ-ын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай
  - МУ-ын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого
  - МУ-ыг бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги
  - МУ-ын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- **Монгол улсын Засгийн газраас гаргасан эрх зүйн баримт бичгүүд:**
  - МУ-ын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам
  - МУ-ын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам
  - Журам батлах тухай /Мал хамгаалах сан бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах журам
  - эрхлэх талаар авах зарим арга хэмжээний тухай
  - Журам батлах тухай /Малчдаас монгол ямааны ноолуур худалдан авсан

- үндэсний үйлдвэрлэгчдэд эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн татаас олгох
- Ноолуурын салбарт 2012 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай
  - Журам батлах тухай /Улсын сайн малчин, Улсын тэргүүний тариаланч хамт олон, тариаланч шалгаруулах журам/
  - Малын удмын сангийн үндэсний төв, цөм сүргийн үндэсний төв байгуулах тухай
  - Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээнд хяналт тавих журам
  - Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг, түүнийг хэрэглэх журам
  - Мал өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангах, шалгах, дүгнэх заавар батлах тухай
  - Мал эмнэлгийн ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажил зохион байгуулах
  - Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрийн хүлээн авах, үеийн мал эмнэлэг хорио цээрийн журам батлах тухай
  - Бод малыг индексжүүлсэн тамга, дугаарын сүлжээнд хамруулах тухай журам батлах тухай /ХХААС, ХЗДХС/
  - Гойд ашиг шимт мал шалгаруулах журам батлах тухай
  - Махны хяналтын дүрэм батлах тухай

Дээрхи хууль, эрх зүйн актууд нь Хөдөө аж ахуйн салбар тэр дундаа мал аж ахуйн салбарын эрх зүйн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжууд юм. Монгол улсын Засгийн газраас дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгөөр олон тооны төсөл хөтөлбөрийг мал аж ахуйн салбарт хэрэгжүүлж байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь Монгол Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгүүдийн хэрэгжүүлэхээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй ажлууд юм. Үүнээс үзэхэд Мал аж ахуйн салбарын харилцаа нь эрх зүйн орчны хувьд нилээд бэхэжсэн салбар болсон нь харагдаж байна.

## 2. Зээл, тусламжийн хувьд

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас “Мал сүргийг ган зудаас хамгаалахад туслах”, “Малын эрүүл мэнд”, “Малын чанар сайжруулах” зэрэг томоохон хөтөлбөрүүдийг батлан гаргаж хэрэгжүүлж байгаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлд нааштай ахиц өөрчлөлт гарахад нөлөө үзүүлж байгаа нь эргэлзээгүй.

Малчид, иргэдэд хагас суурин, суурин хэлбэрийн эрчимжсэн аж ахуйг эрхлэх сонирхол нэмэгдэж байгааг харгалзан төр засгаас зохих дэмжлэг туслалцаа үзүүлсээр байна. Тухайлбал: 2000 оны эхээр байран маллагаатай суурин аж ахуй эрхлэгчдийн тоо улсын хэмжээнд 100 хүрэхгүй байсан бол 2000 оны сүүлээр 600-д хүрч өссөн байна. Мөн улсын хэмжээнд 1990-2001 оныг хүртэлх 10 жилийн хугацаанд хадлан тэжээл бэлтгэх зориулалтын техник хэрэгсэл ердөө 700-г оруулж ирсэн байсан бол сүүлийн жилүүдэд дотоод, гадаадын хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглаж бага оврын трактор, хадлан, тариалангийн дагалдах тоног төхөөрөмжийг худалдан авч малчид, иргэдэд 50-60 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож байна. Үүний үр дүнд улсын хэмжээнд хадлан тэжээл бэлтгэлийн хэмжээ ихээхэн нэмэгдэж байна.

Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах нэг үндэс болох бэлчээрийн эзэмшил, ашиглалт, уст цэгийн хангамжийг сайжруулахад төр засаг анхаарлаа хандуулж сүүлийн жилүүдэд улсын төсвийн болон гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгөөр нийтдээ 4000 орчим худаг засварлаж ашиглалтанд оруулснаар 5,5 сая га бэлчээрийг сэргээж сайжруулсан

байна.Түүнээс гадна мал эмнэлэгийн арга хэмжээнд жил бүр 5,3 тэрбум гаруй төгрөг улсаас зарцуулж байна.

### Худаг шинээр гаргах, сэргээн засварлах ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ

Хүснэгт-1

Он	Худаг шинээр гаргах ажилд зориулан улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Худгийн засварын ажилд зориулан улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Худгийн засварын ажилд зориулан гадаадын зээл тусламжаас зарцуулсан хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Нийт
1998	-	238,0	-	238,0
1999	-	282,0	-	282,0
2000	-	260,0	-	260,0
2001	-	391,0	-	391,0
2002	-	515,0	70,4	585,4
2003	-	450,0	519,3	969,3
2004	250,0	428,0	989,6	1667,6
2005	200,0	400,0	1087,3	1687,3
2006	1500,0	1700,0	696,5	3896,5
Нийт	1950,0	4664,0	3363,1	9977,1

### Улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр засварласан болон шинээр гаргасан худгийн тоо

Хүснэгт - 2

Он	Улсын төсвийн хөрөнгөөр засварласан худгийн тоо	Улсын төсвийн хөрөнгөөр шинээр гаргасан худгийн тоо	Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр засварласан болон шинээр гаргасан худгийн тоо	Нийт
1998	167	-	-	167
1999	170	-	-	170
2000	157	-	-	157
2001	254	-	-	254
2002	284	-	20	304
2003	273	-	176	449
2004	213	37	359	609
2005	191	29	371	591
2006	563	180	238	981

Нийт	2272	246	1164	3682
------	------	-----	------	------

/Эх сурвалж: “Усны үндэсний хөтөлбөр”-ийн ХХААХҮ-ийн салбарт хамаарах заалтын 2007 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн /2008.11.03/

Аливаа салбарын хөгжлийн үндэс, тулгуур, хөдөлгөгч хүч нь хүн билээ. Мал аж ахуйн салбарын хувьд малчин, малчин өрх юм. Өнөөгийн байдлаар улсын хэмжээнд 15,534 мянган өрхөд 400 мянга орчим малчин ажиллаж хүнс үйлдвэрлэж, аж үйлдвэрийн түүхий эд бэлтгэж байна. Малчдын маань 49,5 хувь нь 35 хүртлэх насны залуучууд байна. Мал аж ахуйн эрхлэгчдийн олонхид зах зээлийн үеийн аж ахуйг удирдан хөтлөх, захиран зарцуулах, арвижуулах, хөдөлгөөнд оруулах дадлага туршлага, чадвар дутмаг байна. Тэрчлэн малчдын хүүхэд сургууль завсардаж, мэргэжил боловсролгүй хүмүүс хөдөөд олшрох хандлагатай байгаа нь сэтгэл зовоосон асуудал юм.

Иймд малчид хөрөнгө хүч хөдөлмөрөө хорших, аж ахуй эрхлэх арга ажиллагаа, хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулахын зэрэгцээ зах зээлд амьдрах ухаан, аж ахуйч сэтгэлгээг дээшлүүлэх зэрэг олон шаардлагаар дээд боловсрол эзэмших шаардлага тулгарч байгааг харгалзан “МУ-ын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, “МУ-ын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-уудыг батлан мөрдүүлж байна. 2000-2010 оны хооронд арван жилийн хугацаанд дээрхи журмын дагуу малчин өрхийн **32 мянга** гаруй оюутан хамрагдаж /Оюутны тоо давхардсан тоогоор/ **9057693.6** мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

#### 2000 - 2010 онуудад Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагад буцалтгүй тусламжаар малчин өрхөөс суралцагчдын судалгаа

Хүснэгт - 3

№	Үзүүлэлт	Малчин өрхөөс суралцагчдын тоо	Нийт санхүүжилт /мян.төгрөгөөр/
1	2000-2001 оны хичээлийн жил	273	71845.5
2	2001-2002 оны хичээлийн жил	970	264583.9
3	2002-2003 оны хичээлийн жил	2080	567694.6
4	2003-2004 оны хичээлийн жил	3807	984919.6
5	2004-2005 оны хичээлийн жил	5034	1343752.5
6	2005-2006 оны хичээлийн жил	5077	1331802.3
7	2006-2007 оны хичээлийн жил	4808	1231937.9
8	2007-2008 оны хичээлийн жил	4169	1062324.2
9	2008-2009 оны хичээлийн жил	3245	1292773.4
10	2009-2010 оны хичээлийн жилийн 9-3 сар	2795	906059.7
	<b>Дүн</b>		<b>9057693.6</b>

**Тайлбар:** Суралцагчдын тоо давхардсан тоогоор байгаа болно.

Эх сурвалж: БСШУЯ-ны харьяа Сургалтын төрийн сангаас ирүүлсэн мэдээлэл

Мөн түүнчлэн 2008 оны 10 дугаар сарын 09-ний “Монгол улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө зарцуулах тухай” хуулийг батлан гаргаж нэг килограмм ноолуур тутамд 5000 төгрөгийг малчид болон мал бүхий иргэдэд нэг удаа олгож, **30,5 тэрбум** төгрөгийг Монгол улсыг хөгжүүлэх сангаас гаргахаар шийдвэрлэсэн. Энэ нь малчин өрх болон мал бүхий иргэдийг дэмсэн нэг арга хэмжээ байсан боловч нилээд хэл ам дагуулсан шийдвэр байсан.

**Банкны зээл:** Манай улсын ХААН, Анод, Монгол шуудан зэрэг арилжааны банкуудаас малчдад зээл олгож байна.

ХААН банкнаас 2000-2008 онд 11,810 зээлдэгчид олгосон 8,83 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл 2,87 тэрбум төгрөг нь 3,081 зээлдэгчид хамрагдаж байсан бол, 2007 онд 64,734 зээлдэгчийн 99,17 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй болж, 2009 оны 3-р сарын 31-ний байдлаар өссөн дүнгээр 66345 зээлдэгчид 81,91 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

ХААН банк 2000-2009 онд өссөн дүнгээр 440,006 зээлдэгчид 515,84 тэрбум төгрөгийн зээл олгож, 373,661 зээлдэгчийн 433,92 тэрбум төгрөгийн зээл нөхөн төлөгдөж, 2009 оны 03 сарын 31-ны байдлаар 66,345 зээлдэгчид хамаарах 81,91 тэрбум төгрөгийн зээл төлөгдөөгүй байна. Анод банкнаас Завхан, Баян-Өлгий аймгийн салбараар дамжуулан 35 зээлдэгчид 41,42 сая төгрөгийн зээл олгосноос 5 зээлдэгчид хамаарах 11,78 сая төгрөгийн зээлийн хугацаа хэтэрсэн байна.

Монгол шуудан банкнаас орон нутаг дахь салбаруудаараа дамжуулан бүх хот, аймгийн малчдад зориулан 11982 зээлдэгчид 16,98 тэрбум төгрөгийн зээл олгож, 2009 оны 12 сарын 31-ний байдлаар 10431 зээлдэгчид хамаарах 14,48 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

#### Арилжааны банкнаас малчдад олгосон зээлийн тооцоо

/мян.төг/ 2009.03.31-ний байдлаар

Хүснэгт - 4

№	Зээлийн нэр	Банкны нэр	Зээл олголт		Зээлийн үлдэгдэл		
			Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Хувиар %
1	Малчдын зээл	ХАА-н банк	440.006	515.841.150	66.345	81.919.858	15.9
2	Малчдын зээл	Монгол шуудан банк	11.982	16.172.717	10.431	14.485.546	89.6
3	Малчдын зээл	Анод банк	35	41.422	35	41.422	100
4	Дүн		452.023	532.054.989	76811	96.446.826	18.1

/Эх сурвалж: Малчдын зээлийн талаархи судалгаа-УИХТГ-ын Судалгааны төв. 2009 он/

Уг судалгаанд МУ-ын нийт мал сүрэг (барьцааны үнээр нь тооцвол)-ийн 12,6 хувь нь арилжааны банкнаас малчдын авсан зээл (үлдэгдэл)-ийн барьцаанд байгаа бөгөөд барьцаанд авсан тооцооны үнэ нь Үндэсний Статистикийн хорооноос гаргасан үүнээс **бод малд** 15,0-18,3 хувь, **бог малд** 25-28,6 хувиар хямд байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

1992 оноос хойш Хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр том жижиг 80 гаруй төсөл хөтөлбөрийн бүсийн болон орон нутаг, улсын хэмжээнд хэрэгжүүлсэн

байна. Буцалтгүй тусламжаар нийт 75 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж **101,477,689** ам долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

### Буцалтгүй тусламжаар одоо хэрэгжиж буй төслүүдэд:

Хүснэгт - 5

№	Төслийн нэр	Төсөвт өртөг /ам.дол/	Эхэлсэн огноо	Дуусах огноо	Хэрэгжүүлэгч байгууллага	Хандивлагч улс
1	Говийн бүсийн эдийн засгийг хөгжүүлэх санаачлага	10,000,000	2004	2008	ХХААЯ	АНУ
2	Говийн бүсийн өсөлтийг хангах санаачлага	980,000	2004	2008	Аж үйлдвэр	АНУ
3	Дорнод Монголыг хөгжүүлэх ХАА-н мастер төлөвлөгөө боловсруулах	2,500,000	2008	2009	ХХААЯ	БНСУ
4	Төвийн аймгуудад мал эзмэгжүүлэх төсөл	440,909	2007	2009	ХХААЯ	БНЧУ
5	Тогтвортой амжиргаа төсөл	3,905,000	2008	2012	Сангийн яам	Дэлхийн банк
6	Тогтвортой амжиргаа төсөл	8,656,000	2008	2012	Сангийн яам	Дэлхийн банк
7	Малын эрүүл мэнд мал аж ахуйн зах зээлийн төсөл	9,000,000	2007	2011	ХХААЯ, Сангийн яам	Европын холбоо
8	Тогтвортой амжиргаа-2	10,000,000	2008	2013	Сангийн яам	Европын холбоо
	Нийт	<b>36,481,909</b>				

/Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээлэл, хувийг хавсралтаар хавсаргав/

### 3. Татвар /хөнгөлөлт, чөлөөлөлт/-ын хувьд:

Төр, засаг мөнгө зээл, хөрөнгө оруулалт, татвар, даатгалын уян хатан бодлого баримталж мал сүргийг ган, зуд, түймэр, үер, гоц халдварт өвчний хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, гай гамшиг болсон тохиолдолд хөрөнгө хүчийг зохицуулах тогтолцоо, механизм бий болгох чиглэлээр ажиллаж ирсэн бөгөөд хойшид ч ажиллах болно. Өнөөдөр мал аж ахуйн салбарт үнэ бүрэн чөлөөлөгдсөний зэрэгцээ татварын хамгийн хөнгөлөлттэй бодлого үйлчилж байна. Тухайлбал “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-д 2009 оны 06 сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулж малчин өрх, мал бүхий этгээдийн олсон орлогыг хувь хүний орлогын албан татвараас бүрэн чөлөөлөх шийдвэр гаргасан.

Сүүлийн жилүүдэд төрөөс хөдөө аж ахуйн салбарыг дэмжих бодлогыг баримталж төрөл бүрийн арга, хэлбэрээр дэмжлэг туслалцаа үзүүлж байгаагийн нэг хэлбэр нь энэхүү шийдвэр юм. Малчин өрх, малчин нь одоогоор нийгмийн даатгалын шимтгэл, малын хөлийн татвар, зарим нэг албан татвар /буу, автотээврийн татвар/ зэрэг албан татварыг төлдөг бөгөөд эрүүл мэндийн даатгалын хувьд сайн дураараа төлж байна. Малчин

өрх болон мал бүхий 150534 өрхөөс 1999-2009 оныг хүртлэх арван жилийн хугацаанд 49647495,6 мянган малд 1778458,6 мянган төгрөгийн татвар төлсөн байна. /Хүснэгт-5/

### Мал бүхий иргэний орлогын албан татварын ногдуулалтын мэдээлэл

Хүснэгт - 6

Үзүүлэлт		1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Татвар ноогдсон	Мал бүхий өрхийн тоо	163,835	120861	63157	94138	118509	115930	118896	119127	135163	146333	150534
	Малын тоо	13046631,7	19127115,2	15531740,5	20723279,2	23703378,9	24099591,2	30154075,2	32556976,7	39019145,7	46977228,5	49647495,6
Татварын дүн		691031,9	1258685,89	1102421,7	1530214,4	1690927,5	1836330,7	2128525,7	2290902,6	2649715,0	3248056,9	1778458,6

/Эх сурвалж: Үндэсний татварын ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл/

Мөн түүнчлэн “Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай” 1996 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар ямааны ноолуурын экспортын гаалийн татварыг /боловсруулаагүй/ килограмм тутамд 4000 төгрөг байхаар хуульчилсан. Гэсэн хэдий ч дэлхийн зах зээл дээрхи ноолуурын ханшийн уналтаас шалтгаалан ноолуурын үнэ унасантай холбогдуулан 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар энэхүү заалт хүчингүй болгож одоогоор Монгол улс ямааны боловсруулаагүй ноолуурыг ямар ч гаалийн албан татваргүйгээр экспортлож байна.

## 2.2 Газар тариалан Монгол улсын хөдөө аж ахуйн гол салбарын нэг болох нь

### 2.2.1. Газар тариалангийн үйлдвэрлэлтийн хөгжил

#### Газар тариалангийн үйлдвэрлэл


Хүснэгт

Он	Тариалсан талбай /га/						Хураасан ургац /тн/				
	Нийт тариалсан	Үр тариа	буудай	төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал	Үр тариа	буудай	төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал
1970	454633,9	419558,6	347960,2	2873,7	1418,8	30782,8	326536,1	288133,9	22001,0	12571,4	47524,8




1975	50914,0	437067,0	315610,0	4309,0	1964,0	66574,0	536334,0	412997,0	42290,0	19126,0	164463,1
1980	703996,4	557506,0	408212,0	7450,9	2362,5	136677,0	286823,9	229806,3	39340,7	25982,7	102797,5
1985	789647,8	636239,5	482070,0	10338,1	3330,2	139740,0	886171,0	688461,5	113854,4	41187,9	601234,3
1990	787750,7	654090,2	532945,2	12167,0	3649,9	117840,4	718334,6	596205,9	131053,4	41742,4	527142,3
1995	372586,7	356465,8	348485,0	6225,7	3243,8	5951,4	261427,6	256741,1	51980,7	27287,8	18666,8
2000	209256,2	194734,6	-	7882,6	5373,3	755,8	142066,1	138700,0	58907,2	43999,4	4115,0
2005	189548,7	159094,8	153800,0	9757,8	5887,9	5161,1	75468,5	73500,0	82841,4	64159,6	8328,0
2009	282000,0	253389,8	248900,0	13524,0	6517,9	3305,5	391700,0	388100,0	151200,0	78000,0	10400,0

График




График



Хураасан ургац

График




- 2.2.2. Хөдөө аж ахуйн газар эдэлбэр, тариалсан талбай, хөдөө аж ахуйн эдэлбэр газар /га/

Хүснэгт 8

Он	Эдэлбэр газар	Үүнээс		Нийт тариалсан талбай	Үүнээс			
		Хагалсан газар /га/	Хадлан бэлчээрийн талбай		Үр тариа	Төмс	Хүнсний ногоо	Тэжээлийн ургамал
1970	140683,0	744,0	139939,0	454633,9	419558,6	2873,7	1418,8	30782,8
1975	140883,3	793,4	139889,6	486695,6	426735,6	3562,6	1756,8	54634,3
1980	125348,8	1109,2	124239,6	642651,6	530113,6	6334,6	2231,9	103971,5
1985	124642,8	1293,0	123349,8	718905,4	582765,6	41320,6	2886,5	124988,5
1990	125168,4	1347,2	123817,6	811565,8	644332,2	12302,1	3953,2	150916,1
1995	121156,4	1345,8	119810,6	558823	511963,8	8339,4	2809,6	35082,6
2000	127478,2	1352,8	126195,9	302749,6	286054,4	7655,3	4626,7	3268,8

2005	121292,1	723,9	119431,2	223853,2	200386,8	9270	5869,1	3664,5
2009	115860,1	628,8	113353,4	167853,1	163829,7	12000,1	6236,2	4411,2

График



### 2.2.3 Газар тариалангийн салбарт төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-д “хөрс, уур амьсгал, эдийн засгийн нөөцөө зохистой ашиглаж, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд газар тариалангийн бодлого чиглэгдэнэ” гэж заасан нь ойрын 15 жилд баримтлах бодлогын үндсэн үзэл баримтлал болж байна.

Өнгөрсөн жилүүдэд Газрын тухай, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Үр тариалангийн даатгалын тухай, Тариалангийн тухай зэрэг хуулиудыг батлан хэрэгжүүлж байгаа нь нийгэм, эдийн засгийн шинэ нөхцөл, зах зээлийн орчинд газар тариалан эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэ нь тариалангийн талбайг зүй зохистой ашиглах, хөрсний үржил шим, ургацыг хамгаалах, газар тариаланд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, даатгалын системд хамруулах эрх зүйн хэм хэмжээг тодорхой болгосон билээ.

Дээрхи хууль болон бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас 2010 оныг “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх жил болгон, уг бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

УИХ-аас газар тариалангийн салбарын эрх зүйн харилцааг зохицуулсан шийдвэр гаргасанаас хойш үе үеийн Засгийн газрууд газар тариалангийн салбарыг дэмжсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж байсан бөгөөд одоо ч тэрхүү үйл ажиллагаа нь улам эрчимтэй өрнөж аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн газар тариалангийн хөдөлмөр эрхлэх хандлага сүүлийн жилүүдэд нилээд нэмэгдэж байна. Үүнийг төрөөс дэмжиж гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтаар томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- Засгийн газраас “Үр” дэд хөтөлбөрийг 2001 оноос хэрэгжүүлж нийтдээ 1.09 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэгийг 14 аж ахуй нэгжид үзүүлснээр 14.4 мянган тонн элит болон сортын үр гаргаж аж ахуй нэгж, иргэдэд нийлүүлсэн байна. Мөн түүнчлэн сүүлийн 5 жилд давхардсан тоогоор мянга гаруй аж ахуй нэгж, байгууллагад нийтдээ 80.8 мянган тонн үрийг хөнгөлөлттэй олгосон нь тариаланчдад үзүүлсэн томоохон дэмжлэг болсон байна.

Монгол Улсын Засгийн газар хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах

зорилтын хүрээнд “Атрын гурав дах аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийг 2 дах жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.

Засгийн газар хөтөлбөрийн хүрээнд давхардсан тоогоор тариалан эрхлэгч 1500 гаруй аж ахуй нэгж, иргэнд 7,8 мянган тонн шатахуун, 23,3 мянган үр, 1000 тонн эрдэс бордоо, 225,0 тонн ургамал хамгаалалын бодис олгож дэмжлэг үзүүлсний үр дүнд төлөвлөсөн хэмжээндээ тариалалтыг явуулж, 2008 онд 256,4 мянга, 2009 онд 269,0 мянган га-д чанар сайтай уринш бэлтгэсэн байна. “Ногоон хувьсгал” хөтөлбөр болон НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 940 га-д тариалах төмс, хүнсний ногооны үрийг 8,0 мянган өрхөд олгосон нь орлого багатай өрхийн амжиргаанд зохих нөлөө үзүүлсний зэрэгцээ төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг 12-16 хувиар өсгөсөн байна.

Татварын хувьд газар тариалан эрхлэгчид нь Хувь хүний орлогын албан татвар төлж байна. Газар тариалан эрхлэгчдэд зориулсан тусгай зохицуулалт байхгүй бөгөөд Газар тариалангийн даатгалын тухай хууль болон Тариалангийн тухай хуулиар газар тариалан эрхлэгчдийг дэмжиж байна. Тариаланд ашиглах техник тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл, услалтын системийн тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, бордоог гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн шийдвэр гаргасан нь энэ салбарт төрөөс авч буй томоохон дэмжлэг туслалцаа болсон.

\* \* \*

#### Хавсралт

#### Газар тариалангийн салбарын эрх зүйн харилцааг зохицуулж буй Монгол улсын хууль, тогтоомжууд

№	Эрх зүйн актын нэр	Зохицуулсан байдал
1	Монгол Улсын Үндсэн хууль 1992 он	1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.
2	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2006-06-29	5.4.Тусгай сан дараахь төрөлтэй байна: 5.4.14. Тариаланг дэмжих сан; <b>24 дүгээр зүйл. Тариаланг дэмжих сан</b> 24.1.Энэ хуулийн 6.5.3-т заасан Тариаланг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна: 24.1.1. усалгаатай тариаланг хөгжүүлэх, услалтын систем байгуулах, сэргээн засварлах; 24.1.2. тариалангийн газрыг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах; 24.1.3. таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх; 24.1.4. хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх; 24.1.5. тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан буудай худалдан авах; 24.1.6. тусгай сангийн үндсэн хөрөнгөд засвар үйлчилгээ хийх.

3	Газрын тухай хууль 2002-06-07	<p>10.1. Монгол Улсын газрын нэгдмэл санг дараахь байдлаар ангилна: 10.1.1. хөдөө аж ахуйн газар; 11.1. Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газар хамаарна.</p> <p><b>29 дүгээр зүйл. Эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил</b></p> <p>29.1. Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна.</p> <p>29.2. Энэ хуулийн 29.1-д зааснаас гадна гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар иргэнд 0,1 га-гаас илүүгүй газар үнэ төлбөргүй эзэмшүүлж болно.</p> <p>29.3. Багийн иргэдийн Нийтийн Хурлын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Нэг иргэнд давуу эрхээр эзэмшүүлэх тариалангийн газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс, хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байна.</p>
4	Газрын төлбөрийн тухай хууль 97-04-24	<p>4. Газрын төлбөрийг эзэмшил, ашиглалтад олгосон газрынх нь нийт хэмжээгээр тооцно.</p> <p><b>7 дугаар зүйл. Газрын төлбөрийн хувь, хэмжээ</b></p> <p>1. Газрын төлбөрийг түүний суурь үнэлгээнээс энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр дараахь хязгаарт багтаан хувь, хэмжээгээр тогтооно: 1/ нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийн хязгаар 0,01-0,03 хувь; 2/ эзэмшиж, ашиглаж байгаа нэг га тариалан, хадлангийн газрын төлбөрийн хязгаар 0,01-0,03 хувь; 3/ эзэмшиж, ашиглаж байгаа хот, тосгон, бусад суурины нэг га газрын төлбөрийн хязгаар 0,1-1,0 хувь; 4/ зам, шугам сүлжээний газрын километр тутмын газрын төлбөрийн доод хязгаар 1500 төгрөг, дээд хязгаар 7500 төгрөг;</p> <p><b>8 дугаар зүйл. Газрын төлбөрөөс чөлөөлөх</b></p> <p>1. Дараахь төлбөр төлөгчийг дор дурдсан газрыг эзэмшиж, ашигласны төлбөрөөс чөлөөлнө: 1/ малчин өрхийг бэлчээр, хадлангийн газрын; 2/ Монгол Улсын иргэнийг ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглаж буй 0,07 га хүртэлх хэмжээний газрынх нь төлбөрийн 90 хувиар;</p>
5	Тариалангийн тухай хууль 2004-04-22	<p>Энэ хуулийн зорилт нь тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, үржил шимийг нь хамгаалахтай холбогдон иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.</p> <p>3.1.1. “тариалангийн газар” гэж тариалангийн үйлдвэрлэл эрхлэх зориулалттай иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан газрыг;</p>

6	Усны тухай хууль 2004-04-22	Энэ хуулийн зорилт нь ус, түүний сав газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. "Услалтын систем" гэж бэлчээр, хадлан, тариаланг услах зорилгоор гадаргын болон газрын доорхи усыг хуримтлуулах, дамжуулах, хуваарилах, түгээх, илүүдэл усыг зайлуулах зориулалт бүхий усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг багтаасан иж бүрэн цогцолборыг; "ус хэрэглэгч" гэж ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн хэрэглээ болон мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг.
7	Таримал ургамлын үр сортын тухай 99-06-17	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр таримал ургамлын удмын санг хамгаалах, сортыг сорих, баталгаажуулах, үрийн ба сортын чанарт хяналт тавих, үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Байгалийн гамшгийн улмаас тариалах үрээ нөөцөлж чадаагүй үйлдвэрлэгч болон хүнс, тэжээлийн үр тарианы үйлдвэрлэл дагнан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилгоор үрийн нөөцийн улсын сан бүрдүүлнэ.
8	Үрийн тариалангийн даатгалын тухай хууль 99-07-02	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үрийн тариаланг заавал даатгуулахтай холбогдсон даатгалын компани болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. «үрийн тариалан» гэдэгт үрийн зориулалтаар ашиглахаар тариалсан үр тариаг: "үр тариа" гэдэгт усалгаатай болон усалгаагүй нөхцөлд тариалсан буудай, арвай, хошуу будаа, сагад будаа, хөх тариа, тритикале, бог будаа, эрдэнэ шиш, буурцагт ургамлыг. 5.1. Үрийн тариаланг дараахь эрсдэлээс заавал даатгана: 5.1.1. байгалийн эрсдэл: ган, үер, хүчтэй салхи, шуурга, мөндөр, хяруу, цас, цочир хүйтрэл зэрэг; 5.1.2. ургамлын гоц хөнөөлт өвчин; 5.1.3. хөнөөлт шавьж, мэрэгчид; 5.1.4. түймэр.
9	Хүнсний тухай хууль 99-10-07	Энэ хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. «стратегийн хүнс» гэж монгол хүн хүнсэндээ хэрэглэж дадсан, хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай мах, буудай, тарианы үр, давс, ундны усыг; 4.1.2. стратегийн хүнс үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчдийг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих; 5.1.5. стратегийн хүнсний үйлдвэрлэлд улсын захиалга өгөх, хөнгөлөлттэй зээл олгох;

## УИХ-ын тогтоолууд болон бодлогын баримт бичгүүд

№	Эрх зүйн актын нэр	Зохицуулсан байдал
---	--------------------	--------------------

1	Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого батлах тухай	<p>Энэхүү бодлогын зорилго нь эдийн засаг, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмж, чадавхийг нэмэгдүүлэх, мал аж ахуй, газар тариалан, хүнсний салбарын тогтвортой хөгжлийг хангах, экологийн цэвэр, аюулгүй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэгдэнэ.</p> <p>Төрөөс баримтлах энэхүү бодлогын зорилт нь хүнс, хөдөө аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн мах, сүү, гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэхэд оршино.</p> <p>6. Газар тариалангийн талаар</p> <p>Хөрс, уур амьсгал, эдийн засгийн нөөцөө зохистой ашиглаж, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд газар тариалангийн бодлого чиглэгдэнэ.</p>
2	Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны Хөтөлбөр 2008-11-21	<p>2.3.5. Газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх “Атрын 3 дахь аян”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, усалгаатай тариалан эрхлэх, техникийн парк шинэчлэлтийн бодлогыг боловсруулж, техник, технологийн шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлж, хамгаалагдсан хөрсний тариаланг нэмэгдүүлнэ. Шинэ төрлийн таримал тариалах, үр сортын шинэчлэл хийх, таримал ургамлыг хамгаалах тогтолцоо бүрдүүлнэ.</p> <p>2.3.13. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, газрын нөөцийн болон төлөв байдлын мэдээллийн нэгдсэн сантай болох, бэлчээрийг хамгаалах, сайжруулах, усжуулах, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг иж бүрэн авч хэрэгжүүлнэ.</p>
3	Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл  2009 оны 79 дүгээр тогтоолын хавсралт	<p>“Атрын 3 дахь аян”-ыг эрчимжүүлэх ажлын хүрээнд гол мөрөн бусад эх үүсвэрээр усан сан байгуулж, усалгаатай газар тариалан хөгжүүлэх санаачилгыг дэмжих, газар ашиглалтыг сайжруулан нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх, услалтын системийг сэргээн засварлах, шинээр ашиглалтад оруулах; Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн гурил, төмс, хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах; Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх, дундын техник засварын үйлчилгээний нэгж байгуулах; Таримал ургамлын үр үржүүлгийн үндэсний төвийг байгуулах; Үрийн аж ахуй бий болгож, нөөцийн улаан буудай, төмс, хүнсний ногоо хадгалах агуулахын багтаамжийг нэмэгдүүлэх;</p>

## Засгийн газрын тогтоол, журмууд

№	Эрх зүйн актын нэр	Зохицуулсан байдал
	Дүрэм батлах тухай /“Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлангах журам”/	
	<u>Төсөл хэрэгжүүлэх тухай /“Агропарк” төсөл/</u>	<p>“Агропарк” төслийн зорилго нь “Атрын гурав дахь аян” тариалангийн хөгжлийн Үндэсний хөтөлбөрийн хүрээнд сум, дүүрэг бүрт агропарк байгуулан ашиглахад оршино. Агропарк нь 120 м2-аас доошгүй талбайтай дуслын усалгаа бүхий хүлэмж, 18- 20 морины хүчтэй бага оврын тракторын иж бүрдэл, 30 тонноос доошгүй багтаамж бүхий төмс, хүнсний ногооны зоорьтой байна. Хөрөнгө оруулалтын хэмжээ-3841.0 сая төгрөг</p>

	<a href="#">Жагсаалт батлах тухай /Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, зарим сэлбэг хэрэгслийн жагсаалт/</a>	
	<a href="#">Хөтөлбөр батлах тухай /Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр 2009-2016 он/</a>	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийн зорилго нь дотоодын түүхий эд, нөөц боломжид тулгуурласан, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэн, олон тулгуурт эдийн засгийг бий болгож, улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.
	Химийн хорт бодис үйлдвэрлэх, экспортлох, импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгох журам	
	Бэлчээр, тариалангийн хөнөөлт шавьж, мэрэгч амьтантай тэмцэх арга хэмжээнд мэргэжлийн хяналт тавих журам батлах тухай	

**Газар тариалангийн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд**

№	Эрх зүйн актын нэр	Зохицуулсан байдал	Үр дүн
1	<a href="#">Хөтөлбөр батлах тухай /"Өрхийн орлогыг нэмэгдүүлэх "Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөр (II үе шат 2005-2012)/</a> Засгийн газрын 2004 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 169 дүгээр тогтоол 2005-2012 он, 8 жил	Хөтөлбөрийн эхний үе шатанд олсон ололтоо бататгах, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн усалгаатай тариаланг хөгжүүлж, өрх, фермерийн аж ахуй болон жижиг хоршоод хамгаалагдсан хөрсний аж ахуйг эрхлэх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүнсний хангамжийг сайжруулах	Нийт 4910.0 сая төгрөг (улсын төсвөөс 2856.0 сая, орон нутгийн төсвөөс 48.0 сая, гадаадын зээл тусламж, төслөөс 630.0 сая, газар тариаланг дэмжих сангаас 1316 сая төгрөг ) Хөтөлбөрийн хүрээнд 2009 онд 1029 аж ахуйн нэгж, 63.3 мянган өрх төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний аж ахуй эрхлэн 11.2 мянган га-гаас 130.5 мянган тонн төмс, 5.6 мянган га-гаас 68.9 мянган тонн хүнсний ногоо, 542.2 га-гаас 247.8тонн жимс жимсгэнэ хураан авч, 580.4 мянган шил хүнсний ногоог даршилж боловсруулан зах зээлд борлуулж өрхийн дундаж орлогоо 390.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Мөн өвлийн 12.5 га хүлэмжнээс 390.0 тонн, зуны 31.4 га хүлэмжнээс 449.2 тонн, 75.6 га хучлагатай талбайгаас 945.8 тн ургац хураан авсан байна. 2009 онд улсын хэмжээгээр 13.1 мянган га-гаас 156.0 мянган тонн төмс, 6.53 мянган га-гаас 81.5 мянган тонн хүнсний ногоо хураан авсан нь хөтөлбөрийн 2 дахь үе шат батлагдсан 2004 онтой харьцуулбал төмс, хүнсний ногоо тариалсан талбай 5.7 мянган га-гаар буюу 40.7 хувь, хураан авсан ургац 108.1 мянган тонноор буюу 83.5 хувь нэмэгдлээ.



2	<a href="#">Хөтөлбөр батлах тухай</a> <a href="#">/“Өрхийн орлогыг нэмэгдүүлэх “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөр (II үе шат 2005-2012)/</a>	“Бэлчээрийг үр ашигтай, зохистой ашиглах замаар ядуу болон эмзэг бүлгийн малчдын бие даасан байдлыг бэхжүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх”-д оршино.	4,5 сая.CHF Бэлчээр сайжруулах зохистой технологийг боловсруулах 9 төрлийн туршилтуудыг экологийн өөр өөр бүсүүдэд явуулжээ. Хөтөлбөр нь: Ургамлын үрийн аж ахуйн систем нурж, улсын хэмжээнд тэжээлийн нэг болон олон наст ургамлын үрийн нөөцгүй болсон өнөгийн нөхцөлд үрийн аж ахуйг сэргээж, үрийн нөөц бүрдүүлэх ажлыг эхлүүлж, тэжээл үйлдвэрлэлийн ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор нэг болон олон наст ургамлын 20 гаруй тн үр импортоор, 140 тн үр дотоодоос тус тус худалдан авч, үүнээс 98 тн-ыг 102 аж ахуйн нэгж, малчдад тараан тэжээл үйлдвэрлэлийг дэмжсэн Бэлчээрийн талхлалт, уул уурхайн олборлолт, автомашины замбараагүй хэрсэн замуудын улмаас бэлчээрийн бүтээмж, хөрсний бүрхүүл, биологийн төрөл зүйлд аюул учирч, зарим зүйлийн өвс, ургамал аажмаар устан үгүй болж, тэжээллэг чанар муутай сөөг, модлог ургамлаар солигдсоноос ургамлын бүрхүүл сийрэгжсэн. Энэ нь цаг агаарын өөрчлөлтөөс гадна бэлчээрийн нөөцийг буруу ашиглаж байгаа хүний үйл ажиллагаатай ихээхэн холбоотой юм. Бэлчээрийг өнжөөж, амраах, сэлгээх замаар сайжруулах нь Монголын нөхцөлд тохирсон арга гэдгийг туршилт, судалгаанууд нотоллоо. Бэлчээрийг нэгэнт талхалж доройтуулваас үр нэмэлэн тарих аргаар нөхөн сэргээх асуудал манай орны нөхцөлд төвөгтэй, арга технологийн хувьд эрсдэл ихтэй, цаг хугацаа, хөрөнгө хүч их шаардах хүндрэлтэй ажил тул бэлчээрийг хэт доройтуулалгүйгээр зохистой ашиглах нь зүйтэй байна.
3	<a href="#">“Монгол төмс” хөтөлбөр</a> 2008 – 2011 он	Монголын төмсний салбарын бүтээмжийг сайжруулах замаар хэрэглэгчдийг дотоодын үйлдвэрлэлийн эрүүл, тэжээллэг хүнсний төмсөөр хангах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах.	Төсөв - 3872000.00 CHF ЭШХ-үүд нь гэрээний дагуу Имвала сортын-28000, Витара-43000, нийт- 71000 ш-ийг вирусээс эрүүлжигдсэн бэсрэг булцуу үйлдвэрлэсэн бөгөөд 8800 ш –ийг аэропоники системд үйлдвэрлэжээ. 103.7м2 талбай бүхий аэропоники системээр тоноглогдсон хүлэмжийг хамтран ажиллагч 2 хүрээлэн дээр угсарч ашиглалтад оруулсан. Шинээр сонгогдсон үр үржүүлэгчид, жижиг фермерүүдэд хөтөлбөрөөс шинэ сортуудын 178 тн үрийн төмсийг олгосон. Мөн Голландын “Агрико” компаниас төмсний үр шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор 150тн супер элит үр оруулж ирсэн бөгөөд усалгааны систем бүхий 5 компанид үржүүлжээ. Өрхийн аж ахуйг дэмжих зорилгоор 116 өрхөд 5 8тн үрийн төмс олгосон.
4	Атрын гурав дахь аян 2008-2010 он	Энэ хөтөлбөр нь тариалан эрхлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амыг аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой ханган, импортын хараат байдлыг арилгаж тариалангийн хөгжлийг эрчимжүүлэх зорилготой.	Хүүгийн хөнгөлттэй зээлийн, хүүгийн хөнгөлөлтөд 10.2 тэрбум төгрөг улсын төсвөөс олгосон. Хөрс боловсруулах дэвшилтэт технологи нэвтрүүлэх зорилгоор 1000 тн эрдэс бордоо, 116 тн ургамал хамгааллын бодис импортоор авч аж ахуйн нэгж, иргэдийн төлбөрийн чадваргүй байдлыг харгалзан 90 хувиар хөнгөлттэй олгосон байна. 2007-2008 онд 7903.5 га талбай услах хүчин чадал бүхий усалтын систем барихад улсын төсвөөс 6.5 тэрбум төгрөг зарцуулсан. Үүлэнд зориудаар нөлөөлж, бороо оруулах төхөөрөмж авахад 142.5 сая төгрөг зарцуулан зохих хэмжээний материаллаг бааз бий болгосон.



## МОНГОЛ УЛС БОЛОН ӨМНӨД АВСТРАЛИ МУЖ УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Ч. Базар (Ph.D, Ц. Батбаяр, Ц. Болормаа

Судалгааг Өмнөд Австрали мужийн “Уул уурхайн тухай” хуулийг иш болгон Монгол улсын “Ашигт малтмалын тухай хууль”-ийн зарим заалттай харьцуулан хийв. Монгол болон Өмнөд Австрали мужийн ашигт малтмал ашиглах тухай хууль нь зарим нэг тодорхой зохицуулалтын хувьд ижил гэж үзэж болох авч ерөнхий суурь зарчмын хувьд ихээхэн ялгаатай ажээ. Энэхүү ялгаа хоёр улсын нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн шинжтэй үндсэн ялгаануудаас хамааралтай юм. Хоёр орны ашигт малтмалын хууль эрх зүйн харьцуулж болох асуудлуудаас:

- Ашигт малтмалын өмчлөл
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төрөл
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлага
- Тусгай зөвшөөрлийг цуцлах
- Олборлолтын гэрээ
- Байгаль орчныг хамгаалах болон бусад хохирол эрсдлээс урьдчилан сэргийлэх
- Ашигт малтмалаас олох орлого зэргийг судалж, Хүснэгт 1-д дэлгэрэнгүй үзүүлэв.

Түүнчлэн уг судалгаанд уул уурхайн ашигт малтмалыг ашиглах хүрээнд байгаль орчны талаарх шийдвэр гаргахад нутгийн иргэдийн хамтлагтай үр дүнтэй зөвлөлдөх нь Австралийн хөгжлийн үнэлгээний үйл явцын маш сайн бүрэлдэн тогтсон систем болох талаар “Нутгийн иргэдийн хамтлаг, нөхөрлөлтэй зөвлөлдөх нь - Өмнөд Австрали болон Холбооны хууль тогтоомж” гэсэн мэдээллийг Хавсралт хэлбэрээр тусгав.

### 1. Австрали улсын уул уурхайн ашигт малтмалын зохицуулалтын талаархи товч мэдээлэл

Австралийн Хамтын Нөхөрлөлийн улс нь 1901 онд Их Британийн 6 колони орныг нэгтгэж байгуулагдсан бөгөөд Засаг захиргааны 6 мужтай, муж тус бүрт нь бие даасан Засгийн газар ажилладаг ажээ. Уул уурхайн үйлдвэрлэлийн хувьд 200 гаруй жилийн түүхтэй, байгалийн нөөц баялгаа ашиглах талаарх өөрийн эрх зүйн тогтолцоог 150 жилийн өмнөөс бүрдүүлсэн байна.

Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой бөгөөд газар зүйн байршил, ашигт малтмалын онцлогоос хамаараад Муж бүр тусдаа ашигт малтмалын хуулийг дагаж мөрддөг. Үүнд:

1. Өмнөд шинэ Уэльс муж – 1992 онд батлагдсан “Уул уурхайн тухай хууль”-тай. Уг хуулиар алт, мөнгөний уурхайн үйл ажиллагааг зохицуулсан.
2. Квинсланд муж – 1989 онд батлагдсан “Ашигт малтмалын нөөцийн тухай хууль”-тай. Энэ хуулиар бүх төрлийн ашигт малтмалын харилцааг зохицуулсан.
3. Өмнөд Австрали муж – 1971 онд батлагдсан “Уул уурхайн тухай хууль”-тай. Энэ хуулиар бүх төрлийн ашигт малтмалын харилцааг зохицуулсан.
4. Тасмани муж – 1995 онд батлагдсан “Ашигт малтмалын нөөцийн тухай хууль”-тай. Уг хуулиар алт, мөнгө, газрын тос, атомын харилцааг зохицуулсан.
5. Виктория муж - 1990 онд батлагдсан “Ашигт малтмалын нөөцийн тухай хууль”-тай. Хуулиар ихэнхи ашигт малтмалын харилцааг зохицуулсан.
6. Өрнөд Австрали муж – 1978 онд батлагдсан “Уул уурхайн тухай хууль”-тай. Уг хуулиар бүх үнэт металл болон бусад ашигт малтмалын харилцааг зохицуулсан байна.

Австрали улсын уул уурхайн салбарын хууль эрх зүй нь хүдрийн төрлийн ашигт малтмалыг олборлох, газрын тос, хийн ашигт малтмалыг олборлох гэсэн 2 үндсэн чиглэлд хуваагддаг. (Зарим муж улсад, тухайлбал Баруун Австрали мужид эрэх, хайх, хадгалах, олборлох гэсэн 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог бол Күйнсланд мужид техникийн бус аргаар ашигт малтмал олборлох зөвшөөрлийг тусад нь олгохоор хуульчилсан байдаг)

Муж улсуудын ашигт малтмалын хуулийн үйлчлэх ерөнхий хүрээ нь ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа, түүнтэй шууд хамаатай байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдал зайлуулах, тээвэрлэх харилцааг зохицуулахаар хязгаарлагддаг.

Австралийн ашигт малтмалын эрх зүйн зохицуулалт нь ашигт малтмалыг ялган авах, олборлох үйл ажиллагаа нь олборлолтын тусгай зөвшөөрлөөр буюу ашигт малтмалын хуулиар зохицуулагдаж, харин бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудал нь ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, юунд ашиглахаас шалтгаалан ашигт малтмалын хуулиар бус тухайн салбар эрх зүйгээр нь зохицуулагддаг.

Байгалийн нөөц баялаг нь төрийн өмчлөлд байх бөгөөд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь төрөөс тогтоосон хууль, тогтоомжоор зохицуулагдсан тусгай нөхцөл болзлын дагуу хувийн хөрөнгө оруулалт дээр тулгуурлан явагддаг байна.

Түүнчлэн тус улсад хөрөнгө оруулалтын гэрээг “Мужийн гэрээ” нэртэйгээр уурхай бүр дээр хийдэг бөгөөд үүгээр ордын эзэмших эрхийг баталгаажуулах, их хэмжээний хөрөнгө оруулалт татах, бүтээн байгуулалт хийх, татварын нөхцлийг тогтвортой байлгах, талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг цаг хугацаа болон агуулгын хувьд тодорхой байлгах, хөнгөлөлт эдлэх, нэмэлт үүрэг хүлээх харилцааг зохицуулдаг байна. Гэрээнд ихэвчлэн Мужийн Засгийн газрын Ерөнхий сайд, Нөөцийн асуудал эрхэлсэн сайд нар гарын үсэг зурах бөгөөд Мужийн парламент баталдаг ажээ.

Мужийн парламент гэрээг баталж байгаа болохоор ордын үр шимийг оршин суугч иргэдэд хүртээх талаар ихэд анхаардаг бөгөөд орд эзэмшигч компанийг нээлттэй хувьцаат компаний хэлбэрээр ажиллуулж, нутгийн иргэд хувьцааны нилээд хувийг эзэмшихээр гэрээнд тусгадаг байна. Мөн ажиллах хүчний ихэнхийг нутгийн иргэдээс авах, мужийн бүтээгдхүүнийг ашиглах зэргийг ч тодорхой тусгадаг байна.

#### **1. Монгол улсын “Ашигт малтмалын тухай хууль” болон Өмнөд Австрали мужийн “Уул уурхайн тухай” хуулийн зарим заалтыг харьцуулсан байдал**

(Хүснэгт 1 -ийг үзнэ үү)

#### **2. Нутгийн иргэдийн хамтлаг, нөхөрлөлтэй зөвлөлдөх нь - Өмнөд Австрали болон Холбооны хууль тогтоомж**

Байгаль орчны шийдвэр гаргахад нутгийн иргэдийн хамтлагтай үр дүнтэй зөвлөлдөх нь Австралийн хөгжлийн үнэлгээний үйл явцын маш сайн бүрэлдэн тогтсон систем гэдэг нь Холбооны болон Улсын засгийн газрын хууль тогтоох үйл явц, нийтийн эрх зүйн бодлого, шийдвэрүүдийн аль алинаас нь харахад тодорхой байдаг. Нутгийн хамтлагтай зөвлөлдөх нь Австралид шийдвэр гаргахад ихэнх хөгжлийн хөтөлбөрүүдийг үнэлэх, дүгнэх стандарт практик болдог ажээ.

Мэдээллийн талаарх заалтууд

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тавигдах шаардлагууд
- Орон нутаг, холбооны болон улсын түвшинд олон нийтэд мэдээлэх процесс
- Шударга ёсонд хүрэх боломж: нэхэмжлэх нээлттэй эрх (legal standing) болон шүүхийн зардлын асуудал зэрэг нь хуулийн гол харилцаа юм.

Монгол	Австрали	Тайлбар
1 Ашигт малтмалын өмчлөл		
<ul style="list-style-type: none"> <li>Төр эрх олгох буюу өөрөө үйл ажиллагаа явуулж байгаа нь төрийн мэдэлд байгааг харуулж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бүх ашигт малтмал нь Эзэн хааны өмч байна. Өмнөд Австрали мужийн Уул уурхайн тухай хуулийн 1-р бүлгийн 6-д зааснаар Эзэн хааны газар гэдэг нь 1924 онд батлагдсан “Эзэн хааны газар нутгийн тухай” хуулиар зохицуулагдана.</li> </ul>	<p>Австралийн ашигт малтмалын эрх зүйн зохицуулалтаар байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлал төрийн өмч боловч төрөөс өгсөн зөвшөөрлийн дагуу олборлосны дараа ашигт малтмал, газрын тос нь тухайн олборлосон этгээдийн өмч болохоор хуульчилсан зохицуулалт нийтлэг үйлчилж байна. Тухайлбал 1990 оны Викториа мужийн Ашигт малтмалын хуулийн (s11), Баруун Австрали мужийн 1978 оны Уурхайн хуулийн (s85), Куйнсланд мужийн 1989 оны Ашигт малтмалын хуулийн (s9)-д гэх мэтээр ашигт малтмалын өмчлөл шилжих тухай заалтууд Австралийн бүх мужуудын болон холбооны хуульд байдаг.</p> <p>Манай улсын хувьд ч энэ үзэл санаа хуульд тодорхой хэмжээгээр тусгагдсан байна. Ашигт малтмалын хуулийн 27.1. заалтаар тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгосон уурхайн эдэлбэрээс олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдан борлуулах эрх нь олборлосон ашигт малтмалаа өмчлөх эрхийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болохыг хуулиар зохицуулжээ. Харин олсон орлогоо захиран зарцуулан эрхийг зөвхөн 50 саяас дээш америк доллартой тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийх этгээдтэй л “ярилцаж байж” баталгаажуулахаар хуульчилжээ. Олсон орлогоо захиран зарцуулах тэдний эрхийг чухам ямар байдлаар яаж баталгаажуулах нь энэ хуулиар тодорхойгүй байгаа боловч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн олборлосон ашигт малтмалаа худалдан борлуулах эрх болон түүнээс салгаж үл болох борлуулаад олсон орлогоо захиран зарцуулах эрхийг ийнхүү компаниудын хөрөнгийн чадвартай холбоотойгоор ялгавартай баталгаажуулахаар хуульчилсан төрийн бодлогын суурь үндэслэл нь юу болох, эдгээр заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд хэр нийцэж байгааг судалж дүгнэлт гаргах нь зүйтэй болов уу.</p>
2. Тусгай зөвшөөрлийн төрөл		
<ul style="list-style-type: none"> <li>- Хайгуулын</li> <li>- Олборлолтын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хайгуулын тусгай зөвшөөрөл</li> <li>Ашиглалтын тусгай зөвшөөрөл</li> <li>Түр хадгалалтын гэрээ</li> <li>Олон төрлийн зориулалт бүхий лиценз</li> </ul>	<p>Австралийн муж улсууд нь тус тусдаа “Mineral law” буюу ашигт малтмалын хуультай, дор бүрнээ зохицуулалтын нарийн ялгаатай боловч ашигт малтмалын хуулийн үйлчлэх ерөнхий хүрээ нь ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа, түүнтэй шууд хамаатай байгаль орчныг нөхөн сэргээх, хаягдал зайлуулах, тээвэрлэх харилцааг зохицуулахаар хязгаарлагддаг тул агуулгын хувьд үндсэндээ хайгуулын болон олборлолтын гэсэн 2 төрлийн тусгай зөвшөөрөл олгогдож байна. (Зарим муж улсад, тухайлбал Баруун Австрали мужид эрэх, хайх, хадгалах, олборлох гэсэн 4 төрлийн тусгай зөвшөөрөл олгодог бол Куйнсланд мужид техникийн бус аргаар ашигт малтмал олборлох зөвшөөрлийг тусад нь олгохоор хуульчилсан байдаг) Харин манай хуулийн үйлчлэх хүрээ нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хуульлагдсан бөгөөд ашигт малтмалыг эрэх хайх үйл ажиллагааны эрхийг хайгуулын, түүнийг ялган авах, олборлох, ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагааны эрхийг ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгохоор заажээ.</p>
3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага		

<p>-Монгол улсын хууль тогтоомжын дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа</p> <p>-Монгол улсад татвар төлөгч</p>	<ul style="list-style-type: none"> <li>Хайгуулын тусгай зөвшөөрөл /лиценз/-г ямар ч хүнд олгоно./ Уул уурхайн тухай хуулийн 5 дугаар бүлэг/ Лицензээр олгогдох газар нь 1000 квадрат км-с ихгүй байх ба үнэт чулууны хайгуулын газрын хувьд уг хэмжээ 20 квадрат км-с ихгүй гэж заажээ.</li> <li>Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргагч нь уурхайн үйл ажиллагаа, уг ордыг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, бусад бичиг баримт зэргийг бэлтгэхийн зэрэгцээ өргөдлийн төлбөрийг төлнө. Олон төрлийн зориулалт бүхий лиценз нь хэд хэдэн зорилгоор олгогддог. Үүнд:</li> </ul>	<p>Австралийн ашигт малтмалын эрх зүйн зохицуулалтаас харахад ашигт малтмалыг ялган авах, олборлох үйл ажиллагаа нь олборлолтын тусгай зөвшөөрлөөр буюу ашигт малтмалын хуулиар зохицуулагдаж, харин бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудал нь ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, юунд ашиглахаас шалтгаалан ашигт малтмалын хуулиар бус тухайн салбар эрх зүйгээр нь зохицуулагдаж байна. Худалдаа, борлуулалтын хувьд хуулиар олгогдсон эрхийн дагуу олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулахад төрөөс заавал тусгай зөвшөөрөл авдаггүй. Учир нь олборлолт явуулахын гол зорилго нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах замаар ашиг орлого олоход чиглэгддэг тул олборлолтын тусгай зөвшөөрөл нь худалдан борлуулах эрхийг шууд дагуулдаг байна.</p>
	<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн ус зайлуулах үйл ажиллагаа</li> <li>Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг зайлуулах</li> <li>Уурхайн үйл ажиллагааг дэмжих бусад нэмэгдэл үйл ажиллагаа зэрэг болно.</li> <li>Уул уурхайн үйл ажиллагааг дэмжих зорилгоор явагдаж буй бизнесийн үйл ажиллагаа</li> <li>Хүдрийн үйлдвэрийг барьж байгуулах болон удирдахад</li> </ul>	
4. Тусгай зөвшөөрлийг цуцлах		

<p>Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйл тэр чигтээ "Тусгай зөвшөөрлийг цуцлах" харилцааг зохицуулжээ. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 14.4 хэсэгт "хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тусгай хэрэгцээнд авснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмал эрэх, хайх, ашиглах боломжгүй болсон бол тухайн шийдвэр гаргасан байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлнө" гэсэн заалт бий.</p>	<p>Олон нийтийн тусын тулд, сайн санааны үүднээс урган гарсан байх зарчмийг гол үндэс болгон тусгай зөвшөөрлийг цуцлах эрх зүй үйлчилдэг.</p>	<p>Австралийн эрх зүйн цаад үр дагавар нь ашигт малтмалын хайгуул, олборлолтыг хэзээ, хаана, хэнээр хийлгэхийг өмчлөгчийн хувьд төр шийдэх онцгой бүрэн эрхтэй хэдий ч нэгэнт шийдээд олгосон тусгай зөвшөөрөл хуулиар тогтоосон хугацаанд, үүргээ зохих ёсоор биелүүлж байгаа эзэмшигчдээ бүрэн хадгалагдах, хэрэв зайлшгүй шаардлагын улмаас цуцлагдахад хүрвэл хууль ёсны эзэмшигч төрөөс нөхөх олговор авах эрхээр хангагдахыг баталгаажуулсан байна. Харин зайлшгүй шаардлага гэдэг нь олон нийтийн тусын тулд, сайн санааны (in good faith) үүднээс урган гарсан байх нь гол зарчим. Байгаль орчинг хамгаалах, олон нийтийг болзошгүй аюулаас сэргийлэх, хүний амьдрах орчин, эрүүл мэндийг хамгаалах гэх мэт олон үндэслэл үүнд багтана. Эдгээр зорилгоор төрөөс тусгай зөвшөөрлийг цуцлах нь эрх зүйн ерөнхий зарчим, шударга ёсны үнэлэмжид харшлахгүй хэмээн үзэж болно. Үүний зэрэгцээ дээрх зорилгоор тусгай зөвшөөрлийг цуцалсан нь төр болон бусад сонирхогч этгээдэд санхүүгийн ашиг орлого авчраагүй байх нь дараагийн нэг чухал зарчим Тусгай зөвшөөрөл эзэмшигч хэдийгээр үнэ цэнэтэй эрхээ алдаж байгаа ч түүний оронд хэн ч, түүний дотор төр, санхүүгийн аливаа ашиг олоогүй байх нь энэ зарчмын гол агуулга аж.</p> <p>Харин манай улсын хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 13 дугаар зүйлд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг Засгийн газрын шийдвэрээр төрийн мэдэлд авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг зогсоож болохоор заасан бөгөөд үүнийг "талбайг нөөцөд авах" гэж тодорхойлсон байна. "Талбайг нөөцөд авах" гэсэн өнөөгийн хуульд байгаа зохицуулалтыг нарийвчлан авч үзвэл энэ нь тусгай зөвшөөрлийн дагуу олгогдсон үйл ажиллагааны эрхийг төрөөс хураах хууль зүйн үндэслэл болох Засгийн газрын "нөөцлөгдсөн эрх" юм гэж үзэж болохоор байна. Учир нь тусгай зөвшөөрөлтэй талбайг нөөцөд авсан нь тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл болохоор мөн хуулийн 56.1-д заасан байна.</p> <p>Тусгай зөвшөөрөлтэй талбайг нөөцөд авах Засгийн газрын зорилгыг хуулийн 13.1-д "тусгай зөвшөөрлийн бүртгэлийг цэгцлэх; тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд гарсан хилийн маргааныг шийдвэрлэх; улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийх, ашигт малтмал эрэх, хайх" гэж тодорхойлжээ. Эдгээр үндэслэлийг тус тусад нь хууль зүйн үүднээс авч үзвэл агуулгын хувьд ямар утгатай болох, ямар учраас тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болж байгааг ойлгоход түвэгтэйн дээр энэхүү "талбайг нөөцөд авах" хуулийн зохицуулалтад тодруулах, хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай олон асуулт гарч байна.</p> <p>Түүнчлэн улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгаа хийх, ашигт малтмал эрэх, хайх зорилгоор Засгийн газар бусдын эзэмшилд хуулийн дагуу байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргах эрхтэй гэсэн нь Засгийн газар ямар ч тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг хэдийд ч буцаагаад авч болохоор ойлгогдож байна. Засгийн газраас энэ тал дээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх ямар нэг хөнгөлөлт, "хүндэтгэн үзэх" шалтгаан байх эсэх нь ч тодорхойгүй байна.</p>
5. Олборлолтын гэрээ		

<p>-Орд бүр дээр тодорхой үүрэг хүлээлгэсэн гэрээ байгуулдаггүй.</p> <p>- Хуулийн 29-р зүйлд заасан тодорхой тохиолдлуудад Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна. Гэрээнд төрөөс татварын орчинг тогтвортой байлгах үүрэг хүлээдэг бол хөрөнгө оруулагч нь байгаль орчныг хамгаалах, бүс нутгийг хөгжүүлэх зэрэг үүрэг хүлээдэг.</p>	<p>-Хөрөнгө оруулалтын гэрээг "Мужийн гэрээ" гэсэн нэртэйгээр бараг бүх уурхай дээр хийдэг. Мужийн эрхлэх асуудлын хүрээнд ашигт малтмалын асуудал ордог тул тухайн мужийн парламент уг гэрээг батална. Гэрээнд ихэвчлэн мужийн Ерөнхий сайд, нөөцийн асуудал эрхэлсэн сайд нар гарын үсэг зурна.</p> <p>-Мужийн парламент гэрээг баталж байгаа тул ордын үр шимийг нутгийн иргэд илүү хүртэх бодлогыг дэмждэг. Үүнд ажиллах хүчийг аль болох мужийн оршин суугчдаас авах, тухайн мужийн бүтээгдхүүн хэрэглэхийг гэрээгээр шаарддаг. Мөн тухайн мужийг нээлтэй хувьцаат компанийн хэлбэрээр ажиллуулж хувьцааны нилээд хувийг оршин суугч иргэд эзэмшихээр гэрээнд тусгадаг.</p> <p>- Гэрээнд нөхөн олговрын заалтуудыг ч тусгадаг. Тухайн газар нутгийг мужийн болон улсын тусгай хамгаалалтад авах, нөөцөд авах зэрэг шаардлага гарч зохих хууль тогтоомж гарвал компанийн оруулсан хөрөнгийг муж өөрөө нөхөн төлөх үүрэг хүлээдэг байна.</p>	<p>Австрали улсын зохицуулалт мужийн оршин суугч уугуул иргэдэд байгалийн баялаг, ашигт малтмалаасаа ашиг хүртэх давуу эрх бүхий, эерэг зохицуулалт болсон байна. Монгол улсын хувьд Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж байсан туршлагауд нь ихэнхдээ сөрөг үзүүлэлттэй байгаа, гэрээ байгуулалгүйгээр ашиглаж байгаа ордын сөрөг нөлөөллүүд нэмэгдэх хандлагатай байгаа.</p>
6. Байгаль орчныг хамгаалах болон бусад хохирол эрсдлээс урьдчилан сэргийлэх		
<p>-Энэ үүргийг тусгай зөвшөөрөл эзэмшигч дангаараа хүлээдэг.</p> <p>-Үүргийн биелэлт, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд төр хяналт тавина.</p>	<p>-Нутгийн иргэдийн хамтлагтай зөвлөлдөх нь Австралид шийдвэр гаргахад ихэнх хөгжлийн хөтөлбөрүүдийг үнэлэх, дүгнэх нь стандарт практик болдог ажээ. Мэдээллийн талаарх заалтууд, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тавигдах шаардлагууд, Орон нутаг, холбооны болон улсын түвшинд олон нийтэд мэдээлэх процесс, шударга ёсонд хүрэх боломж: нэхэмжлэх нээлттэй эрх (legal standing) болон шүүхийн зардлын асуудал зэрэг нь хуулийн гол харилцаа юм.</p>	<p>Австралид Нутгийн иргэдийн хамтлагтай зөвлөлдөх, "Уугуул иргэдийн эрхийн акт" зэргийг батлан гаргасан нь нутгийн иргэд байгаль орчноо хамгаалахад уугуул гэсэн сэтгэлээс хандахаас гадна газар тариалан, бүтээн байгуулалт, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд давамгайл оролцох эрхтэй болсон. Мөн байгаль хамгаалах эрх нь хүний бусад үндсэн эрхийн адил хэмжигдэх болсон нь бусад оронд туршлага болохуйц зохицуулалт юм. Монгол улсын хувьд өнөөгийн байдлаар иргэдийн эрх, оролцоог хуулиар зохицуулсан эрх зүйн орчин бий боловч амьдрал хэрэгжүүлэх тал дээр төдийлөн ахиц олохгүй байна. Нэг талаас орон нутгийн захиргаа, нөгөө талаас уул уурхайн компани нь л голлох үүрэгтэй оролцож байгаагаас иргэдийн оролцоо орхигдож зарим талаар сөргөлдөөн үүсэх ч хандлага гарч байна.</p>
7. Ашигт малтмалаас олох орлого		



<p>-Тусгай зөвшөөрлийн төлбөр</p> <p>-Нөөц ашигласны төлбөрөөс бүрддэг. Энэ төлбөр тогтмол хэмжээтэй.</p>	<p>- Австралийн хойд бүс нутаг нь ашигт суурилсан Ашигт малтмалын нөөц ашигласны /AMHA/ төлбөрийн системтэй орон бөгөөд төлбөрийн хэмжээ нь 18% байдаг.</p> <p>Австралийн бусад бүс нутагт борлуулалтын нийт дүнд AMHA төлбөрийг ноогдуулдаг тогтолцоотой ба тэдгээр нь эрдэс баялгаас хамаарч өөр, өөр байдаг. Баруун Австралид нүүрсэнд 7.5%, зэсийн баяжмалд 5%, цэвэршүүлсэн зэсэнд 5%, хээрийн жонсонд 5%, төмрийн хүдэрт 5-7.5 % гэх мэтээр ашигт малтмалын төрөл боловсруулалтын түвшингээс хамаарч 2.5-7.5% хооронд AMHA төлбөрийг тогтоожээ.</p> <p>Эцсийн бүтээгдхүүн үйлдвэрлэж байгаа тохиолдолд ноогдуулах AMHA төлбөрийн хувь норм харьцангуй бага байдаг бол боловсруулалтын түвшин багатай бүтээгдхүүн, түүхий эд үйлдвэрлэж байгаа тохиолдолд ноогдуулах AMHA төлбөрийн хувийг үүнээс илүү өндөр түвшинд тогтоон мөрддөг байна.</p>	<p>Тухайн орны эрдэс баялгийн нөөц нөхөн сэргээгдэхгүй тул энэ нь ямар ч хуулийн этгээдэд үнэ төлбөргүйгээр ашиглагдах ёсгүй гэсэн утгыг AMHA төлбөр агуулдаг.</p> <p>Австрали улс нь AMHA төлбөрийн борлуулалтад болон ашигт суурилсан хоёр өөр системийг хослуулан хэрэглэдэг нь улсын эрдэс баялгийн нөөцөөсөө хүртэх хувийг баталгаажуулах гэсэн Засгийн газрын хамгаалалтын арга хэмжээ юм.</p> <p>Австралийн Засгийн газраас байгалийн нөөц баялаг ашигладаг компаниудад онцгой ашгийн 40 хувийн татвар ногдуулах шийдвэр гаргаж, 2012 оноос эхлэн хэрэгжүүлэх юм. Үүний дүнд эхний хоёр жилд 11.1 тэрбум ам.долларын орлого энэ татвараас орж ирнэ хэмээн Австралийн Засгийн газрын төлөөлөгчид ярьж байна. Нэмэлт татвар ногдуулж байгаатай холбогдуулан бусад компанийн 30 хувийн татварыг 2014 он гэхэд 28 хувь болгож бууруулах аж. Энэ нь бүх Австрали хүнд байгалийн баялгийг тэгш хуваарилах боломжийг олгоно хэмээн тус улсын Ерөнхий сайд Кевин Рүдд онцолж байгаа юм.</p> <p>Онцгой ашгийн татвараас орж ирэх орлогоор тус улс нийгмийн халамж, эрүүл мэндийн салбарт түлхүү хөрөнгө оруулахаар төлөвлөж байна.</p> <p>Өндөр татвар ногдуулах болсон өөр нэг шалтгаан нь уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт нь тус улсын эдийн засгийн хурдыг хоёр дахин нэмэгдүүлж байна. Энэ салбараас олж буй асар их хэмжээний ашиг нь инфляцийг хөөрөгдөж эхэлжээ.</p> <p>Австралийн төв банкнаас эдийн засгийн хөөс үүсэхээс сэргийлж, бодлогын хүүгээ нэмэх болсон. Гэтэл нөгөө талаас ашиг орлогоороо давамгайлж байгаа уул уурхайнхны хөлд бусад салбар нь чирэгдэх магадлалтай гэж үзэж байгаа аж.</p> <p>Монгол улсын хувьд ижил татвар ноогдуулдаг.</p> <p>AMHA төлбөрөөр хуримтлагдсан орлогыг юунд зарцуулдаг вэ? Дэлхийн жишгээр уул уурхайн үйлдвэрлэлтэй ихэнх орон энэхүү орлогыг “Үндэсний орлогын сан” байгуулж, нийтийн эрх ашигт нийцсэн тодорхой бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт хийдэг байна.</p>
---	--	---

### ШИГТГЭЭ

- Австралийн хууль тогтоомжууд нь Нийтийн эрх зүй, Холбооны парламентаас батлагдсан Холбооны хууль, Австралийн улсын болон нутаг дэвсгэрийн парламентаас батлагдсан хуулиудад үндэслэдэг. Улс тус бүрийн хуулиуд нь бие биендээ харилцан нөлөөтэй боловч албан ёсны биш байдаг. Гэхдээ Австралийн Парламентаар батлагдсан хууль Австралид бүхэлд нь үйлчилдэг. Нийтийн эрх зүй нь Английн уламжлалт эрх зүйгээс шүүхийн преидент, тайлбар, сайжруулж, өргөжүүлсэн байдлаар үүсэж хөгжсөн ажээ.

### Үндсэн эрх:

Байгаль орчны үнэлгээ хийхэд олон нийтийн оролцоо нь ямар ч хууль тогтоох системд үр нөлөө бүхий үйл явц гэж тооцогдохгүйгээр, хүний болон иргэний суурь эрхүүд нь байх ёстой байрандаа байна гэж хэлж болохгүй гэдгийг эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрдөг. Шударга ёсыг тогтоох, үг хэлэх эрх чөлөө, үүний дотор хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сонгох, сонгогдох эрх, мэдээлэл авах эрх, засгийн газрын ил тод, хариуцлагатай байдал нь санаж байвал зохих зүйлсийн зөвхөн цөөхөн хэсэг нь юм. Австралид дээрх эрхүүд нь эрхийн Билл, эсхүл аль нэг улсын болон холбооны Үндсэн хуулинд нэгтгэгдээгүй боловч угаас үнэ цэнэтэй байдлаар баталгаажсан, ардчилсан парламентын системд хэвшин тогтсон ажээ. Эдгээр эрхийг нийгэмд найдвартай хэвшүүлээгүйгээс байгаль орчны үнэлгээний процесс нь үргэлжид бүтэлгүйтэх, авлигын эрсдэлд учрах болно. Эдгээр



эрх нь баталгаажигдаж чадвал нутгийн хамтлагтай зөвшилцөн хууль тогтоох процесс нь жамаараа явах болно гэж үздэг.

### **Байгаль орчны үнэлгээ:**

Австралид хөгжлийн болон байгаль орчны үнэлгээ нь санал болгож буй хөтөлбөр төслөөсөө хамааран орон нутаг, улсын эсвэл Холбооны Засгийн газрын түвшний (заримдаа нэгээс илүү түвшний) үнэлгээ байж болно. Улс бүр хөгжлийн болон байгаль орчны үнэлгээний өөрийн гэсэн системтэй боловч улс бүрийн хуулиудад ижилхэн зарчмууд нэлээд тусгагдсан байдаг.

### **Мэдээллийн талаарх заалтууд:**

Төсөл, хөтөлбөрийн талаар олон нийт мэдээллээр хангагдсан байхыг баталгаажуулах эхний алхам нь мэдээллийн талаарх заалт, нөхцлийг шаардах явдал юм. Австралид олон нийтэд зарлахаас нь өмнө уг төсөл, хөтөлбөртэй холбоотой зарим мэдээллээр хангах хууль зүйн шаардлага байдаг. Хуулийн дагуу иргэд, олон нийт өргөдлөө үнэлж дүгнэх эрх бүхий албан тушаалтнаар батлуулахын өмнө гаргаж буй саналынхаа талаарх тусгай мэдээлэл, техникийн нарийвчилсан зүйлс, тайлан, төлөвлөгөө зэргийг олж авах, танилцах боломжоор хангагдсан байдаг. Энэ нь үнэлгээний процесст байдаг л энгийн зүйл мэт санагдаж болох ч ихээхэн ач холбогдолтой юм. Төсөл хөтөлбөр, байгаль орчны гарч болохуйц нөлөөллийн талаар хэдийчинээ их мэдээллээр хангана, тэр хэмжээгээр олон хүн тухайн төсөл хөтөлбөрийн талаар ул суурьтай шийдвэр гаргаж чадна.

Өмнөд Австралид орон нутгийн түвшинд (Хөгжлийн акт, 1993) орон нутгийн консул зэрэг эрх бүхий үнэлэх байгууллагаар хөгжлийн төсөл, хөтөлбөр батлуулах тохиолдолд тухайн өргөдөлд дараах зүйлсийг хавсаргасан байхыг шаарддаг. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтнаас үндэслэлтэйгээр шаардсан ямар ч мэдээлэл
- Төлөвлөгөө, зураглал, дүрслэгдэж болохуйц тодорхойлолт, бусад баримт бичиг зэрэг болно.

Мөн эрх бүхий байгууллага нь хангалттай төлөвлөгдөж хийгдээгүй төсөл, хөтөлбөрийн үзэл санааны талаарх тодруулга, нэмэлт мэдээллийг хүсэх эрхтэй байдаг. Энэ нь “төсөл, хөтөлбөр бүрийн үзэл санаа нь илүү нарийн тодорхойлогдсон, авч хэлэлцэгдсэн байх, хэрэв зөвшөөрөгдвөл үргэлжлүүлэх, зөөлрүүлэх” явдлыг баталгаажуулахад оршино. Эдгээр нь үндсэн зарчим боловч тогтвортой үйлчлэлийг нь баталгаажуулахын тулд системтэйгээр кодчилогдсон байдаг. 1993 оны Хөгжлийн актын дагуу, нэмж хүссэн мэдээллийг ирүүлээгүй тохиолдолд эрх бүхий үнэлэх албан тушаалтан нь дахин ямар нэгэн үнэлгээ дүгнэлт хийхгүйгээр уг хөгжлийн хөтөлбөрийг батлахаас татгалзах бүрэн эрхтэй.

### **Байгаль орчинд нөлөөлөх байдал (БОНБУ)-ын үнэлгээний загварууд:**

БОНБУ-ний зорилго нь үнэлж, дүгнэх эрх бүхий албан тушаалтанд уг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлснээс үүдэн гарч болох нөлөөллүүдийн талаар зөвлөх үйл явц юм. Урт болон түргэн хугацаанд илрэх нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөлөөллүүд, тэдгээрийг хэрхэн зохицуулж, сулруулж болох талаар тухайн баримт бичигт тусгадаг. Тухайн төсөл, хөтөлбөр болон байгаль орчны байж болох нөлөөллөөс хамаарч үнэлгээ, дүгнэлтийг Улсын болон Холбооны Засгийн газар аль аль нь хийж болно. Улсын түвшинд бол Өмнөд Австралийн Хотын хөгжил, төлөвлөлтийн сайд тухайн хөгжлийн төслийг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой гол хөтөлбөр болохыг тунхаглан зарлаж болох бөгөөд тэр нь “Үндсэн хөтөлбөр”-өөр үнэлэгддэг. (Хөгжлийн акт 1993-ын 46 дахь хэсэг)

Төсөл, хөтөлбөрийг шалгагдах ажиллагаа хэмээн зарлахаасаа өмнө Холбооны Байгаль орчны Сайд нь тухайн төсөлд холбогдуулан захиргааны аливаа үүрэг хариуцлага хүлээж

болох Холбооны Засгийн газрын сайдуудад уг төслийг илгээх ёстой. Тухайн төслийг хүлээн авсан бусад сайд түүнийг шалгагдах төсөлд тооцох эсэх талаар тайлбар, зөвлөгөө өгдөг. Холбооны Байгаль орчны Сайд нь түүнчлэн улсын, эсвэл нутаг дэвсгэрийн сайдуудаас (74-2 дахь хэсэг) тайлбар авахаар хүсэх, мөн олон нийтийн зарим гишүүдээс тайлбар авах ёстой байдаг. (74-3 дахь хэсэг).

Хэрэв Холбооны Байгаль орчны Сайд тухайн ажиллагааг хянах нь зүйтэй гэж шийдвэл, тэрээр байгаль орчинд нөлөөлөх байдлыг тогтоох үнэлгээний нэг аргыг сонгох ёстой. Тухайлбал, “Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай” актад тусгагдсан үнэлгээний аргууд байдаг бөгөөд үүнд:

- Итгэмжлэн үнэлэх
- Илгээгдсэн мэдээллийг үнэлэх
- Урьдчилан баримтжуулах
- Олон нийтийн байгаль орчны тайланг үнэлэх
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үнэлэх
- Олон нийтийн санал асуулгаар үнэлэх зэрэг болно.

Эндээс тухайн ажиллагааг итгэмжлэн үнэлэх нь шаардагдаж болох үнэлгээний хамгийн доод шат бол олон нийтийн санал асуулга авах нь үнэлгээний хамгийн дээд хэлбэр нь юм. Байгаль орчны сайд нь үнэлгээний аргаа сонгон шийдэхээс өмнө өргөдөл гаргагч нь Байгаль орчин, биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай актад заасны дагуу урьдчилсан мэдээллийг ирүүлэх ёстой. Урьдчилсан мэдээлэл нь дараах зүйлсийг агуулсан байна:

- Улсын болон нутаг дэвсгэрийн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж буй холбогдох нөлөөллийн ямар нэг үнэлгээний нарийвчилсан зүйлс;
- Хэрэгжиж байгаа болон ирээдүйд хэрэгжих байгаль орчны ямар нэгэн үнэлгээний нарийвчилсан зүйлс;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эсвэл байгаль орчны олон нийтийн тайланг анхаарч үзэх эсэх;
- Санал болгож буй үйл ажиллагааны сонголтууд;
- Холбогдох нөлөөллийг бууруулах, үгүй болгоход чиглэсэн зөөлрүүлэх техник ажиллагаа ;
- Арга хэмжээ авч буй хүнд холбогдох байгаль орчны тэмдэглэл, тухайлбал, байгаль орчныг хамгаалах талаарх улсуудын холбооны, улсын, нутаг дэвсгэрийн хуулийн дагуу тухайн хүний эсрэг явуулж буй аливаа үйл явцын талаарх нарийвчилсан зүйл гэх мэт.

Тухайн төсөл нь “хянагдах үйл ажиллагаа” мөн бол үүнийг Холбооны болон улсын түвшинд аль аль нь үнэлэх давхардлаас зайлсхийхийн тулд улсын Засгийн газар болон Холбооны Засгийн газрын хооронд хамтын ажиллагааны гэрээ байж болдог. Энэ тохиолдолд улсын болон Холбооны Засгийн газрын эрх мэдэлтнүүдийн хооронд зөрчилдөөн үүсвэл Холбооны эрх мэдэлтнүүдийн нөхцөл, шаардлага нь давамгайлна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх загвар (EIS) нь хамтын ажиллагааны томоохон систем биш бөгөөд төслийг цааш нь хэрхэн үргэлжлүүлж болох, эсвэл тухайн төслийг үргэлжлүүлэх эсэхийг тодорхойлохоор БОНБУ-г бэлтгэдэг шинжлэх ухааны шинжээчид, инженерүүдийг төслийн өргөдөл гаргагч нь хөлслөн авч ажиллуулдаг.

**ШИГТГЭЭ**

- Өмнөд Австралийн хойд хуурай нутаг дахь Олимпын Далангийн Ураны уурхайн өргөтгөлд ажилласан BHP Billiton компани нь 4600 хуудас хэмжээтэй БОНБУ-г 5 жил гаруйн хугацаанд бэлтгэсэн байна. Нутгийн иргэдийн санал, ашиг сонирхлыг харгалзсан энэхүү баримт бичгийг Өмнөд Австралид урд өмнө нь хэзээ ч хийгдэж байгаагүй хамгийн том, олон нийтийн баримт бичиг болсон хэмээн тухайн үед хэвлэлд нийтэлж байжээ. Тэрхүү Олимпын далангийн өргөтгөл нь Австралийн нутгийн иргэдийн зүгээс маш эерэгээр үнэлэгдсэн ба тус улсын эдийн засгийг дээшлүүлэхэд таатай нөхцлийг олгосон хэмээн тооцогддог.

Австрали дахь БОНБУ-ний загварын талаар гардаг шүүмжлэл нь төсөлд өөрчлөлт хийх төлөв байдал хурдан явцтай, төслийг нэгэнт эхэлсэн тохиолдолд буцаан татах боломж хязгаарлагдмал зэрэг болно.

**Орон нутгийн түвшинд хөгжүүлэх нь:**

Орон нутгийн түвшинд хэрэгжих жижиг төслүүдэд олон нийтийг оролцуулах нь тухайн төслөөс шууд нөлөөлөл хүртэх хүмүүстэй зэрэгцэн зөвлөлдөх боломжийг олгодог. Өмнөд Австралийн процесс нь нутаг дэвсгэр бүр бүсэд хуваагддаг гэсэн байдлаар явагддаг. Бүс болгон тухайн бүсэд баригдах дэд бүтэц, хөгжлийн тодорхой хэлбэрүүд бүхий өөрийн гэсэн зорилтуудтай. Тухайлбал, орон нутаг бүр “үйлдвэрийн бүс”, “худалдааны бүс”, “суурин бүс” зэргээр төрөлжүүлсэн байж болно. Хэрэв тухайн хөгжлийн санал нь уг бүсэд тохиромжгүй бол олон нийтэд мэдэгдэх шаардлага үүсч болох, эсвэл бүсийн зорилго, зарчимтай нийцэхгүй хэмээн үзэж болно.

Өмнөд Австралид 3 төрлийн мэдэгдэл (сонордуулга) байдаг бөгөөд үүнд:

- 1 дэх категори, мэдэгдлийг шаарддаггүй
- 2 дахь категори, ойролцоох газруудыг өмчлөгч, эзэмшигчид нь мэдэгдэхийг шаарддаг
- 3 дахь категори, ойролцоох газруудыг өмчлөгч, эзэмшигчид болон холбогдох албан тушаалтны мэдэгдсний дагуу улс даяар сонин хэвлэлээр тухайн төслийн талаарх нарийн мэдээллийг нийтлүүлсний үндсэн дээр, ашиг сонирхолд нь шууд нөлөөлж болох аливаа этгээдэд мэдэгдэхийг шаарддаг. (38 дахь хэсэг)

Категори 3-ын дагуу мэдээлэл авсан этгээд нь тухайн төслийг баталсан холбогдох албан тушаалтны шийдвэрийн талаар гомдол гаргах эрхтэй. Мэдээлэл авсан эрх бүхий этгээд нь төслийг үнэлэх албан тушаалтанд бичгээр болон амаар хүсэлт, өргөдөл өгч болно. Төслийн талаар мэдээлэл авсан этгээд нь мөн төслийн талаарх танилцуулга, төлөвлөгөө, нарийвчилсан детальтай танилцах эрхтэй. 3 дахь категорийн ангилалд хамаараагүй бол төслийн баримт бичигтэй олон нийт танилцах боломжгүй.

Иймэрхүү баримт бичигтэй олон нийт танилцах бусад хувилбарууд бий. Жишээлбэл, олон нийтийн гишүүн нь 1991 оны Мэдээллийн эрх чөлөөний тухай актын дагуу өргөдөл гаргаж болно. “Хөгжлийн акт” нь мөн төслийн өргөдлийн бүртгэлийн баримт бичигтэй олон нийт төлбөргүйгээр хянаж болох нөхцлийг хангах үүднээс орон нутгийн засаг захиргаа зэрэг үнэлэх эрх бүхий албан тушаалтны ажлын байранд байршуулах шаардлагыг тавьдаг.

Тиймээс иргэд ажлын цагаар тэдгээр баримт бичгүүдтэй нарийн танилцах эрхтэй болно. Энэхүү актад дурдсан шаардлагын дагуу иргэнд мэдээлээгүй, эсвэл албан тушаалтан нь төслийг буруу категорид хамруулсан гэж үзвэл тэд тэрхүү захиргааны шийдвэрийн талаар Дээд шүүхэд хянуулахаар өргөдөл гаргаж болно.

**Эрхээ хамгаалуулах нь - Нэхэмжлэх эрх (Standing):**

Австралид байгаль орчны шударга ёсыг тогтоох чухал хандлагуудын нэг нь байгаль орчны асуудлаар шүүхэд хэрэг үүсгүүлэх буюу “нэхэмжлэл гаргах” олон нийтийн эрх, чадвар юм. Энгийнээр хэлбэл, нэхэмжлэх эрх буюу standing нь хэн нь хууль зүйн ажиллагаа үүсгүүлэх буюу нэхэмжлэх давуу талтай вэ гэдгийг тогтоох зарчим гэж ойлгож болно. Нэхэмжлэх эрх нь зарим хууль тогтоомжид нэгтгэгдэн орсон нийтийн эрх зүйн зарчим юм.

Нэхэмжлэх эрхийн анхны ололт нь Австралид, өөрт учирсан онцгой хохирлоо нэхэмжилсэн нэхэмжлэгчийн талаар Английн шүүхийн *Boyce v Paddington Borough* Зөвлөл “Нэхэмжлэгчид өөрт учирсан хохирол нь олон нийтэд учирсан хохирлоос илүү буюу онцгой байх ёстой” (“The requirement that the plaintiff's damage be peculiar to himself means no more than that his or her particular grievance must be significantly greater than that of the rest of the public generally, not that the damage suffered must be unique”) гэдгийг хүлээн зөвшөөрсөнд оршино.

**БАРИМТ**

1. Австралийн байгаль орчны тэргүүлэгч төрийн бус байгууллагуудын нэг болох Австралийн Хамгаалалтын Сангаас Төв Queensland-ын Farnborough дахь Жуулчны газар байгуулах зөвшөөрлийг олгосон Холбооны Засгийн газрын шийдвэрийн эсрэг “нэхэмжлэх эрх”-ийг турших зорилгоор асуудал гарган тавьсан байна. Уг байгууллага нь тэрхүү асуудалдаа амжилт олоогүй боловч “нэхэмжлэх эрх”-ийн талаар тодорхой тайлбарыг гаргуулж чаджээ. Австралийн Хамгаалалтын Сангийн хэргийг шийдвэрлэсэн шүүгч Gibbs-ээс *Australian Conservation Foundation v Commonwealth* (1980) 28 ALR257 тоот шийдвэрийн 268 дахь параграфд:

- “...”түүнд учирсан тусгай хохирол” гэдэг нь миний бодлоор, тухайн үйл ажиллагааны асуудлаар тусгай сонирхолтой байх гэдэгтэй ижил утгаар ойлгох нь зүйтэй” гэсэн байна.

Тухайн асуудлаарх “тусгай сонирхол” нь хэдийд бий болж болохыг шүүхээс тайлбарлаагүй боловч байгаа байр суурийг тодруулсан. Тухайн тодорхой орчинтой холбогдох тусгай харилцаа байгаа тохиолдолд тэрхүү “тусгай сонирхол” нь гарч ирнэ.

Нийтийн эрх зүйн явцуу байдлыг эс тооцвол, нэхэмжлэх хууль зүйн эрх нь Австрали даяар зарим байгаль орчны хуулиудад тусгагдсан байдаг. Тухайлбал, Өмнөд Австралид өргөдлийг “хэрэгжүүлэхэд тохирохгүй” гэж үзэхгүй л бол, өргөдөл гаргагч нь түүний өргөдлийг батлахаас татгалзсан, эсвэл батлахын тулд тодорхой нөхцөл шаардаад байгаа шийдвэрийн эсрэг гомдол гаргах эрхтэй.

Хөгжлийн актын 85 дахь хэсэг нь ямар ч хүн тухайн актын зөрчил, эсвэл хүчингүй болгогдсон актыг хэрэгжүүлүүлэхээр шүүхэд хандаж болох эрхийг хангасан байдаг. 1993 оны Хөгжлийн акт болон 1982 оны Төлөвлөлтийн актын дагуу өргөн баригдаж буй өргөдлийн шийдвэрийн талаар мэдэгдэл, хүсэлт гаргасан ямар ч иргэн\_Байгалийн нөөц, хөгжлийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

**Зардал:**

Байгаль орчны хуулийн зөрчлийг арилгах, хуулийг сахиулах зорилготой нэхэмжлэл гаргах нээлттэй боломж нь одоогийн байдлаар нилээд олон улсын шүүхийн ажиллагаанд хэрэгждэг боловч олон нийт эрхээ хамгаалуулах боломж нь шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулагдах зардлын асуудлаас үүдсэн бэрхшээлтэй тулгарч байна. Байгаль орчны өмгөөлөлд зардлын асуудал нь Австралийн шүүхүүдэд анхаарал татсан асуудал юм. Ерөнхийдөө, шүүгч нь гарсан шийдвэрт ялагдсан талыг шүүхийн

зардлыг төлөхийг үүрэг болгодог. Байгаль орчны өмгөөллийн иймэрхүү хандлага нь хэрэг үүсгүүлэх гэж буй хүний, ялангуяа өөрийнхөө эрхийн төлөө ажиллаж буй хүний хувьд сөрөг үйлчлэлтэй юм.

Хөгжлийн акт 18 жилийн өмнө батлагдсанаас хойшх хугацаанд дөнгөж нэг юм уу, хоёр л нийтийн эрх ашгийн нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байдаг талаар судлаачид өгүүлжээ. Үүний шалтгаан нь, тухайн актын дагуу шүүхийн зардлыг ялагдсан талаар гаргуулах тухай зохицуулалт аж. Айдас гэж болохоор энэхүү заалт нь нийтийн эрх ашгийн өмгөөлөгчдийг иймэрхүү хэргийг үүсгүүлэхээс зайлсхийх шалтгаан болдог байна. Гэхдээ хөгжлийн асуудалд холбогдох өргөдлийн талаар гаргасан албан тушаалтны шийдвэрийг эсэргүүцэж Байгаль орчин, нөөц баялаг, хөгжлийн шүүхэд нэхэмжлэл гаргавал энэ нь шүүхийн зардлаас чөлөөлөгдөх бөгөөд талууд нь өөр өөрсдийн зардлаа л төлдөг байна.

Шүүхийн зардлын асуудал нь төрийн албан тушаалтан, эсвэл хууль зөрчсөн өргөдөл гаргагчийн эсрэг арга хэмжээ авахад гарах зардалд дагалдах буюу хоёрдогч зардал юм. Байгаль орчны асуудлаарх нэхэмжлэл нь голдуу, нэлээд техникийн шинжтэй бөгөөд инженер, архитектор, төлөвлөгөө гаргагчид, зэрэг нэлээн үнэтэй шинжээчдийг шаарддаг. Тэдгээр шинжээчдийн зардлын асуудал нь байгаль орчны өмгөөлөгчдийг тэднийг ажлаа эхлэхээс нь өмнө халшраадаг байна.

#### БАРИМТ

- Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоог хангахын тулд Канадын Онтарио мужид хөгжсөн “Хөндлөнгийн оролцооны санхүүжилтийн төсөл” хэмээн танигдсан загварыг Австрали улсыг дагаж мөрдөхийг зөвлөсөн. Энэхүү сангийн зорилго нь шалгууртаа нийцсэн байгаль орчны өмгөөлөгчдийг тус сангаас санхүүжилт хүсэхийг зөвшөөрөх явдал юм. Michael Jeffrey “Энэ нь байгаль орчны маш их үнэлэмж, хүндлэлийг, тодруулбал, мэдээлэл авах, олон нийтийн оролцоо, эрхээ хамгаалуулах боломжийн засаглалыг бэхжүүлнэ. Байгаль орчны илүү тэнцвэртэй шийдвэр гаргах явдал нь шууд үр дүнг авчирна” хэмээн үзэж буй юм. (Jeffrey 2005). Австралид хэрэгжүүлэх иймэрхүү төслүүд нь өөрчлөлтийг авчрах, байгаль орчны шударга ёсны бодит үр дүн болно.

Нөгөө талаар, Австрали даяар, улс бүрт хүрч ажилладаг Байгаль орчныг хамгаалагчдын газар (БОХГ)-т өгөх холбооны санхүүжилтийг нэмэгдүүлэх замаар санхүүжилтийн асуудлыг шийдэж болно. Австралид улс бүрт ажилладаг БОХГ нь байгаль орчны нийтийн эрх ашгийн эрх зүйгээр мэргэшсэн ашгийн төлөө бус, хууль зүйн төв юм. БОХГ нь санхүүжилтийн асуудал тохиолддог боловч зөвлөгөө өгөх, арга хэмжээ авахад тэднийг төлөөлөх зэргээр орон нутгийн хамгаалах бүлгүүдэд үйлчлэн ажилладаг. БОХГ нь үйл ажиллагаагаа таслахгүй үргэлжлүүлж байх үүднээс холбооноос хязгаарлагдмал санхүүжилт авч байгаа ч тухайн санхүүжилтийг өмгөөллийн үйл ажиллагаанд зарцуулахгүй гэсэн нөхцөл юм. БОХГ-ын хүсэлт, Австралийн Засгийн газрын бодлогын өөрчлөлтийн дүнд дээрх нөхцөл хориг харьцангуй дээшилсэн боловч тус байгууллагаас хэрэгжүүлдэг байгаль орчны нийтийн эрх ашгийн өмгөөллийг идэвхтэй явуулахад энэхүү санхүүжилт нь хангалттай биш ажээ.

**Дүгнэхэд,** Австрали дахь байгаль орчны шударга ёс хийгээд нутгийн хамтлагийн оролцоо нь олон талт цогц систем бөгөөд Австралид байгаль орчны асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо, байгаль орчны шударга ёсныг тогтооход ихээхэн чухал үүрэгтэй юм.

\*\*\*

**Ашигласан эх сурвалж:**

- “Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль” 2006 он
- Өмнөд Австрали муж улсын “Уул уурхайн тухай хууль”. 1971 он
- С.Болд-Эрдэс. “Ашигт малтмалын татварын зарим асуудалд”. [www.tsahimurtuu.mn](http://www.tsahimurtuu.mn)
- Д.Мөнхтуяа. “Австрали –Монголын уул уурхайн эрх зүйн зохицуулалтын талаарх зарим харьцуулалт”. 2009 он. [www.forum.mn](http://www.forum.mn)
- Д.Мягмарцэрэн, Ц.Болормаа. “Уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтын бодлого болон хууль эрх зүйн орчин”. Харьцуулсан судалгаа. 2010.
- Gerry Bates, Австралийн байгаль орчны хууль, 6 дахь хэвлэл (2006)
- “Хүний эрх хөгжил төв” ТТБ, Норвегийн “Fredskorpset” сангийн хамтран зохион байгуулсан “Байгаль орчин, Хүний эрх: Шударга ёс” Үндэсний бага хурлаас гаргасан зөвлөмж. 2009



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**БАЙГАЛИЙН ЦЭВЭР ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХАНГАМЖИЙГ  
ДЭМЖИХ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ, ГАДААДЫН ТУРШЛАГА  
(Тойм судалгаа)**

*Ө. Мөнхтунгалаа, С. Дорждагва, Г. Чулуун*

**Агуулга**

**Оршил**

<b>I</b>	<b>Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дэлхийн чиг хандлага, байгалийн цэвэр хүнсний стратеги ач холбогдол, зарим мөн чанар</b>
<b>II</b>	<b>Монгол Улсад импортоор орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний төрөл зүйл, тэдгээрийг дотоодод үйлдвэрлэж буй талаархи зарим статистик үзүүлэлт</b>
-	Хүнсний бараа бүтээгдэхүүний импорт ба дотоодын үйлдвэрлэл
<b>III</b>	<b>Хүнсний чанарын хяналтын тогтолцооны ерөнхий үндэс, эрх зүйн орчин</b>
<b>IV</b>	<b>Хүнсний чанарын баталгааг хангахтай холбогдсон хууль эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ</b>
a)	Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хуулиудын товч агуулга
b)	Экологийн цэвэр бүтээгдэхүүн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ
<b>V</b>	<b>“Экологийн цэвэр хүнс” –ийг дэмжиж буй НҮБ –ийн дэмжлэг, гадаад дотоо-дын зарим туршлага</b>
a)	АНУ –ын мал аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл
b)	БНХАУ –ын аюулгүй хүнсний зэрэглэл
c)	Чили улсын жимсний үйлдвэрлэлийн туршлага

**Дүгнэлт**

**Ашигласан материалын жагсаалт**

\* \* \*

**Оршил**

УИХ –ын Тамгын газрын Судалгааны төвд ирсэн захиалгын дагуу<sup>73</sup> Монголын бэлчээрийн мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнийг экологийн хувьд цэвэр байлгах чиглэлд гарсан болон гарвал зохих эрх зүйн зохицуулалтын талаар, мөн түүнчлэн, байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн, тухайлбал, мал аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүний чанарын асуудлыг хуульчилсан гадаад орны туршлагад холбогдох тойм мэдээллийг боловсруулав.

Хүнсний аюулгүй байдал нь хүнсний хангамж, хүнсний чанарын асуудалтай харилцан уялдаатай тул “байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл” –ийг тухайлан авч

<sup>73</sup> УИХ –ын гишүүн Я. Батсуурийн 2010.11.10 –ны өдрийн №9/7702 тоот албан бичиг;



үзэхдээ, түүнийг [энд] схемчилж үзүүлсэн 3 үндсэн ухагдахуунтай заавал холбож ярих хэрэгцээ шаардлага үүсдэг юм.

Бид мэдээллийн агуулгыг “захиалагчийн шаардлага” –д аль болохоор нийцүүлэх үүднээс, тухайн асуудлыг, “хүнсний аюулгүй [баталгаат] байдал” доторхи тодорхой нэг бүрдэл хэсэг болгон “харж”, сэдвийн хүрээг зориуд нарийсгасан болно. Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн ба экологийн цэвэр хүнс нь тодорхойломжийнхоо хувьд ч өөр хоорондоо ялгаатай. Тэдгээр нь:

1. Экологийн цэвэр хүнс буюу экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн гэдэг нь түүхий эд материалаас эхлээд үйлдвэрлэлийн бүх үе шатандаа, тэр ч байтугай түүний сав баглаа боодол нь [хүртэл] хүний бие махбодид болон байгаль орчинд ямар нэг хохирол учруулдаггүй [тийм] бүтээгдэхүүнийг хэлнэ; гэж олон улсын стандартад заажээ.
2. [Харин], экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдэг нь байгалийн жинхэнэ цэвэр түүхий эдийг бэлтгэх, тэдгээрийг завсрын ба эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэх, савлан гаргах бүхий л үйл явц, технологи нь хүний бие махбод, байгаль орчинд ямар нэг хор хөнөөлгүй байгаад зогсохгүй, биологи - экологийн талаар ашигтай байхыг хэлдэг. <http://72.29.76.63/montrade/>

“Экологийн цэвэр бүтээгдэхүүн” нэр томъёонд цэвэр байгалийн болон хөдөө аж ахуйн гаралтай, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аливаа үйлчлэлгүй, боловсруулалтын шатанд нь хэрэглэгддэг химийн болон бусад төрлийн бодис, нэмэлтүүд, тэдгээрийн хэмжээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй, байгаль орчинд халгүй технологиор үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн багтдаг байна.

Монгол Улсын Засгийн газраас “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг батлан (2009) хэрэгжүүлж байна. 8 жилийн хугацаатай хэрэгжих уг хөтөлбөр нь манай хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжих дөрвөн<sup>74</sup> гол хөтөлбөрийн нэг юм. Энэ хөтөлбөрийн хүрээнд монгол дахь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг зөрчиж байгаа асуудлыг [хэрхэн] шийдвэрлэх, байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамжийг дэмжин чиглүүлэх бодлого зохицуулалтын олон асуудал туссан байна.

Мал аж ахуйн болон газар тариалангийн хүнсний бүтээгдэхүүний чанарын удирдлагын тухайлсан асуудлыг, ийнхүү, нийгэм дэх хүнсний нөөц, хангамж, хүртээмжтэй шууд холбон авч үзэх зайлшгүй шаардлагатай болдгийг харгалзан бид монголын хүнсний салбарын боломж нөөцийг зарим үзүүлэлийг дурдахын зэрэгцээ, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дэлхийн чиг хандлага, байгалийн цэвэр хүнсний стратеги ач холбогдол, мөн чанарын талаар товчхон өгүүлж (I), Монгол Улсад импортоор оруулж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний төрөл зүйлийн болон тэдгээрийг дотоодод орлон үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдийн талаархи статистик үзүүлэлт (II) –ийг тойм байдлаар авч үзэв.

Манай орны хувьд далай тэнгисийн гаралтай хоол хүнсний хэрэглээ, тийм төрлийн бүтээгдэхүүний нийт хүнсний багтаамжид эзлэх хувийн жин бага юм. Мах гурил ... цаашлаад бүх хүнс газар эхийн өгөөж шим байдаг. Тэгэхээр, газар тариалангийн болон мал аж ахуйн салбарын хүнсний бүтээгдэхүүний чанарын удирдлагын асуудал нь, тухайн

<sup>74</sup> “Хүнсний баталгаат байдал”, “Монгол мал”, “Атрын III аян”, “Монголд үйлдвэрлэл хөгжүүлэх хөтөлбөр” –үүдийг хэлж байна; “Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн” Үндэсний хөтөлбөр ... эд бүгд харилцан уялдаатай бодлогын баримт бичгүүд юм;



тохиолдолдоо, хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг хангах асуудалд нэгтгэгдэн зангидагдаж байгааг тэмдэглэх зөв болов уу.

Хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг хангах талаар шууд болон дамаар гарсан эрх зүйн зохицуулалтын эх үндэс, тухайлсан заалтуудыг, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд тодруулан авч үзэж холбогдох тойм мэдээлэл (III) –ийг гарган, хүнсний чанарын баталгааг хангах чиглэлийн эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийв. (IV) Мөн, экологийн цэвэр хүнсний үйлдвэрлэл хүртээмжийг дээшлүүлэх талаар НҮБ –аас тавьж байгаа анхаарал дэмжлэг, зарим гадаад орон (АНУ, БНХАУ, Чили Улс) –ы эрх зүйн зохицуулалтын онцлог (V) –ийг тодруулах чиглэлээр ажиллав.

Энэхүү тоймыг бэлтгэхдээ, Гаалийн Ерөнхий газраас тус Төвд ирүүлсэн «Монголд импортоор орж байгаа “хамгийн их хэмжээтэй”, “хамгийн их үнийн дүнтэй” 100 нэрийн бүтээгдэхүүний жагсаалт» -д багтсан хүнс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний талаархи дүн ... холбогдох бусад мэдээллийг эх сурвалж болгож ашиглав.

#### **I. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дэлхийн чиг хандлага, байгалийн цэвэр хүнсний стратеги ач холбогдол, зарим мөн чанар**

Дэлхийн улс орнуудад хөдөө аж ахуйн эрчимжсэн үйлдвэрлэлд химийн найрлага бүхий төрөл бүрийн бордоо, антибиотик, пестицид гэх зэрэг химийн бодисуудыг их хэмжээгээр хэрэглэж бүтээгдэхүүний массыг нэмэгдүүлж, хадгалах хугацааг уртасгадаг хэдий ч хөрсний үржил шимийг муутгаж, байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгааг тогтоосон байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд уламжлалт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сул тал, экологийн цэвэр органик хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн давуу талыг сурталчилах болсоноор эрүүл, тэжээллэг чанартай хүнсний бүтээгдэхүүн хэрэглэх сонирхолтой хэрэглэгчдийн тоог өсгөж, үүнийг дагаад зах зээл дэх бүтээгдэхүүний нэр төрөл нь олширч экологийн цэвэр органик хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хүнсний зах зээл дэх эзлэх хувь нэмэгджээ.

Дэлхийн экологийн цэвэр органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн бодлого нь хүн ба байгаль орчны уялдаа холбоог сайжруулах философи - экологийн үзэл баримтлалын хүрээнд эрүүл хөрс, эрүүл экосистем болон хүний эрүүл мэндийг дэмжихэд зориулагдсан үйлдвэрлэлийн тогтолцоо бөгөөд хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх аливаа үйлчлэлгүй, боловсруулалтын шатанд нь хэрэглэгддэг химийн болон бусад төрлийн бодис, нэмэлтүүд, тэдгээрийн хэмжээ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй, байгалийн гаралтай органик нэгдлүүдээр боловсруулсан хөрс шороон дээр тарьж, үржүүлсэн амьтны болон газар тариалангийн гаралтай түүхий эдүүдийг ямар ч химийн найрлага хольц, технологийн боловсруулалт хийлгүйгээр үйлдвэрлэсэн байх нийтлэг шалгуур тавьдаг байна.

Дэлхийд хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн арга технологиос хамааруулж,

1. экологийн цэвэр бүтээгдэхүүн;
2. органик бүтээгдэхүүн;
3. органик бус бүтээгдэхүүн;
4. генийн өөрчлөлттэй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн; гэж ангилан зах зээлд нийлүүлэгддэг.

Дэлхийн зах зээлд нийтлэг шаардлага хангасан бүтээгдэхүүнд экологийн цэвэр бүтээгдэхүүн, органик бүтээгдэхүүн гэж баталгаажуулдаг байна. АНУ-ын Хүнс, ХАА-н байгууллага (FAO) -аас хийсэн судалгаагаар дэлхийн зах зээлийн нийт бараа эргэлтийн

дөнгөж хоёрхон хувийг органик бүтээгдэхүүн эзэлдэг ажээ. Уг бүтээгдэхүүний гол хэрэглэгч нь Хойд Америк болон Баруун Европын орнууд зонхилж байна.

Органик бүтээгдэхүүний зах зээлийг тодорхойлогч үндсэн үзүүлэлтүүдэд борлуулалтын хэмжээ, хүн амд ногдох хэрэглээ, үйлдвэрлэлийн эргэлтэнд эзлэх хувь хэмжээ, органик газар тариалангийн статус ордог. Органик бүтээгдэхүүн үйлдвэрлэгч фермерүүд ихэвчлэн борлуулалтын өөрийн цэгтэй. Түүнээс гадна бүтээгдэхүүний борлуулалтыг төрөлжсөн дэлгүүр, худалдааны төв болон нийтийн хоолны газруудад нийлүүлдэг аж. Харин жирийн дэлгүүрүүдэд органик бүтээгдэхүүнээ борлуулах нь тэдэнд нэмэгдэл орлого болж байдаг.

Органик бүтээгдэхүүн бусад салбарын бараанаас үнийн хувьд өндөр байдаг учир худалдааны субъектэд орлого олох боломжийг нээгдээрээ онцлог. Тиймээс органик бүтээгдэхүүн сав баглаа боодол, тээвэрлэлт, хадгалалтаараа бусдаас ялгагдах тэмдэгтэй байна.

Дэлхий нийтээр Green Economy Initiative гэсэн хөгжлийн модель гаргаж ирж энэ чиглэл рүү ханддлагатай байгаа өнөө үед Монгол Улс экологийн тэнцвэр, экологийн цэвэр байдал, экологийн цэвэр хүнсний талаар түлхүү ярих ёстой юм. Энэ чиглэлд идэвхтэй ажиллах, бүтээлч санаачилгатай үйл ажиллагаа өрнүүлэх нь дотоодын зах зээлээ тэр дундаа улсынхаа хүнсний салбарыг гадны импортын хараат байдлаас гаргах, иргэдийнхээ эрүүл мэндэд оруулсан том хөрөнгө оруулалт болоод зогсохгүй ... цаашлаад XXI зууны монгол айл өрхийн амжиргаа, хүнс тэжээлийн гол эх үүсвэр нь экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэл болох үндэс суурийг бүрдүүлэх стратегийн ач холбогдолтой юм.

“Байгалийн цэвэр хүнс – Эрүүл амьдралын үндэс” уриан дор дотоодын зах зээл дээрх хүнсний бараа бүтээгдэхүүний тоо, чанар, стандарт, эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнүүдээр хангах, туслах аж ахуй болон тэдгээртэй холбоотой бичил болон жижиг бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авагдаж, анхны алхамууд хийгдэж байгаа боловч үр дүн нь сайн биш явж иржээ. Үр дүнг тодотгох үүднээс зарим тоо баримт дурдъя.

Улсын мэргэжлийн хяналтын газраас хүнсний чанар, аюулгүй байдлын талаар судалгаа, лавлагааны статистик мэдээллийн сан бүрдүүлний зэрэгцээ хүнсний стратегийн буюу гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд улсын болон салбарын хэмжээнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авч нэгдсэн дүгнэлт гаргасан байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас сүүлийн 5 жилд давхардсан тоогоор хүнс, хөдөө аж ахуйн, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын 209813 аж ахуйн нэгж, цэг, салбарт шалгалт хийж 449227 зөрчил илрүүлж, гарсан зөрчлийн 80 шахам хувийг арилгуулж ажилласны зэрэгцээ хууль тогтоомж, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг зөрчсөн 7689 объектийн үйл ажиллагааг түр буюу бүр мөсөн зогсоон, хүнсний чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бараа, бүтээгдэхүүнийг хураан авч устгаснаар хүн амын эрүүл мэнд, удмын санд учирч болох хор аюулаас урьдчилан сэргийлжээ.

Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл хангамж нь хүн амын худалдан авах чадвар эрэлт хэрэгцээний огтлолцол дээр оршдог, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, эдийн засаг, байгаль орчны ... зэрэг олон салбар дундын нэгдмэл зохицуулалт шаардсан, өргөн хүрээтэй цогц ойлголтоор томъёологддог ярвигтай хүнд асуудал юм. Энд төр, засаг, олон нийтийн байгууллага, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн хамтын хүчин чармайлт, удирдлагын нэгдсэн менежмент зайлшгүй хэрэгтэй. Гэтэл дороос гарсан санал санаачилгад шийдвэр гаргах түвшиндээ хайхрамжгүй хандсан олон жишээ бэлээхэн байдаг тухай салбарын мэргэжилтнүүд

олонтаа шүүмжилж тэмдэглэсэн байна.

Эко системээ аврах, бичил бизнесийн сэтгэлгээг хөгжүүлэх нь органик хөдөө аж ахуйн хөгжлийн үндэс суурь юм. Жишээ нь, ногоочид бүтээгдэхүүнийхээ гарцыг нэмэгдүүлэх гэж гадаадын (хятад) бордоо ихээр хэрэглэж байхад, зарим нь ядаж өөрсдөө идэхийгээ органик аргаар тарьж боловсруулж байна. Байгалийн цэвэр хүнсийг өргөн хүрэн сурталчилж, нэгэнт бий болсон нийгэмд төлөвшиж ядаж байгаа “органик монгол” сэтгэлгээг улам сайн нэвчүүлэх хэрэгтэй байна.

Монгол хүн далай тэнгисийн, ургамал амьтны гаралтай хүнсний зүйлийг бараг хэрэглэдэггүй. Энэ нь биед хоол хүнс шимэгдэх, энерги болж хувирахад чухал нөлөөтэй фосфор, хүчтэй шүлт үүсгэж хүчил шүлтийн тэнцвэрийг хэвийн түвшинд баригч далайн шүр (бичил биетнүүдийн наалдац), артерийн даралтыг хэвийн байлгаж зүрх судасны олон өвчнөөс сэргийлж эмчилдэг яргай загас, хүнд металлыг бие махбодиос зайлуулагч альгены хүчил агуулагч хүрэн замаг ... гэх мэт нэн чухал шимт бодис агуулсан далайн ургамал амьтныг хоол хүнсэндээ хэрэглэж эрүүл мэндээ дэмжих явцыг “бололцоогүй” болгон хязгаарладаг.

Дээр нь шинэ ургацын интоор, жүрж, нимбэг, ананас, усан үзэм гэм мэт С, Р, В<sub>1</sub>, В<sub>2</sub> болон каротин нимбэгний хүчлийг үлэмж хэмжээтэй агуулдаг цитрусийн жимс, ил хөрсний ногоон навчин ногоо ... зэрэг шимт бодисоор нэн баялаг ургамал, түүгээр хийсэн бүтээгдэхүүн ч мөн адил. Ийм нөхцөлд **нэмэлт хүнс, баяжуулсан болон чиглэсэн үйлчлэлтэй хоол тэжээлийн асуудалд ач холбогдол өгөхгүй**, дан ганц байгалийн цэвэр монгол хүнсний талаар [хэт] анхаарах нь өрөөсгөл байж болох талтай.

Ерөнхий ухамсарын төвшиндөө монголчуудын хүнсний боловсрол ядмаг байна. Жишээ нь, С аминдэм вирусийн үржлийг зогсоогч интерферон, антител, лизоциний ялгарлыг нэмэгдүүлж, эс орчмын бүтцийг сайжруулж, судасны ханыг бэхжүүлж, цусан дахь липидийн хэмжээг тэнцвэржүүлдэг ... зэрэг гайхамшигт үйлчлэл, нөлөөтэй амин чухал нэмэлт хүнс юм. Гэтэл түүнийг бид эм гэж үзэх нь нэн элбэг. Аливаа өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл явцыг бие организмын антиоксидант (эд эсийн өөрийгөө хамгаалах чадвар) тогтолцоог бэхжүүлэхэд чиглүүлэх учиртайг онцлон тэмдэглэмээр байна.

Хүнсний аюулгүй байдал бол эрүүл мэндийн асуудал, эрүүл мэндийн асуудал нь эргээд өөрөө дан ганц үндэсний уламжлалт ба байгалийн гаралтай цэвэр хүнсээр [дагнан] зохицуулагддаг зүйл биш гэдгийг ч мартаж болохгүй.

## II. Монгол Улсад импортоор орж ирж байгаа хүнсний бүтээгдэхүүний төрөл зүйл, тэдгээрийг дотоодод үйлдвэрлэж буй талаархи зарим статистик үзүүлэлт

### а) Хүнсний бараа бүтээгдэхүүний импорт ба дотоодын үйлдвэрлэл

Гаалийн Ерөнхий газрын мэдээллээр 2007-2009 онд мөнгөн дүнгээр хамгийн ихээр импортолсон бараануудыг<sup>75</sup> нэгтгэж үзэхэд, давхардсан тоогоор 180 нэр төрлийн бараа дурдагдсан байдгийн 43 нь хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн байв. Бидний энд онцолж авч үзсэн хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний талаархи мэдээллийг цааш лавшруулж авч үзлээ.

Монгол Улс өөрийн хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгыг гол хэрэгжүүлэх арга механизм нь дотоодын үйлдвэрлэлээр хүнсний хэрэгцээгээ хангах явдал юм. Дотоодод үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний үйлдвэрийн талаархи судалгаа, мэдээллийг гаргахдаа Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргаж ирүүлсэн “Хүнсний

<sup>75</sup> Хэмжих нэгж нь өөр тул хэмжээгээр харьцуулах боломжгүй байв.

үйлдвэрүүдийн судалгаа” –нд тулгуурлав.

Монгол Улсын импортын барааны бүтцийг мөнгөн дүнгээр нь харьцуулж үзвэл дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

№	Ангилал	Импортод эзлэх хувь
1.	Эрдэс бүтээгдэхүүн	26,6%
2.	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	19,8%
3.	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги	12,6%
4.	<b>Хүнсний бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>8,5%</b>
5.	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	7,7%
6.	Химийн болон химийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн	6,0%
7.	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	<b>4,6%</b>
8.	Бусад	14,1%

Нийт импортын барааг 126 орноос худалдан авчээ. Үүнээс, хүнсний гол нэрийн импортын бараанд ургамлын тос, гурил, гурилан бүтээгдэхүүн, лаазалсан төрөл бүрийн мах, хүнсний ногоо, шар айраг, жимс жимсгэнэ орж байна. Гэтэл эдгээрийн ургамлын тосноос бусдыг нь ямар нэгэн хэмжээгээр монголд үйлдвэрлэж, боловсруулж байгаа юм. Жимсний хувьд дотоодод бэлтгэх нь харьцангуй бага байгаа. Харин, гурил болон гурилан бүтээгдэхүүнийг Атрын III аяны үр дүнд дотоодод бүрэн үйлдвэрлэх боломжтой гэж дүгнэж байгаа нь статистик үзүүлэлттэйгээ авцалдахгүй байгааг байгааг анхаарах шаардлагатай болов уу.

ХХААХҮЯ -наас 2009 онд хийсэн судалгаагаанд дурдсанаар, манай улсад нийтдээ 1090<sup>76</sup> үйлдвэр, аж ахуйн газар үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрийг ангилж үзвэл, Монгол Улс нийт 64 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэдэгээс, мах, сүү, өрөм, өлөн гэдэс, өтгөн цөцгий, гүзээтэй тос ... гэх мэт малын гаралтай 10 төрлийн хүнсний уламжлалт аргаар боловсруулж бэлтгэдэг байна

Хүнсний технологийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар, хүнсний бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэхэд хамгийн гол анхаарах зүйл нь өнөөдөр ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн ажил буюу эрүүл ахуйн хангамж тун хангалтгүй байгаа явдал юм. Энэ ажил нь өөрөө нарийн технологи шаардаж байдаг тул үйлдвэрлэлдээ сайн анхаарахгүй бол зарим алдаа гарахад л хэрэглэгч гадаадын бүтээгдэхүүнийг худалдаж авах магадлал огцом өсдөг; гэж үздэг байна.

Үүний зэрэгцээ дотоодод бэлтгэж байгаа бүтээгдэхүүн нь олон улсын болоод дотоодын шаардлага, стандартаа төдийлөн хангаж чадахгүй байна. Тухайлбал, гурилын түүхий эд болох улаанбуудайг тариалах хураах явцдаа ч технологи (техник хангамжийн талаасаа боломжоор хангагдсан ч гэсэн) -оо нарийн баримтлаагүйгээс чанарын доголдолтой,

<sup>76</sup> Хүнсний үйлдвэрүүдийн судалгаа, 2009, УБ, ХХААХҮЯ;

стандарт сайн хангаагүй улаанбуудай нийлүүлдэг тухай гурил үйлдвэрлэгчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр олонтаа тэмдэглэн хэлж байжээ. Энэ бол нэг жишээ. Нарийн технологи хэрэглэх, хэвшүүлэхийн тухайд мэргэжилтэй боловсон хүчнээс шалтгаалсан дутагдал багагүй гарсаар байгаа нь хүнсний аль ч салбарт түгээмэл үзэгдэл юм.

Монгол улсын хэмжээнд бүртгэлтэй аж ахуйн нэгж 36000 орчим байна. Эдгээрийн 60 гаруй хувь нь жижиг дунд үйлдвэр гэсэн ангилалд хамаардаг ба нийт аж ахуйн нэгжийн 30 хувь буюу 13 мянга орчим нь тогтмол татвар төлдөг буюу үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна гэсэн дүн байна. Аж ахуйн нэгжүүдийг тэдгээрт ажиллагсдын тоогоор нь ангилан үзвэл 1 - 9 ажиллагсадтай нэгжүүд 80 орчим хувийг эзэлж байна. Тэгэхээр, бичил бизнесийн дийлэнх хувийг чухамхүү тэд хийж байна үг юм. Энэ 13 мянга орчим жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 83% нь худалдаа үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. Ингээд цаана нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 3000 гаруй үйлдвэрлэгчид үлдэж байгаагийн 1090 нь хүнсний үйлдвэрлэгчид [болж] байна.

Манай улс байгаль цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, бэлчээрийн мал аж ахуйг зонхилон эрхэлдэгээс шалтгаалан хөдөө аж ахуйгаас сүү бэлтгэх саалийн хугацаа бага (4 сар орчим) байдаг. Энэ нь дулааны улиралд сүүний нөөцийн илүүдэл үүсч, хүйтний улиралд сүүний хангамжид хомсдолыг бий болгодог. Дулааны улиралд бий болсон сүүний нөөцийн илүүдэлийг нөөшлөн хуурай сүү үйлдвэрлэх боловсруулах үйлдвэрлэл хөгжөөгүйгээс нийт хөдөө аж ахуйд бэлтгэж байгаа сүүний  $\frac{1}{3}$  -ийг цуглуулж чадахгүй “алдаж” байдаг тооцоо бий. Үүнээс шалтгаалан хүйтний улиралд дутагдалтай байгаа сүүний хэрэгцээг импортын сүүгээр хангаж байна. Монгол Улс жилдээ 18 сая орчим литр сүүг импортлон хэрэглэдэг тоон үзүүлэлт байна.

Импортын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн талаар товчхон өгүүлье.<sup>77</sup> Манай улсын нийт импортын 10.7 хувийг хүнсний бэлэн бүтээгдэхүүн эзэлж байна. Импортын гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг илгээгч улсаар нь авч үзвэл, гурилыг ОХУ -аас, төмс цагаан будааг БНХАУ -аас, элсэн чихрийг Тайланд болон Малайз улсаас оруулж ирж байна. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээс цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тосыг 100 хувь импортоор оруулж байгаа бөгөөд цагаан будааны 100 хувийг, элсэн чихрийн 70 хувийг БНХАУ -аас, ургамлын тосны 68.4 хувийг, импортын гурилын 97 хувийг ОХУ -аас тус тус оруулж ирдэг.

Байгалийн гаралтай экологийн цэвэр хүнс, түүний дотор “монголын онцлогтой” мах, махан бүтээгдэхүүний экспортын талаар энд [дашрамд] дурдмаар байна. Монголын мал сүргийн тоо 31 сая толгой болж, улсын мах, махан бүтээгдэхүүний салбар нь дэлхийн зах зээлд үхэр адууны ястай, ясгүй мах, хонины мах, төрөл бүрийн лаазалж ариутгасан махан бүтээгдэхүүн, адуу, үхэр, бог малын боловсруулсан өлөн гэдэс, амьтны хоол тэжээл, дотор мах дайвар бүтээгдэхүүн ... зэргийг экспортлож байна.

Түүнчлэн мах, махан бүтээгдэхүүний нөөц их байгаа боловч сүргийн бүтцэд экспортын илүү хэрэгцээтэй үхэр, адууны тоо бага байна. Нөгөө талаас хонь, ямааны махны дотоодын нөөц их байгаа ч тэдгээрийг худалдаалах гадаад зах зээл “урсгал бөгөөд хараат” зохицуулалтай<sup>78</sup>, гарц нь бусад орны малын махнаас харьцангуй бага, махны чиглэлээр төрөлжсөн малын үүлдэр угсаа бий болоогүй байгаа нь сул тал болж байна.

Улсын мах, махан бүтээгдэхүүний салбарын хувьд махыг түүхий байдлаар экспортлохоос

<sup>77</sup> 2009 оны эхний 4 сарын байдлаар;

<sup>78</sup> Холбогдох яам, газрын зарим илтгэл тайланд “гадаад зах зээлгүй”, “борлуулах зах зээл олж чадаагүй” ... гэх мэтээр дурдсан нь бий.

илүү боловсруулсан эцсийн бүтээгдэхүүн хийж гаргавал стратегийн хувьд илүү ач холбогдолтой байх юм. Гэвч манай экспортын мах, махан бүтээгдэхүүний дүнд махан консерв, хиам зэрэг боловсруулсан эцсийн бүтээгдэхүүний эзлэх хувь маш бага, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн хувьд хөрөнгө санхүүгийн чадамж муу байгаагаас техник, тоног төхөөрөмж нь дэлхийн стандартад хүрэхгүй байна. Мөн мах, махан бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргахад тээврийн асуудал ихээхэн хүндрэл үүсгэдэг. ОХУ болон БНХАУ-аас бусад орон руу мах экспортлоход тулгардаг хамгийн гол бэрхшээл нь тээврийн асуудал юм байна. Энэхүү бэрхшээл нь махны чанарыг алдагдуулахгүй тээвэрлэх хөргүүртэй тээврийн хэрэгсэл, чингэлэгийн хангамж муу байгаагаас үүддэг.

### III. Хүнсний чанарын хяналтын тогтолцооны ерөнхий үндэс, эрх зүйн орчин

Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээлийн асуудал нь нийгмийн тогтвортой байдал, улс төр, эдийн засаг, тусгаар тогтнолын нэг чухал баталгаа болдог учир төрийн бодлогын үндсэн чиглэлд хамаардаг. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг тариалангийн талбай, малын бэлчээр, дэлгүүрийнлангуунаас эцсийн хэрэглэгч хүртэлх бүхий л шатанд “эрсдэлийг урьдчилан тооцох арга”-д тулгуурлан явуулдаг шинэ системд шилжих, шилжүүлэх явдал бол төр засгийн хойшлуулалтгүй хэрэгжүүлэх бодлого зорилт юм.

Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 157 дугаар тогтоолд “... улсын тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдол бүхий экспортын болон дотоодын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, улмаар **дэлхийн хөгжлийн нийтлэг хандлагатай уялдуулан экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх замаар** улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нь төрөөс баримтлах бодлогын эрхэм зорилго мөн” гэж заасан байна.

Байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, мал аж ахуйн болон газар тариалангийн аливаа бүтээгдэхүүнийг экологийн талаас нь цэвэр байлгах зорилго зорилт нь мэргэжлийн хяналт, нийгмийн эрүүл мэнд, стандартчилал, статистик мэдээлэл, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах, хэрэглэгчдийг хамгаалах, татвар бүртгэл, гаалийн болон боловсролын асуудал хариуцсан байгууллага, төр ба хувийн хэвшлийн түншлэл, төрийн бус байгууллагын оролцоо, иргэдийн хэрэглээний соёл ... зэрэг олон талт хамтын хүчин чармайлт, үйл ажиллагааны үр дүнд шийдвэрлэгдэх ёстой өргөн хүрээтэй цогц асуудал мөн.

Монгол Улсад, хүнсний бүтээгдэхүүний баталгааг тодорхойлох нэгдсэн аргачлалгүйгээс хүнсний баланс гаргах, хоол тэжээлийн дутагдалд орсон ядуу иргэд, айл өрхөд бодит дэмжлэг үзүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлогоо нэгмөр тодорхойлж хэрэгжүүлэхэд [зарим талаар] түвэгтэй байдал үүсгэдэг. Түүнчлэн хилээр орж ирж буй хүнсний бүтээгдэхүүний бүртгэл, дотоодын статистик мэдээ тэр бүрий бодит байдалд яв цав нийцдэггүйгээс Монгол Улсын хүнсний балансыг зөв тооцон гаргаж байгаа гэдэгт ч эргэлзэж болохоор байдал ажиглагддаг.

Монгол Улсын Засгийн газар Ромын 1992 оны “Дэлхийн хоол тэжээлийн тунхаглал”-ыг хүлээн зөвшөөрч “Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, монгол хүний хоол тэжээл” Үндэсний хөтөлбөрийг 1994 онд батлан хэрэгжүүлсэн. Гэвч зах зээлийн харилцаанд шилжих эхэн үеийн эдийн засгийн хямрал, хүн амын ядуурал, дахин давтан тохиолдож буй ган, зуд зэрэг байгалийн гамшиг болон хөтөлбөрийг боловсруулах явцад нөхцөл байдлыг дутуу үнэлсэн зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан үндэсний хөтөлбөрийн зарим зорилтууд бүрэн хэрэгжиж чадаагүй юм. Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн талаар дэлхийн хэмжээнд тавьж буй зорилтын агуулга, үзэл санаа манай энэ Үндэсний хөтөлбөрт тусгалаа олсон нь хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангах, эрүүл мэндийг сайжруулах асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд ихээхэн дэм



хөшүүрэг болж байгааг үгүйсгэж болохгүй юм.

Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх байгалийн нөөцийн судалгаа чухал үүрэгтэй. Бэлчээрийн мал аж ахуйгаас гарч байгаа хүнсний болон бусад түүхий эдүүд экологийн цэвэр бүтээгдэхүүнд бүртгэгддэг. Ялангуяа, манай [монгол] мах, сарлагийн сүүн бүтээгдэхүүнийг экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдэг талаас нь дотоод гадаадын эрдэмтэд судалж, энэ төрөл чиглэлийн бүтээгдэхүүнийг европын болон азийн зарим орнуудад гаргах боломжтой гэж үздэг. Монголын хээр хөдөө химийн болон биологийн хорт бодисуудын бохирдолд өртөөгүй, бага өртсөн ... давуулаг нөхцөлтэй. Иймээс манай улсын хувьд био болон экологийн цэвэр түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох боломж байгаа юм.

Монгол малыг жилийн дөрвөн улиралд нүүдэлчдийн зан заншлаар бэлчээрлүүлэн тарга, хүч авахуулдаг нь орчин үеийн фермерийн аргаар бордож тэжээсэн махнаас хавьгүй илүү “цэвэр экологи чанар” -тай болохоор Европын холбооны улсуудаас манайд, монгол малын мах нийлүүлэх санал тавьдаг ч “стандартын шаардлага” хангасан мах экспортлох боломж бий болгож яадахгүй явж ирлээ.

Эндээс юу харагдаж байна вэ гэвэл, бид өөрсдийн нөөц бололцоо, давуулаг байдлаа нэн тэргүүнд ашиглаж, **экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоог нэгдсэн бодлогоор зохицуулах**, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эхний ээлжинд стратегийн чухал ач холбогдол бүхий голлох нэрийн хүнсний бүтээгдэхүүнийхээ хангамж, чанар, аюулгүй байдлыг зохих шаардлагад нийцүүлж, байгалийн цэвэр бүтээгдэхүүнээр [ядаж] дотоодынхоо хэрэгцээг хангах зорилтыг хэрэгжүүлмээр байгаа юм.

#### IV. Хүнсний чанарын баталгааг хангахтай холбогдсон хууль эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ

Монгол улсын Хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, зохицуулахад чиглэсэн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Хүнсний тухай” /1999/, “Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай”, “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” /2003/, “Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай” /2002/, “Хувирга-сан амьд организмын тухай” /2007/, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” /2003/ ... зэрэг хуулиудаар зохицуулагдаж байна. Тэдгээр хуулийн чиг зорилт болон зохицуулж байгаа гол асуудлыг авч үзье. (Хүснэгт 1.)

а) Хүнсний аюулгүй байдалтай холбоотой хуулиудын товч агуулга

Хүснэгт 1.

Хуулийн нэр	Хуулийн зорилт	Хүнсний чанарын баталгаат байдлыг хангах асуудал
Хүнсний тухай хууль	Хүн амын хүнсний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах;	Тус хуулийн “Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, түүний тогтолцоо” гэсэн 4-р бүлэгт хяналтын албад, улсын байцаагч нар хүнсний бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх замаар чанарын баталгааг хангах тогтолцоог бүрдүүлэхээр заагджээ.

<i>Амьтан ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль</i>	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулах;	Энэхүү хуулинд амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн үүний дотор хүнсний бүтээгдэхүүнийг хил гаалиар нэвтрүүлэх үеийн чанарын баталгаат байдлыг хангах, хянах зүйл заалтууд орсон ба манай улсын хилийн болон гүний мэргэжлийн хяналтын байгууллагууд, түүний байцаагч нарын гол мөрдлөг болгодог хууль эрхзүйн баримт юм.
<i>Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль</i>	Стандартчилал, чанарын баталгаажуулалт, стандарт, чанарын хяналтын эрх зүйн үндсийг тодорхойлж тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах	Энэ хуулийн заалтуудад стандартыг боловсруулах, мөрдүүлэх, баталгаажуулах, хянах ажлыг бүхэлд нь стандарт хариуцсан төрийн төв байгууллага дангаар хариуцан гүйцэтгэх чиг үүрэгтэй байхаар заагдсан байна.
<i>Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль</i>	Стандартчилал, тохирлын үнэлгээний эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулах	Тус хуулиар импортын бүтээгдэхүүний стандарт тохирлын үнэлгээг боловсруулах, мөрдүүлэх ажлыг стандарт хариуцсан төрийн төв байгууллага хэрэгжүүлэх ба хяналтыг улсын мэргэжлийн хяналт газар гүйцэтгэхээр заагджээ.
<i>Хувиргасан амьд организмын тухай хууль</i>	Хувиргасан амьд организмыг (шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүн) гарган авах, ашиглах, улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэрт биоаюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах	Байгаль орчны асуудал хариуцсан сайдын байгуулсан Биоаюулгүйн үндэсний зөвлөл хувиргасан амьд организм буюу шилжмэл гентэй хүнсний импортын зөвшөөрлийг зохих эрсдлийн үнэлгээний үндсэн дээр олгож байхаар хийгдсэн.
<i>Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль</i>	Бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах	Энэхүү хуулийн бүлэг заалт бүр хүнсний баталгаат байдлыг хангахад хэрэглэгч, үйлдвэрлэгч, борлуулагч, хэрэглэгчийн эрх ашиг хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагын эрх үүргийг тодорхой зааж өгсөн.

Эдгээр хууль эрх зүйн актууд нь хүнсний аюулгүй байдлыг хангах эрхзүйн үндсэн баримт болох боловч хоорондоо уялдаа сул, хүнсний аюулгүй байдлын зарим чухал асуудал, заалтууд тодорхойгүй орхигдсон байна. Тухайлбал:

“Хүнсний тухай хууль”-д, Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтууд, ялангуяа генийн инженерчлэл, биотехнологийн дэвшлийг ашиглан шинээр гаргаж авч байгаа шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүн, хүнсний нэмэлтүүд, биологийн идэвхит нэмэлт хүнс, экологийн цэвэр бүтээгдэхүүн зэрэг зарчмын ойлголт, GMP, HACCP зэрэг орчин үеийн чанарын тогтолцоонуудын талаар заалт огт



тусгагдаагүй байна.

“Хүнсний аюулгүй байдлыг хангахад хяналт тавьж оролцох төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой ХХААЯ, ЭМЯ-ны үүрэг тодорхойгүй, дутуу, дулимаг болсон байна. Эрүүл ахуй, чанарын аюулгүй байдлыг хангах асуудлыг аль ч байгууллагад хариуцуулалгүй эзэнгүйдүүлж, үйлдвэр худалдаа, мэргэжлийн хяналтын байгууллага, СХҮТ-ийг чиг үүрэг, оролцоог тодорхойлоогүй, бүтээгдэхүүнд тавих чанарын шаардлага, шошгожуулалтын талаар дурьдагдаагүй байна.

“Амьтан, ургамлын хорио цээрийн хяналт шалгалтын тухайн хууль”-иар импортоор оруулж буй хүнсний бүтээгдэхүүнийг хянах шалгах асуудлыг зохицуулдаг бөгөөд манай улсын хилийн мэргэжлийн хяналтын албад баримтлан ажилладаг гол хууль эрх зүйн акт юм. Гэтэл энэ хуулинд хувь хүн, иргэд хүнсний бүтээгдэхүүн оруулж ирэхэд дээд тоо хэмжээний хязгаарыг тодорхой заагаагүй учраас хүнсний ганзагын наймааг хязгаарлах хууль эрхзүйн үндэсгүй болж байна. Өөрөөр хэлбэл, манай хуулиудад тухайн төрлийн харилцааг бүхэлд нь зохицуулах олон талын оролцоог анхаардаггүй, зөвхөн холбогдох төрийн төв байгууллагуудын чиг үүрэг, хэрэгжүүлэх төрийн салбар бүтцийг зааж өгөхөөр хязгаарладаг нь учир дутагдалтай байна.

Гэтэл 2007 онд батлагдсан “Хувиргасан амьд организмын тухай” хуулиар дэлхий дахинаа улам бүр өсөн нэмэгдэж буй шилжмэл гентэй хүнсний бүтээгдэхүүнийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зохих биоаюулгүй байдлын үнэлгээ гарсаны үндсэн дээр зөвшөөрөл олон улсын хилээр нэвтрүүлэхээр заагджээ. Энэ нь урьдчилсан хяналтын тогтолцооны нэг элемент мөн бөгөөд учир нь хүнсний бүтээгдэхүүнийг хилээр оруулж ирэхээсээ өмнө тодорхой хэмжээний хяналт, шинжилгээнд хамруулах зарчим хэрэгжиж байгаагийн жишээ юм.

Ийм шаардлага тавих нь зүйтэй бөгөөд ард иргэдээ био - аюулаас хамгаалах эхний алхмууд хийгдэж байна хэмээн сайшааж байгаа ч манайд одоогийн байдлаар хүнсний бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах асуудлыг дагнан хариуцсан тодорхой бүтэц, байгууллага байхгүй учраас (FDA шиг) зөвшөөрөл олгох процесс улам хүндрэл бэрхшээлтэй, чирэгдэл хүнд сурталтай болох вий гэсэн болгоомжлол төрж байна.

Хүнсний хэрэгцээний дийлэнхи хувийг импортоор хангаж байгаа манайх шиг улс хүнсний импортод чанд хяналт тавьж иргэдээ хүнсний гаралтай элдэв эрсдлээс хамгаалахын зэрэгцээ мөн хүнс импортлох үйл явцыг чирэгдэл багатай, аж ахуйн нэгжүүдийн сонирхлыг татахуйц байдлаар зохион байгуулахгүй бол хүнсний хомсдол нүүрлэх аюултай.

Импортын урьдчилсан хяналтын тогтолцоог институтчилах замаар хүнсний чанарын баталгааг хангах нь Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Ариун цэврийн тухай хуулиудад импортын хүнсний бүтээгдэхүүний стандарт тогтоох, тохирлын баталгаа олгох, ариун цэвэр эрүүл ахуйн хяналтыг УМХГ, хил гүний мэргэжлийн хяналтын байгууллагууд хэрэгжүүлэхээр заасан боловч тогтоосон стандартын дагуу шинжилгээ үнэлгээ гаргах лаборатори байхгүй (техникийн хүчин чадал сул, хүний нөөц хангалтгүй) нөхцөлд тунхаглалын шинжтэй хууль батлаад хэрэгжилт хангагдахгүйд хүрч байна. Тиймээс бодит нөхцөл, хүчин чадалдаа нийцсэн бодлого барих шаардлагатай байгаа бөгөөд анхнаасаа хэрэгжихгүй нь тодорхой хууль баталснаар аливаа хуулийг хэрэгжүүлэхгүй байж болох хандлага, нийгмийн сэтгэлгээг даамжруулах муу талтай.

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 11 -д стандартчилал, баталгаажуулалтын төв байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагын захиалга, гэрээний дагуу төлбөртэй ажил, үйлчилгээ, сургалт явуулах, улсын

стандартыг хэвлэн борлуулах гэж заасан нь СХҮТ -ийг төрийн үйлчилгээг үзүүлэх нэгж бус ашгийн төлөө ажиллахыг дэмжсэн утгатай заалт байна. Улмаар СХҮТ нь стандартуудыг таниулан сурталчлах боломжгүй, харин зарж борлуулах үүрэг хүлээсэн байгууллага болсон байна.

b) Экологийн цэвэр бүтээгдэхүүн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ<sup>79</sup>

Судалгааны явцад эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулахдаа эрдэмтэн, доктор, мэргэжлийн экспертүүдийн санал, зөвлөмж, шүүмжлэл гаргасаар байхад тусгалаа олж чадахгүй, салбарын баримт бичгүүдээ сайн судлаж уялдуулаагүй байгаа нь анзаарагдсан бөгөөд дахиад л үр ашиг муутай, өнөөгийн хэрэгцээ шаардлагаа хангахгүй, давхардсан, нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн, хянаж үнэлэх боломж хомс баримт бичиг боловсруулагдах үндсийг бүрдүүлж байна.

Асуудлын гол нь хүнсний аюулгүй байдлын асуудлыг цогцоор шийдэхийн тулд эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулахдаа энэ салбарын гол эрдэмтдийн шинжлэх ухаанаар батлагдсан мэдээлэлд тулгуурлан, олон улсын гэрээ конвенцэд нэгдэн орсон зорилтоо шингээсэн, хүнсний үндсэн тулгуур зарчмуудыг мөрдлөг болгон бодлогын баримт бичиг боловсруулах шаардлага байна.

Хүнс Хөдөө аж ахуйн салбарт хүнсний аюулгүй байдлыг хангах, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэлээр олон хөтөлбөр хэрэгжиж байдгийн нэг нь “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” /2006/ хөтөлбөр юм. Эл хөтөлбөрийн хэрэгжилтэд ХХААЯ -ны хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс 2009 онд дүн шинжилгээ хийснийг энд дам авч хэрэглэв. (Хүснэгт 2.)

**Хүснэгт 2.**

Шалгуур үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
• Баталгаажсан экологийн цэвэр бүтээгдэхүүний нэр төрлийн тоо	Төлөвлөөгүй	байхгүй	-
• Үйлдвэрлэсэн хэмжээ, тонн	Төлөвлөөгүй	байхгүй	-
• Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч үйлдвэрийн тооны өсөлт, хувиар	Төлөвлөөгүй	байхгүй	-
• Хөрөнгө оруулалтын хэмжээний өсөлт, хувиар	Төлөвлөөгүй	байхгүй	-
• Экспортод гаргасан бүтээг-дэхүүний нэр төрлийн тоо	Төлөвлөөгүй	байхгүй	-
• Экспортод гаргасан бүтээгдэхүүний хэмжээ, сая төг	Төлөвлөөгүй	байхгүй	-
• Зах зээлийн гарцын тоо	Төлөвлөөгүй	байхгүй	-
• Эко-маркет сүлжээний тоо	Төлөвлөөгүй	бий болоогүй	-
• Шинээр бий болсон ажлын байрны тоо	Төлөвлөөгүй	байхгүй	-

ХХААЯ -нд хэрэгжиж буй ихэнхи хөтөлбөрүүд хэрэгжих явцдаа замхарч, хэлбэр нэрээ сольж дахин санхүүжилт авч байгаа нь хөтөлбөрүүдийн боловсруулалтын чанар муу, төлөвлөлт, тайлагналт хоёрыг ямар ч уялдаагүй баталсан, тухайн үеийн эдийн засгийн

<sup>79</sup> <http://www.mofa.gov.mn/>

уналт, байгаль цаг уурын эрсдлийг тооцоогүй, талуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо муу байгаа нь сөргөөр нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, хүнсний чанар, аюулгүй байдлыг бодлогоор ханган хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий яам, газрууд бодлогын хэрэгжилтийг ихээхэн анхаарч байгаа мэт боловч үйл ажиллагаа нь үр дүн муутай, ажил үүрэг нь олон газар давхардсан ... зэрэг асуудал байсаар байна.

**V. “Экологийн цэвэр хүнс” –ийг дэмжиж буй НҮБ –ийн дэмжлэг, гадаад дотоодын зарим туршлага**

Байгалийн цэвэр хүнс, хүнсний бүтээгдэхүүнийг дэмжих асуудлыг хүнсний баталгаат байдлыг хангах ерөнхий агуулгын хүрээнд авч үзэж, энэ чиглэлд улс орнууд ихээхэн анхаарч байна. Хоол тэжээлийн дутагдалтай хүмүүсийн тоо дэлхийн хэмжээнд 1 тэрбум хол давжээ. Улс орон бүр дотооддоо болон бүс нутгийн түвшинд төрөл бүрийн арга хэмжээ авч байгаа ч үр дүн төдийлөн сайн биш байгаа нь ч харагддаг. Хүнсний баталгаат байдал нь зөвхөн бүс нутагт ч биш дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй асуудлуудын нэгд тооцогдох болсоор удаж байна.

Олон улсын түвшинд НҮБ -ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн –ий ахалсан ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тэрхүү ажлын хэсэг дэлхийн нийтийн хүнсний баталгаат байдлыг хангах хөтөлбөр боловсруулж, түүнийхээ хэрэгжилтийг нь хангах талаар ажилладаг. Ази номхон далайн бүсийн хүрээнд л гэхэд хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр ажилладаг хүрээлэн, асуудал эрхэлсэн хороо ... гэх мэт байгууллага бодлогын түвшинд ажиллаж байна. НҮБ –ын ХХАА –н байгууллага дэлхийн 80 гаран оронд олон тодорхой төсөл хэлэгжүүлж байгаа ба эдгээр орны тоонд манай улс багтдаг.

Экологийн цэвэр хүнс, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөхиүлэх эрх зүйн орчин, дүрэм журмын уялдаа холбоо, тэдгээрийн хэрэгжилт хангалтгүйгээс манайд, нийлүүлэгчдийн “тулгасан” стандартыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болдог “гарцгүй” байдлаас болон бүтээгдэхүүн нэгбүрчлэн шалгаад байх хүний нөөц, техникийн боломж хүрэлцээгүйгээс, мөн түүнчлэн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны буруу хандлага ажиллагаанаас шалтгаалан зах зээлд шаардлага хангахгүй хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувийн жин буурахгүй байгаа юм.

Монгол Улсын Засгийн газар НҮБ –ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэмжлэгтэйгээр “Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр нь Засгийн газрын урт болон дунд хугацааны бодлого зорилтод суурилсан, дотроо дөрвөн чиглэлтэй. Тэдгээр нь:

- 1) Хүнс үйлдвэрлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай эрхзүйн орчныг бүрдүүлэх;
- 2) Газар тариалангийн болон мал аж ахуйн үйлдвэрлэлээ нэмэгдүүлж хүнсний хангамжийг дээшлүүлэх;
- 3) Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах;
- 4) Хоол хүнсний тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх;

НҮБ –тай хамтарч ажиллаж байгаа тухайн улс орны төр засгаас Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв санхүүг нь шийдэж өгөх учиртай. Монголын Засгийн газрын эл хөтөлбөр 2009–2012, 2012–2016 онд хоёр үе шаттай хэрэгжинэ. Хөтөлбөрт хүнсний баталгаат байдлыг хангахтай холбогдсон олон чиглэл, салбарыг хамарсан тодорхой дэд төслүүд бий бөгөөд тэдгээрийн хэрэгжилтээс гарах үр дүн тодорхойлсон болохоор, эл байдал нь мөн салбарт хандивлагчид, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд чухал түлхэц болно гэж үздэг.

**а. АНУ –ын мал аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл**

АНУ мал аж ахуйн хүнсний бүтээгдэхүүн салбараас үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрхэн зах зээлд борлуулах вэ гэдэгт бодолгоо чиглүүлж байна. Энэ нь цаад утгаараа хэрэглэгч, үйлдвэрлэгчийн аль алиныг нь хамгаалсан бодлого болдог ажээ. АНУ -д үндсэндээ дллорхи 3 төрлийн бодлогыг сүү үйлдвэрлэлийг дэмжих, тус үйлдвэрлэлийг авч үлдэх зорилгоор авч хэрэгжүүлж байна.

1. Хил, гаалийн бодлого;
2. Төв болон мужийн засгийн газраас гаргадаг сүүний зах зээлийн захиалга;
3. Сүүний үнийг дэмжих хөтөлбөр;

Сүү, сүүн бүтээгдэхүүний импорт, экспортыг зохицуулах бодлого ордог байна. Импортын татварыг өндөр тогтоох нь дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний үнийг өндөр байлгах бололцоо олгодог бөгөөд АНУ-д нийт сүү, сүүн бүтээгдэхүүний 6 хувийг импортын бүтээгдэхүүнээр хангадаг ажээ.

Өөрийн орны зах зээлийг хамгаалахын тулд импортын сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээнд хязгаарлалт тавихаас гадна экспортыг дэмжсэн татаасыг өгдөг байна. Үүний гол зорилго нь өөрийн оронд бий болсон илүүдэл бүтээгдэхүүнийг гадагш гаргах явдал ажээ. Төв болон мужийн засгийн газраас гаргадаг сүүний зах зээлийн захиалгын систем нь Америк улсад борлуулах нийт сүүний захиалганд үндэслэн сүүний үнийг тогтвортой барих бодлого байдаг. Үүнд сүүг чанарын хувьд нь ангилаад шингэн чигээр нь зарах сүүний үнийг өндөр байлгах замаар аж ахуйгаас гарч буй сүүний дундаж үнийг өндөр барих явдал юм.

Энэ систем нь мөн сүү боловсруулагчдаас фермерүүдэд төлөх сүүний үнийн доод хэмжээг тогтоож өгдөг. Энэхүү системийн бас нэгэн давуу тал нь шингэн сүүний үнийг өндөр байлгаснаар фермерүүдийн сүү үйлдвэрлэх сонирхолыг төрүүлдэг байна. Сүүний үнийг дэмжих бодлого нь гол төлөв сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулсан сүү үйлдвэрлэдэг фермерүүдийн тус сүүний үнийг өндөр байлгахад чиглэгддэг.

Дээрхи бодлогын хэрэгсэлээс ялгаатай тал нь гэвэл тус бодлогын хэрэгсэлээр дамжуулан уух шингэн сүүний үнийг өндөр байлгадаг бол энэхүү бодлогын хэрэгсэлээр дамжуулан сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сүүний үнийг өндөр барьдаг байна. Ингэхийн тулд үйлдвэрлэсэн сүүн бүтээгдэхүүнийг Засгийн газар жилийн тодорхой хугацаанд худалдаж авдаг юм байна. Харин хөдөөгийн хөгжлийг дэмжих зорилгоор:

- а) Хөдөө аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, өрсөлдөөнийг дэмжих;
- б) Байгаль, орчны үйлчилгээ, тодорхой хэсгүүдэд газрын менежментийг сайжруулах;
- в) Хөдөөгийн хөгжлийн хамрах хүрээг тэлэх;

Бодлогын хүрээнд фермерүүдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, аж ахуйнуудыг шинэчлэн сайжруулах, бүтцийн өөрчлөлтийг дэмжих гэх мэт арга хэмжээнүүд ордог байна. Үүнд:

- Мэргэжилийн сургалтанд хамруулах, залуу фермерүүдийг дэмжих,
- Үйлдвэрлэлээ бэхжүүлэхэд хөрөнгө оруулалт хийх,
- Бүтээгдэхүүнийг боловсруулах болон зах зээлд гаргах сүлжээг сайжруулах,
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдийн бүлгүүдийг дэмжих,
- Нэмүү өртөг бий болгох боломжтой болон чанартай бүтээгдэхүүнүүийн үйлдвэрлэлийг дэмжих,
- Бүтээгдэхүүнийг газар зүйн гарал үүслээр нь танил болгох;

АНУ -д нийт бэлчээрийн газрын 50 -иас илүү хувь нь хувийн өмчинд байдаг байна. Энэ нь мал аж ахуйн фермерүүдэд удаан хугацаанд оршин тогтнох баталгаа болдог төдийгүй зээлийн барьцааны хамгийн чухал хэрэгсэл юм байна.

б. БНХАУ -ын аюулгүй хүнсний зэрэглэл

Ямар нэг бохирдолгүй, хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан, тэжээллэг чанар болон бусад шинжээрээ хүний эрүүл хооллоход шаардлагатай бүх болзлыг хангасан хүнсний бүтээгдэхүүнээ хятадууд “**ногоон хүнс**” гэдэг.

Ногоон хүнс нэршил нь, нэг талаас экологийн цэвэр ... гэсэн утга санааг илэрхийлэх “байгалийн өнгө” -ийг заах бөгөөд нөгөө талаас хүний шимт хоол тэжээл гэсэн утгаа давхар илэрхийлсэн тухайн орны “экологийн цэвэр бүтээгдэхүүн” –ий томъёолол юм. “Ногоон” - тодотголыг авахын тулд тэнд ямар ямар онцгой шаардлага тавигддаг, энэ нь худалдааны бусад тэмдэгтүүдээс чухам юугаараа ялгаатай талаар товч дурьдвал:

- Тусгай чанарын стандартад тэнцсэн байх; (Green Food standart)
- Чанарын онцгой баталгаатай байх; Энэ нь зөвхөн үйлдвэрлэл болон худалдааны байгууллагаас гадна дээд түвшний хяналтын байгууллагын давхар давхар баталгаатай байхыг хэлдэг байна.
- Ийм “тэмдэг” –ийг эзэмшигч нь зөвхөн уг тэмдэгт бүтээгдэхүүнийг борлуулах эрх эдлэхээс хэтрэхгүй, өөрөөр хэлбэл, ногоон тэмдгийг ашиглах эрхээр байнга хангагдахгүй.

Ногоон хүнсний сав баглаан дээр “ногоон хүнс” гэсэн дармал бичиг наагдах бөгөөд ард нь сертификатын дугаар тавигдана. Мөн хувийн дугаар, сериалын дугаар нь шошго болон уутан дээрхтэйгээ таарч байх ёстой.

Ногоон хүнсний тусгай стандарт нь дараахи онцлог шаардлагыг хангана. Үүнд:

- Түүхий эд бэлтгэсэн газар нь ногоон хүнс бэлтгэх экологийн стандартад тэнцсэн орчинтой байх; Үүнийг үндэсний ХАА -н газраас батлана.
- Үйлдвэрлэлийн бүх процесс - тариалангийн технологи, мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, загас үржүүлэг ... зэрэг нь мөн, үндэсний ХАА -н газраас баталсан журмын дагуу явагдсан байх ёстой.
- Бүтээгдэхүүн нь чанарын тусгай стандартад нийцсэн байх;
- Хаяг, шошго, чимэглэл нь үндэсний тэмдэгтийн стандартаар хийгдсэн, ногоон хүнсэнд зориулан батлагдсан загвартай байх.

Ногоон хүнс нь дотроо АА буюу А гэсэн 2 түвшинтэй.

- I түвшний буюу АА ангиллын бүтээгдэхүүн нь гарал үүслийн хувьд экологийн цэвэр орчинд бэлтгэгдсэн байна;
- Ямар ч химийн нэгдэл хэрэглээгүй буюу эсвэл бордоо, хүнсний нэмэлт органик нэгдлүүд нь байгаль орчин болон хүний эрүүл мэндэд хор нөлөө үзүүлэхгүйг нь батласан загвартай байна;
- Органик бордоо, ногоон бордуур, ээлжлэн тариалант ... зэрэг шилдэг аргуудыг зөв хослуулсан байх шаардлагатай байдаг аж.

Харин, А зэрэглэлт хүнс нь гарал үүслийн хувьд дээрхтэй адил шаардлага тавигдахаас гадна түүхий эд бэлтгэлээс авхуулаад бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэл бүх шат дамжлага нь хатуу тогтоосон горимын дагуу явагдах ба бүтээгдэхүүний чанар нь ногоон хүнсний стандартыг шууд хангах ёстой. Энд химийн ямарч нэгдэл хэрэглэгдэхгүй.

Дашрамд тэмдэглэхэд, байгалийн цэвэр бүтээгдэхүүн буюу экологийн стандартад нийцсэн хүнсний бүтээгдэхүүн худалдаж авч байгаа гэдэгт итгэлтэй байхыг ногоон шошгоор баталгаажуулдаг жишиг зөвхөн хятадад төдийгүй Европын зах зээлд нэвтрээд олон жил болж байна. Монголд Засгийн газрын бус байгууллагуудын оролцоо санаачилгаар, бусдын жишгийг даган “ногоон шошго” төсөл хэрэгжиж байна. Мөн түүнчлэн, “ногоон эдийн засаг” гэдэг өргөн ойлголтын цаана аж ахуйн нэгж, төрийн байгууллагын үйл ажиллагаа, айл өрхийн амьдралын хэрэглээ ... эд бүгд уялдуулах тухайн чиглэлд уялдуулан нэгтгэх том санаа давхар явж байдаг.

Монголд, 3 жилийн өмнөөс “гурван Ц” буюу “цэвэр үйлдвэрлэл, цэвэр байгаль, цэвэр хүнс” гэсэн уриалга хөдөлгөөнийг эхлэл санаачилгын байгууллагуудаас дэвшүүлэн ... энэ хүрээнд хүрээ цараа багатай ч зарим ажлууд хийгдэж байна. Цэвэр үйлдвэрлэлийн энэ зарчим мэдлэгийг бий болгож, ухамсарыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй гэж үзнэ. Зөвхөн экологид ээлтэй байх бус, үүний цаана зардал хэмнэх учраас эдийн засгийн үр ашиг бий болох юм.

Монгол бол экологийн цэвэршил сайтай цөөн орны тоонд багтдаг. Монголын био, эко бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд таниулах зорилгоор байгалийн гаралтай био, органик бүтээгдэхүүнд нарийн тогтоосон шалгуурын үндсэн дээр ногоон зураасан код болон “Made in Organic Mongolia” шошгыг МҮХАҮТанхим олгож байна. “Made in Organic Mongolia” шошго байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнд олгогдох ба “экологийн органик цэвэр бүтээгдэхүүн” -ий монгол брэндийн нэрийн хуудас болж өгдөг.

#### с. Чили улсын жимсний үйлдвэрлэлийн туршлага<sup>80</sup>

Чили нь дэлхийн хамгийн их жимс экспортлогч таван орны нэг юм. Чилийн Фанадасиан институцийн ажиллаж байгаа туршлагагы авч үзье. Засгийн газрын “Агропекуари Хяналт”-ын тэтгэлэгийн хөтөлбөрөөр дамжуулан Чилийн Эдийн засгийн хөгжлийн Агентлаг жимсний үйлвэрлэлийг хөгжүүлэх үндэсний төлөвлөгөө боловсруулсан.

Эхний шатанд, төрөл бүрийн жимсний сортуудын хүйтэнд хэр тэсвэртэйг тогтоох суурь судалгаа хийсэн байна. Энэхүү Хөгжлийн төлөвлөгөөний хүрээнд, жимсний төвүүдийг (хайрцаглах, сонголт хийх, хөргүүлийн ... г. м.) байгуулсан байна. Энэ нь Чилийн жимсний кластер гэж нэрлэгдэх тэр бүтэцийг бий болгожээ.

Хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйлчилгээний агентлаг экспортлогчдийн бүтээгдэхүүнд чанарын шалгалт хийх үйлчилгээг зогсоож, ариун цэврийн шалгалтад илүү анхаарч эхэлсэн. Фундасион Чили өөрийн Чанарын шалгалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн ба гол зорилго нь нэг төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг бууруулах, тухайн үеийн экспортын чанарын шаардлагыг хангах явдал байсан. Фундасион Чили экспортод нийлүүлж байгаа нийт бүтээгдэхүүний 30 орчим хувьд чанарын шалгалт хийж эхэлсэн. Фундасион Чили ургац хураан авсаны дараа жимсийг муутгахгүй байх талаар техник тусламж үзүүлэх хөтөлбөр гаргаж ажилласан.

Копефрут болон Чилийн бусад экспортлогчид өөрсдийн бүтээгдэхүүний чанарын стандартыг импортлогч талтай байгуулсан хэлэлцээрийн дагуу, импортлогч орны эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тогтоож байсан. Гэхдээ энэ бүхэнд олон улсын зах зээлд очихоор ачигдсан жимсний даатгалын асуудал тавигдсан.

Экспортын үйл ажиллагаа эхлэж байх үед даатгалын компаниуд жимсний тээвэрлэлтийг даатгалд хамруулах эрсдлийг хүлээхээс зайлсхийж, импортын жимс нь импортлогч орны эрүүл ахуйн шаардлагыг хангахгүйн улмаас буцаагдаж болзошгүй гэж болгоомжилж байсан. Фундасион Чили гарал үүслийн чанарын сертификат олгож, тээвэрлэлтийн

<sup>80</sup> Дэлхийн банк, “Чили улсын жимсний үйлдвэрлэлийн туршлага” сэдэвт зөвлөгөөний материал, Чили, Сантьяго, 2010;



горимыг “бүрэн нөхцөлөөр” хангах болсоноор даатгалын компаниуд эрсдлийн даатгалыг боломжийн үнээр хийж эхэлсэн. Энэ утгаар, Фундасион Чили нь Копефрутын үйл ажиллагааг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсэн. 80 -аад оны дунд үеэс 90 -ээд оны эхэн үе хүртэл хоршооллын шинэ жимсэнд чанарын баталгаа гарган өгч байсан.

Фундасион Чили нь киви жимсний чанарт үнэлгээ хийж “бүрэн нөхцлийн” аюулгүй байдлыг хангасан гэсэн баталгаа гарган лацдаж өгдөг байсан. Тиймээс Копефрут өөрийн Буин, Кенкиви, Курисо төвүүдэд чанарын шалгалт хийдэг болсон. Копефрут өөрийн алим, усан үзэмний талбайд Фундасион Чилийг чанарын шалгалт хийх бүрэн эрхийг олгон итгэл хүлээлгэсэн байна. Үүнээс гадна, сан Копефрутын боловсруулсан бүтээгдэхүүнд, гол нь алим, лийрийн жүүсний чанарын шалгалтыг худалдан авагчийн тавьсан техникийн шаардлагын хэмжээнд хийж, баталгаа гаргадаг болсон. Чанарын асуудалд ийнхүү анхаарал тавихын зэрэгцээ, Копефрут нь ургац хураах, хураалтын дараагийн үеийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллаж, экспортын жимсний чанарыг сайжруулах арга хэмжээ авсан; г. м.

\*\*\*

## Дүгнэлт

1. Аливаа улс орон “байгалийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн” –ийг дэмжсэн тусгай бие даасан хуультай байх ба болох нь тэргүүн зэргийн тэмүүлэх зорилт биш гэж үзэж байна. Монгол орны онцлог, давуу талаа түшиглэн олон улсын болон үндэсний стандартын шаардлагад нийцсэн, өрсөлдөх чадвар бүхий экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, улмаар “экологийн цэвэр бүтээгдэхүүн” -ий монгол брэндийг бий болгож гадаад, дотоодын зах зээлд гарган сурталчилж, эдийн засгийн шинэ чадавхи бий болгох сэдэл зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2006 онд “Экологийн цэвэр бүтээгдэхүүн” хөтөлбөр баталсан нь эдүгээ хэрэгжилтийн шатандаа явж байгааг дурдах нь зөв болов уу.

Харин, хамгийн гол асуудал бол манай хувьд, хүнсний бодлогын стратегиа зөв тодорхойлж, хэрэгжиж байгаа нэр зүүсэн бодит үр дүнгээ төдийлэн өгөхгүй байгаа дотоод, гадаадын **олон хөтөлбөр төслийг нэгдсэн стратегийн хүрээнд цогцоор нь эргэн харж шинэчлэх**, тэдгээрийг хооронд нь харилцан уялдуулах шаардлагатай байна.

Ингэхийн тулд, үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон “хүнсний асуудал” –ыг бодлогын хүрээнд бүхэлд нь хариуцсан Хүнсний бодлогын үндэсний зөвлөл байгуулан, улс орны хүнсний хангамж, хүрэлцээ, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлын стратеги, үйл ажиллагааг хариуцуулан ажиллуулах нь, ялангуяа, монголын нийгмийн хөгжлийн хөгжлийн өнөөгийн шатанд чухал ач холбогдолтой гэж үзнэ.

Учир нь орон нутгаас ирсэн мэдээллүүд зарим аймгийн хувьд асуудал хариуцсан албан хаагчдын дутагдалтай ажиллагаанаас шалтгаалж өмнөх 2000 оны тооллогын дүнгээс илт эерж байсан байна. Тухайлбал, Ховд аймагт 2000 онд “Нийтийн сууцны байшин доторх сууц” буюу нийтийн орон сууцанд 854 өрх суудаг гэсэн статистик байтал 2009 онд ирүүлэхдээ энэ тоог 500 гаруйхан болгож өгсөн байна. Гэтэл 300 орчим орон сууц нь хаана орхигдоод байгаа нь тодорхойгүй байна. Ийм төрлийн мэдээллүүдийн улмаас Хүн ам, орон сууцны тооллого-2010-ын дүн гартал орон сууцны тоог тодорхой гаргах боломжгүй байна. Иймд орон сууцны хангамжийн талаар зарим тоог улсын хэмжээнд гаргасан байдлаар танилцуулж байна. Үүнд:

Хүснэгт А

- Орон сууцны хангамж

Хүснэгт В

- 2000 - 2009 онд шинээр ашиглалтад орсон орон сууц /өрхийн тоогоор/

Хүснэгт С

- 2000 - 2009 онд шинээр ашиглалтад орсон орон сууц /талбайн хэмжээгээр/

Хүснэгт D

- Орон сууцны фонд


<sup>115</sup> Орон сууцыг хувьчлах тухай хууль. 1996 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

<sup>85</sup> 2000 оны хүн ам, орон сууцны тооллого. Монголын Үндэсний статистикийн газар. 2001 он

## А. Орон сууцны хангамж

Хүснэгт А

Үзүүлэлт	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
• Инженерийн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоо	119711	120721	121766	123244	128518	133691	142287	149219	154635	163209
• Нийт өрхийн тоо	541149	548730	568600	585600	596400	611000	632500	645700	677800	716500
• Инженерийн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь	22,0	22,0	21,4	21,0	21,5	21,8	22,4	23,0	22,8	22,7



■ Инженерийн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоо

## В. 2000 - 2009 онд ашиглалтад орсон орон сууц /өрхийн тоогоор/

Хүснэгт В


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
•	Ашиглалтад оруулсан орон сууцны тоо	айл	680	1010	1045	1478	5274	5173	8596	6932	5416	8574



## С. 2000 - 2009 онд ашиглалтад орсон орон сууц /талбайгаар /

Хүснэгт С


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
	Нийт талбай	мян. м <sup>2</sup>	108.3	119.3	122.9	286.6	266.8	277.5	467.6	446.6	444.8	512.2
	үүнээс: -төрийн	мян. м <sup>2</sup>	7.1	13.5	13.5	40.4	25.3	9.1	16.2	18.1	3.5	5.0
	-хувийн	мян. м <sup>2</sup>	101.2	105.8	109.4	246.2	241.5	268.4	451.4	428.5	441.3	507.2
	Сууцны ашигтай талбай	мян. м <sup>2</sup>	71.5	85.4	103.2	238.5	225.9	243.8	370.9	363.0	378.1	429.8
	үүнээс: -төрийн	мян. м <sup>2</sup>	5.2	9.3	10.4	29.5	20.0	7.1	13.9	16.9	2.9	3.8
	-хувийн	мян. м <sup>2</sup>	66.3	76.1	92.8	209.0	205.9	236.7	357	346.1	375.2	426



## D. Орон сууцны фонд /талбайгаар/

Хүснэгт D

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009
Орон сууцны фонд		мян. м <sup>2</sup>	6474.4	6559.8	6663.0	6901.5	7127.4	7371.2	7742.1	8105.1	8483.2	8913.0
• өссөн дүнгээр												



## ХӨЁР. ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖИЙН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ, ЦААШДЫН ЗОРИЛТ

Шинэ нийгмийн харилцаанд шилжсэн үеэс ард, иргэдийг орон сууцаар хангах, орон сууц, түүний дэд бүтцийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангасан тохилог орон сууцаар өрх бүр өөрсдийгөө хангах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэлээр Засгийн газраас нилээд хэдэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсний дотор 2002-2006 онд хэрэгжүүлсэн “Орон сууц” үндэсний хөтөлбөр, Азийн хөгжлийн банкны зээлээр 2003-2007 онд хэрэгжүүлсэн “Орон сууцны санхүүжилт” -ийн төсөл, Японы Засгийн газрын ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжаар 2003-2007 онд хэрэгжүүлсэн “Гэр хорооллын нөхцөл сайжруулах” төсөл, Засгийн газрын 2005 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “40000 орон сууц” хөтөлбөр, Засгийн газрын 2008 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр” багтаж байна.

## 1.1. “Орон сууцны санхүүжилтийн төсөл” ба “Гэр хорооллын нөхцөл сайжруулах төсөл” -ийн хүрээнд хийгдсэн ажлууд

АХБ-ны тусламжаар хэрэгжсэн “Орон сууцны санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд нийт 2473 зээлдэгчид 28.3 тэрбум төгрөгийн орон сууцны зээлийг, Японы Засгийн газрын Ядуурлыг бууруулах сангийн тусламжаар АХБ-тай хамтран хэрэгжүүлсэн “Гэр хорооллын нөхцөл сайжруулах төсөл”-ийн хүрээнд 10 хотын гэр хорооллын 1822 иргэнд 1.2 сая ам.долларын зээлийг банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан олгосон нь

орон сууцыг урт хугацааны зээлээр худалдан авах санхүүжилтийн тогтолцооны эхлэлийг тавьсан бөгөөд орон сууцны эрэлт, нийлүүлэлтийг хангах боломжийг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн гэж дүгнэдэг.

Бага, дунд орлоготой иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2006 оны 200 дугаар тогтоол, Сангийн Сайд, Барилга, хот байгуулалтын Сайд, Улаанбаатар хотын Засаг даргын хамтарсан 196/372/567 дугаар тушаалаар “Орон сууцны санхүүжилтийн корпораци”-ийг байгуулж, Засгийн газрын бондын эх үүсвэрээс 28.3 тэрбум төгрөг, АХБ-ны төслийн эх үүсвэрээс 4.4 тэрбум төгрөгийг хөтөлбөрт оролцогч банкуудад байршуулан, 2219 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлэн 672 айлын орон сууцыг ашиглалтад оруулж, иргэдийн орон сууцны зээлийн санхүүжилтэд 4.7 тэрбум төгрөгийг зарцуулан 278 иргэнийг орон сууцны урт хугацаатай зээлд хамруулсан байна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан Засгийн газрын 2008 оны 303 дугаар тогтоолоор батлуулж, хотын төвийн инженерийн шугам сүлжээнд ойр байрлалтай гэр хорооллуудыг сонгон авч, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.

Улаанбаатар хотын хэмжээнд олон нийтийн оролцоотой дахин төлөвлөлт хийж, эхний ээлжинд төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжтой Баянзүрх дүүргийн 13,14-р хорооны нутаг дэвсгэр дээр XIV хороолол, Сүхбаатар дүүргийн 9-12-р хорооны нутаг дэвсгэр дээр VII хороолол, Баянзүрх дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэр дээр Зүүн Сэлбэ, Баянгол дүүргийн 16-р хорооны нутаг дэвсгэр дээр Гандан хороолол, Чингэлтэй дүүргийн 7,8-р хорооны нутаг дэвсгэр дээр МҮОНРТ-ийн ХЭГ-ын орчмын, Баянзүрх дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэр дээр Дарь-Эхийн нийтийн болон амины орон сууцны хороолол, Багануур дүүргийн Баялаг хороолол, Дархан хотын Орон сууцны II, VII, X, XI, XII, XIII хорооллууд, Эрдэнэт хотын Орон сууцны II-A, VII, VII-A, XI хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.

Зам тээвэр, Барилга хот байгуулалтын яамнаас Баянзүрх дүүргийн 13,14-р хорооны нутаг дэвсгэр дэх XIV хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх төслийн нэгжийг байгуулан ерөнхий хөрөнгө оруулагч болох Тайван-Монголын хамтарсан “Кей энд Ти” ХХК болон “Бэрэн констракшн” ХХК, “Эрхэс” ХХК, “Набсан” ХХК -тай хамтран ажиллаж байна. Тус хорооллын VI хэсгийн иргэдийн газрыг орон сууцаар солих болон зах зээлийн үнээр худалдан авах замаар чөлөөлж, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 790 айлын орон сууц, түүний инженерийн дэд бүтцийг байгуулах ажлыг эхлүүлж энэ онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

Сүхбаатар дүүргийн 9-12-р хорооны нутаг дэвсгэр дээр Орон сууцны VII хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу ОССК-д олгосон газарт 1000 айлын үйлчилгээтэй орон сууц барихаар инженер геологийн судалгааны ажлуудыг хийж дуусган, газар өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрыг худалдан авах, орон сууцаар солих зэрэг хэлбэрээр газар чөлөөлөх ажил хийгдэж байна. Тус хорооллын бохир усны 21-р коллектор, дулааны 6а, 6в магистралийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлын зураг төсөл бэлэн болж, эхний ээлжийн шугамын угсралтын ажлыг хийж байна.

Буянт-Ухаа, Баянголын амны орон сууцны хороолол, Хотын шинэ төв, Ургач наран зэрэг хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, орон сууцны хорооллын инженерийн дэд бүтцийг барьж байгуулахад зориулан улсын төсвөөс нийтдээ 43.08 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр орон сууц барих нөхцөлийг бүрдүүлсэн.

## 1.2. “40000 орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилт

“40000 орон сууц” хөтөлбөр 2004-2009 онуудад хэрэгжсэнээр барилгын салбарын хөгжил эрчимжиж, барилга угсралт, хот байгуулалтын ажил өргөжин, Засгийн газрын бонд, гадаадын хөрөнгө оруулалт, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн хүч, хөрөнгөөр 40124 айлын орон сууц ашиглалтад орсон боловч энэ нь хүн амын орон сууцны эрэлт, хэрэгцээг хангаж чадахгүй байна.



Шатах, тослох болон барилгын материалын зах зээлийн үнийн өсөлт, орон сууцны эрэлт, хэрэгцээ их, нийлүүлэлтийн хэмжээ бага зэргээс шалтгаалан орон сууцны нэг ам дөрвөлжин метр талбайн үнэ дундажаар 850 ам.долларт хүрсэн тул бага, дунд орлоготой иргэд орон сууцаа шууд худалдан авах нь байтугай орон сууцны зээлийн сарын төлбөрийг төлөх чадваргүй хэвээр байна.

Иймээс орон сууцны эрэлтийг дэмжиж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого баримтлан, хүн амын орон сууцны нөхцөл, хангамжийг сайжруулах дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага Монгол Улсын өмнө нэн чухал асуудал болон тулгараад байна.

### **1.3. Засгийн газрын бондын хөрөнгөөр төрийн албан хаагчдад олгож буй зээлийн талаар**

Зах зээл дээр бэлэн байгаа 4000 гаруй орон сууцыг урт хугацааны зээлээр төрийн албан хаагчдад олгох санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын 2009 оны 10 дугаар сарын 14-ний 321 дүгээр тогтоолыг батлуулж, 180 тэрбум төгрөгийн бондын эх үүсвэрээс төрийн албан хаагчдад олгох зээлийн журмыг боловсруулан, Засгийн газрын 2009 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 368 дугаар тогтоолоор батлуулсан.

Дээрхи тогтоолуудын дагуу Засгийн газрын бондын эх үүсвэрээс 4000 төрийн албан хаагчдыг орон сууцны зээлд хамруулах ажлыг ОССК-аар дамжуулан зохион байгуулж байна. 2010 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар нийтдээ 80.0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, нэрс нь тодорхой болсон 3900 төрийн албан хаагчдын зээлийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

### **1.4. “Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох тухай” Засгийн газрын 2009 оны 212 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар**

Зам тээвэр, Барилга хот байгуулалтын яамнаас ахмад дайчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолоор батлуулсан ба “Ахмад дайчдад орон сууц эсвэл түүнтэй адилтгах мөнгөн тусламжийн хэмжээг тогтоох, түүнийг олгох журам”-ыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран боловсруулж, Засгийн газрын 2008 оны 72 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна.

Энэ тогтоолын хүрээнд ахмад дайчдад олгох орон сууц нийлүүлэх тендерт шалгарсан 12 компанийн орон сууцыг 640 ахмад дайчинд олгох ажлыг зохион байгуулаад байна.

### **1.5. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр**

“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг УИХ-ын 2010.06.25-ны 36 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Хөтөлбөрт орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр “100 мянган айлын орон сууц” төслийг Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, сумын төвүүдэд хэрэгжүүлэх, орон сууцны хорооллыг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, спорт цогцолбор, худалдаа, үйлчилгээний төв, ногоон байгууламжийн хамт цогцоор нь барих, газар хөдлөлтийг тэсвэрлэхгүй орон сууцны барилга байгууламжийг буулган оронд нь орон сууцны шинэ хороолол, цогцолбор барьж байгуулах, бага, дунд орлоготой иргэдийг орон сууцны урт хугацаатай, бага хүүтэй зээлд хамруулах замаар орон сууцны эрэлтийг дэмжиж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилтуудыг шийдвэрлэхээр тусгагдсан болно. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөлтийн ажлууд хийгдэж эхлээд байна.

\*\*\*

## II. ХОТ СУУРИНГИЙН УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ, ЭЗЭМШЛИЙН БАЙДАЛ

### Танилцуулга

Ус ашиглалтын талаархи холбогдох хуулиудыг цогцоор авч үзэж, усны салбарын удирдлага, зохион байгуулалтын бүтэц, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, ус ашигласны төлбөр, хураамж ... зэрэг усны салбарын олон талт харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох багц асуудлын нэг нь Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга юм.

Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэх гэж байгаатай холбогдуулан хот, аймаг орон нутгийн усан хангамж, ариутгах татуургын өнөөгийн байдал, тэдгээрийн эзэмшлийн талаархи товч лавлагааг гаргав. Мэдээллийг бэлтгэхдээ бид захиалагчаас ирүүлсэн тодорхой чиглэлүүдэд тухайлан анхаарч, холбогдох зарим тоон үзүүлэлтүүдийг мэргэжлийн байгууллага (Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг) –аас гаргуулж авсан болно.

Манай орны нийт ус ашиглалт, усны хэрэглээ жилд 500 сая м<sup>3</sup> байдаг. Нийт хүн амын 30.5 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, 35.8 хувь нь зөөврийн ус тээврийн үйлчилгээнээс, 24.6 хувь нь ус түгээх байр, худгаас, 9.1 хувь нь булаг, шанд, гол горхиноос усаа авч хэрэглэж байна. Усны хэрэглээний түвшин нь хаа газар харилцан адилгүй бөгөөд хот, суурин газрын инженерийн хангамж бүхий орон сууцанд оршин суугчид хоногт дунджаар 230 - 350 л., хөдөө орон нутаг болон гэр хороололд оршин суугчид дунджаар 5 - 10 л. ус хэрэглэдэг.

Ус ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд цаашид хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах... явдал хотжилтын түвшнийг тодорхойлох тодорхойлох үндсэн дэд бүтэц зайлшгүй хамаарч, нийгмийн хөгжлийг тэтгэх голлох хүчин зүйлсийн нэгчухал үзүүлэлт болж байна.

Монгол Улс усны нөөц багавтар орны тоонд багтдаг бөгөөд байгаа багаахан нөөц нь нутаг дэвсгэртээ жигд бус тархсан, хяналт, менежмент сул, эрх зүйн орчин нь төдийлөн боловсронгуй бус, ус хангамжийн түвшин доогуур, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн хүртээмж, хүчин чадал ядмагт тооцогддог тул тулгамдаад олон асуудал хэдийнэ хуримтлагджээ.

Улсын хэмжээнд ус ашиглалт, усны хэрэглээнд тавих хяналт боловсронгуй бус, энэ талаархи эрх зүйн орчин, нэгдсэн мэдээлэл, хяналтын тогтолцоо хараахан бүрдээгүй байгаа нь ус ашиглалт, усны хэрэглээний мэдээллийг нарийвчлан гаргаж хянах, нэгдсэн менежмент хийхэд хүндрэл учруулдаг байна.

Энд болон хойно хавсралтад дурдсан өнөөгийн бодит зарим нөхцөл байдал, бүхэлдээ, ус, усны ашиглалтын асуудлыг улс үндэстний ирээдүйн хөгжил дэвшилтэй харилцан уялдаатайгаар, шинэлэг байдлаар авч үзэх хэрэгцээг тодорхойлж өгч байна.

Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод<sup>86</sup> ...“Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцлийг бүрдүүлэх” –ээр заасан. Үүнтэй уялдан 2010 оны 5 дугаар сард “Ус” үндэсний хөтөлбөр батлагдсан билээ. Төрийн энэхүү бодлогын баримт бичиг нь усны нөөцийг хомсдол, бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглан, монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиг зорилготой. Бодлогын хэрэгжилтийг хангах, хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр гүйцэтгэх засаглалын зүгээс шат дараатай олон арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна.

Засгийн газрын тогтоол шийдвэрээр ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр,

<sup>86</sup> жишээ нь, Засгийн газрын 2006 оны 246 дугаар тогтоол ... г. м.;

төлөвлөгөө батлагдаж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж хандивлагч орнуудын зээл, тусламжид хамруулан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлж, улмаар салбарын яамнаас тухайн чиглэлийн ажлын дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж явж ирсэн.

#### а) Ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдал

Монгол Улсад хот, суурин газар бий болж төвлөрсөн ус хангамж, цэвэрлэх байгууламжийг хөгжүүлж эхэлснээр нийтийн аж ахуйн салбар бүрэлдэн тогтож, түүний үйл ажиллагаа нь хүмүүсийн ажиллаж, амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн ажиллагааг хангах, хүрээлэн байгаа орчин, хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чухал хувь нэмэр оруулж байна. Гэвч, хүн ам өсч төв суурин газрын нягтрал ихсэн, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнээс үүдээд цэвэрлэх байгууламжууд нь бохир усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж чадахгүй, улмаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл бүрдээд байна.

Манай улсын хүн амын 1.4 сая орчим нь төв, суурин газарт амьдарч байгаагийн ойролцоогоор 1 нь ариутгах татуургын сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдардаг. Хүн амын дийлэнх хувь нь оршин суудаг гэр хороолол болон зуслан, суурин газрын эмнэлэг, сургууль, хот, суурин газраас алслагдсан амралт, сувиллын газар, жуулчны баазад бохир ус татан зайлуулах систем байхгүйгээс нүхэн жорлон ашиглаж хөрс, ус болон байгаль орчныг ихээхэн бохирдуулж байна.

Цэвэрлэх байгууламжийн ашиглалт, тоног төхөөрөмжийн байдалд 2006 онд хийсэн үзлэгийн дүнгээс үзэхэд, улсын хэмжээнд нийт 103 цэвэрлэх байгууламж байгаагаас цэвэрлэгээний түвшин нь стандартын шаардлагад хүрсэн хэвийн ажиллагаатай - 41 (~40%), хэвийн бус ажиллагаатай - 27 (~26%), ажиллагаагүй -35 (~34%) байгууламж байсан байна.

Хөрөнгө хүрэлцээгүйгээс шалтгаалан цэвэрлэх байгууламжид цаг тухайд нь засвар үйлчилгээ, техник, технологийн шинэчлэлт хийгдээгүй явж ирсэн. Мөн аймгийн төв, суурин газрын үйлдвэр, аж ахуйн байгууллагын үйлдвэрлэлийн хэмжээ багассанаас цэвэрлэх байгууламжид цугларах бохир усны хэмжээ эрс багасч, технологийн горим алдагдан цэвэрлэгээний түвшин буурч, улмаар бохир усыг голд шууд хаях үзэгдэл гарсаар байна.

*ШУА -ийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн Хөрс, ус, эрдэс судлалын итгэмжлэгдсэн лабораторийн мэдээ мэдээлэлд, Туул гол бохир усны шууд хаягдлаас байнга бохирдож байдаг тухай дурдсан байдаг. Жишээ нь, бохир ус цэвэрлэх “Харгиа” байгууламжийн үйл ажиллагааны доголдол, технологийн хоцрогдлоос үүдэн химийн хорт бодистой ус Төв цэвэрлэх байгууламж (ТЦБ) руу очно. ТЦБ нь энэ хорыг ариутгах хүчин чадалгүйгээс Туул гол руу хортой ус юүлэгдэг аж. Хром болон химийн бусад хорт бодис ихээр агуулсан ус нийлүүлдэг “Энх ду мэнд” /119,4 шоо метр/, “Желбо лидер” /4895/ “Орхоны хөндий” /111,6/ ... зэрэг арьс шир, ноос ноолуур угааж боловсруулдаг нэр бүхий 27 компани 1 сард 17000 шоо метр бохир усыг ариутгалгүй хаягдаж байна.*

*Жил жилээр гаргасан Усны судалгаанаас үзэхэд, Туул голын бохирдлын хэмжээ байнга нэмэгдсэн ирсэн байдаг аж. Ялангуяа Сонгинын гүүрнээс доошоогоо Туул гол их бохирдолтой байна. Одоогоос 45 жилийн өмнө 40 мян. шоо метр ус цэвэрлэх хүчин чадалтай баригдсан ТЦБ –аар, өнөөдөр, түүний даац хэмжээнээс олон дахин давсан их ус арга буюу дамждаг болсон.*

*Бохирдсон усыг цэвэрлэх хоёр үндсэн технологи байдгийн нэг нь шүүж авах механик цэвэрлэгээ, нөгөө нь биологийн цэвэрлэгээ буюу төрөл бүрийн бактерийн тусламжтайгаар хорт бодисыг идүүлж цэвэрлэх арга юм. Идэгдэж цэвэрлэгдсэн том ширхэгтэй бодисууд хэсэг хугацааны дараа усныхаа ёроолд тунадаг. Дээд хэсгийн тунгалаг ус нь халх маягаар гол руу урсана. ТЦБ үүнийг цэвэрлэж амжилгүй “умбуур бодис” -ыг гол руу алддаг байна. Умбуур бодисыг шүүж цэвэрлэх ёстой. Түүнчлэн, Туул голын усны химийн найрлаганд хүнд металлын агууламж их болчихсон нь том аюул юм.*

Усны цэвэрлэгээний түвшинг лабораторийн шинжилгээгээр тогтоосны үндсэн дээр технологийн горим мөрдүүлэх шаардлагатай байдаг боловч, өнөөдрийн байдлаар Улаанбаатар, Багануур, Дархан – Уул, Орхон, Зүүнхараа, Хөтөлийн цэвэрлэх байгууламжаас бусдад нь цэвэрлэгээний түвшинд хяналт тавих лабораторийн асуудал дутмаг, шийдэгдээгүй байна. Цэвэрлэх байгуулам-жийн цэвэрлэгээний түвшинд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд цэвэр-лэсэн усанд умбуур бодис, аммиак, нитрит, хром, нефтийн бүтээг-дэхүүн, өөх тос зэрэг бодисууд зөвшөөрөгдөх хэмжээнээс их байх тохиолдол байнга гарч байна.

Арьс, ширний үйлдвэрээс гарч байгаа бохир усанд хийсэн шинжилгээний дүнгээс харахад төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлж байгаа бохир усны хүчилтөрөгч, умбуур бодисын хэмжээ нь зөвшөөрөгдөх агууламжаас 5 - 20 дахин их байгаа бөгөөд сульфат, сульфитын агууламжтай байгаа. Энэ нь Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн технологийн горимд доголдол үүсэх үндсэн нөхцөл болж өгдөг байна.

Иймэрхүү байдал цаашид үргэлжилбэл Туул, Хараа, Хангал, Ерөө, Орхон голууд бохирдож, экологийн цэвэр тунгалаг шинжээ алдахад хүрэх аюултай юм. Иймд байгаль орчныг бохирдлоос хамгаалах, хүн амын эрүүл амьдрах орчинг бий болгох зорилгоор ариун цэврийн байгууламжийг сайжруулах бодлого хөтөлбөрийг улам боловсронгуй болгож тэдгээрийн хэрэгжилтийг хангах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

2002 оны Тогтвортой Хөгжлийн Дэлхийн Чуулга уулзалтаас гаргасан Йоханнесбургийн “үйл ажиллагааны төлөвлөгөө” –нд ус хангамж, ариун цэврийн шаардлага хангаагүй байгууламжид “харъяалагдах” хүн амын тоог 2 дахин бууруулах нь хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх нэг гол арга зам гэж тодорхойлсон байдаг. Түүнтэй уялдаатайгаар Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт” -д 2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын эзлэх хувийг 2 дахин бууруулах зорилт дэвшигдсэн. Зорилго зорилтууд бол өргөн хүрээндээ тодорхойлогдсон гэж хэлж болохоор байгаа. Иймд ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөрийг дэлхий нийтийн чиг хандлага, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт болон өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрх зүйн үндсэн баримт бичгүүдэд нийцүүлэх явдал чухал байна.

\*\*\*

**b) Улсын хэмжээнд ажиллаж байгаа Нийтийн аж ахуйн байгууллагуудын харъяа ус хангамжийн эх үүсвэрүүдийн талаархи товч мэдээлэл (өгөгдсөн үзүүлэлтүүдээр)**

№	Хот, аймаг	Аж ахуйн нэгжийн нэр	Өмчлөлийн хэлбэр			Ашиглаж байгаа худгийн тоо <sup>1</sup>	Хоногт ашиглах усны хэмжээ	Зарим тодруулга (харъяалал)
			Төрийн өмч	Орон нутгийн өмч	Хувийн өмч			
			(%)	(%)	(%)	(ш.)	(м³)	
(a)	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)	(8)

1.	Улаанбаатар хот	• Ус сувгийн удирдах газар		+		176	150000 – 160000	
2.	Дархан-Уул аймаг	• “Дархан – Ус суваг” ХХК		+		18	15000	
		• “Дулаан - Шарын гол” ХХК		+		8	-	
3.	Орхон аймаг	• “Эрдэнэт - УДТС” ХХК		+		9	1610	
		• “Эрдэнэт - Амьдрал” ХХК		+		14	60000 - 70000	(Эрдэнэт үйлдвэрт)
4.	Архангай аймаг	• “Ундарга” ХХК		+		5	800	
5.	Баян - Өлгий аймаг	• “Суат” ХХК		+		2	2800	
6.	Баянхонгор аймаг	• “Чандмань Баянхонгор” ХХК		+		2	1350	
7.	Булган аймаг	• “Булган – Мээж” ХХК		+		7	677.5	
8.	Говь - Алтай аймаг	• “Ундарга - Алтай” ХХК		+		4	900 - 1250	
9.	Говь-сүмбэр аймаг	• “Ус - Ду” ХХК		+		4	1500	
10.	Дорноговь аймаг	• “Чандмань – Илч” ХХК		+		3	1250	
11.	Дорнод аймаг	• “Дорнод НАА” ХХК		+		8	11520	
12.	Дундговь аймаг	• “Дундговь – Ус” ОНӨҮГ		+		5	1440	
13.	Завхан аймаг	• “Амь ус трейд” ХХК		+		6	2400	
14.	Өвөрхангай аймаг	• “Онги ус суваг” ХХК		+		3	1080	
15.	Өмнөговь аймаг	• “Гүний ус” ХХК		+		4	1100	
16.	Сүхбаатар аймаг	• “Дөрвөлж” ХХК		+		3	800	
17.	Сэлэнгэ аймаг	• “Урсгал ус” ХХК		+		15	4840	
18.	Төв аймаг	• “Төв чандмань - ДЭХГ”		+		3	1300	
19.	Увс аймаг	• “Чандмань - Увс” ХХК		+		5	1400 - 1600	
20.	Ховд аймаг	• “Шим ус” ХХК		+		9	1500	
21.	Хөвсгөл аймаг	• “УС НААК” ХХК		+		10	1100 - 1300	

22.	Хэнтий аймаг	• “Хэнтий – Ус” “ХХК		+		3	2700	
23.	Сэлэнгэ аймаг Сайхан сум / Хөтөл/	• “Гавшгай – Ус” ХХК		+		5	4800	
24.	Сэлэнгэ аймаг Мандал сум	• “Цант орхон” “ХХК		+		3	40	Зөөврийн ус хангамжийн системтэй
25.	Бор - Өндөр баг							Бор – Өндөрийн уурхайд
НИЙТ ДҮН							222657.5 м³	

\* \* \*

**с) “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль” -ийн шинэчилсэн найруулгын төсөлд Усны газраас ирүүлсэн саналын тойм**

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2.2. -д “Цэвэр усыг ахуйн болон үйлдвэрлэ-лийн зориулалтаар ашиглахтай холбогдсон харилцааг Усны тухай хуулиар зохицуулна” хэмээн заасан байна. Тиймээс “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль” -ийн төслийг түр хойшлуулах буюу “Усны тухай”, “Рашааны тухай”, “Ус рашаан ашигласны төлбөрийн тухай” хуулиудын шинэчилсэн найруулгын төсөлтэй хамтатган багцаар хэлэлцэх шаардлагатай байна.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим заалт, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Усны тухай” хуультай зарим талаар зөрчилдөж байна. Тухайлбал:

- “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар бүлгийн 9 дүгээр зүйл нь бүхэлдээ “Усны тухай” хуулийн 2 дугаар бүлгийн 19 дүгээр зүйлтэй нийцэмжгүй байна.
- Энэ хуулийн шинэчилсэн найруулсан төсөлд Усны Зохицуулах Зөвлөл нь орон тооны бус 4 гишүүнтэй (9.2), орон тооны дарга, ажлын албатай (9.8), байхаар тус тус тусгагдсаны дээр 12 тусгай зөвшөөрөл бий болгож, түүний хураамжаар санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлэхээр (9.9), заасан нь “дэмжүүштэй бус” заалт бөгөөд, тэдгээр нь, өмнө дурьдсанчилан, “Усны тухай” хуультай зөрчилдөж байгаа бөгөөд энэ асуудлыг хэрхэн зохистой шийдвэрлэх талаар “Усны тухай”, “Рашааны тухай”, “Ус рашаан ашигласны төлбөрийн тухай” (бусад) хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэг дээр тухайлан авч үзэж байгаа болно.
- “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9.9 болон 9.11 заалтууд хоорондоо зөрчилдөх шинжтэй байна.
- “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 10.2 -д “Тухайн нутаг дэвсгэрт усны үнэ, ... үйлчилгээний төлбөрийг тогтооно” гэж заажээ. Усны газар энэ заалтыг оновчтой бус гэж үзэж байгаа болно. Тухайн заалт “Ус рашаан ашигласны төлбөрийн тухай” хуультай уялдахгүй байгаа болно.
- “Ус боловсруулах” (12.2.2), “аж ахуйн харилцааны дүрмийн дагуу ...” (13.2), “урсгал ус” (17.4.4) ... гэх мэт албан ёсны бус, мэргэжлийн бус хэллэг шинэчилсэн



найруулгын төслийн агуулгад цөөнгүй таарч байна.

- f. “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 17.4 дэх заалт бүхэлдээ “Усны тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 31 дүгээр зүйлтэй утга давхцсан, зарим талаар бас зөрчилдсөн шинжтэй байна. Эл асуудлыг “Усны тухай” хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд төсөлд зөв зохистой шийдвэрлэх боломжтой бөгөөд, тэнд “тодорхой санал” туссан болно.
- g. “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 19.1 нь “Усны тухай” хуулийн 36.7 дахь заалтад харшилж байна.
- h. “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгалаа олсон 12 [шинэ] тусгай зөвшөөрлийн асуудал, тэнд заасан торгууль төлбөрийн [хэт бага] хэмжээ ... зэргийг дахин нягтлах шаардлагатай байна.

**d) “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын чиглэлд хүлээгдэж буй бодлогын зарим зохицуулалт, тулгамдсан зорилтууд**

- Ариун цэврийн байгууламжийн талаар эрх зүйн орчин, удирдлага - зохион байгуулалт, хяналт, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, ариун цэврийн байгууламжийн талаархи хууль тогтоомж, стандартыг шинэчилж, ариутгах татуургын байгууламжийн үйл ажиллагааны хяналтын дэвшилтэт тогтолцоог бий болгох;
- Төв, суурин газрын ариутгах татуургын нэгдсэн сүлжээг өргөтгөн тэлэх, энэ үйл явцын хурдцыг нэмэгдүүлэх, одоо ажиллаж байгаа цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийг сэргээн засварлаж шинэчлэх, техник, технологийг сайжруулах;
- 2015 он гэхэд нийт хүн амын 36.6 хувийг төвлөрсөн ариутгах татуургын шугам сүлжээнд хамааруулах завсрын зорилтын биелэлтийг хангах;
- Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдоогүй айл өрх, албан газар болон аялал жуулчлалын баазуудад байгаль орчинд халгүй жорлон (био болон хуурай жорлон), хаягдал (саарал) усыг цэвэршүүлэн хэрэглэхэд хялбар дэвшилтэт технологийг нэвт-рүүлж, тэдний өдөр тутмын хэрэглээнээс үүсэх хаягдал бохир усны хэмжээг багасгах;
- Ус хангамж, ариутгах татуургын тусгай зориулалтын машин механизм, тоног төхөөрөмжийн парк шинэчлэлтийг аймгийн төвүүдэд хийх, нийт аймгуудын төв, хотуудыг ундны болон бохир усны хяналтын системтэй болгож үйл ажиллагааг жигдрүүлэх;
- Хот тосгоны усан хангамж, ариутгах татуургын ашиглалтад тавих анхаарал хяналтыг сайжруулах замаар, нийт хүн амын хүн амын дундах халдварт өвчлөлийн тархцыг багасган бууруулж, улмаар, ард олныг эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд амьдрах боломж нөхцлөөр хангах;
- Суурин газрын ариутгах татуургыг бага оврын цэвэрлэх байгууламжийн технологиор холбох замаар бохир усыг зайлуулан орчны ариун цэврийн нөхцлийг сайжруулах асуудлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу дэс дараатай шийдэх, хорт бодис ихээр гаргадаг үйлдвэр, аж ахуйн газрыг бохир ус урьдчилан цэвэрлэх байгууламжтай болгох, бохир усны цэвэрлэгээнээс гарсан лагийг боловсруулах техно-логи нэвтрүүлэх;
- Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийг тоог нэмэгдүүлэн, тэдгээрийн

ашиглалт үйлчилгээний технологийг сайжруулах, амины орон сууц, гэр хорооллыг цэвэр, бохир усны системд холбон хүн амын ая тухтай амьдрах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх таатай нөхцлийг хангах, хот суурингаас алслагдсан газарт нүхэн жорлонгийн сайжруулсан хувилбар, бага оврын цэвэрлэх байгууламж ашиглах, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах ... замаар хүн амын эрүүл ахуйн дундач нөхцлийг сайжруулж, нийгэм, эдийн засгийн хөгжлийг тэтгэх нэг хүчин зүйл болгох;

\* \* \*

#### Ашигласан материал

1. Монгол Улсын [тухайн асуудалд холбогдох] хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүд;
2. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Усны газрын албан бичиг, 2010.10.20., №4/1427;
3. Цахим мэдээллийн эх сурвалжууд:
  - a. <http://www.asuinfo.mn/agency/water/>
  - b. <http://www.asuinfo.mn/agency/water/>
  - c. <http://www.land-construction.gov.mn/law/class/>



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



## “ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ ЗӨВЛӨМЖ

(УИХ -ын БОХХААБайнгын хорооны даргын 2010.12.21 -ний өдрийн 08 тоот захирамжаар томилогдсон Ажлын хэсэгт)

Хуулийн төслийн Засгийн газраас өргөн барьсан хувилбарыг УИХ-аар хэлэлцэх явцад гишүүд болон Байнгын хороодыг холбогдох мэдээлэл судалгаагаар хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, хуулийн төслийг сайжруулж үзэл баримтлалд дурьдсан зорилгыг хангахуйц хэмжээний бодит байдал болон олон улсын жишигт нийцсэн зах зээлийн загвар, хяналт, зохицуулалтын механизмыг бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох үүднээс Ажлын дэд хэсгийн гишүүний хувьд дараахь санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан үндэслэлээс үзэхэд уг хууль нь

1. Мал аж ахуйн гаралтай түүх эд бэлтгэлийн тогтолцоог оновчтой болгох, түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх
2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг зохион байгуулалттайгаар бэлтгэн нийлүүлэгчээс хэрэглэгч, үйлдвэрлэгчид шууд борлуулах биржийн худалдааны нээлттэй, шударга тогтолцоог бий болгож түүхий эдийн үнэ бүрдэж байгаа өнөөгийн механизмыг өөрчлөх, улмаар таваар, түүхий эдийн биржийн сонгодог хэлбэрийг төлөвшүүлэх, олон улсын стандартад нийцүүлэх хэмээн тусгажээ.

Гэвч хуулийн төслийг боловсронгуй болгох үүднээс зарим асуудлыг хэрхэн зохицуулах талаар сайтар хэлэлцэж нэгдсэн шийдвэрт хүрэх, Монгол улсын нөхцөл болон олон улсын жишигт нийцүүлэх, зах зээлийн загвар, ажиллах механизмыг тодорхой болгох, үүдэн гарах эерэг, сөрөг үр дагаврыг тооцох шаардлага байна гэж үзэж байна. Үүнд:

1. Энэхүү хуулиар зохицуулж байгаа биржийн харилцааны онцлог бол бэлэн бараа, түүхий эдийг талбай дээр нь шууд худалдахаас илүүтэй ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийг урьдчилан худалдаалах санхүүгийн зах зээл гэдгийг сайтар бодолцож холбогдох зохицуулалтыг хийх шаардлагатай. Үүнд:

- Хуулийн төслийн 6.1.2-т заасан “Ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжаа” гэдэгт ямар ямар арилжааны хэлцлүүдийг ойлгох, нэр төрөл, онцлог, ялгаа нь юу байх /фьючерс, опцион, форвард гэх мэт / биржийн хэлцэл талаас нь хуулийн нэр томьёоны тодорхойлолт өгөх, эдгээр хэлцлийг “үүсмэл үнэт цаас”-т тооцох, үнэт цаасыг гаргах шийдвэр, хяналт, зохицуулалттай холбоотой асуудлыг хариуцах субъектийг тодорхой болгох, холбогдох хуульд өөрчлөлт оруулах / Үнэт цаасны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль .. гэх мэт/.

Мөн эдгээр хэлцлийн арилжааны ерөнхий зохицуулалт, тавигдах бүртгэлийн болон бусад шаардлага, хориглох зүйлс, зөрчилтэй хэлцэл гэж юуг хэлэх, гэрээнд оролцогч талуудын эрх ашгийг хэрхэн хамгаалах, зах зээлд оролцогч, зуучлагч болон дэд бүтцийн байгууллагууд, тэдгээрт тавигдах шаардлага, үйл ажиллагааны ерөнхий зарчмыг хуульчлах, хууль зөрчсөнд хүлээлгэх хариуцлагыг зөрчлийн төрөл бүрээр тодорхой тусгах.

Хуулийн төсөлд зайлшгүй тусгах шаардлагатай олон асуудлуудыг тусгаагүй байна. Эдгээр асуудлыг хуулинд тусгаагүйгээс хяналт, хариуцлагын тогтолцоо алдагдах, үйл ажиллагааны зөрчил гаргах, зах зээл дээр ойлгомжгүй байдал, эрсдэл үүсэх үр дагавартай. Журмаар зохицуулж болохгүй ерөнхий хүрээний асуудлууд, зайлшгүй хуулиар тавигдах шаардлага, зах зээлийн зарчмыг тодорхой

хуульчлаагүйгээс зах зээл дээр өөр өөрийн “тоглоомын дүрмийг” тогтоож эмх замбараагүй байдал үүсгэх талтай.

Таваар түүхий эдийн биржийн арилжаа нь нэг талаасаа бараа түүхий эд нийлүүлэлтийн зах зээл боловч нөгөө талаасаа таваарын гэрээ хэлцэл хийгдэх, арилжаалагдах санхүүгийн зах зээл гэдгийг бодолцож эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

2. Хуулийн төсөлд таваар түүхий эдийн биржийн харилцааг зохицуулах, хяналт тавих эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын оролцоо, эрх, үүргийг тусгаагүй байна. Тухайлбал, “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай “хуулийн 4.1.-д “СЗХ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэнд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн” хэмээн заасан байна.

Таваар түүхий эдийн бирж нь “бирж” талаасаа зах зээлд оролцогч олон байгууллага, иргэдийн оролцоо, нийтлэг эрх ашигт үйлчилдэг, 2 -р эрэмбийн үнэт цаас буюу үүсмэл үнэт цаас /таваарын гэрээ/ арилжаалагддаг, тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий мэргэжлийн оролцогчид /брокер, дилер, бирж, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага ... гэх мэт/ оролцдог, тэдгээрт тавигдах тусгай зөвшөөрлийн болон мэргэжлийн үйл ажиллагааны шаардлагыг хуулиар тогтоосон байдгаараа онцлогтой. Иймд таваар, түүхий эдийн арилжааны зах зээл, дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах эрх бүхий байгууллагын статус, үйл ажиллагааг хуульчлах шаардлагатай.

Хуулийн төслийн 15.1-д энэхүү чиг үүргийн “Биржийн хяналтын хороо” хэрэгжүүлнэ хэмээн заасан байгаа нь нэг талаас, банкнаас бусад санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын байгууллага буюу СЗХ-ны эрх үүргийг бүдэгрүүлж ийм төрлийн чиг үүрэгтэй төрийн захиргааны бас нэгэн байгууллагыг бий болгоно гэж ойлгогдож байна. Энэ тохиолдолд “Бараа түүхий эдийн биржийн хяналт, зохицуулалтын хороо” хэмээх нэг агентлаг байгуулагдах ч юм шиг, эсвэл шууд утгаараа энэ нь зөвхөн биржийн өөрийнх нь Хяналтын хороо ч юм шиг ойлгомжгүй байна. Хэрвээ дахиад нэг агентлаг байгуулагдлаа гэж үзвэл мөн л бие даасан эрх зүйн байдлын тухай хууль шаардагдах, үүнийг дагалдаж оруулах мөн төдий хэмжээний зардал гаргаж бүтцийн байгууллага бий болгох шаардлага бий болж байна.

Иймд энэхүү зах зээлийг харилцааг зохицуулах, хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий Төрийн захиргааны төв байгууллага нь хэн байх, түүхий эдийн чанар, стандартыг хэн тогтоох, мэргэжлийн хяналт болон зах зээлийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтыг хариуцах байгууллага нь хэн байх, төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа хоорондоо хэрхэн яаж уялдуулах асуудлыг хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна. Мөн зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллагууд буюу мэргэжлийн холбоод, нийгэмлэгүүд, тэдгээрийн зах зээлд тавих хяналт, зохицуулалтыг ч хуульчлах шаардлага байна.

3. Зах зээлийн схем, ажиллах механизм ямар байх нь тодорхойгүй байна. Олон шат дамжлагагүйгээр үнэ бүрдэж чадах уу, малчид одоогийнхоос өндөр ханшаар түүхий эдээ брокеруудад өгч чадах уу, биржийн арилжаагаар хийгдсэн хэлцлийн шаардлагад нийцсэн бараа, түүхий эдийг хугацаанд нь чанарын стандартын дагуу нийлүүлж чадах уу, арилжааг хэрхэн зохион байгуулах вэ, дэд бүтцийн байгууллагууд нь хэрхэн ажиллах вэ, өртөг зардал нь хэр байх вэ? гэх мэтийн олон асуудлуудыг сайтар ярилцаж, тодорхой шийдэлд хүрсэний дараагаар хуульчлах шаардлагатай байна. Үүнтэй холбогдуулан хэд хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд

- Зах зээлийг иж бүрэн хувилбараар сонгодог хэлбэрээр ажиллуулах /түүхий эд бэлтгэлийн агентууд - төвлөрсөн агуулах бүхий хоршоод- зуучлагч (брокерийн эрх бүхий хоршоод ч байж болно) – чанар, стандартын хяналтын байгууллага – хяналт, зохицуулалтын төрийн байгууллага - биржийн арилжаа - төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага - эрсдэл, даатгалын компани - өөрийгөө зохицуулах мэргэжлийн холбоод нийгэмлэгүүд - тээвэр зуучлалын компаниуд - худалдан авагч гэх мэтийн зах зээлд оролцогч дэд бүтцийн байгууллагуудын бүрэн оролцоотой иж бүрэн зах зээлийн систем.

Энэ нь ажил үүргийн хуваарилалт, эрсдэлийн хуваарилалт ил тод зах зээлийн хамгийн зохион байгуулалттай хэлбэр. Агентууд, агуулах, тээвэр зуучлалын компаниуд, зуучлагчдын зардал, ашиг түүхий эдийн үнэд шингэж байгаа ч гэсэн эдгээр зардлууд нь ченжээр дамжуулсан ч зайлшгүй гарах зүй ёсны зардалд тооцогдоно. Хамгийн гол нь чанар, стандартыг хангасан бараа, түүхий эдийг нэгдсэн зохион байгуулалттайгаар арилжаалдаг, эрсдэлийг сайтар бууруулсан байдгаараа ялангуяа ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжаанд тохиромжтой.

- Зах зээлийн холимог загвар. Малчид түүхий эдээ агуулах бүхий брокеруудаар дамжуулан худалдах буюу өөрөө биечлэн захиалга өгөх хэлбэр. 1 -р тохиолдолд брокерийн эрх бүхий хоршоо, эсвэл брокер малчдаас түүхий эдийг стандартын дагуу ангилан худалдаж авна. Эсвэл малчин өөрөө түүхий эдээ ямар үнээр худалдах захиалгаа брокерт өгнө. Энэ төрлийн арилжаа нь биржийн болон биржийн гадуурхи арилжааны хэлцлээр хийгдэж болох юм.

Эхний тохиолдолд биржийн арилжаагаар 1 -р схемийн дагуу хэлцэл хийгдэж, арилжаа явагдах бол малчин өөрөө хатуу үнээр захиалга өгсөн бол биржийн гадуурхи арилжаагаар түүхий эдийг арилжаалж болох юм. Энэ тохиолдолд худалдан авагч өөрөө тээвэрлэлт, худалдан авах ажиллагаагаа зохион байгуулах, эсвэл мэргэшсэн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой. 2 -р тохиолдолд түүхий эдийн үнэ арай өндөр тогтож болох боловч, харьцангуй эрсдэлтэй, худалдан авагчдад төвөгтэй, эсвэл өөрийн компанийн тээврээр гүйцэтгүүлэх бол эсрэгээрээ ашигтай ч байж болох юм.

Үүнийг талбай дээрхи арилжаа болон ирээдүйд нийлүүлэх бараа, түүхий эдийн арилжааны холимог хэлбэр буюу зах зээлийн 2 шатлалт схем гэж ба ойлгож болно. Зах зээлийг аль болох өрсөлдөөнтэй, уян хатан зохион байгуулах шаардлагын үүднээс биржийн болон биржийн бус арилжааг аль алины нь хуулиар нээлттэй зохицуулах нь зүйтэй болов уу.

Ялангуяа хууль батлагдсаны дараахь хугацаанд арилжаа худалдааны энгийн хэлбэр нэг хэсэгтээ үйлчилж яваандаа боловсронгуй сонгодог хэлбэрт шилжих боломжтой. Нөгөө талаас дан ганц биржийн зуучлагч агентаар дамжуул гэж шаардах нь тодорхой хэмжэний монополь үүсгэж болзошгүй. Гэхдээ биржийн гадуурхи арилжаа ч гэсэн зохион байгуулалттай байх шаардлагатай.

- Хуулийн төслийг эцэслэн боловсруулах, зарим зөрчилтэй ойлгомжгүй асуудлуудыг хуульчлах явцдаа мэргэжлийн хүмүүсийн оролцуулж санал авах, хэлэлцүүлэг хийх, хуулийн төсөлд тусгасан оролцогч байгууллагууд энэ хууль батлагдсанаар тухайн үйл ажиллагааг хариуцан явуулж чадах чадавхитай эсэхэд дүгнэлт гаргах, энэхүү дүгнэлтийг Ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, бэлтгэл ажлыг зохион байгуулах шаардлагатай болов уу.

Эцэст нь дүгнэхэд, энэхүү харилцаа нь урьд өмнө нь хэд хэдэн удаагийн оролдлогоор

хэрэгжүүлж ирсэн бөөний худалдааны сүлжээ, таваарын биржийн үйл ажиллагаанаас ихээхэн өөр, санхүүгийн болон бараа, түүхий эдийн зохион байгуулалттай арилжааны нэгдсэн систем, зах зээлийн сонгодог хэлбэр гэсэн хуулийн тулгуур үзэл баримтлал, концепцэд нийцүүлэх нь зүйтэй болов уу. Аливаа шинэ харилцааг эхнээс нь зөв зохион байгуулаагүй тохиолдолд ихээхэн зардал чирэгдэл гарч, зах зээлийн нэр хүндэд муугаар нөлөөлөх талтай. Хуулийн төсөл нь бүхэлдээ үзэл баримтлалын зорилгодоо бүрэн нийцээгүй, зарим асуудлаар нэгдсэн шийдэлд хүрээгүй байгаа нь харагдаж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛСЭН:

Ажлын дэд хэсгийн гишүүн, УИХ-ын Судалгааны төвийн дарга, эдийн засгийн ухааны доктор (Ph.D) Ц. Норовдондог

2010.12.29



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

# ХАВСРАЛТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

“Бодлогын судалгаа, шинжилгээ”  
эмхэтгэл (VII боть) -ийн хавсралт

**УИХ -ын 2009 оны намрын чуулганы хугацаанд Тамгын газрын Судалгааны төвөөс  
хийж гүйцэтгэсэн судалгаа, мэдээлэл, лавлагаа**

**(VIII ботид орсон бусад судалгааны жагсаалт)**

№	Судалгаа, мэдээлэл, лавлагаа	Гүйцэтгэсэн судлаачид
<b>Нэг. НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ</b>		
1	• “Төрөөс их дээд сургуулийн оюутнууд судлаачдад олгодог тэтгэлэг, зээл тусламжийн талаархи бусад орны туршлага эрх зүйн зохицуулалт (Харьцуулсан судалгаа)	Ц. Норовдондог (Ph.D), П. Амаржаргал, Ц. Болормаа, Г. Гэрэл, Д. Жигваагүнсэл, Ө. Мөнхтунгалаа, О. Нарантуяа
2	• Хараа хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаархи экспертийн санал асуулгын судалгаа, дүн шинжилгээ	Ц. Товуусүрэн, А. Пагма ... бусад
3	• Эрүүл мэндийн даатгалын байгууллагын бие даасан тогтолцоо: ИЭМДИТХуулийн төсөлд тусгагдсан байдал, хууль эрх зүйн үр дагавар (Лавлагаа мэдээлэл)	Ч. Базар (Ph.D)
4	• Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлийн [ЗАСГИЙН ГАЗРЫН БУС] байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны зарим онцлог	Ц. Норовдондог (Ph.D), Г. Чулуун Т. Мягмаржав, Ө. Мөнхтунгалаа
<b>Хоёр. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ЗАСАГ ЗАХИРГАА, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ</b>		
9	• Европын гишүүн орон Дани, Франц, Герман, Ирланд, Испани, Англи улсын орон нутгийн сонгуулийн тогтолцооны зарим зохицуулалт	Судлаачид
10	• Нийслэлийн дүүргүүдийн эрх зүйн байдалтай холбоотой зарим санал	Р. Хатанбаатар, Л. Батжав (Ph.D)
11	• Дүүргийн эрх мэдлийг зохицуулж буй эрх зүйн орчин (Мэдээлэл - лавлагаа)	Р. Хатанбаатар, Б. Ариунжаргал
12	• Гадаадын зарим орны улстөрийн намын тухай хууль дахь санхүүжилттэй холбоотой асуудлаархи харьцуулсан судалгаа	Р. Хатанбаатар, П. Амаржаргал Б. Хатантуул
13	• Улсын Их Хурлын тухай хуулийн 34.3 дахь заалтад нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох судалгаа, бусад орны туршлага	А. Пагма, Ц. Товуусүрэн, Г. Алтан - Оч (Ph.D), Ч. Базар (Ph.D), Б. Мөнхцэцэг
14	• Гадаадын зарим орны өмгөөллийн эрх зүйн зохицуулалтын онцлог	Л. Батжав (Ph.D)

15	<ul style="list-style-type: none"> <li>Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн заалттай холбоотой гадаад орнуудын харьцуулсан судалгаа</li> </ul>	<i>П. Амаржаргал, Ч. Базар (Ph.D), Ц. Болормаа, Г. Гэрэл, Б. Хатантуул</i>
16	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилийн байдал болон хуулийн төсөлд хийсэн шинжилгээ</li> </ul>	<i>Ц. Норовдондог (Ph.D), Ч. Онончимэг, Ц. Элбэгзаяа, О. Нарантуяа</i>
17	<ul style="list-style-type: none"> <li>Улстөрийн намуудын гишүүнчлэлийн асуудал</li> </ul>	<i>Л. Батжав (Ph.D)</i>
18	<p><b>Төрийн дээд одон медалийн тухай хуулийн төслийн агуулгын зарим асуудалд</b></p> <p><i>(Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын дэд хэсэгт хүргүүлсэн танилцуулга, санал зөвлөмж)</i></p>	<i>Ц. Норовдондог (Ph.D), Г. Чулуун</i>



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

ISBN 978-999-9--56-70-8

УИХ -ын Тамгын газар ©  
«БОДЛОГЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ»  
(Судалгааны эмхтгэл, VII боть)

«Мөнхийн үсэг» хэвлэх үйлдвэр  
Хэвлэлтэд шилжүүлсэн 2011.3.15  
Тираж 300, Хэвлэлийн хуудас 20  
Цаасны хэмжээ 176 \* 250  $\frac{1}{10}$   
(Анхны хэвлэл)

УБ, 2011









UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

























